2026
№ 01 (55)



ШҮҮХИЙН ШИЙДВЭР

ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

ОНОЛ-АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

UNIYERSITY OF INTERNAL AFFAIRS

SCHOOL FOR COURT DECISION EXECTION SERYICE

COURT DECISION EXECUTION STUDY

THEORETICAL AND METHODOLOGICAL QUARTERLY JOURNAL

2026

№01

Ulaanbaatar

Эрхлэн гаргаж, эмхэтгэсэн:

Нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа П.Баярбаатар

Сургалт, судалгааны 403 анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн

Хэвлэлийн хуудас: 27.9

Хэвлэлийн тоо: 10

ISBN: 978-99978-770-2-4

ISSN: 3079-3378

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ” сэтгүүл

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,

Цагдаагийн академийн өргөн чөлөө,

Хилчний гудамж,

Дотоод хэргийн их сургууль

И-мэйл: setguul.cd@gmail.com

Веб: uia.gov.mn

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ	**JOURNAL EDITOR BOARD**
Сэтгүүлийн эрхлэгч **Чинзориг Д.** Сургалт, судалгааны 403 дугаар ангийн дарга бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, доктор, хурандаа	**Editor of the journal** **Chinzorig D.** Ph.D, Colonel, Director, Studying and Research Unit №403- School For Court Decision Execution Service.
Ерөнхий редактор **Галбадрах Б.** Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн профессор, доктор, дэд профессор, дэд хурандаа	**Editor of the journal** **Galbadrakh B.** Ph.D, Associated Professor, Lieutienant Colonel, Professor, Social Work and Psychology Department.
Нарийн бичгийн дарга **Баярбаатар П.** Ял эдлүүлэх тэнхимийн дэд профессор, доктор, дэд хурандаа	**Secretaty of the journal** **Bayarbaatar P.** Ph.D, Associate Professor of the Department of Sentence Enforcement Lieutenant Colonel
Гишүүд **Алтангэрэл Б.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн тэргүүлэх профессор, доктор, профессор	**Members** **Altangerel B.** Ph.D, Professor, Leading Professor, Court Decision Execution Studying Professors' Research Team.
Очгэрэл Ц. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн тэргүүлэх профессорын орлогч, доктор, дэд профессор	**Ochgerel Ts.** Ph.D, Associated Professor, Professor, Professor Court Decision Execution Studying Professors' Research Team.
Алтан-Очир М. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын хүрээлэнгийн эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа	**Altan-Ochir M.** Ph.D, Associated Professor, Colonel, Head, of Court Decision Execution Study Center.

Батбаяр Э. Ял эдлүүлэх тэнхимийн профессор, доктор, дэд профессор, хурандаа	**Batbayar E.** Ph.D, Associated Professor, Colonel, Professor, Penal Law Department.
Батгэрэл Я. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, доктор, хурандаа	**Batgerel Ya.** Ph.D, Colonel, Professor, Civil Court Decision Execution Department.
Галсанжамц Г. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн судалгааны чиглэл хариуцсан профессор, доктор.	**Galsanjamts G.** Ph.D, Professor, Court Decision Execution Studying Professors' Research Team.
Мөнхбат Ц. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн судалгааны чиглэл хариуцсан профессор, доктор, профессор.	**Munkhbat Ts.** Ph.D, Professor, Professor, Court Decision Execution Studying Professors' Research Team.
Нямдорж Н. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн судалгааны чиглэл хариуцсан профессор, доктор	**Nyamdorj N.** Ph.D, Professor, Court Decision Execution Studying Professors' Research Team.
Нямгомбо Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн судалгааны чиглэл хариуцсан профессор, доктор, дэд профессор, хурандаа	**Nyamgombo B.** Ph.D, Associate Professor, Colonel, Professor of Court Decision Execution Studying Professors' Research Team.
Батболд Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн судалгааны чиглэл хариуцсан профессор, доктор, хурандаа	**Batbold B.** Ph.D, Colonel, Professor of Court Decision Execution Studying Professors' Research Team.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн сэтгүүл

ДУГААРЫН ТОВЧООН	
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	
Б.Галбадрах Ногоон хорих байгууллагын үзэл санаа	11-19
Я.Батгэрэл Төлбөр төлөгчийн патентын эрхээс төлбөр гаргуулах боломж, шийдэл	20-30
Н.Жинжиймаа Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй гадаад орны туршлага	31-46
М.Даваабат Хүчиндэх гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй хоригдлын нийгэмшиж буй байдал	47-59
Н.Бадраа Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, анхаарах асуудал	60-71
Г.Батжаргал нийгмийн ажлын үйлчилгээнд ухаалаг технологи, хиймэл оюун ухаан, мэдээллийн системийн хэрэглээний үр дүнгийн шинжилгээ	72-90
С.Цэрэндолгор Суралцагчдын тууштай зан чанар, тэсвэр хатуужлыг хөгжүүлэхэд шаардлагатай багшийн ур чадвар	91-104
И.Санчиргарав Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн байдал ба хорих ял эдлүүлэх үйл явц дахь хүртээмжийн асуудал	105-119
Б.Дэнсмаа Интернэтийн орчинд зайн сургалтын зохион байгуулах судалгаа	120-128
Ч.Урангоо Хуулийн этгээдийн санхүүгийн баримт бичигт үзлэг, нэгжлэг хийх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний ач холбогдол	129-137
О.Ундармаа Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Оросын холбооны улсын дотоод хэргийн яамны хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааны үр ашигт нөлөөлөх сэтгэл зүйн хүчин зүйлсийн үнэлгээний шинжилгээ	138-149
Б.Сайнбаяр Гадаадын зарим оронд хоригдлын гаргасан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулж буй талаар харьцуулсан судалгаа	150-160

С.Бямба-Эрдэнэ Гадаадын зарим орны иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог	161-168
Б.Мөнхзаяа Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх isrs4st аргачлалыг дэвшүүлэх нь	169-183
Г.Сэргэлэн Цагдан хорих байрны харуул хамгаалалтыг боловсронгуй болгох, боломж шийдэл	184-196
Б.Базарсад Хоригдлыг суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлын ач холбогдол	197-208
М.Батмөнх Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдал	209-219
Ж.Еркебулан Хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын шийдэл	220-232
А.Анхжаргал Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба технологийн уялдаа холбоо, уламжлал	233-245
Г.Батдондог Хоригдлын тодорхой хэмжээгээр хязгаарлагддаг үндсэн эрх буюу хөдөлмөрлөх эрх	246-258
Ц.Цэндсүрэн Эмэгтэй хоригдлын ял эдлэх үеийн уламжлал, шинэчлэл	259-265
Б.Намуундарь Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага	266-275
О.Энхмэнд Цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт	276-286
Д.Мөнхбаяр Шийдвэр гүйцэтгэгчийн ажлыг үнэлэх эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ	287-301
Шинжлэн магадлах ухаан	
О.Должинсүрэн Сонсогч суралцагч шинэ ухагдахууныг хэрхэн ойлгож байгааг судалсан судалгаа үр дүн	302-308

П.Эрдэнэбаатар Хурууны хээний бодит байдлыг илрүүлэх технологийн өнөөгийн байдал, ирээдүйн хэтийн төлөвийн талаарх олон улсын судалгаа	309-323
Ц.Нандинцэцэг Цэргийн дэг журамтай болон цэргийн дэг журамгүй сургалтын орчин дахь сонсогч, суралцагчдын биеийн антропометрийн үзүүлэлт ба сэтгэцийн төлөв байдлын харьцуулсан судалгаа	324-330
М.Цогтбаяр Хуурамч тамганы дардаст илрэх шинж тэмдгийн асуудал	331-337
Ш.Батсүх Кибер гэмт хэрэг, дижитал нотлох баримтын шинжилгээ	338-355
Л.Отгонбаяр Зам тээврийн ослын хэргийн газрын үзлэгийн зарим асуудал	356-361
Э.Ижилцэцэг Шинжээчийн дүгнэлт түүнийг үнэлэх олон улсын туршлага	362-376
Э.Цолмон Хэргийн газраас мөр илрүүлэхэд гэрлийн үүсгүүр ашиглаж буй өнөөгийн байдал, хөгжил, хэтийн төлөв	377-383
Б.Номун Хэт улаан гэрлийг магадлах ажиллагаанд ашиглаж буй өнөөгийн байдал	384-398

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм хүндэт уншигч танд энэ өдрийн мэнд хүргэе.

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас улирал тутамд эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, судлал” онол, арга зүйн сэтгүүлийн 2026 оны 01 дүгээр улирлын дугаарыг уншигч та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал" сэтгүүл нь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, эрдэмтэн судлаачид болон практик ажилтнуудын мэдлэг, туршлагыг хуваалцахад зориулагдсан мэргэжлийн сэтгүүл юм. Энэхүү сэтгүүл нь хууль сахиулахуйн салбарын онол, практик, бодлого төлөвлөлт, шинэ хандлага, тулгарч буй асуудлуудыг гүнзгийрүүлэн судалж, шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, хууль, эрх зүй судлал зэрэг шинжлэх ухааны түүх, шүүмж, судалгаа болон онол, практикийн асуудлаарх эрдэмтэн, судлаач, багш, суралцагчдын эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны үр дүнг хэвлэн нийтэлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилготой онол, арга зүйн сэтгүүл юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл улирал тутмын онол, арга зүйн сэтгүүл нь шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын шинжлэх ухаан, практикт өөрийн гэсэн байр суурийг эзэлсэн, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн сэтгүүл болон хөгжиж 12 жилийн хугацаанд 50 дугаарыг эрхлэн гаргаж, эрдэмтэн, судлаачдын 60 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг олны хүртээл болгон хэвлэн нийтэлсэн билээ.

Сэтгүүл нь АНУ-ын салбартаа тэргүүлэгч Turnitin LLC-ийн Монгол Улс дахь албан ёсны төлөөлөгч “Юнисолюшн Партнерс” ХХК-тай хамтран ажиллаж, зохиогчдын ирүүлсэн бүтээл бүрийн давхцалыг шалгаж (Plagiarism), сэтгүүлд тавих хэлбэр болон агуулгын шаардлагыг өндөрсгөсөн. Мөн эрдэм шинжилгээний сэтгүүлийнхээ чанар чансааг нэмэгдүүлэх зорилгоор Парист төвтэй "ISSN International Centre"-д олон

улсын ISSN дугаар авах тухай хүсэлтээ хүргүүлж, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр албан ёсоор бүртгэгдэж, олон улсын стандартын ISSN-L (3079-3378), 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр DOI: https://doi.org/10.63570/nrv4qh89 дугааруудыг тус тус авч олон улсын бүртгэлээр баталгаажуулсан.

Мөн Монгол Улсын шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн 2026 оны 03 дугаарын сарын 10-ны өдрийн А/34 тоот тушаалаар дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтад нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулганаар дэмжигдэж батлуулсан зэрэг амжилттай байна.

Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь хууль зүйн шинжлэх ухааны болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын ололтыг түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэдэг.

Сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлд Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг болон Хууль зүйн их, дээд сургуулийн магистр, докторын сургалтын хөтөлбөрт эрдэм шинжилгээний багц цаг тооцон ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургуулиас эрхлэн гаргадаг мэргэжлийн сэтгүүлүүдийг сонирхсон судлаач бүхэн онлайнаар https://journal.uia.gov.mn/ холбоосоор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал онол арга зүйн сэтгүүлийн цахим хувилбарыг https://journal.uia.gov.mn/index.php/cces/issue/view/158-ээс тус тус хандан өгүүллүүдийг бүрэн эхээр нь унших боломжтой юм.

Уншигч Таны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тань өндөр амжилт хүсье.

Эрдэм шинжилгээ, судалгааны үйлс тань өөдрөг байх болтугай.

Хүндэтгэсэн,

ДОКТОР, ХУРАНДАА Д.ЧИНЗОРИГ

НОГООН ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ҮЗЭЛ САНАА
THE CONCEPT OF GREEN CORRECTIONS

Б.Галбадрах

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн профессор,доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа

Э.Билэгсайхан Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 2025-7051 дүгээр дамжааны суралцагч

Товч утга:

Дэлхий дахинд өрнөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нөөцийн хомсдол зэрэг сорилтууд эрчимжиж буйтай холбоотойгоор төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэх шаардлага нэмэгдэж байна. Энэ хүрээнд хорих байгууллагын тогтолцоо нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх, хоригдлын нийгэмшүүлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлд шинэчлэгдэх шаардлагатай болж байна.

Өгүүллийн зорилго нь тогтвортой хөгжлийн зорилтууд болон ногоон эко орчны үзэл баримтлалтай уялдуулан “ногоон хорих байгууллага” концепц, олон улсын туршлага, хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг судалж, таниулахад оршино.

Хорих байгууллагын үйл ажиллагаанд сэргээгдэх эрчим хүч ашиглах, нөөцийн хэмнэлт, хог хаягдлын менежмент, ногоон байгууламж, байгальд суурилсан сургалт, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь байгууллагын зардлыг бууруулах, аюулгүй байдлыг сайжруулах, хоригдлын зан үйлийн өөрчлөлт, нийгэмшүүлэх үйл явцад эерэг нөлөө үзүүлдэг байна. Мөн хорих байгууллагын тогтвортой хөгжлийн бодлого нь байгаль орчны хамгаалал, хүний эрх, нийгмийн шударга ёс,

эдийн засгийн үр ашиг зэрэг олон талт зорилтыг уялдуулсан институцийн шинэчлэлийн чухал чиглэл болж хөгжиж байна.

Түлхүүр үгс: Тогтвортой хөгжил, ногоон эко орчин, ногоон хорих байгууллага, хоригдлын нийгэмшүүлэх үйл ажиллагаа, сэргээгдэх эрчим хүч.

Abstract: In the context of intensifying global challenges such as climate change, environmental degradation, and resource scarcity, there is an increasing need to align the activities of public institutions with the principles of sustainable development. Within this framework, correctional systems, as an integral component of public administration, are required to undergo transformation aimed at reducing their negative environmental impact, improving the efficient use of resources, and enhancing the effectiveness of rehabilitation and social reintegration initiatives for incarcerated individuals.

The purpose of this article is to examine and disseminate knowledge on the concept of "green corrections" by linking it to the Sustainable Development Goals (SDGs) and the principles of environmentally sustainable practices. In particular, the study explores international experiences, policy approaches, and practical measures implemented within correctional institutions to promote environmental sustainability and institutional resilience.

The integration of renewable energy sources, resource-efficient technologies, waste management systems, green infrastructure, and nature-based education and vocational programs within correctional institutions has been shown to contribute to reduced operational costs, improved safety and security, and positive behavioral changes among prisoners, thereby supporting their rehabilitation and social reintegration.

Furthermore, sustainable development policies in correctional institutions represent an important direction for institutional reform, as they seek to balance multiple objectives, including environmental protection, human rights, social justice, and economic efficiency. Such policies are increasingly recognized as strategic mechanisms for enhancing the effectiveness, accountability, and social responsibility of modern correctional systems.

Keywords: Sustainable development; Green environment; Green corrections; Prisoner rehabilitation and social reintegration; Renewable energy.

Дэлхий дахинд уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нөөцийн хомсдол зэрэг глобал сорилтууд эрчимжиж буй өнөө үед төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Энэ хүрээнд хорих байгууллагын тогтолцоо нь зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх, ял эдлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна байгаль орчны хамгаалал, нийгмийн хариуцлага, эдийн засгийн үр ашиг, хүний эрхийн баталгааг хангах цогц институтийн тогтолцоо болж өөрчлөгдөж байна.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтуудад сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтууд тусгагдсан бөгөөд дэлхийн улс орнуудын хөгжлийн бодлогын үндсэн чиглэл болж байна (Нэгдсэн Үндэсний байгууллага, 2026). Эдгээр зорилтууд нь хорих байгууллагын үйл ажиллагаатай шууд хамааралтай бөгөөд байгууллагын бодлого, дэд бүтэц, сургалт, хөдөлмөр эрхлэлт, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмыг нэвтрүүлэх шаардлагыг тодорхойлж байна.

Сүүлийн жилүүдэд “ногоон хорих байгууллага” (Green Prisons) гэсэн ойлголт олон улсын хэмжээнд бодлогын шинэ чиглэл болон хөгжиж, хорих байгууллагын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх, мөн хоригдлын зан үйлд эерэг өөрчлөлт бий болгох зорилготой хөтөлбөрүүд хэрэгжих болсон байна. Ногоон байгууламж, байгальд суурилсан үйл ажиллагаа, сэргээгдэх эрчим хүч, дахин боловсруулах технологи зэрэг нь хорих байгууллагын зардлыг бууруулах, аюулгүй байдлыг сайжруулах, хоригдлын сэтгэл зүйн байдал, нийгэмшүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг болох нь судалгаагаар тогтоосон байна.

Мөн хорих байгууллагын хөгжлийн бодлого нь зөвхөн байгаль орчны асуудал бус, харин хүний эрх, нийгмийн шударга ёс, хөдөлмөр эрхлэлт, нийгэмшүүлэх үйл ажиллагааг нэгтгэсэн институтийн шинэчлэлийн нэг хэсэг болох нь олон улсын туршлагаас тодорхой харагдаж байна. Жишээлбэл, зарим улс орнууд хорих байгууллагын дэд бүтцийг байгальд ээлтэй технологид шилжүүлэхийн зэрэгцээ хоригдлуудад “ногоон ур чадвар” (green skills) эзэмшүүлэх сургалт зохион байгуулж, хөдөлмөр

эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлж байна.

Дэлхийн улс орнуудад хорих байгууллагын тогтолцоог байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, мөн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд илүү тэсвэртэй болгох арга замыг тасралтгүй эрэлхийлсээр байна.

Учир нь ногоон байгууламж, байгальд суурилсан үйл ажиллагаанд хоригдол болон алба хаагчдыг хамруулах нь хорих байгууллагад гарч буй хүчирхийллийн түвшнийг бууруулах, сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах, мөн нийгэмшүүлэх (rehabilitation) үйл явцыг дэмжихэд бодитой эерэг нөлөө үзүүлдэг байна. Жишээ нь 2024 оны есдүгээр сард Европт зохион байгуулагдсан олон улсын семинарын үеэр танилцуулсан судалгааны үр дүнгээс харахад биологийн төрөл зүйлээр баялаг цэцэрлэгт хүрээлэн, ногоон орчныг хөгжүүлэх нь хоригдол болон алба хаагчдын сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд тогтвортой хөгжлийн зарчмыг баримлан хэрэгжүүлж буй төрөл бүрийн санаачилга нь хоригдлуудын хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтын боломжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулдаг болохыг тогтоосон байна (UNODC, 2024).

Мөн байгальд ээлтэй, “ногоон” хорих байгууллагыг хөгжүүлэх нь урт хугацаанд хорих байгууллагын удирдлагад санхүүгийн бодит хэмнэлт бий болгодог байна. Тухайлбал, Ирланд Улсад хэрэгжүүлсэн гэрэлтүүлгийг LED системд шилжүүлэх хөтөлбөрийн үр дүнд цахилгаан эрчим хүчний хэрэглээ мэдэгдэхүйц буурч, жил бүр ойролцоогоор 265,000 еврогийн зардал хэмнэсэн бөгөөд гэрэлтүүлэгт зарцуулах цахилгаан хэрэглээ 50 хувиар буурсан байна (Irish Prison Service, Climate Action, 2023).

Үүнтэй адил Бүгд Найрамдах Малави Улсын нэгэн хорих байгууллага түлш үйлдвэрлэх зориулалттай био-задлагч (biodigester) төхөөрөмж суурилуулсны дараа түлээ болон цахилгааны зардлаас сар бүр ойролцоогоор 400 ам.доллар хэмнэж байгаа тухай мэдээлэгдсэн байна (How human waste can protect Malawi’s, 2021).

Хорих байгууллагын байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь өнөөдөр ч өндөр хэвээр байгаа бөгөөд ялангуяа байгалийн нөөцийн хэрэглээ, үүсгэж

буй хог хаягдлын хэмжээ, мөн орон нутгийн экосистемд үзүүлэх сөрөг үр дагаврын хувьд асуудал болж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Эквадор Улсад эмзэг экосистем болон уугуул иргэдийн амьжиргааны орчинд байрлах бүс нутагт хоёр том хэмжээний, өндөр хамгаалалттай хорих байгууллага барихаар төлөвлөсөн нь тухайн орон нутгийн уугуул иргэдийн байгууллагуудаас урьдчилсан зөвшилцөл авалгүй хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор өргөн хүрээний эсэргүүцэл, жагсаал цуглаан өрнөхөд хүргэсэн байна (Indigenous communities rise up against prison projects in Ecuador, 2025). Эдгээр төслүүдийн хүрээнд барилгын талбай бэлтгэх зорилгоор 74 акр талбай бүхий халуун орны хуурай ой устах аюулд өртсөн, өөрөөр хэлбэл экосистемүүдийн нэг устгагдсан тухай мэдээлэгдсэн байна. Үүнтэй төстэй байдлаар, Бүгд Найрамдах Гондурас Улсын Сван арлууд (Swan Islands)-ын нэг дээр шинэ хорих байгууллага барихаар төлөвлөсөн нь тухайн арлын хуурай газрын болон усан орчны экосистемд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн улмаас байгаль хамгаалагчид, судлаачдын ноцтой санаа зовних асуудлыг үүсгээд байна (Conservationists alarmed by plan to build prison on island reserve: "This project means quite strong environmental damage", 2024).

2025 оны гуравдугаар сард Penal Reform International болон United Nations Interregional Crime and Justice Research Institute хамтран байгаль орчинд ээлтэй, тогтвортой хорих байгууллагыг бий болгох гарын авлага боловсруулан нийтийн хүртээл болгосон бөгөөд уг баримт бичигт сайн туршлагын жишээ, мөн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын зэрэгцээ илүү эрүүл, засрал хүмүүжлийн чиг баримжаатай орчныг бүрдүүлэх бодит арга хэмжээ, хэрэгжүүлэх алхмуудыг тусгасан байна. Тус гарын авлагад хорих байгууллагууд нь их хэмжээний нүүрс төрөгчийн ул мөр (carbon footprint) үүсгэдэг ч байгаль орчны тогтвортой байдлын талаарх хэлэлцүүлэгт ихэвчлэн орхигддог болохыг онцолсон байна. Гэсэн хэдий ч хорих байгууллагууд нь байгаль орчны хамгаллын үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой бөгөөд үүнд хоригдлын шууд оролцоог хангах, сайн сайхан байдал (well-being) болон нийгэмшүүлэх боломжийг нэгтгэн хэрэгжүүлэх замаар бодит үр нөлөө бий болгож чадах юм.

Хорих байгууллагын бодлого, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмыг баримлах, нэвтрүүлэх, мөн уур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн тусгайлсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах чиглэлээр зарим улс орнууд бодит алхмууд хийж эхлээд байна. Тухайлбал, Канад Улсын Засан хүмүүжүүлэх алба (Correctional Service)-ны 2023–2027 оны тогтвортой хөгжлийн стратегид эрчим хүч, ус, хог хаягдлын хэрэглээг бууруулах арга хэмжээг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт дэвшүүлсэн байна (Penal Reform International and UN Interregional Crime and Justice Research Institute, Green Prison: A Guide to Creating Environmentally Sustainable Prisons, 2025).

Мөн Бүгд Найрамдах Кени Улсын шүүх эрх мэдлийн салбарыг “ногоонжуулах” стратегийн удирдамж нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн салбарын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон бөгөөд хорих байгууллагын үйл ажиллагааг байгальд ээлтэй болгох төлөвлөгөөг нийгэмшүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулан тусгасан байна. Шинэ санаачилгын хүрээнд хуучин хувцсыг дахин ашиглах, дахин боловсруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь байгаль орчны тогтвортой байдлыг дэмжихээс гадна олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хувь хүний нийгэмшилд эерэг нөлөө үзүүлэх зорилготой юм. Уг хөтөлбөр нь хоригдлуудад ногоон үйлдвэрлэлийн салбарт хэрэгцээтэй практик ур чадвар, мөн бизнес эрхлэлт, маркетингийн анхан шатны мэдлэг олгоход чиглэгдэж байна.

Түүнчлэн хорих байгууллагын фермийн аж ахуйг орчин үеийн техник, технологид тулгуурлан шинэчлэх, хорих анги хүнсний бүтээгдэхүүний өөрийн хэрэгцээг хангах, илүүдэл бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах боломж бүрдүүлэх зорилт дэвшүүлээд байна. Хорих байгууллагын тогтвортой хөгжлийн санаачилгуудыг, ялангуяа зэвсэгт, иргэний мөргөлдөөнд өртсөн бүс нутгуудад хүнсний хомсдолын асуудлыг шийдвэрлэхэд ашиглах боломж олон улсад судлагдаж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Өмнөд Улсад хэрэгжүүлж буй Green Corrections Initiative (Ногоон хорих байгууллагын санаачилга)-ийн хүрээнд хөдөө аж ахуйн ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж, хүнсний аюулгүй байдлыг

бэхжүүлэх, мөн хоригдлуудын хөдөө аж ахуйн салбарт ажиллах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд хорих байгууллагууд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжих, эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг нэвтрүүлэх замаар байгууллагын нүүрс төрөгчийн хор хөнөөл болон үйл ажиллагааны зардлыг бууруулах жишээ нэмэгдэж байна. Тухайлбал, Умард Ирландын Засан хүмүүжүүлэх алба бүх хорих байгууллагууддаа нарны эрчим хүчний хавтан (solar panels) суурилуулах зорилт дэвшүүлээд байгаа юм. Мөн Бүгд Найрамдах Исламын Пакистан Улсад сүүлийн үед зургаан хорих байгууллагад нарны эрчим хүчний системийг суурилуулсан бөгөөд энэ нь цахилгаан тасалдах давтамж өндөр байдаг нөхцөлд тогтвортой, санхүүгийн хувьд илүү үр ашигтай эрчим хүчний эх үүсвэрийг бий болгоход чиглэжээ. Тухайн байгууллагуудын удирдлага шинэ, найдвартай эрчим хүчний эх үүсвэр ашигласнаар:

- Хүнсний бүтээгдэхүүн, эм тариаг тасралтгүй муудгахгүйгээр хадгалах нөхцөл бүрдсэн
- Дижитал мэдээллийн удирдлагын системийг тасралтгүй, үр ашигтай ажиллуулах боломж нэмэгдсэн гэж тэмдэглэсэн байна.

Зарим улсын хорих байгууллагууд тээврийн салбартаа ч байгальд ээлтэй шинэчлэл хийж эхэлжээ. Тухайлбал, Канад Улсад 2027 он гэхэд хорих байгууллагын тээврийн хэрэгслийн дор хаяж 50 хувийг утаагүй (zero-emission) эсвэл гибрид тээврийн хэрэгслээр солих зорилт дэвшүүлсэн байна.

Гэсэн хэдий ч хорих байгууллагыг “ногоон” болгох үйл явц өргөжихийн хэрээр хорих байгууллагын шинэчлэлийн чиглэлээр судалгаа хийдэг судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд “ногоон дүр эсгэх” (greenwashing) эрсдэл бий болж болзошгүйг анхааруулж байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн байгаль орчны нэрийн дор хязгаарлагдмал, гаднах шинж чанартай арга хэмжээ хэрэгжүүлэх нь бодит тогтвортой байдлыг хангахгүй бөгөөд илүү үр дүнтэй арга зам нь:

- Хорих ял эдэлж буй хүмүүсийн тоог бууруулах
- Хорих нөхцөлийг сайжруулах
-

- Ял эдлүүлэх бодлогын цогц шинэчлэл хийх зэрэг өргөн хүрээтэй пенитенциар реформ буюу шинэчлэлийг хэрэгжүүлэх явдал болохыг онцолж байна.

Мөн зарим улсын хорих байгууллагыг “ногоожуулах” бодлого хэрэгжүүлэх явцад хүний эрхийн асуудлыг орхигдуулах эрсдэл байгааг судлаачид тэмдэглэж байна. Тухайлбал:

- Хөдөлмөрийн нөхцөл стандарт хангахгүй байх
- Шударга бус хөдөлмөрийн хөлс олгох
- Хоригдлын хөдөлмөрийг хэт ашиглах зэрэг эрсдэлүүд үүсэх магадлалтай талаар анхааруулж байна.

Хорих байгууллагын тогтвортой хөгжлийн бодлого нь зөвхөн байгаль орчны технологийн шинэчлэлээр хязгаарлагдах бус, харин хүнсний аюулгүй байдал, эрчим хүчний тогтвортой байдал, хүний эрхийн баталгаа, ял эдлүүлэх бодлогын шинэчлэл зэрэг олон талт хүчин зүйлсийг уялдуулсан институтийн цогц өөрчлөлт байх шаардлагатайг олон улсын туршлага харуулж байна.

Монгол Улсын хувьд хорих байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн шинэчлэх асуудал нь стратегийн ач холбогдолтой бөгөөд байгаль орчны хамгаалал, эрчим хүчний хэмнэлт, хүнсний аюулгүй байдал, хоригдлын хөдөлмөр эрхлэлт, нийгэмшүүлэх үйлчилгээ зэрэг олон чиглэлд бодлогын уялдаа холбоог хангах шаардлага үүсээд байна. Иймээс хорих байгууллагын тогтвортой хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох, “ногоон хорих байгууллага” концепцыг үндэсний нөхцөлд нийцүүлэн нутагшуулах нь орчин үеийн хорих ял эдлүүлэх тогтолцооны хөгжлийн чухал чиглэл болж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Indigenous communities rise up against prison projects in Ecuador. (2025, 01 22). Mongabay.

(2024). Conservationists alarmed by plan to build prison on island reserve: "This project means quite strong environmental damage". Yahoo News.

Irish Prison Service, Climate Action. (2023). Retrieved from www.irishprisons.ie/wp-content/

(2025). Penal Reform International and UN Interregional Crime and Justice Research Institute, Green Prison: A Guide to Creating Environmentally Sustainable Prisons.

Нэгдсэн Үндэсний байгууллага. (2026, 03 25). Retrieved from https://www.undp.org/mn/mongolia/sustainable-development-goals

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ПАТЕНТЫН ЭРХЭЭС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ БОЛОМЖ, ШИЙДЭЛ

POSSIBILITIES AND SOLUTIONS FOR RECOVERING PAYMENT FROM THE DEBTOR'S PATENT RIGHTS

Я.Батгэрэл. ДХИС-ийн Сургалт судалгааны 403-р анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа

Batgerel.Ya, Ph.D, Associate Professor, Colonel, Department of Civil Enforcement, School of Judicial Enforcement, Law Enforcement University of Mongolia

Товч агуулга: Өнөө үед хөрөнгийн тухай уламжлалт ойлголт өөрчлөгдөж, оюуны бүтээлч хөдөлмөрийн үр дүнд үүссэн баялаг бүтээх нь түгээмэл төдийгүй үр ашигтай болж байна. Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөнд хамаарна. Иймд патентын үндсэн ойлголт, түүний төрөл, эрх зүйн зохицуулалт, онцлогийн талаар онол, чиг хандлага, энэ

төрлийн өмчийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг судлан, түүнээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх талаар дүгнэлт, санал гаргасан болно.

Судалгааны ажилд эрх зүйн баримт бичгийг харьцуулах, нэгтгэн дүгнэх, системчлэн кодчилох аргуудыг ашиглан сэдэвт хамаарал бүхий эрдэмтдийн бүтээл, онолын сурах бичиг, өөрийн орны хууль тогтоомжийг харьцуулан судаллаа. зэрэгцээ практикт байгууллагын холбогдох ажилтнуудтай ярилцлага хийсэн санал асуулга авсан болно.

Abstract: Nowadays, the traditional concept of property has been changing, and the creation of wealth derived from intellectual and creative labor has become not only common but also highly efficient. Rights that provide benefits to their holders or grant them the authority to claim something from others, as well as intellectual values, are considered part of intangible assets.

Therefore, this study examines the fundamental concept of patents, their types, legal regulation, and specific characteristics, as well as theoretical approaches and current trends related to this form of property and its legal framework. Based on this analysis, the study identifies the challenges encountered in enforcement proceedings when recovering payments from patent rights and proposes

conclusions and recommendations aimed at improving the effectiveness of enforcement procedures.

In this research, methods such as the **comparative analysis of legal documents, synthesis, and systematic coding** were employed. Relevant scholarly works, theoretical textbooks, and the legislation of the home country related to the research topic were comparatively analyzed. In addition, interviews with relevant staff members of the institution were conducted and survey questionnaires were administered to obtain practical insights.

Түлхүүр үг: Оюуны өмчийн эрх зүй, шийдвэр гүйцэтгэгч, оюуны өмч, патентын эрх, оюуны өмчийн байгууллага, төлбөр төлөгч

Keywords: Intellectual property law, court enforcement officer, intellectual property, patent rights, intellectual property office, бebtor

Нэг. Удиртгал.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгч иргэн болон төлбөр төлөгч хуулийн этгээдийн эзэмшлийн эд хөрөнгийг битүүмжлэх, хураах, улмаар худалдан борлуулахтай холбоотой харилцааг тодорхой зохицуулсан байдаг. Тодруулбал, тухайн этгээдийн эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, мөн эдийн бус хөрөнгийг төлбөр барагдуулах зорилгоор албадан хураан авч, хуульд заасан журмын дагуу борлуулах боломжтой. Энэ хүрээнд хөдлөх хөрөнгийг ихэвчлэн үнэ хаялцуулах дуудлага худалдааны хэлбэрээр борлуулдаг бол үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг албадан дуудлага худалдааны журмаар худалдан борлуулахаар хуульчилсан байдаг. Ийнхүү дуудлага худалдаагаар борлуулсан хөрөнгийн орлогоор төлбөр төлөгчийн өр, төлбөрийг барагдуулах нөхцөлийг бүрдүүлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхээс гаргасан шийдвэр, магадлал, тогтоолыг бодит байдал дээр хэрэгжүүлэх, тэдгээрийн биелэлтийг хангах зорилготой эрх зүйн зохицуулалт бүхий үйл ажиллагаа

юм. Энэхүү ажиллагааг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд албадлагын арга хэмжээг хэрэглэж шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангадаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн

зорилго нь шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх зарчмыг бодитоор хэрэгжүүлэх, улмаар иргэн болон хуулийн этгээдийн зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг сэргээн хамгаалахад оршино.

Төлбөр төлөгчийн хөрөнгөөс төлбөр гаргуулах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх нь шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг хангах чухал механизм болдог. Энэ хүрээнд шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөрөнгийг тогтоох, битүүмжлэх, хураах, улмаар хуульд заасан журмын дагуу худалдан борлуулах зэрэг ажиллагааг явуулдаг. Тухайн хөрөнгийг борлуулснаар олсон орлогоор төлбөр авагчийн нэхэмжилсэн төлбөрийг барагдуулах боломж бүрдэж, шүүхийн шийдвэрийн биелэлт бодитоор хангагдах нөхцөл бүрддэг. Иймээс төлбөр төлөгчийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөө, үр ашигтай байдалтай шууд холбоотой чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг.

Өнөөгийн байдлаар төлбөр төлөгчийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа онолын болон практик түвшинд хангалттай судлагдсан бөгөөд “патентын эрх”-ээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар онолын түвшинд судлагдаагүй, практик хэрэгжилт хангалтгүй байгаа нь шүүхийн шийдвэрийн бодит биелэлтэд сөргөөр нөлөөлөх нэг үндэс болжээ. Энэ хүрээнд төлбөр төлөгчийн “патентын эрх”-ээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онолын үндэслэл, эрх зүйн зохицуулалтын онцлог, түүний үр нөлөөг дээшлүүлэх арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах шаардлага зүй ёсоор тавигдаж буй билээ.

Иймээс эдийн бус хөрөнгийн нэг төрөл болох “патентын эрх”-ийн талаар судалж, түүнээс төлбөр гаргуулах боломж, шийдлийг тодорхойлох, дүгнэлт-санал дэвшүүлэхэд энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Хоёр. Үндсэн хэсэг.

Патент гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, патент эзэмшигч нь тодорхой хугацаанд дараах онцгой эрхийг эдлэх эрхийг хэлнэ (Патентийн тухай хуулъ, 2021). Үүнд:

1. Патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусдад лицензийн гэрээгээр ашиглуулах;

2. Патентын эрх шилжүүлэх, өв залгамжлуулах;

3. Патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусад этгээд зөвшөөрөлгүй ашиглахаас хамгаалуулах;

4. Зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах.

Патентын эрх нь оюуны өмчийн эрх зүйн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг тодорхойлж, тэдгээрийг зохиогч, патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглахтай холбогдсон онцлог нэг төрлийн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээний цогцыг хэлнэ. Хуулийн эдгээр хэм хэмжээ нь оюуны өмчийн бусад төрлийн объектод холбогдол багатай зөвхөн тухайн төрлийн харилцааг зохицуулахад зориулагдсан байдаг. Энэ нь тухайн харилцааны зохицуулалтын онцлог арга, тусгайлсан зарчим, зорилготой холбоотой. Энэ гурван ойлголт нь нэг институтэд орж байгаа нь хоорондоо төсөөтэй тул эрх зүйн нэгдсэн хэлбэрээр, тухайлбал Патентын хуулиар хамгаалагддаг (О.Жамбалдорж, 2004).

Зохиогчийн болон патентын эрхэд хамаарах бүтээлүүд нь аль аль нь оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүн бөгөөд оюуны сэтгэлгээний хүчээр бүтээгдсэн байдаг боловч мэдэгдэхүйц ялгаатай. Шинжлэх ухаан, утга зохиолын зэрэг бүтээлийн гол үнэ цэнэ, эрх зүйн хамгаалалтын зүйл нь уран сайхны дүр, хэлбэр байдаг бол патентын бүтээлийн үнэ цэнэ нь бүтээлийн шийдлийн агуулгад оршдог.

Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар гэсэн гурван төрөл зүйлийн оюуны бүтээлийн тухайд хуулиар тодорхойлсон шалгуур, шаардлагыг хангасан нөхцөлд патент эсхүл гэрчилгээ олгох эрх зүйн үндэс бүрдэнэ гэж ойлгож болно.

Шинэ бүтээл гэдэг нь байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэх арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдэл юм (О.Жамбалдорж, 2004).

Зохиогч өөрийн бүтээлээ шинэ бүтээлийн шалгуур хангасан гэж үзэж, хүсэлт буюу мэдүүлэг гаргасныг холбогдох эрх бүхий байгууллага (оюуны өмчийн байгууллага) хүлээн зөвшөөрч, өмчлөх эрх буюу патент олгоно. Зохиогч нь эрхээ баталгаажуулсан патент гэрчилгээ авснаар өмчлөх эрх үүсдэг.

Патентын тухай хуулийн дагуу гагцхүү патент зохиогч, эзэмшигч патентыг ашиглах, худалдах зэргээр аж ахуй, үйлдвэрлэлийн эргэлтэд оруулах онцгой эрхийг эдэлдэг.

Ашигтай загвар гэж багаж, хэрэгсэл, түүнтэй адилтгах бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд хамаарах техникийн шийдлийг хэлнэ (Патентийн тухай хуулъь, 2021). Энэ нь салбарын шинжтэй, үйлдвэрлэлд нэвтрэх байдал болон шинэ шинжээрээ шинэ бүтээлтэй төстэй боловч шинэ бүтээлийн түвшинд хүрэхгүй, шинэлэг байдал нь тухайн бүтээлийн агуулгаар илэрдэг байна. Холбогдох эрх бүхий байгууллагаас (оюуны өмчийн байгууллага) тухайн бүтээлийг ашигтай загвар гэж хүлээн зөвшөөрч гэрчилгээ олгодог. Ингэснээр зохиогч бүтээлийг өмчлөх эрхтэй болно.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Патентын хамтын ажиллагааны хэлэлцээр гэж байдаг ба түүний дагуу Дэлхийн оюуны өмчийн байгууллагаар дамжуулан мэдүүлэг гаргаж, тухайн мэдүүлэгт бүртгүүлэхийг хүссэн улс орнуудыг эсхүл тухайн нэг улсыг тусгайлан зааж эрх зүйн хувьд баталгаажуулах боломж байдаг. Энэ тохиолдолд тухайн улсын оюуны өмчийн байгууллага нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд өөрийн улсын нутаг дэвсгэрт үйлчлэх патент олгодог. Патентын хамтын ажиллагааны хэлэлцээрийн механизмыг ашиглахын давуу тал нь зохиогч патент авах мэдүүлгийг нэг болон хэд хэдэн улсад бүртгүүлэхээр гаргаж болдогт оршино. Манай улсад өнөөдрийн байдлаар бүртгэлтэй байгаа патентын талаас илүү хувийг энэ механизмыг ашиглаж авсан байдаг (Н.Чинбат, Иргэний эрх зүйн лекцийн товчоон, 2014).

Бүтээгдэхүүний загвар гэж бүтээгдэхүүний гадаад харагдах байдалд хамаарах дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн уран сайхны шийдлийг хэлдэг (Патентийн тухай хуулъь, 2021). Мөн

холбогдох эрх бүхий байгууллагаас зохиогчид бүтээлийг нь бүтээгдэхүүний загвар мөн болохыг хүлээн зөвшөөрч, өмчлөх эрхтэй болохыг баталгаажуулж олгосон гэрчилгээг бүтээгдэхүүний загварын патент гэнэ.

Бүтээгдэхүүний загвар нь тухайн бүтээгдэхүүн иж бүрдэл бүтээгдэхүүн байх, эсхүл нэг бүрийн шинжээр илэрхийлэгдсэн байхаас үл хамааран Оюуны өмчийн газар бүртгүүлж, патент авсан байх ёстой.

Патентын хүчинтэй хугацаа.

Холбогдох эрх бүхий байгууллага (оюуны өмчийн байгууллага) шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентыг цаасан, эсхүл цахим хэлбэрээр олгоно. Патентын загварыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Патент нь дараах хугацаанд хүчинтэй байна. Үүнд:

1. Шинэ бүтээлийн патент анхдагч огнооноос хойш 20 жил;
2. Ашигтай загварын патент анхдагч огнооноос хойш 10 жил;
3. Бүтээгдэхүүний загварын патент анхдагч огнооноос хойш 15 жил.

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгах хугацааны хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу (25,000-120,000 төгрөг) тэмдэгтийн хураамж төлнө.

Патентыг хүчинтэй байлгах эхний таван жилийн хураамжийг патент олгосон өдрөөс хойш зургаан сарын дотор, патентыг хүчинтэй байлгах хугацааны дараагийн жилүүдийн хураамжийг тухайн патентын хүчинтэй хугацаа дуусахаас өмнө төлнө.

Патентыг хүчинтэй байлгах хугацааны хураамжийг төлөөгүй бөгөөд хугацаа сэргээлгэх хүсэлт гаргаагүй бол патент эзэмшигчийг патентын эрхээсээ татгалзсанд тооцож, эрх бүхий байгууллага (оюуны өмчийн байгууллага) патентыг хүчингүй болгох бөгөөд энэ тухай албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

Патент эзэмшигч, түүний эрх.

Патент эзэмшигч /Patent owner/ гэж патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг өмчлөх онцгой эрхийг

хуульд заасан журмын дагуу олж авсан хувь хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Патент эзэмшигч нь бүтээлийн зохиогч өөрөө, түүний өв залгамжлагч эсвэл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн ба хуулийн этгээд байна.

Патент эзэмшигчийн онцгой эрх гэдэг нь патенттай бүтээлийг түүний зөвшөөрөлгүй ашиглах, ашиглалтыг таслан зогсоох бүрэн эрхийг ойлгоно. Энэ нь энгийнээр хэлбэл патенттай бүтээлийг зөвхөн патент эзэмшигчийн зөвшөөрлөөр ашиглах ба зөвшөөрөлгүй ашиглалтыг патент эзэмшигчийн эрхийг зөрчсөнд тооцно (З.Намжил, 2000). Патент эзэмшигч дараах эрхийг эдэлнэ.

1. Патент эзэмшигч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвараа ашиглах онцгой эрх эдэлнэ

2. Патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг зөвхөн патент эзэмшигчийнх нь зөвшөөрлөөр ашиглана.

3. Патент эзэмшигч патент эзэмших эрхээ бусдад шилжүүлэх эрхтэй.

4. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, хэрэглэх болон энэ зорилгоор хадгалах, гадаадаас оруулахыг патент, гэрчилгээ эзэмшигч хориглох эрхтэй.

Патент авах эрхийг нэн түрүүнд бүтээлийн зохиогч эдэлнэ. Зохиогч өөрт нь олгогдсон патент авах эрхээ хувь хүн, хуулийн этгээдэд шилжүүлж болно. Патентыг олж авсан этгээд бүрэн эрхтэй патент эзэмшигч байна. Хэрвээ зохиогч нь анхнаасаа өөрийн нэр дээр патент авахыг хүсээгүй бол зохиогч нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг бүртгэхээс өмнө өөр этгээдийн нэр дээр патент шилжүүлэхийг хүссэн мэдүүлгийг Оюуны өмчийн газарт өгнө. Ер нь патент авах эрхийг шилжүүлэх явдал нь зохиогч болон ирээдүйн патент эзэмшигчийн хооронд байгуулсан тусгай гэрээний үндсэн дээр хэрэгждэг

Мөн патент эзэмшигчээр хэд хэдэн этгээд байж болно. Тэдний зарим нь бусдад патент эзэмших эрхээ шилжүүлж болох ба хэд хэдэн этгээд байх

нөхцөлтэй аж үйлдвэрийн өмчийн объектыг ашиглах талаарх хамтын үйл ажиллагаанд тэдгээрийн хоорондын гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр хэрэгжинэ. Ийм гэрээгүйгээр тэдний хэн нэг нь хамгаалагдсан бүтээгдэхүүнийг өөрийн үзэмжээр ашиглах, бусад эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх, лиценз өгөх эрхгүй.

Б) Барааны тэмдэг гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, верийн бараа, үйлчилгээг бусдын бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор крах ялгагдах нартай илэрхийлэл, тухайлбал тодорхой агуулаг дур буюу эдгээрийн хослон дүрсэлсэн илэрхий агуулга бүхий Барааны тэмдэг нь үйлдвэрлэгч, хэрэглэгчийг идэвхтэй холбож хэрэглэгчид Барааны чанарын талаар тодорхой ойлголт өгч байдаг. Үйлдвэрлэгч өөрийн хүндийг дээдэлж бүтээгдэхүүнийхээ чанарыг дээшлүүлэх эрмэлзэл төрүүлж байдаг.

Барааны тэмдэг нь үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний талаар сурталчилгаа явуулах, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

В) Газар зүйн заалт гэж тухайн барааны чанар, нэр хүнд, онцлог бусад шинж чанар нь түүний газар зүйн гарал үүсэлтэй салшгүй холбоотойг илэрхийлсэн, уг бараа үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн нэрийг хэлнэ. Газар зүйн заалтад тавих шаардлага, газар зүйн заалтын мэдүүлэг гаргах, газар зүйн заалтыг бүртгэх, гэрчилгээ олгох, газар зүйн заалт хэрэглэгчийн эрх, газар зүйн заалтыг ашиглах журмыг «Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай» 2003 оны хуулиар 13 тодорхойлжээ.

Г) Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах нь Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай 1967 оны конвенцод зааснаар оюуны өмчийн эрх зүйд хамаардаг. Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах асуудлыг Иргэний хууль, Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах тухай хуулиар тодорхойлжээ. Иргэний хуулийн 189-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар зах зээлд давамгайлж байгаа этгээд түүнд үйл ажиллагааных нь хүрээнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй. Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах тухай хуулиар шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах эрх зүйн механизмыг тодорхойлжээ.

Дөрөв. Патентын эрхээс төлбөр гаргуулах ажиллагаа.

Төлбөр төлөгч нь Патентын эрх эзэмшдэг бол түүнээс төлбөр гаргуулах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу зохион байгуулах боломжтой байна. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээд нь патентын эрх эзэмшдэг талаарх мэдээллийг тодруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл Оюуны өмчийн байгууллагаас мэдээлэл авах замаар төлбөр төлөгчийн патентын эрхийг дангаар болон хамтран эзэмшдэг эсэх, хэрэв уг эрхийг хамран эзэмшдэг бол хэдэн этгээд хамтран эзэмшдэг, тэдгээрийн эдлэх эрхийн хувь хэмжээг зайлшгүй тодруулах шаардлагатай болно. Түүнчлэн төлбөр төлөгчөөс патентын эрх эзэмшдэг эсэх талаар тайлбар гаргуулан авах,

Төлбөр төлөгчийн эзэмшиж буй патентын эрхийг ШШГТ хуулийн 65 дугаар зүйл[1]-д заасны дагуу албадан дуудлага худалгаагаар худалдан борлуулах шаардлагатай тул дуудлага худалдааны нийтлэг журмын дагуу битүүмжлэх, хураах ажиллагааг заавал гүйцэтгэнэ. Патентын эрхийг битүүмжлэх, хураах, үнэлүүлэх ажиллагааг ШШГТ хуульд заасан нийтлэг ажиллагааны журмаар гүйцэтгэх бөгөөд төлбөрт гаргуулах хөрөнгийг онцлогоос хамааран дараах байдлаар гүйцэтгэх боломжтой байна.

Патентын эрхийг битүүмжлэхдээ төлбөр төлөгчийг байлцуулан захиран зарцуулах эрхийг хязгаарлаж, Оюуны өмчийн байгууллагад патентын эрхийг битүүмжилсэн тухай танилцуулж захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлнэ. Түүнчлэн хамтран эзэмшигч байгаа бол тэдгээрт төлбөр төлөгчийн патентын эрхийг битүүмжилсэн талаар мэдэгдэх нь зүйтэй. Патентын эрхийг битүүмжлэх шийдвэр болон битүүмжлэх ажиллагааны тэмдэглэлд тухайн патентын эрхийн бүртгэлийн дугаар, шилжүүлэх болон ашиглах зэрэг захиран зарцуулах эрхэд тавьсан хязгаарлалт зэрэг ач холбогдол бүхий мэдээллийг тусгана.

Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд шаардлагатай бол патентын эрхийг ашиглуулснаас олох орлогыг хязгаарлаж төлбөрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлэх тухай

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д “Төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу хөрөнгийн албадан дуудлага худалдаа /цаашид "дуудлага худалдаа" гэх/-гаар худалдан борлуулна” гэж заасан.

мэдэгдэл хүргүүлнэ. Шийдвэр гүйцэтгэгч патентын эрхийг битүүмжлэхдээ “патент”-ыг эзэмшилдээ авах шаардлагатай.

Худалдан борлуулах ажиллагааг албадан дуудлага худалдааны журмаар гүйцэтгэх бөгөөд дуудлага худалдааны ялагчид патентын эрхийг шилжүүлэхдээ эрх шилжүүлэх гэрээ байгуулан гэрээг Оюуны өмчийн байгууллагад бүртгүүлнэ.

Дөрөв. Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Патентын эрхээс төлбөр гаргуулах боломжийг судлан, уг эрхээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шатыг тодорхойлон гаргасан бөгөөд судлаачийн зүгээс судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилгодоо бүрэн хүрсэн гэж дүгнэж байна.

Хэрэв төлбөр төлөгч нь патентын эрх эзэмшиж байгаа бол, шүүхийн шийдвэр гүйцэтгэх явцад тухайн патентыг албадан худалдан борлуулах замаар төлбөрийг барагдуулах боломж бүрджээ. Энэ нь хөрөнгийн уламжлалт хэлбэрээс гадна оюуны өмчийн хөрөнгийг ч төлбөр гаргуулах эх сурвалж болгон ашиглах боломжийг нээж өгдөг бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төлбөр төлөгчийн эдийн бус хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг тогтмол зохион байгуулах, энэ талаар шийдвэр гүйцэтгэгч нарт сургалт зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах шаардлагатай байна.

Тав. Санал

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн зөвхөн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах байдлаар хязгаарлахгүйгээр патентын эрхээс төлбөр гаргуулах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор дараах санал, зөвлөмжийг гаргалаа.

1. Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа төлбөр төлөгчийн патентын эрх эзэмшиж байгаа эсэхийг Оюуны өмчийн газраас тодруулж ажиллах,

2. Төлбөр төлөгч патентын эрх эзэмшиж байгаа тохиолдолд төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дээр дурдсан үе шат, арга журмын дагуу явуулах,

3. Шийдвэр гүйцэтгэгч нарт эдийн бус хөрөнгө, патентын эрхээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар сургалт зохион байгуулах.

International Practices in the Implementation of Corrective Compulsory Measures

Н.Жинжиймаа

Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэслэгч, И-мэйл: jinjiimaa.n@uia.gov.mn

Jinjiimaa Nyamdavaa, Ph.D

Associate Professor Department of Private Law School of Law and Social Sciences University of Internal Affairs, Mongolia, Email: jinjiimaa.n@uia.gov.mn,

ORCID: 0009-0009-4241-2488

Хураангуй

Хүүхэд, өсвөр үеийнхний үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн хариуцлагын тогтолцоонд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ (ХЧААХ) хэрэглэх нь ял шийтгэлийг орлуулах бус, харин түүнийг хамгийн сүүлчийн арга болгон хэрэглэх, ингэснээр хүүхдийг нийгэмд дахин дасан зохицох, зан төлөвийг засах, нийгмийн харилцаанд эергээр оролцох чадварыг төлөвшүүлэхэд чиглэсэн орчин үеийн эрүүгийн бодлогын чухал хэрэгсэл болон хөгжиж байна. Олон улсын хэмжээнд өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь ял шийтгэл бус, сэргээн засах, сэргээн тогтоох, нийгэмшүүлэх зарчимд тулгуурлан хөгжүүлэх хандлага давамгайлж, үүний бодит илрэл нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн цар хүрээ, институцийн оролцооны хэлбэрээр илэрч байна.

Энэхүү судалгаанд Герман, Норвеги, Япон, Канад, Франц зэрэг улс орнууд Өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрхэн зохицуулж, хэрэгжүүлж буй эрх зүйн загвар, институцийн хамтын ажиллагаа, хэрэгжилтийн практик, түүний үр нөлөөг харьцуулсан эрх зүйн үүднээс судаллаа. Судалгаанд сүүлийн үеийн олон улсын эрдэм шинжилгээний бүтээл, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Зөвлөл, UNICEF, UNODC зэрэг байгууллагын тайлан, бодлогын баримт бичгүүдэд тулгуурласан баримт бичгийн шинжилгээ, чанарын дүн шинжилгээний аргыг ашиглав.

Судалгааны үр дүнд дээрх орнуудын туршлагаас харахад ХЧААХ нь зөвхөн хууль зүйн арга хэмжээ бус, боловсрол, нийгмийн хамгаалал, сэтгэл зүй, орон нутгийн оролцоонд суурилсан цогц бодлогын хэрэгсэл болох нь тогтоогдож, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад бодитой нөлөө үзүүлж байгааг тодорхойлов. Эдгээр сургамжид тулгуурлан Монгол Улсад хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах, институц хоорондын уялдааг бэхжүүлэх, олон нийтийн оролцоонд суурилсан сэргээн засах загварыг нутагшуулах боломж, чиглэлийг тодорхойлон санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: хүүхдийн эрх, өсвөр үеийн шударга ёс, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, сэргээн засах, харьцуулсан эрх зүй

Abstract

The application of educational coercive measures within the system of liability for crimes and offences committed by children and juveniles has increasingly become an important instrument of modern criminal policy. Rather than replacing criminal punishment entirely, these measures aim to limit the use of punitive sanctions to a last resort. In this context, educational coercive measures are intended to facilitate the social reintegration of juveniles, correct behavioral patterns, and promote their constructive participation in social relations.

At the international level, the prevailing approach in juvenile justice systems emphasizes that educational coercive measures should not function as punitive sanctions but should instead be grounded in principles of rehabilitation, restorative justice, and social reintegration. This tendency is reflected in the legal regulation, institutional arrangements, and practical implementation of such measures across various jurisdictions.

This study examines the legal frameworks, institutional cooperation, implementation practices, and effectiveness of educational coercive measures applied to juvenile offenders in several countries, including Germany, Norway, Japan, Canada, and France. The research adopts a comparative legal approach and employs document analysis and qualitative analysis methods based on recent international academic literature as well as policy documents and reports from

international organizations such as the United Nations, the Council of Europe, UNICEF, and UNODC.

The findings indicate that educational coercive measures constitute not merely a legal response but a comprehensive policy instrument incorporating elements of education, social protection, psychological support, and community participation. These measures prioritize the protection of children's rights and interests while contributing to the reduction of recidivism among juvenile offenders. Based on the experiences of the countries examined, the study aims to identify potential directions and policy recommendations for improving the implementation of educational coercive measures in Mongolia, strengthening institutional coordination, and introducing community-based rehabilitative models.

Keywords: children's rights, juvenile justice, educational coercive measures, rehabilitation, comparative law

Оршил

Өсвөр насныхны үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн асуудал нь зөвхөн эрүүгийн эрх зүйн хүрээнд хязгаарлагдах бус, нийгэм, эдийн засаг, боловсрол, гэр бүлийн орчин, сэтгэл зүйн олон хүчин зүйлтэй нягт уялдсан цогц үзэгдэл болж байна. Иймээс орчин үеийн өсвөр насныханд холбогдох шударга ёсны бодлого нь хүүхдэд ял шийтгэл оногдуулахыг нэн тэргүүний арга гэж үзэхээс татгалзаж, хүмүүжлийн, сэргээн засах, дахин нийгэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг түлхүү хэрэглэх хандлагатай болж байна (Goldson & Muncie, 2015; Muncie, 2014).

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенц болон Бээжингийн дүрэмд хүүхдэд холбогдох аливаа эрүүгийн хэрэгт хүүхдийн эрх ашиг, хөгжлийн хэрэгцээг нэн тэргүүнд харгалзан үзэх, хорих ял болон бусад ял шийтгэлийг хамгийн сүүлчийн арга хэлбэрээр хэрэглэх зарчмыг тодорхой тусгасан байдаг (United Nations, 1985, 1989). Энэхүү олон улсын нийтлэг стандарт нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ (ХЧААХ)-г гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд оногдуулахад эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг баримтлах салшгүй бүрэлдэхүүн

хэсэг болгон хөгжүүлэх онол, практикийн үндэс болж байна (UNODC, 2018; Council of Europe, 2020).

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн хор уршгийг арилгах, хариуцлагын ухамсрыг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд дахин дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд ял шийтгэлийн формаль шинжээс илүү материаллаг, бодит үр нөлөөг чухалчилдаг онцлогтой (Bazemore & Umbreit, 2001; McCold & Wachtel, 2003). Судалгаагаар ийм арга хэмжээ авсан хүүхдийн дахин гэмт хэрэг үйлдэх магадлал харьцангуй бага байдаг нь тогтоогдсон бөгөөд энэ нь сэргээн засах болон сэргээн тогтоох шударга ёсны онолын үндэслэлийг баталгаажуулж байна (Howell, 2015; Shoemaker, 2018).

Монгол Улсын хувьд Эрүүгийн хуульд хүүхдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн зохицуулалт тусгагдсан боловч хэрэгжилтийн бодит байдал, институц хоорондын уялдаа холбоо, олон нийтийн оролцоо хангалтгүй хэвээр байгааг судлаачид онцолж байна (OECD, 2020; UNICEF, 2021). Иймээс гадаад улс орнуудын амжилттай хэрэгжүүлж буй туршлагыг харьцуулан судлах нь Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход онолын болон практикийн өндөр ач холбогдолтой болж байна.

Судалгааны арга зүй:Судалгаанд дараах аргуудыг ашиглав. Үүнд: харьцуулсан эрх зүйн арга – сонгосон орнуудын хууль тогтоомжийг харьцуулах; баримт бичгийн шинжилгээ – олон улсын байгууллагын

тайлан, бодлогын баримт бичгийг судлах; чанарын дүн шинжилгээ – хэрэгжилтийн үр нөлөө, институцийн оролцоог үнэлэх.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний онолын үндэс

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ (ХЧААХ) нь уламжлалт ял шийтгэлийн тогтолцоонд зонхилж ирсэн формаль, шийтгэх шинжийг сулруулж, хүүхдийн хөгжил, хүмүүжил, нийгэмшлийн бодит хэрэгцээнд чиглэсэн материаллаг үр дүнг чухалчилдаг онцлогтой. Өсвөр насныхны зан төлөв, сэтгэл зүйн төлөвшил нь бүрэн гүйцэд тогтоогүй,

орчны нөлөөнд автах байдал өндөр байдаг тул тэдэнд оногдуулах хариуцлага нь насанд хүрэгчдээс ялгаатай, уян хатан, хувь хүнд чиглэсэн байх шаардлагатайг криминологийн судалгаанд удаа дараа онцолж ирсэн байдаг (Shoemaker, 2018; Howell, 2015).

Энэхүү арга хэмжээний онолын үндэс нь юуны өмнө сэргээн засах (rehabilitative) онолд тулгуурладаг. Сэргээн засах онолын дагуу гэмт хэрэг үйлдэх зан төлөв нь хувь хүний ёс суртахууны доголдлоос илүүтэй нийгэм, гэр бүл, боловсрол, эдийн засгийн орчны сөрөг нөлөөтэй холбоотой гэж тайлбарладаг бөгөөд хариу арга хэмжээ нь шийтгэхэд бус, тухайн сөрөг хүчин зүйлсийг арилгах, хүүхдийн чадвар, нөөцийг хөгжүүлэхэд чиглэх ёстой гэж тайлбарладаг (Muncie, 2014; Goldson & Muncie, 2015). Иймээс ХЧААХ-ний хүрээнд сургалт-хүмүүжлийн хөтөлбөр, сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн ажилтны дэмжлэг, гэр бүлийн оролцоог хослуулан хэрэгжүүлэх нь түгээмэл байдаг.

Үүний зэрэгцээ ХЧААХ нь сэргээн тогтоох шударга ёс (restorative justice)-ны онолд суурилдаг. Энэхүү онол нь гэмт хэргийг зөвхөн хууль зөрчсөн үйлдэл бус, харин хохирогч, нийгэм, гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хоорондын харилцааг эвдсэн үйл явц гэж тайлбарладаг бөгөөд түүнийг сэргээх, эвлэрүүлэх, хариуцлагын ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэдэг (Bazemore & Umbreit, 2001; McCold & Wachtel, 2003). Судалгаагаар сэргээн тогтоох арга хэмжээнд хамрагдсан өсвөр насныхан үйлдлийнхээ хор уршгийг ухамсарлах, хохирогчийн байр суурийг ойлгох, цаашид хууль зөрчихөөс зайлсхийх хандлага илүү өндөр байдаг нь нотлогдсон байна (UNODC, 2018; Tyler, 2006).

Олон улсын эрх зүйн түвшинд ч ХЧААХ-ний онолын суурийг дэмжсэн зарчим, стандартууд тогтсон. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Бээжингийн дүрэм, Эр-Риядын удирдамжид өсвөр насныханд хорих ял, хатуу шийтгэл оногдуулахыг хамгийн сүүлчийн арга гэж үзэх, оронд нь хүмүүжлийн болон нийгэмшүүлэх шинжтэй арга хэмжээг түлхүү хэрэглэхийг зөвлөмж болгосон байдаг (United Nations, 1985, 1990). Мөн Хүүхдийн эрхийн конвенцод хүүхдийн эрх ашиг, хөгжлийн хэрэгцээг нэн тэргүүнд тавих зарчим нь ХЧААХ-ний онолын суурийг олон улсын хэмжээнд баталгаажуулж байна (United Nations, 1989).

Иймээс ХЧААХ нь дан ганц эрүүгийн эрх зүйн институт бус, харин криминологи, нийгмийн бодлого, хүүхэд хамгааллын салбарын огтлолцолд орших, урьдчилан сэргийлэх болон дахин нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий цогц арга хэмжээ гэж үзэх онолын үндэслэл бүрдэж байна. Энэ нь илүү хүний эрхэд суурилсан, үр нөлөөтэй, тогтвортой болгох боломжийг бүрдүүлдэг (Council of Europe, 2020; OECD, 2020).

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний үндэсний эрх зүйн зохицуулалт

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад өсвөр насны этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хариу үзүүлэхдээ шийтгэхээс илүү хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг чухалчлах хандлага давамгайлж байна (Muncie, 2014; Shoemaker, 2018). Ийм хандлага нь өсвөр үеийн шударга ёсны тогтолцоонд хүүхдийн эрхийг хамгаалах, хорих ялыг зөвхөн зайлшгүй шаардлагатай нөхцөлд буюу хамгийн сүүлчийн арга хэлбэрээр хэрэглэх олон улсын эрх зүйн зарчимтай нийцдэг (United Nations, 1985; United Nations, 1989).

Монгол Улсад өсвөр насны этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, мөн Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжид тулгуурлан хэрэгжиж байна. Эдгээр хууль тогтоомж нь өсвөр насны этгээдийн нас, сэтгэл зүйн онцлог, нийгмийн нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлд өсвөр насны этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг тодорхойлсон байдаг. Энэ арга хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг шийтгэхээс илүүтэй зан төлөвийг засах, нийгмийн харилцаанд дахин дасан зохицох, боловсрол эзэмших боломжийг дэмжихэд чиглэдэг (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015, 8.7 дугаар зүйл).

Тус зүйлд зааснаар өсвөр насны этгээдэд дараах төрлийн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх боломжтой. Үүнд:

- Эцэг, эх эсхүл асран хамгаалагчийн хараа хяналтад шилжүүлэх;
- Зан үйлийн тодорхой хязгаарлалт тогтоох;
- Сургалт, хүмүүжлийн хөтөлбөрт хамруулах;
- Нийгэмд тустай ажил гүйцэтгүүлэх.

Өсвөр насны этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан зохицуулж, хүүхдийн эрхийг хамгаалах процессын баталгааг тогтоосон байдаг. Тухайлбал, насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхдээ өмгөөлөгчийн оролцоог заавал хангах, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийн оролцоог хангах зэрэг хүүхдэд ээлтэй процессын зохицуулалтыг тусгасан байна.

Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хууль нь хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс хамгаалах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлдог. Энэ нь өсвөр насны этгээд гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн нийгмийн болон орчны хүчин зүйлсийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Гэсэн хэдий ч практикт өсвөр насны этгээдэд оногдуулж буй эрүүгийн хариуцлагын арга хэмжээг авч үзэхэд ялын хэрэглээ харьцангуй давамгай хэвээр байгааг зарим судалгаанд дурдсан байдаг (UNICEF, 2021). Энэ нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэглээ практикт хангалттай түвшинд хэрэгжихгүй байгааг илтгэж байна.

Иймээс өсвөр насны этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгохын тулд шүүхийн практикт хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг илүү өргөн хэрэглэх, нийгмийн үйлчилгээний байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоотой уялдсан цогц бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гадаад орны туршлага ба Монгол Улсад хэрэгжүүлэх боломж

Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт хүлээлгэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ (ХЧААХ)-ийг үр нөлөөтэй хэрэгжүүлж буй гадаад улс орнуудын туршлагаас харахад эдгээр арга хэмжээ нь зөвхөн эрүүгийн эрх зүйн хүрээнд хязгаарлагдахгүй, боловсрол, нийгмийн хамгаалал, орон нутгийн оролцоо, сэргээн тогтоох шударга ёсны зарчимд тулгуурласан олон салбарыг хамарсан бодлогын цогц механизм хэлбэрээр хөгжиж байна. Ийм цогц хандлага нь өсвөр насныханд ял шийтгэл оногдуулахыг хамгийн сүүлчийн арга болгон хязгаарлаж, тэднийг нийгэмд дахин дасан зохицох, хариуцлагын ухамсар төлөвшүүлэхэд чиглэсэн хүмүүжлийн арга хэмжээг нэн тэргүүнд тавьж байгаагаараа онцлогтой юм.

Герман Улсад өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэс нь өсвөр үеийн шүүхийн тухай хууль (Jugendgerichtsgesetz)-д суурилдаг. Энэхүү хууль тогтоомж нь өсвөр насныханд оногдуулах хариуцлагыг ял шийтгэлийн формаль шинжээс илүү хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэх бодит үр дүнд чиглүүлдэг онцлогтой. Тухайлбал, нийгэмд тустай ажил гүйцэтгүүлэх, сургалт-хүмүүжлийн болон зан төлөв засах хөтөлбөрт хамруулах, эвлэрүүлэн зуучлалын арга хэмжээг өргөн хэрэглэх боломжийг хуульчилсан бөгөөд хорих ялыг зөвхөн онцгой нөхцөлд хэрэглэдэг.

Эдгээр арга хэмжээг орон нутгийн нийгмийн үйлчилгээний болон боловсролын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлдэг бөгөөд ингэснээр хүүхдийг нийгмээс тусгаарлах бус, харин нийгмийн эерэг орчинд дасан зохицох боломжийг хадгалж, хариуцлага, сахилга бат, хамтын ажиллагааны ур чадварыг төлөвшүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Судалгааны дүнгээс харахад Германд хүмүүжлийн шинжтэй арга хэмжээ авсан өсвөр насныхны дахин гэмт хэрэг үйлдэх түвшин хорих ял эдэлсэн хүүхдүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц бага байгаа нь энэхүү

загварын бодит үр нөлөөг илтгэж байна (Hazel, 2008; Goldson & Muncie, 2015). Ийм нийгэмд суурилсан хүмүүжлийн арга хэмжээний загвар нь Монгол Улсад нийгмийн үйлчилгээний байгууллагын оролцоог нэмэгдүүлэх замаар хэрэгжүүлэх боломжтой туршлага гэж үзэж болно.

Норвеги Улсад өсвөр насныханд холбогдох хэргийн шийдвэрлэлд сэргээн тогтоох шударга ёсны зарчимд тулгуурласан арга хэмжээг өргөн хэрэглэдэг. Тус улсад “Conflict Council” буюу эвлэрүүлэн зуучлах

зөвлөлийн тогтолцоо үйл ажиллагаа явуулж, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны этгээд, хохирогч, тэдний гэр бүл болон орон нутгийн төлөөллийг хамруулсан уулзалтыг зохион байгуулдаг. Энэ уулзалтын үеэр гэмт хэргийн хор уршгийг хамтаар хэлэлцэх, хариуцлага хүлээлгэх, харилцааг сэргээх үйл явцыг нийгмийн түвшинд хэрэгжүүлдэг.

Энэхүү механизм нь хүүхдэд үйлдлийнхээ нийгмийн үр дагаврыг ухамсарлуулахын зэрэгцээ хохирогчийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн эв нэгдлийг сэргээх давхар зорилготой. Судалгаагаар ийм арга хэмжээнд хамрагдсан өсвөр насныхны дахин гэмт хэрэг үйлдэх магадлал буурч, нийгэмд дасан зохицох чадвар сайжирдаг болохыг тогтоосон байна (Norwegian Ministry of Justice and Public Security, 2014; UNODC, 2018). Ийм төрлийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо нь Монгол Улсад сэргээн тогтоох шударга ёсны механизмыг хөгжүүлэхэд хэрэгжүүлэх боломжтой туршлагын нэг юм.

Канад Улсад Өсвөр үеийн эрүүгийн шударга ёсны тухай хууль (Youth Criminal Justice Act)-ийн хүрээнд өсвөр насныхныг шүүхийн албан ёсны процессоос аль болох зайлсхийлгэх, орон нутгийн түвшинд асуудлыг шийдвэрлэх бодлогыг баримталдаг. Жижиг, дунд зэргийн зөрчил үйлдсэн өсвөр насныхныг зөвлөгөө өгөх төв, сэтгэл зүйн дэмжлэгийн хөтөлбөр, залуучуудын хөгжлийн клуб зэрэг нийгэмд суурилсан үйл ажиллагаанд хамруулснаар тэднийг “гэмт хэрэгтэн” хэмээн шошголохоос сэргийлж, нийгэмд эергээр дахин нэгтгэх боломжийг бүрдүүлдэг.

Энэхүү загвар нь төрийн зардлыг бууруулахын зэрэгцээ урт хугацаанд тогтвортой үр дүн бий болгодог болохыг судалгаанууд харуулж байна (Canadian Department of Justice, 2019; Zimring, 2005). Ийм орон нутгийн оролцоонд суурилсан хөтөлбөрүүдийг Монгол Улсад хөгжүүлэх

нь өсвөр насныхны нийгэмд эергээр дасан зохицох үйл явцыг дэмжихийн зэрэгцээ дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой юм.

Япон Улсад өсвөр насныханд холбогдох хэрэгт гэр бүлийн оролцоог онцгойлон чухалчилдаг. Тус улсын Гэр бүлийн шүүх нь өсвөр насныхны хэрэгт шийдвэр гаргахдаа хүүхдийн зан төлөв, гэр бүлийн орчин, боловсролын нөхцөл байдлыг иж бүрэн үнэлж, эцэг, эхэд хүүхдийн

хүмүүжилд идэвхтэй оролцох үүрэг хүлээлгэх, зөвлөгөө, сургалтад хамруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг. Соёлын хүчин зүйлийг харгалзан үзсэн энэхүү хандлага нь хүүхдийн хариуцлагын ухамсрыг гэр бүлийн орчинд төлөвшүүлэхэд чиглэдэг бөгөөд Монголын уламжлалт гэр бүлийн харилцааны онцлогтой тодорхой хэмжээгээр нийцэх боломжтой туршлага гэж үзэж болно (Cunneen & Goldson, 2015; Muncie, 2014).

Франц Улсад өсвөр насныханд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих зарчимд тулгуурладаг. Шүүхийн хяналтыг хадгалсан хэвээр нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн дэмжлэгтэйгээр хүмүүжлийн арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү “хяналттай дэмжлэг”-ийн загвар нь хүүхдийг нийгмээс тусгаарлахгүйгээр эрсдэлтэй зан төлөвийг тогтмол хянах, засах боломж олгодог давуу талтай (Council of Europe, 2010; Goldson, 2013).

Ийнхүү гадаад улс орнуудын туршлагаас харахад өсвөр насныханд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгэмд суурилсан үйлчилгээ, орон нутгийн оролцоо, гэр бүлийн дэмжлэг, сэргээн тогтоох шударга ёсны механизм зэрэг олон хүчин зүйлс чухал үүрэгтэй байдаг. Эдгээр туршлага нь Монгол Улсад өсвөр насныханд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын бодлогыг боловсронгуй болгох, хүмүүжлийн шинжтэй арга хэмжээг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаанд өсвөр насны этгээдэд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх гадаад улс орнуудын эрх

зүйн зохицуулалт, хэрэгжилтийн туршлагыг харьцуулан шинжилсний үндсэн дээр хэд хэдэн чухал асуудлыг тодорхойлох боломжтой байна.

Нэгдүгээрт, судалгаанд хамрагдсан улс орнуудын нийтлэг шинж нь өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхдээ шийтгэхээс илүүтэй хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх чиг баримжааг баримталж байгаа явдал юм. Германд өсвөр үеийн шүүхийн тогтолцоо нь

ял шийтгэлийг хамгийн сүүлчийн арга хэлбэр болгон хэрэглэх зарчимд тулгуурлаж, нийгэмд суурилсан хүмүүжлийн арга хэмжээг түлхүү ашигладаг (Hazel, 2008; Goldson & Muncie, 2015). Ийм арга хэмжээ нь өсвөр насныхны зан төлөвийг засах, нийгмийн харилцаанд дахин дасан зохицох боломжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг болохыг олон улсын судалгаанууд баталсан байдаг (Howell, 2015).

Хоёрдугаарт, сэргээн тогтоох шударга ёсны зарчимд суурилсан механизм нь өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгтэй тэмцэхэд үр нөлөөтэй арга хэрэгсэл болох нь Норвегийн туршлагаас тодорхой харагдаж байна. Норвегийн “Conflict Council” тогтолцоо нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны этгээд, хохирогч болон орон нутгийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийн замаар хариуцлагын ухамсрыг төлөвшүүлэх, нийгмийн харилцааг сэргээх боломжийг бүрдүүлдэг (Norwegian Ministry of Justice and Public Security, 2014; UNODC, 2018). Энэ нь гэмт хэргийн үр дагаврыг зөвхөн эрх зүйн хүрээнд бус, нийгмийн харилцааны түвшинд шийдвэрлэх боломжийг бий болгодог.

Гуравдугаарт, өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод орон нутгийн оролцоо, нийгмийн үйлчилгээний тогтолцоо чухал үүрэгтэй болох нь Канадын туршлагаас харагдаж байна. Канад Улсад өсвөр насныхныг шүүхийн албан ёсны процессоос аль болох зайлсхийлгэх, орон нутгийн түвшинд асуудлыг шийдвэрлэх бодлогыг баримталдаг бөгөөд зөвлөгөө өгөх төв, сэтгэл зүйн дэмжлэгийн хөтөлбөр, залуучуудын хөгжлийн клуб зэрэг нийгэмд суурилсан арга хэмжээг өргөн хэрэглэдэг (Canadian Department of Justice, 2019; Zimring, 2005). Ийм арга хэмжээ нь өсвөр насныхныг нийгмээс тусгаарлах бус, харин нийгэмд дахин нэгтгэх боломжийг нэмэгдүүлдэг давуу талтай.

Дөрөвдүгээрт, гэр бүлд суурилсан хүмүүжлийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой болохыг Японы туршлага харуулж байна. Япон Улсад гэр бүлийн шүүх нь хүүхдийн зан төлөв, гэр бүлийн орчин, боловсролын нөхцөл байдлыг иж бүрэн үнэлсний үндсэн дээр эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх, зөвлөгөө, сургалтад хамруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг

(Cunneen & Goldson, 2015; Muncie, 2014). Энэ нь өсвөр насныхны зан төлөвийг засахад гэр бүлийн оролцоо чухал нөлөөтэйг харуулж байна.

Түүнчлэн Францын туршлагаас харахад шүүхийн хяналттай боловч нийгмийн үйлчилгээний байгууллагын оролцоонд тулгуурласан "хяналттай дэмжлэг"-ийн загвар нь өсвөр насны этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр зан төлөвийн өөрчлөлтийг дэмжих үр нөлөөтэй арга механизм болж байна (Council of Europe, 2010; Goldson, 2013).

Эдгээр туршлагыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзвэл, Монгол Улсын Эрүүгийн хуульд өсвөр насны этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх боломжийг хуульчилсан боловч практикт ялын хэрэглээ харьцангуй давамгай хэвээр байгааг зарим судалгаанд дурдсан байдаг (UNICEF, 2021). Энэ нь өсвөр насныханд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын үндсэн зорилго болох нийгэмшүүлэх, зан төлөвийг засах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх бодлогын хэрэгжилт төдийлөн хангалттай түвшинд хүрээгүй байгааг илтгэж байна.

Иймээс гадаад улс орнуудын туршлагаас харахад өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого нь зөвхөн эрүүгийн эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй, харин боловсрол, нийгмийн хамгаалал, сэтгэл зүйн дэмжлэг, орон нутгийн оролцоог хамарсан олон салбарын уялдаа холбоонд тулгуурласан байх шаардлагатай байна. Ийм цогц хандлагыг Монгол Улсад хэрэгжүүлэх нь өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх, улмаар дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Дүгнэлт, бодлогын зөвлөмж

Энэхүү судалгаанд гадаад улс орнуудын Өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ (ХЧААХ)-ний эрх зүйн зохицуулалт, институцийн бүтэц, хэрэгжилтийн практик, үр нөлөөг харьцуулан шинжилсний үндсэн дээр Монгол Улсад нутагшуулах онолын болон бодлогын ач холбогдол бүхий хэд хэдэн дүгнэлтийг гаргав.

Нэгдүгээрт, судалгааны үр дүнгээс харахад ХЧААХ нь өсвөр насныханд ял шийтгэл оногдуулах уламжлалт хандлагыг халж, хүүхдийн эрх ашиг, хөгжлийн хэрэгцээг нэн тэргүүнд тавьсан, сэргээн засах болон дахин нийгэмшүүлэх чиг баримжаатай орчин үеийн эрүүгийн бодлогын гол бүрэлдэхүүн хэсэг болж байна. Герман, Норвеги, Канад, Япон, Франц зэрэг орны туршлагаас үзэхэд хүмүүжлийн шинжтэй, нийгэмд суурилсан арга хэмжээ нь дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах, нийгмийн зардлыг хэмнэх, хүүхдийн нийгэмшилд эерэг үр нөлөө үзүүлэх давуу талтай болох нь эмпирик судалгааны үр дүнгээс харахад баталгаажсан байна (Howell, 2015; Shoemaker, 2018; OECD, 2020).

Хоёрдугаарт, ХЧААХ-ийн үр нөлөө нь зөвхөн хууль тогтоомжийн заалтаас бус, институц хоорондын уялдаа холбоо, олон нийтийн оролцоо, мэргэжлийн хүний нөөцийн чадавхаас ихээхэн хамааралтай болох нь тогтоогдлоо. Олон улсын туршлагаас харахад шүүх төвтэй болон олон нийтийн оролцоонд суурилсан загварууд нь харилцан нөхөх байдлаар уялдсан тохиолдолд илүү тогтвортой үр дүнд хүрч байна (Goldson & Muncie, 2015; UNODC, 2018). Энэ нь Монгол Улсад ХЧААХ-ийг хэрэгжүүлэхдээ салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг бодлогын түвшинд системтэйгээр шийдвэрлэх шаардлагатайг илтгэж байна.

Дээрх дүгнэлтэд тулгуурлан дараах бодлогын зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

Нэгд, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлд ХЧААХ-ийг хэрэглэх шалгуур, төрөл, хэрэгжилтийн хугацаа, хяналт-шинжилгээний механизмыг илүү тодорхой болгох шаардлагатай. Ингэснээр хууль хэрэглээний жигд бус байдлыг багасгаж, хүүхдийн эрхийг хамгаалах баталгааг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ (Council of Europe, 2020; UNICEF, 2021).

Хоёрт, өсвөр үеийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон талт мэргэжлийн багийн (multi-disciplinary team) тогтолцоог институцийн түвшинд нэвтрүүлэх нь зүйтэй. Шүүх, прокурор, цагдаа, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, боловсролын байгууллагын төлөөллийг хамарсан энэхүү загвар нь хүүхдийн хэрэгцээнд нийцсэн, хувь хүнд чиглэсэн шийдэл

боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй нөхцөлийг бүрдүүлнэ (Howell, 2015; Goldson, 2013).

Гуравт, сэргээн тогтоох шударга ёсны зарчимд суурилсан олон нийтийн оролцоотой хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай. Эвлэрүүлэн зуучлал, олон нийтийн зөвлөл, орон нутгийн дэмжлэгийн механизм нь Монголын уламжлалт нийгмийн харилцаанд нийцэх боломжтой бөгөөд өсвөр насныхны хариуцлагын ухамсрыг төлөвшүүлэхэд онцгой ач холбогдолтой (Bazemore & Umbreit, 2001; UNODC, 2018).

Дөрөвт, ХЧААХ-ийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх үндэсний хэмжээний судалгаа, мониторингийн тогтолцоог бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай. Өгөгдөлд суурилсан бодлого боловсруулах нь өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжих тогтвортой байдлыг хангах, нөөцийг оновчтой хуваарилахад чухал үүрэг гүйцэтгэнэ (Zimring, 2005; OECD, 2020).

Эцэст нь дүгнэхэд, Монгол Улсад хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хөгжүүлэх нь эрүүгийн бодлогын хүрээнд хийгдэх салангид шинэчлэл бус, харин хүүхэд хамгаалал, боловсрол, нийгмийн бодлоготой уялдсан цогц реформ байх ёстой. Ийм реформ нь олон улсын хүний эрхийн стандарттай нийцсэн, урт хугацаанд тогтвортой, шинжлэх ухааны үндэслэлтэй Өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна (United Nations, 1989; Council of Europe, 2020; UNICEF, 2021).

Ашигласан материал

Үндэсний эрх зүйн эх сурвалж

Хууль тогтоомж

-

- Монгол Улсын Эрүүгийн хууль. (2015). Эрүүгийн хууль. Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.
- Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. (2017). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.

- Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль. (2016). Хүүхэд хамгааллын тухай хууль. Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.

Олон улсын эрх зүйн эх сурвалж

- Bazemore, G., & Umbreit, M. (2001). A comparison of four restorative conferencing models. Juvenile Justice Bulletin.

- Canadian Department of Justice. (2019). Youth Criminal Justice Act: Summary and background. Government of Canada.

- Cavadino, M., & Dignan, J. (2013). The penal system: An introduction (5th ed.). SAGE Publications.

- Council of Europe. (2010). Guidelines on child-friendly justice. Council of Europe Publishing.

- Council of Europe. (2020). Child-friendly justice guidelines. Council of Europe Publishing.

- Cunneen, C., & Goldson, B. (2015). Decriminalizing youth justice. Palgrave Macmillan.

- Goldson, B. (2013). Unsafe, unjust and harmful to wider society: Grounds for raising the minimum age of criminal responsibility. Youth Justice, 13(2), 111–130.

- Goldson, B., & Muncie, J. (2015). Youth crime and justice (2nd ed.). SAGE Publications.

- Hazel, N. (2008). Cross-national comparison of youth justice. Youth Justice Board for England and Wales.

- Howell, J. C. (2015). Preventing and reducing juvenile delinquency (2nd ed.). SAGE Publications.

- McCold, P., & Wachtel, T. (2003). In pursuit of paradigm: A theory of restorative justice. Restorative Practices E-Forum.

- Muncie, J. (2014). Youth and crime (4th ed.). SAGE Publications.

- Norwegian Ministry of Justice and Public Security. (2014). Mediation and reconciliation in criminal cases. Government of Norway.

ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭН ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ХОРИГДЛЫН НИЙГЭМШИЖ БУЙ БАЙДАЛ

THE SOCIAL REINTEGRATION STATUS OF INMATES SERVING SENTENCES FOR RAPE OFFENSES

М.Даваабат. Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, хошууч

Davaabat.M. Major, Senior Lecturer, Department of Enforcement of Court Decisions Administration and Strategy, Academy of Management, University of Internal Affairs

Хураангуй: Судлаачдын зүгээс хүчиндэх гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа хоригдлын нийгэмшиж буй өнөөгийн байдалд шинжилгээ хийх зорилгоор нээлттэй, хаалттай 6 хорих ангийн 122 алба хаагч, хүчиндэх гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа 323 хоригдлоос судалгаа авч өгөгдлийг SPSS 26 программ хангамжаар шинжлэн судалж, хоригдлын нийгэмшиж буй байдлыг эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудлыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад тулгуурлан дүгнэлт санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Abstract: The present study aimed to analyze the current state of socialization among inmates serving prison sentences for the crime of rape. For this purpose, data were collected from 122 correctional officers and 323 inmates convicted of rape across six open and closed correctional facilities. The collected data were processed and analyzed using the SPSS 26 software package. Based on the identified legal framework, prevailing challenges, and the need to enhance existing mechanisms, the study sought to formulate evidence-based conclusions and recommendations to improve the social reintegration process of these offenders.

Түлхүүр үг: Үндсэн хууль, төрийн бодлого, хоригдол, нийгэмшүүлэх ажил, хорих байгууллага, нийгмийн ажил, боловсрол, сургалт, хууль, хүчиндэх гэмт хэрэг

Key words: Constitution, public policy, prisoner, socialization work, penitentiary institution, social work, боловсрол, training, law, the crime of rape

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг

хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гээд гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцохгүй харин гэм буруутай нь нотлогдсон тохиолдолд Эрүүгийн хуулиар эрүүгийн хариуцлага буюу ял зэмлэлийг эдлүүлэх асуудлыг заасан (Төрийн мэдээлэл, 1992). Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу эрүүгийн ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнд зэмлэлийг эдлүүлэх буюу цээрлүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх буюу нийгэмшүүлэхэд чиглэгдэж байна.

Монгол Улсад 1996 оноос хүүхэд хамгаалал, 1999 оноос боловсрол, 2000 оноос хороо, 2003 оноос хорих байгууллагын, 2007 оноос халамж, 2008 оноос эрүүл мэндийн салбарын нийгмийн ажилтан бий болон өөр өөрсдийн онцлогийг тусган хөгжиж ирсэн байна (Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, 2014). Хорих байгууллагын “нийгмийн ажил” гэсэн нэр томьёо, ойлголт хууль зүйн салбарт бий болоод 20-оод жил болсон цаг хугацаанд нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт, нийгмийн ажлын заавар, нийгэмшүүлэх хөтөлбөр зэрэг эрх зүйн бичиг баримт боловсрогдон гарч хэрэгжиж байгаа билээ.

ШШГТХ-д “хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”, “хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах” талаар хуульчилсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүчиндэх гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа 2021 онд 795, 2022 онд 914, 2023 онд 1044, 2024 онд 1164 хоригдол ял эдэлсэн байна (Хорих ял эдлүүлэх алба, 2021-2024).Түүнчлэн хүчиндэх гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа хоригдлууд нь сүүлийн 4 жилийн хугацаанд нийт хорих ял эдлэгсдийн 20-30 орчим хувийг

эзэлж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг нарийвчлан судлах нь зүйтэй гэж үзсэн.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулж, хуулиар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд ял эдлүүлэх нь чухал боловч өнөө үед тухайн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, сөрөг зан үйлийг засах, улмаар нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

Үндсэн хэсэг

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд эрүүгийн хариуцлага, ялын бодлогын үзэл баримтлалдаа тусган, хэрэгжүүлж буй үндсэн асуудал нь хорих ял шийтгэгдсэн хүнийг цээрлүүлэх, нийгэмшүүлэх, суллахад бэлтгэх замаар дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгчид еэрэг нөлөөлөл үзүүлэн амьдралын зөв хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байна.

Хорих байгууллагад зохион байгуулах сургалтыг сайн дурын үндсэн дээр зохион байгуулахаас гадна албадан сургалт хэлбэртэйгээр ганцаарчилсан, бүлгийн, нийтэд чиглэсэн байдлаар хөдөлмөртэй хослуулан зохион байгуулахыг нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалтад заасан. Энэхүү эрх зүйн зохицуулалтын хүрээнд хорих байгууллын нийгмийн ажилтан хоригдлын сэтгэл зүй, хувийн онцлогийг танин мэдэх замаар хүн бүрд тохирсон сургалт, хүмүүжлийн ажлыг зохиож нийгэмшүүлэх зорилгыг хангах учиртай. Хоригдлын авир араншныг хэрхэн танин мэдэхээс нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хөдөлмөр, дэглэм, сургалт, боловсрол олгох ажлын үр нөлөө шууд шалтгаалдаг (П.Баярбаатар, 2024, хууд. 54).

Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааг ШШГЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/269 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн ажлын заавар”, ШШГЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын

22-ны өдөр А/207 дугаар тушаалаар “Хорих ял эдлүүлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30 өдрийн А/167 А/233 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хоригдлыг суллахад бэлтгэх нийгэмшүүлэх хөтөлбөр”-ын хүрээнд зохион байгуулж байна.

Хэрэгжиж буй эрх зүйн зохицуулалтаас үзэхэд хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг хууль, журам, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж буй хэдий ч хэтэрхий ерөнхийлсөн, хоригдлын хувийн ялгаатай байдал, үйлдсэн гэмт хэргийн онцлогт тохируулан нийгэмшүүлэх асуудлыг журам, заавар, хөтөлбөрийн хүрээнд нарийвчлан зохицуулаагүй орхигдуулсан гэж үзэж болохоор байна.

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажил нь эрүүгийн ялын зорилгыг хангах, хоригдлыг нийгэмд эргэн зөв амьдрах төлөвшлийг бий болгоход чиглэсэн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, ёс зүй, хөдөлмөрийн дадал, хүмүүжил олгох, хууль, дэг журмыг хэвшүүлэх үйл ажиллагаа юм. Хорих ангийн нийгмийн ажил нь сургалт, хөдөлмөр эрхлэлт, ахуй нөхцөл, эрүүл мэндийн асуудал хамаардаг бөгөөд хоригдолд явуулах сургалт нь тэднийг бичиг үсэг сургахаас эхлээд ерөнхий боловсрол, мэргэжил-сургалт үйлдвэрлэлийн чиглэлийн боловсрол, мэргэжил олгох, эрх зүй, ардын уламжлалт зан үйл, бие даан амьдрах хэв маягт сургах хэлбэрээр зохион байгуулдаг.

Нийгэмшүүлэх ажил нь нэг талаас нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн хүн, нөгөө талаас нийгмийн төгөлдөр бус байдал буюу улс төр, эдийн засгийн тогтворгүй нөхцөл, ажилгүйдэл, архидалт, тааламжгүй гэр бүлийн орчин, сөрөг нөлөө үзүүлэгчид, сурган хүмүүжүүлэх ажиллагаа дутагдсан, амьдралын бэрхшээлээс гарахад нь туслаагүй, хувь хүний бие сэтгэл зүйн хөгжил тэр ч бүү хэл байгалийн сөрөг үзэгдлийн хохирогч болсон хүний бэрхшээлийг даван туулахад нь чиглэгдсэн цогц үйл ажиллагааны үр дүн гэж үздэг (П.Баярбаатар, 2024, хууд. 121).


Иймд хүчиндэх гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдолд зориулсан тусгай хөтөлбөрүүд нь тэдний нийгэмшил, боловсрол, мэргэжил олгох, сэтгэл зүйн дэмжлэг зэрэг олон талын шаардлагыг хангах зорилготой байдаг. Хоригдолд явуулах тусгай хөтөлбөр нь нийгэмд амьдрах амьдралын чанарыг сайжруулах, нийгэмд эргэн орох боломжийг нэмэгдүүлж дахин гэмт хэрэг үйлдэх урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин эрх зүйн боловсрол олгодог үр дүнтэй үйлчилгээ юм.

ШШГБ-ын хэмжээнд хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, дахин нийгэмшүүлэх, мэргэжлийн боловсрол сургалтад хамруулах ажлыг зохион

байгуулах чиглэлээр “Шинээр ирсэн хоригдолд зохион байгуулах сургалтын хөтөлбөр (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2023)”-ийн дагуу хорих ангид шинээр ирсэн хоригдолд хууль, эрх зүйн сургалтыг зохион байгуулж, тэдний сэтгэл зүйд эерэг нөлөөлөл үзүүлэхүйц сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч хорих ангиуд нь “Хорих ял эдлүүлэх үеийн сургалтын хөтөлбөр (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2021)”-ийн сургалт, суурь боловсрол олгох, бичиг үсгийн болон мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж байна.

Хоригдолд мэргэжил эзэмшүүлэх сургалтыг барилгын засал чимэглэлчин, цахилгаанчин, гагнуурчин, тогооч, мужаан, сантехникч, бетон арматурчин мэргэжлийн боловсрол олгох сургалт, мөн барилгын сантехникч, засал чимэглэлчин, өрөг угсрагч, цахилгаанчин, мужаан, гагнуурчин, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, тогооч, керамик эдлэл урлаач, арьсаар гар урлалын зүйл урлаач, автомашины засварчин, гутлын үйлдвэрийн технологийн ажилтан мэргэжлээр мэргэжлийн сургалтыг зохион байгуулж, суралцагчдад чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэхийг (Хорих ял эдлүүлэх алба, 2024) олгож байна.

ШШГЕГ-ын хэмжээнд 2021-2024 оны байдлаар нийт 16313 хоригдол хорих ял эдэлснээс сүүлийн 4 жилийн хугацаанд нийгэмшүүлэх ажлын хүрээнд 1143 буюу 7 хувьд мэргэжлийн үнэмлэх, 1683 буюу 10.3 хувьд нь чадамжийн гэрчилгээ олгосон бол суурь боловсролын сургалтад 234 буюу 1.4 хувь, бичиг үсгийн сургалтаар 793 хоригдол буюу 4.8 хувийг уншиж бичиж сургасан байна. Дээрх сургалтын үйл ажиллагаа нь нийт ял эдлэгсдийн 23.6 хувьд хүрч бусад 70-76 хувьд төдийлөн хүрэхгүй байна гэж үзэж болох юм.




Зураг 1. Хоригдлын сургалтад хамрагдсан байдлын судалгаа

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын боловсролын байдлыг 2021-2024 оны хэмжээнд авч үзэхэд дээд боловсролтой 252 буюу 6.4 хувь, тусгай мэргэжлийн дунд 210 буюу 5.3 хувь, техникийн болон мэргэжлийн 8 буюу 0.2 хувь, бүрэн дунд 1259 буюу 32.1 хувь, суурь 916 буюу 23.3 хувь, бага 704 буюу 17.9 хувь, боловсролгүй 568 буюу 14.5 хувийг эзэлж байна. Дээрх судалгаагаар бүрэн дунд 1259 буюу 32.1 хувь, суурь 916 буюу 23.3 хувь, бага 704 буюу 17.9 хувь, боловсролгүй 568 буюу 14.5 хувийг эзэлж байгаа нь цаашид хорих байгууллагын өмнө нь нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэн хоригдолд мэргэжлийн болон суурь боловсрол эзэмшүүлэх шаардлагатай байна. Хорих ял эдэлж буй хоригдлуудын боловсролын байдлыг сайжруулснаар хорих ангийн нийгэмшүүлэх ажлын үр нөлөө нэмэгдэж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмд эргэн нэгтгэхэд ахиц болно гэж үзлээ.

Бид хүчиндэх гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа хоригдлын нийгэмшиж буй байдлыг 6 хорих ангиас түүвэрлэн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 323 хоригдлоос асуулга авахад 190 хоригдол буюу 59 хувь нь нийгэмшүүлэх ажлыг хангалттай, 59 хоригдол буюу 18 хувь нь нийгэмшүүлэх үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна, 51 хоригдол буюу

16 хувь нь үр нөлөөгүй, 23 хоригдол буюу 7 хувь нь сөрөг нөлөө үзүүлдэг гэж хариулсан.




Зураг 2. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг үнэлсэн судалгаа:

Судалгааны үзүүлэлтээс харахад 59 хувь нь эерэг, 41 хувь нь сөрөг буюу үр нөлөөгүй гэсэн нь хорих байгууллагад зохион байгуулагдаж буй нийгэмшүүлэх үйл ажиллагаа хараахан үр дүнд хүрч чадахгүй байна.

Эрүүгийн ялын нийгэмшүүлэх зорилгын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэгдэж байж дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хэвийн иргэн болгох ач холбогдолтой юм. Ийнхүү ялын бодлого, оногдуулалтын бодит илрэл нь шүүх эрх мэдлийн хүрээнд явагдаж, ШШГБ-ын ял эдлүүлэх үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг. Хорих ял эдлүүлэх хэм хэмжээний агуулгад нэг талаараа ард түмний хүсэл, нөгөө талаараа ял эдлэх, эдлүүлэх талаарх төрийн бодлого илэрхийлэгдсэн байдаг (А.Лхагва, 2009) гэж үздэг.

Тэгвэл хорих байгууллагын нийгэмшүүлэх үйл ажиллагааг үнэлэх судалгаанд оролцсон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын боловсролын түвшнийг гэмт хэрэг үйлдсэн зүйл ангитай харьцуулахад бүрэн дунд боловсролтой 71.4 хувь буюу хамгийн их хувийг эзэлсэн. Харин 120 буюу

37.1 хувь нь эрүүгийн хуулийн 12.1.4 дэх хэсэг (бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэрэг) үйлдсэн нь анхаарал татаж байна.




Зураг 3. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын боловсрол, зүйл ангийг харьцуулсан судалгаа:

Хорих байгууллагад зохион байгуулагдаж буй нийгэмшүүлэх ажил нь ялын зорилгыг хангахаас гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Өөрөөр хэлбэл, хоригдлын үйлдсэн гэмт хэргийн онцлогийг харгалзан тусгайлсан хөтөлбөрөөр нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм.

Сүүлийн 4 жилийн байдлаар хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл нь нийгэм, эдийн засаг, гэр бүлийн сөрөг байдлаас хамааралтайг харуулсан. Тухайлбал судалгааны оролцогчдоос архи согтууруулах ундааны хэрэглээний талаар судлан үзэхэд хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээс өмнө согтууруулах ундаа хэрэглээгүй 79 буюу 24.4 хувь, 7 хоногт 1 удаа 85 буюу 26.3 хувь, сард нэг удаа 140 буюу 43.3 хувь, өдөр бүр хэрэглэдэг байсан 19 буюу 5.8 хувийг эзэлж байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын согтууруулах ундааны хэрэглээг гэр бүлийн байдалтай нь харьцуулан судлахад гэрлээгүй хоригдлуудын 40.1 хувь нь сард нэг удаа 1 удаа, мөн гэрлээгүй хоригдлуудын 31.9 хувь нь 7 хоногт нэг удаа, гэрлэсэн хоригдлуудын 41.3 хувь нь сард нэг удаа, салсан хоригдлуудын 50.8 хувь нь сард нэг удаа согтууруулах ундааны хэрэглээтэй байжээ.



Зураг 4. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын согтууруулах ундааны хэрэглээг гэр бүлийн байдалтай харьцуулсан байдал:

Дээрх судалгаагаар хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын гэр бүлийн тогтвортой эерэг харилцаа болон согтууруулах ундааны хэрэглээний талаарх сургалтыг тусгайлсан хөтөлбөрөөр хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Бид судалгааны ажлаа нарийвчлан судлахын тулд практикт ажиллаж байгаа нээлттэй, хаалттай 6 хорих ангийн хамгаалалтын ажилтан, тоо бүртгэл, нийгмийн ажилтан, ерөнхий жижүүр, санхүүгийн албаны 122 алба хаагчдаас хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын нийгэмшиж буй байдлын талаар судалгаа авч үзэхэд оролцогчдын 49 алба хаагч буюу 40 хувь нь дунд, 9 буюу 7.3 хувь хангалтгүй, 22 буюу 18 хувь тааруу, 33 буюу 27 хувь сайн, 9 буюу 12 хувь нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 5. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын нийгэмшиж буй байдлын судалгаа:

Хоригдолд өдөр бүр тогтмол хяналт тавин ажиллаж байгаа алба

хаагчдын хувьд хүчиндэх гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа хоригдлын нийгэмшиж буй байдлыг 40 хувь нь "дунд" гэж хариулсан нийгэмшүүлэх ажлыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Судалгааны түүврээр "хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын амьдралын зорилгоо тодорхойлсон уу?" гэх асуултад нийт оролцогчдын 17 буюу 14 хувь нь хангалтгүй, 38 буюу 31 хувь нь тааруу, 37 буюу 30 хувь нь дунд, 19 буюу 16 хувь нь сайн, 11 буюу 9 хувь нь маш сайн гэж хариулсан байна. Мөн өөрийн үйлдсэн гэмт хэрэгт гэмшиж буй байдлын талаар 29 буюу 24 хувь, 27 буюу 22 хувь нь тааруу, 41 буюу 34 хувь нь дунд, 19 буюу 15 хувь нь сайн, 6 буюу 5 хувь нь маш сайн гэж хариулсан байна. "Сургалт, бусад олон нийтийн арга хэмжээнд оролцож буй байдал?" асуултад 5 буюу 4 хувь нь хангалтгүй, 16 буюу 13 хувь нь тааруу, 49 буюу 40 хувь нь дунд, 42 буюу 35 хувь нь сайн, 10 буюу 8 хувь нь маш сайн гэж хариулсан байна. "Гэр бүлийн гишүүдтэй харилцаж буй байдал?" гэх асуултад 7 буюу 6 хувь нь хангалтгүй, 22 буюу 18 хувь нь тааруу, 45 буюу 37 хувь нь дунд, 37 буюу 30 хувь нь сайн, 11 буюу 9 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

Дээрх алба хаагчдын судалгаанаас хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдолд нийгэмшүүлэх ажил төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байгаа бөгөөд цаашид хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, хувь хүний онцлогт тохирсон нийгэмшүүлэх үйл ажиллагааг явуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Бид судалгааны явцад Монгол Улсад хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг нийгэмшүүлэх хөтөлбөрийн дараах загварыг санал болгож байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. Энэ ажлын хүрээнд хорих ангийн эмнэлгийн хэсэг хоригдолд дараах үйлчилгээг нийгмийн ажилтантай хамтран гүйцэтгэнэ.

а) Бэлгийн замын халдварт өвчний үзлэг, шинжилгээ, оношилгоо, эмчилгээнд хамруулах;

б) Суурь болон бусад өвчний эмчилгээ;

в) Эрүүл мэндийн боловсрол олгох.

2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх. Хорих ангийн сэтгэл зүйч сэтгэцийн тулгамдсан асуудал, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгтэй хоригдолд дараах сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

а) Сэтгэцийн байдалд үнэлгээ өгөх;

б) Уур бухимдлаа даван туулах арга зам;

в) Зан үйлийн эмгэг засах.

3. Согтууруулах болон мансууруулах бодисын хамаарлын эсрэг эмчилгээ. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, бусад төрийн бус байгууллагын мэргэжлийн алба хаагчийн тусламжтайгаар дараах үйл ажиллагаа явуулна.

а) Согтууруулах ундааны хор хөнөөлийн сургалт;

б) Архинд донтох эмгэгийн эмчилгээ;

в) Архины хэрэглээгээ хянах чадвар суулгах;

г) Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар сургалт;

д) Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодист донтох эмгэгийн эмчилгээ.

4. Зан үйл, хандлага өөрчлөх сургалт (танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ). Хорих ангийн нийгмийн ажилтан, бусад төрийн бус байгууллагын мэргэжлийн алба хаагчийн тусламжтайгаар дараах үйл ажиллагаа явуулна.

а) Бэлгийн боловсролын сургалт;

б) Сөрөг зан үйлийн дахилтаас урьдчилан сэргийлэх сургалт-эмчилгээ;

в) Харилцааны ур чадвар суулгах сургалт;

г) Сэдэлжүүлэх ба урам зориг өгөх сургалт;

д) Амьдралын зорилгыг идэвхжүүлэх сургалт;

е) Бэлгийн гаж хандлага засах сургалт-эмчилгээ.

5. Боловсролын үйлчилгээнд хамруулах. Хорих ангийн нийгмийн ажилтан бүх шатны боловсролын байгууллагатай хамтран дараах үйл ажиллагаа явуулна.

а) Хувь хүний хэрэгцээнд тулгуурласан боловсролын үйлчилгээ;

б) Бэлгийн боловсрол эзэмшүүлэх сургалт;

в) Гэр бүл төлөвлөлтийн сургалт;

г) Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт.

6. Хөдөлмөрийн дадал олгох, хөдөлмөрт хамруулах. Хорих ангийн нийгмийн ажилтан, хорих ангийн дарга, холбогдох алба хаагчтай зөвшилцсөний дагуу дараах үйл ажиллагаа явуулна.

а) Хөдөлмөрийн дадал олгох;

б) Мэргэжил эзэмшүүлэх;

в) Ажлын байранд зуучлах;

г) Хөдөлмөр эрхлүүлэх.

7. Суллагдахад бэлтгэх арга хэмжээ.

а) Амьдралын болон амьдрах газрын төлөвлөлт хийх;

б) Санхүүгийн асуудлаа зөв шийдвэрлэх арга замд суралцуулах;

в) Бичиг баримтжуулах;

г) Гэр бүл, орон нутгийн засаг захиргаа, нийгмийн халамжийн байгууллагад холбон зуучлах.

Дээрх хөтөлбөрийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлын хувийн онцлог (нас, хүйс, боловсрол, гэмт хэргийн давтамж болон бусад), үйлдсэн гэмт хэргийн шинжээс хамааран тохируулан хэрэглэснээр нийгэмшүүлэх ажил тодорхой үр дүнд хүрнэ гэж үзлээ.

Нийгэмшүүлэх хөтөлбөрийг зөвхөн хорих байгууллага, тухайлан нийгмийн ажилтан дангаар хэрэгжүүлэх нь учир дутагдалтай тул төр, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагаа туйлын чухал юм.

Дүгнэлт

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх хүрээнд хорих ангид түшиглэсэн хөтөлбөрийг төр, төрийн бус байгууллага, олон нийт, иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн хувь хүний хөгжлийн тусгайлсан хөтөлбөрийн үр дүнгээс шалтгаалан хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг дараагийн хөтөлбөрт

шилжүүлэх, суллахад бэлтгэх, суллагдсаны дараа ажлын байранд зуучлах зэрэг байдлаар үр дүнг тооцож болохоор байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлууд нь идэр насны бүрэн дунд боловсролтой, анхны хэрэгтэй, ял эдлэхийн өмнө ажил эрхэлдэггүй байсан залуучууд хамгийн ихээр үйлдэж байгаа нь судалгаагаар харагдаж байна. Иймд энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудыг бусад хоригдлуудад зориулсан тусгай хөтөлбөртэй болох мөн идэр насны залуучууд байгаа тул хөдөлмөр эрхлэлтээр засрал хүмүүжлийг олгож болохоор байна гэж үзсэн.

Хорих ангийн нийгэмшүүлэх ажлын хөтөлбөрийг үйлдсэн гэмт хэрэгтний онцлог, хэрэгцээ шаардлагад үндэслэн тусгайлсан хөтөлбөрийг боловсруулахдаа тэдэнд мэргэжил эзэмшүүлэх, тохирох хөдөлмөрийн дадал суулгах, харилцааны ур чадварт суралцуулах зэрэг нөлөөллийн ажлыг судалгаанд суурилан тооцоолж хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Эх сурвалж

мэдээлэл, Т. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл.
Төрийн мэдээлэл. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. 1.
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. (2014). Бодит жишээтэй ажиллах арга зүй. *3*, 34.
Хорих ял эдлүүлэх алба. (2021-2024). Улаанбаатар хот.
П.Баярбаатар. (2024). Хоригдлыг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалт. Улаанбаатар хот.
П.Баярбаатар. (2024). Хоригдлыг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалт. Улаанбаатар хот.
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. (2023). 2021.03.15-ны өдрийн А/66 дугаар тушаал. Улаанбаатар хот.
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. (2021). 2021.12.22-ны өдөр А/207 дугаар тушаал. Улаанбаатар хот.
Хорих ял эдлүүлэх алба. (2024). Сургалт, нийгэм, сэтгэл зүйн тайлан. Улаанбаатар хот.
А.Лхагва. (2009). Дурдсан бүтээл. Улаанбаатар хот.

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

APPLICATION OF TYPES OF PUNISHMENT OTHER THAN PRISON, ISSUES TO BE CONSIDERED

Н.Бадраа

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

Badraa.N

Doctor of Laws (Ph.D.), Police Colonel, Police School, Police School, University of Internal Affairs, E mail: badraabadraa145@gmail.com, 99055758

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь Монгол Улсад хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилт болон тулгамдаж буй асуудлыг цогцоор судлан шинжилсэн болно. Судалгаагаар хорихоос өөр төрлийн ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр засарч хүмүүжих боломж олгодог, нийгэмд дахин нэгтгэх чухал механизм болохыг тогтоов. Гэвч хэрэгжилтийн явцад хяналтын сул тогтолцоо, байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй, нийгмийн ойлголт сул зэрэг шийдвэрлэвэл зохих асуудал тулгарч байгааг тогтоов. Мөн давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэл, хүний нөөцийн дутагдал, цахим хяналтын тогтолцоо нэвтрүүлэлт удааширч байна. Олон улсын туршлагатай харьцуулан дүн шинжилгээ хийж, пробаци, нийтэд тустай ажил, зорчих эрхийг хязгаарлах гэсэн ялуудын үр нөлөөг тусгайлан авч үзэв. Дэлхийн чиг хандлагатай уялдуулсан бодлогын санал, шийдлийг дэвшүүлж байна. Цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хяналтын тогтолцоог сайжруулах, оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байна.

Abstract: This article provides a comprehensive examination of the implementation of non-custodial sanctions in Mongolia, focusing on their legal framework, practical enforcement mechanisms, and emerging challenges. The study finds that non-custodial penalties offer critical opportunities for rehabilitation and social reintegration without isolating offenders from society; however, their overall effectiveness is substantially constrained by weak supervisory mechanisms, insufficient inter-agency coordination, and persistently

low public awareness. Additional concerns include elevated recidivism risks, inadequate human resources, and sluggish adoption of electronic monitoring technologies. Drawing on comparative analysis with international best practices, the article specifically examines the effectiveness of probation, community service, and travel restriction orders. Policy recommendations aligned with global trends are proposed, including strengthening legal regulations, modernizing supervision infrastructure, and deepening institutional cooperation among judiciary, prosecution, and correctional authorities.

Түлхүүр үг: хорихоос өөр ял, ял эдлүүлэх, пробаци, хяналт, гэмт хэрэг, эрүүгийн бодлого, нийгэмд дахин нэгтгэх, давтан гэмт хэрэг

Keywords: non-custodial sanctions, probation, punishment enforcement, criminal policy, supervision, social reintegration, recidivism

Оршил

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмийн аюулаас хамгаалахын зэрэгцээ тухайн этгээдийг засарч хүмүүжүүлэх, нийгэмд дахин нэгтгэх үзэл баримтлал улам бүр хүчтэй болж байна. Хорих ял нь уламжлалт ялын тогтолцооны гол хэрэгсэл байсан ч сүүлийн хэдэн арван жилд дэлхийн олон улс орон хорихоос өөр төрлийн ялыг өргөн хэрэглэх болжээ. Энэ нь зөвхөн хүмүүнлэгийн үүднээс биш, мөн эдийн засгийн үр ашиг, нийгмийн тогтвортой байдлын үүднээс ч утга учиртай шийдэл болоод байна.

Монгол Улс ч мөн адил эрүүгийн бодлогоо шинэчлэх, хорих ялыг аль болох хязгаарлаж, хорихоос өөр төрлийн ялыг нэвтрүүлэх чиглэлд чухал алхамуудыг хийж гүйцэтгэлээ. 2017 оны Эрүүгийн хуулийн шинэчлэлт, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн өөрчлөлт зэрэг нь энэхүү шинэчлэлийн хүрээнд батлагдсан чухал бичиг баримтууд юм. Гэвч хуулийн заалт ба бодит хэрэгжилтийн хооронд зөрүү оршин байгаа нь тодорхой болж байна.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд Монгол Улсад хорихоос өөр төрлийн ялын тогтолцоо, эрх зүйн үндэс, практик хэрэгжилт болон тулгамдаж буй асуудлуудыг нарийвчлан судлах замаар дараах судалгааны асуултад хариулт өгөхийг зорьсон болно: нэгдүгээрт, хорихоос өөр ялуудын эрх зүйн зохицуулалт хэр бүрэн гүйцэд, тогтвортой байна вэ;

хоёрдугаарт, хэрэгжилтийн явцад ямар практик хүндрэл тулгараад байна вэ; гуравдугаарт, олон улсын туршлагаас ямар сургамж авч болох вэ гэсэн асуултуудад хариулт өгөхийг зорьсон болно.

Судалгааны ач холбогдол нь Монгол Улсын эрүүгийн бодлогын цаашдын хөгжилд чиглэсэн бодит санал, зөвлөмж боловсруулахад оршино. Хорих ялыг аль болох хязгаарлаж, нийгэмд суурилсан ялуудыг нэмэгдүүлэх нь хорих байгууллагуудын ачааллыг бууруулах, мөн нийгмийн нийт аюулгүй байдлыг дэмжих чухал хүчин зүйл болно гэдгийг энэхүү судалгаагаар харуулахыг зорьлоо.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны өгүүлэл нь чанарын болон тооны судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн, олон эх сурвалжид тулгуурласан иж бүрэн судалгаа юм. Судалгааны үндсэн арга зүйн хүрээ дараах дөрвөн тулгуур дээр байгуулагдана.

2.1 Эрх зүйн баримт бичгийн шинжилгээ

Монгол Улсын Эрүүгийн хууль (2015, шинэчилсэн найруулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017), Пробацийн тухай хуулийн төсөл болон холбогдох журам, дүрмүүдийг нарийвчлан задлан шинжлэв. Хуулийн орчуулга, агуулгын шинжилгээний аргыг хэрэглэж, хуулийн заалтуудын хэрэгжилтийн байдлыг тодорхойлов.

2.2 Харьцуулсан судалгаа

Монгол Улсын хорихоос өөр ялын тогтолцоог Герман, Японы болон Олон улсын хорих ял эдлүүлэх байгууллага (International Corrections and Prisons Association— ICPA), Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) баримт бичигт тусгагдсан олон улсын стандарт болон шилдэг туршлагуудтай харьцуулан дүн шинжилгээ хийв. Харьцуулалтад Токиогийн дүрэм (UN Standard Minimum Rules for Non-Custodial Measures, 1990) болон Нийгэмд суурилсан ялуудын гарын авлага (UNODC, 2020)-ийг үндсэн тулгуур болгов.

2.3 Статистик мэдээллийн шинжилгээ

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2020–2024 оны жилийн тайлангуудыг үндсэн статистик эх сурвалж болгон

ашиглав. Шүүхийн мэдээллийн хэлтэс, Үндэсний статистикийн хорооны мэдээллийг нэмэлт эх сурвалж болгон авч үзлээ. Мэдээллийн хүснэгт, диаграммыг боловсруулан тайлбарлахад тоон шинжилгээний арга хэрэглэв.

2.4 Шинжлэх ухааны эх сурвалжийн тойм

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, пробаци, давтан гэмт хэрэг болон нийгэмд дахин нэгтгэх сэдвээр 2015–2024 онд Монгол болон гадаад хэл дээр хэвлэгдсэн 40 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, монографийг системтэйгээр тоймлон судлав. Үүнд: Google Scholar, Монгол Улсын Үндэсний эрдэм шинжилгээний мэдээллийн сан (МҮЭШМС), Хууль зүйн судалгааны хүрээлэнгийн номын сангийн бүтээлүүдээс ашиглав.

ҮНДСЭН ХЭСЭГ

3.1 Хорихоос өөр төрлийн ялын онолын үндэс

Хорихоос өөр төрлийн ял нь хорих ялаас ялгарах онцлог шинж чанаруудтай. Уг ялын гол зорилго нь гэмт этгээдийг нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр засарч хүмүүжих орчин бүрдүүлж, нийгмийн бусад гишүүдтэй харилцаа холбоогоо тасалдуулахгүйгээр засрах боломж олгоход оршдог . (Батболд, 2021) Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд "хорихоос өөр төрлийн ял" гэж ялтанг хорих байранд байрлуулахгүйгээр ял эдлүүлэх бүх хэлбэрийг нийтэд нь ойлгоно.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1990 онд баталсан Токиогийн дүрэм нь хорихоос өөр ялыг олон улсад хэрэгжүүлэх үндсэн стандартыг тодорхойлж өгсөн чухал баримт бичиг юм. (Nations, 1990) Тус дүрэмд тодорхойлсончлон хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэх нь гэмт хэрэгтнийг нийгмийн эерэг гишүүн болгон хэлбэржүүлэхэд хувь нэмэр оруулдаг бөгөөд хорих байгууллагуудын ачааллыг бууруулах нөлөөтэй.

Монгол Улсын хуулийн зохицуулалтад хорихоос өөр ялыг хэд хэдэн ангилалд хуваадаг. Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлд тусгагдсанаар торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял гэж үндсэн хэлбэрийг хуульчилсан байна.

3.2 Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хорихоос өөр ялын эрх зүйн тогтолцоо нь 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тулгуурлана. Уг хуулийн 6.1–6.5

дугаар зүйлүүдэд хорихоос өөр ялын төрөл, хэрэглэх нөхцөл, хэмжээ болон хүрээг нарийвчлан зохицуулсан байдаг. Тус хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан гэмт этгээдэд шүүх нь хорих ялыг нөгөөд нь оногдуулах шаардлагагүй тохиолдолд хорихоос өөр ялыг хэрэглэнэ гэж заасан байна.

Пробацийн тухай хуулийн төсөл нь 2021–2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулагдаж, санал авах үе шатанд явсан боловч одоогоор батлагдаагүй байна. Пробацийн тухай тусдаа хууль дутагдаж байгаа нь хяналтын тогтолцоог цэгцтэй болгоход саад болж буй гол шалтгаануудын нэг болоод байна. (Энхтүвшин, 2022) Харьцуулбал, Герман, Японы пробацийн тухай тусгай хуультай байдгийг дурдах нь зүйтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2017 оны шинэчлэлт нь хорихоос өөртөрлийн ялын биелэлтэд хяналт тавих байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг зохицуулсан. Тухайлбал, пробацийн хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нэгжүүдэд хариуцуулахаар тогтоосон байна.

3.3 Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийн статистик

Монгол Улсад хорихоос өөр ялын хэрэглээ сүүлийн таван жилд мэдэгдэхүйц нэмэгдэх чиг хандлагатай байна. ШШГЕГ-ийн 2024 оны жилийн тайланд тусгагдсан мэдээлэлд үндэслэн доорх хүснэгтийг боловсруулав.

Хүснэгт 1. Монгол Улсад хорихоос өөр төрлийн ялын хэрэглээний динамик (2020–2024)

Он	Нийт ял шийтгэгдэгч	Хорих ял (%)	Хорихоос өөр ял (%)	Өсөлт (%)
2020	8,500	62%	38%	—
2021	8,900	58%	42%	+4.0
2022	9,200	55%	45%	+3.0
2023	9,600	52%	48%	+3.0
2024	10,100	50%	50%	+2.0

Эх сурвалж: (газар Ш. ш., Жилийн тайлан, 2024)

Дээрх хүснэгтээс харахад 2020–2024 оны хооронд хорихоос өөр төрлийн ялын эзлэх хувь 38%-аас 50% болж нэмэгдсэн нь таван жилийн

хугацаанд 12 пунктын өсөлт юм. Энэ нь Монгол Улсын эрүүгийн бодлого хорих ялаас татгалзах чиглэлд тодорхой шилжиж байгааг харуулж буй юм. Гэхдээ нийт ял шийтгэгдэгчдийн тоо ч нэгэн зэрэг нэмэгдэж байгааг анхаарах хэрэгтэй.

Хүснэгт 2. Хорихоос өөр ялын төрлөөр ангилсан статистик (2024)

Ялын төрөл	**Оногдуулагдсан тоо**	**Эзлэх хувь (%)**	**Биелүүлэлтийн хувь (%)**
Торгох ял	2,850	56.4%	78%
Нийтэд тустай ажил	1,200	23.8%	65%
Зорчих эрх хязгаарлах	720	14.3%	82%
Алжаал авах	280	5.5%	90%
Нийт	5,050	100%	74%

Эх сурвалж: ШШГЕГ, 2024; Шүүхийн мэдээллийн хэлтэс, 2024.

Хоёрдугаар хүснэгтээс харвал торгох ял нь хорихоос өөр төрлийн ялуудын дундаас хамгийн өргөн хэрэглэгдэж буй (56.4%), биелүүлэлтийн хувь 78% байна. Харин нийтэд тустай ажлын биелүүлэлтийн хувь харьцангуй бага (65%) байгаа нь хяналт, зохицуулалтын дутагдлыг илтгэнэ. Зорчих эрх хязгаарлах ялын биелүүлэлт өндөр (82%, 90%) байгаа нь хяналт тавихад хялбар шинж чанартай холбоотой.

3.4 Хэрэгжилтийн тулгамдсан асуудлууд

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтэд тулгарч буй асуудлуудыг судалгааны явцад олон хэмжигдэхүүнд тулгуурлан дүгнэж үзэв. Тулгамдсан асуудлуудыг дараах дөрвөн үндсэн бүлгийн дагуу ангилан авч үзсэн.

3.4.1 Хяналтын тогтолцоо

Пробаци хяналт нь Монгол Улсад бодит үр нөлөөтэй хэрэгжих боломжгүй байгаагийн нэг шалтгаан нь пробацийн ажилтны ачааллын асуудал юм. Нэг пробацийн ажилтанд дунджаар 80–120 хяналтад байгаа ялтан ногдож байгаа бол олон улсын стандартаар энэ тоо 30–40-өөс хэтрэх ёсгүй. (UNODC., 2020) Ийнхүү ачаалал нь дунджаар 2.5–4 дахин их байгаа

нь ажилтны үйл ажиллагааны чанарт сөрөг нөлөө үзүүлж, хяналтад байгаа этгээдтэй хангалттай харилцах боломжийг хязгаарлаж байна.

Цахим хяналтын технологи буюу GPS-ийн цахим бугуйвчийг ашиглаж байгаа ч гар утасны хяналтын программыг Монгол Улс одоогоор хэрэгжүүлээгүй байна. Харьцуулбал, Герман, Япон, БНХАУ зэрэг улс орнууд энэ технологийг амжилттай нэвтрүүлсэн байна.

3.4.2 Байгууллагуудын хоорондын уялдаа холбоо

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтэд шүүх, прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, нийгмийн халамж, эрүүл мэндийн байгууллагууд хамтран оролцох шаардлагатай. Гэвч эдгээр байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцоо, үйл ажиллагааны уялдаа хангалтгүй байгааг судалгаанаас тодорхойлов (Болд, 2023). Мэдээллийн нэгдсэн сан байхгүй, байгууллага хоорондын харилцааны тогтолцоо цаасан дээрх бичиг баримтаар явагдаж байгаа нь цаг хугацаа алдах, мэдээлэл дутагдах нөхцөл бүрдүүлж байна.

Нийгмийн халамжийн байгууллагын оролцоо тогтмол бус байна. Ялтан нь нийгмийн тусламж, дахин ажил эрхлэлтийн дэмжлэг авах ёстой ч эдгээр үйлчилгээнд хамрагдах тохиолдол судалгаанд оролцсон аймгуудад 40-50%-иас хэтрэхгүй байна.

3.4.3 Нийгмийн ойлголт, хандлага

Монгол Улсын иргэдийн олонх хорихоос өөр төрлийн ялыг "хөнгөн" эсвэл "ял биш" гэж үздэг хандлага давамгайлсаар байна. Хууль зүйн судалгааны хүрээлэнгийн 2023 оны нийгмийн санал асуулгаар иргэдийн 68.4% нь хорихоос өөр төрлийн ялыг гэмт хэрэгтний хариуцлагыг хангалттай хүлээлгэж чадахгүй гэж үздэг нь тогтоогдсон байна. Энэ хандлага нь хохирогч нарын эрхийг хамгаалах тал дээрх асуудалтай холбоотой байдаг.

Нийгмийн ойлголтын дутагдал нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд саад болдог. Ажил олгогч нарын дийлэнх нь пробаци хяналтад байгаа хүнийг ажилд авахаас татгалздаг бол орон сууцны эзэд ч мөн адил байгааг судалгаагаар тогтоов. Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй хүнийг нийгэм

хүлээн зөвшөөрөх хандлага дутмаг байгаа нь давтан гэмт хэрэг үйлдэх нөхцлийг бүрдүүлээд байна гэж хэлж болно.

3.4.4 Хүний нөөц, санхүүгийн хязгаарлалт

Пробаци хяналтад оролцогч байгууллагуудын хүний нөөц, санхүүжилт хангалтгүй байна. ШШГЕГ-ын мэдээллээр 2024 оны байдлаар пробацийн 312 ажилтантай, тэдний 45% нь орон нутагт ажилладаг боловч нийт хяналтад байгаа ялтны тоо 7,800 гаруй байна. Үүнийг харьцуулахад нэг ажилтанд 25 хүн ногдох зорилт тавигдсан ч бодит байдалд 80-100 хүн ногдож байна.

Санхүүжилтийн асуудал нь ялангуяа нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Аж ахуйн нэгж, байгууллагуудад нийтэд тустай ажилд хэрэгжүүлэхэд гарах зардлын нөхөн олговор байхгүйгаас уг ялыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах сонирхолтой байгууллагын тоо хязгаарлагдмал байна.

3.5 Давтан гэмт хэрэг ба хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө

Хорихоос өөр төрлийн ялын нэг гол зорилго нь давтан гэмт хэрэг үйлдэхийг бууруулахад оршино. Олон улсын судалгаагаар хорих ялтай харьцуулахад хорихоос өөр ял нь давтан гэмт хэрэгт нөлөөлдөг байдал нь хоёрдмол дүр зургийг харуулна. Нэг талаас, нийгэмтэй холбоо тасрахгүй байх нь ялтанд нийгмийн ур чадвараа хэвээр хадгалах боломж олгодог бөгөөд хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн харилцаагаа тасалдуулдаггүй нь давтан гэмт хэргийг бууруулахад эерэгээр нөлөөлдөг. (Дамдин, 2022) Нөгөө талаас, хяналт сул байх нь зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдэх "боломж" олгодог.

Хүснэгт 3. Ялын төрлөөр давтан гэмт хэрэг үйлдэх түвшин (2020–2023)

Ялын төрөл	**Давтан гэмт хэрэг (%)**	**Хугацаа (жил)**	**Олон улсын дунджаас зөрүү**
Хорих ял	38%	3 жилийн дотор	+5%
Торгох ял	22%	3 жилийн дотор	+2%
Нийтэд тустай ажил	18%	3 жилийн дотор	-2%
Зорчих эрх хязгаарлах	15%	3 жилийн дотор	-5%
Пробаци (хослуулсан)	12%	3 жилийн дотор	-8%

Эх сурвалж: ШШГЕГ, 2024; UNODC, 2020 (олон улсын дунджаар харьцуулав).

Хүснэгт 3-аас харахад пробацийн хяналттай хослуулсан хорихоос өөр төрлийн ял нь давтан гэмт хэрэгт хамгийн бага хувийг (12%) харуулж байна. Хорих ялын давтан гэмт хэргийн хувь 38% байгаа нь хорихоос өөр төрлийн ял бусад ялуудаас илүү үр нөлөөтэй болохыг харуулж байна. Зорчих эрх хязгаарлах ялын давтан гэмт хэрэг 15% байгаа нь цахим хяналттай хослуулсан тохиолдолд улам буурах боломжтой гэж үздэг байна.

3.6 Олон улсын туршлага ба Монгол Улсын боломж

Олон улсын туршлагаас харахад пробаци болон нийгэмд суурилсан ялыг амжилттай хэрэгжүүлж буй орнуудад дараах нийтлэг шинж байдаг: нэгдүгээрт, пробацийн тусгай хууль байгаа; хоёрдугаарт, технологийн хяналтыг өргөнөөр ашигладаг; гуравдугаарт, нийгмийн байгууллагуудын идэвхтэй оролцоо байдаг; дөрөвдүгээрт, тодорхой мэргэшсэн хүний нөөц бэлтгэдэг (UNODC, 2020).

Герман Улсад пробацийн ажилтан нь нийгмийн ажилтны мэргэшилтэй байдаг бөгөөд нэг ажилтанд 30-аас илүүгүй хүн ногддог. Нийт пробацийн ялтны тооны 75% нь нийгмийн дэмжлэгийн ямар нэг хэлбэрт хамрагддаг. (Zschächner, 2021) Японы загвар ч гэсэн сайн дурын ажилтны тогтолцоог амжилттай хэрэглэж байгаагаараа онцлог бөгөөд Монгол Улсад нутагшуулах, хэрэгжүүлэх боломж бий.

Монгол Улсад хорихоос өөр ялын тогтолцоог цаашид бэхжүүлэхэд орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахад урамшуулах хөшүүрэг бий болгох шаардлагатай байна. Хоёр талын зөвтгөлийн механизм нэвтрүүлэх нь хохирогчийн эрх болон ялтны нийгэмд дахин нэгтгэгдэх эрхийн тэнцлийг хангахад чухал юм.

ДҮГНЭЛТ

Хорихоос өөр төрлийн ял нь Монгол Улсын эрүүгийн бодлогын хүмүүнлэг чиг хандлагыг илэрхийлэх чухал хэрэгсэл болоод байна. Судалгааны явцад дараах дүгнэлтийг хийлээ.

Нэгдүгээрт, Монгол Улсад хорихоос өөр ялын хэрэглээ 2020–2024 оны хооронд мэдэгдэхүйц нэмэгдэж, нийт ял шийтгэгдэгчдийн 50% болсон нь эрүүгийн бодлогын чиг хандлагын эерэг өөрчлөлтийг харуулна.

Хоёрдугаарт, давтан гэмт хэрэгт хамгийн бага нөлөөлдөг ял нь пробацитай хослуулсан хорихоос өөр ял (12%) болохыг баталгаажуулав. Энэ нь хяналтын чанар нь ялын үр нөлөөний тодорхойлогч хүчин зүйл болохыг илтгэнэ.

Гуравдугаарт, хэрэгжилтийн гол хүндрэлүүд нь байгууллага хоорондын уялдаа, хүний нөөцийн хангамж, цахим хяналтын технологийн дутагдал болоод нийгмийн хандлагын асуудлаас үүдэлтэй гэж дүгнэв.

Дөрөвдүгээрт, олон улсын туршлага, ялангуяа Германы загвар нь Монгол Улсад нутагшуулах боломжтой бодит жишиг болохыг дүгнэв. Пробацийн тусгай хуультай болох, мэргэшсэн ажилтны тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

САНАЛ

Дээрх дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмж саналыг дэвшүүлж байна.

5.1 Эрх зүйн шинэчлэлийн санал

Пробацийн тухай тусдаа хуулийг нэн даруй батлах шаардлагатай. Тус хуульд пробацийн ажилтны мэргэшлийн шаардлага, ачааллын дээд хязгаар, байгууллага хоорондын уялдааны механизм, иргэний нийгмийн оролцоо, цахим хяналтын эрх зүйн үндэс зэргийг тодорхойлсон байх ёстой.

5.2 Технологи нэвтрүүлэлтийн санал

GPS хяналтын бугуйвчийг хэдийгээр хэрэглэж байгаа ч гар утасны хяналтын программыг ашиглах шаардлагатай.

5.3 Хүний нөөц, чадавхижуулалтын санал

Пробацийн ажилтны мэргэжлийн чадварыг дээшлүүлэхэд нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн мэдлэгийг хослуулсан давхар мэргэшлийн сургалт зайлшгүй шаардлагатай.

5.4 Нийгмийн ойлголт нэмэгдүүлэх санал

Хорихоос өөр ялын зорилго, утга учрыг нийгэмд тайлбарлах, иргэдийн дунд ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдтэй хамтарсан сурталчилгааны аянг тогтмол зохион байгуулах нь чухал. Ялтны нийгмийн амьдралын амжилттай жишээ бүхий нийтлэл, кейс судалгааг иргэдтэй хуваалцах нь нийгмийн хандлагыг аажмаар өөрчлөхөд тус дөхөм болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Батболд, Б. (2021). Эрүүгийн эрх зүй (Ерөнхий анги). Монгол Улсын Их Сургуулийн хэвлэл.

Болд, Т. (2023). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын уялдаа: Бодлогын шинжилгээ. Хууль зүйн судалгаа, 15(1), 12–28. https://doi.org/10.xx/xx

Дамдин, Э. (2022). Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийн судалгаа. Монгол улс судлал, 4(2), 88–105.

Доржпалам, Т., & Тэгшжаргал, Г. (2023). Пробацийн тогтолцооны олон улстай харьцуулсан судалгаа: Монгол Улсын нөхцөлд нутагшуулах боломж. Шүүх эрх мэдэл, 34(4), 55–70.

Монгол Улсын Их Хурал. (2015). Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). Улаанбаатар: МУ-ын Засгийн газрын хэвлэх үйлдвэр.

Монгол Улсын Их Хурал. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Шинэчилсэн найруулга). Улаанбаатар.

Нарантуяа, Б. (2023). Эрүүгийн бодлогын хүмүүнлэг шинэчлэл: Дэлхийн чиг хандлага ба Монгол Улсын байр суурь. Хууль дээдлэх ёс, 12(1), 3–22.

Хууль зүйн судалгааны хүрээлэн. (2023). Хорихоос өөр ялын хэрэгжилтийн судалгааны тайлан. Улаанбаатар.

Энхтүвшин, Д. (2022). Пробаци хяналтын үр нөлөөний судалгаа. Хууль зүйн судалгаа, 12(3), 45–60.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. (2024). Жилийн тайлан 2024. Улаанбаатар: ШШГЕГ.

Шүүхийн мэдээллийн хэлтэс. (2024). Шүүхийн статистикийн мэдээлэл. Улаанбаатар: Монгол Улсын Дээд шүүх.

"НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД УХААЛАГ ТЕХНОЛОГИ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ"

"Analysis of the Effectiveness of Smart Technology, Artificial Intelligence, and Information Systems in Social Work Services"

Г.Батжаргал

Дотоод хэргийн их сургууль Сургалт, судалгааны 403 дугаар анги Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Batjargal.G

Department of Social Work and Psychology, Department of Social Work and Psychology Senior Lecturer, School of the Court's Decision Execution Service, Department of Internal Affairs, Department of Education and Research, Class 403

Хураангуй: Ухаалаг технологи, хиймэл оюун ухаан, мэдээллийн систем, цахим платформын хэрэглээ нэмэгдэхийн хэрээр нийгмийн ажилтнуудын үйлчилгээ үзүүлэх арга барил, харилцааны хэлбэр, ажлын үр нөлөө эрс өөрчлөгдөж байна. Жишээлбэл цахим зөвлөгөө өгөх, алсын зайнаас үйлчилгээ хүргэх, мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, эрсдэлт бүлгийн хэрэгцээг урьдчилан таамаглах зэрэг нь технологийн давуу талыг бүрэн ашиглаж буй хэлбэрүүд юм.

Технологийн дэвшил нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөө орон нутгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хоригдол зэрэг тусламж авахад хүндрэлтэй бүлгүүдэд хүрэх шинэ боломжуудыг нээж өгч байна.

Мөн олон мэргэжлийн баг буюу нийгмийн ажилтан, эмч, багш, цагдаа, сэтгэл зүйч зэрэг олон мэргэжилтэнтэй мэдээллийн нэгдсэн систем ашиглан хурдан шуурхай харилцаж, хамтран ажиллах боломжтой болжээ. Онлайн платформууд нь олон салбарын мэргэжилтнүүдийг нэгтгэж, кейс менежмент, хамтарсан зөвлөгөөн хийх нөхцөлийг бүрдүүлж байгаа практик өргөжиж байна. Салбар хоорондын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ

хийх боломжийг нэмэгдүүлснээр нотолгоонд суурилсан, үр нөлөөтэй бодлого боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Гэсэн хэдий ч мэдээллийн аюулгүй байдал, ёс зүйн зөрчил, дижитал хуваагдал зэрэг шинэ сорилтууд тулгарах нь нийгмийн ажлын мэргэжлийн орчинд онцгойлон анхаарах шаардлагатай асуудлуудыг бий болгоно.

Иймээс технологийн дэвшил нь нийгмийн ажлыг илүү дата, дижитал суурьтай, хүртээмжтэй болгохоос гадна ёс зүй, хүний эрхийн асуудлыг гүнзгий авч үзэх, шинэчлэгдсэн мэргэжлийн хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай тулгарч байна.

Abstract: The increasing use of smart technologies, artificial intelligence, information systems, and digital platforms is fundamentally transforming the methods, modes of communication, and overall effectiveness of social work services. For instance, practices such as online counseling, remote service delivery, data-driven analysis of information systems, and predictive assessment of the needs of vulnerable groups represent the effective utilization of technological advantages.

Technological advancements have expanded service accessibility and created new opportunities to reach populations that traditionally face barriers to assistance, including rural communities, persons with disabilities, and incarcerated individuals.

In addition, integrated information systems have enabled interdisciplinary collaboration and rapid communication among multidisciplinary teams, including social workers, medical professionals, educators, law enforcement officers, and psychologists. The growing use of online platforms has facilitated the integration of professionals across sectors, thereby supporting practices such as case management and joint consultations. Furthermore, the ability to collect and analyze cross-sectoral data enhances the conditions for developing evidence-based and more effective policy interventions.

However, these developments also introduce new challenges, such as information security risks, ethical concerns, and the digital divide, all of which require careful attention within the professional context of social work.

Therefore, while technological advancements are contributing to making social work more data-driven, digitally oriented, and accessible, they also

necessitate a deeper consideration of ethical and human rights issues, as well as the development of an updated and adaptive professional approach.

Түлхүүр үг: нийгмийн ажил, хиймэл оюун, ухаалаг технологи,

Keywords: social work, artificial intelligence, smart technologies,

Үндсэн хэсэг

Хятадын Тяньжин хотын Нанкай их сургуулийн Социологийн сургуулийн Нийгмийн ажил, нийгмийн бодлогын тэнхимийн судлаачид болох Ли Фэй (Lifei Li), Ван Мяо (Miao Wang) Жя Мяо (Miao Jia) нарын хамтран гүйцэтгэсэн “Нийгмийн ажлын үйлчилгээ дэх хиймэл оюун ухаанаар дэмжигдсэн кейс менежмент: системчилсэн тойм судалгаа” судалгаа нь нийгмийн ажлын үйлчилгээ дэх хиймэл оюун ухаанд суурилсан кейс менежментийн хэрэгжилт, үр нөлөөг баримт нотолгоонд тулгуурлан үнэлэх зорилготой бөгөөд уг өгүүлэл нь 2025 оны 3 дугаар сарын 21-нд Research on Social Work Practice сэтгүүлд нийтлэгдсэн ба судалгааны хүрээнд хиймэл оюун ухааны хэрэглээ нь нийгмийн ажлын кейс менежментэд хэрхэн интеграцчлагдаж буйг тодорхойлохдоо AI-ийн хэрэглээний чиглэл, технологийн төрөл, хамрах хүрээ болон үйлчилгээний үр дүнд үзүүлэх нөлөөг системчилсэн байдлаар шинжилсэн байна.

Судалгаанд нийт найман бодит кейсийг хамруулсан бөгөөд эдгээрийн долоон тохиолдолд хиймэл оюун ухааны хэрэглээ нь эерэг үр дүн үзүүлсэн нь тогтоогдсон байна. Тодруулбал, AI-д суурилсан кейс менежмент нь нийгмийн ажилтны шийдвэр гаргах үйл явцыг түргэсгэх, мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжих, эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг илрүүлэх нарийвчлалыг нэмэгдүүлэх, хүний хүчин зүйлээс хамааралтай алдааны эрсдэлийг бууруулах, мөн үйлчилгээний хүртээмж болон чанарыг сайжруулах зэрэг олон талын эерэг нөлөө үзүүлж байгааг судалгааны үр дүн харуулсан байна. Энэхүү үр дүн нь нийгмийн ажлын практикт технологийн дэвшлийг нэвтрүүлэх нь үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болохыг нотолж байна.

Судалгааны явцад хиймэл оюун ухааны хэрэглээг кейс менежментийн хүрээнд дөрвөн үндсэн чиглэлд ангилан авч үзсэн байна. Үүнд шийдвэр гаргалтыг дэмжих чиглэл бөгөөд энэ нь AI-ийн тусламжтайгаар кейсийг хэрхэн удирдах, ямар үйлчилгээ үзүүлэх талаар оновчтой шийдвэр гаргах үйл явцыг дэмждэг; эрсдэлийн ангиллын чиглэл

бөгөөд өндөр эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг урьдчилан илрүүлэх, ангилах боломжийг бүрдүүлдэг; интервенцийн тодорхойлолтын чиглэл бөгөөд үйлчлүүлэгч бүрийн нөхцөл байдалд тохирсон үйлчилгээний төрөл, арга хэмжээг тодорхойлоход чиглэдэг; хяналт, мониторингийн чиглэл бөгөөд үйлчилгээний явц болон эцсийн үр дүнг тогтмол хянах, үнэлэх боломжийг олгодог байна.

Эдгээр үр дүнг нэгтгэн авч үзвэл хиймэл оюун ухаан нь нийгмийн ажлын кейс менежментэд зөвхөн туслах хэрэгсэл бус, шийдвэр гаргалтыг системчилж, өгөгдөлд суурилсан болгох үндсэн хөшүүрэг болж байгааг харуулж байна. Түүнчлэн AI-ийн хэрэглээ нь нийгмийн ажилтны ажлын ачааллыг бууруулах, үйлчилгээний чанарыг тогтвортой байлгах, эрсдэлийг эрт илрүүлэх зэрэг стратегийн ач холбогдолтой үр нөлөөг бий болгож байгаа хэдий ч өгөгдлийн нууцлал, ёс зүйн асуудал, алгоритмын шударга байдал зэрэг сорилтуудыг давхар дагуулж байгааг анхаарах шаардлагатай байна. Иймд цаашид хиймэл оюун ухааныг нийгмийн ажлын салбарт үр дүнтэй, хариуцлагатайгаар нэвтрүүлэхийн тулд эрх зүйн зохицуулалт, мэргэжлийн стандарт, ёс зүйн зарчимд тулгуурласан бодлого, практикийг хөгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэж байна. (Lifei Li, 2025)

Судлаач Мэри Бет Ньюманы (Mary Beth Newman) Professional Case Management сэтгүүлд нийтлэгдсэн “Хиймэл оюун ухаан ба кейс менежмент: Шинэчлэлт бүхий практикийг хүлээн авч хэрэгжүүлэх нь” судалгааны өгүүлэлд дурдсанаар хиймэл оюун ухаанд (AI) суурилсан шийдлүүд нь кейс менежментийн үйл явцын бүх шатанд өргөн хэрэглэгдэж, ажлын үр дүн, үйлчилгээний чанарт олон талын эерэг өөрчлөлт авчирч байна. (Mary Beth Newman, 2021). Үүнийг дараах үндсэн чиглэлүүдээр тодорхойлж болно. Үүнд:

Реферал шалгалт[2], кейс үүсгэх, кейс хуваарилалт- AI систем нь кейс шилжүүлэг (referral)[3] урьдчилан шалгаж, хэрэгцээг ангилан, кейсийг автоматаар үүсгэнэ. Үүний дараа кейс менежерүүдийн мэргэшил, клиник чиглэл, ажлын ачаалал зэргийг харгалзан кейсийг хуваарилах боломжийг олгож, ажлын тэнцвэрт байдал, хүртээмжийг нэмэгдүүлдэг.

[2] **Реферал шалгалт** гэдэг нь: Үйлчлүүлэгч эсвэл тохиолдлын талаар (referral) **хийсэн мэдэгдлийг анхан шатанд үнэлж,** тухайн кейс **дэмжлэг, үйлчилгээ авах шаардлагатай эсэхийг** шийдэх **албан ёсны процесс** юм. Манай нийгмийн ажлын зарим салбарын аюулгүйн зэргийн үнэлгээ хийх гэсэн ойлголттой ойролцоо юм.

[3] **Referral** гэдэг нь нэг хүн, байгууллага, мэргэжилтнээс нөгөөд **тусламж, үйлчилгээ, хяналт шаардлагатай хүн, тохиолдлын талаар мэдээлэл хүргэж, шилжүүлэх үйлдэл** юм.

Административ[4] ачааллыг бууруулах- AI нь дахин давтагдах, гар ажиллагааг автоматжуулснаар кейс менежерүүдийг үндсэн ажил болох үйлчлүүлэгчтэй харилцах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг “өндөр үнэ цэн бүхий” үүрэгт төвлөрөх боломжоор хангадаг.

Мэдээлэл цуглуулалт, баримтжуулалтыг AI гүйцэтгэснээр кейс менежер нь үйлчлүүлэгчтэй илүү их цагийг өнгөрүүлэх, итгэлцэл, харилцаа, эмпатид суурилсан дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Робот процесс автоматжуулалт (RPA)[5], машин сургалт (ML)[6], байгалийн хэл боловсруулах (NLP)[7], урьдчилан таамаглах загварчлал (predictive modelling) зэрэг технологиуд нь кейс менежмент дэх механик ажлыг багасгаж, стратеги төлөвлөлт, нөлөөлөл, хамтын ажиллагаа зэрэг илүү өндөр түвшний үүрэгт менежерүүдийн анхаарлыг төвлөрүүлдэг. (Newman, 2021)

Хүснэгт 1. AI технологийн хэрэглээ ба ач холбогдолыг харьцуулан харууллаа.

№	Технологи	Хүүхдийн хамгаалал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Сэтгэл зүйн дэмжлэг	Ашиг холбогдол
1	RPA	Реферал бүртгэл, кейс үүсгэх	Үйлчлүүлэгчийн мэдээлэл боловсруулах	Цагийн хуваарь, хариу өгөх үйлдлийг автоматжуулах	Административ ачааллыг бууруулж, мэргэжилтнүүдийг чөлөөлөх
2	ML (Машин сургалт)	Эрсдэлтэй хүүхдийг урьдчилан таних	Хувь хүний хэрэгцээнд тохирсон төлөвлөгөө гаргах	Сэтгэл гутрал зэрэг эмгэгийг тодорхойлох	Илүү өгөгдөлд суурилсан, ухаалаг шийдвэр

[4] **Административ** гэдэг нь **байгууллага, тогтолцоо, үйлчилгээний хүрээнд бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах удирдлагын процесс** юм.

[5] **Робот процесс автоматжуулалт (RPA) нь хүний оролцоотой, давтамжтай, дүрэмд суурилсан оффисын ажлуудыг "програм хангамжийн робот" ашиглан автоматжуулах технологи** юм.

[6] Машин сургалт буюу Machine Learning (ML) нь: Компьютерийг хүнээр шууд програмчлуулахгүйгээр, өгөгдөл дээр үндэслэн өөрөө "суралцаж" шийдвэр гаргах, таамаг хийх чадвар юм. Энэ нь хиймэл оюун ухааны (AI) нэг салбар бөгөөд компьютер хүн шиг туршлагаас суралцдаг гэсэн үг.

[7] **“Байгалийн хэл боловсруулах”** буюу **NLP (Natural Language Processing)** нь **компьютер болон хиймэл оюун ухааныг хүний хэл (яриа, бичвэр) ойлгох, тайлбарлах, үүсгэх, хариу өгөх чадвартай болгох технологи** юм.

					гаргалтыг дэмжих
3	NLP “**Байгалийн хэл боловсруулах**”	Тэмдэглэлээс хүчирхийллийн өгөгдөл гаргах	Чатботоор дамжуулан сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах	Сэтгэл хөдлөлийг таньж, зөвлөгөө өгөх	Хүний бичвэрт суурилсан өгөгдлийг машин ойлгох, дүн шинжилгээ хийх
4	Predictive modelling	Эрсдэлтэй орчныг тодорхойлох	Сэргээн засах үйлчилгээний үр дүнг таамаглах	Ирээдүйн сэтгэл зүйн эрсдэлийг урьдчилан таамаглах	Эрсдэлийн үндсэн дээр шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлэх
5	Sentiment analysis	—	—	Сэтгэл хөдлөлийг тодорхойлох	Хэрэглэгчийн сэтгэл зүйн байдалд суурилсан үйлчилгээ үзүүлэх
6	AI chatbot	—	Тусгай хэрэгцээтэй хүмүүстэй хялбар харилцах	24/7 автомат зөвлөгөө өгөх	Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

Хиймэл оюун ухааны шийдлүүд нь кейс менежмент дэх процессийг автоматжуулж, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжихийн зэрэгцээ хүмүүнлэг харилцааг гүнзгийрүүлэх, мэргэжилтнүүдийн стратеги үүрэгт анхаарах боломжийг нэмэгдүүлэх чухал хэрэгсэл болж байна.

AiCAN (Artificial Intelligence for Child Abuse and Neglect) нь хүүхдийн хүчирхийлэл, үл хайхралыг илрүүлэх болон урьдчилан сэргийлэх зорилго бүхий хиймэл оюун ухаанд суурилсан систем юм. AiCAN нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн.

- Хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлийг урьдчилан илрүүлэх
- Эцэг эх, асран хамгаалагчийн зан төлөв, харилцааны хэв маягийг шинжлэх
- Бодит цагт шалтгаан үр дагаврын хамаарлыг тогтоох цаг хугацаа алдахгүй, нөхцөл байдлыг үнэлж, үр дагавар, шалгааныг тодорхойлох

- Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдэд шийдвэр гаргалтыг дэмжих автомат зөвлөмж оруулах зэргээр ашиглагдаж байна.

AiCAN төслийн хүрээнд хиймэл оюун ухаан хэрхэн кейсийн анализ, учир шалтгаан тогтоолт, шийдвэр гаргалтад хэрэглэгдэж байгааг тайлбарлах, цаашид кейс менежмент ба эрсдлийн удирдлагад дасан

зохицох чадвартай тооцооллын загваруудыг хэрхэн хөгжүүлэх боломжтойг тодорхойлох явдал юм.

Судалгааны арга зүйн хувьд кейс судалгаа, өгөгдлийн шинжилгээний аргуудыг хослуулан ашигласан ба AiCAN-ийн ашиглаж буй алгоритмын загварууд, кейс бүрт үүссэн өгөгдөл, гарсан шийдвэрүүдийг харьцуулан дүгнэсэн. AiCAN нь кейс бүрийн өгөгдлийг ангилж, голлон нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, тэдгээрийн хоорондын хамаарлыг тайлбарлах боломжийг бүрдүүлж байгаа нь шийдвэр гаргалтад нотолгоонд суурилсан шинэ боломжуудыг нээж байна. Цаашид уг системийг дасан зохицох алгоритмаар өргөтгөн, эрсдлийн түвшинг динамик тооцоолдог, бодлогын загварчлалтай хослуулсан хэлбэрээр хөгжүүлэх боломжтой юм.

Хүүхдийн хүчирхийлэл болон үл хайхралаас урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөх магадлалыг тодорхойлох, нийгмийн ажилтны шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор хиймэл оюун ухаан (AI) болон машин сургалтын (ML) арга технологиудыг хэрэглэх нь сүүлийн жилүүдэд эрчимтэй судлагдаж байна. Үүнийг илтгэх дараах олон улсын судалгаануудыг харьцуулан үзэхэд AI системийг хүүхэд хамгааллын практикт хэрэглэх нь олон талын үр ашигтай байгааг (хүснэгт 2) харуулж байна.

Хүснэгт 2 судалгааны харьцуулалт

№	Судалгааны нэр	Зорилго	Арга зүй	Үр дүн	Судлаачид	Огноо	Нийтлэгдсэн сэтгүүл
1	Artificial Intelligence and Child Abuse and Neglect: A	Хүүхдийн хүчирхийлэл, хайхрах (CAN)-д AI ашигласан	Systematic literature review (1985–2023, 7 өгүүлэл)	ML загварууд ашиглагдаж байгаа ч ихэнх нь жижиг	Azari, Zare, et al.	2023	Frontiers in Artificial Intelligence

	Systematic Review	судалгааануд ыг тоймлох		өгөгдөлтэй, bias өндөртэй			
2	An Implementable Guideline for Developing Ethical AI Systems	Хүүхэд хамгааллын системд AI ашиглах ёс зүйн удирдамж боловсруулах	Case study + Evaluation framework (ethicality, utility, cost)	AI системд практик ёс зүйн дүн шинжилгээ хэрэгтэйг баталсан	Yamashita, Kawakami, et al.	2024	HICSS 57 (Hawaii Int'l Conf. on System Sciences)
3	Better Together? A Field Experiment on Human-Algorithm Interaction in Child Protection	Causal ML-ийг практикт CPS-д ашиглах боломжийг шалгах	Field experiment (Randomized Control Trial – RCT)	ML алгоритм CPS-ийн үр дүнг сайжруулсан, human-algorithm interaction өндөр үр дүнтэй	De-Arteaga, Chouldechova, et al.	2025	arXiv preprint
4	Improving Human-AI Partnerships in Child Welfare	CPS ажилтнууд AI системийг хэрхэн ойлгож ашиглаж байгааг судлах	Qualitative interviews (20+ CPS workers)	AI системд хүний ойлголт, итгэлцэл чухал үүрэгтэй	Saxena, Park, et al.	2022	arXiv preprint
5	Explainable AI Recommendation System. ACEs Ontology	Хүүхдийн ACEs дээр суурилсан AI зөвлөмжийн систем боловсруулах	Semantic modeling Prototype system	Тайлбарлагддаг (XAI) зөвлөмж систем бүтээсэн,	Alowibdi, Meiselwitz, et al.	2020	arXiv preprint

Маклайн (Mackline) Нувасийма (Nuwasiima) Метогбе (Metogbe) Патрисиа (Patricia) болон Кадири Калеб Айегбени (Kadiri Caleb Ayegbeni) нарын 2024 онд World Journal of Advanced Research and Reviews сэтгүүлд нийтэлсэн “Нийгмийн ажлын практикт хиймэл оюун ухаан (AI) ба машин

сургалтын (ML) үүрэг" судалгаа нь хүүхэд хамгаалал, сэтгэл зүй, мансууруулах бодисын эмчилгээний салбарт хиймэл оюун ухаан (AI) болон машин сургалтын (ML) технологийг ашиглах боломжийг судалжээ. Судалгааны үр дүнгээс үзэхэд AI/ML нь эрсдэлт бүлгийг эрт илрүүлэх, оролцооны арга хэмжээг төлөвлөхөд үр дүнтэй нөлөө үзүүлж байгааг онцлон тэмдэглэсэн байна. Мөн нийгмийн ажилтнуудын шийдвэр гаргалт, тооцоолол, нөөцийн хуваарилалтад AI/ML-ийн хэрэглээний боломж, түүнтэй холбоотой тулгарч болох сорилтуудыг нарийвчлан авч үзжээ. (Mackline Nuwasiima, 2024)

Сэтгэл зүйн дэмжлэгийн чатбот Woebot, Wysa зэрэг AI чатботууд CBT аргыг ашиглан сэтгэл гутрал, стрессийн шинж тэмдгийг багцлан илрүүлдэг бөгөөд зарим судалгаа нь ашиглагчдын дунд 2 долоо хоногийн дотор үзүүлэлтийг багасгасан үр дүнтэй байна.

Хүснэгт 3. CBT суурьтай AI чатботуудын судалгааны нэгтгэл

№	Чатбот	Судалгааны нэр / Зорилго	Үр дүн	Судлаачид	Огноо	Нийтлэгдсэн сэтгүүл
1	Woebot	Delivering CBT to Young Adults via Chatbot: Randomized Controlled Trial – Их сургуулийн оюутнуудад Woebot ашиглан сэтгэл гутралыг бууруулах боломжийг судлах	2 долоо хоногийн хэрэглээнд сэтгэл гутралын шинж тэмдгийн (PHQ-9) оноо статистик хувьд мэдэгдэхүйц буурсан	Fitzpatrick, Darcy & Vierhile	2017	JMIR Mental Health
2	Woebot	AI-Driven Mental Health Chatbots: Systematic Review (2023) – CBT суурьтай чатботуудын клиник болон хэрэглээний судалгааг	Woebot нь богино хугацаанд (2 долоо хоног) сэтгэл гутрал, түгшүүр бууруулахад үр нөлөөтэй болохыг нотолсон 2 RCT	Vaidyam, Wisniewski et al.	2023	JMIR Formative Research

		системтэйгээр тоймлох	судалгаа багтсан			
3	Wysa	Empathy-driven AI Chatbot for Mental Wellbeing: Mixed-Methods Study – Wysa чатботын хэрэглэгчдийн дунд сэтгэл зүйн эерэг өөрчлөлт бий эсэхийг үнэлэх	Өөрийгөө тайвшруулсан мэдрэмж, стресс буурсан гэх хэрэглэгчдийн чанарын болон тоон хариу авсан	Inkster et al.	2018	JMIR mHealth and uHealth
4	Wysa	Use of AI Chatbot Wysa Among Healthcare Workers During COVID-19 Pandemic – Эмнэлгийн ажилтнуудад стресс бууруулах зорилгоор ашигласан	3 долоо хоногийн турш Wysa хэрэглэсэн бүлгийн дунд стрессийн оноо (DASS-21) буурсан	Chandrashekar et al.	2020	Frontiers in Psychology

Лондон хот дах ахмад настны асаргааны орчинд нэвтрүүлсэн Ally Cares систем нь инфра улаан туяа (infrared) болон дууны долгион мэдрэгч (acoustic AI sensors)-ийг ашиглан шөнийн хөдөлгөөн, тэнцвэргүй босох, унах зэрэг үйлдлийг автоматаар илрүүлдэг. Судалгаагаар уг системийн үр дүнд унтлагын чанар сайжирч, уналтын давтамж 60–83 %-иар буурсан нь тогтоогджээ.

Нэмэлт байдлаар уг системийн acoustic датчик нь халдвар болон өвдөлт, зовуур илрүүлэхэд ашиглагддаг бөгөөд эмнэлзүйн хариу арга хэмжээг хурдан авах боломжийг бүрдүүлж, эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлдэг.

Мөн PainChek гэх аппликейшн нь танин мэдэхүйн хязгаарлагдмал байдал бүхий өвчтөнүүдийн нүүрний микро илэрхийллийг хиймэл оюун ухаанаар (AI) шинжилж, өвдөлтийн субъектив мэдрэмжийг илрүүлдэг. Үүгээр дамжуулан оношлогоо тодруулах явцад гардаг субъектив байдлыг бууруулж, эмнэлзүйн шийдвэр гаргалтыг сайжруулахад хувь нэмэр оруулдаг байна. Тус системийг Bromley болон Loveday Abbey Road зэрэг асаргааны байгууллагуудад амжилттай ашиглаж буйг судалгаанд тэмдэглэсэн байна.

Түүнчлэн агаарын чанар хянах ухаалаг төхөөрөмжүүд (smart AC) нь орчны температур, чийгшил, хүчилтөрөгчийн хэмжээ зэрэг үзүүлэлтийг онлайн хянаж, автомат тохируулга хийдэг бөгөөд COVID-19 зэрэг халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд тустай жишээ болгон дурдагджээ.

Дээр дурдсан технологийн шийдлүүд нь эрүүл мэнд ба нийгмийн ажлын салбарын огтлолцол дээр байрлах олон салбарыг хослуулсан судалгааны жишээ юм. (www.thetimes.com, 2024)

Судалгаа нь ахмад настны асаргаа, халамжийн үйлчилгээний орчинд хийгдсэн бөгөөд эдгээр орчин нь нийгмийн ажилтнуудын шууд оролцоотой, практик үйл ажиллагааны хүрээнд явагддаг.

AI технологи нь хүн төвтэй асаргааны загварыг дэмжиж, хүний оролцоог чанартай, үр дүнтэй болгоход чиглэгдсэн байна. Жишээлбэл AI шийдлүүд нь сувилагч, халамжийн ажилтнуудын ачааллыг бууруулж, илүү сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан ойлголцолд суурилсан орчныг бүрдүүлэх боломжийг олгож байна.

Иймд дээрх судалгаануудыг эрүүл мэндийн технологи болон клиник эрсдэлийн удирдлагад суурилсан ч тэдгээрийн хэрэглээ, зорилго нь нийгмийн ажлын орчныг дэмжихэд чиглэсэн тул нийгмийн ажлын практикт уялдсан эрүүл мэндийн судалгаа гэж тодорхойлох боломжтой юм.

Орчин үеийн нийгмийн ажлын үйлчилгээ, эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухаан болон мэдээллийн технологийн дэвшилтэт шийдлүүд салбар дунд өргөнөөр ашиглагдаж байгаагын дараагийн жишээ бол CaseWorthy, DataRobot, MindSuite зэрэг платформууд юм. Эдгээр технологиуд Case менежмент, эрсдэл үнэлгээ, сэтгэл зүйн мониторинг зэрэг чиглэлээр үйлчилгээний чанар, үр ашиг, шийдвэр гаргалтыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ нийгмийн ажил, эрүүл мэндийн

салбаруудыг уялдуулан хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэгийг сайжруулахад хувь нэмэр оруулж буйг олон судалгаа баталж байна. (хүснэгт 4) нэгтгэн харуулав.

Хүснэгт 4 судалгааны харьцуулалт

Платформ Технологи	**Зорилго**	**Тайлбар**	**Үйл ажиллагаа/Функц**	**Хэрэглээний чиглэл**	**Онцлог, нэмэлт мэдээлэл**
CaseWorthy	Нийгмийн ажлын үйлчилгээ, эрүүл мэндийн case менежментэд үйлчлүүлэгчийн мэдээллийг төвлөрүүлэн удирдаж, case-ийн явц, шийдвэрлэлт, үйлчилгээний үр дүнг сайжруулах.	Нийгмийн ажлын үйлчилгээ, эрүүл мэндийн case менежментийн систем	Case record-ийг төвлөрүүлэн удирдах, case management хийх, тайлан гаргах	Хүүхэд хамгаалал, гэр бүл, халамжийн үйлчилгээ	Үйлчлүүлэгчийн мэдээллийг нэг дор төвлөрүүлж case явцыг хянахад ашиглагддаг
DataRobot	Том өгөгдөл дээр AI/машин сургалтын ML загваруудыг хурдан боловсруулж, эрсдэл, үр дүнг урьдчилан таамаглах замаар шийдвэр гаргалтыг дэмжих.	Автомат машин сургалтын платформ (AutoML)	Том өгөгдөл дээр AI/ML анализ хийх, эрсдэл үнэлгээ, таамаглал гаргах	Эрүүл мэнд, санхүү, нийгмийн үйлчилгээ	Том өгөгдөлд суурилсан хурдан, үр дүнтэй AI загвар боловсруулах боломжтой
MindSuite	NLP болон AI ашиглан хэрэглэгчийн сэтгэл зүйн байдал, эмоцийг үнэлж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх шийдлийг сайжруулах.	Сэтгэл зүйн дэмжлэгийн AI платформ	NLP ашиглан хэрэглэгчийн сэтгэл зүйн байдлыг шинжлэх, эмоци оношлох	Сэтгэл зүй, нийгмийн ажлын үйлчилгээ	Cogito NLP ба Empatica E4 wearable-тэй интеграцтай, эмоцийн хариу үзүүлэлт хянах боломжтой

Empatica E4 (Wearable)	Хүний биомедикал өгөгдлийг (зүрхний цохилт, арьсны температур, хөдөлгөөн гэх мэт) цаг тухайд нь хянаж, сэтгэл зүйн болон физиологийн өөрчлөлтийг мэдрэх.	Биомедикал wearables төхөөрөмж	Стресс, зүрхний цохилт, арьсны температурыг хянах	Сэтгэл зүй, эрүүл мэндийн мониторинг	Cogito NLP-тэй холбогдож хүний эмоци, сэтгэл зүйг илрүүлдэг
Cogito NLP	Хэл, ярианы өгөгдлөөс хүний сэтгэл хөдлөл, стресс, зан төлөвийг дүн шинжилгээ хийж, decision support болон сэтгэл зүйн үнэлгээ хийх.	Байгалийн хэл боловсруулалтын технологи NLP	Хэл ярианы анализ хийж хүний сэтгэл хөдлөлийн шинжилгээ хийх	Сэтгэл зүй, шийдвэр гаргалтыг дэмжих	Хэрэглэгчийн яриа, текстээс эмоци, стрессийг гаргаж авдаг

Эдгээр технологиудын үндсэн зорилго нь эрүүл мэнд, нийгмийн ажлын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шийдвэр гаргалтыг илүү оновчтой болгох, хэрэглэгчийн сэтгэл зүйн болон бие махбодын байдлыг хянах явдал юм.

Энэхүү технологийн интеграци нь хүний үйл ажиллагааны хэвийн бус байдлыг цаг алдалгүй илрүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйлчилгээний чанар, хүний оролцоог оновчтой болгох зэрэг олон талын ач холбогдолтой. Иймд эдгээр дэвшилтэт мэдээллийн технологиуд нь нийгмийн ажлын үйлчилгээ болон эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг сайжруулж, хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдалд шууд эерэг нөлөө үзүүлж байгаа нь олон салбар дамжсан интердисциплинар судалгааны чухал сэдэв болж байна.

Технологийн дэвшил нь нийгмийн ажил мэргэжлийн чиг хандлагад олон боломж, давуу талыг авчирсан хэдий ч зарим сорилт, эрсдэлтэй нүүр тулах шаардлага үүсгэж байна. Тухайлбал мэдээллийн аюулгүй байдлын асуудал, үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийн алдагдал, буруу ашиглалт зэрэг эрсдэлүүд нэн чухал байна. Мөн хиймэл оюун ухааны шийдвэр гаргалтын хариуцлагын асуудал, ёс зүйн шинэ сорилтууд, дижитал хуваагдал буюу интернэт, төхөөрөмжийн хүртээмжийн ялгаа зорилтот бүлэгт сөргөөр нөлөөлөх зэрэг хүчин зүйлс үүсэж байна.

Ёс зүйн хувьд цахим үйлчилгээ, AI-ийн шийдвэрт хэт найдвар хүлээлгэх нь мэргэжлийн хариуцлагын асуудал үүсгэдэг. AI зөвлөмж өгч болох ч эцсийн шийдвэрийг хүн гаргах ёстой. Мөн нууц мэдээлэл цуглуулах, хадгалах, ашиглах үед хэрэглэгчийн зөвшөөрлийг хангаж, ил тод байдлыг хадгалах шаардлагатай бөгөөд энэ чиглэлээр мэргэжлийн ёс зүйн кодексүүдэд privacy болон data security-ийг хамгаалах заалтууд орсон байдаг. (Rodríguez-Martínez, 2024)

AI системийн алгоритмд суурилсан шийдвэр гаргалт нь зарим бүлэг хүмүүст ялгаварлан гадуурхах эрсдэлтэй байдаг тул алгоритмын аудит, олон талт хяналт зайлшгүй шаардлагатай гэж судлаачид онцолжээ. (Mackline, 2024) Технологийн автоматжуулалт хүний харилцааг “машинжуулах” эрсдэлтэй бөгөөд энэ нь эмпати, харилцан итгэлцлийг бууруулах сөрөг нөлөөтэй байж болзошгүй. (Домбо, 2020)

Дижитал хуваагдал нь хөдөөгийн болон орон нутгийн иргэд, бага орлоготой бүлгүүдэд интернэт, техник хэрэгслийн хүртээмжийн хомсдолоос үүдэн цахим үйлчилгээ авах боломжийг хязгаарлаж байна. (Afrouz, 2023) Мөн нас, боловсрол, соёл, хэлний бэрхшээлтэй хүмүүсийн дижитал чадварын ялгаа хүртээмжийг бууруулдаг. (Nuwasiima, 2024) Үүний улмаас нийгмийн үйлчилгээний ижил хүртээмжтэй байдал сөргөөр нөлөөлж, өрхийн амьдралын чанарт шууд нөлөө үзүүлдэг тул улс орнууд, байгууллагууд дижитал боловсрол, боломжийг нэмэгдүүлэх бодлого, төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна. (Afrouz, 2023)

ДҮГНЭЛТ

Технологийн хөгжил нь нийгмийн ажлын онол, арга зүй, практикт суурь өөрчлөлт авчирч байна. Хиймэл оюун ухаан, өгөгдлийн аналитик, цахим платформ зэрэг дэвшилтэт технологийн шийдлүүд нь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шийдвэр гаргалтыг өгөгдөлд суурилсан, шинжлэх ухааны байдлаар хийх боломжийг нэмэгдүүлж байна. Үүний зэрэгцээ, салбар хоорондын хамтын ажиллагаа, инновацын экосистемийг өргөжүүлэх шинэ гарц бий болж байна.

Телехалт, цахим зөвлөгөө, кейс менежментийн автоматжуулалт зэрэг технологи нь алслагдсан бүс нутгийн иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, нийгмийн ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжих боломжийг бүрдүүлж байна. COVID-19 цар тахлын үед нийгмийн ажилтнууд харилцаа, үйлчилгээний арга барилаа цахим технологид тулгуурлан шинэчилсэн нь

практикт эерэг үр нөлөө үзүүлснийг судалгаагаар нотолсон. Жишээлбэл FaceTime, Zoom, Skype зэрэг платформууд нь үйлчлүүлэгчидтэй итгэлцэлтэй харилцаа бий болгоход тустай байсан бол Apricot, Casebook зэрэг программ хангамжууд нь мэдээлэл удирдах, ажлын уялдаа холбоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан байна.

DSM-5-TR, Google Translate**,** мөн Calm, Thought Diary зэрэг хэрэгслүүд нь оношилгоо, харилцаа, сэтгэлзүйн дэмжлэгийг газар зүйн хязгаарлалтаас үл хамааран хүргэх боломжоор хангаж байна. Мөн удирдлагын түвшинд цахим гарын үсэг, календарийн систем, Google Docs зэрэг хэрэгсэл нь багийн зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулсан. Түүнчлэн Magic Notes зэрэг хиймэл оюунд суурилсан системүүд уулзалтын тэмдэглэл, дүгнэлтийг автоматжуулж, захиргааны ажлын ачааллыг бууруулахад дэмжлэг үзүүлж байна.

АНУ-д нэвтрүүлж буй урьдчилан таамаглах алгоритмууд (predictive algorithms) нь гэмт хэрэгт өртөмтгий бүлгийн эрсдэлийг үнэлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг хөгжүүлэхэд ашиглагдаж байна. Иймд технологийн дэвшил нь нийгмийн ажлын салбарт хүний оролцоо, мэргэжлийн үнэлгээг дэмжихийн зэрэгцээ шийдвэр гаргалтыг системчилсэн, үр дүнтэй болгох шинэ боломжуудыг нээж байна.

Нийгмийн ажлын шинэ загварууд нь AI, машин сургалт (ML), өгөгдлийн аналитик зэрэг технологийг практикт нэвтрүүлснээр илүү үр дүнтэй, шинжлэх ухаанд суурилсан үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж байна. Жишээлбэл, Австралийн Client Risk Assessment систем нь эрсдэлийг эрт илрүүлж, оновчтой шийдвэр гаргалтыг дэмждэг болох нь судалгаагаар нотлогдсон (2023).

Салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих цахим платформууд нь кейсийн мэдээллийг боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүй зэрэг салбаруудтай хуваалцан, хамтын шийдвэр гаргалтыг хөнгөвчилж байна. Мөн Борман **(**Bohrman) боловсруулсан “Ухаалаг нийгмийн ажил” (Smart Social Work) загвар нь хиймэл оюуныг мэргэжлийн ёс зүй, хүний үнэлгээг хослуулсан хэрэгсэл болгон ашиглаж, эрсдэлийг урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлж байна.

Ийнхүү хиймэл оюун болон дижитал технологид суурилсан шинэ шийдлүүд нь нийгмийн ажлын хүртээмж, үр нөлөө, хариу арга хэмжээний чанарыг шинэ түвшинд хүргэж байна. Гэсэн ч Монгол Улсад энэ үйл явц

анхан шатандаа явж байгаа бөгөөд AI, өгөгдлийн систем, дижитал платформын хэрэглээний үр нөлөө, хууль эрх зүйн зохицуулалт нь бүрэн төлөвшөөгүй хэвээр байна.

Хэдийгээр E-Mongolia болон И-халамжийн онлайн систем, цахим зөвлөгөөний туршилт зэрэг нь дэвшлийн эхлэл болсон ч систем хоорондын уялдаа, мэдээллийн аюулгүй байдал, мэргэжлийн ёс зүйн зохицуулалт хангалтгүй байна. Хиймэл оюун ухааныг нэвтрүүлснээр цаг хэмнэх, хүртээмж нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг боломжууд бий болж байгаа ч хууль, ёс зүйн зохицуулалт тодорхойгүй байдалтай байна. Тухайлбал AI-ийн хариуцлагын тогтолцоо, мэдээллийн хамгаалалт, ёс зүйн хүрээ тодорхой бус, сул хэвээр байна. Иймд дараах чиглэлүүдэд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- AI-д суурилсан эрсдэлийн үнэлгээний үндэсний загвар боловсруулах;
- Кейс бүртгэлийн нэгдсэн өгөгдлийн сан байгуулах;
- Телесоциал ажлын стандарт, цахим ёс зүйн удирдамж боловсруулах, хэрэгжүүлэх.

Түүнчлэн техник зохион байгуулалтын чадамж, хууль эрх зүйн үндэслэл, мэргэжлийн ёс зүйн зохицуулалтыг цогцоор шийдвэрлэснээр ухаалаг технологийн шилжилтийг тогтвортой хөгжлийн стратеги болгон хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Энэ нь Монгол Улсад хүний төвтэй, шинжлэх ухаанд суурилсан, хүртээмжтэй нийгмийн ажлыг хөгжүүлэх суурь нөхцөл болно.

Гэсэн хэдий ч энэхүү шинэчлэл нь мэдээллийн аюулгүй байдал, ёс зүйн тодорхойгүй байдал, дижитал хуваагдал зэрэг сорилтыг давхар дагуулж байна. Иймд технологийн хөгжлийг техникийн төдийгүй нийгмийн, ёс зүйн, бодлогын хүрээнд цогцоор судалж, олон талт хамтын ажиллагаа, зохицуулалтаар дэмжих шаардлагатай.

Цаашид нийгмийн ажилтнууд зөвхөн үйлчилгээ үзүүлэгч бус, технологи бүтээлцэгч, судлаач, ёс зүйн хяналт хэрэгжүүлэгч болох шаардлагатай. Ингэснээр тэд тэгш байдал, шударга ёс, хүний эрх, хамтын оролцоог дижитал эрин зуунд ч хадгалан, технологийг нийгмийн ажлын үнэт зарчимтай уялдуулсан, илүү хүртээмжтэй, хүний хөгжилд чиглэсэн практик хөгжүүлж чадна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нийгмийн ажилтны дижитал чадавхыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх

- Аймаг, дүүргийн түвшинд нийгмийн ажилтнуудад хиймэл оюун, кейс систем, өгөгдөл ашиглах чадварыг эзэмшүүлэх богино хугацааны сургалт, цахим сертификатын систем нэвтрүүлэх.
- Цахим платформууд (Zoom, Apricot, Casebook зэрэг)-ыг ашиглах чадварыг жигд түвшинд хүргэх.

Технологийн туршилтын загваруудыг хэрэгжүүлэх (пилот төсөл)

- Хүүхэд хамгаалал, сэтгэл зүйн зөвлөгөөний чиглэлээр AI chatbot, автомат сануулга, телесоциал үйлчилгээний загваруудыг тодорхой бүс нутагт туршиж, үнэлгээ хийх.
- Үр дүнтэй туршлагыг үндэсний түвшинд өргөжүүлэх арга зүй боловсруулах.

Салбар хоорондын хамтын ажиллагааг платформоор дэмжих

- Боловсрол, эрүүл мэнд, хууль зүйн байгууллагуудын хооронд өгөгдлийн уялдаа, хамтарсан кейс менежментийг дэмжих API систем, цахим шийдлийг хөгжүүлэх.
- Triple Helix (төр – хувийн хэвшил – иргэний нийгэм) загварын хүрээнд хамтрагч талуудын үүрэг, оролцоог тодорхой болгох.

Судалгаа, үнэлгээний тогтолцоог бий болгох

- Хиймэл оюун ухаан, өгөгдлийн системийн хэрэглээний үр нөлөөг тогтмол үнэлэх үндэсний индикатор боловсруулах.
- Судалгаанд суурилсан бодлого боловсруулах тогтолцоог хөгжүүлэх (их сургууль–төрийн байгууллага–мэргэжлийн холбоо хамтран).

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Afrouz, M. (2023). Digital divide and access to social services in rural communities. Journal of Social Work Technology, 15(2), 120–135. https://www.emerald.com

2. Bohrman, L. L. (2021). Artificial intelligence assisted case management in social work services: A systematic review. Research on Social Work Practice. https://doi.org/10.1177/10497315251329531

3. Digital Government and Triple Helix. (2022). Digital Government and Triple Helix: Estonia Case Study, 1.

4. Li, L., & Wang, M. (2025). Artificial intelligence–assisted case management in social work services: A systematic review. Research on Social Work Practice. Retrieved from https://journals.sagepub.com

5. Lucas, R. A. (2023). A systematic review of technology-mediated social work practice: Benefits, uncertainties, and future directions. Journal of Social Work. Retrieved from https://journals.sagepub.com

6. Nuwasiima, M., & Peterson, M. (2024). The role of artificial intelligence (AI) and machine learning in social work practice. World Journal of Advanced Research and Reviews. Retrieved from https://wjarr.com

7. Nuwasiima, M., & Peterson, M. (2024). The role of artificial intelligence (AI) and machine learning (ML) in social work practice. World Journal of Advanced Research and Reviews.

СУРАЛЦАГЧДЫН ТУУШТАЙ ЗАН ЧАНАР, ТЭСВЭР ХАТУУЖЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ БАГШИЙН УР ЧАДВАР

TEACHING METHODOLOGIES FOR DEVELOPING STUDENTS' PERSEVERANCE AND RESILIENCE

С.Цэрэндолгор

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн багш, хошууч

S.Tserendolgor

Senior lecturer, Department of Warding and Intelligence, the School of Court Decision Execution, University of Internal affairs, Master and Major;

Хураангуй: Ажлын байранд тулгардаг хүний нөөцийн асуудлын гол шалтгаануудад "Сэтгэл ханамж" буюу алба хаагчдын ажлын байрнаас халшрах хам шинжээс шалтгаалсан шилжилт хөдөлгөөн ордог. Энэ асуудал хувь хүний зорилго, хатуужил, тэс тэвчээр, сахилга баттай хамааралтай байх боломжтой гэж үзсэн тул дотоод хэргийн их сургуулийн суралцагч нарын тууштай зан чанар, тэсвэр хатуужил, урт хугацааны зорилгыг тодорхойлон, дээрх хамаарлыг нотлохын тулд "Цагдаа судлал", "Хил судлал", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль"-ийн "Аюулгүй байдал судлал", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл", "Нийгмийн ажил" хөтөлбөрүүдэд суралцаж буй 110 суралцагч нараас "GRIT" буюу тэсвэр хатуужил номын судалгааны 8 асуумжаар судалгаа авч, судалгаанд анализ хийх аргыг ашигласан. Судалгааны үр дүнд урт хугацааны зорилгоо тодорхойлж, зорилгоо биелүүлэхийн төлөө тууштай, бэрхшээлийг даван туулж чадах сэтгэлийн тэнхээтэй суралцагч нарын эзлэх хувийг тодорхойлохыг зорьсон. Судалгаанд оролцогчдын 80-95% нь бэрхшээлд шантардаггүй, эхлүүлсэн ажлаа дуусгаж чаддаг, өөрийгөө хөдөлмөрч тууштай гэж тодорхойлсон. Гэвч урт хугацааны сахилга бат, сонирхлын тогтвортой байдал, холын зорилгыг тодорхойлох ур чадвар 70-85% аар сул гэж тодорхойлогдсон. Энэ үр дүн манай сургуулийн суралцагч нарын 95% нь богино хугацааны зорилго, зорилтыг биелүүлэх тэсвэр хатуужилтай боловч урт хугацааны зорилгыг хэрэгжүүлэх тууштай зан чанар, сонирхлын

тогтвортой байдал сул байгаа нь багш нар анхаарал хандуулж, дээрх зан чанар, тэсвэр хатуужил суулгах шинэлэг арга зүйд суралцах шаардлагатай гэж үзсэн.

Abstract: Employee turnover in the workplace is often driven by key human resource challenges, among which job dissatisfaction, including burnout among personnel, is a major contributing factor. This issue may be related to individual characteristics such as personal goals, resilience, perseverance, and self-discipline. Therefore, this study aimed to examine the level of perseverance, resilience, and long-term goal orientation among students of the Internal Affairs University and to explore the potential relationship between these factors.

To achieve this objective, a survey based on the 8-item GRIT scale developed by Angela Duckworth was administered to 110 students enrolled in the programs of "Police Studies," "Border Studies," and the School of Court Decision Enforcement, including "Security Studies," "Court Decision Enforcement," and "Social Work." Quantitative data analysis methods were applied to interpret the findings.

The study aimed to determine the proportion of students who demonstrate strong perseverance in achieving long-term goals and possess the mental resilience to overcome challenges. The results indicated that 80–95% of participants reported that they do not give up easily when facing difficulties, are capable of completing tasks they have started, and consider themselves hardworking and persistent.

However, 70–85% of respondents showed relatively lower levels in terms of long-term self-discipline, consistency of interests, and the ability to define long-term goals. These findings suggest that while approximately 95% of the students possess the resilience necessary to achieve short-term goals, their perseverance, consistency of interests, and commitment to long-term goals remain comparatively weak.

Түлхүүр үг: Сахилга бат, тууштай зан чанар, тэсвэр хатуужил, GRIT

Key words: Self-discipline, perseverance, and resilience are key components associated with grit in achieving long-term goals

Удиртгал: Энэхүү судалгаа нь дотоод хэргийн их сургуулийн сурагчдын нарын сахилга бат, тэсвэр хатуужлыг сайжруулахад багш нарын заах арга зүй, сургалтын шинэлэг аргыг нэвтрүүлэх шаардлагатай болохыг тодорхойлох зорилго тавьсан.


"Сахилга бат" гэдэг нь дүрэм журмыг чанд дагаж мөрдөх хүмүүжил гэж тодорхойлсон (тайлбар, 2026). “Тэсвэр тэвчээр” гэдэг нь хүний зовлон бэрхшээл, элдэв зүйлийг хүлцэн дааж өнгөрүүлэх чадварыг хэлнэ (тайлбар, 2026).

Багш нар сурагчдын хувьд манлайлагч, үр дуурайлал авдаг хүмүүсийн эгнээнд багтана. Сурагчдын амжилттай сурагчах, эзэмшсэн мэргэжлээрээ тууштай ажиллах, амжилт гаргах нь багшийн ур чадвараас ихээхэн хамааралтай. Энэ нь багш сурагчийг ойлгох, аливаа асуудлын мөн чанарыг тайлбарлан, таниулах, тэднийг алдаа гаргах бүрд шалтгаан, нөхцөлийг олж мэдэх, туслан, дэмжих замаар сурагчийг нарт төлөвшил, зөв хүн байхад нөлөөлөх нь сургалтын чанарт эерэг үр дүнг бий болгох боломжтой.


Дотоод хэргийн их сургуулийн эрхэм зорилго нь нийгэмд шударга ёсыг тогтоох чин эрмэлзэл, төлөвшил бүхий иргэнийг бэлтгэх, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын мэдлэг оюуны төв байна гэж тодорхойлсон. Зөв хүн байхад шаардлагатай олон ур чадвар байдаг ч ихэнх суурийг гэр бүлийн орчноос олж авдаг. Их сургуульд элсэн сурагчаж байгаа 18-22 насны сурагчийг шударга, ёс зүйтэй, төлөвшсөн иргэн болгож бэлтгэхэд сахилга бат, тэсвэр хатуужил, тууштай зан чанарт зайлшгүй сурагчах шаардлагатай.



Дээрх судалгааг цагдаа судлал, хил судлал, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, аюулгүй байдал судлал хөтөлбөрийн 110 суралцагчаас “тэсвэр хатуужил, тууштай зан чанар”-ыг тодорхойлох 8 асуумжийг google form ашиглан авсан (Duckworth, 2016). Судалгааны нэгдүгээр асуумж: Шинэ санаа, санаачилга нь заримдаа тухайн хүний өмнө эхлүүлсэн ажлуудад төвлөрөх анхаарлыг сарниулах хандлагатай байдаг уу? гэсэн асуултад нийт оролцогчдын 84.8% нь урт хугацааны зорилгод төвлөрөхөөс илүү шинэ санаа, боломжид анхаарал сарних хандлагатай байгааг харуулж байна.




Судалгаанд оролцогчдын ихэнх буюу 80% нь саад бэрхшээлийг даван туулах чадвартай, тууштай байдлын өндөр түвшинтэй байгааг харуулж байна.




Судалгаанд оролцогчдын 80% нь сонирхол тогтворгүй гэж хариулсан нь аливаа санаа, үйл ажиллагаанд богино хугацаанд өндөр


сонирхол үзүүлдэг боловч түүнийг урт хугацаанд хадгалах чадвар сул байгааг харуулж байна.




Судалгаанд оролцогчдын 93% нь өөрсдийгөө шаргуу хөдөлмөрч гэж өндөр түвшинд үнэлсэн нь тэдний хичээл зүтгэл, тууштай байдлын үзүүлэлт өндөр байгааг харуулж байна.




Судалгаанд оролцогчдын 75% нь зорилгоо тогтвортой баримтлах бус, тодорхой хугацааны дараа өөрчлөх хандлагатай байгаа нь урт хугацааны зорилгын тууштай байдал сул байгааг илтгэнэ.



Судалгаанд оролцогчдын 86% нь урт хугацааны үйл ажиллагаанд анхаарлаа тогтвортой хадгалах чадвар сул байгааг харуулж байна.



Судалгаанд оролцогчдын 94% нь эхлүүлсэн ажлаа дуусгах чадвар өндөр байгаа нь хичээл зүтгэлийн тууштай байдал сайн хөгжсөнийг харуулж байна.




Судалгаанд оролцогчдын 95% өөрсдийгөө тууштай, нягт нямбай гэж дүгнэсэн байна. Үр дүнгээс үзэхэд суралцагчид богино хугацаанд идэвхтэй, хөдөлмөрч боловч урт хугацааны зорилгыг баримтлах, нэг чиглэлд тууштай ажиллах чадвар дутмаг байна. Энэ нь орчин үеийн анхаарал сарниулах хүчин зүйлс, зорилгын тодорхой бус байдалтай холбоотой байж болзошгүй дээрх судалгаанаас харж болно.

Дотоод хэргийн их сургуулийн суралцагч нарын тууштай, тэсвэр хатуужилтай зан чанар нь богино хугацаанд илэрч, урт хугацаандаа зорилгоо биелүүлэх тэсвэр хатуужил, тууштай зан чанар сайтар төлөвшөөгүй болохыг судалгаанаас харж байна. Энэ нь суралцагч нарын урт хугацаандаа амжилттай ажиллах, мэргэжилдээ тууштай суралцах, мэргэших ур чадварыг багш нар заар арга зүйдээ тухайлан зааж, жил бүр үнэлгээ хийж, арга аргачлалаа шинэчлэн, сайжруулж, төлөвшсөн иргэнийг бэлтгэх сургалтын шинэ арга зүйд суралцах шаардлагатай гэж үзсэн.

Академик мэдлэгийг өдөр бүр хуваарийн дагуу технологийн зөрчилгүй зохион байгуулж байгаа ч төгсөгч нарын ажлын байран дээрх судалгааны үр дүн хангалтгүй үзүүлэлттэй байдаг. Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн “Аюулгүй байдал судлал” хөтөлбөрийн боловсролын магадлан итгэмжлүүлэх тайланд 2021 оны 13 төгсөгчид мөшгих судалгаа хийхэд 2 төгсөгч 1-3 жилийн хугацаанд ажлаас гарсан байна. (судлал, Аюулгүй байдал, 2025). Ажлаас гарсан төгсөгчийн тоо 2 байгаа нь бага тоо мэт боловч, урт хугацаандаа тууштай ажиллах төгсөгчдийн эзлэх хувь буурч, энгийн сургууль төгссөн алба хаагчдын эзлэх хувь нэмэгдэх боломжтой.

“Аюулгүй байдал судлал” /2019-2024/ хөтөлбөрийн суралцахуйн үр дүн /plo/-д хийсэн судалгаанд 54 суралцагч хамрагдсан. Энэ судалгаа нь суралцагчдын сэтгэл ханамжийн байдалд тулгуурлан таамаглал дэвшүүлж сургалтын чанар, сургалтын орчин, багшийн харилцаа, хандлага мэргэжлийн ур чадвар суралцагчдын сэтгэл ханамжид хэрхэн нөлөөлдгийг судлахыг зорьсон.

Зураг. Суралцагчийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн таамаглал




Дээрх судалгаанд суралцагч 4 хүчин зүйлээс шалтгаалан сэтгэл ханамжтай суралцах боломжтой гэдгийг харуулж байна. Судалгаанд хамрагдсан 54 суралцагчдын 50 хувь нь багш нарын дэмжин туслах үйлчилгээ амжилттай суралцахад чухал нөлөөтэй гэж тодорхойлсон байна (судлал, Аюулгүй байдал, 2025).

Ирээдүйн хууль сахиулах салбарын алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, эзэмшсэн мэргэжилдээ эзэн болоход багш нарын “Манлайлах” ур чадварыг нэмэгдүүлэх, бусдад эергээр нөлөөлөх, зөв иргэн байх, хуулийг хэрэгжүүлэхэд ёс зүйтэй, урт хугацааны зорилгоо тодорхойлж чаддаг, тууштай, өөрийн хамгийн сайн хувилбар бүтээх тэсвэр хатуужилтай төрийн алба хаагчийг бэлтгэхэд шаардлагатай ур чадваруудыг тогтмол эзэмшүүлэхэд хэрэгтэй мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааг сургалтаас гадуур зохион байгуулахад манлайлж оролцох ёстой.

“Z” үе буюу 1998 оноос хойш төрсөн хүүхдүүд 1-4 дүгээр дамжаанд суралцаж байна. Эдгээр хүүхдүүдийн суралцах орчин нөхцөл бидний таамаглалаас давсан. Үүний тод илрэл нь “Хиймэл оюун” буюу AI-д суурилсан платформ, программ, гар утасны хөгжлийг дурдаж болно.

Багш нар өөрсдийн туршлага, мэдлэгт суурилан суралцагч нарт үнэ цэнтэй мэдээлэл олгодог ч цахим орчны эх сурвалж тодорхойгүй мэдээллээр тархи цэнэглэж байгаа энэ үеийн хүүхдүүдийг хэрхэн зөв хүн болгож, төлөвшүүлэх бэ? Гэсэн асуулт урган гарч байна.

Судлаач миний хувьд “ChatGPT” -г сургалтад ашиглахыг хориглох эрх байхгүй, харин хэрхэн зохистой хэрэглэж болох талаар зааварчилгаа өгөх боломжтой. Энэ өгүүлбэр танд ойлгомжгүй санагдаж байвал дараах судалгаагаар эргэлзээг тань багасгахыг зорилоо. Судалгаанд хамрагдсан суралцагч нарын сэтгэл ханамжид нөлөөлөх хувьсагчдын уялдаа, холбоо, хамаарлыг Cronbach’s Alpha-ийн хэмжүүрээр шинжилсэн. Үүнд:



Зураг.Суралцагчийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн тоон шинжилгээ

Хэмжилзүйн шинжилгээний үр дүн нь энэхүү судалгааны ажлын хамгийн чухал бөгөөд судалгааны үр дүнг боловсруулах, харьцуулах шинжлэх, бататгах, дүгнэх хэсэг юм. Уг шинжилгээгээр далд хувьсагч бүр манлайлалд хэрхэн нөлөөлж байгааг харуулж, хүчин зүйл тус бүрийн үр дүнг гаргасан болно. Кронпа альфа буюу тогтвортой байдал нь далд хувьсагчдын багц үзүүлэлт хоорондоо хэрхэн уялдаатай байгааг илэрхийлнэ. Найдвартай байдлын хэмжүүрийг дараах томьёогоор тодорхойлон үр дүнг гаргасан.

N далд хувьсагчийн тоо ʊ дундаж дисперс č Дундаж ковариац

Хүснэгт №1. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн

Хувьсагчид	**Далд хувьсагч**	**Cronbach’s Alpha**	**Найдвартай байдал**	**Дундаж хазайлт**
Сургалтын чанар, үнэлгээ	СЧ-1	**0.848**	**0.847**	**0.483**
	СЧ-2			
	СЧ-3			
	СЧ-4			
	СЧ-5			

	СЧ-6			
	СЧ-7			
Дэмжин туслах үйлчилгээний үнэлэмж	ХХ-1	**0.853**	**0.852**	**0.497**
	ХХ-2			
	ХХ-3			
	ХХ-4			
	ХХ-5			
	ХХ-6			
	ХХ-7			
Багшийн заах арга, хандлага, ёс зүй	БЗ-1	**0.898**	**0.891**	**0.623**
	БЗ-2			
	БЗ-3			
	БЗ-4			
	БЗ-5			
Оролцогч талуудын оролцоо	От-1	**0.909**	**0.901**	**0.615**
	От-2			
	От-3			
	От-4			
	От-5			
	От-6			
Суралцагчийн сэтгэл ханамж	СХ-1	**0.935**	**0.935**	**0.643**
	СХ-2			
	СХ-3			
	СХ-4			
	СХ-5			
	СХ-6			
	СХ-7			
	СХ-8			

Судалгааны дүнд суралцагчийн сэтгэл ханамжид нөлөөлөх хувьсагчдын уялдаа холбоо, хамаарлыг Cronbach's Alpha-ийн хэмжүүрээр шинжилсэн. Үүнд:

- 0.6-аас бага байвал үр дүнгүй;
- 0.6-0.8 хүртэл найдвартай тохиромжтой үр дүнтэй
- 0.8-аас их байвал найдвартай маш сайн гэж үздэг.

Сургалтын чанар, үнэлгээний Cronbach's Alpha нь 0.848, найдвартай байдал (Дотоод нийцлийн хэмжүүр) 0.847[8], AVE 0.483, Дэмжин туслах үйлчилгээний үнэлэмжийн Cronbach's Alpha 0.853, нийлмэл найдвартай байдал 0.852, AVE 0.497, Багшийн заах арга, хандлага, ёс зүй Cronbach's

[8] Утга нь 0-ээс 1 хооронд хэлбэлздэг бөгөөд өндөр утга нь найдвартай байдлын өндөр түвшинг харуулж байна.

Alpha 0.898, нийлмэл найдвартай байдал 0.891, AVE 0.623[9], Оролцогч талуудын оролцооны Cronbach's Alpha **0.909,** нийлмэл найдвар **0.901** (судлал, Аюулгүй байдал, 2025).

Хүснэгт №2: Замын шинжилгээний үр дүн

	Original sample (O)	Sample mean (M)	Standard deviation (STDEV)	T statistics (|O/STDEV|)	P values
Багшийн заар арга, хандлага, ёс зүй -> Сонсогч, суралцагчийн судалгаа	0.323	0.331	0.123	2.622	0.009
Дэмжин туслах, үйлчилгээний үнэлэмж -> Сонсогч, суралцагчийн судалгаа	-0.080	-0.081	0.131	0.610	0.542
Оролцогч талуудын оролцоо -> Сонсогч, суралцагчийн судалгаа	0.482	0.472	0.102	4.744	0.000
Сургалтын чанар, үнэлгээ -> Сонсогч, суралцагчийн судалгаа	0.287	0.289	0.124	2.306	0.021

Замын шинжилгээгээр судалгааны таамаглал хэрхэн батлагдах эсэхэд SMART PLS 4.0 програмаар санал асуулгын тоо мэдээнд дүн шинжилгээ хийлээ.

Судалгааны үр дүн T статиктик утга хамгийн их ач холбогдлыг илэрхийлдэг. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн үр дүнгээс харахад T статистик[10] нь Пи[11] (P) утгыг олоход ашигладаг ба Пи утга нь 0 утга үнэн гэж үзвэл тэг рүү ойртох тусам статистикийн хувьд таамаглал батлагдлаа гэж үзнэ.

Үүнээс дүгнэж үзвэл Суралцагчийн сэтгэл ханамжид "Багшийн харилцаа, хандлага" ,"Оролцогч талуудын оролцоо", "Сургалтын чанар,

[9] 0.5-аас дээш AVE утгыг ерөнхийд нь зөвшөөрч болохуйц гэж үздэг, 0.483 AVE утга нь үзүүлэлтүүдийн хэлбэлзлийн ойролцоогоор 55.3% нь далд бүтэцтэй холбоотой болохыг харуулж байгаа бөгөөд энэ нь нилээд сайн бөгөөд нийлмэл хүчин төгөлдөр байдлыг харуулж байна. Энэ нь шалгуур үзүүлэлтүүд нь хэмжих ёстой бүтцийг хангалттай төлөөлж байна гэсэн үг юм.

[10] Энэ нь түүврийн дундаж болон таамагласан олонлогийн дундаж хоорондын зөрүүг авч, түүврийн дундажийн стандарт алдаанд хуваах замаар тооцоологддог.

[11] Пи (P value) тэг рүү ойртох тусам таамаглал статистикийн хувьд ач холбогдол бүхий гэж үздэг. Өөрөөр хэлбэл таамаглал батлагдаж байна гэж үзнэ.

үнэлгээ” гэсэн гэсэн хүчин зүйлс нөлөөлдөг гэсэн таамаглал батлагдлаа (судлал, Аюулгүй байдал, 2025).

Дэмжин туслах үйлчилгээний үнэлэмж гэсэн хүчин зүйл нь онолын хувьд суралцагчийн сэтгэл ханамжид нөлөөлөх боловч бидний судалгаагаар нөлөөлдөг эсэх нь батлагдаагүй бөгөөд бид цаашид эдгээр хүчин зүйлийн далд хувьсагчид болох асуултуудад анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл эдгээр хувьсагчид суралцагчдын хувьд сэтгэл ханамж үүсгэж чадахгүй байгаад анхаарах шаардлагатай. Судалгааг 2025 онд 1-4 дүгээр дамжааны суралцагч нараас авсан. Судалгааны үр дүнд багш, суралцагч нарын дэмжин туслах үйлчилгээ сэтгэл ханамжтай суралцахад 50% чухал гэж үзсэн ч үлдсэн 50% суралцагч нар сэтгэл ханамжийг өөр зүйлээс авах магадлалтай гэж таамаглал гаргасан. Үүнд суралцагч нарын бие хүний онцлог, ирээдүйд хэн болохыг зорьдог, тэд юу хийж чадахыг хэлж өгөх, урамшуулах, тууштай хөдөлмөрлөх, бэрхшээл бол хүн бүрд тулгардаг амьдралын дүрэм гэдгийг мөн чанарын түвшинд тайлбарлах нь багшийн заах арга зүйн чухал хэсэгт хамаарахыг харуулж байна.

Судалгаагаар багш, суралцагч хоёрын харилцаа буюу дэмжин туслах нь сургалтын чанар, ирээдүйн төлөвшсөн иргэнийг бүтээхэд чухал гэж тодорхойлохыг хичээсэн ч хиймэл оюуны эрин үед багшийн өгсөн даалгаврыг хийхийн тулд 2-3 ном, өгүүлэл, цахим эх сурвалж ашиглахын оронд ChatGPT рүү нэвтэрч ороод нэг кноп дараад хүссэн мэдээллээ авч, хэн байх аа заалгаж байгааг хэрхэн зохицуулах талаар бид анхаарал

хандуулж эхэлсэн ч нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байна. Хиймэл оюун бол алгоритм буюу программ. Гэтэл суралцагч нар багшаас асуухыг урьтал болголгүй, цахимаас мэдээлэл авч, түүндээ итгэж, шийдвэр гаргаж байгаа нь ирээдүйн төлөвшсөн, тууштай, тэсвэр хатуужилтай хууль сахиулагч, иргэнийг бүтээхэд томоохон саад болж байгааг дахин сануулъя.

Багш нар суралцагчдын хиймэл оюуны хэрэглээг багасгах боломжгүй ч шинжлэх ухааны хандлагад нөлөөлөх боломжтой. Ингэхийн тулд гэрийн даалгаврыг бүтээлч байдлаар хийлгэх, симуляц сургалтын аргыг түгээмэл ашиглах, өөрийн биеэр үлгэрлэж, бодит жишээтэйгээр амжилттай хүний дадлыг хичээл бүрийн эхэнд тайлбарлан, ярьж өгөх энгийн аргуудыг тогтмол хийх нь чухал гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

Дотоод хэргийн их сургуулийн суралцагч нарын тууштай, тэсвэр хатуужилтай зан чанарыг хөгжүүлэхийн тулд амьдралын зорилгоо тодорхойлох, хэрхэн зорилгодоо хүрэх талаар богино хугацааны сургалт зохион байгуулдаг байх.

Амьдралын зорилгоо тодорхойлж чадсан суралцагчдын тэсвэр хатуужил, бэрхшээлийг даван туулах сэтгэл зүй, сахилга бат, тууштай зан чанарыг хөгжүүлэх бие бялдар, оюун санааны бясалгалын хөтөлбөрт тогтмол хамруулах

Сургалтын хөтөлбөрт заасан хичээлээс гадна, нэмэлтээр бүтээлч сэтгэлгээ, тэсвэр хатуужил, алдаагаа даван туулах сэтгэл зүйг хөгжүүлэх орчин бүрдүүлэх, туршилт хийх боломжоор хангах

Сахилга бат, тэсвэр хатуужил, тууштай зан чанар нь хувь хүний амьдралын чанар, хүсэл мөрөөдөл, эрүүл аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй талаар багш нар хичээл эхлүүлэхээс өмнө тайлбарлан, яриа таниулга хийж байх

Суралцагч нарын анхаарал төвлөрөл, бүтээлч сэтгэлгээ, тууштай байдлыг үнэлэх үнэлгээний системийг бүтээх

АШИГЛАСАН ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

1. https://www.pewresearch.org/
2. GRIT, Angela Duckworth., USA., 2016
3. As a motivational speaker, Sinek has spoken at the UN Global Compact Leaders Summit in 2016
4. Unlock podcast “GRIT”., Уб., 2022
5. https://www.linkedin.com/in/tamir-altandush
6. Аюулгүй байдал судлал хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан., 2025

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ БА ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ХҮРТЭЭМЖИЙН АСУУДАЛ

Ишдоржийн САНЧИРГАРАВ

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр Гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын тэнхимийн багш, хууль зүйн магистр, хошууч Sanchirgarav.201@gmail.com

SANCHIRGARAV Ishdorj

Lecturer, Security Department, the School of Court Decision Execution, University of Internal affairs, Master in law, and major; Sanchirgarav.201@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн зохицуулалт, ялангуяа хорих ял эдлүүлэх ажиллагаанд оролцох үеийн эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг судлан шинжилсэн. Судалгаанд олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичиг, бодит нөхцөл байдлын жишээг ашиглан харьцуулсан болон задлан шинжилгээний аргыг хэрэглэв. Судалгааны үр дүнд Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч түүний хэрэгжилтийн түвшин хангалтгүй, ялангуяа хорих байгууллагын хүртээмж, дэд бүтэц, үйлчилгээний чанарт доголдол байгааг тогтоов. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг бодитой хангахын тулд эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

Abstract: This article examines the legal regulation of the rights of persons with disabilities, with a particular focus on the implementation of their rights during the process of serving imprisonment sentences and the challenges encountered therein. The study employs comparative and analytical methods based on international and national legal instruments, as well as real-life practical examples. The findings indicate that, although Mongolia has established a legal framework to protect the rights of persons with disabilities, its implementation remains insufficient. In particular, there are notable shortcomings in the accessibility, infrastructure, and quality of services within correctional institutions. Therefore, the study concludes that it is necessary to improve the

implementation of legal regulations in order to effectively ensure the rights of persons with disabilities.

Түлхүүр үгс: хөгжлийн бэрхшээл, хүний эрх, хүртээмж, хорих анги, эрх зүй

Keywords: Disability, human rights, accessibility, correctional facilities, law

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль, эрх зүйн зохицуулалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцод:

Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр шүүхийн шатны бүх үйл ажиллагаа, түүний дотор мөрдөн байцаалт болон шүүхийн өмнөх шатны бусад ажиллагаа зэрэг хууль эрх зүйн бүх ажиллагаанд шууд болон шууд бус оролцох үүрэг, тухайлбал гэрчийн хувьд үр нөлөөтэй оролцох явдлыг байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээ болон насны онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах замаар шүүх ажиллагаанд хүртээмжтэй, үр дүнтэй оролцох эрхийг оролцогч улсууд хангана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх ажиллагаанд үр дүнтэй, хүртээмжтэй оролцох нөхцөлийг хангах үүднээс оролцогч улсууд шүүхийн байгууллагуудад тухайлбал, цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг зохих сургалтад хамруулах явдлыг дэмжинэ

Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх

Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийг хангах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүний дараахь эрхийг хангана:

a/ Эрх чөлөөтэй байх, хувийн халдашгүй эрхээ эдлэх;

b/ Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур тэдгээр хүний эрх чөлөөг үл хасах, эсхүл зөвхөн хуульд нийцсэн журмын дагуу эрх чөлөөг хасах болон аль ч тохиолдолд хөгжлийн бэрхшээл нь эрх чөлөөг нь хасах үндэслэл болохгүй байх.

Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх чөлөөг аливаа журмын

дагуу хассан бол уг тохиолдолд оролцогч улсууд нь бусадтай адил тэгш нөхцөлийн үндсэн дээр боломжит хэрэглэгдэхүүнээр хангахыг оролцуулан энэхүү конвенцийн зорилго, зарчим болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байдлаар тэдэнд хандах явдлыг хангана.

Монгол Улсын үндсэн хуульд:

Монгол улсын иргэн бүр Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд ч боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд:

Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

Хууль зүйн туслалцаа авах эрх

✓ Шүүх прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

✓ Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай хууль зүйн зөвөлгөө, тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

✓ Шүүх прокурор, хууль хяналтын байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүнд түүний эрх, үүрэг болон холбогдох мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж өгнө.

✓ Шүүх прокурор, хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх

үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ба үйлчилгээний зардлыг улсын төсөвт тусгана.

Эрүүгийн хуульд:

✓ Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх

✓ Хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;

✓ Асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;

✓ Таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд:

✓ Хоригдлын хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй хоригдлыг бие, эрүүл мэндийн нөхцөлд нь таарсан ажил гүйцэтгүүлж болно.

✓ Хорих анги хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын онцлог байдлыг хүндэтгэсэн, тэдгээрийн эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн хорих ял эдлүүлэх ажиллагаанд оролцох явцад гарах хүндрэл бэрхшээлийн талаар:

Үндсэн эрхийг хязгаарлаж болох үндэслэлийг олон улсын хэм хэмжээ, Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ зөвхөн онцгой нөхцөлд л гэж байгаа юм. Тэр нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээс урган гардаг. Улмаар хуульд үндэслэгдсэн байх ёстой. Түүнээс хорих ангид хоригдож буй, ял шийтгэл эдэлж буй гэдэг үндэслэлээр сурч боловсрох, хөгжих эрхийг хязгаарлаж болохгүй. Үүнтэй

холбоотой хөгжлийн бэрхшээлтэй хоригдол ч адил, тэгш эрхээр хангагдсан байх ёстой юм.

Тухайлбал, сурч хөгжих эрх хаана байхаас үл хамаарч хүн бүрд хүртээмжтэй байх ёстой гэсэн үүднээс хоригдол байх хугацаандаа ч мэдлэг боловсролоо дээшлүүлэх, өөрийн зардлаар их дээд сургуульд суралцах, өдөр тутмын сонин, сэтгүүл захиалах, хорих анги дахь номын санг үнэ төлбөргүй ашиглах зэрэг эрхүүдийг нэг бүрчлэн зааж баталгаажуулсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын тухайд авч үзвэл:

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ болон хөгжлийн бэрхшээлийн төрөл болон насны ангиллаас хамаараад сурч боловсрох хүсэл эрмэлзэл нь янз бүр байдаг. Хорих ангиас зохион байгуулдаг хууль эрх зүй, зан үйлд нөлөөлөх сургалт, бичиг үсгийн болон үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцлөөс хамааран нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар, төрийн бус байгууллагуудтай хамтран төлөвлөгөө боловсруулан сургалтанд хамруулдаг.

Мөн хорих ангиас сулагдан гарахад нийгэмд байр сууриа олж амьдрах, амьжиргааны түвшинээ дээшлүүлэх, ажил хөдөлмөрт хамрагдах зэрэгт дэмжлэг үзүүлэн сантехник, авто засварчин, барилгын засал чимэглэл, гагнуурчин, тогооч, мужаан, гар урлалын сургалтыг зохион байгуулж мэргэжлийн үнэмлэх олгодог.

Хорих ангиас зохион байгуулж буй сургалтанд нийт хоригдлууд заавал хамрагдсан байх ёстой ба мэргэжил олгох сургалтанд хоригдлууд өөрсдийн саналаар болон нийгмийн ажилтан санал болгосноор суралцдаг.

Хэдий хорих байгууллагад сургалтыг шат дараалалтай орж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй хоригдол сургалтанд хамрагдахад төдийлөн орчин бүрэн бүрдээгүй байна. Жишээлбэл сургалтанд хамруулж буй өрөө хоригдлын байрны 2 давхарт байрладаг. Энэ нь тулгуур эрхтний бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй хоригдолд маш хүндрэлтэй байх ба сургалтыг явуулж буй сургагч багш дохионы хэлний мэдлэггүйгээс сонсголын бэрхшээлтэй хоригдол сургалтанд хамрагддаггүй. Зайлшгүй хууль эрх зүй, зан үйлд нөлөөлөх сургалт, бичиг үсгийн болон үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцлөөс хамааран нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар,

төрийн бус байгууллагуудтай хамтран хорих ангиас зохион байгуулж буй сургалтанд хамрагддаггүй.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хоригдол номын сангаар үйлчлүүлж ном, сонин, сэтгүүл уншиж өөрийгөө хөгжүүлэх боломж муу. Учир нь орчин нөхцөл бүрдээгүй, брайл үсгээр бичсэн ном, товхимол байдаггүйтэй шууд утгаар холбогдож байна.

2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хоригдол арьсан урлал-4, мужаан-6, сантехник-3, тогооч-8 мэргэжлийн үнэмлэх олгох сургалтад хамрагдсан байдлаас харж болохоор байна.

Монгол улсын хорих байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн дэд бүтэц, барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг хангасан эсэх

Хоригдолтой ажиллах наад захын жишиг дүрэмд:

✓ Хоригдлуудын ашиглаж байгаа бүх өрөө тасалгаа, түүний дотор унтлагын өрөө нь ариун цэврийн бүх шаардлага хангасан байх ёстой бөгөөд эдгээр өрөөний хэмжээ ноогдох талбай, гэрэлтүүлэг, халаалт, агааржуулалтыг онцгой анхаарвал зохино.

Хоригдлуудын амьдарч ажиллаж байгаа өрөө тасалгаанд:

а/ Цонх нь байгалийн гэрэлд уншиж, ажиллаж болох хангалттай хэмжээтэй, агааржуулалтын хиймэл системтэй эсэхээс үл хамааран цэвэр агаар орохоор хийгдсэн байвал зохино.

б/ Хиймэл гэрэлтүүлэг нь хоригдлын хараанд аюулгүй, уншиж, ажиллаж болохоор хангалттай байвал зохино.

✓ Ариун цэврийн төхөөрөмжүүд нь хоригдол бүр шаардлагатай үедээ цэвэр, тохиромжтой нөхцөлд өөрийн байгалийн хэрэгцээгээ хангаж болохоор хангалттай байвал зохино.

Дээрх жишиг дүрэмд нийт хоригдлын өрөө болон ариун цэврийн өрөөний байх ёстой шаардлагын талаар дурдсан боловч хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эрхийг хангах үүднээс шаардлагтай зам, талбай, ариун цэврийн өрөөний талаар тусгайлан дурдагдаагүй байна.

Хорих байгууллагын дэд бүтцэд мөн хөгжлийн бэрхшээлтэй хоригдолд зориулсан ариун цэврийн өрөө огт байхгүйгээс гадна налуу зам зарим хорих ангид байдаг ч стандартад нийцдэггүй байна.

1.1 НАЛУУ ЗАМ

1.1.1. Явган хүний зам, талбайн түвшин барилга байгууламжийн шалны хоорондох уналтын зөрүү 4 см-ээс их бол налуу зам, эсхүл шат төлөвлөнө.

1.1.2. Налуу замын бүтээц, тэдгээрийн хаалт хамгаалалтыг галд тэсвэртэй материалаар хийнэ. Гал тэсвэрлэлтийн хязгаар 2 цагаас багагүй байна.

1.1.3. Налуу замын өгсөлт бүрийн эхлэл, төгсгөл дээр тэгш талбайг төлөвлөх ба өргөн нь налуу замын өргөнөөс багагүй, урт нь 1.5 м-ээс багагүй байна. Налуу замынчиглэлийг өөрчлөх тохиолдолд тэгш талбай нь өргөн дугуйт тэргэнцэр эргэхэд саадгүй байна.

1.1.4. Дугуй хэлбэрийн налуу замыг нормын дагуу төлөвлөж болох ба дугуй хэлбэртэй налуу замын завсар хоорондын талбайн урт түүний радиусаас хамаарч 2м-ээс багагүй байна.

1.1.5. Налуу зам, тэгш талбайн захаар 5 см-ээс багагүй өндөртэй хашлага хийх шаардлагатай.

1.1.6. Барилгад тэргэнцэртэй хүн хэн нэгний тусламжгүйгээр нэвтрэх боломжийг хангаж, шалны хоорондох уналтын зөрүү 4 см -ээс их бол налуу зам хийх ба зам нь 1х12 харьцаа бүхий налуутай байна. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт зай хэмжээ, харагдах байдлыг Зураг 1 -т үзүүлэв.



Зураг 1. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт
(Жишээ зураг)

1.1.7. Их

1.2.1 Шат нь хөгжлийн бэрхшээлтэй хүн, бага насны хүүхэд, өндөр настан зорчиход тав тухтай, аюулгүй байх үүднээс гишгүүрийн өндрийн хэмжээ жигд, мөн халтирахгүй материалаар хийгдсэн байна.


1.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний явах чигийн дагуу шатны гишгүүр нягт, тэгш, тээглэх зүйлгүй, гадаргуу нь бага зэрэг барзгар байна.

1.2.3 Гишгүүрийн ирмэг 5 см-ээс багагүй дугуйралтай байна.

1.2.4 Шатны гишгүүрийн захаар 2 мм-ээс багагүй хашлага байна.Шатны гишгүүрийн өргөн гадна шатанд 40 см, дотор шатанд 30 см, харин гишгүүрийн өндөр гадна шатанд 12 см, дотор шатанд 15 см байна.

1.2.5 Шатны бариул нь өргөн голчтой бат бөх байвал барихад амар, тулгуур сайтай байна.

1.2.6 Шатны барьц бариул нь ханатай зэрэгцэн тогтоогдсон бол хана, бариулын хооронд зайтай байна.




Зураг 5. Шатны бариул (Жишээ зураг) / бариуланд хараагүй хүний тэмдэглэгээ хийх /

1.2.7 Барьц бариулууд нь ханын хөндийд тогтоогдсон бол ханын хөндийн дээд, доод хэсгийн налуугийн өндөр тооцогдсон байна.

1.2.8 Хараагүй болон сул хараатай хүнд зориулж шатны гишгүүрийг дээрээс нь доош, бариулын хэсэг, шатны эхлэл, төгсгөлийн гишгүүрийг талбайн гадаргууг барзгар болгох буюу тод өнгөөр тэмдэглэнэ.

1.2.9 Гишгүүрийг тод өнгөөр ялгаж будах буюу гишгүүрийн

гадаргууг гэрэлтэй өнгөөр, ирмэгийг хар бараан өнгөөр ялгаж болно. Гишгүүрийг доороос гэрэлтүүлж болно.



Зураг 6. Шатны гишгүүр болон бариулын хэмжээ (Жишээ зураг)


1.3 АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ

1.3.1 Олон нийтийн барилгын ариун цэврийн өрөөнд тэргэнцэр болон бусад хэрэгсэл ашиглах хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулан ариун цэврийн өрөөг төлөвлөнө.

1.3.2 Ариун цэврийн өрөөний өргөн 1.65 м, урт нь 1.8 м, хаалганы өргөн 0.9 м-ээс багагүй, босгогүй байна.


1.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний ариун цэврийн өрөө, бусад өрөөний хаалгыг гадагшаа онгойхоор төлөвлөнө.

1.3.4 Тэргэнцрээс бие засах суултуурын нэг талаас шилжин суух хангалттай зайтай байна.



Зураг 7. Орон сууцны угаалгын өрөөний жишиг зураг (Жишээ зураг)

Нийтийн бие засах хэсгийн нэг өрөө(кабин)-г тулгуур, таяг болон бусад тоног, хэрэгсэл ашигладаг хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж хажуугийн хана дагуулсан бариул, хувцасны өлгүүр, бусад хамрагдах тоноглолын хамт тохижуулж төхөөрөмжилнө.




Зураг 8. Тулгуур таяг ашигладаг ХБХүнд зориулсан өрөө (Жишээ зураг)

1.3.5 Бие засах өрөөний орцын хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүн саадгүй харах боломжтойгоор таних тэмдгүүдийг өнгөөр болон товойлгон бичиж байрлуулах ёстой. Таних тэмдгүүд нь бүх барилгад адил байна. Эрэгтэй, эмэгтэй хүн бие засах өрөөг цуг (нэг дор) байршуулахыг хоригпоно.

1.3.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэргэнцрээс суултуур дээр шилжиж суух боломжийг хангахын тулд ариун цэврийн өрөө(кабин)-нд байгаа суултуурын хажуу хэсэгттэргэнцэр байршуулах чөлөөт орон зай (талбай) гаргана.

1.3.7 Ариун цэврийн өрөөний бие засах газарт 1 хөтөвчийг шалнаас 0.4 м өндөрт ихгүй өндөрт, 2 талд нь босоо тулгуур бариул хийж өгнө.



Зураг 9. Тулгуур таяг ашигладаг ХБХүнд зориулсан хөтөвч (Жишээ зураг)

1.3.8 Нийтийн зориулалттай бие засах өрөөний гар угаах хэсэгт тосгуурыг шалнаас 0.8 м-ээс ихгүй өндөрт, хажуугийн хананаас 0.2 м-ээс багагүй зайд, толь, гар хатаах төхөөрөмж болон гар нүүрийн алчуур хатаах өлгүүрийг (доод ирмэг хүртэлх зай) шалнаас 0.9 м-ээс ихгүй өндөрт байршуулна. Мөн тосгуурыг өрөөнд тусад нь төлөвлөж болно.

1. Тэргэнцрийн налуу зам стандарт шаардлага хангаж байгаа

эсэхийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан шалгана. Үүнд:

Хүснэгт 1. Тэргэнцрийн налуу замын шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Хүний зориулалттай /орон сууц, олон нийт/ барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүний орох боломжийг хангасан налуу зам болон бусад тоног төхөөрөмжүүд /орох түвшин хүртэл хэрэглэх өргүүр/-ээр тоноглосон эсэх	□	□
2	Налуу замын өгсөлт бүрийн эхлэл төгсгөл дээр тэгш талбайг төлөвлөх ба өргөн нь налуу замын өргөнөөс багагүй, урт нь 1.5м-ээс багагүй байна. Налуу замын чиглэлийг өөрчлөх тохиолдолд тэгш талбай нь өргөн дугуйт тэргэнцэр эргэхэд саадгүй байгаа эсэх	□	□
3	Налуу зам, тэгш талбайн захаар 5см-ээс багагүй өндөртэй хашлагатай эсэх	□	□
4	Явган хүний замын урт, налууг интервалаар шаталсан хэлбэрээр төлөвлөсөн эсэх	□	□
5	Налуу замыг халтирахаас сэргийлсэн барзгар гадаргуутай байхаар төлөвлөсөн эсэх	□	□
6	Налуу 6%-с дээш бол бариул нэмэлтээр төлөвлөсөн эсэх	□	□
7	Налуу замын эхлэл төгсгөлд бариулыг 0.3м-ээс ихгүй илүү гаргаж төгсгөсөн эсэх	□	□
8	Бариулын хөндлөн огтлолын диаметр 3см-ээс багагүй 5см-ээс ихгүй, хөндлөн огтлолоор зузаан нь 0.04м-ээс ихгүй байгаа эсэх	□	□

Нийтийн бие засах газрын стандарт шаардлага хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан шалгана. Үүнд:

Хүснэгт 2. Ариун цэврийн өрөөг хүлээн авах шаардлага

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүнд зориулсан нэгээс доошгүй тасалгааг төлөвлөсөн эсэх	□	□
2	Нийтийн бие засах хэсгийн нэг өрөө(кабин)-г тулгуур, таяг болон бусад тоног, хэрэгсэл ашигладаг хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан хажуугийн хана дагуулсан бариул,хувцасны өлгүүр, бусад хамрагдах тоноглолын хамт тохижуулж төхөөрөмжилсөн эсэх	□	□

3	Эрэгтэй хүний нийтийн бие засах өрөөнд шалнаас 400мм өндөрт нэгээс доошгүй тооны хөтөвч (писсуар)-ийг байршуулах бөгөөд түүний хоёр хажуу талд тулж барих бариулыг босоо чиглэлд тоноглосон эсэх	□	□
4	Ариун цэврийн өрөөний стандарт геометр хэмжээ тохирч байгаа эсэх	□	□
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлэх боломцоог хангасан эсэх	□	□
6	Таних тэмдгүүдийг өнгөөр болон товойлгон бичиж байрлуулсан эсэх	□	□
7	Иж бүрэн тоноглогдсон эсэх. (өлгүүр, хогийн сав, гар хатаагч, бариул, ариун цэврийн цаас гэх мэт.)	□	□
8	Гар угаах хэсэгт нэгээс цөөнгүй тосгуурыг шалнаас 800 мм-ээс ихгүй өндөрт, хажуугийн хананаас 200 мм-ээс багагүй зайд суурилуулсан эсэх	□	□
9	Толь, гар хатаах төхөөрөмж болон гар нүүрийн алчуур хатаах өлгүүрийг (доод ирмэг хүртэлх зай) шалнаас 900 мм-ээс ихгүй өндөрт байршуулсан эсэх	□	□

Хорих ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын судалгаа, хорих байгууллагын дэд бүтэц болон сурч боловсрох эрх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хэрхэн зохион байгуулагдсан талаарх судалгаа


Ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын судалгаа[12]


Хөгжлийн бэрхшээлтэй хоригдол мэргэжил эзэмших сургалтанд хамрагдсан талаар?



[12] ШШГЕГазраас авсан судалгаа


Хөгжлийн бэрхшээлтэй нийт хоригдолтой харьцуулахад мэргэжил олгох сргалтанд хамрагдсан.








Хоригдлын байранд налуу зам байдаг эсэх талаар?



Хөгжлийн бэрхшээлтэй хоригдолд зориулсан стандарт ариун цэврийн өрөө байгаа эсэх талаар? [13]



ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар хорих ялыг биечлэн эдлүүлэхээс гадна “Хорих ял шийтгүүлсэн хоригдлын гэмт санаа бодлыг арилгах, засан төлөвшүүлэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, их дээд сургуульд элсэн суралцуулах” зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсад хэрэгжиж, даган мөрдөж буй хууль эрх зүйн акт болох Монгол Улсын нэгдэн орсон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль цаашлаад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хорих ангийн дотоод журам зэрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг ял эдлүүлэх” талаар зохицуулсан заалт огт тусгагдаагүй, хорих ялаар шийтгэгдсэн хөгжлийн

бэрхшээлтэй хоригдлыг /энгийн, бүрэн чадвар, чадамжтай/ хоригдлын нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх орчин нөхцөлд ял эдлүүлж байна.

Хорих ялаар шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг тохирсон ажлын байраар ханган ажиллах, хөдөлмөрт хамруулах болон сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгах, ар гэртэй холбон зуучлах, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, тогтоолгох, сунгах, эрүүл мэндийн болон нийгмийн бусад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж байгаа нь сайшаалтай боловч тэдний үндсэн эрх болох сурч боловсрох эрх хангалттай түвшинд хүрч чадахгүй, хорих ангийн дэд бүтэц тэдний орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангах, тулгуур эрхтэний бэрхшээлтэй, сонсгол болон хэл ярианы, харааны бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй болон дотор эрхтний өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хоригдлуудад зориулсан төлөвлөлт байхгүй байна.

ИНТЕРНЭТИЙН ОРЧИНД ЗАЙН СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАХ СУДАЛГАА

A STUDY ON THE ORGANIZATION OF DISTANCE LEARNING IN THE INTERNET ENVIRONMENT

Б.Дэнсмаа. ДХИС-ийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, ахлах дэслэгч

Densmaa B. Senior Lieutenant, Lecturer, Department of Civil Enforcement of Court Decisions, Study and Research Unit №403-School of Court Decision Execution, University of Internal Affairs

Хураангуй: Холбоо, мэдээллийн технологийн хурдацтай хөгжил нь хүн төрөлхтөнд өргөн боломжуудыг бий болгож байна. Үүний нэг жишээ нь боловсролын салбар дахь зайн сургалтын систем юм. Мэдээллийн даяарчилал эрчимтэй явагдаж буй өнөөгийн нөхцөлд иргэдийн боловсролын түвшинг дээшлүүлэх чадваржуулах нь боловсролын системийн тулгамдсан асуудал болж байна.

Гадаадын улс орнуудын сургалтын системийн туршлагаас үзэхэд ихэнх томоохон их сургуулиуд нь сургалтын системдээ зайн сургалтыг нэвтрүүлж баклавар, магистр, докторийн сургалтуудыг явуулж байна.

“Монгол улсын хэмжээнд 1990 ээд оноос хойш зайн сургалтыг хогжүүлж ирсэн. Томоохон их дээд сургуулиуд зайн сургалтыг нэвтрүүлж баклавар, магистр болон нарийн мэргэжлийн сургалтуудыг явуулж байна” (Д, 2025).

Зайн сургалтын системд зориулагдан зохиогдсон нээлттэй эхийн програм хангамжуудыг сайтар судлах, шаардлагатай бол өөрсдийн эх хэлрүү хөрвүүлэн, хөгжүүлэлт хийн ашиглах явдал юм. Дэлхийн мянга мянган мэргэжилтнүүдийн хамтран зохион бүтээж, байнга шинэчилсээр ирсэн нээлттэй эхийн програм хангамжийг ашиглах нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэхээс гадна ирээдүйтэй арга зам байж болох юм.

Түлхүүр үгс: зайн сургалт, интернэт, программ, сүлжээ.

Abstracr: he rapid development of information and communication technology has created unprecedented opportunities for humanity. One notable example of this progress is the emergence and expansion of distance learning

systems within the field of education. In the context of accelerating information globalization, enhancing the educational level and capacity of citizens has become a pressing issue for modern education systems.

An examination of international educational practices indicates that many leading universities have successfully integrated distance learning into their academic systems, offering undergraduate, master's, and doctoral programs through online platforms.

In Mongolia, distance learning has been developing since the 1990s. Major universities have adopted distance education and currently offer undergraduate, graduate, and specialized professional training programs through this mode of delivery.

A critical aspect of advancing distance learning systems lies in thoroughly studying open-source software designed for such purposes. Where necessary, these systems can be localized into the native language and further developed to meet specific needs. Utilizing open-source software—continuously developed and updated through the collaborative efforts of thousands of experts worldwide—not only reduces time and financial costs but also represents a sustainable and forward-looking approach.

Keywords: Distance Learning, Internet, Software, Network

УДИРТГАЛ:

Одоогийн байдлаар дэлхийн ихэнх өндөр хөгжилтэй орнуудын их дээд сургуулиудын сургалтын үйл явц, системийг ажиглаад үзэхэд ихэнх нь урьдын бичиг цаастай зууралдаж цаг их алддаг уламжлалт аргыг ардаа орхиж тоон технологи тэр тусмаа интернэтийн сүлжээг ашиглан сурах хугацааг багасгаж, сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлээд зогсохгүй сургалтын төлбөрийн төсвийг ихээхэн хэмнэж байна. Тооцоолон бодох төхөөрөмж компьютерийн хурдацтай хөгжлийн оргил үе гэж хэлж болох 20-р зууны сүүлчээс Америк, Европын их дээд сургуулиуд сургалтын системдээ техникийн дэвшлийг нэвтрүүлэж байна. Зайн сургалтын хэлбэр гэдэг нь сургууль, багш нар оюутнуудтайгаа зайнаас харилцаж, сургалтын процессийг зөвхөн сургууль дээр байх хугацаанд биш интернэтийн сүлжээг ашиглан хүссэн үедээ, хүссэн цагтаа суралцах боломжийг олгодгоороо давуу талтай (mn.wikipedia.org/wiki/Зайны_сургалт, n.d.).

Аливаа систем төгс байж чаддаггүйтэй адил зайн сургалтын систем ч гэсэн өөрийн дутагдалтай талтай. Ахмад үеийн багш нар үүнийг хэрэгжүүлснээр оюутнууд хэт их бэлэнчлэх сэтгэлгээтэй болдог, хүн хоорондын харилцааг багасгадаг, олон цагаар компьютерийн дэлгэц шагайх нь эрүүл мэндэд муу, сүлжээний ачааллыг нэмэгдүүлж, компьютерийн тэжээлээс ялгарах нүүрстөрөгч нь бидэнд хортой, цаашлаад дэлхийн дулааралд хүртэл нөлөөлдөг гэж үздэг. Дэлхийн нийтээрээ глобалчлагдаж хаанаас ч ямар ч мэдээллийг богино хугацаанд олж авах боломжтой болж байгаа энэ эрин үед бид цаг үеэсээ хоцролгүй техник технологийн ололт дэвшлийг өөрсдийн орчин нөхцөлд тохируулж нэвтрүүлэх нь эрхэм зорилго болоод байна.

ҮНДСЭН БИЧВЭР:

Зайн сургалт бол үнэндээ танхимын сургалттай бараг л ижил юм. Гэвч түүний ялгагдах гол ялгаа нь ямар нэгэн холбогдох зам байх ёстой. Жишээ нь гар утас ч юм уу, компьютерыг нэрлэж болох юм. Гар утсаар алсын зайн сургалт явуулах бүрэн боломжтой. Зайн сургалтыг зарим талаар электрон сургалт буюу е-сургалт гэж нэрлэдэг. Тэгвэл е-сургалт нь дотоод сүлжээнд ажилладаг. Интернэтэд ажилладаг гэх мэтээр ангилагдана. Зайн сургалт нь текст, видео, аудио, виртуал орчин гэх мэтээс бүрдэнэ. Алсын зайн сургалт нь зарим тохиолдолд маш өндөр үр дүнтэй байдаг. Маш сурахдаа олж аваагүй мэдлэгээ компьютерээсээ хэдхэн цагийн дотор олж мэдээд сурчих тохиолдол байдаг. Иймээс Зайн сургалт нь орчин үед заавал байх ёстой хэрэгтэй. Зайн сургалтаар сурч байхад хүн өөрийнхөө хувийн онцлогт тохируулаад бас өөрөө өөрийгөө хянаад сураад байх боломжтой байдаг нь том давуу тал юм. (Н, 2021) Сүүлийн жилүүдэд хүчирхэг программууд гарсантай холбоотойгоор маш их үр дүнтэй, бүтээмжтэй Зайн сургалтыг бүтээх, зохион байгуулах боломж бүрдэж байна. Монгол улсын дотоодын их дээд сургуулиудын хэмжээнд авч үзвэл зайн сургалт, электрон сургалт бүртгэлийн систем бүрэн утгаараа хэрэгжиж чаддаггүй ч тодорхой хэмжээнд нэвтэрсэн. Жишээ нь: Оюутны хичээл сонголтыг вебээр хийх, оюутны дүнгийн мэдээллийг веб-д байрлуулах, номын сангийн бүртгэлийн систем, дотоод сүлжээний аюулгүй албаны хяналтын программыг ашигладаг.

1. Зайн сургалтын төвшингүйд (Ковид-19 хямрал бх сургалтын хөтөлбөр, 2020)

Зайн сургалт нь үндсэндээ 4-н хэсэгт хуваагддаг. Хамгийн энгийнээсээ хамгийн дэвшилттэй рүү нь эрэмбэлсэн.

- Мэдлэгийн санд суурилсан сургалт

Үүнийг яг зайн сургалт гэхэд хэцүү ба гэхдээ түүнд хүнд сургах, мэдүүлэх үндсэн шинж байгаа учраас алсын зайн сургалтад заавал оруулдаг. Жишээ нь: программ болгонд Help гэж байдаг түүнд программын зааврууд, ажиллах зарчим хэргийг бичсэн байдаг. Энэ бол мэдлэгийн сангийн нэгэн жишээ юм. Түүнчлэн encyclopedia бол ийм сангийн сонгодог жишээ. Тодорхой үгээр хайлт хийн өөрийн хэрэгцээт сэдвээ гаргаж байна гэдэг бол хэрэглэгчтэй харьцаж байгаа бөгөөд үүнийг интерактив программ гэж нэрлэдэг.

- Онлайн сургалт

Онлайн дэмжлэг гэдэг форум, чатын өрөө, онлайн самбарууд, асуулт хариултын хэсэг, и-мэйл, шууд мессежний үйлчилгээ орох болно. Өмнөх мэдлэгийн санг бодвол илүү интерактив, бас илүү нарийвчилсан төвшинд харьцах боломжтой юм.

- Бодит биш хугацааны сургалт

Ихэнхдээ CD-ROM дээрх интернэт болон дотоод сүлжээ, вебээ суурилсан алсын зайн сургалтууд энэ төрөлд ордог. Зааварчлагч багш бүх шаардлагатай хичээл, материалуудыг нэгэнт бэлдээд хөтөлбөрийн дагуу тавьчихсан байдаг бөгөөд хичээллэгч нь онлайн зааврын дагуу ажиллахад л болно. Хэрэглэгчтэй хамт хэн нэгэн зэрэг хичээллэх шаардлагагүй бөгөөд хэрэглэгч дуртай үедээ хичээл рүүгээ орон хичээллэх боломжтой.

- Бодит хугацааны сургалт

Энэ хэлбэр нь алсын зайн сургалт болохоос биш яг үнэндээ танхимын сургалттай бараг ижил юм. Амьд багш анги бүрдүүлж хэсэг хүмүүсийг нийлүүлэн товлосон цагтаа вебдээ орох ёстой. Тэгээд л веб болон компьютер ашиглан хоорондоо харилцаж суралцах үйл явц юм. Энэ бүхэн бас л өөрийн давуу талуудтай. Жишээ нь: газар зүйн байрлалаас үл хамааран хэрэглэгчид нэг дороо суралцах боломжтой болж байдаг. Бас

бодит ангид хичээллэхгүй тул нэг дор хэчнээн ч хүн суралцах боломжтой бөгөөд энэ нь хэрэглэгчид нэг нэгэндээ огт саад болохгүй гэж бодохоор гайхалтай үр дүн үзүүлдэг.

2. Зайн сургалтыг сонирхолтой болгох аргууд (Ковид-19 хямрал бх сургалтын хөтөлбөр, 2020)

Шинэ материал, шинэ процесс, шинэ программ бүтээхэд маш олон янзын дэд элементүүдийг ашигласнаар сонирхолтой болгодог. Ингэснээр илүү үр дүнтэй боддог. Гэхдээ мэдээж бүх л сургалтыг Е-Сургалт болгох аргагүй ч ихэнх сургалтыг алсын зайнаас явуулж болдог байна. Е-Сургалтыг амжилттай болгоход дараах зүйлс чухал үүрэгтэй.

- Агуулгыг төрөлжүүлэн ангилах

Зураг, дуу, текст зэрэг нь хамтдаа бөгөөд харилцан зохилдлогоотой ажиллаж чадвал тархинд маш хүчтэйгээр нөлөөлж гүн цээжлэгдэх нь гарцаагүй.

- Анхаарал татахын тулд олон талт сонирхолтой зүйлсийг зохиох

Тоглоом тоглуулах, таавар таалгах, дэлгэц дээрээс юм олуулах гэх мэтээр илүү сонирхолтой байдлыг хангаж чадвал суралцагчийг залхаахгүй, уйдаахгүй байх юм.

- Тэр дор нь засах аргачлалаар хангах

Е-сургалтын хамгийн том давуу тал бол суралцагч буруу хариулж байгааг тэр дор нь засах боломжтой байдаг явдал юм. Сургалтын явцад аль нэг хэсэг дээр буруу ойлгосон тохиолдолд түүнийг аль болох хурдан засаж залруулах нь их чухал юм. Яагаад гэвэл ямар ч сургалт нь өмнөх сурсан дээрээ нэмж сурах байдлаар дөрөөлж явдаг юм. Тэгэхээр аль нэг алхам дээр буруу сурсан тохиолдолд цаашдаа тэр чигээрээ буруу явах аюултай. Тэгэхээр харилцан хариу өгөх систем нь их чухал байдаг. Сайн хийгдсэн зайн сургалт нь ийм системээр сайн хангагдсан байдаг.

- Бусад зайн-суралцагч болон зайн-багштай харилцах багажуудаар тоноглох

Чатын өрөө, хэлэлцүүлгийн самбар, шууд мессеж, и-мэйл зэрэг багажууд нь суралцагч хүнд маш их хэрэг болдог чухал багажууд билээ.

Тэгэхээр зайн сургалт нь эдгээр багажуудыг аль болох л сайн ашиглахаар төлөвлөгдөх нь зүйтэй юм.

- Интерактив

Зайн сургалт нь интерактив буюу олон талт ажиллагааг санал болгодог. Харилцан контактаа байдгийн хамгийн энгийн жишээ нь та асуултуудын хариултыг дарж сонгосноор илэрч байдаг. Түүнчлэн хичээлийн үед объектыг чирч зов байрлалд оруулж байгаа нь харилцан үйлчлэлцэж байгаа хэрэг. Интерактив тоглоомууд нь сургалтын маш хүчирхэг хэрэгсэл юм. Өмнө нь яагаад олигтой суудаггүй байсан хүүхэд интерактив тоглоомоор маш их зүйл сурч авдаг нь батлагдсан зүйл. Тоглоом тоглож байхад хүүхэд залуус өөрсдөө ч анзаарахгүйгээр орчин тойрон, хэл ус болон бусад юм үзэгдлийн тухай маш их мэдээлэл авч суралцаж байдаг юм. Тэгвэл энэ байдлыг нь олон олон программууд ашиглахыг хичээдэг. Энэ бүхэн нь сургалтын шилдэг аргуудын нэг юм.

Монгол Улсын зайн сургалтын өнөөгийн байдал

Манай улсад 1990-ээд оны эхнээс зайны сургалтын хөгжлийн эхлэл тавигдаж, тусгайлан сонгосон зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан зайны сургалт явуулах талаар багагүй туршлага хуримтлуулж иржээ. Ялангуяа, НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-ын дэмжлэгтэйгээр 1992-1997, 1997-2001 онд Монгол улсын БСШУЯ-аас хэрэгжүүлсэн Говийн малчин эмэгтэйчүүдийн сурч боловсрох хэрэгцээг хангах албан бус боловсрол, Сурч амьдаръя зэрэг төсөл нь Монголын онцлогт тохирсон зайны сургалтын өвөрмөц бүтэц тогтолцоо, арга зүйг боловсруулан хэрэглэсэн байна (П, 2021).

БСШУЯ-ны Алсын Зайн Сургалтын Систем	БСШУЯ Мэдээлэл холбооны технологийг боловсролын бүх салбарт ашиглан, багш нарын болон бусад салбарын боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх зорилтын хүрээнд УБ хот болон 18 аймгуудыг хамарсан зайн сургалтын бие даасан томоохон сүлжээг байгуулж өнөөдрийн байдлаар боловсролын салбарын уулзалт семинар, сургалтууд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хурал семинаруудыг зохион байгуулж байна.

Edu Olloo	2009 онд интернэт мэдээллийн сайт "www.olloo.mn" сайтын захиалгаар Бисиконсалтинг ХХК хийж гүйцэтгэсэн. Энэ сургалтын онцлог нь Монголд анх удаа 5000 үнэтэй 3 сарын эрхтэй карт ашиглан интернэтээр Англи хэлийг дуу, дүрс, тесктэн хэлбэрээр сурах боломжийг олгосон. Интернэтээр сургалт явуулдаг энэ төрөл нь Монголд шинээр нэвтэрч байгаа тул төдийлөн хүн болгонд хүрч чадаагүй. Сайтын хандалтыг харахад өдөрт дунджаар 200 гаруй зочид нэвтэрдэг бөгөөд байнгын 2-3 гишүүн 10 орчим зочид үзэж байдаг.
EnglishEZ- Англи хэлний 7 хоногийн туршилтын сургалт	Olloo.mn сайтаас хойш гарч ирсэн интернэтээр төлбөртэй карт худалдан авч англи хэл сургах зорилготой шинэ вэбсайт юм. Хөгжилтэй, хурдан, хаанаас ч хэзээ ч уриатай энэ сургалтад хамрагдахын тулд 5 төрлийн үнэ бүхий нийт 4 сарын хугацаатай карт худалдан авч суралцдаг.
ШУТИС-Е-Сургалт	2007 оноос эхлэн Шинжлэх ухаан технологийн их сургууль нээлттэй сургууль, зайн сургалтын системийг хэрэгжүүлж Магистрын төвшний сургалтыг зайнаас суралцах боломжтой болгосон. Их дээд сургуулийн боловсролын системд анх удаагаа хэрэгжүүлж эхэлсэн гэж хэлж болохоор энэ сургалтын системийн давуу тал нь интернэтийг сүлжээг ашиглан зайнаас багш нарын бэлдсэн аудио, видео, текст хичээлүүдийг хүссэн үедээ үзэж суралцах бололцоотой.
CISCO сүлжээний академи	1999 оноос эхлэн сүлжээний төхөөрөмж үйлдвэрлэгч "CISCO" компанийн харьяа CISCO Networking Academy байгуулагдсан бөгөөд дэлхийн олон орны их дээд сургуулиудтай хамтарч зайнаас багш, оюутнуудын суралцах, шалгалт өгөх орчныг бүрдүүлж өгсөн иж бүрэн интерактив веб сургалт.
OCW-OpenCourseWare	2002 оноос эхэлж АНУ-н Массачутесийн Технологийн их сургууль энэхүү төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд интернэтээр бүгдэд нээлттэйгээр, үнэ төлбөргүй хүргэж чадсанаараа алдартай. Одоогийн байдлаар нийт 1900 гаруй хичээлийн агуулга материал үнэ төлбөргүйгээр англи хэл дээр байршаад байна.
Moodle- Модулийн Объект Чиглэлтэй Динамик Сургалтын Орчин	Австралийн Moodle компанийн боловсруулсан зайн сургалтын ERP Moodle систем нь нээлттэй эх код нь үнэгүй байдаг тул дэлхийн олон орны боловсролын системд хэрэглэгдэж байгаа. Систем нь дуут, график

	харьцуулалт, асуулт хариулт, хэлэлцүүлэг хүссэнээрээ өргөтгөж сайжруулж өөрсдийн системд нэвтрүүлэх боломжтойгоороо давуу талтай. 2009 оны 2 сарын байдлаар албан ёсоор бүртгэгдсэн 49,256 веб сайтад 28,177,443 хэрэглэгчтэйгээр 2,571,855 гаруй хичээлийн материал байршуулагдсан судалгаа гарсан байдаг.

Хүснэгт1: Монгол Улсад ашиглагдаж байгаа зайн сургалтын системүүд судалгаа

Монголын их дээд сургууль, сургалтын төвүүд ч дээрх системийг судлан өөрсдийн системд нэвтрүүлэх гэж оролдсон боловч хэт нүсэр, хөгжүүлэхэд бага зэрэг хэцүү гэсэн шалтгаанаар төдийлөн газар авч чадаагүй. Тухайлбал КТМС 2007 онд Японы хөрөнгө оруулалтаар Moodle системийг хэрэгжүүлэх гэж оролдож байсан. МУИС Боловсролын их сургуульд нэвтрүүлж байсан. USI мэргэжил сургалтын төв Moodle системийг яг одоогоор ашиглаж байна.

Зайн сургалтын системд ашиглаж болох нээлтэй болон бусад программ хангамж

Зайн сургалтын системд нээлтэй эхийн хөгжүүлэлт хийгдэж байгаа болон албан ёсоор зарагдаж байгаа олон системүүд байдгаас доорх системүүдийг хамгийн шилдэг нь гэж үздэг. (Д, 2025)

Big Blue Button	Зайн сургалтын энэхүү систем нь веб дээр суурилагдсан бөгөөд их дээд сургуулийн сургалтад тохиромжтой. Давуу тал маш ихтэй программ хангамжийн тал дээр linuxubuntuүйлдлийн систем дээр суурилагдсан.
Open meeting	Зайн сургалтын энэхүү систем нь веб дээр суурилагдсан. Аудио, видео болон самбар, бичиг баримтаа хуваалцах (share) мөн дэлгэцээр бичих боломжийг олгодог.
WebHuddle	Виртуал уулзалтын платформ бөгөөд үнэтэй болон үнэгүй хувилбаруудтай веб дээр суурилсан аппликейшн.
Tokbox	Open tokплатформын API бөгөөд хэрэглэгчид кодыг өөрчлөн зохион байгуулах боломжтой. Цэвэрхэн дизайн болон нэмэлт олон боломжийг агуулсан вебд суурилсан программ хангамж.
Saba meeting, saba webinar, saba classroom	Saba нь веб дээр суурилсан зайн сургалтын платформ бөгөөд мөн хүний нөөцийн программ хангамж юм. Зуу зуун байгууллага сургалтын төв, сургуулиуд ашигладаг

	бөгөөд үйлдвэрлэлийн байгууллагууд түлхүү ашиглаж байна.
WebEx	Cisco іпс компанийн зайн сургалтын систем бөгөөд сургалтын орчны бүхий л шаардлагыг хангасан веб суурилсан веб аппликейшн юм. Дэлхийн олон сая хэрэглэгчдэд webex-ээр дамжуулан боловсрол олгодог ба cisco inc.компани харилцаа холбоо сүлжээний салбарт тэргүүлэх байрыг эзэлдэг.
Adobe Acrobat Connect	Энэхүү платформ нь виртуал хурал, зайн сургалт дүрс дуу дамжуулах томоохон систем ба flash, flex, java программчлал дээр хийгдсэн систем юм. Америкийн нэгдсэн улсын Батлан хамгаалахын яам хэрэглэдэг систем бөгөөд нэр хүндийн хувьд томоохон байр суурийг эзэлдэг.

Хүснэгт2: Зайн сургалтын системүүдийн программ хангамж

Дүгнэлт

Интернэтийн орчинд зайн сургалтыг нээлттэй болон төлбөртэй программ хангамжийг ашиглан явуулах боломжтой. Хэрэглэгчийн хандалтын нууцлалтыг сайжруулах. Зайн сургалтын үйл ажиллагааг BigBlueButton программыг манай улсын хэмжээнд ашиглаж боломжтой программ хангамж байна .

Big Blue Button программ хангамж нь байнга шинэчлэгдэн нэмэлт боловсруулалт хийгддэг. Одоогийн байдлаар Bigbluebutton 0.8RCхувилбар нь шинэчлэгдэн гарсан байгаа. Программын зохиогч нь сургалтын мэргэжилтнүүдэд ашиглах заавар, семинар, сургалт зохион байгуулдаг мөн монгол хэлээр заавартай тул ашиглахад амар байдаг зэрэг давуу талуудтай.

Ашигласан эх сурвалж

mn.wikipedia.org/wiki/Зайны_сургалт. (огноо байхгүй). wikipedia.org.-ээс Гаргасан

Д, Н. (2025). file:///C:/Users/DELL/Downloads/3-5104.pdf. file:///C:/Users/DELL/Downloads/3-5104.pdf.-ээс Гаргасан

Ковид-19 хямрал бх сургалтын хөтөлбөр. (2020). Зайн сургалтын орчинд чанарын үр дүнг хангах.

Н, Э. (2021). https://enkhuush.coo.mn/54270/zain-surgaltiin-onoliin-oilgolt.html.

П, О. (2021). Мэргэжлийн боловсрол сургалтын өнөөгийн нөхцөл байдал. Улаанбаатар.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САНХҮҮГИЙН БАРИМТ БИЧИГТ ҮЗЛЭГ, НЭГЖЛЭГ ХИЙХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Ч.УРАНГОО

ДХИС-ийн Сургалт судалгааны 403-р анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч

Товч агуулга: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн санхүүгийн мэдээлэл, тэр дундаа үндсэн хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, элэгдэл, үнэ цэний бууралтын мэдээллийн ач холбогдлыг судлан зах зээлийн эдийн засгийн нөхцөлд байгууллагын санхүүгийн сахилга бат, эдийн засгийн тогтвортой байдлын чухал үзүүлэлт болохыг тодорхойлж, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд (санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тайлангийн тодруулга) нь байгууллагын санхүүгийн бодит байдлыг илэрхийлэх гол эх сурвалж болохыг харуулсан.

Илтгэлд үндсэн хөрөнгийн биет ба биет бус ангилал, тэдгээрийн бүртгэл, элэгдэл, үнэ цэний бууралтыг үнэн зөв тодорхойлох нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх, төлбөрийн шаардлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй болохыг судалгааны үр дүнд нотоллоо. Түүнчлэн санхүүгийн тайлан болон үндсэн хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хөрөнгийн бодит байдлыг үнэн зөв үнэлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх түүний ач холбогдлыг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, үзлэг, нэгжлэг хийх ажиллагаа, санхүүгийн байдлын тайлан, эд хөрөнгийн бүртгэл

Abstract: This study examines the significance of financial information of enterprises and legal entities in enforcement proceedings, particularly focusing on fixed asset accounting, valuation, depreciation, and impairment. It aims to demonstrate that, within a market economy, financial discipline and economic stability of organizations are key indicators reflected through such information. Furthermore, it highlights that the components of financial statements—namely

the statement of financial position, statement of comprehensive income, statement of changes in equity, statement of cash flows, and notes to the financial statements—serve as primary sources for presenting the true financial condition of an entity.

The study also analyzes the classification of fixed assets into tangible and intangible categories, emphasizing that accurate accounting, depreciation, and impairment recognition play a decisive role in the enforcement of court decisions and the effective realization of payment obligations. The findings confirm that financial statements and fixed asset records are essential in objectively assessing the actual financial condition of assets during enforcement proceedings, thereby enhancing the effectiveness of enforcement actions.

Keywords: Court decision, enforcement proceedings, inspection and search procedures, statement of financial position, asset accounting

УДИРТГАЛ

Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр нь заавал биелэгдэх шинж чанартай бөгөөд иргэн, хуулийн этгээд үүнийг биелүүлэх үүрэгтэй. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн сахилга бат, өр төлбөр түүнийг хэрхэн төлж барагдуулах чадвар нь эдийн засгийн тогтвортой байдлын чухал үзүүлэлт болдог. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа нь өр төлбөрийг барагдуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх үндсэн механизм бөгөөд уг ажиллагаанд нуугдмал хөрөнгө илрүүлэх, ялангуяа компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлийг тогтоох нь онцгой ач холбогдолтой юм. Энэхүү илтгэлд төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн бүртгэлийг үзлэг, нэгжлэг хийх ажиллагаагаар илрүүлэхийн эрх зүйн орчин, ач холбогдлыг дурдана. Иймд үндсэн хөрөнгийн бүртгэл, түүний үнэлгээ, элэгдэл болон үнэ цэний бууралтын мэдээлэл нь зөвхөн санхүүгийн ил тод байдлыг хангаад зогсохгүй, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хөрөнгийн байдлыг үнэн зөв тогтоох, төлбөрийн шаардлагыг биелүүлэх боломжийг олгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх чухал арга хэрэгсэл юм.

Санхүүгийн байдлын тайлангийн ойлголт

Санхүүгийн тайлан нь аж ахуй нэгжийн гаднын болон дотоодын хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад нь шаардагдах тухайн байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, эздийн өмч , өр төлбөр), санхүүгийн үр дүн (орлого, үр дүн), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээний) – ийн талаарх мэдээллээр хангана. (систем, Сангийн сайдын тушаал , 2017)

- Санхүүгийн байдлын тайлангийн гол зорилго бол Байгууллагын санхүүгийн байдал болон гүйцэтгэлийн талаарх бодит мэдээллийг сонирхогч талуудад хүргэх;
- Удирдлага, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, аудит, төрийн байгууллага болон олон нийтэд шийдвэр гаргах үндэслэл болох мэдээллээр хангах;
- Байгууллагын санхүүгийн хариуцлага, ил тод байдлыг хангах;
- Үндэсний болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бэлтгэх явдал юм.

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны явцад бий болсон, байгууллагын эзэмшилд байгаа, ирээдүйд үр өгөөж өгөх нөөц юм. Хөрөнгийг хөрвөх чадвараар нь эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө гэж ангилна (агентлаг, огноо байхгүй)

Өр төлбөр. Бизнесийн өнгөрсөн үйл ажиллагааны явцад үүссэн бусдын өмнө хүлээх санхүүгийн хариуцлагыг өр төлбөр гэнэ. Төлөгдөх хугацаагаар нь богино, урт хугацаат өр төлбөр гэж ангилна (агентлаг, огноо байхгүй).

Эздийн өмч. Өмчийн эздийн оруулсан хөрөнгийн хэлбэр, мөнгөн дүнг харуулна (агентлаг, огноо байхгүй).

Хөрөнгө = Өр төлбөр + Эздийн өмч (газар, огноо байхгүй).

Иж бүрэн санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн:

- Санхүүгийн байдлын тайлан: Тухайн цаг үеийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн үлдэгдлийг харуулна.
- Орлогын дэлгэрэнгүй тайлан: Тайлант хугацааны орлого, зардал болон цэвэр ашиг, алдагдлыг илэрхийлнэ.
-

- Өмчийн өөрчлөлтийн тайлан: Эздийн өмчид гарсан өөрчлөлтүүдийг (хувьцаа, хуримтлагдсан ашиг) бүртгэнэ.
- Мөнгөн гүйлгээний тайлан: Мөнгөн хөрөнгийн орох, гарах урсгалыг харуулна.
- Санхүүгийн тайлангийн тодруулга: Тайлангийн үзүүлэлтүүдийг дэлгэрүүлэн тайлбарласан нэмэлт мэдээллүүд орно. (агентлаг, огноо байхгүй)

Санхүүгийн байдлын тайлангаас хөрөнгийн талаар авч үзвэл эргэлтийн хөрөнгө болон эргэлтийн бус хөрөнгө гэж ангилж байна. Үүнээс эргэлтийн бус хөрөнгө нь аж ахуй нэгж, хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө юм.

Үндсэн хөрөнгийн бүртгэлийн ойлголт, ач холбогдол

.

Үндсэн хөрөнгө гэдэг нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагддаг, биет болон биет бус хөрөнгийг хэлнэ. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг хассан үнийн дүнгээр санхүүгийн тайланд тайлагнасан байна. Олон улсын стандартад үндсэн хөрөнгийн зорилгыг үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлж, аж ахуйн нэгж өөрийн үндсэн хөрөнгөндөө хийсэн хөрөнгө оруулалт болон тэрхүү хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар олж авах боломжтой байдлаар бэлтгэнэ. Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнийн тодорхойлолт болон хөрөнгөтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрөх элэгдлийн зардал ба үнэ цэний бууралтын гарзын тооцоололт юм (ERS, НББОУС 16 Үндсэн хөрөнгө, n.d.).

Үндсэн хөрөнгө нь борлуулах бус үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах удаан хугацаанд ашиглагдахын зэрэгцээгээр элэгдэлд ордог бөгөөд биет байдлаар бодитойгоор оршдог, тодорхой хэмжээний өртөгтэй байна.

Үндсэн хөрөнгийг шинж чанараар нь биет бус болон биет хөрөнгө гэнэ.

Биет бус хөрөнгүүдийн хувьд бусад хөрөнгүүдээс ялгагдах гол ялгаа нь "биет шинж чанаргүй" байдагт оршино. Биет шинж чанаргүй тул түүнийг элэгдүүлэх бус хорогдуулах ёстой. Мөн энэ шинж чанар нь бусад

хөрөнгүүдээс ялгагдах бүртгэлийн хамгийн том ялгаа буюу хорогдуулахгүй байх нөхцөлийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, тодорхойгүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй бөгөөд зөвхөн үнэ цэний бууралтыг нь шалгана гэсэн үг. Түүнчлэн ихэнх биет бус хөрөнгүүд нь үлдэх өртөггүй байдаг. Эдгээр онцлогууд нь биет бус хөрөнгийн бүртгэлийн биет хөрөнгүүдээс онцгой болгодог (ERS, НББОУС 38 , n.d.)

Биет үндсэн хөрөнгө нь **г**азар, газрын тохижуулалт, барилга, түрээсийн сайжруулалт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл, тооцоолох олшруулах машин, дуусаагүй барилга, байгалийн нөөц гэх мэт биетээр орших эд зүйл юм.

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан үндсэн хөрөнгө гэж юу болох түүнийг үзлэг, нэгжлэг хийх ажиллагаанд хэрхэн тодорхойлж авч үзэх талаар толилууллаа. Тэгэхээр тухайн хөрөнгийн үнийн дүнг зөвхөн харах бус үнийн дүнд тусгагдсан үндсэн хөрөнгийн бүртгэлийг тодруулах шаардлага үүсэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Аж ахуй нэгж бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө.” гэж заасан байна. Иймд мөн хуулийн 14.4 дүгээр зүйлийн 14.4-т ... нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.

Үүнд: 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ;
14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;
14.4.3.бүх өр төлбөр;
14.4.4.аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр;
14.4.5.бүх орлого;
14.4.6.бүх зардал;
14.4.7.нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс.

14.5.Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2015).заасны дагуу эд хөрөнгийн бүртгэлийг шаардах юм. Үндсэн хөрөнгийн бүртгэл нь аж ахуй нэгжийн бүртгэлтэй хөрөнгийн жагсаалттай байх бөгөөд хөрөнгийг

анхны өртөг, элэгдэл, зэх зээлийн үнэ болон зах зээлийн үнийн дүнд эзлэх хувь хэмжээг тогтоосон бүртгэл юм.

Жишээ нь: Компани дараах Тээврийн хэрэгслийг 40,000,000 төгрөг, барилгыг 30,000,000 төгрөг, тоног төхөөрөмжийг 10,000,000 төгрөгөөр нийт хямдрал байхгүйгээр 80,000,000 төгрөгөөр худалдан авчээ.

Дээрх хөрөнгийн зэх зээлийн эзлэх хувийг тооцоолбол:

- Тээврийн хэрэгсэл: 40,000,000 / 80,000,000 = **50%**
- Барилга: 30,000,000 / 80,000,000 = **37.5%**
- Тоног төхөөрөмж: 10,000,000 / 80,000,000 = 12.5% гэж үзвэл анхны өртөг хуваарилан үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгана.

Хөрөнгө	**Хувь**	**Анхны өртөг**
Тээврийн хэрэгсэл	50%	40,000,000
Барилга	37.5%	30,000,000
Тоног төхөөрөмж	12.5%	10,000,000
Дүн	100%	80,000,000

Өөрийн хэрэгцээнд зориулан барьж, угсарч бий болгосон биет үндсэн хөрөнгийн анхны өртгийг тодорхойлохдоо худалдан авсан хөрөнгийн өртөг тооцох болон дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг бүрдүүлэх зарчмуудтай адил аргачлалыг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл, тухайн хөрөнгийг бий болгоход шууд болон шууд бус байдлаар хамаарах бүх зардлыг зохих журмын дагуу хуримтлуулж, өртөгт шингээнэ.

Хэрэв аж ахуйн нэгж нь хэвийн үйл ажиллагааныхаа хүрээнд зах зээлд борлуулах зорилгоор ижил төрлийн хөрөнгийг үйлдвэрлэдэг бол өөрийн хэрэгцээнд зориулан барьж, бий болгосон хөрөнгийн өртөг нь борлуулалтын зориулалттай ижил төрлийн бүтээгдэхүүний өртөгтэй ижил зарчмаар тодорхойлогдоно.

Харин үйлдвэрлэлийн явцад үүссэн хэвийн бус буюу давтагдашгүй, онцгой шинжтэй зардлуудыг (жишээлбэл, үр ашиггүй ажиллагаанаас

үүдэлтэй алдагдал, илүүдэл материалын зарцуулалт гэх мэт) тухайн хөрөнгийн анхны өртөгт оруулахгүй бөгөөд эдгээрийг тухайн үеийн зардалд шууд хүлээн зөвшөөрнө.

Биет үндсэн хөрөнгийн ашиглалтын явцад гарч буй дараах зардлуудыг бүртгэхдээ санхүүгийн тайлагналын үндсэн зарчим болох хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг баримтална. Өөрөөр хэлбэл, тухайн зардал нь ирээдүйд эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх магадлалтай, өртгийг найдвартай хэмжих боломжтой байх нөхцөлийг хангаж байвал уг зардлыг хөрөнгийн дансны үнэд нэмэгдүүлэн капиталжуулна. Энэ нь тухайн хөрөнгийн үнэ цэнэ, ашиглах боломжийг бодитоор илэрхийлэхэд чиглэнэ.

Ийм төрлийн капиталжих зардалд үндсэн хөрөнгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтын хугацааг уртасгах, эсвэл анхны өртгийн түвшнийг дээшлүүлэхтэй холбоотой зардлууд хамаарна. Харин эдгээр шалгуурыг хангахгүй, зөвхөн хөрөнгийн хэвийн үйл ажиллагааг хадгалах зорилготой засвар, үйлчилгээний зардлыг тухайн тайлант хугацааны зардалд шууд хүлээн зөвшөөрнө. Энэ нь зардлыг орлоготой зөв хугацаанд нь тохируулсан байх шаардлагатай.

Биет үндсэн хөрөнгийн бүртгэлийн дараа үеийн тайлан нь мөн хоёр үндсэн хандлагад тулгуурладаг. Нэгдүгээрт, өртгийн загварын дагуу хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэний бууралтыг хассан дүнгээр буюу үлдэгдэл өртгөөр илэрхийлнэ. Энэ арга нь найдвартай, тогтвортой мэдээлэл өгөх давуу талтай (Ц.Мөнх-Очир, 2019).

Хоёрдугаарт, дахин үнэлгээний загварын хүрээнд хөрөнгийг зах зээлийн нөхцөлд ойролцоо бодит үнээр дахин үнэлж, уг үнэлгээнээс хойших хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэний бууралтыг хассан дүнгээр тайлагнана. Энэ арга нь хөрөнгийн бодит үнэ цэнийг илүү үнэн зөв тусгах боломжтой боловч зах зээлийн үнийн хэлбэлзлээс хамааран хэлбэлзэлтэй байж болзошгүйг анхаарах шаардлагатай.

Үндсэн хөрөнгийн бүртгэлийг зөв тодорхойлсон байдал нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Төлбөр барагдуулахад ашиглагдах худалдан борлуулах хөрөнгийн бодит үнэ

цэнийг зөв тодорхойлж, ямар хөрөнгөөс, ямар хэмжээгээр төлбөр гаргуулахыг тодорхойлох үйл явц хялбар, үр дүнтэй болно. Мөн хөрөнгийг хэт өндөр эсвэл хэт бага үнэлснээс үүдэх маргааныг багасгах юм.

ДҮГНЭЛТ

Иймд үндсэн хөрөнгийн бүртгэлийг үнэн зөв тодорхойлох асуудал нь зөвхөн нягтлан бодох бүртгэлийн хүрээнд хязгаарлагдах бус, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны үр ашиг, шударга байдлыг хангах суурь нөхцөл болдог. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн ил тод, бодитой байдал нь шийдвэр гүйцэтгэгчид төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгийн байдлыг бодитой тогтоох, хөрөнгөгүй болохыг нотлох, эсхүл байгаа хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж төлбөрийн шаардлагыг хангахад чухал ач холбогдолтой.

Гэвч практикт тулгарч буй томоохон хүндрэлүүдийн нэг нь төлбөр төлөгч-хуулийн этгээдийг хөрөнгөгүй, эсхүл төлбөрийн үүргээ биелүүлэхэд хүрэлцэхүйц хөрөнгөгүй болохыг нотлох ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой байна. Үүний улмаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашрах, цаашлаад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт бодит үр дүнд хүрэхгүй байх нөхцөл бүрдэж байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4, Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4-т заасан зохицуулалтууд практикт үр нөлөө багатай хэрэгжиж байгаа нь ажиглагдаж байна.

Энэхүү нөхцөл байдал нь төлбөр төлөгч-хуулийн этгээдтэй холбогдох гүйцэтгэх баримт бичгийн биелэлт хангалтгүй байгаатай шууд хамааралтай бөгөөд улмаар шийдвэр гүйцэтгэгчээс компанийн удирдлага, нягтлан бодох бүртгэл, мөн хувьцаа эзэмшигчдэд хариуцлага хүлээлгэх ажиллагаа үр дүнгүй болох хандлагыг бий болгож байна. Иймээс үндсэн хөрөнгийн бүртгэлийн суурь мэдлэгтэй байх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, эрх зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

ERS. (n.d.). НББОУС 16 Үндсэн хөрөнгө. Retrieved from Standarts.mn: https://standards.mn/standard/stous

ERS. (n.d.). НББОУС 38 . Retrieved from Standards.mn: https://standards.mn/standard/stous

газар,Ж.д.(n.d.).ЖДҮ.Retrievedfrom https://office.sme.gov.mn/storage/uploads/files/

систем, Э. з. (2015). Төрийн мэдээлэл эмхтгэл:2015, №27. Retrieved from Legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=11201

систем, Э. з. (2017). Сангийн сайдын тушаал . Retrieved from АЖ АХУЙН НЭГЖИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,ТОДРУУЛГЫГ БЭЛТГЭХ ЗААВАР: https://legalinfo.mn/mn/detail?lawId=208277#:~:

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГТ НӨЛӨӨЛӨХ СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖИЛГЭЭ

AN ASSESSMENT AND ANALYSIS OF PSYCHOLOGICAL FACTORS AFFECTING THE EFFECTIVENESS OF HUMAN RESOURCE MANAGEMENT IN THE MINISTRY OF INTERNAL AFFAIRS OF THE RUSSIAN FEDERATION AND THE COURT DECISION ENFORCEMENT AGENCY OF MONGOLIA

О.Ундармаа Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн багш, ахмад

Undarmaa.O Captain, Lecturer at the Department of Social Work and Psychology

Хураангуй

Тус өгүүлэлд алба хаагчдын удирдлагын үйл ажиллагааны үр ашигт нөлөөлөх сэтгэл зүйн хүчин зүйлсийг үнэлэхэд тулгарч буй асуудлуудыг Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам болон Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жишээн дээр авч үзсэн болно. Дээрх асуудлыг судлах хэрэгцээ шаардлага нь Орос болон бусад орнуудын алба хаагчдын удирдлагын үр ашгийг үнэлэх чанарыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагаас үүдэлтэй юм. Сэтгэл зүйн хүчин зүйлсийг тооцох нь ийм төрлийн үнэлгээний чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ нь байгууллагын хүний нөөц удирдлагын үндсэн объект болдогтой холбоотой. Өгүүллийн зорилго нь Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага (цаашид ШШГБ гэх)-ын алба хаагчдын удирдлагад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг даван туулахад чиглэсэн санал зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны ажилд алба хаагчдын удирдлагын сэтгэл зүйтэй холбоотой гадаад болон дотоодын онолын хандлагуудыг шинжлэн судалсан. Өгүүлэлд ОХУ-ын Дотоод хэргийн байгууллагын алба хаагчдын болон Монгол Улсын ШШГБ-ын алба хаагчдын дунд явуулсан асуулгын

судалгааны үр дүнг тусгав. ШШГБ-ын алба хаагчдын дунд явуулсан судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийснээр дараах үр дүнгүүдийг тогтоолоо:

1. ОХУ-ын Дотоод хэргийн яамны алба хаагчдын дийлэнх нь боловсон хүчний удирдлагын тэргүүлэх арга барил бол "идэвхжүүлэлт, сэдэлжүүлэлдийн систем" гэж үзсэн байна.

2. Монгол Улсын ШШГБ-ын алба хаагчдын хувьд ажлын сэтгэл ханамж, идэвх санаачилга болон мэргэжлийн үйл ажиллагааны бүтээмжид нөлөөлөх гол хүчин зүйл нь "шийдвэр гаргалтын чанар" болон "хүний нөөцийн үнэ цэнэ"-ийг нэмэгдүүлэх явдал гэж үзжээ.

Асуулгын судалгааны үр дүнд үндэслэн ШШГБ-ын алба хаагчдын удирдлагын үр ашгийг үнэлэх шинэ системийг нэвтрүүлэхэд чиглэсэн зөвлөмжүүдийг боловсруулсан. Эдгээр зөвлөмжүүд нь бүхэлдээ алба хаагчдын мэдээлэл хүртээмжийг нэмэгдүүлэх, удирдлагын шийдвэр гаргахад тэдний саналыг тусгахад чиглэгдсэн болно.

Abstract

This article examines the issues encountered in assessing psychological factors that influence the effectiveness of personnel management, using the examples of the Ministry of Internal Affairs of the Russian Federation and the Court Decision Enforcement Agency of Mongolia. The need to study this issue arises from the growing demand to improve the quality of evaluating management effectiveness among personnel in Russia and other countries. Considering psychological factors is an important component of such assessments, as human resources represent the primary object of organizational management.

The purpose of this study is to develop recommendations aimed at overcoming the challenges faced in personnel management within the Court Decision Enforcement Agency of Mongolia (hereinafter referred to as CDEA).

The research analyzes both international and domestic theoretical approaches related to the psychology of personnel management. The article also presents the results of survey research conducted among officers of the Ministry of Internal Affairs of the Russian Federation and officers of the CDEA of

Mongolia. Based on the analysis of the survey data collected from CDEA officers, the following findings were identified:

The majority of officers of the Ministry of Internal Affairs of the Russian Federation consider the system of motivation and stimulation to be the leading method of personnel management.

For officers of the CDEA of Mongolia, the key factors influencing job satisfaction, initiative, and professional productivity were identified as the quality of decision-making and the enhancement of the value of human resources.

Based on the survey findings, recommendations were developed for introducing a new system for evaluating the effectiveness of personnel management within the CDEA. These recommendations are primarily aimed at increasing personnel access to information and incorporating their opinions into managerial decision-making processes.

Түлхүүр үг: алба хаагчдын удирдлага, сэтгэл зүйн хүчин зүйлс, сэдэлжүүлэлд, хүний хүчин зүйл, дотоод хэргийн байгууллагын алба хаагч, эмпирик судалгаа, асуулга.

Keywords: personnel management, psychological factors, motivation, human factors, law enforcement officers, empirical research, questionnaire.

Үндэслэл

Алба хаагчдын удирдлагын үйл ажиллагааны үр ашгийг үнэлэх явдал нь аливаа байгууллагын удирдлагын тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Үүнтэй холбогдуулан менежментийн үр ашгийг ихээхэн тодорхойлдог сэтгэл зүйн хүчин зүйлсийн гүйцэтгэх үүргийг тэмдэглэх нь зүйтэй. Дээрх хүчин зүйлс нь гадаад болон дотоод шалтгаанаар нөхцөлдөж болно. Тухайлбал, хамт олны дундах нийгэм-сэтгэл зүйн таагүй уур амьсгал эсвэл алба хаагчдын дотоод хувийн зөрчил нь хамт олны ерөнхий байдалд сөрөг нөлөө үзүүлдэг.

Үүний зэрэгцээ сэтгэл зүйн хүчин зүйлс нь алба хаагчдын удирдлагын үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлт (индикатор) болж, эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Үүний жишээ болгон алба хаагчдын дунд мэргэжлийн үйл ажиллагаандаа амжилтад хүрэх сэдэл (амжилтын мотиваци) давамгайлахыг дурдаж болно. Оросын Холбооны Улс болон Монгол Улс дахь алба хаагчдын удирдлагын үр ашгийн үнэлгээний үр дүнг

харьцуулан шинжлэх, мөн ийм үнэлгээ хийхдээ сэтгэл зүйн хүчин зүйлсийг тооцож үзэх нь удирдлагын салбарт хамгийн чухал ач холбогдолтой асуудлуудыг илрүүлэх боломж олгож байгаа нь энэхүү өгүүллийн үндэслэл, ач холбогдлыг тодорхойлж байна.

Тулгарч буй асуудал

Удирдлагын үр ашгийн эх сурвалжийг судлах асуудал нь арвин баялаг түүхтэй. Удирдлагын онолын үүсэл гарлыг судалснаар түүний төлөвшил, хөгжлийн үе шатуудыг мөшгөн үзэх боломжтой. Тус онол нь XX зуунд эрчимтэй хөгжсөн бөгөөд үүнийг "Удирдлагын социологи" гэж нэрлэх нь бий. Удирдлагын онолын хөгжлийн үндэс нь дараах дөрвөн үндсэн хандлагад тулгуурладаг:

1. Менежментийн үндсэн сургуулиудын үзэл баримтлал;
2. Удирдлагыг үйл явц гэж үзэх хандлага;
3. Системийн хандлага;
4. Нөхцөл байдлын хандлага. Орчин үеийн удирдлагын онолын хөгжлийг сүүлийн гурван чиглэлтэй холбон авч үздэг.

Эхний хандлага нь дотроо дөрвөн сургуулийг багтаадаг:

1. Шинжлэх ухааны удирдлагын сургууль (Ф. Тейлор, Ф. Гилбрет, Г. Гант, Г. Эмерсон нар): Удирдлага дахь шинжлэх ухааны хандлага болон менежментийг практикт хэрэгжүүлэх үйл явцыг зааглах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Энэ хүрээнд бүтээмжийг дээшлүүлэх нь хөдөлмөрийн зохион байгуулалттай шууд холбоотой гэсэн санааг анхлан дэвшүүлсэн.

2. Захиргааны (сонгодог) сургууль (А. Файоль): Төрөл бүрийн байгууллагуудад ашиглах удирдлагын зарчмуудыг нэгтгэн системчилсэн нь тэдний гол гавьяа юм.

3. "Хүний харилцаа"-ны сургууль (Э. Мэйо, М. П. Фоллет, Р. Лайкерт, Д. Моутон, Ф. Фидлер нар): Зан үйлийн сэтгэл судлалтай холбоотой хандлагыг чухалчилдаг. Энэ чиглэлийн хүрээнд хөдөлмөрийн үр ашигт нөлөөлөх хувь хүний харилцаа, идэвхжүүлэлт, хэрэгцээ, алба хаагчдад хандах хандлага зэрэг хүчин зүйлсийн ач холбогдлыг илрүүлсэн.

4. "Удирдлага дахь тоон аргууд"-ын сургууль (Р. Кофф, С. Бир, Д. Экман, А. Энтховен, Э. Квейд): Үйл ажиллагааны судалгааны арга зүйг боловсруулсан нь энэ сургуулийн хамгийн чухал ололт юм.

Шинжлэх ухааны удирдлагын сургууль нь удирдлагын шинжлэх ухааны хандлага болон практик менежментийг зааглан үзэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Энэхүү хандлагын хүрээнд хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нь хөдөлмөрийн зохион байгуулалттай шууд хамааралтай болохыг анхлан нотолсон билээ.

Захиргааны (сонгодог) удирдлагын сургууль нь байгууллагын төрлөөс үл хамааран удирдлагын зарчмуудыг нэгтгэн жигдрүүлэх чиглэлээр томоохон гавьяа байгуулсан юм.

"Хүний харилцааны" сургууль нь зан төлөвийн сэтгэл судлалтай холбоотой хандлагыг баримталдаг. Энэ чиглэлээр хөдөлмөрийн үр ашигт нөлөөлөхүйц хувийн харилцаа, урам зориг (мотиваци), хэрэгцээ, ажилчдад хандах хандлага зэрэг хүчин зүйлсийн ач холбогдлыг илрүүлэн тодорхойлсон.

"Удирдлагын тоон аргууд"-ын сургууль-ийн хамгийн чухал ололт нь үйл ажиллагааны шинжилгээний арга зүйг боловсруулсан явдал юм.

Дээрх "сургуулиуд"-аас гадна удирдлагын онолын хөгжилд дараах гурван хандлага ихээхэн ач холбогдолтой: 1. Үйл явцын хандлага, 2. Системийн хандлага, 3. Нөхцөл байдлын хандлага.

Үйл явцын хандлага: Удирдлагын чиг үүргүүдийг харилцан зохион байгуулснаар бүх үйл явцыг зохицуулах боломжтой гэсэн үндсэн санаанд тулгуурладаг. Удирдлагын сэтгэл судлалд удирдлагын чиг үүргүүдийг: 1) төлөвлөлт, 2) зохион байгуулалт, 3) идэвхжүүлэлт, 4) хяналт ба шийдвэр гаргалт, 5) харилцаа холбоо гэсэн ангилалд бүлэглэдэг.

Системийн хандлага: Байгууллагыг "нийгэм-техникийн систем" гэж үзэх шинэ ойлголтыг боловсруулсан. Энэхүү хандлагын ачаар өмнөх бүх онолын хандлагуудыг нэгтгэж чадах удирдлагын цогц онолыг бий болгох хэрэгцээг ухамсарласан болно.

Нөхцөл байдлын хандлага нь байгууллагын асуудлууд болон тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох ерөнхий арга зүй, сэтгэлгээний хэлбэр юм. Энэхүү хандлагын гол үзэл баримтлал нь: аливаа

байгууллага бол гадаад орчинтой байнга харилцан үйлчлэлцэж байдаг нээлттэй систем юм. Байгууллагын дотоодод өрнөж буй үйл явцын гол шалтгаан нь тухайн байгууллагын эргэн тойронд үүссэн нөхцөл байдалд оршдог.

Байгууллагын зорилгод амжилттай хүрэхийн тулд удирдагчийн ашиглах оновчтой арга барил, техникүүд нь хувьсамтгай байх ёстой бөгөөд зөвхөн тухайн нөхцөл байдлаас хамаарч хэрэглэгдэх ёстой. Энэхүү хандлагыг бүхэлд нь "удирдлагын харьцангуй байдал"-ын үзэл баримтлал гэж тодорхойлж болно. Дээрх сургуулиудыг удирдлагын социологийн хүрээнд авч үзсэн байдаг.

Алба хаагчдын удирдлагад зориулсан эрдэм шинжилгээний бүтээлүүд нь хүн (ажилтан эсвэл алба хаагч)-ий нөлөө буюу "хүний капитал"-ыг судлахад чиглэдэг. Тухайлбал:

❖ Р. Аккова боловсон хүчнийг байгууллагын нөөцөд хамааруулсан бол;

❖ М. Вебер улс төрч хүний гүйцэтгэх үүрэг, чанарын талаар бичихдээ: "Үүнийг чадаж байгаа хүн удирдагч байх ёстой, түүгээр ч барахгүй тэрээр үгийн шууд утгаараа баатар байх ёстой. Бүх итгэл найдвар нь нуран унасан ч үл шантрах тэрхүү сэтгэлийн хат, тэвчээрээр өөрийгөө зэвсэглэх хэрэгтэй" хэмээжээ.

❖ М. Мескон байгууллагын хяналтын асуудлыг хөндөхдөө хүмүүс бол "хяналтын салшгүй элемент" гэдгийг онцолсон.

❖ С. Янг "байгууллагын зорилго нь түүний гишүүдийн сайн сайхан байдлыг хадгалах, нэмэгдүүлэх замаар шууд тодорхойлогддог" гэж заасан байна.

❖ А.Н. Яндовскийн үзэж байгаагаар алба хаагчдын удирдлага нь "материаллаг, техникийн, нийгэм-сэтгэл зүйн гэсэн хэд хэдэн дэд системүүдийн харилцан үйлчлэл болох удирдлагын орчны системийн шинж чанарыг ойлгоход тулгуурладаг".

Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны (цаашид ОХУ-ын ДХЯ гэх) системд дотоод хэргийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашгийг судлах асуудлыг суурь түвшинд боловсруулж ирсэн. Ю.Е.

Аврутины үзэж буйгаар дотоод хэргийн байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг үнэлэх онолын үндэслэл нь: 1. Нийгмийн хэм хэмжээний шатлал ба харилцан хамаарал (үүнд эрх зүй нь голлох ангилал бөгөөд гүйцэтгэх ажлын явцад зарим хэм хэмжээнээс хазайх хууль ёсны хязгаарыг тогтоодог); 2. Нийгмийн хэм хэмжээнд бэхэжсэн зан үйлийн хэвшмэл загвар, стандартууд нь зөвхөн хувь хүний түвшинд төдийгүй нийгмийн ухамсарт нийтлэг үзэгдэл болж тусах, хэрэгжих явдал юм.

Иймд хувь алба хаагчид болон ОХУ-ын ДХЯ-ны системийн байгууллагуудын зүгээс нийгмийн хэм хэмжээг сахин биелүүлж буй түвшин нь тухайн системийн үр ашгийг, тэр дундаа удирдлагын тогтолцооны үр ашгийг хэмжих үндэс суурь болдог.

Дүгнэж хэлэхэд, удирдлагын салбарт байгаа онолын судалгаанууд нь менежментийн үр ашиг болон байгууллага дахь хүний хүчин зүйлийг тооцох хоёрын хооронд салшгүй холбоо байгааг баталж байна.

Эмпирик судалгаанд үндэслэн онолын шинэ заалтуудыг боловсруулах нь

Алба хаагчдын удирдлагад нөлөөлж буй гол хүчин зүйлс болон тулгарч буй сорилтуудыг илрүүлэх зорилгоор ОХУ-ын Дотоод хэргийн яамны алба хаагчид (75 судалгаанд оролцогч) болон Монгол Улсын ШШГБ-ын алба хаагчдын (286 судалгаанд оролцогч) дунд эмпирик судалгаа явууллаа. Тус судалгааны үр дүн нь Монгол Улсын ШШГБ-ын алба хаагчдын удирдлагад тулгарч буй хүндрэлийг даван туулахад чиглэсэн зөвлөмжүүдийг томьёолох боломжийг олгов.

Эмпирик судалгааны хүрээнд асуулгын аргыг ашигласан. Дээрх алба хаагчдад зориулан боловсруулсан асуулгад тодорхой хариулт шаардсан хаалттай асуултуудыг багтаасан болно.

ОХУ-ын Дотоод хэргийн яамны алба хаагчдын дунд явуулсан судалгааны үр дүнд алба хаагчдын удирдлага болон байгууллагын үйл ажиллагааны үр ашигт нөлөөлж буй гол хүчин зүйлс, сорилтуудыг тодорхойлов. Энэхүү судалгаа нь боловсон хүчний албаны өнөөгийн байдал, тулгарч буй асуудлууд болон үйл ажиллагааг нь сайжруулах боломжит чиглэлүүдийн талаар ач холбогдол бүхий өгөгдлүүдийг өгсөн

юм. Судалгааны үр дүнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна:

1. Удирдлагын үр ашигт нөлөөлөх хүчин зүйлс: Судалгаанд оролцогчдын нэлээдгүй хувь нь (45.3%) алба хаагчдын удирдлагын үр ашигт хууль тогтоомж, нийгэм, технологийн хүчин зүйлс, төсвийн хязгаарлалт, боловсон хүчний хомсдол болон авлигын нөхцөл байдал нөлөөлдөг гэж хариулжээ. Энэ нь алба хаагчдын удирдлагын тогтолцоонд цогц хандлага шаардсан олон талт, нарийн төвөгтэй хүчин зүйлс нөлөөлж байгааг харуулж байна.

2. Боловсон хүчний албанд тулгарч буй сорилтууд: Судалгаанд оролцогчдын олонх нь (70.6%) орон тооны цомхотгол болон алба хаагчдад тавих шаардлага нэмэгдэж байгааг боловсон хүчний албаны гол "сорилт" гэж үзжээ. Энэ нь тус албаны үндсэн асуудал нь нөөц боломжийн хязгаарлагдмал байдал болон алба хаагчдын ур чадварт тавигдах шаардлага өсөн нэмэгдэж буйд оршиж байгааг онцолж байна.

3. Ажлын ачаалал ба ур чадвар**:** Судалгаанд оролцогчдын 49.3% нь цагдаагийн алба хаагчдын ажилд ачааллын өсөлт болон шинэ ур чадвар эзэмших хэрэгцээ ихээхэн нөлөөлж байгаад онцгой анхаарал хандуулсан байна. Энэ нь мэргэжлийн шаардлага нэмэгдэж буй нөхцөлд алба хаагчдын мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэх шаардлагатайг илтгэж байна.

4. Удирдлагын тогтолцооны үр нөлөө: Алба хаагчдын удирдлагын тогтолцоо нь байгууллагын үр ашигт хэрхэн нөлөөлж буйг судлахад судалгаанд оролцогчдын 38.6% нь тус тогтолцоог: боловсон хүчний нөөцийг бүрдүүлдэг; алба хаагчдын идэвх санаачилгыг (мотиваци) нэмэгдүүлдэг; боловсон хүчний тогтвор суурьшилтыг дэмждэг; зардлыг оновчтой болгодог; цагдаагийн ажлын чанар болон байгууллагын нэр хүндийг дээшлүүлдэг гэж үзсэн байна. Энэ нь алба хаагчдын удирдлагын тогтолцоо нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр ашигт цогц байдлаар нөлөөлдөг болохыг харуулж байна.

5. Алба хаагчдын удирдлагын үр ашгийг үнэлэх шалгуур үзүүлэлт**:** Судалгаанд оролцогчдын 42.6 хувь нь удирдлагын үр ашгийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр дараах хүчин зүйлсийг нэрлэжээ. Үүнд: гэмт хэргийн түвшин, хэрэг илрүүлэлт; цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамж; алба хаагчдын сахилга бат болон мэргэшсэн байдал зэргийг заасан байна. Үр ашгийг үнэлэх ийм цогц хандлага нь гэмт

хэргийн үзүүлэлтүүдийг алба хаагчдын ёс зүй, мэргэжлийн ур чадвартай уялдуулан авч үзэж буйг илтгэж байна.

6. Удирдлагын үр ашигт нөлөөлөх хүчин зүйлс: Судалгаанд оролцогчдын олонх нь (54.2%) алба хаагчдын удирдлагын үр ашигт дараах хүчин зүйлс чухал нөлөөтэй гэж үзжээ. Үүнд: боловсон хүчний сонгон шалгаруулалт, хуваарилалтын чанар; алба хаагчдыг сургаж хөгжүүлэх тогтолцооны үр ашиг; идэвхжүүлэлт, урамшууллын тогтолцоо байгаа эсэх зэрэг юм. Энэ нь дээрх бүх хүчин зүйлсийг нэгдмэл байдлаар тооцох шаардлагатайг баталж байна.

7. Удирдлагын үр ашгийг дээшлүүлэх чиглэлүүд: Судалгаанд оролцогчдын 58.6 хувийн үзэж байгаагаар ОХУ-ын ДХЯ-ны алба хаагчдын удирдлагын үр ашгийг дээшлүүлэх нь дараах чиглэлүүдээс хамаарна: боловсон хүчнийг сонгон шалгаруулах, үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох; сургалт болон мэргэшил дээшлүүлэх тогтолцоог хөгжүүлэх; алба хаагчдын удирдлагын орчин үеийн технологийг нэвтрүүлэх. Энэ нь боловсон хүчний сонгон шалгаруулалтаас эхлээд удирдлагын шинэ технологийг нэвтрүүлэх хүртэлх бүх шатанд цогц шинэчлэл хийх нь чухал болохыг харуулж байна.

8. Боловсон хүчний албаны үйл ажиллагааг хэмжих үзүүлэлт: Судалгаанд оролцогчдын 41.3 хувь нь боловсон хүчний албаны үр ашгийг хэмжихдээ дараах үзүүлэлтүүдэд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзжээ. Үүнд: боловсон хүчний тогтвор суурьшил, алба хаагчдын ажлын сэтгэл ханамж; сул орон тоог нөхөх хугацаа, сонгон шалгаруулалтын чанар; сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийн үр ашиг зэрэг юм. Энэ нь боловсон хүчний албаны үр ашгийг боловсон хүчний урсгалаас эхлээд алба хаагчдын сэтгэл ханамж хүртэлх өргөн хүрээнд үнэлэх шаардлагатайг илэрхийлж байна.

9. Боловсон хүчний албаны үйл ажиллагааг сайжруулах арга замууд: Боловсон хүчний албаны ажлыг сайжруулах зорилгоор судалгаанд оролцогчдын 37.3 хувь нь дараах хүчин зүйлсийг онцлов. Үүнд: боловсон хүчний албаны мэргэжилтнүүдийн мэргэшлийг дээшлүүлэх; хүний нөөцийн үйл ажиллагааг автоматжуулах; боловсон хүчний албаны үр ашгийг үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгцээг баталж байна.

10. Удирдлагын тэргүүний аргууд: Боловсон хүчний удирдлагын тэргүүний аргын хувьд судалгаанд оролцогчдын олонх нь (42.6%) "ажлын үр дүнд суурилсан идэвхжүүлэлтийн систем"-ийг нэрлэжээ. Энэ нь алба хаагчдын урамшууллыг тэдний гүйцэтгэж буй үүрэг даалгаврын бодит үр дүнтэй шууд холбон боловсруулахад гол анхаарлаа хандуулах ёстойг харуулж байна.

Монгол Улсын ШШГБ-ын алба хаагчдын дунд явуулсан асуулгын судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийснээр алба хаагчдын ажлын сэтгэл ханамж, идэвх санаачилга (мотиваци) болон бүтээмжид нөлөөлөх гол хүчин зүйлсийг илрүүллээ.

ШШГБ-ын алба хаагчдаас судалгаанд оролцогчдын дийлэнх нь (73.2%) боловсон хүчний албаны үйл ажиллагааг үнэлэхдээ уламжлалт аргууд (жишээ нь: алба хаагчдын үнэлгээний хүснэгт, 360 градусын үнэлгээ) болон орчин үеийн технологиудыг (жишээ нь: үр ашгийн гол үзүүлэлтүүдийг хэмжих буюу KPI, HR-аналитик) хослуулан ашигладаг гэж хариулжээ.

Ашиглаж буй аргуудын нарийвчлал болон бодит байдалд нийцэх байдлын тухайд судалгаанд оролцогчид санал зөрүүтэй байв. Тухайлбал:

- Судалгаанд оролцогчдын зөвхөн 27.2% нь эдгээр аргуудыг "маш нарийн, бодит үнэлгээ өгдөг" гэж үзсэн;
- 26.2% нь дээрх аргуудыг "харьцангуй нарийн, бодит үнэлгээ өгдөг" гэсэн байр суурьтай байна;
- Харин 25.2% нь энэ асуултад хариулж чадаагүй бөгөөд үүнийг тодорхойлохын тулд илүү нарийвчилсан судалгаа шаардлагатай гэж үзсэн.

Боловсон хүчний албаны үйл ажиллагааны бүх талыг эдгээр аргууд хэрхэн тусгаж байгаа тухайд судалгаанд оролцогчдын 27.6% нь уг үзүүлэлтийг тухайн байгууллагын онцлогт нийцүүлэн үнэлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүний зэрэгцээ судалгаанд оролцогчдын 23.1% нь эдгээр аргууд нь үйл ажиллагааны бүх талыг бүрэн хэмжээгээр эсвэл үндсэн үзүүлэлтүүдийг хамарч чаддаг гэдэгтэй санал нэгджээ.

Монгол Улсын ШШГБ-ын алба хаагчдын удирдлагын үр ашгийн үнэлгээ нь судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар:

1. Улсын хэмжээнд мөрдөгддөг, бүх байгууллагад нийтлэг аргууд (судалгаанд оролцогчдын 43.4% нь тэмдэглэсэн);

2. Зөвхөн ШШГБ-т зориулан тусгайлан боловсруулсан арга зүйгээр (судалгаанд оролцогчдын 22.4% нь тэмдэглэсэн) тус тус хэрэгждэг байна.

Энэ нь хэрэглэж буй арга зүй олон янз байгааг харуулахын зэрэгцээ ШШГБ-ын зүгээс боловсон хүчний чиглэлээрх шинжлэх ухааны эрэл хайгуул, судалгааны ажилд анхаарал хандуулж байгааг илтгэж байна.

Ашиглагдаж буй арга зүй болон практик үйл ажиллагаа нь алба хаагчдын удирдлагын үр ашгийн бодит дүр зургийг хэр зэрэг бодитой, бүрэн дүүрэн тусгаж байгааг үнэлэхэд судалгаанд оролцогчдын санал хуваагдсан байна. Тэдний 31.4% нь дээрх үнэлгээнүүдийг бүрэн бөгөөд үнэн зөв гэж тэмдэглэсэн бол, 23.1% нь эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын онцлогоос хамаардаг гэж үзжээ. Энэ нь ШШГБ-ын салбар нэгж бүрийн үйл ажиллагааны үр ашгийн үнэлгээнд нэмэлт шинжилгээ хийх шаардлагатайг харуулж байна.

ШШГБ-ын удирдлагын үр ашгийн үнэлгээг боловсронгуй болгох зөвлөмжийн тухайд судалгаанд оролцогчид дараах саналуудыг дэвшүүлэв:

- ✓ Орчин үеийн технологийг нэвтрүүлэх (37.8%);
- ✓ Мэргэшсэн боловсон хүчнийг бэхжүүлэх (36.4%);
- ✓ Олон улсын туршлагыг судалж нэвтрүүлэх (25.5%).

Энэхүү үр дүн нь ШШГБ-ын удирдлагын үнэлгээг чанаржуулахад шаардлагатай арга хэмжээнүүдийн хүрээ өргөн байгааг илтгэж байна. Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр шийдвэр гаргалтын чанар (35.3%), хүний нөөцийн үнэ цэнэ (32.9%) болон байгууллагын өрсөлдөх чадвар (27.3%) дээшилж, улмаар ШШГБ-ын үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ гэж судалгаанд оролцогчид үзжээ.

Үүний зэрэгцээ, зөвлөмжийг хэрэгжүүлэх явцад тулгарч болох хүндрэлүүдийг судалгаанд оролцогчид дараах байдлаар тодорхойлов: мэргэшсэн боловсон хүчний хомсдол (38.8%), санхүүгийн бэрхшээл болон алба хаагчдын зүгээс шинэчлэлд үзүүлэх эсэргүүцэл (26.2%). Иймд мэргэшсэн хүний нөөцийн дутагдал нь ШШГБ-ын удирдлагын үр ашгийг үнэлэх шинэ тогтолцоог нэвтрүүлэхэд тулгарч буй хамгийн том асуудал болж байна.

Дээрх саад бэрхшээлийг даван туулахын тулд дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай:

1. Мэдээлэл хүртээмжийг нэмэгдүүлэх: Алба хаагчдын мэдээлэл хүртээмжийг дээшлүүлж, шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах, мэргэшсэн боловсон хүчнийг бэхжүүлэхэд олон улсын туршлагыг ашиглах.

2. Тэргүүлэх чиглэлд анхаарал хандуулах: Мэргэшсэн боловсон хүчний хомсдолыг арилгах асуудлыг алба хаагчдын удирдлагын шинэ стратеги, бодлого боловсруулах түвшний тэргүүлэх чиглэл болгох.

3. Алба хаагчдын ялгаатай байр суурийг үнэлэх: Тодорхой асуудлууд дээр илэрхий давамгайлсан санал байгаа хэдий ч бусад хувилбарт өгсөн саналуудыг анхаарч, ялгаатай байр сууринд уян хатан хандах замаар үйл ажиллагааг сайжруулах.

4. Оролцоог хангах: Шийдвэр гаргах үйл явцад алба хаагчдын оролцоог нэмэгдүүлж, удирдлагын гол асуудлуудын хэлэлцүүлэгт тэднийг идэвхтэй оролцуулах.

Дүгнэлт

Удирдлагын онол нь арвин баялаг түүхтэй. Энэхүү онолын хүрээнд менежментийн үр ашгийг үнэлэхэд томоохон нөлөө үзүүлсэн сэтгэл зүйн хандлагуудыг боловсруулж ирсэн. Судалгааны ажлууд нь удирдлагын үр ашиг болон байгууллага дахь хүний хүчин зүйлийг тооцох явдал нь хоорондоо салшгүй хамааралтай болохыг баталж байна.

Байгууллагын алба хаагчдын удирдлагын үр ашиг нь сэтгэл зүйн хүчин зүйлсээс (тухайлбал, идэвхжүүлэлт, урамшууллын тогтолцоо байгаа эсэхээс) шууд хамаардаг.

Монгол Улсын төрийн албан хаагчдын ажлын сэтгэл ханамж өндөр байх, амжилтад хүрэх сэдэл (мотиваци) болон мэргэжлийн бүтээмж нь алба хаагчдын удирдлагын үр ашгийг дээшлүүлэхтэй харилцан хамааралтай юм. Эдгээр хүчин зүйлсийг Монгол Улсын ШШГБ-ын удирдлагын үр ашгийг үнэлэх явцад бодитойгоор тооцож үзэх нь зүйтэй байна.

“ГАДААДЫН ЗАРИМ ОРОНД ХОРИГДЛЫН ГАРГАСАН ЗӨРЧЛИЙГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ЯВУУЛЖ БУЙ ТАЛААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА”

“A COMPARATIVE STUDY ON HOW VIOLATIONS COMMITTED BY INMATES ARE INVESTIGATED AND RESOLVED IN SELECTED FOREIGN COUNTRIE”

Б.Сайнбаяр:

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, хошууч

Sainbayar.B:

Major, Lecturer Department of Sentence Emforcement and Law, School of Correctional Institution, University of Internal affairs Mongolia

Хураангуй: Хорих байгууллага нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ял шийтгэлийг хэрэгжүүлэх, тэднийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чухал үүрэгтэй институт юм. Энэ хүрээнд хоригдлын дэг журам, сахилга хариуцлагыг хангах асуудал нь онцгой ач холбогдолтой бөгөөд сахилгын шийтгэл нь хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хэрэгсэл болдог.

Хоригдлын дотроос гаргасан зөрчилд оногдуулах сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээ, хэрэгжүүлэх журам нь улс орон бүрийн эрх зүйн тогтолцоо, ял эдлүүлэх бодлогоос хамааран ялгаатай байдаг. Тухайлбал, Орос болон Герман улсуудын хорих байгууллагын тогтолцоо, сахилгын арга хэмжээний зохицуулалт нь өөр өөр онцлог, зарчимд тулгуурласан байдаг.

Иймд тус илтгэлээр Орос болон Герман улсын хорих байгууллагад хоригдолд оногдуулж буй сахилгын шийтгэлийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм, онцлог шинжийг харьцуулан судалж, тэдгээрийн давуу болон сул талыг тодорхойлохыг зорилоо.

Abstract: Correctional institutions are important entities responsible for enforcing the sentences imposed on individuals who have committed crimes, rehabilitating them, and preventing reoffending. In this context, ensuring

discipline, order, and accountability among inmates is of particular importance, and disciplinary sanctions serve as a key mechanism for maintaining the normal functioning of correctional facilities.

The types, severity, and procedures for implementing disciplinary sanctions imposed for violations committed by inmates vary depending on each country's legal system and penal policy. For example, the correctional systems and regulations governing disciplinary measures in Russia and Germany are based on different characteristics and principles.

"Therefore, this paper aims to comparatively examine the legal regulation, implementation mechanisms, and specific features of disciplinary sanctions imposed on inmates in correctional institutions in Russia and Germany, and to identify their strengths and weaknesses.

Түлхүүр үгс: хоригдол, зөрчил, хариуцлага, сахилгын шийтгэл, үүрэг

Keywords: prisoner, violation, liability, disciplinary sanction, duty

Үндсэн хэсэг

"Зөрчил" гэх ойлголт нь нийгмийн шинжлэх ухаанд, ялангуяа философи, нийгмийн ухаан, сэтгэл судлал, хууль зүй, улс төр судлал зэрэг олон салбарт хэрэглэгддэг өргөн хүрээний ухагдахуун юм. Зөрчил гэх үг нь латинаар *conflictus*-"мөргөлдөөн", "мухардах" гэсэн ойлголттой эртний философид, ялангуяа Грек философичдын бүтээлд анх илэрч гарсан.

Гераклит (МЭӨ 540–480) тодорхойлохдоо "Бүх зүйл зөрчилдөөнөөс төрдөг" хэмээн үзсэн. Түүнийхээр ертөнцийн хөгжил нь эсрэг талуудын тэмцэл, зөрчлийн үр дүнд явагддаг хэмээн тодорхойлсон бол монгол хэлний тайлбар тольд зөрчил гэх үгийг "Зөрчих үйлийн нэр; харилцан харших, үл тохирох эсрэг тэсрэг явдал" (толь, 2025 он) хэмээн тайлбарладаг.

Хүний эрх тэр дотроо хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамааралтай олон улсын эрх зүйн нийтлэг эх сурвалжийн "Хоригдолд хүлээлгэх сахилгын шийтгэл" эрх зүйн институтын зохицуулалтыг доорх байдлаар тогтоосон.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, гийтгэх ёсгүй” хэмээн тусгасан.

Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй” 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана”

Хүний эрхийн конвенцийн 37 дугаар зүйлд “Эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрт насных нь хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хасуулсан нэр төрийг нь хүндэтгэн, хүнлэг хандана” 40 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “… гэм буруутай нь тогтоогдсон хүүхдэд хамаарах хууль, журам, тусгай байгууллага, алба байгуулахад тус дөхөм үзүүлбэл зохино”.

Мөн НҮБайгууллагаас 1955 онд батлан гаргасан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд зааснаар Сахилга ба шийтгэл:

- Сахилга дэг журмыг найдвартай хяналт, хамтын амьдралын зохих журмыг хангахад шаардлагатай хязгаарлалтыг л хэрэглэж хатуу сахиулбал зохино.
- Хоригдлуудыг тухайн хорих газрын үйлчилгээнд сахилгын арга хэмжээ болгон ажиллуулж болохгүй.

Гэхдээ энэ журам нь өөрөө удирдах системийн ажиллагаанд саад болох ёсгүй бөгөөд нийгмийн, хүмүүжлийн спортын үйл ажиллагааны тодорхой хэлбэрийн хариуцлагыг дахин хүмүүжүүлэх зорилгоор байгуулсан хэсэгт хяналтын дор ажиллаж байгаа хоригдлуудад өөрт нь хариуцуулж болно.

Оросын холбооны улсын Эрүүгийн ял эдлүүлэх тухай хууль (Б.Гомбо, 2018 он) болон Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Хорих ял эдлүүлэх тухай хуульд (Б.Отгонбаяр, 2022 он) хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн эрх зүйн зохицуулалтын талаар манай орны эрх зүйн зохицуулалттай харьцуулсан судалгааг авч үзлээ.

Оросын холбооны улсын Эрүүгийн ял эдлүүлэх тухай хууль нь 24 бүлэг 190 зүйлтэйгээр 1996 батлагдан гарсан ба 1998-2008 он хүртэл нийт 18 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна. Тус хуулийн 15 дугаар бүлгийн 115-119 дүгээр зүйлүүдэд тусгаж өгсөн байна.

115 дугаар зүйлд: Хоригдолд хэрэглэх шийтгэлийн арга хэмжээ

116 дугаар зүйл. Тогтоосон хэв журмыг санаатайгаар зөрчих

117 дугаар зүйл: Эрх чөлөөгөө хасуулсан хоригдолд шийтгэлийн арга хэмжээг хэрэглэхдээ зөрчил гаргасан нөхцөл байдал, хоригдлын зан төлөв, урьд өмнөх биеэ авч явсан байдлыг харгалзан үзнэ.

118 дугаар зүйл: Ганцаарчлан болон нийтийн камерт хорих, камер шилжүүлэх, торгуулийн тусгаарлах өрөөнд байршуулах нөхцөл, энэ зүйл нь ОХУ-ын үндсэн хуульвай зөрчилдөөгүй бөгөөд хоригдлыг өмгөөлөгч, эрх зүйн туслалцаа авах эрхийг нь хязгаарлахгүй.

119 дүгээр зүйл: Эрх чөлөөгөө хасуулсан хоригдолд шийтгэл, шагналын арга хэмжээг авах хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан

Оросын холбооны улс болон Монгол улсын хуулийн сахилгын шийтгэл, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагааны талаар заалтуудын нийтлэг буюу ижил тал
• Сахилгын шийтгэлийн зарим төрлүүд болох тусгаарлах тасалгаанд шилжүүлэх буюу сахилгын хорих байранд хорих
• 1 жилийн дотор тухайн хоригдол сахилгын зөрчил гаргаагүй тохиолдолд тухайн хоригдлыг сахилгын зөрчил гаргаагүйд тооцох
• Хоригдлын гаргасан зөрчилд тохируулан сахилгын шийтгэл ногдуулах
• Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийг бичгээ хэлбэрээр ногдуулах
• Хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийг хорих ангийн дарга оноох

Оросын холбооны улсын Эрүүгийн ял эдлүүлэх тухай хуулийн сахилгын шийтгэл, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагааны талаар заалтуудыг өөрийн орны хуулийн тус заалтуудтай харьцуулбал дараах ялгаатай талууд байна.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	Оросын холбооны улсын Эрүүгийн ял эдлүүлэх тухай хууль

➢ Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэл 3 төрөл	Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэл 6 төрөл
➢ Хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийг хорих ангийн дарга оноох	Хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийг хорих ангийн дарга болон дэд дарга оноох эрх бүхий албан тушаалтан байна.
➢ Насанд хүрсэн эмэгтэй хоригдлыг сахилгын хорих байранд 15 хоног, шаардлагатай тохиолдолд 30 хоног хорих	Насанд хүрсэн эмэгтэй хүнд 3 сар хүртэлх хугацаагаар хорих

Оросын холбооны улсын хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийн эрх зүйн зохицуулалт нь манай орны эрх зүйн зохицуулалттай ерөнхий утгаараа адилхан боловч хоригдолд ногдуулж буй сахилгын шийтгэлийн хугацаа нь харьцангуй урт хэлбэртэй байгаа бөгөөд сахилгын хорих байранд хорих нөхцөл нь манай орныг бодвол боловсронгуй ба сахилгын хорих байранд хорих үед давхардуулан зарим төрлийн эрхийг хасдгаараа онцлогтой байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Хорих ял эдлүүлэх тухай хууль нь 36 бүлэг 202 зүйлтэй бөгөөд 13 дугаар бүлэгт хоригдолд ногдуулах сахилгын арга хэмжээг 102-107 дугаар зүйлд хуульчилж өгсөн байна (Б.Отгонбаяр, 2022 он).

102.1. Хорих ял эдэлж буй хоригдол энэ хууль заасан зүйл заалтг зөрчвөл хорих ангийн дарга сахилгын арга хэмжээ авч болно.

102.2. Хоригдолд сахилгын арга хэмжээ авахгүйгээр сануулга өгч болно. /хоригдлын гаргасан зөрчилд тохируулан хорих ангийн дарга сануулах арга хэмжээ авах бөгөөд энэ нь тухайн хоригдлын гаргасан зөрчлийн хор уршиг шалтгаан нөхцөлөөс хамаарах юм/

102.3. Хоригдлын гаргасан зөрчлийн үйлдлээс болж эрүүгийн болон мөнгөн хохирол үүссэн тохиолдолд хоригдолд энэ хуульд заасан сахилгын арга хэмжээг давхардуулан оноож болно.

103 дугаар зүйл. Хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийн төрлүүдийг хуульчилсан.

103.1. сануулах

103.2. 3 сар хүртэлх хугацаагаар өөрийн мөнгийг ашиглах эрхийг хязгаарлах ба бүрэн хориглох. Тухайн улсын хоригдлууд хоригдож байх хугацаандаа 4 төрлийн мөнгө ашигладаг байна. Үүнд:

-Өөрийн мөнгө буюу ял эдэлж байх хугацаанд ашиглах мөнгө-Энэ нь манай өмнөх 2002 оны хуулинд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 10 хувьтай тэнцэх хэмжээний мөнгө хоригдол биедээ байлгахыг зөвшөөрдөг байсан бол 2017 оны хуульд бэлэн мөнгө байлгахгүйгээр хуульчилсан.

-Нэрийн дансан дах мөнгө-Энэ нь манай оронд хэрэгждэг бөгөөд хоригдол болгон нэрийн данстай байж түүгээрээ мөнгөн гуйвуулга болон шилжүүлэг хийх эрхтэй.

-Гэрийн мөнгө нь хөдөлмөр эрхэлсний цалин хөлснөөс ар гэртээ шилжүүлэх, ар гэрээс нь тухайн хоригдолд мөнгөн гуйвуулга хийх боломжтой данс юм. Манай улсад хоригдол өөрийн нэрийн дансаар дамжуулан мөнгөн гуйвуулга авах, явуулах эрхтэй байдаг.

-Суллагдсаны дараа ашиглах мөнгө-хоригдол хоригдож байх хугацаандаа ажилласан ажлынхаа цалин хөлсийг ар гэртээ олгохгүйгээр уг дансанд байршуулж болдог байна.

103.3. 2 долоо хоног хүртэл хугацаагаар хоригдлын унших эд зүйлсийг мөн 3 сар хүртэл хугацаагаар радио болон телевизийг ашиглах эрхийг хасах болон бүрэн хорих, хязгаарлах. Давхар шийтгэл ногдуулах үед энэ заалтыг зөвхөн 2 долоо хоног хүртэл хугацаагаар хориглоно. Уг шийтгэл ганцаарчилсан буюу хоёроор хорих системд тохирох бөгөөд Герман улс нь хоригдлыг ганцаарчлан хорьдог.

103.4. 3 сар хүртэлх хугацаагаар чөлөөт цагаар хэрэглэх эд зүйлсийг эсвэл олон нийтийн үйл ажиллагаанд оролцох эрхийг хязгаарлах эсвэл бүрэн хориглох. Энэ нь ганцаарчлан хорих механизмтай шуул холбоотой бөгөөд олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, чөлөөт цагаар ашиглах боломжтой эд зүйлс нь хоригдолд гол хэрэгсэл болон хувирч байгаа нь харагдаж байна.

103.5. 4 долоо хоног хүртэл хугацаагаар чөлөөт цагаар ганцаарчилсан байдлаар хорих буюу чөлөөт цагийг хасаж буй утга санаа юм.

103.6. Хөдөлмөр эрхлэх байдлыг хориглох ба 4 долоо хоног хүртэлх цалинтай ажлыг хасах

103.7. 3 сар хүртэлх хугацаагаар хорих ангиас гадуурх иргэдтэй уулзах эрхийг хасах. Үүнийг манай улсад хэрэгжиж буй хоригдлын эргэлт, уулзалтыг хасах, хориглох ойлголттой адилтган үзэж болно.

103.8. 4 долоо хоног хүртэл хугацаагаар сахилгын хорих байранд хорих

103.9. Зөвхөн хүнд эсвэл удаа дараа сахилгын зөрчил гаргасан тохиолдолд сахилгын хорих байранд хорих гэх сахилгын шийтгэлүүдийг ногдуулдаг байна.

105 дугаар зүйл. Сахилгын зөвшөөрөл

105.1. Сахилгын арга хэмжээг хорих ангийн даргын шийдвэрээр авах бөгөөд өөр анги руу шилжих үед гаргасан зөрчлийн талаар хүлээн авах хорих ангийн даргад мэдэгдэнэ.

105.2. Сахилгын зөрчил нь тус хорих ангийн даргын эсрэг тохиолдолд хянан шалгах хороо уг асуудлыг шалгаж, шийдвэр гаргана.

106 дугаар зүйл. Сахилгын арга хэмжээ авах үйл ажиллагаа

106.1. Хоригдлын гаргасан зөрчлийн нөхцөл байдлыг тодорхой болгох, хоригдлын байр суурийг сонсох. Бүх болсон явдлын талаар протокол үйлдэх ба хоригдлын байдлыг тэмдэглэх

106.2. Хүнд хэлбэрийн сахилгын зөрчил гаргасан нөхцөлд тухайн хоригдлын засрал хүмүүжлийн ажилд оролцож байгаа албан хаагч болон бусад алба хаагчтай хурал хийж шийдвэр гаргах ба сахилгын шийтгэл ногдуулах хоригдол эмнэлгийн хяналтад байдаг эсэх эсвэл хөхүүл хүүхэдтэй тохиолдолд хорих ангийн эмчийн байр суурийг харгалзан үзнэ.

106.3. Гарсан сахилгын шийдвэрийг хорих ангийн дарга тухайн сахилгын шийтгэл ногдуулсан хоригдолд амаар хэлэх бөгөөд тодорхой тайлбарлаж тушаалд бичнэ

107 дугаар зүйл. Хорих ангийн эмчийн оролцоо

107.1. Сахилгын хорих байранд хорихоос өмнө хорих ангийн эмчийн байр суурийг сонсоно. Сахилгын хорих байранд хоригдсон хоригдол эмчийн хяналтад байна.

107.2. Хэрвээ сахилгын байранд хоригдох хоригдолд сахилгын хорих байр нь эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх бол сахилгын хорих байранд хорихгүй. Хоригдож буй тохиолдолд шууд таслан зогсооно (Б.Отгонбаяр, 2022 он) гэх хуулийн заалтуудыг өөрийн орны хуулийн заалтуудтай харьцуулбал дараах нийтлэг талууд байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман улс болон Монгол улсын хуулийн сахилгын шийтгэл, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагааны талаар заалтуудын нийтлэг буюу ижил тал
• Хоригдолд ногдуулах сахилгын арга хэмжээг хорих ангийн удирдлага буюу ангийн дарга шийдвэрлэдэг.
• Тухайн хоригдлын гаргасан зөрчилд тохируулж сахилгын шийтгэлийн төрлүүдээс оноох
• Сахилгын арга хэмжээг шууд биелүүлэх буюу манай орны хуульд зааснаар 24 цагийн дотор тухайн хоригдолд сахилгын шийтгэлийг оноосон байх
• Сахилгын зөрчил гаргасан хоригдлыг шилжүүлэх үед эдлээгүй үлдсэн арга хэмжээг хүлээн авсан хорих ангид мэдэгдэн, эдлүүлэх
• Хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийг ангийн дарга хувийн ашиг сонирхлын үүднээс оноосон эсэхэд тавих хяналт буюу манай улсад прокурорын байгууллага хяналт тавих тогтолцоо.
• Сахилгын хорих байранд хоригдож буй хоригдолд хорих ангийн эмч өдөр бүр биеийн байдалд үзлэг хийх бөгөөд анх сахилгын хорих байранд хоригдох үед эмч бүрэн үзлэг хийдэг ба эмчийн саналыг үндэслэн хоригдолд ногдуулсан сахилгын арга хэмжээг өөрчлөх үндэслэл болдог.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хуульд заасан сахилгын шийтгэл, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагааны талаар заалтуудыг өөрийн орны хуулийн тус заалтуудтай харьцуулбал дараах ялгаатай талууд байна (Б.Отгонбаяр, 2022 он).

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Хорих ял эдлүүлэх тухай хууль
➢ Хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийг 3 төрөлд хуульчилсан	Герман улсын хувьд сахилгын шийтгэлийг 8 төрлөөр хуульчилсан
➢ Зөвхөн хоригдлын нэрийн дансыг ашигладаг	Хоригдлын мөнгөний дансыг 4 төрлөөр ашигладаг
	Хоригдлыг чөлөөт цагаар нь ганцаарчлан хорих /чөлөөт цагаар буюу нарлах үед бусад хоригдлуудтай уулзах нөхцөлийг хязгаарлах/
➢ Сахилгын нэг зөрчил гаргасан хоригдолд энэ хуулийн 227.1-д	Хоригдлын гаргасан зөрчлөөс хамааран эрүүгийн болон мөнгөн

заасан шийтгэлийг давхардуулан ногдуулахыг хориглоно.	торгуулийн хэрэг үүссэн тохиолдолд давхар сахилгын арга хэмжээ ногдуулна.
➢ Тусгай нэгжээс бусад хорих ангид хоригдлыг бөөнөөр нь хорьдог	Хоригдлыг ганцаарчлан хорьдог

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хоригдолд ногдуулж буй сахилгын шийтгэлийн төрлүүд нь хоригдлыг ганцаарчлан хорьдог тул нөхцөл байдлаасаа шалтгаалан манай орныхоос ялгаатай байх нь их бөгөөд анх холбооны улс нь хоригдлыг бөөнөөр нь хорьдог тогтолцоо байсан ба тухайн улсын бодлогын хүрээнд хоригдлыг бөөнөөр нь хорих биш харин бусад хоригдлоос тусгаарлаж хорих нь зөв гэсэн шийдвэрийн үндсэн дээр тус явдлыг зогсоож, тусгаарлан хорьж эхэлсэн байна. Мөн манай оронд 1966 онд батлагдан хэрэгжиж байсан “Бүгд Найрамдах Монгол Улсын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль”-ийн хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийн төрлүүдтэй ихэнх төрлүүд нь адил байна (Б.Отгонбаяр, 2022 он) хэмээн үзжээ.

Манай орны тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлын хувьд Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хорих ялын бодлоготой ижил бүхий ганцаарчлан хорьдог тул тухайн улсын сахилгын шийтгэлийн төрлүүдээс тохирох төрлийг сонгон эрх зүйн зохицуулалт хийж болох юм. Тухайлбал: хоригдлын гадаалуулах эрхийг хасах буюу хугацааг багасгах, ном сонин унших эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах, телевиз радио үзэх, сонсох эрхийг хязгаарлах, хөдөлмөр эрхлэх боломжтой хоригдлыг өрөөнд нь хөдөлмөрлүүлж, цалин хөлс олгож, зөрчил гаргасан тохиолдолд тухайн хоригдлын цалинг хасах зэрэг тухайн хоригдолд өдөр тутамд хэрэглэгддэг зүйлсийг нь хязгаарлах замаар шийтгэл хүлээлгэвэл сахилгын шийтгэл нь илүү тохирсон, үр нөлөөтэй болох магадлалтай тул тухайн тогтолцоог судлах шаардлагатай хэмээн үзэж байна. Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй 2017 оны хуульд тусгай нэгж хорих ангид ял эдэлж буй хоригдолд тохирох ганц заалт нь сахилгын хорих байранд хорих сахилгын шийтгэл тул үүнийг л ногдуулж байна. Учир нь тухайн ангид ял эдэлж буй хоригдлыг хөдөлмөрлүүлж, шагналын хоног олгодоггүй ба удаан хугацааны уулзалт хийх болон утсаар ярих эрхгүй байна.

Дүгнэлт

Хоригдлын гаргасан зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах эрх зүйн зохицуулалт нь улс орон бүрийн хууль зүйн тогтолцоо, нийгмийн үнэт зүйл, хорих бодлого, хүмүүжлийн арга барилтай нягт холбоотой байдаг.

Оросын Холбооны Улс өнөөгийн байдлаар хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийг илүү хатуу, урт хугацаатай байдлаар хэрэгжүүлж байгаа бөгөөд сахилгын байранд хорих үед давхар эрх хасах (жишээ нь, уулзалт, бичиг харилцаа, соёл хүмүүжлийн арга хэмжээнд оролцох эрхийг хасах) зэрэг онцлогтой байна.

Харин Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын туршлагаас харахад тус улс хорих ял эдлүүлэх бодлогоо хүмүүжлийн сэтгэлзүй, хувь хүний өөрчлөлтөд суурилсан хэлбэрт шилжүүлж, хоригдлыг бөөнөөр бус, ганцаарчлан хорих системийг нэвтрүүлсэн нь тус улсын онцлог болж байна. Энэ нь хоригдлыг бусад зөрчил гаргагчдын сөрөг нөлөөнөөс тусгаарлах, дотоод сэтгэлзүйд нь нөлөөлөх, өөрийгөө хянах чадварыг хөгжүүлэх боломжийг олгож байна хэмээн үзлээ.

Монгол Улсад хорих байгууллагын сахилгын бодлого нь тухайн цаг үеийн улс төр, нийгэм, эрх зүйн хөгжлийн түвшинтэй нягт уялдаатайгаар хувьсан өөрчлөгдөж ирсэн байна. Хоригдолд ногдуулах сахилгын шийтгэлийн төрлүүд нь анх “хүнд хүчир хөдөлмөрөөр хүмүүжүүлэх” социалист үзэл санаанд тулгуурлаж байсан бол өнөө үед хүний эрхийг дээдэлсэн, хүмүүжил, зан төлөвт чиглэсэн бодлого руу шилжсэн нь дээрх онолуудаас харагдаж байна.

Ашигласан эх сурвалж

А.Лхагва. (2001 он). Гяндан салаанаас шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн заснал. Улаанбаатар хот.

Б.Гомбо. (2018 он). Хоригдлын үйлдсэн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа. Улаанбаатар хот.

Б.Отгонбаяр. (2022 он). Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэл, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Улаанбаатар хот.

Г.Тамир. (2014 он). "Онцгой дэглэмтэй хорих ангид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааны онцлог".

Г.Эрдэнэбат, Б. Г. (2013). "Криминологи". Улаанбаатар хот.

Ж.Болдбаатар, Д. (1997 он). Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. Улаанбаатар хот.

журам, Х. а. (2017 он).

журам, Х. а. (2017 он). Retrieved from https://dornod.cd.gov.mn/.

комисс, Х. э. (2014 он). Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. *Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд 1955 он*, pp. 82-83.

Л.Баасан. (2010 он). *"Монгол улсын хөдөлмөрийн эрх зүй".* Улаанбаатар.

льш. (?ү%). *о,.* дзк.

С.Жанцан. (2014 он). *"Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол".* Улаанбаатар хот.

С.Нарангэрэл. (2008 он). *"Эрх зүйн толь бичиг".* Улаанбаатар хот.

толь, М. х. (2025 он). *https://mongoltoli.mn/*.

хууль, З. е. (2015 он). Retrieved from https://legalinfo.mn/.

хууль, М. у. (2017 он). Retrieved from https://legalinfo.mn/.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

FEATURES OF ENFORCEMENT PROCEEDINGS OF CIVIL COURT JUDGMENTS IN SELECTED FOREIGN COUNTRIES

Сүхбаатарын Бямба-Эрдэнэ

Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, ахмад

Byamba-Erdene Sukhbaatar

Department of Private Law, school of law, University of Internal Affairs, Mongolia, https://orcid.org/0009-0005-6434-41818, Byaaba97@gmail.com

Хураангуй:

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний процессын эрх зүйн сүүлийн шат бөгөөд шүүхийн шийдвэр биелэгдэж, дуусахаас нааш зогсдоггүй онцлогтой билээ.

Би энэхүү өгүүллийнхээ хүрээнд Монгол Улсын нэгэн адил эх газрын эрх зүйн бүлд хамаардаг Оросын Холбооны Улс /цаашид ОХУ гэж товчилно, Эстони Улс, социалист эрх зүйн бүлд хамаарах Бүгд Найрамдах Хятад Ард Улс /цаашид БНХАУ товчилно/ зэрэг 3 улсын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлогийг Монгол Улстай харьцуулан судалснаа өгүүлэх болно.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр, төлбөр төлөгч, төлбөр авагч, иргэн, шүүх, албадан дуудлага худалдаа, эд хөрөнгө,

Abstract: The enforcement of civil court judgments is the final stage of civil procedural law and is characterized by its continuity, as it does not cease until the court decision has been fully executed and completed.

In this article, I examine and compare the specific features of the enforcement of civil court judgments in three countries—Russian Federation and Estonia, which belong to the continental legal family, and the People's Republic of China, which belongs to the socialist legal system—with those of Mongolia.

Keywords: Court judgment, judgment debtor, judgment creditor, citizen, court, compulsory auction (forced sale), property.

Үндсэн хэсэг:

Монгол Улсын эрх зүйн тогтолцоо нь Ром-Германы эрх зүйн бүлд хамаардаг. Төр буюу улсын их хурлаас батлан гаргасан Үндсэн хуульд заасны дагуу хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд төр бүхий л нөөц боломжоороо анхаарч ажиллаж ёстой.

Иргэд эдийн болон эдийн бус баялгийн хүрээнд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган хандаж, шүүхээс зөв бурууг дэнслэн, шударга ёсыг тогтоож, шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болоход буруутай этгээд тухайн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

Зарим иргэдийн эрх зүйн ухамсарт шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлж, бусдын зөрчигдсөн эрхийг сэргээж өгөх сэтгэл байдаггүй тул нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн зүгээс шүүхэд дахин хандаж, албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас бичүүлэх нь түгээмэл байдаг.

Албадан гүйцэтгэх захирамжийг төрийг төлөөлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч-шийдвэр гүйцэтгэгч нар иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлж шударга ёсыг тогтоодог билээ.

Монгол Улс нь анхны Үндсэн хуулиа эх газрын эрх зүйн бүлийн тогтолцоонд хамааруулж боловсруулан 1924 онд баталсан цаг мөчөөс эхлэн дараа дараагийн Үндсэн хуулиуд болох 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд эх газрын эрх зүйн бүлийн онцлогийг шингээсэн байдаг.

Бид мөнхийн хөрш ОХУ, БНХАУ болон зарим улс орны эрх зүйн тогтолцоог харьцуулан судлах замаар Монгол Улсын хууль тогтоомжийг ялангуяа иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйг боловсронгуй болгох, хөгжүүлэх боломжийг эрэлхийлэх ёстой.

Нэгт, Оросын холбооны Улсын ИХШГА-ны онцлог: ОХУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны алба, түүний орон нутгийн байгууллага нь Хууль зүйн яамны харьяаны төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага юм. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх нь төрийг хүндэтгэж

байгаагийн нэг илрэл бөгөөд эцсийн дүнд шүүхийн шийдвэр биелэгдсэн үед шударга ёс хангагдсан гэж үздэг (ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, 2020, хууд. 160).

ОХУ-д "Гүйцэтгэх ажиллагааны тухай холбооны хууль", "Шүүхийн гүйцэтгэгчийн холбооны тухай хуулийг ОХУ-ын Төрийн Дум 1997 оны 6-р сарын 04-ний өдөр баталж, 1997 оны 7-р сарын 03-ны өдөр Холбооны Зөвлөлөөр дэмжсэнээс хойш одоог хүртэл хугацаанд дагаж мөрдөж байна (ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, 2020, хууд. 129).

ОХУ-ын Гүйцэтгэх ажиллагааны тухай холбооны хуулийн 30 дугаар зүйлийн 30.12 дэх хэсэгт зааснаар "Сайн дураар гүйцэтгэх хугацааг Холбооны энэхүү хуулиар өөрөөр тогтоогоогүй бол хариуцагчаас гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн тухай тогтоолыг хүлээн авсан өдрөөс эхлэн таван хоногоор тогтооно" гэжээ. (ОХУ-ын Төрийн дум, 1997).

Дээрхээс харахад ОХУ-д хариуцагчид төлбөр төлөх хугацааг шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс 5 хоногоор зааж өгдөг байна.

Мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт "Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр гаргасан гүйцэтгэх баримт бичиг болон гүйцэтгэх баримтын шинжтэй шүүхийн шийдвэрт заасан шаардлагуудыг хариуцагч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн санаачилгаар буюу нэхэмжлэгчийн хүсэлтээр Оросын Холбооны Улсаас гарч явахыг түр хязгаарлах тухай тогтоол гаргах эрхтэй" гэж заасан (ОХУ-ын Төрийн дум, 1997).

ОХУ-д гүйцэтгэх баримт бичгийн мөнгөн дүнгээс үл хамааран хариуцагчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг нь төлбөрийг төлж барагдуулахаас нааш хилээр гарах эрхгүй болгодог.

ОХУ-д үл хөдлөх эд хөрөнгө барьцаалагчийн эрх ашгийг тэргүүн ээлжид тавьдаг. Гүйцэтгэх ажиллагааны тухай холбооны хуулийн 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэгт "Барьцаалагчийн шаардлагыг Холбооны энэхүү хуулийн 111 дүгээр зүйлээр тогтоосон шаардлагыг хангах дэс дарааллыг баримтлахгүйгээр дуудлага худалдаа явуулсан зардлыг нөхсөний дараа барьцаалсан эд хөрөнгийг худалдсан мөнгөөр хангана" гэж заажээ (ДХИС-ийн ШШГС, 2020, хууд. 177).

ОХУ-д 500.000 рублиэс дээш үнэлгээтэй үл хөдлөх эд хөрөнгийг ОХУ-ын Гүйцэтгэх ажиллагааны тухай холбооны хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт “Дуудлага худалдаанд эхлэн дуудах үнэ нь эд хөрөнгийг үнэлсэн тухай тогтоолд заасан үнээс бага байж болохгүй” гэж заасан бөгөөд ОХУ-д дуудлага худалдааны зохион байгуулагч нь дуудлага худалдааны материалыг хүлээн авснаас хойш 2 сарын хугацаанд хөрөнгийг худалдан борлуулах ёстой байдаг (ОХУ-ын Төрийн дум, 1997).

Мөн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.4 дэх хэсэгт “Дуудлага худалдаанд ялсан этгээд нь дуудлага худалдаа явуулсан өдрөөс 5 хоногийн дотор эд хөрөнгийн үнийг бүрэн хэмжээгээр төлөөгүй” гэж заасан тул энэ тохиолдолд анхны дуудлага худалдаа хүчингүй болж дуудлага худалдаа явагдаагүйг зарладаг (ОХУ-ын Төрийн дум, 1997).

ОХУ-д хариуцагчийн үл хөдлөх эд хөрөнгийг үнэлэгдсэн үнээр анхны дуудлага худалдаанд оруулж, хөрөнгө зарагдаагүй бол дуудлага худалдаа болсон өдрөөс хойш 1 сарын дотор хөрөнгийг хоёр дахь дуудлага худалдаанд оруулсан байх ёстой. Хоёр дахь дуудлага худалдаагаар хөрөнгийн үнийг 15 хувиар үнэ бууруулж нийтэд зарлаж дуудлага худалдаанд оруулдаг (ШШГС, 2020, хууд. 188).

Хэрвээ хоёр дахь дуудлага худалдаагаар үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлогдоогүй бол шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийг 25 хувиар үнэ бууруулж, төлбөр авагчид төлбөрт тооцон авахыг санал болгодог. Төлбөр авагч саналаас татгалзвал төлбөр төлөгчид хөрөнгийг буцааж өгдөг. Мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.4 дэх хэсэгт “Хариуцагч төлөх өрийн талаар хоёр дахь дуудлага худалдаа явагдаагүйг зарласан тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь нэхэмжлэлийг барагдуулахыг тооцож, анхдагч дуудлага худалдаанд эхлэн дуудсан үнээс, 25 хувиар доод үнээр өөртөө үлдээхийг нэхэмжлэгчид санал тавина”. Хариуцагчид өртэй этгээдэд төлөх өрийг (түүний зээлдүүлэгч нь нэхэмжлэгч болно) өмнөх хэмжээгээр төлөх үүрэг хадгалагдана” гэж заасан байдаг (ДХИС-ийн ШШГС, 2020).

Монгол Улсад: Төлбөр төлөгчид төлбөр төлөх хугацааг шийдвэр гүйцэтгэгч өөрийн үзэмжээр тогтоож өгөхөөс гадна зөвхөн 50 сая төгрөгөөс дээш төлбөртэй этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг. Үл хөдлөх эд хөрөнгийн үнийг харгалзан үзэхгүйгээр анхны болон хоёр дахь албадан дуудлага худалдаанд оруулах боломжтой. Хөрөнгийг анхны АДХ-

гаар 30 хувь, хоёр дахь АДХ-гаар 50 хувиар үнэ бууруулж, дуудлага худалдааны дуудах үнийг тогтоодог. Тухайн үл хөдлөх эд хөрөнгийг 2 удаа албадан дуудлага худалдаанд оруулаад хөрөнгө худалдан борлогдохгүй бол хөрөнгийг үнэлэгдсэн үнээр төлбөр авагчид төлбөрт тооцон авахыг санал болгож, төлбөр авагч татгалзвал гүйцэтгэх баримт бичгийг буцаадаг.

Хоёрт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ИХШГА-ны онцлог: Иргэний хэргийн хариуцлагыг БНХАУ-ын Иргэний хуулийн 106 дугаар зүйлд "Иргэн, хуулийн этгээд гэрээгээ зөрчих буюу бусад үүргээ биелүүлэхгүй бол иргэний хэргийн хариуцлага хүлээнэ" гэж заасан байна (Сүхбаатар, З., Оюундэлгэр, П., 2004, хууд. 35).

Мөн хуулийн 108 дугаар зүйлд "Зээлээ бүгдийг нь төлөх хэрэгтэй. Хэрэв зээлдэгч нь зээлээ шууд төлж чадахгүй бол зээлдүүлэгчийн зөвшөөрөлтэй эсвэл Ардын шүүхийн шийдвэрлэснээр хуваан төлж болно. Төлөх чадвартай байтал төлөхгүй бол Ардын шүүхээс шийдвэрлэж албадан төлүүлнэ" гэж заасан байдаг (Сүхбаатар, З., Оюундэлгэр, П., 2004, хууд. 36).

БНХАУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхэд харьяалагддаг боловч тусдаа шийдвэр гүйцэтгэх хэлтэстэй. Үүний зэрэгцээ, төлбөр төлөгчийн эд хөрөнгийг үнэлэх, зарах гэх мэт туслах чиг үүргийг өөр байгууллагуудад хуваарилдаг.

Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх гол цөм нь эд хөрөнгө байдаг учир хариуцагчийн эд хөрөнгийг цаг тухайд нь үр дүнтэй олж тогтоох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний алхам бөгөөд үүний урьдчилсан нөхцөл, түлхүүр юм. Мэдээллийн технологид суурилсан аргуудын тусламжтайгаар Хятад улсын шүүхүүд өмчийг таних аргыг шинэчилсэн. Мэдээллийн технологид суурилсан сүлжээ нь шүүх, засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллагуудтай хамтран өмчийн бүртгэлийн мэдээлэлд нэвтрэх, техникийн болон аюулгүй байдлын стандартыг нэгтгэх боломжийг олгодог ба бүх өмч хөрөнгийн бүх хэлбэрийг хамарсан хэрэг бүртгэлт, хяналт шалгалтын системийг бий болгосон явдал юм.

Хөрөнгийг захиран зарцуулах үр ашгийг дээшлүүлэх зорилгоор цахим үнэлгээ, дуудлага худалдааг бүх талаар хөнгөвчлөх: БНХАУ-д

шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх явцад хариуцагчийн бүх хөрөнгийн 60 орчим хувь нь нэхэмжлэгчид шууд шилжүүлэх боломжгүй газар, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, өмчлөл, оюуны өмч байдаг. Сүүлийн жилүүдэд, хятадын шүүхүүд хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг цахимжуулах ажлыг бүх талаар нь хялбаршуулж байна.

Нэгт, цахим лавлах системийг ажиллуулсан. Хөрөнгийн үнэлгээний уламжлалт аргыг хадгалан үлдэх явцдаа өөр арга жишээлбэл, холбогдох талуудын хооронд үнийн хэлэлцээр хийх, зорилтот лавлагаа, цахим лавлагаа авах аргыг ашигладаг. Шийдвэр гүйцэтгэгч дуудлага худалдаагаар эд хөрөнгийг зарах тохиолдолд холбогдох талууд эхлэх үнийн талаар тохиролцож болно. Хэрэв зөвшилцөлд хүрч чадахгүй бол дуудлага худалдаагаар зарагдах эд хөрөнгийн зах зээлийн үнийн талаар холбогдох байгууллагуудтай зөвлөлдөнө. Хэрэв эхлэх үнийг дээр дурдсан хоёр аргаар шийдэх боломжгүй бол шийдвэр гүйцэтгэгч цахим лавлагаа системд нэвтэрч, үл хөдлөх хөрөнгийн байршил, давхрын дугаар, хэмжээ, чиглэл эсвэл тухайн загварын жил гэх мэт бүхий л мэдээлэлд нэвтэрнэ. Ингэснээр систем мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэдэн минутын дотор лавлагаа үнэ авна.

Хоёрт, Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж байна. Эд хөрөнгө цахим дуудлага худалдаагаар зарах, төлбөр хийх, үнэ хаялцуулах, гүйлгээг баталгаажуулах гэх мэт уламжлалт арга хэмжээнд оролцогч бүх үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулсан. БНХАУ-ын дээд шүүх нь "Хяналтын тухай мэдээллийг нээлттэй болгох" веб сайттай болсон. Үүний дагуу холбогдох тал болон олон нийт хууль сахиулахтай холбоотой бүх мэдээллийг нээлттэй, бүхий л сувгаар авах боломжтой болжээ (Б.Батчимэг, 2024, хууд. 120).

Монгол Улсад ИХШГА-г шүүх хэрэгжүүлдэггүй. Мөн цахим орчинд үл хөдлөх эд хөрөнгийг үнэлгээг гаргахгүй, албадан дуудлага худалдааг явуулдаггүй.

Гуравт, Эстони Улсын ИХШГА-ны онцлог: Эстони Улсад 2001 оноос эхлэн хувийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэвтрүүлсэн. Эстони Улсад шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлс нь улсын төсвөөс биш төлбөр авагчийн төлсөн зардал, урамшууллаас хамаардаг. Шийдвэр гүйцэтгэгч нар бие даан шийдвэр гаргах, нэхэмжлэлийн бүртгэлийг хөтлөх, өр

төлбөртэй хүмүүсийн өмч хөрөнгийн талаарх мэдээлэл, улсын бүртгэлд хүсэлт гаргах, шүүх хуралдаанд оролцогчидтой баримт бичгээр харилцах, өр төлбөртэй хүмүүсийн эд хөрөнгийг цахим хэлбэрээр хураан авах, төлбөр авагчийн эд хөрөнгийг дуудлага худалдаагаар байршуулах ажиллагаа явуулдаг (ДХИС-ийн ЭШ-ний нэгдсэн хүрээлэн, 2020, хууд. 166).

Эстони Улсад хэрэв өр төлбөрийг барьцаалсан бусад эд хөрөнгийг хураах нь нэхэмжлэгчийн шаардлагыг бүрэн хангаагүй, эс тэгвээс нэхэмжлэгчийн шаардлагыг бүрэн хангахгүй бол онцгой тохиолдолд төлбөрийн хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон амьжиргааны өртгийн зөрүүгийн 20 хүртэлх хувьтай тэнцэж байвал 1 сар хүртэлх хугацаагаар төлбөр төлөгчийг баривчлах боломжтой байдаг (ДХИС-ийн ЭШ-ний нэгдсэн хүрээлэн, 2020, хууд. 167).

Монгол Улсад төлбөр төлөгчийн эд хөрөнгийг цахим хэлбэрээр хураадаггүй. Мөн төлбөр төлөгчийг гэмт хэрэг хийснээс бусад тохиолдолд баривчлах боломжгүй.

Дүгнэлт

Гадаадын зарим орны онцлогийг судлахад ОХУ-аас үл хөдлөх эд хөрөнгийн анхны дуудлага худалдааг хөрөнгийн зах зээлийн үнэлгээгээр, хоёрдох албадан дуудлага худалдааг хөрөнгийн үнэлгээг 15 хувь бууруулж албадан дуудлага худалдаанд оруулдаг, худалдан борлогдоогүй хөрөнгийг тогтоогдсон хөрөнгийн үнэлгээнээс 25 хувиар үнэ бууруулж төлбөрт тооцон өгдөг, мөн төлбөрийн мөнгөн дүн харгалзахгүйгээр төлбөр төлж барагдуулах хүртэл хугацаанд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж байгаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн биелэлтэд өндөр ач холбогдолтой байна.

БНХАУ-д иргэний шийдвэр гүйцэтгэлийг шүүх хэрэгжүүлдэг нь засгийн газрын мэдлээс ангид байлгаж, хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжийг олгожээ. Мөн БНХАУ, Эстони Улсад цахим дуудлага худалдааг зохион байгуулдаг нь шинэлэг бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хурдан шуурхай гүйцэтгэхэд нөлөөлдөг байна.

Түүнчлэн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, төлбөр төлөхгүй удаашруулж байгаа төлбөр төлөгчид Эстони зэрэг улс

үндсэн төлбөр дээр нэмж хүү, торгууль, алданги тооцож төлбөр дээр нэмж төлүүлдэг байна.

Монгол Улсад төлбөр төлөгчийн гадаад зорчих эрхийг үнийн дүн харгалзахгүй түдгэлзүүлэх, төлбөр төлөх хугацааг богино хугацаагаар тогтоох, дуудлага худалдааны дуудах үнийг уян хатан тогтоох, цахим дуудлага худалдаа зохион байгуулах, төлбөрөө төлөхгүй чирэгдэл учруулж байгаа төлбөр төлөгчийн үйлдэлд үндсэн төлбөр дээр нэмж хүү, алданги тооцдог болох эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байгааг онцлон тэмдэглэж энэхүү өгүүллийг төгсгөж байна.

Ашигласан материалын жагсаалт

ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль. (2020). Монгол, Орос, Солонгос Улсын Шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл. Уб.

Б.Батчимэг. (2024). Захиргааны хэрргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Уб.

ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль. (2020). Монгол, Орос, Солонгос Улсын Шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл. Уб.

ДХИС-ийн ЭШ-ний нэгдсэн хүрээлэн. (2020). Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэлийн судалгааны тайлан. Уб.

ОХУ-ын Төрийн дум. (1997). ОХУ-ын Гүйцэтгэлийн холбооны тухай хууль. Москва.

Сүхбаатар, З., Оюундэлгэр, П. (2004). Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хууль. Уб.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ISRS4ST АРГАЧЛАЛЫГ ДЭВШҮҮЛЭХ НЬ

Монгол улс, Дотоод хэргийн их сургууль-Цагдаагийн сургуулийн багш, ахлах дэслэгч Б.Мөнхзаяа /Мэдээллийн аюулгүй байдлын магистр/ Baaskamuugii1103@gmail.com

Хураангуй—Мэдээллийн технологигүйгээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага бараг үгүй болсон өнөө үед кибер аюул занал асах ихээр нэмэгдэж буй нь аливаа байгууллага нь аюулгүй байдлын зөрчилд өртөхөд үндсэн шалтгаан болж байна. Мэдээллийн аюулгүй байдлын зөрчилд өртөхөөс сэргийлэх буюу байгууллага өөрийн үйл ажиллагаа болон үнэ цэнтэй хөрөнгийг аюул заналаас хамгаалахын тулд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үр дүнтэйгээр удирдах явдал юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон, онц чухал мэдээллийн дэд бүтцэд багтдаг тул мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх тал дээр онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай. Эрсдэлийн менежментийн үндэс суурь нь эрсдэлийн үнэлгээ байдаг хэдий ч санхүүгийн хийгээд хүний нөөцийн хязгаарлагдмал нөөцтэй, мэдээллийн аюулгүй байдлын тусгайлсан мэргэжилтэнгүй байгууллагууд энэ тал дээр анхаарал хандуулахгүй, орхигдуулсан хэвээр байна. Учир нь одоо байгаа эрсдэлийн үнэлгээний аргууд байгууллагууд шууд авч хэрэгжүүлэхэд тохиромжгүй байдаг. Тиймээс бид энэ судалгааны ажлаараа үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл технологийн цөөн тооны ажилтантай салбар байгууллагууд эрсдэлийн үнэлгээг өөрсдөө хэрэгжүүлэх боломжийг олгох ISRA4ST аргачлалыг дэвшүүлж буй юм.

Abstract-In the modern era, it is almost impossible for organizations to operate without information technology. Consequently, cyber threats have been increasing significantly, becoming one of the primary causes of security incidents within organizations. To prevent information security breaches and to protect organizational operations and valuable assets from potential threats, it is essential for organizations to effectively manage information security risks.

The Court Decision Enforcement Agency is connected to the national government information network and is considered part of the critical

information infrastructure. Therefore, particular attention must be given to the implementation of information security risk management within this organization.

Although the foundation of risk management lies in risk assessment, organizations with limited financial and human resources, as well as those lacking specialized information security professionals, often fail to adequately address this issue. One of the main reasons is that existing risk assessment methodologies are not always suitable for direct implementation in such organizations.

Therefore, this research proposes the ISRA4ST methodology, which enables branch organizations with a limited number of IT personnel to independently conduct information security risk assessments.

Түлхүүр үг—эрсдэлийн үнэлээ, ISRA4ST аргачлал, байгууллага

Keywords — Risk assessment, ISRA4ST methodology, organization.

I. УДИРТГАЛ

Мэдээллийн технологи, интернэтийн хэрэглээ нь аливаа байгууллагууд үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлаа хангаж ажиллахад туслах салшгүй нэгэн хэсэг болсон энэ цаг үед бид ажиллаж амьдарч байна. Мэдээллийн технологи, интернэтийн хэрэглээ нь байгууллагуудад үйл ажиллагааны төдийгүй эдийн засгийн хувьд маш их давуу тал авчирч буй хэдий ч маш олон эрсдэлийг бий болгодог. Цахим гэмт хэрэг өсөхийн хэрээр эдгээр эрсдэлүүд өдөр бүр илт мэдрэгдэж, үүний үр дагавар болох хор хохирол учирсаар байна (R.Manship, 2026).

Гэвч мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлээс үүдэн гарах үр дагаврын талаарх ойлголт байгууллагын том жижгээс хамааран харилцан адилгүй байна. Хүний нөөц, санхүүгийн чадамжтай том байгууллагууд нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэн, эрсдэлийг зохих ёсоор удирдаж байхад хүний нөөцийн хийгээд санхүүгийн чадамж султай жижиг дунд байгууллагууд нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг удирдах, кибер аюул заналаас өөрсдийгөө хамгаалах талаар хэт бага анхаардаг эсвэл бүр ямар ч үйл ажиллагаа хэрэгжүүлдэггүйг олон судалгаа харуулж байна (Duncan, 2020).

Судалгаанаас харахад жижиг, дунд байгууллагууд нь аюул заналын талаар бодолцдог болохоо илэрхийлж, үүнд чиглэсэн ямар арга хэмжээ авах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч тэдэнд мэдээллийн аюулгүй байдлаа сайжруулах цаг хугацаа, мэдлэг чадвар, санхүүгийн нөөц хязгаарлагдмал нь тэднийг кибер аюул заналын хохирогч болгох үндсэн шалтгааны нэг хэвээр байсаар байгаа юм.

Мэдээллийн аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэх хамгийн сайн арга бол эрсдэлд суурилсан аргыг хэрэгжүүлэх буюу мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг зөв удирдах шаардлагатай (A. Shameli-Sendi, 2016). Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн менежмент нь байгууллагын үнэ цэнтэй мэдээллийн хөрөнгө (техник хангамж, программ хангамж, өгөгдөл, дамжуулах төхөөрөмжүүд болон сүлжээ)-д учирч болзошгүй эрсдэл, тэдгээр эрсдэлийн шийдвэрлэх арга хэрэгслийн талаарх ойлголтоор хангадаг тасралтгүй үйл явц юм (Landoll, 2006) (Vaughn, 2010) (Z. I. Saleh, 2011) (University, 2011). Гэвч мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн менежментийг бодитоор хэрэгжүүлэх нь амаргүй ажил байдаг. Учир нь технологийн хурдацтай өөрчлөлт, халдлага үйлдэгчийн мэдлэг, ур чадварын түвшин гэх мэт эрсдэлийн хүчин зүйлүүд нь байнга өөрчлөгдөж байдаг. Кембриджийн Их Сургууль эрсдэлийн менежментийг: "Байгууллага нь үйл ажиллагааны хийгээд бизнесийн алдагдал, хохирол амсахгүй байхын тулд эрсдэлийн тооцоог, бууруулах үйл ажиллагаа" (University, 2011) юм гэж тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолтын эхний хэсэгт дурдсан эрсдэлийн тооцоог эрсдэлийн үнэлгээ хийх замаар хийдэг.

Эрсдэлийн үнэлгээ нь эрсдэлийн менежментийн үндэс суурь бөгөөд үүнийг олон салбарт ашиглаж болох ч мэдээллийн аюулгүй байдлын хувьд зайлшгүй хийх шаардлагатай. Эрсдэлийн үнэлгээ нь эмзэг байдал, аюул заналыг таньж тодорхойлох, улмаар болзошгүй аюул заналыг арилгахын тулд ямар сөрөг арга хэмжээ авах буюу аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх шийдвэр гаргах боломжийг олгодог (Duncan, 2020), (Landoll, A Complete Guide for Performing Security Risk Assessments, 2006), (Shameli-Sendi, 2012). Эрсдэлийн үнэлгээг зохих ёсоор, тогтмол хийдэггүй байгууллагууд нэр хүндээ алдах, хууль эрх зүйн асуудал, тэр байтугай Эрсдэлийн үнэлгээг тогтсон нэг аргаар хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд

тухайн байгууллагын онцлогоос хамаарч хэрэгжүүлэх аргууд нь ялгаатай байх шаардлагатай болдог. Үүний улмаас олон судлаачид өөр өөрийн аргуудыг санал болгосон байдаг ба одоогийн байдлаар эрсдэлийн үнэлгээг хийхэд зориулагдсан олон аргачлал, загвар, стандартууд буйгаас дурдвал National Institute Standards and Technology Special Publication 800-30 (NIST SP 800-30) (”NIST SP - 800-30rev1,” 2012, 2025), International Standard Organization/International Electrotechnical Commission (ISO/IEC 27005) (management), CRAMM (guide, 2001), Microsoft’s Risk Assessment model(MRAM) (Guide, 2006), EBIOS (2010, 2014) CORAS (den Braber, 2007) Operationally Critical Threat, Asset, and Vulnerability Evaluation (OCTAVE) (Mellon, 2005), information technology (IT)-Grundschutz , Metodologia de Analisis y Gestion de Riesgos de los Sistemas de Informacion (MAGERIT) (3.0., 2014) зэрэг юм. Эдгээр аргууд нь өөр өөрийн гэсэн онцлог шинж чанаруудтай. Бидний судалгааны объект нь төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага хэдий ч мэдээллийн аюулгүй байдлын тусгайлсан орон тоогүй, санхүүгийн хязгаарлагдмал нөөцтэй гэсэн шинж чанартай (F.Macedo, 2009), (Moyo, 2014). Энэ төрлийн байгууллагууд нь эрсдэлийн үнэлгээг зохих давтамжаар кибер аюулгүй байдлын тухай хуульд зааснаар 2 жилд 1 удаа хийлгэдэг хэдий ч энэ хугацаанд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг дотооддоо хийж шаардлагатай арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Учир нь дээр дурдсан эрсдэлийн үнэлгээний аргачлал, загвар, стандартуудыг шууд авч хэрэгжүүлэхэд цаг хугацаа, санхүү, хүн хүчний нөөцийн хувьд өртөг өндөртэй байхаас гадна заавал мэргэжлийн хүн гүйцэтгэх шаардлагатай байдаг тул тухай бүр хэрэглэхэд тохиромжгүй юм. Тиймээс бид энэ судалгааны ажлаараа эрсдэлийн үнэлгээг өөрсдөө дотооддоо үнэлэх, хэрэгжүүлэх боломжийг олгох ISRA4ST (Information Security Risk Assessment for Small Telecommunication Organizations) аргачлалыг дэвшүүлж буй юм. Уг арга нь хэрэгжүүлэхэд хялбар хийгээд мэдээллийн аюулгүй байдлын эсвэл эрсдэлийн менежментээр мэргэшсэн мэргэжилтэн заавал шаардахгүй давуу талтайгаас гадна санхүүгийн нэмэлт зардалгүйгээр богино хугацаанд хэрэгжүүлж, учирч болзошгүй эрсдэлийн талаар мэдээллээр хангах болно.

II. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГУУД

CRAMM[15] нь хамгийн анхны эрсдэлийн үнэлгээний арга нь бөгөөд төрийн байгууллага, аж үйлдвэр зэрэг томоохон байгууллага ашиглахад тохиромжтой, эрсдэлийг үнэлэх хэрэгсэл ашиглах чадвартай туршлагатай хүний хэрэгцээ гардаг мөн хэт их хэвлэмэл хувилбар ашигладаг учир удаан үргэлжилж цаг алддаг дутагдалтай талтай (A. Shameli-Sendi, 2016). ISO27005[13] стандарт нь нарийвчилсан тайлбар, сайн бүтэцтэй, ашиглахад хялбар, иж бүрэн лавлагаатай байдгаараа давуу талтай боловч мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх тодорхой аргыг заагаагүй байдгаараа сул талтай юм. NIST-SP 800-30 (”NIST SP - 800-30rev1,” 2012, 2025) гарын авлага нь мэдээллийн технологийн системд тодорхойлсон эрсдэлийг үнэлэх, бууруулахад шаардлагатай тодорхойлолт, практик удирдамжийг агуулсан үр дүнтэй эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг боловсруулах үндэс суурь болж өгдөг. Expression des Besoins et Identification des Objectifs de Sécurité - Expression of Needs and Identification of Security Objectives (EBIOS) (2010, 2014) арга нь байгууллага бүрийн нөхцөл байдалд дасан зохицох, арга зүйн хэрэгсэл, дадал зуршилд нь тохируулдаг гол агуулгыг сайжруулахын тулд модулийг шат дараатайгаар дахин ашигладаг давуу талтай. Харин эрсдэлд хяналт тавьдаггүй их хэмжээний мэдээллийг бий болгодгоороо дутагдалтай юм. CORAS (den Braber, 2007) нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэхэд ашиглагддаг чанарын арга бөгөөд Unified Modeling Language (UML) дээр суурилж загварчлагддаг, хэрэглэгчид болон тэдний ажиллах орчны хоорондын хамаарлыг диаграммаар харуулдаг давуу талтай. OCTAVE (Mellon, 2005) аргыг ашиглан байгууллага чухал хөрөнгийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлын эрсдэлд суурилан мэдээллийг хамгаалдаг. Байгууллагыг үнэлж, аюулгүй байдлын хэрэглээг голлон, өөрөө удирддагаараа бусад аргуудаасаа давуу талтай юм. IT Grundschutz (Application of the Elementary Threats from the IT-Grundschutz Catalogues for Performing Risk Analyses. Bonn: Ferderal Office for Information Security, 2011) арга нь харьцангуй техникийн түвшинд учрах аюул занал, шаардлагатай хариу арга хэмжээний жагсаалтыг агуулдаг. MAGERIT (3.0., 2014) нь мэдээллийн системийг хариуцдаг хүмүүст эрсдэл байгаа эсэх, тэдгээрийг цаг тухайд нь арилгах шаардлагатай байгааг ойлгуулах, эрсдэлд дүн шинжилгээ хийх системчилсэн аргыг санал болгох, эрсдэлийг хяналтад байлгах зохих арга хэмжээг тодорхойлох, төлөвлөхөд

туслах, болон шууд бусаар тухайн байгууллагыг тухайн тохиолдол бүрд хамааралтай үнэлгээ, аудит, баталгаажуулалт, итгэмжлэлийн үйл ажиллагаанд бэлтгэдэг давуу талтай. Систем нь учирч болохгүй аюулаас хамгаалагдсан байдаг бөгөөд энэ нь батлагдаагүй зардал гаргах сул талтай. Өмнө дурдсанчлан эдгээр аргуудыг жижиг хэмжээний болоод харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад шууд авч хэрэгжүүлэхэд цаг хугацаа, санхүү, хүн хүчний нөөцийн хувьд өртөг өндөртэй байхаас гадна заавал мэргэжлийн хүн гүйцэтгэх шаардлагатай байдаг тул мэдээллийн аюулгүй байдлын бие даасан нэгжгүй жижиг дунд байгууллагад хэрэглэхэд тохиромжгүй юм.

III. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ISRA4ST АРГАЧЛАЛ



1-р зураг. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх ISRA4ST аргыг хэрэгжүүлэх үйл явц

Юуны түрүүнд дэвшүүлж буй аргачлалд ашиглаж буй нэр томьёог тодорхойлъё. Үүнд:

Хөрөнгө – тухайн байгууллагад үнэ цэнтэй, хамгаалах шаардлагатай аливаа зүйл.

Аюул занал – Мэдээлэлд зөвшөөрөлгүй хандах, устгах, задруулах, өөрчлөх, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах замаар мэдээллийн системээр дамжуулан байгууллагын үйл ажиллагаа, эд хөрөнгөд сөрөг үр дагавар учруулах аливаа нөхцөл байдал, үйл явдал.

Эмзэг байдал – нэг болон хэд хэдэн аюул заналд ямар нэг эд хөрөнгө болон хэсэг эд хөрөнгө өртөж болох сул тал

Эрсдэл – болзошгүй үзэгдлүүд, тэдгээрийн үр дагаврын нэгдэл

Магадлал – Аюул занал, нөлөөлөлд өртсөн хөрөнгө, ашиглагдсан эмзэг байдал, хөрөнгө, бизнесийн үйл явцын үр дагаврыг тодорхойлох

Аюулгүй байдлын хяналт – аюул заналаас хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх аюулгүй байдлын сөрөг механизмууд

Үр дагавар – эмзэг байдлыг ашигласан аюул заналын улмаас үүдсэн хохирлын хэмжээ

А. ISRA4ST аргачлалыг хэрэгжүүлэх заавар Бидний дэвшүүлж буй арга нь Олон улсын цахилгаан холбоо (International Telecommunications Union - ITU)-оос харилцаа холбооны байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмж (X.1055, 2008) дээр үндэслэн тодорхой тооны дагалдах шалгах хуудас, хүснэгт, баримт бичиг зэргээр хангах юм. Ингэснээр бидний дэвшүүлж буй аргыг мэргэжлийн баггүй, санхүүгийн болоод хүний нөөц хязгаарлагдмал жижиг байгууллагууд эрсдэлийн дотоод үнэлгээг төлөвлөсөн давтамжаараа гүйцэтгэж, учирч болзошгүй эрсдэлүүдийн талаар мэдээлэлтэй болж, тэдгээрийг хэрхэн залруулах төлөвлөгөөгөө гаргах нөхцөл бүрдэх юм.

Одоо дэвшүүлж буй аргынхаа алхам бүр дээр хийгдэх үйлдлүүдийг дэлгэрэнгүй танилцуулъя. Үүнд:

Алхам-1: Хөрөнгийн бүртгэл хийх. Энэ алхамд урьдчилан боловсруулсан хөрөнгийн бүртгэлийн шалгах хуудсыг ашиглан тухайн байгууллага хөрөнгүүдээ тодорхойлно. Бидний дэвшүүлж буй аргачлал нь ITU байгууллагаас тодорхойлсон хөрөнгийн мэдээлэл дээр үндэслэн харилцаа холбооны байгууллага дахь хөрөнгүүдийг бүртгэхэд зориулсан шалгах хуудсаар хангана. Энэ алхмын үр дүнд эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах тухайн байгууллага дахь хөрөнгийн жагсаалтыг гаргаж авна

Алхам-2: Чухал хөрөнгийг таньж тодорхойлох. Алхам 1-н үр дүн дээр үндэслээд чухал хөрөнгө гэж ITU байгууллагаас тодорхойлсон шалгах хуудастай харьцуулах замаар тухайн байгууллагад байгаа чухал хөрөнгүүдийг тодорхойлно.

Алхам-3: Аюул заналыг таньж тодорхойлох. Энэхүү арга нь байгууллагын мэдээллийн хөрөнгөнд учирч буй аюул заналыг тодорхойлоход зориулагдсан дагалдах хүснэгтээр хангах ба түүний Алхам 2 дээр таньж тодорхойлсон хөрөнгүүд дээр тулгарч болох аюул заналуудыг тэмдэглэж, тодорхойлно.

Алхам-4: Эмзэг байдлыг таньж тодорхойлох. Алхам 2 дээр таньж тодорхойлсон чухал хөрөнгийн эмзэг байдлуудыг энэхүү аргачлалын дагалдах баримт бичиг болох хүснэгтийн тусламжтайгаар таньж тодорхойлно. Энэ алхмын үр дүнд тухайн байгууллагын чухал хөрөнгүүдийн эмзэг байдлын бүртгэл бий болно.

Алхам-5: Одоо байгаа хяналтуудыг бүртгэх. Алхам 4 дээр тодорхойлогдсон эмзэг байдлыг бууруугаар ашиглаж болзошгүй аюул заналыг бууруулахын тулд хэрэгжүүлсэн аюулгүй байдлын механизмууд хяналтуудыг энэхүү аргачлалын дагалдах баримт бичиг болох шалгах хуудас дээр тэмдэглэж, бүртгэнэ.

Алхам-6: Эрсдэлийн үр дагаврыг тодорхойлох. Хөрөнгийн жагсаалт, урьдчилан бэлдсэн шалгах хуудасны дагуу тодорхойлсон аюул болон эмзэг байдлын мэдээлэл дээр үндэслэн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал нь тухайн чухал хөрөнгөд үзүүлэх үр дагаврыг бэлтгэсэн хүснэгтээр шалгаж тодорхойлно. Үр дагаврыг “маш ноцтой”, “ноцтой”, “дундаж”, “бага”, “маш бага” гэсэн чанарын үнэлгээгээр тодорхойлно.

Алхам-7: Магадлалыг тодорхойлох. Аюул занал, зөрчилд өртсөн хөрөнгө, бууруугаар ашиглагдсан эмзэг байдал, хөрөнгө болон байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх үр дагавар, одоо хэрэгжүүлсэн аюулгүй байдлыг хяналт дээр үндэслэн аюулгүй байдлын зөрчил учруулж болзошгүй үзэгдлүүдийн эрсдэлийн магадлалыг тодорхойлно. Магадлалыг “өндөр магадлалтай”, “магадлалтай”, “болзошгүй”, “бага магадлалтай”, “ховор” гэсэн чанарын үнэлгээгээр үнэлнэ..

Алхам-8: Эрсдэлийн түвшин тодорхойлох. Алхам 6 болон Алхам 7 дээр үнэлж гаргасан үр дагавар болон магадлал дээр үндэслэн эрсдэлийн

түвшнийг тодорхойлно. Үүнийг 1-р хүснэгтэд үзүүлсэн эрсдэлийн матриц (Singapore, 2019)-ын тусламжтайгаар гүйцэтгэх ба Энэ алхмын үр дүнд утгаар илэрхийлсэн түвшин бүхий эрсдэлүүдийн жагсаалтыг гаргаж ирнэ.

1-р хүснэгт. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний матриц

Маш ноцтой	Дундаж	Дунджаас өндөр	Өндөр	Маш өндөр	Маш өндөр
Ноцтой	Бага	Дундаж	Дунджаас өндөр	Өндөр	Маш өндөр
Дундаж	Бага	Дундаж	Дундаж	Дунджаас өндөр	Өндөр
Бага	Бага	Бага	Дундаж	Дундаж	Дунджаас өндөр
Маш бага	Бага	Бага	Бага	Бага	Дундаж
	Ховор	Бага магадлалтай	Болзошгүй	Магадлалтай	Өндөр магадлалтай

Алхам-9: Эрсдэлийг эрэмбэлэх. Өмнөх алхамд үнэлэн гаргасан эрсдэлийн түвшин бүрээр эрсдэлүүдийг нь эрэмбэлнэ. Энэ алхмын үр дүнд аюулгүй байдлын зөрчилд хүргэж болзошгүй эрсдэлүүдийн “маш өндөр” түвшнээс “бага” түвшин рүү эрэмбэлсэн жагсаалтыг гаргаж ирнэ. Эрсдэлийн үнэлгээний шалгуурын дагуу эрэмбэлэгдсэн эрсдэлүүдийн жагсаалтыг ашиглан тухайн байгууллага эрсдэлийг бууруулах, хадгалах, зайлсхийх, хуваалцахад чиглэсэн эрсдэлийг залруулах төлөвлөгөөг гаргах боломжтой болно.

IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлэгт бид өөрсдийн дэвшүүлж буй аргачлалын хэрэгжих боломжийг үнэлэх зорилгоор харьцуулсан шинжилгээг хийх юм. Ингэхдээ бид эхлээд харьцуулсан шинжилгээг хийх мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний арга (загвар стандартууд)-ыг сонгож тодорхойлно. Үүний дараа тэдгээр сонгосон ажлуудыг харьцуулах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно. Эцэст нь бидний өөрсдийн дэвшүүлж буй арга болон сонгосон аргуудыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, үр дүнг танилцуулна.

А. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний аргуудыг сонгох нь

Бид судалгааны ажлаа гүйцэтгэх явцдаа мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний маш олон аргууд байгааг олж тодорхойлсон (Бүлэг 1) бөгөөд тэдгээр аргуудыг (1) мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний (загвар, зөвлөмж, стандарт бус) арга эсэх, (2) баримт бичгийг нь төлбөргүй ашиглах боломжтой эсэх, (3) шинэчлэлт хийгдэж байгаа эсэх гэсэн Macedo (F.Macedo, 2009) нарын тодорхойлсон үзүүлэлтээр үнэлж (2-р хүснэгт), өөрийн аргатай харьцуулах аргуудыг тодорхойлов. Үүнд: EBIOS (2010, 2014), OCTAVE (Mellon, 2005), IT Grundschutz (Application of the Elementary Threats from the IT-Grundschutz Catalogues for Performing Risk Analyses. Bonn: Ferderal Office for Information Security, 2011), MAGERIT (3.0., 2014) аргууд багтана.

2-р хүснэгт. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний аргуудын сонголт

Нэр	**Сонгох шалгуурууд**			**Сонгосон эсэх**
	1	**2**	**3**	
ISO/IEC 27005[13]	Х	П	П	Үгүй
NIST SP 800-30 [14]	Х	П	П	Үгүй
CRAMM [15]	П	Х	П	Үгүй
MRAM [16]	П	Х	Х	Үгүй
EBIOS [17]	П	П	П	Тийм
CORAS [18]	Х	П	П	Үгүй
OCTAVE[19]	П	П	П	Тийм
IT rundschutz[22]	П	П	П	Тийм
MAGERIT [23]	П	П	П	Тийм

В. Шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох нь Бүлэг IV.А-д сонгогдсон аргуудтай өөрсдийн дэвшүүлсэн аргыг харьцуулах шалгуур үзүүлэлтүүдийг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

(а) Хэрэгжүүлэх дэлгэрэнгүй нарийн зааварчилгаатай эсэх. Тухайн аргыг хэрэгжүүлэх нарийн зааварчилгаагаар хангаж байх нь цаг хугацааг хэмнээд зогсохгүй хэрэгжүүлэхэд хялбар байх нөхцөлийг бий болгодог;

(b) Эрсдэлийн үнэлгээг хийх хамрах хүрээг урьдчилан тодорхойлох шаардлагатай эсэх. Хамрах хүрээг тодорхойлох нь нэлээд амаргүй ажил байдаг бөгөөд энэ ажлыг мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн менежментийн талаар өргөн ойлголттой буюу мэргэжлийн хүн гүйцэтгэхээс гадна маш их хэмжээний урьдчилсан мэдээлэл цуглуулах шаардлагатай болдог;

(c) Эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг эрсдэлийн үнэлгээ хийж буй тал тодорхойлох шаардлагатай эсэх. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон дагалдах баримт бичгээр хангах нь мэргэжлийн хүний оролцоогүйгээр эрсдэлийн үнэлгээг хийх боломжийг бий болгодог;

(d) Эрсдэлийн үнэлгээг хийхэд хэр их цаг хугацаа шаардагдах. Эрсдэлийн үнэлгээг хийхэд шаардагдах хугацаа бага байх тусам эрсдэлийг хурдан шуурхай олж илрүүлэх давуу талыг бий болгоно.

(e) Ямар арга зүйг ашигладаг болох. Эрсдэлийн үнэлгээг хийхэд ашиглаж буй арга зүйгээс хамааран үнэлгээг системтэйгээр гүйцэтгэх боломжоор хангадаг;

(f) Дагалдах баримт бичгээр хангадаг эсэх. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичгээр хангаснаар тухайн байгууллага эрсдэлийн үнэлгээг өөрсдөө гүйцэтгэх боломжийг бий болгох юм.

(g) Эрсдэлийг ямар аргаар үнэлэх. Эрсдэлийг хөрөнгийн ноцтой байдал, мэдэгдэж буй эмзэг байдлын цар хүрээ, байгууллагын өмнө тохиолдсон тохиолдлууд зэргээс шалтгаалан янз бүрийн нарийвчлалтайгаар хийж болно. Эрсдэлийн шинжилгээний аргачлал нь нөхцөл байдлаас шалтгаалан чанарын болон тоон, эсвэл тэдгээрийн хослол байж болно. Жижиг байгууллагын хувьд чанарын үнэлгээг ашиглан эрсдэлийг үнэлэх нь илүү тохиромжтой гэж үздэг.

(h) Эрсдэлийн үнэлгээг хийх мэргэшсэн хүн эсвэл баг шаардлагатай эсэх. Эрсдэлийн үнэлгээгээр мэргэшсэн эсвэл мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтнийг тусгайлан шаардахгүйгээр тухайн байгууллага өөрийн дотоод бүрэлдэхүүнээсээ хүн эсвэл баг томилон эрсдэлийн дотоод

үнэлгээ хийлгэх нь хөрөнгө мөнгө хийгээд цаг хугацааг хэмнэх нөхцөлийг бүрдүүлнэ;

(i) Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад тусгайлан зориулсан эсэх. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад тусгайлан зориулагдсан байх нь салбарын онцлогт нийцтэй байдлаар эрсдэлийг бодитоор үнэлэх давуу талыг бий болгоно

(j) Зөвхөн технологи төвтэй эрсдэлийг авч үздэг эсэх. Жижиг салбар нэгж байгууллагуудын хувьд бодлогын хэмжээний дүрэм журам боловсруулж мөрдөх боломж олгогдоогүй байдаг тул байгууллагын үйл ажиллагаа буюу бизнес төвтэй эрсдэлээс илүүтэй технологи төвтэй эрсдэлийг авч үзэх нь практик ач холбогдолтой байдаг.

В. Харьцуулсан шинжилгээ, түүний үр дүн Энэ бүлэгт Бүлэг IV.Б-д тодорхойлсон үзүүлэлтүүдийг ашиглан бид өөрсдийн дэвшүүлсэн ISRA4ST аргыг Бүлэг IV.А-д сонгосон аргуудтай харьцуулсан үр дүн (3-р хүснэгт)-г танилцуулж байна.

Харьцуулсан үр дүнгээс харахад дэвшүүлж буй ISRA4ST болон OCTAVE (Mellon, 2005) зэрэг арга нь эрсдэлийн үнэлгээг хийх нарийвчилсан зааварчилгаагаар хангадаг ба энэ нь цаг хугацааг хэмнээд зогсохгүй хэрэгжүүлэхэд хялбар болгоно. Харин зөвхөн бидний дэвшүүлж буй аргачлал нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийхийн өмнө хамрах хүрээг урьдчилан тодорхойлохыг шаардахгүй ба энэ боломжоор хангахын тулд хөрөнгийн бүртгэлийг хийх шалгах хуудсаар хангадаг. Шалгуур үзүүлэлт (c)-ийн үр дүнгийн хувьд EBIOS, IT Grundschutz, MAGERIT аргууд нь мэргэжлийн хүн болон тусгайлсан программаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлдог бол бидний дэвшүүлж буй арга нь урьдчилан бэлдсэн шалгах хуудсаар хангаж эрсдэлийг хурдан шуурхай үнэлэх боломжийг бий болгоно. Мөн түүнчлэн дэвшүүлж буй ISRA4ST аргачлал нь урьдчилан бэлдсэн шалгах хуудасны дагуу эрсдэлийн үнэлгээг хийх тул цаг хугацааны хувьд хурдан шуурхай эрсдэлийг олж илрүүлэх боломжийг бүрдүүлсэн давуу талтай. Шалгуур үзүүлэлт (e)-ийн харьцуулалтаас харахад EBIOS, MAGERIT аргууд нь өөрсдийн тусгай зориулалтын программ хангамжаар арга зүйгээ гаргадаг бол ISRA4ST аргын хувьд урьдчилан бэлдсэн шалгах хууднуудын дагуу мэргэжлийн бус

хүн ч тодорхойлоод явах боломжийг бүрдүүлсэн байгаа нь давуу юм. Цаашлаад OCTAVE, ISRA4ST аргууд нь эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичгээр хангасан байгаа нь тухайн байгууллага эрсдэлийн үнэлгээг өөрсдөө байгууллагын хэмжээнд гүйцэтгэх боломжоор хангаж байна. Харин EBIOS, IT Grundschutz, MAGERIT аргууд нь томоохон хэмжээний байгууллагад үнэлгээ хийхэд зориулагдсан бөгөөд өөрсдийн гэсэн тусгай программ хангамжийн тусламжтайгаар их хэмжээний мэдээлэл цуглуулан тухайн мэдээлэл дээрээ дүн шинжилгээ хийхдээ тоон болон чанарын аргуудыг хослуулан хийдэг бол бидний дэвшүүлсэн арга нь жижиг хэмжээний салбар байгууллагад шинжилгээ хийхэд цуглуулах мэдээлэл өгөгдөл бага учраас чанарын аргаар үнэлгээ хийх нь илүү тохиромжтой юм. Бусад дурдагдсан аргуудын хувьд заавал мэргэжлийн баг болон шинжээч нь удирдлагуудтай хамтран эрсдэлийн үнэлгээг боловсруулдаг бол. Бидний дэвшүүлж буй ISRA4ST аргын хувьд жижиг хэмжээний байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын тусгайлсан мэргэжилтнийг бэлтгэх нөөц боломж бололцоогүй учраас дотоод бүрэлдэхүүнээсээ томилон эрсдэлийн үнэлгээ хийлгэх нь хөрөнгө мөнгө хийгээд цаг хугацааг хэмнэдгээрээ давуу болж байгаа юм. Бидний дэвшүүлсэн арга нь харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг жижиг салбар нэгж байгууллагад тусгайлан зориулж бэлтгэсэн шалгах хуудсаар үнэлгээ хийнэ гэдгээрээ бусад аргуудаасаа онцгой шинж чанартай юм. Томоохон хэмжээний байгууллага болон өөрсдийн бие даасан компаниудын хувьд бодлогын дүрэм журмыг дотооддоо боловсруулж түүнийхээ хэрэгжилтийг хангаж ажиллах боломжтой байдаг бол жижиг салбар нэгж байгууллагын хувьд өөрсдөө дүрэм журам гаргах боломжгүй дээрээс нэгдсэн тушаал шийдвэр мөрддөг учраас байгууллагын үйл ажиллагааг бизнес төвтэй эрсдэлээс илүүтэй технологи төвтэй эрсдэлийг авч үздэгээрээ салбар нэгж байгууллагын хувьд практик холбогдолтой юм.

Ингээд ерөөнхийлөн дүгнэвэл бидний дэвшүүлж буй аргачлал нь харилцаа, холбооны салбарт үйл ажиллагаагаа явуулдаг, санхүү болон мэдээллийн аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцөөр дутмаг жижиг хэмжээний салбар байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг өөрсдийн дотоод нөөц бололцоондоо түшиглэн хийж хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой аргачлал юм.

V. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаараа бид мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх ISRA4ST аргачлалыг дэвшүүлэв. Харьцуулсан шинжилгээний үр дүн дээр уг аргачлал нь санхүү болон мэдээллийн аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцөөр дутмаг жижиг хэмжээний салбар байгууллагууд нь энэхүү аргачлалыг хэрэгжүүлэн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг өөрсдийн дотоод нөөц бололцоондоо түшиглэн хийх боломжтойг харуулж байна. Эрсдэлийн дотоод үнэлгээний үр дүнд үндэслэн тухайн байгууллага эрсдэлийг бууруулах, хадгалах, зайлсхийх, хуваалцахад чиглэсэн эрсдэлийг залруулах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх замаар учирч болох эрсдэлийг зөв зохистойгоор удирдах нөхцөл бүрдэнэ. Энэхүү дэвшүүлж буй аргачлалаа бодит практик хэрэгжүүлэн туршиж, цаашлаад энэхүү аргачлал, түүнийг дагалдах баримт бичигт үндэслэсэн эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл хөгжүүлэх нь бидний цаашид хийх ажил юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

”NIST SP - 800-30rev1,” 2012. (2025, 11 26). Retrieved from NIST: http://www.nist.gov/customcf/get pdf.cfm?pub id=91209

2010, A. E. (2014). Expression of Needs and Identification of Security Objectives. France.

3.0., M. o.–V. (2014). Ministry of Finance and Public Administration-Technical Secretariat, Information, Documentation and Publications Unit Publications Center. Methodology for Information Systems Risk Analysis and Management.

A. Shameli-Sendi, R. A.-B. (2016). “Taxonomy of information security risk assessment (ISRA)”, Computers & Security. In R. A.-B. A. Shameli-Sendi.

Application of the Elementary Threats from the IT-Grundschutz Catalogues for Performing Risk Analyses. Bonn: Ferderal Office for Information Security. (2011). Ferderal Office for Information Security B. Supplement to BSIStandard, 100-3.

den Braber, I. H. (2007). Model-based security analysis in seven stepsa guided tour to the CORAS method. BT Technology Journal, vol. 25, no. 1, 101-117.

Duncan, A. A. (2020). Cybersecurity Risk Management in Small and Medium-Sized Enterprises: A Systematic Review of Recent Evidence.

ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОЛОМЖ ШИЙДЭЛ

Г.Сэргэлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн 8023 дугаар дамжааны магистрант, хошууч.

G.Sergelen, aster's student of the 8023th course of Court order enforceent and Strategy, captain

Товч агуулга: Цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд мөрдөгдөх гол эрх зүйн акт бол 1999 онд батлагдсан “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль юм.

Энэхүү хууль нь батлагдсан цагаасаа өнөөг хүртэл тодорхой цаг хугацаанд нэмэлт өөрчлөлт орж ирсэн боловч нэмэлт өөрчлөлт оруулахдаа дорвитой шинэчлэл хийгдээгүй өдийг хүрсэн. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд олон эрх зүйн актууд өөрчлөгдөн найруулагдаж, шинэчлэгдэж, зарим нь хүчингүй болж ирсэн боловч уг хуульд дорвитой өөрчлөлт ороогүй.

Хүний нийгэм хөгжихийн хэрээр эрх зүйн хэм хэмжээ дагаж өөрчлөгдөж байдаг жамтай. Иймээс уг хуулийг нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу шинэчлэн найруулж, өөрчлөх цаг нь болсон.

Цагдан хорих ажиллагааны аюулгүй байдлын тогтолцоог субъектийн шинжээр нь цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, алба хаагчдын аюулгүй байдал, цагдан хоригдогчдын аюулгүй байдал, цагдан хорих шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд хяналт тавих болон бусад хэлбэрээр оролцогч байгууллага, албан тушаалтны аюулгүй байдал, цагдан хорих байранд байрлаж буй бусад иргэд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал гэж, аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг эх сурвалжаар нь гадаад, дотоод хүчин зүйлс, цаг хугацаагаар нь шууд болон тодорхой хугацаанд нөлөөлөл үзүүлэх, аюул заналын магадлалаар нь бодит болон болзошгүй хэмээн ангилан судлах нь арга зүйн чухал ач холбогдолтой гэж үзсэн.

Abstract: The main legal act applicable to the enforcement of detention orders is the Law on the Arrest and Enforcement of Detention Orders for Suspects and Accused Persons, adopted in 1999.

This law has been amended from time to time since its adoption, but no significant changes have been made to the amendments. Within the framework of legal reform, many legal acts have been amended, revised, and some have been repealed, but the law has not undergone any significant changes.

As human society develops, legal norms naturally change. Therefore, it is time to revise and change the law according to the needs of society.

The security system of detention operations is divided into the following categories: the security of the organization and officers implementing the detention decision enforcement, the security of detainees, the security of organizations and officials participating in the supervision and other forms of detention decision enforcement, and the security of other citizens and clients staying in the detention facility, and the factors affecting security by source. It is considered methodologically important to study internal factors, their direct and temporary impact, and their probability of threat, categorizing them as real or potential.

Түлхүүр үг: Цагдан хорих байр-хоригдогч, хоригдол-эрсдэл-аюулгүй байдал, харуул хамгаалалт

Keywords: Detention facility-detainee, prisoner-risk-security, guarding

УДИРТГАЛ

Нийгмийн хүчин зүйл буюу цагдан хорих шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын эрх зүйн орчин, улс орны эрүүгийн буюу гэмт хэргийн нөхцөл байдал, хүн амын нийгмийн сэтгэл зүй, ухамсар, боловсролын түвшин, түүнчлэн нийгмийн амьдралд болж буй бусад үйлд явдлаас, тухайлбал, хэвлэл мэдээлэл, жагсаал цуглаан, өлсгөлөн суулт, олон нийтийг хамарсан бусад арга хэмжээнээс төрсөн, хүлээн авсан хууль эрх зүйн шинэтгэл, шүүх, хууль сахиулах байгууллагын ажлын арга барил, алба хаагчдын мэдлэг ур чадварын талаар хоригдогчид, тэдний гэр бүлийн болон хамаарал бүхий бусад хүмүүс ташаа ойлголт, итгэл үнэмшил нь цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлал байдаг.

Мөн хоригдогчдын гадна хань харилцаанаас ирэх нөлөөлөл буюу улс төр, бизнес, гэмт бүлэглэлийн цагдан хорих байгууллагын хэвийн үйл

ажиллагааг алдагдуулах, эрмэлзэл байдаг бөгөөд энэ нь цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, хоригдогчид болон алба хаагчдад дарамт шахалт үзүүлэх байдлаар илэрдэг.

Түүнчлэн байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлсийн үр дүнд бий болсон нөхцөл байдал болон тухайн цагдан хорих төв, цагдан хорих байрны байршил, орон нутгийн онцлог, хориотой бүсийг стандартын дагуу байгуулсан эсэх асуудал ба дийлэнх цагдан хорих байрууд суурин газрын төвд байрладаг тул хориотой бүсийг тогтоох боломж хязгаарлагдмал байдаг, мөн хөрш залгаа бусад барилга байгууламж маш ойрхон зэрэг нь тухайн цагдан хорих байрны аюулгүй байдлыг хүндрүүлдэг практик бий.

ҮНДСЭН ХЭСЭГ

Цагдан хорих байрны аюулгүй байдалд нөлөөлөл үзүүлдэг дотоод хүчин зүйлс нь тухайн хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах ажилтны ур чадвар, түүнчлэн тухайн ажлын үр дүнг тооцох, ач холбогдлыг дээшлүүлэх талаар хэрхэн ажиллаж байгаа болон бусад асуудлууд тухайлбал, цагдан хорих байрны хоригдогчдын дотоод уур амьсгал буюу гэмт санаа бодол, сэдэлт, хорих байранд гэмт хэрэг үйлдэгдэх боломж нөхцөл, учирч болох хор уршиг, түүний хэр хэмжээгээр тухайн цагдан хорих байрны аюулгүй байдлын ерөнхий нөхцөл байдал тодорхойлогдоно.

Цагдан хорих байрны аюулгүй байдалд нөлөөлөх дотоод хүчин зүйл нь:

-Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх байгууллагын зохион байгуулалтын бүтэц, удирдлага, дотоод хяналтын механизм, алба хаагчдын орон тоо, байгууллагын төсөв санхүүгийн чадамж,

-Цагдан хорих төв, цагдан хорих байрны барилга байгууламжийн архитектур, төлөв байдал,

-Цагдан хоригдогчдын тоо, тэдний үйлдсэн /сэрдэгдэж буй/ гэмт хэргийн шинж байдал,

-Цагдан хорих байранд хоригдогчийн зүгээс үйлдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоо, шинж чанар,

-Цагдан хорих төв, цагдан хорих байрны харуул хамгаалалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, тэдгээрийн хүрэлцээ, хангамж, эдэлгээ,

-Алба хаагчдын чадвар, чадамж, шилжилт хөдөлгөөн, дотоод уур амьсгал, ахуй хангамж, эрүүл мэнд, гэр бүл, нийгмийн асуудал

-Алба хаагчдын албаны бэлэн байдлын түвшин, түүнийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан, төлөвлөсөн ажил, арга хэмжээ, харуул хамгаалалтыг зохион байгуулах хэлбэр, ээлжийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтийн чанар, мэргэжлийн ур чадвар, алба хаагчдын ажил албандаа үнэнч байдал зэрэг нь аюулгүй байдлыг хангах чухал үзүүлэлт болно.

Цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоол болох бөгөөд хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй байхад баривчилж болохгүй гэсэн хүний халдашгүй эрхийн талаар баталгаажуулсан байна.

Хоригдсон этгээдийн хэргийг шалгаж байгаа буюу хянан шийдвэрлэх гэж байгаа мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч түүнтэй уулзахаар хорих байранд үнэмлэхээ үзүүлж нэвтрэх эрхтэй гэж өөрчлөлт оруулсан боловч тэдний аюулгүй байдлыг хангах талаар тусгагдаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Цагдан хорих байр руу ажил үүргийн дагуу шүүх, прокурор, цагдаа, хүний эрхийн байгууллагуудын албан тушаалтан, ажилтан, төр засгийн өндөр дээд албан тушаалтан, гадаад улсын дипломат консул зэрэг олон төрөл, мэргэжлийн хүмүүс нэвтрэх бөгөөд тэдгээрийн хувийн аюулгүй байдлыг хангах асуудал нь хуульд тусгаагүй боловч хорих байгууллага өөрийн хамгаалалтын бүсэд нэвтэрсэн гэдэг утгаараа аюулгүй байдлыг хангах үүргийг гүйцэтгэдэг.

Хэдийгээр цагдан хоригдсон этгээд захидал харилцаа хэрэглэхээс бус интернэт /facebook, youtube, twiter/, гар утас зэрэг мэдээлэл солилцох, хүлээн авах маш олон төрлийн арга хэрэгслүүд байх боловч ШШГБ-гын онцлог чиг үүрэгтэй холбоотойгоор аюулгүй байдлыг хангах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлын хувьд хорих анги,

цагдан хорих байранд интернэт болон гар утас ашиглах эрхийг нь холбогдох журмаар хязгаарладаг.

Цаашид энэ гар утас, цахим технологитой холбоотой асуудлыг журмаар бус хуулиар зохицуулан, эрх зүйн зөрчилд тооцох эсэх, хэрэв тооцсон бол ямар тохиолдолд зөрчил гэж авч үзэх талаарх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай юм.

Улмаар гар утас, интернэт ашиглах гэх мэт асуудал нь цагдан хоригдсон этгээдийн аюулгүй байдлыг ханган хуульд заасан үндэслэлээр хязгаарлуулсан хүний эрх, эрх чөлөөнд хамаарах эсэхэд анхаарал хандуулан эрх зүйн зохицуулалтыг тал бүрээс нь харж шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

Хоригдох этгээдийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэрт заасан хугацаагаар хорино заасан ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хорьж мөрдөх хугацаа 18 сар, тодорхой төрлийн гэмт хэрэгт нэмж 6 сараар сунгаж болохоор заасан нь цагдан хорих байранд хоригдсон этгээд олон сараар хоригдох хугацаа багассан нь цагдан хорих байрны аюулгүй байдалд ихээхэн ач холбогдолтой болсон юм. Учир нь олон сараар хорих нь тухайн этгээдийг сэтгэл санааны хувьд болон цагдан хоригдож байгаа этгээдүүдийн зүгээс өөрсдийн хань харилцаа, ойр дотнын хүмүүстэй холбоо тогтоох, үйлдсэн хэргийн нөхцөл байдлыг бүдгэрүүлэх, улмаар эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, хоригдож байгаа орчин нөхцөлөө өөрчлөх зорилгоор цагдан хорих байрны ажилтан, алба хаагчдыг эрхшээлдээ оруулахыг эрмэлзэх, улмаар тэдгээрийг болон хамт хоригдож буй этгээдүүдийг эд зүйл, шан харамжаар татахыг оролдох, айлган сүрдүүлэх, заналхийлэх, дарамтлах зэрэг үйл ажиллагаа явуулж байдаг.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухайн хуулийн 3 дугаар бүлэгт хоригдсон этгээдийн эрх, үүрэг түүнийг хэрэгжүүлэхийг заасан бөгөөд хоригдсон этгээд нь хорих байранд өөрийн өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзаж болно. Хоригдсон этгээд өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах нөхцөлөөр хангагдсан байна гэж заасан бөгөөд хүний эрхийн байгууллагаас хаалтын наана цаанаас өмгөөлөгчтэйгөө уулзах нь хүний эрхийг зөрчиж, өмгөөлүүлэх эрхээр хязгаарлаж байна гэж зөвлөмж өгсний дагуу хаалтыг авсан.

Дээрх нөхцөл байдлаас үүсэж өмгөөлөгч нар хоригдсон этгээдийг өмгөөлөх гэхээсээ илүү ар гэрээс нь хориотой эд зүйл /захиа, тамхи, хоол, цай гэх мэт/ нэвтрүүлэх зөрчил арилахгүй байсаар байна. Мөн хоригдсон этгээдийн зүгээс албаны захиргаагаар дамжуулахгүй өмгөөлөгчөөрөө дамжуулж хань хамсаатан болон бусад байгууллага, иргэдэд өргөдөл, гомдол захиа гаргаж байгаа нь хорих байрны аюулгүй байдалд шууд болон шууд бусаар нөлөөлж байна гэж үзэж байна.

Хоригдсон этгээд нь өдөрт 3400 килокалори (ккал)-аас дээш хэмжээний илчлэгтэй хоолоор үнэ төлбөргүй хангагдана гэж заасан байдаг бөгөөд Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/214 тоот тушаалаар “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлын хоногийн хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм” -д 3500 килокалори буюу 100 килокалориор илүү байхаар тогтоосон байна. Энэ нь цагдан хоригдож байгаа хөдөлгөөн бага байгаа хүнд өгч байгаа хоолны нормын хувьд их ба өглөө цай, талх, өдөр, орой 1, 2 дугаар хоолоор хангадаг бөгөөд давхар эргэлт уулзалтаар хоол, хүнсний зүйлийг авдаг. Мөн албаны зүгээс захиалгат хоолоор үйлчилдэг.

Цаашид ар гэрээс ирэх уулзалтын үеэр хоригдсон этгээдэд ирж буй хоол хүнсийг нэвтрүүлэхгүй байх нь чухал юм. Орчин үед хүнсний аюулгүй байдал эрчимтэй яригдах болсон цагт тухайн эргэлтээр ирсэн зүйлийн чанарт авчирсан хүн нь хариуцна гэж байгаа боловч хоолны чанарыг мэдэх боломжгүй. Ирж байгаа хоол, цайг алба хаагч нүдээр үзэж, үнэрлэж үзлэг хийж байгаа боловч хамгаалалтын ажилтан амсаж үзэх боломж байхгүй. Учир нь алба хаагчийн аюулгүй байдал нэгдүгээрт тавигдаж байгаа учраас хордлого авах, цаашлаад амь насанд нь учирч болох эрсдэлтэй.

Иймд уулзалтаар ирж байгаа хүмүүс цагдан хорих төв болон цагдан хорих байрны захиргааны дэлгүүрээс нэгдсэн журмаар шаардлагатай зүйлсээ худалдаж авах нь олон улсын стандарт болон хүнсний аюулгүй байдал хангагдаж алба хаагч болон хоригдсон этгээдийн амь насанд ч аюул учруулахаас урьдчилан сэргийлсэн том алхам болно.

Ингэснээр цагдан хорих байранд хориотой эд зүйл нэвтрэхээс урьдчилан сэргийлж гэмт хэрэг, зөрчил гарах, цаашлаад байгууллагын аюулгүй байдалд ихээхэн нөлөөтэй гэж судлаач бидний зүгээс үзэж байна.

Цагдан хоригдсон этгээд зөрчил гаргасан тохиолдолд өсвөр насны хүнийг 7 хоног, сэжигтэн, яллагдагчийг 15 хоног сахилгын өрөөнд хорихоор заасан бөгөөд өсвөр насны хүнийг 30 минут, сэжигтэн яллагдагчийг 15 минут салхинд гаргана гэж заасан байдаг. Сэжигтэн, яллагдагчийг 7 хоногт 2 удаа 30 минутаас багагүй хугацаагаар гаргана гэж заасантай харьцуулахад сахилгын өрөөнд байгаа этгээд салхинд өдөр болгон гарч байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Харин сахилгын өрөөнд байгаа хоригдсон этгээдэд сахилгын шийтгэл эдэлж дуустал захидал, цахилгаанаар харилцах, мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчөөс бусад хүмүүстэй уулзах, хүнсний болон нэн хэрэгцээтэй зүйлийг худалдан авах, эргэлт авах, ном, сонин, сэтгүүл унших эрхийг нь хязгаарлана гэж заасныг хүлээн зөвшөөрч байгаа боловч ном уншихыг зөвшөөрөх хэрэгтэй гэж судлаачдын зүгээс үзэж байна. Гэхдээ уран зохиолын ном биш хууль, эрх зүйн чиглэлээр /зөрчлийн хор уршиг, нийгэм, сэтгэл зүйн /уншуулбал илүү нийгэмших, сэтгэл санаа нь тайвшрах боломжтой гэж үзэж байна.

Хоригдогчдын эрхийг хангах чиглэлээр оруулсан нэг томоохон заалт бол өлсгөлөн зарлах асуудал байдаг. Хуульд зааснаар өлсгөлөн зарласан этгээдийн тавьсан шаардлага үндэслэлтэй бол хорих байрны захиргаа шаардлагыг биелүүлэх боломжтой бүх арга хэмжээг авах үүрэгтэй, өлсгөлөн зарласан этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан тохиолдолд эрүүл мэндийг сайжруулах албадлагын арга хэмжээ авч болно гэж зааж өгсөн нь хорих байгууллага хоригдогчийн эрүүл мэнд болон аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн болох харагдаж байна.

Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зааврын 1.2-т Хүний биеийн физиологийн хэрэгцээг нөхөхгүй хүнсний бүтээгдэхүүн, хоол тэжээлийг удаан хугацаагаар хэрэглэх өвчин эмгэгийн улмаас хоолны шингэц муудах болон хоол тэжээлийг зориудаар хязгаарлах үед үүсэх эмгэг байдлыг өлсгөлөн гэж тодорхойлсон. Зорилт хэсэгт хорих анги, цагдан хорих байр, баривчлах байранд өлсгөлөн зарласан гэж заасан боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүргийг тусгаагүй нь учир дутагдалтай. Зөвхөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээс гадна цагдан хорих байранд эмчийн хяналтад өлсгөлөн зарлах тохиолдол гарч байсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хоригдогчдын эрүүл мэндийн асуудал ямагт анхаарлын төвд байсаар ирсэн бөгөөд түүний дотор Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хоригдогчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, эрүүл мэндийн үйлчилгээ, үзлэг шинжилгээг тогтмолжуулах, эрүүл мэндийг сахин хамгаалах ажил нь тус байгууллагын ажлын чухал хэсэг байдаг. Харин сэжигтэн, яллагдагчийн эрүүл мэндийг сахин хамгаалах эрх зүйн үндэс нь доорх байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

-Үндсэн хуульд зааснаар монгол улсын иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдахаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй бөгөөд иргэдэд эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй тусалж, үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно гэж заасны дагуу цагдан хорих байранд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавин ажиллаж байна.

-“Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийн (25-р зүйл.) Эмнэлэг эрүүл ахуйн хангамж гэсэн хэсэгт: хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хангахуйц ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах үүрэгтэй... мөн хуулийн (25.2-т.) Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байгууллагад эмнэлгийн ажилтан ирж үйлчлэх журмыг эрүүл мэнд, нийгмийн хамгаллын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэж заасныг баримтлан ажиллаж байгаа.

Харин НҮБ-ын “Хоригдогчидтой харьцах наад захын жишиг дүрмүүд” -ийн 22.2-т мэргэжлийн эмчилгээ шаардлагатай өвчтэй хоригдлыг тусгай, эсхүл ердийн эмнэлэгт хэвтүүлбэл зохино. Шоронгийн эмнэлгүүд өвчтөнийг зохих ёсоор сувилах эмчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмтэй байхаас гадна хангалттай мэргэшсэн эмнэлгийн ажилтнуудтай байвал зохино. Түүнчлэн 91 дүгээр зүйлд мөрдөн байцаалтад байгаа хоригдогч хэрэв төлбөрийн чадвартай бол шоронд байх хугацаандаа хувийн их эмч, шүдний эмчийн үйлчилгээгээр үйлчлүүлэхийг зөвшөөрч болно... хэмээн сэжигтэн яллагдагч, шүүгдэгчийн эрүүл мэндийн байдалд цагдан хорих байрны захиргааны зүгээс хэрхэн анхаарал хандуулж ажиллах талаар тодорхой тусгажээ. Эдгээр болон бусад эрх зүйн актыг удирдлага

болгон цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас эмнэлгийн алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалт, бусад улс оронд туршлага судлуулах чиглэлээр жил бүр тодорхой ажлуудыг тууштай хэрэгжүүлдэг боловч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлын эрүүл мэндийн асуудал одоог хүртэл анхаарал татсан хэвээр байна.

Хоригдогчдын эрүүл мэндийн хүндрэлтэй байдлын шалтгаан нөхцөл нь ихэвчлэн өөрсдийн биеийн онцлог, архаг хууч өвчлөлөөс хамааралтай байдаг боловч анхаарлын төвөөс гадуур орхигдуулж болохгүй асуудал юм.

Мөн төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо муу байдгаас болж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сэжигтэн яллагдагчид хүргэх асуудал удаашрах, цаг алдах, тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал: Цагдан хорих байранд хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрүүл мэндийн асуудал нь нэг талаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллын анхаарах ёстой зүйл мэт боловч хорих тогтоол, шийдвэр гаргасан мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн энэ талаар авах арга хэмжээ, гүйцэтгэх үүрэг тодорхой бус байдлаас болж ялангуяа нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн үйлчилгээ авах шаардлагатай хоригдогчдыг цаг алдалгүй шуурхай эмнэлгийн үйлчилгээнд хамруулах ажилд хүндрэл учирдаг байна.

Хоригдол этгээдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн ажилтан ирж үйлчлэх журмыг Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 59, А/67 тоот тушаалаар батлагдан хэрэгжиж байгаа нь хоригдогчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байна.

“Хорих байрны дотоод журам” -д “Хоригдох этгээдийн хувцсыг хураан авч, нэг загварын хувцас, улавч олгож, суллагдах болон хорих анги руу шилжих үед нь буцаан авч, түүний хувцсыг эргүүлэн олгоно” гэсэн зохицуулалттай.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хоригдлын жам ёсны эрхийг хангах, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах

зорилгоор “Хорих байгууллагын харуул хамгаалалтын стандарт”-ын дагуу хорих анги, цагдан хорих байранд засвар тохижилт хийн, хорих өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт, чийгшил, нэг хоригдолд ногдох талбайг хууль журамд нийцүүлсэн.

Цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэдэг хамгаалалтын алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдол бүхий заалт оруулж өгсөн нь хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “хорих байрны ажилтан дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно, хоригдсон этгээдээс хорих байрны ажилтан болон хоригдсон этгээд, бусад хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулахаар довтолсон, хорих байрны ажилтны зэвсгийг булаахаар довтолсон, барьцаалагдсан хүн, барилга байгууламж, тээврийн хэрэгслийг чөлөөлөх, хорих байрны барилга байгууламж, тээврийн хэрэгслийг эзлэхээр бүлэглэн довтолсон, хорих байгууллагын ажилтан болон бусдын эсрэг хүч хэрэглэн довтолж, зэвсэг хэрэглэн эсэргүүцэж байгаа этгээдийг баривчлахад, хорих байрнаас оргосон этгээдийг баривчлах болон онц хүнд, хүнд гэмт хэрэгт мөрдөгдөж байгаа этгээдийг хуяглан хүргэх үед оргохоор завдсан, хорих байрны ажилтнаас зэвсгээ хураалгахыг шаардсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, хоригдсон этгээдийг хүч хэрэглэн суллахыг оролдсон” гэх тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болох талаар зааж өгсөн нь цагдан хорих байрны хамгаалалтын алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн чухал заалт болсон гэж бидний зүгээс дүгнэж байна.

Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг зөвхөн прокурорын байгууллага гүйцэтгэхээр зааж өгсөн нь хоригдогчийн аюулгүй байдлыг хангахад чухал шийдвэр болсон юм.

Мөн хүний эрхийн байгууллага хүний эрх, эрх чөлөө хэрхэн хангагдаж эрүүдэн шүүлт явагдаж байгаа эсэхэд, мэргэжлийн хяналтын байгууллага хоолны илчлэг, эрүүл ахуй, орчин нөхцөл зэрэгт хяналт тавьж хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд анхааран ажилладаг юм.

2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан А/192, А/81 дугаар тушаалаар “Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам”-ыг баталж хэрэгжүүлж ирснээр алба хаагч,

хоригдогчийн заагийг гаргаж өгснөөр алба хаагчдын аюулгүй байдлыг хангаж өгсөн.

Мөн аюулгүйн тойрог тогтоох журмаар шаардлагатай техник хэрэгсэлд хөдөлгөөнийг хориглосон тэмдэглэгээг хэрхэн хийхийг тусгасан ба аюулгүйн тойрог тогтоох журмыг зөрчсөн тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар нэг бүрийн тусгай хэрэгсэл болон сахилгын шийтгэл оногдуулахаар заасан байгаа нь алба хаагчийн аюулгүй байдал, инженер техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан асуудал болсон.

Аюулгүйн тойрог тогтоох журмыг цагдан хорих байрууд өөрийн онцлогт тохируулан байгуулж алба хаагч, цагдан хорих байр, инженерийн бүрэн бүтэн байдал, бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах, цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагааг хангуулах үндсэн зорилготойгоор тогтоож өгсөн.

ДҮГНЭЛТ

Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Хорих байгууллагын үйл ажиллагааг зохицуулж ирсэн үе үеийн хууль тогтоомжид тусгаж иржээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчлэл явагдаж буй өнөө үед цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн шинэчлэл зогсонги байдалд байна гэж үзлээ.

Монгол Улсад шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх явдлыг багасгах талаар эрх зүйн болоод зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж буй хэдий боловч цагдан хоригдож буй этгээдүүдийн тоо төдийлөн буурахгүй байна.

Цагдан хорих ажиллагаа нь хорих ял эдлүүлэх ажиллагаанаас ялгагдах үндсэн гол ялгаа нь хоригдогч-хоригдлын эрх зүйн байдал буюу тухайн ажиллагааны нөхцөл, журамтай холбоотой байна.

САНАЛ

Судалгааны явцад гаргасан дүгнэлтдээ үндэслэн Цагдан хорих байрны харуул хамгаалалтын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээрх дараах саналыг гаргаж байна.Үүнд:

1.Эрүүгийн хэргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийг шинэчлэн хүрээнд цагдан хорих ажиллагааны бүлгийг тус хуульд багтаан шинээр тусгах;

2.Цагдан хорих байр бүрийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг жил бүр хийдэг удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнд шилжих;

3.Хорих байгууллагын алба хаагчийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан аюулгүй

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Олон улсын гэрээ, конвенц, дүрэм

1. “Аливаа хэлбэрээр хоригдсон болон саатуулагдсан бүх хүнийг хамгаалах зарчмуудын цогц” 1988 он.

Хоёр. Монгол Улсын хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.

2. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. 1999 он.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он.

5. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль. 2002 он.

6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.

7. Эрүүгийн хууль 2002 он.

8. Эрүүгийн хууль 2017 он.

9. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 7-р сарын 25-ны өдрийн А/197 дугаар баталсан “Хорих ангийн Харуул хамгаалалтын журам”.

10. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/214 тоот тушаалаар “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлын хоногийн хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм”.

ХОРИГДЛЫГ СУЛЛАГДАХЫН ӨМНӨХ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

THE IMPORTANCE OF SOCIALIZATION BEFORE RELEASE

Б.Базарсад

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн магистрант, ахмад

Captain , Graduate Student of the School of Court Decision Execution, University of Internal Affairs, Training and Research Group 403.

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Хорих ял эдэлж байгаа ялтанг хоригдол гэнэ” хэмээн заасан байдаг. Хорих ял эдэлж буй хоригдол нь тодорхой хугацаанд нийгмээс тусгаарлагддаг ба хорих ялаа эдлээд суллагдах үед нийгмийн харилцаанд оролцохдоо их бага хэмжээгээр ямар нэгэн аливаа асуудалтай тулгарч байдаг. Тэрхүү нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг даван туулах, ажил хөдөлмөр эрхэлж амьдрах цаашлаад гэр бүлээ тэжээн тэтгэх, дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх үүднээс тухайн хоригдлыг суллагдах хугацаа дуусахаас тодорхой хугацааны өмнө нийгмийн амьдралд бэлтгэх зорилгоор суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг тодорхой нарийвчлалтайгаар үр дүнтэй зохион явуулах нь чухал билээ.

Abstract: The Law on Execution of Court Decisions states that "Prisoner is a convict who is serving a prison sentence. A prisoner serving a prison sentence is isolated from society for a certain period of time, and when he is released after serving his prison sentence, he faces more or less problems in participating in social relations. In order to overcome the difficulties faced in participating in social relations, to continue to work and live, to support the family, and to prevent recidivism, to organize pre-release socialization work with a certain precision in order to prepare the prisoner for a certain period of time before the end of the release period. is important.

Түлхүүр үгс: Нийгэмшүүлэх ажил, суллагдах хугацаа, нийгмийн амьдрал.

Keywords: Social work, release period, social life.

ОРШИЛ

Монгол улсын үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн ба бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг” зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх хэмээн хуульчилсан байдаг. Хүн байгаа газарт нийгэм оршин тогтнож байдаг. Нийгмийг бүтээгч хүн нь ямар нэгэн байдлаар гэр бүлд харьяалагдаж, гишүүн нь болж амьдардаг.

Энэ нь чухамдаа Л.Берталанфийн “системийн онол” үзэл баримтлалаар маш тодорхой тайлбарлагдана. Нөгөө талаас хорих анги бол нэг төрлийн нийгэм, нийгмийн нэг хэлбэр бөгөөд хоригдлын ял эдэлж буй орчин нөхцөл, тэнд амьдарч буй бусад хоригдлууд, алба хаагчид, хамаарал бүхий этгээд ч тэрхүү нийгэмд харьяалагдаж, тэрхүү нийгэм гэх “систем”-ийн нэг хэсэгт тооцогдоно. Өрөөсгөлөөр ойлгоход бас нэгэн гэр бүл ч гэж нэрлэгдэх боломжтой.

Тиймээс л хоригдлыг суллагдах хугацаа дуусах үед нь нийгэмшүүлэх ажлыг сайтар ойлгож ухаарах нь маш чухал. Хоригдолд мэргэжил, боловсрол эзэмшүүлж, эерэг зан үйл төлөвшүүлэх системчилсэн сургалтад хамруулан, гэмт санаа бодлоос нь татгалзуулах төрөл бүрийн нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь нийгэмшүүлэх ажлын салшгүй чухал ойлголтууд мөн юм. Хорих ял эдэлж байх бүхий л хугацаанд дээрх сургалт, хүмүүжлийн ажлуудыг зохион байгуулж байдаг. Тиймээс суллагдах хугацаа дөхсөн хоригдлыг арай өөр аргаар нийгмийн амьдралд гарахад нь хөл алдахгүй байдлаар ажил хийх боломжоор хангах, ажил хөдөлмөр хийх чадвартай болгох, хамгийн наад захын ухаалаг гар утас барих, цахим төлбөр тооцоолууруудад чадавхжуулах наад захын шаардлага тулгарч байгаа юм.

СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Хоригдлыг суллагдах хугацаа дуусах үед нь тодорхой төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулснаар тэднийг нийгмийн амьдралд дахин гэмт хэрэгт холбогдохгүй амьдрахад нь туслах, өөрийн гэсэн ур чадвартай, мэргэжилтэй болж ажил хөдөлмөр эрхлэх цаашлаад гэр бүлээ тэжээн тэтгэх, нийгмийн хөгжил, цахим хөгжилд хөл алдахгүй зэрэгцэн алхах боломжийг хоригдолд олгох зэрэг гол ач холбогдолд

тулгуурлан нийгэмшүүлэх ажлын бодит үр дүнд хүрээсэй гэсэн итгэл найдварыг тээж энэхүү илтгэлийг бичлээ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Судалгааны ажлын үндсэн агуулгын хүрээнд:

- Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил;
- ШШГТ хууль, Хорих ангийн дотоод журамд зааснаар суллагдаж буй хоригдлын эрх зүйн боломжийн талаар;
- Гэр бүлийн харилцаа хоригдлын нийгэмших үйл явцад хэрхэн нөлөөлдөг талаар;

Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/127 дугаар тушаалаар “Нийгмийн ажлын аргачилсан заавар”-ыг баталсан. Тухайн зааварт “**хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил”** гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйл 219.1 дэх хэсэгт зааснаар хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг (тушаал, 2018) хэлнэ гэж заасан нь хоригдол нийгмийн харилцаанд оролцох, ахин гэмт хэрэгт холбогдохгүй байхад нь чиглэсэн нийгэмшүүлэх ажлыг түлхүү авч хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг нь энэхүү тодорхойлолтоос харагдаж байна.

Тэгвэл хоригдлыг суллагдахын өмнө нийгмийн харилцаанд гарахад нь ямар ажил арга хэмжээг хэрэгжүүлэх тухай тодорхой эрх зүйн болон хууль, журмаар зохицуулж өгсөн оновчтой дүрэм, заавар дутмаг байна.

Нийгмийн ажлын аргачилсан зааврын 3.4 дэх хэсэгт хоригдлыг суллагдахын өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээнд дараах ажил арга хэмжээнүүдийг тусгасан байна. Үүнд:

1. Ялын хугацаа дуусаж, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хоригдлыг

нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх зорилгоор 3 сарын өмнө сургалтад хамруулах гэж зааж өгсөн байна. Тухайн асуудал дээр ихэнх хорих анги тухайн хоригдлыг суллагдахаас 3 сарын өмнө сургалтад хамруулж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байгаа ба тухайн 3 сарын хугацаанд ямар чиглэлээр, юуны тухай сургалтыг зохион байгуулах нь тодорхойгүй байгаа

ба тухайн сургалтын төлөвлөгөө болон орчин зохион байгуулалтын талаар тодорхой тусгаж өгөх унь нэн шаардлагатай болоод байгаа юм (тушаал, 2018).

2. Нийгмийн амьдрал болон цаг үеийн мэдээллийг гарын авлага, тусгайлан бэлтгэгдсэн нэвтрүүлэг бусад хэлбэрээр танилцуулах гэж заасан ба тухайн мэдээ мэдээллийг нийгмийн ажилтан нар цаг тухай бүр нь өгч ажиллаж байгаа ба суллагдах хоригдлыг зарим хорих анги нь 1-3 сарын хугацаатайгаар тусгайлан бэлтгэсэн нийгэмшүүлэх байранд байрлуулан сургалт сурталчилгааг зохион байгуулж байгаа ба тухайн нийгэмшүүлэх байрны талаар хууль эрх зүйн зохицуулалт хараахан гараагүй байгаа нь нийтээр нэвтрүүлэх хүлээн зөвшөөрөхөд хүндрэл тулгарч байгаа юм (тушаал, 2018).

3. Мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан бичиг баримтыг бүрдүүлэх гэж заасан ба тухайн хоригдлын өмнө авсан мэргэжлийн гэрчилгээг бүртгэх эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр үйлдвэрлэлийн дадлага, практик дадлага хийлгэж ажлын байранд гараад гологдохооргүй чадвартай болгоход нь түлхүү анхаарах (тушаал, 2018).

4. Хоригдлын гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх гэж заасан байгаа ба зөвлөгөөг ямар хэлбэрээр явуулах тодорхой төлөвлөгөөний дагуу гэр бүлийн судалгаа хийж уулзах гэх мэт ажлуудыг нарийвчлан хийх нь нэн чухал болоод байна.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан нар нь тухайн нийгмийн ажилтны аргачилсан зааварт заагдсан ажлуудыг хоригдлуудад хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдлэг дутмаг байгаа бөгөөд зөвхөн тухайн зааврыг барин суллагдах хоригдлыг нийгэмшүүлнэ гэдэг нь өөрөө өрөөсгөл ойлголт юм. Тиймээс тухайн хоригдол нь нийгэмд гараад хувь хүн болохын нийгмийн нэг эд эс болохын хувьд төрөл бүрээр нийгмийн амьдралд дасан зохицуулж амьдрах чадварыг нэмэгдүүлэх нь чухал юм.

Зарим хоригдлууд нийгэмд гараад хүлээн авах орчин байхгүй, ар гэр, гэр бүлийн хүмүүсийн тавих хараа хяналтгүй байдлаас үүдэн буцаад гэмт хэрэгт холбогдох байдал багагүй гардаг тиймээс тэдний ар гэр, гэр бүл рүү чиглэж ажиллаж өгөх нь бас нэг анхаарах асуудал юм. Гэр бүлийн талаар 3 дугаар бүлэгт тодорхой тусгаж өглөө.

Нийгмийн хөгжил цаг үеэ дагаад улам боловсронгуй болж, хөгжин дэвшиж байна. Энэ үед 1990 оноос хойш гэмт хэрэг үйлдсэн, хорих ангиар

удаан жил явсан, 20 жилийн ял эдлээд гарч байгаа хоригдлуудын хувьд ухаалаг гар утас ашиглах, цахим орчинд нэвтрэх, интернэтээс мэдээлэл хайх, төлбөр тооцоо хийх, автобус унаанд суух, очих газраа заах, саадгүй хүрэх гээд наад захын бидний амьдралд байдаг энгийн зүйлсийг хийж чадахгүй түүндээ ичиж зовсондоо нийгэмд амьдрах итгэл нь алдуурдаг. Үүнээс шалтгаалан гэмт хэрэг, зөрчилд дахин холбогдох явдалд ч гардаг юм.

ШШГТ хууль, Хорих ангийн дотоод журамд зааснаар суллагдаж буй хоригдлын нийгэмшүүлэх ажил, эрх зүйн боломжийн талаар

Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дараах байдлаар тусгасан. Үүнд:

218 дугаар зүйл. Нийгэмшүүлэх ажил

“Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ (тушаал, 2018).”

“Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана.”

“Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна (тушаал, 2018).”

“Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.”

“Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна. Нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, алба хаагч, бусад байгууллага, албан

тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд туслалцаа авч болно.”

“Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.”

Хуулийн эдгээр зүйл заалтаас харахад хоригдлыг нийгэмшүүлэх ажилд алба хаагч, бусад байгууллага, иргэнийг татан оролцуулж болох тухай заасан боловч нийгэмд гараад дахин гэмт хэрэг үйлдэх, архи согтууруулах ундаа хэрэглэж гудамжинд гарах байдал нь нийгэмшүүлэх ажлын судалгаа шинжилгээг сайтар хийж, ач холбогдлыг нь таниулан ойлгуулах ажил дутмаг байгаагийн нэг илрэл юм. Харин “хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан” хэмээн заасан явдал нь хоригдол ял эдэлж эхлэхээс авхуулаад л түүнийг суллагдан гарахад нь бэлтгэх шаардлагатайг харуулж байна (тушаал, 2018).

Мөн хоригдлыг нийгэмшүүлэх ажлын нэг үндсэн чиглэл нь суллагдах хугацаа дуусаж байгаа хоригдолд архи согтууруулах ундаа, хорт зуршлаас хол байлгах сургалтыг тогтмол зохион байгуулж тэдний сэтгэл зүйн байдалд нөлөөлөх явдал бас шаардлагатай байгаа юм.

Хорих ангийн дотоод журмын 11 дүгээр зүйл Нийгэмшүүлэх ажлын талаар тусгасан ба 11 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт “Хоригдлын дунд явуулах нийгэмшүүлэх ажилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Нийгмийн ажлын аргачилсан заавар”-ыг мөрдөнө” (ШШГЕГ, хорих байрны дотоод журам, 2017) гэж заасан байна. Энэ нь хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь тухайн зааврын хүрээнд явагдана гэсэн үг ба тухайн зааварт заасны дагуу хоригдлыг суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлнэ гэдэг нь өрөөсгөл, дутмаг ойлголт юм.

Тиймээс хоригдлын нийгэмшүүлэх ажил, тур дундаа суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг илүү боловсронгуй болгох нэн шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Гэр бүлийн харилцаа хоригдлын нийгэмших үйл явцад хэрхэн нөлөөлдөг талаар

Гэрлэлт болон үрчлэлтэд суурилсан, хүмүүсийн харилцааг гэр бүл гэнэ. Гэр бүл нь нийгмийн бичил хэлбэр мөн. Гэр бүлийн зохион

байгуулалт буюу гэр бүлийн тогтолцоог чулуун зэвсгийн үеэс үүсэлтэй гэж үздэг бөгөөд үүнээс өмнө гэр бүл болох явдал замбараагүй байснаас цус ойртолт элбэг байжээ.

Эдгээрээс үзэхэд гэр бүл хэмээх ойлголт нь 2-оос дээш хүний бүрэлдэхүүнтэй, хоорондын хамааралт харилцаа бүхий нийгмийн бичил бүлгийн шинжийг агуулсан байна.

Манай улсад гэр бүлийн систем хамгийн сонгодог утгаар хөгжсөн гэж үзэж болно. Учир юу гэвэл Монгол хүн гэр бүлсэг /гэрсэг/ шинж чанартай төдийгүй хамаатан садан, цусан төрлийн харилцаа холбоо болон нэг хонхор, дов жалганы үзэл /ярианы хэллэг/-ийг эрхэмлэдэг. Мөн өргөжсөн гэр бүлийн шинжийг хамгийн сонгодог утгаар нь хөгжүүлсэн. Өөрөөр хэлбэл нэг гэр бүлд эцэг эх, хүүхдүүд, тэдний ач зээ, эсвэл өвөө эмээ нь нэг дор, нэг ам бүл болж амьдрах тохиолдол түгээмэл байдаг. Тиймээс Монгол хүнийг нийгэмшүүлэх, гэмт санаа бодлоос нь татгалзуулахын тулд “гэр бүл” хэмээх тэрхүү “үнэт зүйл”-д нь тулгуурлан, тэдний дэмжлэг туслалцааг авч хамтран ажиллах нь нэн чухал.

Тэгвэл систем гэж юу вэ? Систем гэдэг нь нэгтгэх, нэг дор байрлуулах, хамтад нь авч үзэх, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нэгж хэсгүүдийн нийлбэр цогц гэсэн утга бүхий “systema” гэсэн грек үгнээс гаралтай. Энэ үгийг тайлбар толь бичгүүдэд дараах байдлаар тайлбарласан байдаг. “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой буюу харилцан хамааралтай нэгжүүдийн цуглуулга. Харин дэд систем гэдэг нь ямар нэгэн системийн хэсэг болж буй систем юм” хэмээн тодорхойлсон байдаг “Нэгэн цогц байдлаар ажиллах зүйлс буюу хэсгүүдийн бүлэг” хэмээн тодорхойлжээ. Системүүдийг байгалийн болон хүний гараар бүтээгдсэн (загварчлагдсан) хэмээн хуваан үздэг. Хүний гараар бүтээгдсэн системүүд гол төлөв тодорхой зорилго, багц зорилтуудтай байдаг бол байгалийн системүүд тодорхой зорилгогүй хэрнээ харьцангуй тогтвортой, уян хатан бөгөөд үр ашигтай байдаг. Байгалийн төрөл бүрийн системүүд байдаг.

Систем гэсэн ойлголтыг хамгийн энгийнээр “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой хэсгүүдийн олонлог” хэмээн тодорхойлсон байдаг. Систем бүр бие бийнээсээ хамаарсан, уялдаа холбоотой элементүүдээс (дэд системүүдээс) тогтож, өөрийг нь хүрээлэн буй орчноос өгөгдөл мэдээлэл хүлээн авч, өөрийн төлөв байдлыг илэрхийлдэг. Системийг хүрээлж буй орчныг системийн орчин гэнэ. Аливаа систем нь

орчинтойгоо байнга харилцан үйлчлэлцэж байдаг төдийгүй үйлчлэх орчноосоо хамааран байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Систем нь том системийн бүрэлдэхүүн хэсэг байхаас гадна өөртөө дэд хэсгүүд буюу дэд системүүдийг агуулж болно (Амарбаясгалан, 2006).

Судалгаанаас үзэхэд давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 70% нь ямар нэгэн байдлаар гэр бүлийн харилцаа холбоо сул, гэр бүлийн гишүүдтэйгээ таарамжгүй харилцаатай эсвэл огт гэр бүлийн харилцаагүй байдаг байна. Тэднийг олон удаа, дахин давтан гэмт хэрэг үйлдэх тусам нь гэр бүлийн гишүүд нь харилцаагаа хөндийрүүлж, таарамжгүй харьцаатай болж, улмаар харилцаагаа таслах хүртэл сөрөг үр дагаварт хүрдэг. Гэр бүлийн дэмжлэг туслалцаагүй хоригдол сэтгэл санааны хувьд тогтворгүй болж энэ байдал нь даамжирсаар дахин давтан гэмт хэрэг үйлдэх, ял эдлэх хугацаандаа зөрчилд холбогдох шалтгаан болно.

Харин эсрэгээрээ гэр бүлтэйгээ харилцаа сайтай, тогтмол уулзалт хийж илгээмж авч утсаар харилцдаг хоригдлуудын хувьд ял эдлэх хугацаандаа аль болох ажил хөдөлмөр, сургалт, нийгэмшүүлэх ажилд идэвхтэй оролцон шагналын хоногоор урамшуулагдаж богино хугацаанд гэр бүлдээ очихыг эрмэлзэнэ. Гэр бүл нь амьдралын боломж тааруухан, санхүүгийн дэмжлэг туслалцаа бага байлаа ч өөрөө цалинтай хөдөлмөр эрхэлж ахуйн хэрэгцээний зүйлсээ худалдан авах санхүүгийн эх үүсвэртэй байж “амиа борлуулах”-ыг л хичээдэг.

Улмаар зарим нь цалингаасаа хохирол төлбөрөө бүрэн барагдуулж, улмаар гэр бүлийн гишүүддээ холбогдох журмын хүрээнд мөнгө шилжүүлж амьдрал ахуйд нь дэмжлэг болох ч тохиолдол элбэг байдаг.

Зарим хоригдлуудын хувьд гэр бүлийн гишүүд нь /эцэг, эх, ах, эгч, дүү, төрөл садан/ хорих ял эдэлж байгаа /хамт эсвэл өөр хорих ангид/ тохиолдол бий. Харин тэдгээр хоригдлуудын гэр бүлийн харилцаа нь зарим тохиолдолд тэдний нийгэмшил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагддаг. Тэд буруу, сөрөг зүйл дээр санаа нэгдэж, гэр бүлийн итгэлцэл, харилцаа холбоогоо сөргөөр ашиглан нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй төдийгүй заримдаа тийм бодит кейс ч тохиолддог.

Кейс-1.

Хоригдол Л.М нь 3 удаагийн ял шийтгэлтэй бөгөөд хамгийн сүүлд 2009 онд танхайн гэмт хэрэгт шийтгэгдэн ял эдэлж байгаад 2017 онд тус

ангиас суллагдсан. Тэрээр багаасаа өнчин өссөн, эцэг, эхээ мэдэхгүй бөгөөд асрамжийн газраар хүмүүжиж ирсэн. Удаа дараа танхайн гэмт хэрэгт шийтгэгдэж байсан тул Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдож Хорих 439 дүгээр "Онцгой" дэглэмтэй хорих ангид ял эдэлж байсан. Түүнийг хариуцсан нийгмийн ажилтан түүний амьдарч байсан асрамжийн төвтэй холбогдож, хамаатан садныг нь судлан, олж харилцаа холбоо тогтоосны үндсэн дээр ойрын хамаатныг нь эргэлт уулзалтаар уулзуулж, "гэр бүл зохиож сайхан амьдрах" тухай ярилцсан байна. Улмаар түүнийг багын найзтай нь уулзуулан, зуучилж гэрлэлтийг нь батлуулан "гэр бүл"-тэй болгосон бөгөөд тэрээр хугацааны өмнө суллагдаж одоогоор тогтсон ажилтай, эхнэр 2 хүүхдийн хамт сайн сайхан амьдарч байгаа билээ.

Дээрх тохиолдлоос үзэхэд хоригдлын ухамсарт "гэр бүл" хэмээх үнэ цэнтэй ойлголтыг төлөвшүүлж, хүний ёсонд гэр бүлийн харилцаа хамгийн чухал болохыг ойлгуулан ухамсарлуулж чадвал тэр л жинхэнэ сайн нийгэмшил болдог нь харагдаж байна. Хүн нэгэнт л гэр бүлийн гишүүн болж нийгмийн харилцаанд оролцож амьдрах жамтай "Нийгмийн амьтан" тул гагцхүү тэр л ёсонд нь тулгуурлан нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах нь хамгийн үр дүнтэй арга юм.

ДҮГНЭЛТ

Хорих ангид хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг нийгэм, сэтгэл зүйн алба тодорхой хууль, журам, зааврын хүрээнд хэрэгжүүлдэг. Харин тухайн эрх зүйн зохицуулалт нь нийгмийн хөгжил, нийгмийн амьдралтай уялдан боловсронгуй илүү нарийн байх шаардлага өнөө үед тулгарч байна. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нь хоригдлыг нийгэмшүүлэхдээ ШШГТХ болон Хорих ангийн дотоод журам, нийгмийн ажилтны аргачилсан зааврыг мөрдлөг болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Дээр дурдсанаар нийгмийн ажлын аргачилсан зааварт заагдсан заалтуудаар хоригдлын суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна гэдэг нь өөрөө өрөөсгөл ойлголт болж байна.

Тиймээс эрх зүйн зохицуулалтын хувьд нарийвчлан судалж боловсронгуй болгох шаардлага нэн түрүүнд тулгарч байгаа юм. Боловсронгуй болгоно гэхээрээ огт хамаагүй зүйлүүдийг тусгана гэдэг ч бас өрөөсгөл тиймээс нийгмийн амьдралд хэрхэн бэлтгэхтэй холбогдуулна сайн судалгаа хийх явдал юм.

Өмнө дурдсанаар Ялын хугацаа дуусаж, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хоригдлыг нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх зорилгоор 3 сарын өмнө сургалтад хамруулах гэж зааж өгсөн байна. Тухайн асуудал дээр ихэнх хорих анги тухайн хоригдлыг суллагдахаас 3 сарын өмнө сургалтад хамруулж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байгаа ба тухайн 3 сарын хугацаанд ямар чиглэлээр, юуны тухай сургалтыг зохион байгуулах нь тодорхойгүй байгаа ба тухайн сургалтын төлөвлөгөө болон орчин зохион байгуулалтын талаар тодорхой тусгаж өгөх нь нэн шаардлагатай болоод байгаа юм. Нийгмийн амьдрал болон цаг үеийн мэдээллийг гарын авлага, тусгайлан бэлтгэгдсэн нэвтрүүлэг бусад хэлбэрээр танилцуулах гэж заасан ба тухайн мэдээ мэдээллийг нийгмийн ажилтан нар цаг тухай бүр нь өгч ажиллаж байгаа ба суллагдах хоригдлыг зарим хорих анги нь 1-3 сарын хугацаатайгаар тусгайлан бэлтгэсэн нийгэмшүүлэх байранд байрлуулан сургалт сурталчилгааг зохион байгуулж байгаа ба тухайн нийгэмшүүлэх байрны талаар хууль эрх зүйн зохицуулалт хараахан гараагүй байгаа нь нийтээр нэвтрүүлэх хүлээн зөвшөөрөхөд хүндрэл тулгарч байгаа юм. Мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан бичиг баримтыг бүрдүүлэх гэж заасан ба тухайн хоригдлын өмнө авсан мэргэжлийн гэрчилгээг бүртгэх эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр үйлдвэрлэлийн дадлага, практик дадлага хийлгэж ажлын байранд гараад гологдохооргүй чадвартай болгоход нь түлхүү анхаарах. Хоригдлын гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх гэж заасан байгаа ба зөвлөгөөг ямар хэлбэрээр явуулах тодорхой төлөвлөгөөний дагуу гэр бүлийн судалгаа хийж уулзах гэх мэт ажлуудыг нарийвчлан хийх нь нэн чухал болоод байна.

Хоригдлыг нийгмийн харилцаанд гарч хувь хүн болж нийгмийн нэг эд эс болоход суллагдах үеийн нийгэмшүүлэх ажил маш чухал гагцхүү тухайн үеэс хоригдол нийгэмд гараад дахин гэмт хэрэг үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох уу? эсвэл нийгмийн хог шаар болж гудамжны архичин болох уу? эсвэл засрал хүмүүжлээ олоод амралын сайхныг ойлгоод гэр бүлтэй, ажил төрөлтэй сайхан амьдрах уу гэдэг сонголтыг хийх ухааныг хайрлах хүмүүс бол хорих ангийн алба хаагчид, нийгмийн ажилтнууд юм тиймээс тухайн үед, ямар аргаар нийгэмшүүлэх нь чухал хамгийн гол нь суллагдаад гарч буй хүн нийгмийн хөгжлөөс хоцрохооргүй ур чадвартай болж гарах нь чухал юм.

САНАЛ

- Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг боловсронгуй болгох
- Нийгмийн ажлын аргачилсан зааварт заасан суллагдах хугацаа дөхсөн хоригдлын нийгэмшүүлэх ажлын хөтөлбөрийг илүү нарийвчлан сургалтын сэдвүүдийг нийгмийн өөрчлөлтэй холбогдуулан боловсронгуй болгох.
- Хоригдлын нийгмийн амьдралд гарахад нь тодорхой мэргэжил эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн дадлага зохион байгуулах, ажлын байраар хангах арга хэмжээг системтэйгээр авч хэрэгжүүлэх
- Суллагдахад хугацаа дөхсөн хоригдлыг нийгэмшүүлэх байранд байршуулах, нийгэмшүүлэх байрны эрх зүйн зохицуулалт, бүтэц, харуул хамгаалалтын аюулгүй байдлыг боловсронгуй болгох
- Хоригдол суллагдаад гарах үед гэр бүлийн хүлээн авах орчин, тэдний уур амьсгалыг судлах.

- Нийгмийн ажилтан нарын мэдлэг, боловсрол, ур чадварыг нэмэгдүүлэх. Мөн нийгмийн ажилтны аюулгүй байдлыг хангахад анхаарах

НОМ ЗҮЙ

Хууль эрх зүйн баримт бичиг:

1. Эрүүгийн хууль. 2015 он.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он.
3. Гэр бүлийн тухай хууль. 1999 он.
4. Нийгмийн ажлын аргачилсан заавар ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 дугаар тушаал.
5. Хорих ангийн дотоод журам ХЗДХСайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний А/183 дугаар тушаал

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

М.Батмөнх
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн магистрант, ахмад

Batmunkh.M
Posgraduate student of University of internal affairs, capitan

УДИРТГАЛ

Энэхүү өгүүллэгийн хүрээнд аливаа хувь хүн, байгууллага, улс нийгэм, бүс нутаг, дэлхийн хөгжил дэвшил, сайн сайхан байдал мэдээллийн технологиос шууд хамааралтай болж, түүн дээр тулгуурлах болжээ. Эдийн засгийн хөгжлийн нэг үндсэн хөдөлгүүр нь мэдээллийн технологи боллоо гэдгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас нэгэнт хүлээн зөвшөөрчээ.

Монгол Улс ч мэдээлэл, мэдээллийн технологи, мэдээллийн систем, сүлжээ нь аливаа байгууллагын маш чухал, үнэт эд хөрөнгө гэж тооцогдох болсон ба түүнийг хулгайлах, хуулбарлах, гэмтээх, эвдлэх, өөрчлөх, устгах нь байгууллагын ашиг сонирхол, түүний үйлчлүүлэгчид, хэрэглэгчдийн эрх, эрх чөлөө, ашиг, сонирхол төдийгүй үндэсний аюулгүй байдлыг ноцтойгоор хөндөх хэмжээнд хүрчээ.

Тиймээс мэдээллийн аюулгүй байдал нь хувь хүн, нэг байгууллага, дан ганц улс орон төдийгүй дэлхийн хамтын нийгэмлэгийн чухал асуудал хэмээн тооцогдох болжээ. Өөрөөр хэлбэл, Интернэтэд улсын хил хязгаар байхгүй учир мэдээллийн аюулгүй байдлын асуудал нэг байгууллага, нэг бүс нутаг, нэг улсын асуудал биш, бүх дэлхийн асуудал болон хувирдаг.

Энэ аюул манай улсад тулгарчихсан, хувь хүн байгууллага төдийгүй үндэсний аюулгүй байдал, улсын тусгаар тогтнолд заналхийлж байгаа боловч бид үүнийг бүрэн мэдэрч чадаагүй яваа нь бүр ч аюултай.

Судалгааны зорилго: Монгол Улсын төрийн байгууллагын мэдээлэл, мэдээллийн сүлжээний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин

зүйлийг судалж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон, шийдвэрлэх боломж, арга замыг дэвшүүлэх.

Судалгааны зорилт:

1. Мэдээллийн аюулгүй байдлын тухай үндсэн ойлголт, мэдээллийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг судлах,
2. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж буй байдалд шинжилгээ хийх (Геологийн мэдээллийн төвийн сүлжээний аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ, харьцуулсан судалгаа хийх),
3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлыг сайжруулах арга замыг тодорхойлж санал дэвшүүлэх зэрэг болно.

Үндсэн хэсэг:

Өнөөдөр бид мэдээллийн эрин зуунд эргэлт буцалтгүй шилжиж, мэдлэгт суурилсан мэдээллийн нийгмийг байгуулж байна. Мэдээллийн нийгэм маш олон дэвшил, шинэ сайхан зүйлс, технологийн ололт амжилтыг авчирсан боловч урд өмнө байгаагүй олон сөрөг үзэгдлийг ч дагуулж ирлээ. Дэлхийн улсуудын аюулгүй байдлын шинжээчид, стратеги судлаачдын үзэж байгаагаар XXI зуунд ердийн зэвсэг ашигласан дайн бараг байхгүй болж программ техникийн зэвсэг ашигласан мэдээллийн дайн хүчээ авах болно. Энэ дайн интернэтийн орчинд төдийгүй өгөгдөл, мэдээлэл, мэдээлэл боловсруулах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээ, мэдээлэлтэй харьцдаг хүний нөөц бүхий бүх орчинд явагдах болно гэж үзэж байна.

Тиймээс мэдээллийн аюулгүй байдлын үндсэн ойлголтуудыг дараах байдлаар ерөнхийлөн томьёолж болохоор байна.

“Мэдээлэл” гэж хүн, эд зүйлс, баримт, үйл явдал, юмс үзэгдэл, үйлдэл болон үйл ажиллагааны тухай өгөгдөхүүнийг хэлнэ.

“Цахим мэдээлэл” гэж цахим хэлбэрт шилжсэн мэдээллийг ойлгоно.

“Аюулгүй байдал” үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.

“Хакер” нь бусдын цахим сүлжээнд нэвтрэх эрхийг устгах, сүлжээг хорт муу санааны үүднээс зөрчилдүүлж буй хүмүүс юм.

Тэд юу хийдэг вэ?

- Дамжигдаж байгаа мэдээг өөрчлөх

- Хортой кодыг бичиж ажиллуулах

"Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д "Мэдээллийн аюулгүй байдал гэж төрөөс улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр гаргах Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, ард иргэд хангагдсан Монгол Улсын талаар гадаадад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ." [14] гэж заасан. Энэ нь цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангахаас өөр ойлголт бөгөөд цахим мэдээллийн аюулгүй байдал нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Нийтэд цахим мэдээллийн аюулгүй байдлыг мэдээллийн аюулгүй байдал хэмээн ойлгож, нэршиж заншсан тул цаашид мэдээллийн аюулгүй байдал гэж нэрлэж бичих болно.

Орчин үед судлаачдын дунд мэдээллийн аюулгүй байдал цахим сүлжээгээр алдагдах эрсдэл өндөртэй болсныг тодорхойлсны зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд ч цахим сүлжээний аюулгүй байдлыг хангах, тасралтгүй хяналт тавих, түүгээр дамжин мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авахыг эрмэлзэх болжээ.

УИХ-д өргөн баригдаад байгаа "Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах" тухай хуулийн төсөлд "Цахим мэдээллийн аюулгүй байдал гэж цахим мэдээлэл гаднын халдлага, аюул занал, учирч болох эрсдэлээс хамгаалагдсан байдлыг хэлнэ" гэж заасан.

Иргэдийн дунд "Цахим мэдээллийн аюулгүй байдал" гэдгийг "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д заасан мэдээллийн аюулгүй байдал гэдэгтэй хольж ойлгох хандлага түгээмэл байдаг.

Тэгвэл "Цахим мэдээллийн аюулгүй байдал" гэдгийг өргөн утгаар нь:

"Жам ёсны болон зохиомол шинжтэй, санаатай болон санамсаргүй үйлчлэлээс мэдээлэл, түүнийг дэмжих дэд бүтцийн хамгаалагдсан байдал"[15] гэж үздэг бол явцуу утгаар нь,

[14] "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 7 дугаар бүлэг

[15] Галатенко В.А. Стандарты информационной безопасности. – М.: Интернет-Ун-т Информ. Технологи., 2004.

Энэ бүхэн дээр тулгуурлан “Цахим Мэдээллийн Аюулгүй Байдал” гэдэг нь “Цахим мэдээлэл, өгөгдөл, холбогдох тоног төхөөрөмж, дэд бүтэц гаднын халдлага, аюул, заналхийллээс хамгаалагдсан байдал” гэж үзэж болохоор байна. Харин “Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь цахим мэдээллийн хамгаалагдсан байдлыг бий болгох, гаднын халдлагаас сэргийлэхэд чиглэсэн төрийн бодлого, төр, түүний байгууллага, албан тушаалтнаас авч буй, иргэдээс хэрэгжүүлж буй цогц арга хэмжээний нийлбэр” хэмээн тодорхойлж болохоор байна.

Мэдээллийн аюулгүй байдал гэдэгт мэдээлэлжүүлэлтийн үйл явцын боломжит сөрөг үр нөлөөнөөс иргэд, нийгэм, төрийн хамгаалагдсан байдлыг ойлгодог. Монгол Улсын “Мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулийн төсөлд мэдээллийн аюулгүй байдал гэдгийг “Мэдээллийн нууцлал, хүртээмж, бүрэн бүтэн байдлыг баталгаажуулж буй хамгаалагдсан байдлыг хэлнэ” хэмээн тодорхойлсон нь товч боловч өргөн агуулгатай болжээ.[1]

Мөн Европын эрдэмтэд энэ тодорхойлолтыг бүр ч өргөсгөн тайлбарласан байдаг. Тухайлбал: энэ ойлголтод мэдээллийн технологи, дэд бүтэц, нөөцийг бий болгох, ашиглах, өндөр ач холбогдолтой мэдээлэл, мэдээллийн үйл ажиллагаанд оролцогчдын эрхийг хамгаалахын тулд эрх зүй, зохион байгуулалт, инженер-техникийн арга хэмжээ явуулахыг хамааруулсан байдаг.

Мэдээллийг боловсруулах автомат системийн (МБАС) аюулгүй байдал гэдэгт уг системд янз бүрийн сөрөг нөлөөлөл үзүүлэх замаар өмчлөгч, хэрэглэгчдэд хор хохирол учруулах оролдлогуудын эсрэг сөрөн зогсох МБАС-ийн чадвараар илэрхийлэгдэх шинж чанарыг ойлгодог. Өөрөөр хэлбэл МБАС-ийн хэвийн ажиллагаанд хөндлөнгөөс санаатай

болон санамсаргүй оролцох халдлага, түүний нэгж хэсгүүдийг хулгайлах, өөрчлөх, эвдлэх, гэмтээх оролдлогуудаас хамгаалагдсан байдлыг хэлнэ.

Аюул заналхийлэл гэдэгт мэдээллийн аюулгүй байдлыг санаатай болон санамсаргүй зөрчих бодитой оршин байгаа эсхүл боломжит аюулыг ойлгодог. Мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтын объект нь

[1] “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 7 дугаар бүлэг

мэдээллийн салбар дахь Монгол улсын **үндэсний ашиг сонирхол** бөгөөд үүнийг мэдээллийн салбар дахь хувь хүний, нийгмийн, төрийн ашиг сонирхол хэмээн ангилдаг. [2]

Мэдээллийн хүрээн дэх хувь хүний ашиг сонирхол:

- Хувь хүн, иргэний мэдээлэл олж авах үндсэн эрхийг хэрэгжүүлэх, хуулиар хориглогдоогүй үйл ажиллагаа явуулах, бие махбод, оюун мэдлэгээ хөгжүүлэхэд мэдээллийг ашиглахад
- Хувь хүний аюулгүй байдлыг хангаж буй мэдээллийг хамгаалахад оршино.

Мэдээллийн хүрээн дэх нийгмийн ашиг сонирхол:

- Мэдээллийн хүрээнд хувь хүний ашиг сонирхлыг хангахад
- Ардчиллыг бэхжүүлэхэд
- Эрх зүйт, иргэний нийгмийг бий болгоход
- Нийгмийн зохицолд хүрэх, дэмжихэд
- Монгол улсыг оюуны шинэчлэлд хүргэхэд оршино.

Мэдээллийн хүрээн дэх төрийн ашиг сонирхол:

- Монгол улсын мэдээллийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх
- Хувь хүн, иргэний мэдээлэл олж авах, ашиглах үндсэн хуулийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгоход оршино.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАМГААЛАГДСАН БАЙХЫН ТУЛД ДАРААХ 5 ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙХ ЁСТОЙ:[1]

- ❖ Нууцлал
- ❖ Бүрэн бүтэн байдал
- ❖ Хүртээмжтэй байдал
- ❖ Хууль ёсны байдал
- ❖ Тасралтгүй байдал

[1] Доктор Т.Халтар., "Монгол Улсын Мэдээллийн аюулгүй байдлын төлөв" судалгаа 2001-2007 он, УБ.,2008.

[2]Доктор Т.Халтар., "Монгол Улсын Мэдээллийн аюулгүй байдлын төлөв" судалгаа 2001-2007 он, УБ.,2008.

Тиймээс мэдээллийн аюулгүй байдал (Цаашид “МАБ” гэх)-ын тогтолцоог бий болгох анхны алхам нь эдгээр шаардлагуудыг зэрэглэх, нарийвчлан задлах, түүнийг хангах явдал юм.

Мэдээллийн аюулгүй байдлын чухал шинж нь хоёр үндсэн шалтгаанаар тайлбарлагддаг:

- Хуримтлуулсан мэдээллийн нөөцийн үнэ цэнэ;
- Мэдээллийн технологиос хамаарч буй байдал.

Зарим байгууллагын системийн доголдол зөвхөн тухайн байгууллагад хохирол учруулдаг бол цөөнгүй байгууллагын (төрийн, харилцаа холбоо, эрчим хүч, тээвэр, хангамжийн г.м) системийн доголдол нь нийгэм эдийн засгийн хөгжил, тогтвортой байдлыг алдагдуулдаг, тэр ч бүү хэл хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралд шууд заналхийлж, улс орны тусгаар тогтнолд аюул учруулж байдаг.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь хууль эрх зүй, захиргаа удирдлага, техник-технологи, цагдаа, тагнуул, олон улсын хамтын ажиллагааны цогц үйл ажиллагаа юм. Түүнчлэн эдийн засгийн хүчин зүйл чухал нөлөөтэй.

Мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлж буй дэлхий нийтийн хүчин зүйлсэд:

Мэдээлэлд нийтлэг мониторинг хийх, мэдээлэл болон мэдээллийн шинэ технологийг тараах салбарт явуулж буй гадаад улсын найрсаг бус бодлого;

- Гадаадын тагнуулын болон тусгай албадын үйл ажиллагаа;
- Монгол улсын ашиг сонирхлын эсрэг чиглэсэн гадаад улсын улс төр, эдийн засгийн байгууллагуудын үйл ажиллагаа;
- Олон улсын гэмт бүлэглэл, бүлэг, гэмт хэрэгтнүүдийн гэмт үйл ажиллагаа (үүнд хууль бусаар нэвтрэх, мэдээллийг өөрчлөх, устгах, хуулбарлах, үйлчилгээг бусниулах, төрөл бүрийн вирусийн довтолгоо үйлдэх, хүсээгүй зар мэдээ тараах, спай болон эдвайр программууд тараах, порно материал сурталчлах г.м орно) зэргийг оруулж болно.

1.2. Дэлхийн улс орнуудын мэдээллийн аюулгүй байдалд хийсэн шинжилгээ

Дэлхий дахинд мэдээллийн технологийн хэрэглээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байна. Гадаадын улс орнуудын хувьд компьютерын сүлжээний аюулгүй байдлыг хангах нь хууль хяналтын байгууллагуудынх нь гол анхаарах чиглэл болсон байдаг аж.

Мэдээллийн аюулгүй байдлын асуудал тулгамдсан асуудлын нэг болж байгааг дараах жишээ, баримтууд харуулж байна. Тухайлбал:

• Хятадын хакеруудын довтолгоо АНУ, Англи, Тайвань, Германы төрийн мэдээллийн санд нэвтэрсэн.[16]

• Хөшөө буулгаснаас үүдэн Эстони яамд, банк, хэвлэл мэдээллийн байгууллага, үүрэн холбооны операторын серверийг Оросын хакерууд ажилгүй болгосон[17]

• Канадын судалгааны институт хятадын нууц кибер тагнуулын сүлжээг илрүүлснээ зарласан. Дэлхийн 100 гаруй орны төрийн байгууллагуудад сүлжээгээ тогтоосон байсан. /www.cnn.com/

АНУ-ын үндэсний Мэдээллийн аюулгүй байдлын агентлагийн судалгаагаар 2017 онд АНУ-ын компаниудын 98% нь компьютерын ямар нэг халдлагад өртсөн байна. Үүнээс хамгийн их тохиолддог халдлага нь:

- Нянтай программаар халдварлуулах
- Өгөгдөл хулгайлах
- Гадна, дотор эх сурвалжаас өгөгдлийг өөрчлөх, устгах, нэмж хасах
- Компьютерын тоног төхөөрөмжийг хууль бусаар ашиглах
- Сүлжээнд хууль бусаар хандах
- Веб сайтыг эвдэх
- Denial of service (DOS)

1.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлөх аюул, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж буй байдал

А. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлж буй аюул

[16] **www.darkreading.com**

[17] **www.spiegel.de**

Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдалд нөлөөлж буй аюулыг мэдээллийн нууцлал, төрийн бодлогод заналхийлж буй аюул, мэдээллийн хүртээмжтэй байдалд заналхийлж буй аюул, мэдээллийн нэгдмэл, халдашгүй байдалд заналхийлж буй аюул хэмээн ангилж болно.[18]

Мэдээллийн нууцлал, төрийн бодлогод заналхийлж буй аюулд:

- Гадаадын улс төр, эдийн засаг, цэрэг, тагнуул, мэдээллийн байгууллагуудын мэдээллийн салбар дахь Монгол улсын ашиг сонирхлын эсрэг чиглэсэн ажиллагаа
- Мэдээллийн технологи, нөөцийг олж авахын төлөө олон улсын өрсөлдөөн хүчтэй болсон
- Техник, технологийн хоцрогдолд орсон
- Мэдлэгтэй боловсон хүчний дутагдаж байгаа
- Нууц мэдээлэл эзэмшигчид гадаадад гарах урсгал ихэссэн
- Төрийн байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлын талаас хянан шалгагдаж, гэрчилгээ аваагүй импортын техник хэрэгсэл, компьютер, тоног төхөөрөмж хэрэглэж байгаа
- Монгол улсын мэдээллийн зах зээлийг гадаадын мэдээллийн байгууллагууд монополчлох.
- Иргэдээс хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцааны нууцын эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах.
- Мэдээллийн шинэ технологи олж авахад саад тотгор учруулах, Монгол улсыг технологийн хараат байдалд оруулах нөхцөлийг бүрдүүлэх
- Монголын зах зээл дээрээс үндэсний програм хангамж, компьютерийн техник хэрэгсэл үйлдвэрлэгчдийг шахан зайлуулах
- Өндөр мэдлэг чадвартай боловсон хүчин гадаадад дүрвэх
- Мэдээллийг хууль бусаар цуглуулах, ашиглах
- Мэдээлэл боловсруулах технологийг зөрчих
- Төрийн өмчийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг хяхан боох явдал орж болно.

Мэдээллийн хүртээмжид заналхийлж буй аюулд:

[18] Доктор Т.Халтар., "Монгол Улсын Мэдээллийн аюулгүй байдлын төлөв" судалгаа 2001-2007 он, УБ.,2008.

- Иргэдийн мэдээллийн үйл ажиллагаа, оюуны амьдралын салбарт эдлэх эрх, эрх чөлөөг хөсөрдүүлсэн эрх зүйн хэм хэмжээний актыг УИХ, төрийн байгууллагуудаас батлан гаргах
- Мэдээллийн системийн бүрдэл хэсгүүд, дэд бүтцийн элементүүдийг бусниулах (үйлчилгээ бусниулах буюу DOS).
- Мэдээлэл бий болгох, хүлээн авах, тараах салбарт монополь бий болгох
- Нийгмийн ач холбогдолтой, шаардлагатай мэдээлэлд зохисгүй, хэтэрсэн хязгаарлалт тогтоох
- Хувь хүн, бүлэг, нийгмийн ухамсарт нөлөөлөх тусгай хэрэгслийг хууль бусаар хэрэглэх.
- Мэдээллийн салбар дахь нийгмийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн заалтыг төрийн байгууллагууд үл биелүүлэх
- Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагуудын мэдээллийн нээлттэй нөөц, архивын нээлттэй материал, нийгмийн ач холбогдолтой бусад материалд иргэд, байгууллага хандахыг хууль бусаар хязгаарлах.
- Өөрийн хувийн байдлын тухай мэдээлэлд хандахыг хязгаарлах
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн салбарт иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг зөрчих.
- Монголын нийгмийн үнэт зүйлстэй зөрчилдсөн ёс суртахуун, оюуны доголдол, хүчирхийллийг сурталчилсан нийтийн соёлыг дэлгэрүүлэх, оюуны үнэт зүйлсийг гутаан доромжлох.
- Мэдээллийг өөрчлөх, худал мэдээлэх, нуух, гуйвуулах явдлууд орж болно.

Мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн зохион байгуулахыг дараах зургаас харна уу [19]

Тайлбар: [19] DMZ-demilitarized zone буюу сүлжээний итгэлтэй болон итгэлгүй хэсгийг салгаж тусгай бүс үүсгэснийг хэлнэ. VPN-virtual private network буюу нийтийн сүлжээний хүрээнд аюулгүй дэд сүлжээ үүсгэснийг хэлнэ. IDS-intrusion detection system буюу хууль бусаар нэвтрэн орох оролдлого, халдлагыг илрүүлдэг систем. Firewall буюу сүлжээ хоорондын дэлгэц-галт хана нь мэдээллийн урсгалыг шүүж зөвшөөрч хориглож байдаг. Router буюу маршрутизатор – чиглүүлэгч нь төрөл бүрийн сүлжээг холбож, мэдээллийн урсгалыг илгээх замыг сонгож байдаг. Мөн мэдээллийг зохих түвшинд шүүдэг.



ДҮГНЭЛТ

Нийгмийн орчин үеийн хөгжлийг мэдээллийн өсөн нэмэгдэж буй үүрэг роль, мэдээллийн харилцаа тодорхойлсоор байна.

Монгол Улс Үндэсний Аюулгүй Байдлын асуудлыг батлан хамгаалах, хил хязгаар, хүнс, байгаль орчин, эдийн засаг гэх мэт хэдхэн салбарт авч үзэж анхаарал тавьдаг боловч мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг орхигдуулсан байна. Гэтэл мэдээллийн аюулгүй байдлаа хангаж чадахгүй байх нь үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд шууд аюул

учруулдаг. Монгол Улсад дайсагнасан улс манай төрийн бодлого, чиг хандлагыг мэдээд зогсохгүй төрийн албан хаагчдын санаа бодол, хүсэл эрмэлзэл, хувийн мэдээлэл, өгөгдлийг ч төвөггүй олж авах, тандах, аливаа мэдээллийг харш зорилгоор ашиглах, удирдах боломжтой болсон байна.

Юуны өмнө мэдээллийн аюулгүй байдал нь бүрэн дүүрэн хамгаалалт бий болгож чаддаггүй, түүнийг байнга сайжруулж, шинэчилж явах ёстой гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй биз ээ.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зөвхөн программ-техникийн арга хэмжээ хэрэгжүүлэхэд хангалттай гэж үздэг байсан ойлголтын үе өнгөрчээ. Мэдээлэл холбооны технологийн хурдтай хөгжил, түүнийг хууль бус зорилгод ашиглах хэдэн түмэн арга бий болсон өнөөгийн үед Монгол Улсад мэдээллийн аюулгүй байдлын ойлголт маш муу, төрийн стратеги,

бодлого бүрэн боловсруулагдаагүй, ихэнх байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц удирдлага байхгүй байна.

Иймээс төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг боловсронгуй болгохын тулд төрийн бүх шатанд хууль тогтоомжийн, захиргааны түвшний цогц арга хэмжээг төлөвлөн шат дараалалтайгаар хэрэгжүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

Санал:

1. Төрийн бүх албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, тусгай хамгаалалтын программыг ашиглан хэвшүүлэх
2. Дотооддоо төрийн албаны тусгай программ үйл ажиллагаанд нэвтрүүлэх

Ном зүй

- “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-аас
- Галатенко В.А. Стандарты информационной безопасности. – М.: Интернет-Ун-т Информ. Технологи., 2004.
- Доктор Т.Халтар., “Монгол Улсын Мэдээллийн аюулгүй байдлын төлөв” судалгаа 2001-2007 он, УБ.,2008.

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ХУЯГЛАН ХҮРГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШИЙДЭЛ

REGULATORY GAPS IN THE LEGAL FRAMEWORK GOVERNING ESCORT AND TRANSPORT OPERATIONS IN CORRECTIONAL INSTITUTIONS

Ж.Еркебулан

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 2024-7051 дүгээр дамжааны суралцагч, хошууч

J.Erkebulan

Training and Research Unit 403-Court Enforcement Service School8 2020-7051st year student, major

Хураангуй: Хууль сахиулах ажиллагаанд хоригдол, хоригдогчийг зөөвөрлөх, тодорхой газар хүргэх ажиллагаа нь алхам тутамд хийгдэж байдаг онцлог ажиллагаа юм. Гэсэн хэдий ч энэхүү онцлог ажиллагааны мөн чанар, утга агуулгад дүн шинжилгээ хийж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ородлого тэр бүр хийгдээгүй байна. Иймээс хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад алдаа шийдэл оршсоор байна.

Хуяглан хүргэх ажиллагаа хэмээх ойлголтыг судлан таниулах замаар хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны агуулга таньж мэдэхийг зорьсон. Ингэснээр хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, зохицуулалтын хүрээ, үүсч болох эрсдэл хийгээд зохицуулалтын дутмаг байдлыг шүүмжлэх, судлаачийн байр сууринаас таамаглал, дүгнэлтийг дэвшүүлэх боломж бүрдэж байна.

Abstract: In law enforcement practice, the transfer and escort of inmates and detainees is a specialized operation carried out at every procedural stage. Nevertheless, the essence and substantive meaning of this particular operation have not been sufficiently analyzed, nor have there been consistent efforts to improve its legal regulation. Consequently, shortcomings and gaps persist within the legal framework governing the escort and transportation of prisoners by correctional institutions.

The study aims to identify and clarify the substantive content of escort and transport operations within correctional institutions by examining and explicating the concept of such operations. In doing so, it becomes possible to critically evaluate the current state and scope of the legal regulation governing escort and transport activities, to identify potential risks and regulatory shortcomings, and to formulate hypotheses and draw reasoned conclusions from the standpoint of the researcher.

Түлхүүр үгс: Тээвэрлэх, хүргэх, дагалдан явах, харуул хамгаалалт, аюулгүй байдал, хоригдол, хууль, хүний эрх.

Keywords: Transportation, conveyance, escort, guarding and security, safety, prisoner, law, human rights.

Үндсэн хэсэг

Хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны зохион байгуулалт, түүний эрх зүйн зохицуулалтын оновчтой байдал, практикт хуяглан хүргэх ажиллагаанд бий болж буй хүндрэл бэрхшээлийг тодруулах, шийдвэрлэх оновчтой саналыг дэвшүүлэх зорилгоор өгүүллийг боловсрууллаа.

Хуяглан хүргэх ажиллагаа бол цэрэг, стратеги, хууль сахиулах зорилго бүхий тусгай ажиллагаанд ихээхэн чухал ойлголт бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх, ял эдлүүлэх ажиллагааны хэвийн байдал, аюулгүй байдалд ихээхэн нөлөө үзүүлдэг. Гэсэн хэдий ч цэрэг болон хууль сахиулах ажиллагаанд хуяглан хүргэх ажиллагааны аюулгүй байдлыг нарийвчлан судлаж, зохион байгуулалт, төрөл ангилалд үзэл санааны хийгээд, эрх зүйн зохицуулалтын бүрэн шинэтгэл хийгдээгүй өнөөг хүрсэн.

Учир нь хуяглан хүргэх ажиллагааг цэрэг болон хууль сахиулах ажиллагааны бусад ажиллагаанаас ялган судлах бус цэрэг болон хууль сахиулах ажиллагаанд хамаарах олон арга хэмжээний нэг хэсэг гэж авч үзэж ирсэнтэй холбоотой. Тухайлбал өгүүллийн хүрээнд хууль сахиулах ажиллагаа тэр дундаа хорих ял эдлүүлэх ажиллагаанд хоригдлыг хуяглан хүргэх ажиллагааны онцлог, зохион байгуулалтыг авч үзэх юм. Уг агуулгаар авч үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь хорих ял шийтгүүлсэн хүнийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино хэмээн эрүүгийн хууль (газар, 2016)-д заасан.

Ингэснээр хоригдлыг нийгэмшүүлэх үндсэн зорилгод хүрэхийн тулд хорих ялыг эдлүүлэхтэй холбоотой хоригдлыг хүлээн авах, хоригдлыг хөдөлмөрлүүлэх, тэднийг сургах, хорих ял эдлэх дэглэм, зэрэглэлийг өөрчлөх зэрэг олон арга хэмжээг холбогдох хуульд тодорхой заасан. Гэтэл эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх бүрт, хоригдлыг хуяглан хүргэх ажиллагаа байнга давтагдаж байдаг болохыг хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд бүрэн уялдуулж өгөөгүй юм.

Нэг үгээр хэлбэл хорих ял эдлүүлэх ажиллагаанд өдөр бүр, байнга хийгддэг хуяглан хүргэх ажиллагааг зөвхөн нэг хорих байгууллагаас нөгөө хорих байгууллагад хүргэх ерөнхий агуулгаар авч үзсэнтэй холбоотой хоригдлыг харуул хамгаалалтын хяналттайгаар А цэгээс Б цэгт хүргэхэд чиглэсэн ажиллагааны аюулгүй байдлыг бүрэн зохицуулж чадаагүй. Хуяглан хүргэлт нь хорих ял эдлүүлэх бусад ажиллагааг бодвол богино хугацаатай бөгөөд уг ажиллагааны үр дүн нь хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилгод тусгайлан шаардагддаггүй учир судлаачдын анхаарал бага өртөж ирсэн.

Иймд хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хорих байгууллагын хуяглан хүргэлтийн ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүгнэлт, санал гаргах хүрээнд энэ судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

Энэхүү өгүүллийг нэгж ойлголтуудыг задлан шинжлэх замаар ерөнхий ойлголтыг нэг мөр тодорхойлох байдлаар судалгааг гүйцэтгэсэн бөгөөд хуяглан хүргэх ажиллагааны ойлголт, хорих байгууллагын ойлголт, аюулгүй байдал хэмээх суурь агуулгуудад дүн шинжилгээ хийнэ. Ингэснээр хуяглан хүргэх ажиллагааны аюулгүй байдал нь хорих ял эдлүүлэх ажиллагаа хийгээд, хорих байгууллагын аюулгүй байдал хэрхэн нөлөөлдөг болохыг тодорхойлох боломж бүрдэнэ.

Уг тодорхойлолтод үндэслэн практикт хуяглан хүргэх ажиллагааг ямар эрх зүйн хэм хэмжээгээр хэрхэн зохицуулж байгаа болон ямар тулгамдсан асуудал бий болоод байгааг авч үзэх юм.

1. Хуяглан хүргэх ажиллагаа

Хуяглан хүргэх ажиллагаа хэмээх нэр томьёог тодорхой болгох нь хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны аюулгүй байдал, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход нэн чухал.

Суут богд Чингис хаан, үд зуур явж гурван зуун тайчуудыг дарж эсэн мэнд гэртээ ирж энх амгалан суув. Нүцгэн баарины Ширээт өвгөн, хөвүүн Алаг Наяа хоёртой элбэж тайчуудын ноён Таргудай Хирилтугийг ойд хогодож байхад олж бариад… тэргэнд суулгаж [Тэмүжинд хүргэхээр] авч явав, мөн Буйр Хөлэн хоёр нуурыг холбож урсахн Оршуун мөрөнд айргууд, буйргууд овгийн татаар аймаг нутаглана. Тэдэнд Амбагай хаан охиноо өгч, өөрөө охиныг хүргэж очоод татаарт баригдав. Татаар, Амбагай хааныг барьж Хятадын Алтан хаанд хүргүүлэв… зэрэг тухайн цаг үед хуяглан хүргэх ажиллагааг явуулж байсан талаар түүхийн эх сурвалжид заажээ (Б.Мэндбаяр, 2020).

Хуяглан хүргэх ажиллагаа гэдгийг нь баривчлагдагч, ялтан буюу цэргийн олзлогдогчийг товлосон газарт харгалзуулан хүргэх зэвсэглэсэн хамгаалалт гэж тодорхойлсон (С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг , 2007). Энэхүү тайлбараас үзвэл хуяглан хүргэх ажиллагаа нь сэжигтэн, яллагдагч, хоригдлыг тодорхой цэгт хүргэхэд чиглэсэн ойлголт болох нь харагдаж байна.

Мөн Б.Нямгомбо өөрийн бүтээлдээ хуяглан хүргэх ажиллагаа гэдгийг ялтанг цагдан хорих байр, хорих анги хооронд шилжүүлэх, тусгаарлах тасалгаа, сахилгын байрнаас гаргаж, тодорхой объектод хүргэх, буцаах үед тодорхой журам, зааврыг баримтлан тээврийн хэрэгсэл болон явганаар гүйцэтгэж байгаа харуул хамгаалалтын ажиллагаа гэж ойлгоно хэмээжээ (Б.Нямгомбо, 2013).

Энэхүү хоёр агуулгаас харахад хуяглан хүргэх ажиллагаа гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээдийг тодорхой цэгт хүргэх ажиллагаа бөгөөд энэ нь харуул хамгаалалтын үйл ажиллагааны нэг төрөл болдог болохыг дурджээ.

Тэгэхээр хуяглан хүргэх ажиллагаа хорих байгууллагын харуул хамгаалалтын нэг төрөл бөгөөд хоригдлын хөдөлгөөнийг үйлдэх үеийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ болохыг анхаарах хэрэгтэй. Учир нь “хуяглан хүргэх ажиллагаа” хэмээх ойлголтыг хууль

сахиулах ажиллагаанд өргөн хэрэглэж ирсэн хэдий ч хуяглан хүргэлтийн ойлголтыг агуулгыг бүрэн тань тодорхойлон ашиглаж ирсэн эсэх нь өгүүллийг анхаарлыг татаж буй хэсэг юм. энэ ойлголтын хамгийн анхаарах шаардлагатай хэсэг бол хуяглах хэмээх үг бөгөөд монгол хэлний тайлбар толинд хуяг дуулгаа өмсөх, ган, болд мэтээр бэхлэх зэрэг утгыг тусгажээ (Монгол хэлний их тайлбар толь, 2016). Үүнээс үзвэл хуяглах нь тухайн хамгаалж буй зүйлд, хор уршиг, аюул учрахаас урьдчилан сэргийлж байгаа утга байна. Тэгвэл хуяглан хүргэх ажиллагаа нь гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүн болон гэмт этгээдийн аюулгүй байдлыг ханган, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байдлаар зөөвөрлөх, шилжүүлэх, хөдөлгөөн үйлдүүлэх ойлголт болж байна.

Харин гадаад эх сурвалжид хуяглан хүргэх ажиллагааг бидний авч үзсэнээр өөрөөр тодорхойлжээ. “Prisoners transport”, “Prisoners escort operation” гэх мэтээр авч үзэж байна. Эдгээр нь хоригдлыг тээвэрлэх болон харгалзах, дагалдан явах гэсэн агуулгыг илүү дурдаж байна. Үүнээс үзвэл олон улсад бидний судалж буй хуяглан хүргэх ажиллагааг “Prisoners transport”, “Prisoners excort” гэсэн бие заасан судлагдахуун болгон ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэдэг байна. Тухайлбал “Escort” буюу дагалдан явах, хамгаалах хэмээх утга нь манай улсын хуяглан хүргэх ойлголттой илүү ойролцоо байна. Escort (Lexipol, 2024) нь хоригдлыг хэрхэн зөөвөрлөх, харгалзан хүргэтэй холбоотой ажиллагааг тайлбарладаг. Энэ мэдээлэлд хоригдлыг явганаар хүргэх ажиллагааны үйл явцыг видео хэлбэрээр үзүүлсэн байдаг.

Тэгэхээр манай улсын хууль тогтоомжид хэрэглэгдэж байгаа “хуяглан хүргэх” хэмээх ойлголт нь тээврийн хэрэгсэл болон явганаар хоригдлыг дагалдан хүргэхтэй холбоотой агуулгыг өөртөө багтаадаг болохыг харж болно.

Иймд бид дан ганц prisoners transport хэмээх агуулгад хамаарах ойлголтыг судлан, өөрийн улсын хууль тогтоомж дахь хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг шинэтгэн сайжруулах нь оновчгүй болохыг анхаарах хэрэгтэй.

Дээрхээс дүгнэн үзвэл хорих байгууллага дахь хуяглан хүргэх ажиллагаа гэж “хоригдлыг явганаар болон тээврийн хэрэгслээр тодорхой цэгт хүргэх зорилгоор аюулгүй байдлын зохих шаардлагад нийцүүлэн

хянан харгалздаг харуул хамгаалалтын үйл ажиллагаа” хэмээн тодорхойлж болно. Энэхүү тодорхойлолтод аюулгүй байдлын зохих шаардлага гэдэгт хүргэж байгаа этгээдийн аюул, эрсдэлийн түвшинд тохирсон арга, хэрэгсэлийг сонгох, хоригдлыг хүргэх үеийн болзошгүй аюул, заналхийлэл, эрсдэлийг урьдчилан тооцоолсон байх ёстой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Үүнээс үзвэл хуяглан хүргэх ажиллагааг явганаар болон тээврийн хэрэгсэлтэйгээр хэмээн хуваах боломжтой болох харагдаж байна. Мөн аюул эрсдэлийн түвшингээр нь тодорхой зэрэг болгон хуваах боломжтой байна. Тэгвэл хоригдлыг явганаар хуяглан хүргэх ажиллагаа нь мөн аюул эрсдэлийн түшингээс хамааран зохион байгуулалт болон хэлбэрийн хувьд ягаатай байх шаардлагатай. Тухайлбал нэг хоригдлыг явганаар хуяглан хүргэх тохиолдол, олон тооны хоригдлыг явганаар хуяглан хүргэх зэргээс шалтгаалан зохион байгуулалт болон хуяглан хүргэх үеийн техник хэрэгслийг ялгамжтай тогтоож хэрэглэх нь зүйн хэрэг. Мөн тээврийн хэрэгсэлийн тусламжтайгаар зохион байгуулж байгаа хуяглан хүргэлт нь ямар төрлийн тээврийн хэрэгсэл гэдгээс шалтгаалан хуяглан хүргэх үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг өөр, өөрөөр авч хэрэгжүүлэх нь дамжиггүй.

Зөвхөн хуяглан хүргэх ажиллагааг тодорхойлох замаар хуяглан хүргэх ажиллагааны төрөл, хэлбэр, арга зүйн ялгаатай байдлыг зайлшгүй тодорхойлох ёстой болох нь харагдаж байна. Иймд эрх зүйн зохицуулалтын хэмжээнд мөн адил хуяглан хүргэх ажиллагааг ялгамжтай зохион байгуулах үндэслэл, шаардлагыг зааж өгөх хэрэгтэй. Тэгвэл өгүүллийн дараагийн хэсэгт энэ тухай товч авч үзье.

2. Эрх зүйн зохицуулалт

Манай улс хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны арвин түүхтэй. Энэ ч агуулгаараа хорих ял эдлүүлэх хууль, эрх зүйн актуудад хуяглан хүргэх ажиллагааг зохицуулж ирсэн хэдий ч эрх зүйн зохицуулалт болон түүний хэрэгжилтэд дутагдалтай зүйлс байсаар байна.

Үүнийг дурдахад өгүүллийн эхний хэсэгт тодорхойлсоноор хуяглан хүргэх ажиллагаа зайлшгүй, төрөл, хэлбэр, өөр өөрийн онцлогт тохирсон

ялгамжтай зохион байгуулалттай байх шаардлагатай болохыг санах хэрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулинд “хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” гэжээ (газар У.-ы. Т., Монгол Улсын Үндсэн хууль , 1992). Энэ заалт нь гагцхүү хуульд заасан үндэслэл, хуульд заасан зохицуулалт, хязгаарлалтын хүрээнд л хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, аливаа ажиллагааг зохион байгуулах ёстой гэдгийг ирэлхийлж байна. Түүнчлэн Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийн 45 дугаар зүйлд “Хорих газарт аваачих буюу нэг хорих газраас өөр хорих газарт шилжүүлэхдээ түүний хөдөлөгөөнийг хүний нүдэнд өртөхөөс аль болох нууж, доромжлол, шохоорхол болон бусад бүх хэлбэрээр ил тод мэдэгдэхээс хамгаалах бүх арга хэмжээг авбал зохино” гэсэн байна (С.Хаш-Эрдэнэ, 2017).

Эдгээр заалтууд нь хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны зохион байгуулалт болон эрх зүйн үндэс, зарчмыг тодорхойлсон байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан байдаг (газар У.-ы. Т., 2017). Үүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хоригдлыг ял эдлэх хорих ангид хүргэх хуяглан хүргэх нэгжтэй байхаар тодорхойлсон. Түүнчлэн хуулийн хэд хэдэн заалтуудад хуяглан хүргэх агуулгыг тусгахдаа хуяглан хүргэх ажиллагаа нь зөвхөн хорих анги хооронд хоригдлыг шилжүүлэх, тээвэрлэхтэй холбоотой харилцаанд хамаарахаар байгааг харж болно.

Түүнчлэн хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан Хорих ангийн харуул хамгаалалтын журам хоригдлыг хуяглан хүргэх тусгайлсан зохицуулалтыг тусгасан ба үүнд нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, шинээр хорих ялаар шийтгэгдсэн хоригдлыг ял эдлэхээр хуваарилагдсан хорих ангид хуяглан хүргэх үүргийг хуульд заасан нэгж хариуцна гэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Хорих байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны стандарт”-д ялтан, хоригдогчийг хорих байр, хорих анги хооронд

шижлүүлэх, өрөө тасалгаанаас гаргаж, тодорхой газар хүргэх ажиллагааг хуяглан хүргэлт гэж заасан. Мөн стандартад хуяглан хүргэх ажиллагааны тодорхой аргачлалуудыг заасан.

Энэхүү заалтуудад үндэслэн хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалын өнөөгийн байдлыг тодорхойлж болно. Өгүүллийн өмнөх хэсэгт тусгаснаар хуяглан хүргэх ажиллагаа бол харьцангуй өргөн хүрээтэй ойлголт болох нь харагдсан ба хоригдлыг тодорхой газарт аваачихад чиглэсэн байх ёстой. Гэтэл эрх зүйн хэм хэмжээний өнөөгийн байдлаар бол зөвхөн тээврийн хэрэгсэл ашиглан хорих анги хооронд, эсхүл шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хүргэхтэй холбоотой агуулгыг тусгасан байгаа нь хуяглан хүргэлт хэмээх агуулгыг бүрэн илэрхийлэхгүй байна.

Хэрэв тухайн ойлголтоор тусгайлсан харилцааг зохицуулах бол тухайн ойлголтыг тодорхойлох буюу хуульд нэр томьёоны тодорхойлолт хийдэг хууль зүйн техникын арга зүй бий. Гэтэл уг арга зүйд суурилахгүйгээр тухайн үгийн агуулга, мөн чанарыг явцуурууллан хэрэглэсэн, эсхүл явцууруулж ойлгон хууль, эрх зүйн актад тусгасан нь хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг үр дүнгүй, хүчин чадалгүй заалт болгон хувиргаж байна.

Ийнхүү хууль, журам, стандартын зөрүүтэй ойлголтууд нь эрх зүйн хийдэл үүсгэж байгаа бөгөөд хууль сахиулах ажиллагаанд тэрхүү хийдлийг арилгах зорилгоор байгууллагын ашиг сонирхолд тулгуурлан шийдвэр гаргах, эрх зүйн актыг өөрчлөх нь МУ-ын Үндсэн хуульд заасан хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хүний эрх, эрх чөлөөг зөрчих болон хүний эрхийг хуулиар хязгаарлах зарчмуудад харшил байна.

3. Тулгамдаж буй асуудал

Хорих байгууллага дахь хуяглан хүргэх ажиллагаа бол хорих байгууллагын үйл ажиллагааны бүхий л үе шат, процессод тогтмол хийгддэг ажиллагаа болохыг онцолсон. Тэгвэл хорих ял эдлүүлэх ажиллагааны турш хоригдлыг хуяглан хүргэх ажиллагаа хийгдэж байгаа бол үүнийг зохицуулсан агуулга хууль сахиулах ажиллагаанд зайлшгүй чухал билээ. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тээврийн хэрэгсэл ашиглах ажиллагааг хуяглан хүргэлт хэмээн үзэж хуулийг

боловсруулсан нь явганаар буюу хорих ангийн байрлалд хоригдлыг шилжүүлэх, дагалдан явах ажиллагааг орхигдуулжээ.

Олон улсын жишигт хоригдлыг хуяглан хүргэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ хоригдлын эрдэлийг үнэлсэний үндсэн дээр хуяглан хүргэх арга журмыг ялгаатай байдлаар тодорхойлдог. Харин манай улсын хувьд хоригдлыг тээврийн хэрэгсэл болон явганаар хүргэхэд харуул хамгаалалтын нөхцөлийг тусгайлсан заасан хэм хэмжээ байхгүй байна .

Харин улсын тухайд эрх зүйн баримт бичгээс дүгнэн үзвэл зөвхөн тээврийн хэрэгсэл ашиглан хоригдлыг хуяглан хүргэх ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж байгаа нь анхаарал татаж байна. Өгүүллийн өмнө хэсэгт дурдсанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хуяглан хүргэх нэгж ажиллах бөгөөд тус нэгж нь хуяглан хүргэх ажиллагааг бие даан зохион байгуулж байгаа. Үүнтэй холбогдуулан хуяглан хүргэх нэгжээс хоригдлыг хуяглан хүргэх ажиллагааны чиглэлээр тоо баримтуудыг нэгтгэдэг байна. Харин хоригдлыг явганаар хуяглан хүргэх ажиллагаанд холбоотой тоо баримтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага огт анхаарахгүй байгаа бөгөөд хоригдлыг явганаар хуяглан хүргэх ажиллагааг харуул хамгаалалтын үйл ажиллагааны нэг хэсэгт хамааруулж байна.

Үүнээс үзвэл хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны ойлголт, мөн чанарыг тайлбарласан байдал ба эрх зүйн хэм хэмжээнд тусгалаа олсон байдал нь асар их зөрүүтэй байгааг харж болно. өгүүлэлд дурдсанаар Үндсэн хуулийн агуулгад хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэнийг ч мөрдөх, мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, саатуулахыг хориглодог. Гэтэл хууль тогтоомжид хуяглан хүргэх ажиллагааны агуулгыг бүрэн тодорхойлоогүй байгаа нь үндсэн хуулийн агуулгатай зөрчилдөж байна. Учир нь хорих ял эдлүүлэх ажиллагаанд албан хаагч болон хууль тогтоогчдын дунд хорих ял эдлүүлэх ажиллагаанд хандах уламжлалт хандлага голлож байгаа юм. Уг уламжлалт хандлага нь 1931 оноос 1990 оныг хүртлэх хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зйн зохицуулалт, уламжлалтай холбоотой юм.

Харин практик хорих ял эдлүүлэх ажиллагаанд өдөр тутамд хоригдлыг тодорхой объектод хүргэж буй хоригдлыг хуяглан хүргэх ажиллагааны хэлбэрийг хууль тогтоомжоор огтхон ч зохицуулаагүй байна.

Энэ нэг талаас ял эдлүүлэх ажиллагаанд орголт, гэмт хэрэг, зөрчил бий болох, алба хаагчийн халдашгүй байдлын аюулгүй байдалд эрсдэл учруулж байна.

Мөн олон улсад хоригдлын эрсдэлийг үнэлэх замаар хуяглан хүргэх буюу хоригдлыг хүргэх ажиллагааг зохион байгуулдаг. Энэ тухайн хуяглан хүргэж байгаа хоригдлын хувийн байдал болон хоригдлын тоо, алба хаагчдын хүчин чадалд тулгуурлан зохион байгуулдагаараа онцлогтой.

Эдгээрээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар “Хуяглан хүргэх ажиллагааны заавар”-ыг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар албаны нууцад хамааруулсан. Үүнтэй холбоотойгоор албан хаагчид хуяглан хүргэх ажиллагааны арга зүйг бүрэн мэдэхгүйд хүрч байна. Түүнчлэн уг заавар нь хоригдол, хоригдогчийг тээврийн хэрэгсэлээр хуяглан хүргэх ажиллагааны шаардлага, арга зүйг зохицуулсан шинжтэй тул хоригдол, хоригдогчийг хуяглан хүргэх ажиллагааг практикт зөвхөн тээврийн хэрэгслээр хуяглан хүргэх ажиллагааг чухалчлах, бусад хэлбэрийг анхаарахгүй байхад хүргэж байна.

Дээрхээс үзвэл хорих байгууллага дахь хуяглан хүргэх ажиллагааны ойлголт мөн чанар нь хууль тогтоомжид бүрэн дүүрэн тусгагдаж чадаагүй байгаа тул хууль тогтоомжийн агуулгыг онолын үзэл санаанд нийцүүлэн сайжруулах шаардлагатай. Эсхүл хуяглан хүргэх ажиллагааны агуулгыг хууль, тогтоомжид тусгахдаа хязгаарлалт тогтоож, түүнд тохирсан эрх зүйн зохицуулалтын аргыг хэрэгжүүлэх ёстой.

Дүгнэлт

1. Хуяглан хүргэх ажиллагаа хэмээх ойлголт нь хууль сахиулах ажиллагаанд өргөн хэрэглэгддэг ойлголт бөгөөд манай улсын хууль цаазын уламжлалд ч мөн адил гэмт этгээдийг хүргэх, зөөвөрлөх ажиллагаанд хамаарч байжээ. Үг зүйн хувьд ч мөн адил гэмт этгээдийг тодорхой газарт хүргэхэд дагалдан явах, зөөвөрлөх, шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах агуулгатай байна. Иймд хуяглан хүргэх ажиллагаа нь хоригдсон этгээдийн аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр тодорхой газар хүргэх, шилжүүлэх, зөөвөрлөхөд дагалдан явж байгаа, харуул хамгаалтын үйл ажиллагааны нэг төрөл болох тодорхой байна.

Тэгвэл уг ойлголт нь хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн агуулгад бүрэн тусгагдаагүй байна.

2. Хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааг ойлголтын хувьд өргөн хүрээтэй болохыг тогтоосон хэдий ч эрх зүйн баримт бичигт хуяглан хүргэх ажиллагааг явцуурууллан тодорхойлсон байгаа нь харагдаж байна. Хэдийгээр хууль тогтоомжид хуяглан хүргэх ажиллагааг тодорхойлж тайлбарлаагүй ч гэсэн хуулийн агуулга, хууль хэрэглээний талаас үзвэл зөвхөн хоригдол, хоригдогчийг тээврийн хэрэгслээр тээвэрлэх, зөөх, шижлүүлэх ажиллагаанд хамаарах зохицуулалт байгаа нь харагдаж байна.

Үүнээс үүдэн хорих байгууллагын хуяглан хүргэх ажиллагааны төрөл болох хоригдол, хоригдогчийг явганаар хуяглан хүргэх ажиллагааны зохицуулалтыг орхигдуулсан, хоригдол, хоригдогчийг явганаар хуяглан хүргэх ажиллагааны үед баримтлах эрх зүйн зохицуулалтгүй орхигджээ. Иймд хоригдлыг явганаар хүргэх үед хоригдол, хоригдогчийн эрхийг хязгаарлах хэр хэмжээг тодорхойлох боломжгүй болж байна.

3. Хүний эрхийг хязгаарлах зарчим гагцхүү хуульд заасан үндэслэл журам байх ёстой болохыг Үндсэн хуулиар тунхагласан. Тэгвэл одоогийн байдлаар хуяглан хүргэх ажиллагаа гэдэгт хоригдол, хоригдогчийг явганаар буюу тээврийн хэрэгслээр хүргэх ажиллагааг бүрэн тусгаж ойлгодог хэдий ч зөвхөн тээврийн хэрэгслээр хүргэх ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон байгаа нь цаашид явганаар хүргэх ажиллагааны үед аливаа эрсдэл үүссэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх арга зүй тодорхойлогдохгүй байхад хүргэж байна.

Түүнчлэн хууль бусаар буюу хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хоригдлыг хуяглан хүргэх үед хүний эрхийн зөрчилд хүргэж байгааг энэхүү өгүүллээр дүгнэж байна.

Санал

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 207 дугаар зүйлд заасан “Хоригдлыг хуяглан хүргэх” гэсэн агуулгыг дэлгэрүүлэн тодорхойлох шаардлагатай.

`

2. Мөн хуульд хуяглан хүргэх ажиллагаа хэмээх ойлголтыг нэр томьёоны тайлбарыг тодорхойлж, түүнд заасан агуулгаар хууль хэрэглээний пракикыг хэвшүүлэх хэрэгтэй.

3. Хоригдлыг хуяглан хүргэх ажиллагааны ойлголт мөн чанарыг албан хаагчдад сургалтаар дамжуулан тайлбарлан таниулах шаардлагатай. Ингэснээр хуяглан хүргэх ажиллагааны цар хүрээ, мөн чанарыг ойлгох, үүгээрээ дамжуулан хуяглан хүргэж ажиллагаанд хандах хандлагыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

4. Хуяглан хүргэх ажиллагааны аргачлал зааврыг боловсруулахдаа хоригдол, хоригдогчийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлд суурилсан хуяглан хүргэх ажиллагааны арга зүйг боловсруулан эрх зүйн хэм хэмжээнд тусгах шаардлагатай. Ингэснээр хуяглан хүргэх өдөр тутмын үйл ажиллагаа болоод тусгай шаардлага бүхий хуяглан хүргэх ажиллагааг харилцан адилгүйгээр зохион байгуулах, үүнтэй холбогдуулан албан хаагчдын хүрэлцээ, чадамжийг үр дүнтэй, хууль ёсны дагуу зохион байгуулах боломж бүрдэнэ.

Эх сурвалжийн жагсаалт

Lexipol. (2024). Prisoner escort procedure. Retrieved from Corrections1: https://www.corrections1.com/

Б.Мэндбаяр. (2020). Хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт /Магистрын зэрэг горилсон судалгааны ажил . Улаанбаатар : ДХИС.

Б.Нямгомбо, Ч. (2013). Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа . Улаанбаатар : Китаб .

газар, М.-ы. И. (2016). Эрүүгийн хууль . Төрийн мэдээлэл эмхэтгэл .

газар, У.-ы. Т. (1992). Монгол Улсын Үндсэн хууль . Төрийн мэдээлэл эмхэтгэл .

газар, У.-ы. Т. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль . Төрийн мэдээлэл эмхэтгэл .

Монгол хэлний их тайлбар толь. (2016). Монгол хэлний их тайлбар толь . Retrieved from www.Menksoft.com: https://mongoltoli.mn/

С.Нарангэрэл. (2007). Эрх зүйн толь бичиг . Улаанбаатар : Адмон принт.

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГАА БА ТЕХНОЛОГИЙН УЯЛДАА ХОЛБОО, УЛАМЖЛАЛ

THE INTERRELATIONSHIP AND EVOLUTION OF PRISON SECURITY OPERATIONS AND TECHNOLOGY

А.Анхжаргал
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахмад

Ankhjargal.A
Captian, Master's Student at the University of Internal Affairs

Хураангуй: Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба технологийн уялдаа холбоо, уламжлал сэдэвт өгүүллийн хүрээнд хэд хэдэн үндсэн асуудлыг хөндөхийг зорьсон. Эхний дугаарт хорих байгууллагын аюулгүй байдал хэмээх ойлголтыг тодруулах, аюулгүй байдлыг хангах ажиллагааны мөн чанар, хүрээг судалсан. Дараагийн дугаарт технологи хэмээх ойлголтын агуулга, мөн чанарыг тодруулахыг зорьсон ба ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдал технологи хоёр хэрхэн уялддаг талаар ерөнхий ойлголтыг уншигчдад хүргэх болно. Ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологийн хэрэглээний асуудлыг оновчтой , эргэлзээгүйгээр таниулах, судлах боломж бүрдэх юм.

Abstract: The article titled "The Relationship Between Prison Security Operations and Technology, and Their Traditions" aims to address several key issues. In the first part, it seeks to define the concept of prison security and to study the nature and scope of security operations. In the following section, it focuses on clarifying the concept and essence of technology, thereby providing readers with a general understanding of how prison security and technology are interrelated. Through this approach, the article intends to present and examine the application of technology in ensuring prison security in an objective and unambiguous manner.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, хүний эрх, хэрэгцээ, ажиллагаа, арга зүй, хэвийн үйл ажиллагаа, хөгжил.

Keywords: Security, human rights, needs, operation, methodology, normal operation, development.

УДИРТГАЛ

Манай улс нь төрт ёсны түүхийн арвин уламжлалтай бөгөөд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж арга зүй, эртнээс бие даан явуулж ирсэн соёлтой. Үүний нэг томоохон хэсэг нь хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн явдал юм. Тэгвэл энэхүү өгүүллээр хорих ял эдлүүлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба технологи хоёрын харилцах хамаарал, уялдаа холбоог судлах болно.

Хорих байгууллагын үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулахад тус байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ихээхэн чухал бөгөөд шинжлэх ухааны мэдлэг, технологийн шийдлийг уялдуулах асуудал хорих байгууллагын хөгжлийн бүхий цаг үед хамтран хөгжиж ирсэн.

Гэсэн хэдий ч хорих байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах ажиллагаа хийгээд технологийн ойлголт агуулгыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй болоод аюулгүй байдал судлал, технологийн салбарын судлаач, шинжээчид нарийвчлан авч үзээгүй бөгөөд ерөнхий ойлголтод тулгуурлан хэрэглэж, хуульчилж, практик эргэлтэд оруулж ирсэн.

Иймд хорих байгууллагын аюулгүй байдлын ойлголт, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны хандлага чиглэлийг тодорхойлох, цаашлаад байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологийн ойлголтыг судлан, таньж мэдэх, хийдэл бүхий ойлголтуудыг нэгтгэх шаардлагатай.

Өгүүллийн хүрээнд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологи гэсэн үндсэн хоёр агуулгын хүрээнд судалсан. Ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдал ба технологийн ойлголтыг зөв хэрэглэх, практик үйл ажиллагаанд оновчтой ашиглах боломж бүрдэнэ.

ҮНДСЭН ХЭСЭГ

I. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үндэсний аюулгүй байдал хийгээд, дотоод аюулгүй байдлыг хангах салбарт онцгой байр суурь бүхий төрийн байгууллага билээ. Иймд уг байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдтэй уялдах гарцаагүй. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.” хэмээн тусгасан (УИХ-ын Тамгын газар , Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай, 2010). Энд заасан хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хангах асуудал хорих байгууллагын үндсэн чиг үүрэг болох бөгөөд үүнд технологийн шийдлийг хэрхэн ашиглаж байгаад дүн шинжилгээ хийнэ. Учир нь өнөөдөр бидний хандлага, сэтгэхүйд тогтсон үзлээр бол аюулгүй байдал бол гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалагдах асуудал болоод байгаа бөгөөд өгүүллийн гол санаа нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах буюу хорих байгууллага дахь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан ажиллагаанд технологи ашиглах бус хорих байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулахад ашиглаж ирсэн технологийн шийдлийн талаар өгүүлэх болно.

Иймд өгүүллийн хүрээнд аюулгүй байдал хэмээх ойлголтын үндсэн утга, мөн чанарыг таньж мэдэхээс эхлэх нь зүйтэй.

Аюулгүй байдал судлалын асуудал нь дан ганц гэмт хэрэг, зөрчил, халдлагад хамаарахгүй бөгөөд тухайн хамгаалагдаж байгаа зүйлийн ашиг сонирхол, үндсэн хэрэгцээнд суурилж байдаг өвөрмөц онцлогтой. Нэг үгээр аюулгүй байдал хэмээх ойлголт нь судлагдаж байгаа объектынхоо хэрэгцээ хангагдах, хэвийн үйл ажиллагааг хангах орчин, нөхцөл, хүчин зүйлсээр тодорхойлогдоно.

Энэ нь аюулгүй байдал болоод аюулгүй байдлыг хангах ажиллагаа өргөн цар хүрээтэй ойлголт болохыг илэрхийлж байгаа юм. Учир нь бидний нийтлэг хандлагад аюулгүй байдал хэмээх ойлголтын хэрэглээг явцуурууллах авч үзэх тохиолдол түгээмэл байдагтай холбоотой. Иймд `

аюулгүй байдал хэмээх ойлголтыг бүрэн тодорхойлох шаардлага тулгарч байна.

Уг ойлголтыг англи хэлэнд “Security” хэмээн авч үзэж байгаа бөгөөд үгийн утга хийгээд үгийн үүсэл түүхэн талаас судлах нь оновчтой. Түүхэн талаас нь авч үзвэл XV зууны эхэн үед Securite буюу аюул, хохирлоос хамгаалагдсан байдал хэмээн авч үзэж байсан айдас түгшүүрээс ангид байх байдал хэмээн ойлгож байлаа. Латин хэлэнд мөн securitas хэмээн хэрэглэж байсан ба айдас, түгшүүргүй гэсэн утгыг агуулдаг (Douglas Harpers, 2023). Харин аажимдаа аюулгүй байдал хэмээх ойлголт нь аюул, занал байхгүйн тухай ойлголт бус харин аюул, заналаас хамгаалагдсан байхын илэрхийлэл болж ирсэн. Нөгөө талаас аюулгүй байдал нь дотоод болон гадаад байдлаараа харилцан адилгүй шинжийг агуулж байна. гадаад талаас нь үзвэл объект, үзэгдэл, үйл явцын хамгаалагдсан байдал бол дотоод талаасаа аюулгүй, заналхийлэлгүй байх төлөв юм (Ч.Улаанхүү, 2016). Эдгээр нь аюулгүй байдал нь объектив хүчин зүйлсийн хувьд биет юмс, үзэгдлийг хамгаалахаас гадна, хохирол учрахаас сэргийлэх боловч субьектив хүчин зүйлсийн хувьд ашиг сонирхол бодит болоход саад учруулахгүй байх төлөвийг агуулж байна.

Харин аюул гэх ойлголтыг аливаа хүн, юмс, үзэгдлийн хэвийн шинжийг алдагдуулдаг сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй юмс, үзэгдэл хэмээн авч үзсэн байна. Түүнчлэн гамшиг, зовлон учруулж болох хор хөнөөлтэй юм хэмээн Я.Цэвэлийн толь бичигт дурдсан (Я.Цэвэл, 2025).

Дээрхээс авч үзвэл аюулгүй байдал хэмээх ойлголт нь сөрөг үр дагаварт хүргэдэг хүчин зүйлээс хамгаалагдсан төлөв хэмээн үзэх боломжтой болохыг харуулж байна. Энэхүү төлөв нь тодорхой аюулгүй байдлын бүхий түвшинд ижил хадгалагдана. Тэгэхээр хувь хүн, бүлэг, улс түмний гэсэн нийгмийн салбар, түвшин бүрд аюулгүй байдал хэмээх ойлголт ижил утгаар ашиглагдах бөгөөд хамгаалагдаж байгаа объектын хүсэл, ашиг сонирхол хэрэгжих, бодит болох орчныг бүрдүүлэх явдал юм. Уг орчныг бүрдүүлэх нь аюулгүй байдлын объектыг хамгаалах агуулгаар тодорхойлогдоно.

Иймд аюулгүй байдал хэмээх өргөн хүрээтэй ойлголтыг хэрэглэхдээ тодорхой хязгаарыг нарийвчлан зааж хэрэглэх нь аюулгүй байдал судлал

хийгээд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход амин чухал билээ.

Тэгвэл хорих байгууллагын аюулгүй байдал хэмээх асуудал аюулгүй байдлын өргөн хүрээг хязгаарлаж байгаа хэдий ч зөвхөн хорих байгууллагын хамгаалалт, халдашгүй байдлыг илэрхийлдэггүй болохыг анхаарах ёстой. Үүнээс үзвэл хорих байгууллагын аюулгүй байдал гэх нь хорих байгууллагын материаллаг орчныг хамгаалах агуулгыг илэрхийлэх бөгөөд нөгөө талаас тус байгууллагын ашиг сонирхол хэрэгжих бодит нөхцөлийг бий болгох хийсвэр агуулга мөн өөртөө багтаана. Энэ талаар хорих байгууллагын аюулгүй байдлын асуудлыг доктор Ц.Очгэрэл нарийвчлан судалсан бөгөөд түүний судалгааны агуулгаас товчлон хүргэе. Тухайлбал хорих байгууллагын аюулгүй байдал гэж хорих байгууллагын гадаад, дотоод сөрөг нөлөөллөөс хамгаалагдах хэрэгцээ хангагдаж, аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх зорилт бүхий цогц арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хөгжих нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ" гэжээ (Ц.Очгэрэл, 2017). Уг тодорхойлолтоос үзвэл дээр дурдсанчлан хорих байгууллагын аюулгүй байдал бол ерөнхий агуулгаараа төлөв байдал болох нь харагдаж байгаа бөгөөд тэрхүү төлөв байдал нь тодорхой шинжүүдийг агуулснаар хорих байгууллагын аюулгүй байдал гэх ойлголт нь бүрэн хэлбэржиж байна.

Үүнд "хэрэгцээ хангагдсан байх", "аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэгдсэн байх", "таслан зогсоох, арилгах арга хэмжээ авагдсан байх" гэсэн шинжүүдийг заажээ. Эдгээр шинжүүд нь өгүүллийн эхний хэсэгт дурдсан объектив болон субьектив агуулгыг аль алиныг агуулсан байна. Ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдал нь хорих байгууллагын зорилго, чиг үүрэг хэрэгжихэд шаардлагатай бүхий хэрэгцээ болоод тэрхүү хэрэгцээг хамгаалах цогц арга хэмжээ авагдсанаар хэмжигдэж байна. Гэсэн хэдий ч аюулгүй байдал нь аюулгүй байх хийсвэр ойлголтыг тодорхойлсон бөгөөд тэрхүү хийсвэр ойлголтыг бодит болгоход чиглэсэн арга хэмжээ авагдсан байх төлөв юм. Харин байдал нь тэрхүү хийсвэр ойлголтод хэрхэн ойртож хэрэгжсэнээр хэмжигдэх зүй тогтолтой юм.

Дээрх агуулгыг дурдсаны шалтгаан нь бидний дундах аюулгүй байдлын хэвшмэл хандлага буюу аюулгүй байдал хэмээх үгийн нийтлэг

хэрэглээтэй холбоотойгоор зөвхөн хорих байгууллагын харуул хамгаалалтад уг сэдвийг чиглүүлдэгтэй холбоотой. Иймд энэхүү хэвшмэл хандлагыг оновчлох үүднээс дурдсан болохыг анхаарах хэрэгтэй.

Аюулгүй байдал хэмээх ойлголтын үг зүйн хөгжил болоод эрдэмтдийн аюулгүй байдал хэмээх ухагдахуунд суурилан авч үзвэл "хорих байгууллагын аюулгүй байдал бол хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааны төлөв бөгөөд ингэхдээ хорих байгууллагын хэрэгцээ хангагдсан, тэрхүү хэрэгцээнд нөлөөлж болох аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамгаалагдсан байх явдал" болж байна.

Өгүүллийн хүрээнд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааг тодорхойлох асуудал тулгарч байгаа бөгөөд аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь түүнийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ болох нь харагдаж байна. Учир нь ажиллагаа гэдэг үгийг зохион байгуулалттай хийж гүйцэтгэх ажил гэж үзсэн (www.Menksoft.com, 2016). Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тус байгууллагын хэрэгцээ хангах, урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн ажиллагааг гүйцэтгэхэд чиглэсэн зохион байгуулалттай ажил юм. Уг агуулгыг сөрөг нөлөөлөл бүхий хүчин зүйл, аюул заналаас үүдэлтэй үйл явцыг судлан тогтоох, хор уршгийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц ажиллагаа болохыг доктор Ц.Очгэрэл тодорхойлсон (Ц.Очгэрэл, 2017). Энэхүү үзэл санаатай судлаачийн хувьд санал нэг байгаа бөгөөд хорих байгууллагын хэрэгцээг хангахын тулд хорих байгууллагын хэрэгцээг судлах, түүнд сөргөөр нөлөөлөх аюул, заналыг судлах, үр дагаврыг бууруулах, тэмцэхэд чиглэсэн арга хэмжээнүүд болох нь харагдаж байна.

Ийнхүү хорих байгууллагын аюулгүй байдал болон аюулгүй байдлыг хангах ажиллагааг судлан шинжилснээр тухайн ажиллагаанд шаардлагатай техник, технологийн шийдлийг тодорхойлох боломж бүрдэнэ. Харин ингэж ойлголтыг бүрэн тодорхойлохгүйгээр аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хамаарах технологийн шийдлийг өрөөсгөл түвшинд авч үзэх эрсдэл тулгарах юм. Яг энэхүү агуулгыг хуульд тусгахдаа дараах ажиллагаанаас бүрдэнэ хэмээн үзжээ. Үүнд:

1. Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт
2. Техникийн хяналт, хамгаалалт
3. Биечилсэн хяналт, хамгаалалт

4. Аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх

5. Гүйцэтгэх ажил зэргийг заасан (УИХ-ын Тамгын газар, 2017) ба эдгээр дээр хоригдолд үзүүлэх нөлөөллийн арга хэмжээг хамааруулж болохоор тусгасан.

Эдгээр нь арга хэмжээ нь хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хорих байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд байгаа бөгөөд миний өгүүллийн хүрээнд дэвшүүлж үзэл санаатай тохирч байгаа юм.

Иймд эдгээр арга хэмжээнд орчин цагийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага технологийн шийдлийг хэрхэн ашиглаж ирснийг судалъя.

II. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа технологийн ойлголт

Энэхүү өгүүллээр аюулгүй байдал, технологийн ойлголтыг нарийвчлан авч үзэхийн зэрэгцээ орчин үеийн технологийн ангилалд тулгуурлан хорих байгууллагын аюулгүй байдал, технологийн хэрэглээг түүхэн баримтын хүрээнд тайлбарласнаараа онцлог юм.

Манай улсын орчин цагийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын түүхэн хөгжлийг 1921 он буюу ардын хувьсгалтай нас чацуу гэж үздэг. Иймд 1921 оноос хойших түүхийн баримтуудад хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд технологийн шийдлийг хэрхэн ашиглаж байсныг тодорхойлъё.

Үүний тулд юуны түрүүнд технологи хэмээх ойлголтыг нэг мөр авч үзэх хэрэгтэй. Технологи хэмээх ойлголт нь дан ганц инженерчлэлийн шийдэл биш юм. Технологи нь зөвхөн машин техник бус, харин шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглэхэд шаардагдах мэдлэг, зохион байгуулалт, ур чадварын цогц юм ((UIS), 2017). Үүнээс үзвэл технологи нь шинжлэх ухааны мэдлэгийг практикт хэрэглэх үйл явц болох харагдаж байна.

Бусад эх сурвалжид технологи гэдэг үг нь байгаль, нийгмийн орчныг өөрийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөхийн тулд шинжлэх ухааны мэдлэгийг практикт ашиглах үйл ажиллагаа гэж үзсэн байна

(Oxford University Press, 2023). Шинжлэх ухааны нээлтүүдийг практик, үйлдвэрлэлд хэрэглэх арга гэж үзсэн (Cambridge University Press & Assessment, 2025). Харин монгол эх сурвалжид дараах байдлаар тусгасан буюу Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаат үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргын цогц гэж тодорхойлжээ (Монгол хэлний их тайлбар толь, 2016). Эдгээрээс үзвэл технологи хэмээх ойлголт нь шинжлэх ухааны мэдлэгийг үйл ажиллагаанд хэрэглэх үйл явц болох харагдаж байна. Иймд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах буюу хэрэгцээ хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шинжлэх ухааны мэдлэгийн шийдлийг ашиглах ерөнхий агуулгыг тодорхойлж болно.

Харин технологийн салбар нь тэрхүү шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглээний чиглэлээр тодорхойлсон ойлголт бөгөөд шинжлэх ухаан “юу” болохыг зааж тодорхойлсон бол технологи нь түүнийг “хэрхэн” хэрэгжүүлэхэд чиглэсэн салбар гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааныг хэрэглээнд нэвтрүүлэх арга зүйг технологи хэмээн үзэж болно. Гэхдээ технологи нь нэг шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоонд бус олон шинжлэх ухааны мэдлэгийн уулзварт бий болдог ойлголт юм. Үүнээс авч үзвэл бидний амьдрал бүхэлдээ технологиор хүрээлэгдэн оршиж байдаг болохыг санах хэрэгтэй.

Жишээлбэл хүн төрөлхтний түүхэнд “анжис” бол хөдөө аж ахуйн хувьсгалын үед бий болсон технологийн шийдэл байлаа. Хүн төрөлхтөн биологи, физикийн шинжлэх ухаан мэдлэгт тулгуурлан бүтээсэн билээ. Мөн хорих байгууллагын удирдлага шийдвэр гаргах ажиллагаандаа SWOT шинжилгээ хийдэг гэж үзье. Энэ бол менежментийн шинжлэх ухааны судлагдахуун болох удирдлагын үйл ажиллагааны асуудал бөгөөд түүнийг практик хэрэглэх аргачлалыг боловсруулсан нь менежментийн технологи болох юм. Үүнээс үзвэл хорих байгууллагын ашиг сонирхлыг хангах, хэрэгцээг хангах, хэрэгцээг хамгаалах тогтолцоонд маш олон шинжлэх ухааны мэдлэг хийгээд тэдгээрийг мэдлэгт суурилсан олон тооны технологийн шийдлийг ашиглаж ирснийг анхаарах хэрэгтэй.

Орчин үед энэхүү технологийн салбарыг олон төрлөөр авч үзэх болоод байна. 2008 оноос эхлэн дэлхийн оюуны өмчийн байгууллагаас

технологийн салбарын ангиллыг шинээр тогтоосон. Энэ үеэс мэдээллийн технологийн салбар илүү хурдацтай хөгжиж ирсэнтэй холбоотойгоор мэдээллийн технологийн салбарыг илүү олон чиглэлд хуваан үзэх болсон. Нийт 5 бүлгийн 35 төрлийн технологийн ангиллыг тогтоосон байна (Ulrich Schmoch, 2008).

Дээрх хоёр агуулгаас авч үзвэл хорих байгууллагын аюулгүй байдал бол хорих байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдахад шаардлагатай хэрэгцээ, хамгаалагдсан, урьдчилан сэргийлэгдсэн байдал бөгөөд энэхүү хэрэгцээг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад шинжлэх ухааны олон талт мэдлэгийг авч хэрэгжүүлсэн байдал хэмээх агуулгаар ойлгох оновчтой гэж үзэж байна. Тухайлбал эдгээр нь хорих байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, хоригдлын аюулгүй байдлыг хангах буюу хоригдол бие хүний хэрэгцээг хангах, хамгаалахад чиглэсэн арга хэмжээ дэх технологийн шийдэл гэх мэт тусгайлан судлагдах өргөн боломжтой юм.

III. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд технологийн шийдлийг ашиглаж ирсэн байдал

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад технологийн шийдлийг ашиглаж ирсэн байдал өргөн хүрээтэй ойлголт хэдий ч судлаачийн хувьд хорих байгууллагын үйл ажиллагаа нь хуулиар хүлээсэн зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд шинжлэх ухааны мэдлэгт суурилсан технологи хэрэглэж ирсэн байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харилцааг зохицуулж ирсэн түүхэн баримтад тулгуурлан авч үзсэн.

1931 онд Хорих байгууллагын хэмжээнд ялтныг хүмүүжүүлэх зорилгоор илтэл тавих, лекц зохион байгуулах, үзүүлэх материал ашиглах зэрэг арга зүйг ашиглаж эхэлсэн (Б.Галбадрах, Э.Өнөболд , 2021). Энэ үйл явдал нь хорих байгууллагын нийгэмшүүлэх ажилд сургалтын технологийн арга зүйг ашиглаж эхэлсэн андагч үйл явдал боллоо. Энэ бол хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн болох хоригдлыг хүмүүжүүлэх, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд сургалтын технологийн шийдлийг ашигласан явдал байв. Тус сургалтын гол зорилго нь хоригдлыг бичиг үсэгт сургах, үйлдвэрлэлийн дадлага олгох, иргэний эрх үүргийг танилцуулах, суллагдсаны дараа нийгмийн ажил,

амьдралд идэвхтэй оролцохын ач холбогдлыг ойлгуулах зэргээр хүмүүжүүлэх чиглэлийг барих болсон талаар дурдсан байдаг.

Мөн 1939 онд БНМАУ-ын ДЯЯ-ны сайдын 02 дугаар сарын 60 дугаар тушаалаар “Засан сайжруулахуйд ба лагериудад хоригдож байгаа хоригдлуудын талаар тодорхой материал байхгүй байх тул Засан сайжруулахуйд ба лагериудад хоригдож байгаа хоригдол ялтнуудыг 1939 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс хувийн хэрэгтэй болгохыг ДЯЯ-ны Хорих, цагдах хэлтсийн дарга Дамбад даалгаж” шийдвэрлэж байлаа (Б.Галбадрах, Э.Өнөболд , 2021). Энэ үйл явдал бол хорих байгууллагын түүхэнд, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд мэдээллийн технологийн шийдлийг нэвтрүүлж ирсэн хамгийн том жишээ байна. Учир нь хүний хөгжлийн түүхэнд хүмүүс анх мэдээллийг баримтжуулж архив эхэлж, хадгалж ирсэн талаар олон баримтуудад тэмдэглэсэн байдаг бөгөөд энэ бол мэдээллийн технологийн хөгжлийн эхлэл байсан гэж үздэг.

Түүнчлэн энэ онд хоригдолд олгож байсан хоол, хувцсыг тодорхой шаардлагад нийцүүлэн олгох хүрээнд журамтай болгон ДЯЯ-ны сайдын 101 дүгээр тушаалаар “Засан сайжруулахуй ба лагериудад ял эдэлж байгаа ялтнуудад хоол ба хувцсыг нийтээр нэгэн норм хэмжээтэй болгох, ажлын бүтээмжийг харгалзан өдөрт 200 гр хүртэл нэмж олгох” шийдвэрийг гаргасан (Б.Галбадрах, Э.Өнөболд , 2021). Уг үйл явдал нь хорих байгууллагын үйл ажиллагаанд хүний технологийн шийдэл, арга зүй нэвтэрч эхэлсэн томоохон баримт юм.

ДЯЯ-ны сайдын 1949 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1141 дүгээр тушаалаар засан хүмүүжүүлэх газрын онцгой лагерийн офицер, ажилтнуудын соёл боловсролыг дээшлүүлэх зорилгоор радио хүлээн авагч ашиглах болжээ (Б.Галбадрах, Э.Өнөболд , 2021). Энэ үйл явдал бол мэдээлэл, холбооны технологийн шийдэл байлаа.

Мөн түүхэн баримтад 1953 онд засан хүмүүжүүлэх байгууллагын боловсон хүчний асуудлыг харьяа газар хариуцахаар болж, засан хүмүүжүүлэх байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, ур чадварын асуудлыг бүрэн хариуцаж ажиллах болсон ба үүнээс гадна тус онд хуяглан хүргэх тусгай зориулалтын машин болон “Газ-А1, М-пикап зэрэг тээврийн хэрэгслийг ашиглах болсон нь хүний нөөцийн болон, инженерийн

технологийн шийдлүүдийг ашиглаж ирсэн баримтууд мөн билээ (Б.Галбадрах, Э.Өнөболд , 2021).

Эдгээр баримтуудаас үзвэл технологийн шийдэл, шинжлэх ухааны мэдлэгийн ололт, амжилтууд нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд өргөн хэрэглэгдэж ирсэн болохыг авч үзэх боломжтой байна.

Нэг үгээр хэлбэл технологийн шийдлийг хорих байгууллагын аюулгүй байдлын салбараас салган авч үзэх судлах, дүгнэх боломжгүй юм. Хүн буй цагт, төр ба түүний чиг үүрэг байгаа л бол, шинжлэх ухааны мэдлэг болон түүний технологид суурилсан олон төрлийн арга зүй, шийдлүүд ямагт бидний амьдралд-нийгмийн харилцааны салбар хүрээг үл харгалзан нөлөөлсөөр, өөрийн үүргийг гүйцэтгэсээр ирсэн ба цаашид ч өөрийн мөрөө үлдээх нь дамжиггүй.

ДҮГНЭЛТ

Өгүүллийн хүрээнд дараах ерөнхий дүгнэлтүүдийг хийж байна.

1. Аюулгүй байдал хэмээх ойлголт нь хүн, нийгэм, байгаль гээд бүхий салбарын асуудлыг холбосон өргөн хүрээтэй ойлголт бөгөөд аливаа юмс, үзэгдэл үйл явцын хэвийн өрнөл, хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэхэд хамааралтай болох нь харагдаж байна. Иймд хорих байгууллагын аюулгүй байдал нь хорих байгууллагын бүхий үйл ажиллагаа, цаашлаад тус байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг, зорилтыг бүрэн илэрхийлсэн өргөн хүрээтэй ойлголт юм. Тэгэхээр хорих байгууллагын аюулгүй байдал бол байгууллагын үйл ажиллагаа, зорилго, чиг үүрэг зэргийг хэрэгжүүлэх боломжийг агуулж байна.

Тэгэхээр байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хамаарах бүхий л хүчин зүйлс, нөхцөл байдал, үйл явдлыг аюулгүй байдлын хэмжээнд авч үзэх, судлах нь хорих байгууллагын аюулгүй байдал судлалын салбарын үндсэн асуудал гэж үзэж байна.

2. Хүн төрөлхтний түүх бол дан ганц хүний хөгжил, хүмүүсийн хоорондын харилцааны түүх бус нөгөөтээгүүр шинжлэх ухааны мэдлэг ба түүний технологийн хөгжил, хувьсал өөрчлөлтийн түүх байдаг. Энэ нь хүн оршин байгаа газраас технологи хэмээх ойлголтыг тусгаарлан авч үзэж

боломжгүй болохыг сануулж байна. Технологийн шийдэл нь бидний амьдралын турш бидэнд олон боломж, давуу тал, хялбар шийдлийг санал болгож ирсэн үйл явж, үе шат, арга хэрэгсэл юм. Харин хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд технологи ашиглах явдал технологийн дэвшилд бус хорих байгууллагын үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн зорилго, зорилт хэрхэн хэрэгжсэн байдлаар үнэлэгддэг байна.

3. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд технологийн шийдэл тухайн цаг хугацаа, нийгмийн хөгжлийн байдлаасаа харилцан адилгүй байдлаар ашиглагдаж ирсэн байна. Технологийн хөгжлөөс хорих байгууллагын үйл ажиллагаа ангид орших боломжгүй бөгөөд гагцхүү шинэлэг арга зүйг хэрхэн нэвтрүүлж, хэрхэн туршиж ирсэн байдлаар аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологийн хэрэглээг тодорхойлж ирсэн нь аюулгүй байдал ба технологи хэмээх ойлголтын хэрэглээ, практик үйл ажиллагааны гажуудал гэж дүгнэж байна.

Иймд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь технологиос ангид тусдаа орших боломжгүй ба цаашид технологийн шинэ шийдэл, арга зүйг идэвхтэй нэвтрүүлэх асуудал бидний тулгамдсан асуудал юм. Харин технологийн шийдлийн хэрэглээ, түүний уламжлалын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэнд олон ололт, амжилтууд байгааг онцолж байна.

НОМ ЗҮЙ

(UIS), U. I. (2017). Measuring Scientific and Technological Services (STS): Draft Paper for Consultation. Montreal : UNESCO Institute for Statistics (UIS).

Cambridge University Press & Assessment. (2025). technology. Retrieved from Cambridge: https://dictionary.cambridge.org/

Douglas Harpers. (2023, 10). etymonline. Retrieved from Online Etymology Dictionary.: https://www.etymonline.com/word/security

Oxford University Press. (2023). Technology. Retrieved from Oxford English Dictionary: https://www.oxfordlearnersdictionaries.com/

Ulrich Schmoch. (2008). Concept of a Technology Classification for Country Comparisons. Germany: World intellectual Property Organisation (WIPO).

ХОРИГДЛЫН ТОДОРХОЙ ХЭМЖЭЭГЭЭР ХЯЗГААРЛАГДДАГ ҮНДСЭН ЭРХ БУЮУ ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ

FUNDAMENTAL RIGHTS OR RIGHT TO WORK, LIMITED TO A CERTAIN MEASURES OF DETENTION

Г.Батдондог
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахмад
Batdondog.G
Captian, Master's Student at the University of Internal Affairs

Товч утга: Бүс нутгийнхаа хэмжээнд хорих ялыг хэрэгжүүлдэг дэлхийн аль ч улс орнууд хорих ял эдлүүлэх ажиллагаанд дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар онцгойлон авч үздэг бөгөөд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар олон улсын эрх зүйн актууд болон үндэсний эрхийн актуудад хэрхэн тусгасан болон хоорондоо хэрхэн уялдаа холбоотой байдгийг тодруулан, харьцуулсан болно.

Abstract: Countries around the world that implement prison sentences within their region pay special attention to the employment of prisoners in the process of serving their sentences, and it clarifies and compares how international legal acts and national legal acts on the employment of prisoners are reflected and how they are interconnected.

Түлхүүр үг: Хорих ял, хоригдлын хөдөлмөр эрхлэлт, хоригдлыг нийгэмшүүлэх, хохирлыг барагдуулах, эрх зүйн орчин, бодит байдал, цалин хөлс, ажлын норм, хөдөлмөрийн нөхцөл, илүү цагаар ажиллах, хөдөлмөрийн мөлжлөг.

Keywords: Imprisonment, prisoner employment, prisoner socialization, compensation for damages, legal framework, reality, wages, work standards, working conditions, overtime work, labor exploitation.

Хураангуй: Монгол улсад төдийгүй дэлхийн улс орнуудад хэрэгждэг эрүүгийн хариуцлагын хамгийн хүнд хэлбэр бол мэдээж хорих ял. Тэгвэл хорих ял эдэлж буй этгээдүүдийн хөдөлмөр эрхлэлт гэж юу вэ?, хоригдлууд хорих ял эдэлж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэхдээ ямар нөхцөл байдал, ямар дүрэм журам, ямар хууль эрх зүйн зохицуулалтаар зохицуулагдаж хөдөлмөр эрхлэх ёстой вэ?, тэдгээр хууль эрх зүйн

үндэслэл, дүрэм журам нь бодит амьдрал дээр бодитой хэрэгжиж байгаа эсэх, хоригдлын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудал байгаа эсэх зэрэг хэд хэдэн дэд сэдвүүдийг хөндөж энэ талаар тусгасан хууль эрх зүйн баримт бичгүүд, эрдэмтэн багш нарын туурвисан ном сурах бичгээс болон энэ талаар хийгдсэн судалгааны ажил, баримт бичгүүдийг уншиж судлан, дүн шинжилгээ хийх замаар хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийн мэдрэмж эрх зүйн зохицуулалт хийгээд ял эдлүүлэх байгууллагын соёлд нэн тэргүүний зүйл байх ёстойг энэхүү илтгэлээ тодруулахыг зорилоо.

Хөдөлмөрийн ачаар хүн бий болоод зогсохгүй түүний ажлын чадвар, сэтгэл зүйн бүх чанар нь өөрчлөгдөн хөгждөг. Ф.Энгельс “Мич хүн болоход хөдөлмөрийн гүйцэтгэсэн роль” зохиолдоо “ Хөдөлмөр бол хүн төрөлхтний нэн тэргүүний үндсэн нөхцөл мөн бөгөөд үүнд хөдөлмөр хүнийг өөрийг нь бий болгосон гэх мэдээжийн утгаар хэлбэл зохих чухам тийм их хэмжээний зүйл” (Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, 2015, хууд. 45) юм хэмээсэн байдаг. Энэхүү ойлголт нь хөдөлмөр нь хүний сэтгэл санаа, бие бялдар, оюун ухаан, оршихуйн амьдралд нь маш том үүрэг гүйцэтгэдэг гэдгийг ойлгож болохоор байна. Тэгвэл нийгэмд хор аюултай үйлдэл, эс үйлдэхүйг санаатай болон болгоомжгүйгээр үйлдэж хорих газрын хаалгыг татан орж ирсэн хоригдлуудад хөдөлмөр эрхлүүлэх нь хоригдлуудын зан үйл, сэтгэл санаанд эергээр нөлөөлдөг төдийгүй нийгэмд эргэж гарахад бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага олгох, мөн нийгэмд учруулсан хор уршгаа нөхөн төлөхөд чухал хэрэгтэй юм. Мөн хоригдолд хөдөлмөр эрхлүүлэх нь хоригдлыг хөдөлмөрөөр дамжуулж хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, иргэн байгууллагад учруулсан хохирлоо барагдуулах төдийгүй өөрсдөө мөнгөн хуримтлалтай болох, мөн хорих байгууллагын нөхцөлд зохион байгуулагддаг үйлдвэрлэл нь тэнд ажиллаж байгаа хоригдлуудад хүмүүжлийн болон эрүүл мэндэд нь сайн нөлөө үзүүлээд зогсохгүй тэднийг нийгмийн гишүүн гэдгээ ухамсарлан ойлгоход тусалдаг (Б.Галбадрах, 2015, хууд. 145) зэрэг олон олон давуу талтай. Гэхдээ энэхүү эрхлүүлэх хөдөлмөр нь хоригдлыг залхаах, ялын шинжтэй, мөлжлөг хэлбэртэй байх нь байж боломгүй асуудал бөгөөд хэрэв ийм хэлбэртэй байвал тэрхүү эрхлүүлж байгаа хөдөлмөр нь хоригдлыг засан сайжруулж, нийгэмшүүлэх, нийгэмд эргэж гарахад нь бэлтгэх гэсэн

гол зорилгоосоо зөрж цээрлэл хэлбэртэй болох юм. Ингэвэл ялтныг хөдөлмөрлүүлэх гэх ойлголтын гол агуулга биеллээ олохгүй юм.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албадан хөдөлмөрийн тухай конвенц 1930, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны А/131 дүгээр тушаалаар батлагдсан "Хоригдлын хөдөлмөрийн норм, цалин хөлсний үнэлгээг тогтоох журам, зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулдаг байх нь ээ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хоригдлыг заавал хөдөлмөр эрхлүүлэх буюу хөдөлмөрт татан оролцуулах шаардлага нь тэдэнд хөдөлмөрөөр хүмүүжил олгох, хөдөлмөрөөр дамжуулж засан сайжруулах зорилтоос урган гарах бөгөөд хөдөлмөрөөс хойш суух, бусдын хүчийг завших, өөрийн үйлдэл, нийгмийн аюулын шинж чанар, түүний улмаас нийгэм, ард иргэдэд учруулсан хор уршиг, учруулсан хохирлоо арилгахын тулд тэд хөдөлмөр эрхэлж мөн улсаас тэдэнд зориулан гаргаж буй зардлын зарим хэсгийг эргүүлэн төлөх боломж бүрддэг юм. Энэ агуулгаас үзвэл нэг талаараа хоригдлыг хөдөлмөрлүүлэх нь эдийн засгийн ач холбогдолтой. Гэхдээ нөгөө талаас буюу гол агуулга нь буюу хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжлийн нөлөө үзүүлэх юм.

Хоригдлын эрх зүйн байдлыг хөндсөн хүний эрхийн олон улсын гэрээ, хэлэлцээрүүд олон байдаг ба эдгээр баримт бичгүүд нь дэлхийн дийлэнх орны үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлэх боломжтой байдаг. Хоригдлын эрх зүйн байдлыг зохицуулсан олон улсын актуудад дараах баримт бичгүүд хамаардаг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлд " Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй. Мөн хүн бүр ямар ч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй" хэмээн заасан байдаг ч энэхүү тунхаглалын үзэл баримтлалтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 215 дугаар зүйлийн 215.1, 215.5 зөрчилдөж байгаа юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 215.1т "Хоригдолд хийсэн хөдөлмөрт нь тооцож хөлс

олгоно” гэсэн нь дээрх конвенцын үзэл санаагаар бол тухайн хоригдлын эрхэлсэн хөдөлмөрийн цалинг нийгэмд тогтоосон нийтлэг жишгээр буюу нийгэмд яг ижилхэн хөдөлмөр эрхэлж буй ажилтантай адил цалин олгох ёстой. Гэтэл 215.5-д “Хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батлах бөгөөд хоригдлын хөдөлмөрийн үнэлгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна” хэмээн тусгасан байна. Энэ нь хоригдлын хөдөлмөрийг хөлсний хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцэхүйц байна гэсэн ойлголтыг төрүүлэхээр байна. Тэгэхээр энэ заалт нь хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлтэй харшилдаж байгаа буюу хүн бүр “Адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний цан хөлс авах ёстой” буюу хоригдол ч гэсэн нийгэмд ажиллаж буй хэн нэгэн хөдөлмөр эрхлэгчтэй адил ажил гүйцэтгэж байгаа бол түүнтэй нийцсэн яг адил цалин хөлс авах ёстой гэсэн үг юм. Хоригдол хэдийгээр нийгмээс тусгаарлагдаж, чөлөөтэй зорчих эрхээ хязгаарлуулж ял шийтгэл авсан ч хөдөлмөрлөж буй байдал болоод хөдөлмөрийн бүтээмж нь эрх чөлөөтэй хүний хөдөлмөрийн бүтээмжээс доогуур биш учраас гүйцэтгэсэн ажил, ажилласан цаг, хугацаандаа тохирсон, тухайн төрлийн ажил үйлчилгээнд олгож байгаа улсын дундаж цалин, хөдөлмөрийн хөлстэй дүйцэхүйц цалин, хөдөлмөрийн хөлс авах ёстой гэж үзэж байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт 1966 он

Энэхүү олон улсын фактын 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэх буюу заавал ажилд тулгаж болохгүй” хэмээн заасан байдаг. Мөн “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүнд хүчир хөдөлмөр хийлгэж хорих ял оногдуулж болдог улсын хувьд эрх бүхий шүүхээс оногдуулсан ялын дагуу хүнд хүчир хөдөлмөр хийлгэхэд дээрх заалт саад болохгүй” гэж заасан ба ингэхдээ “хүнд хүчир хөдөлмөр” гэдгийг тодорхойлон тусгаагүй бөгөөд Монгол улсын хувьд ч тэр шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр бүлэгт “хүнд хүчир хөдөлмөр” гэдгийг тодорхойлон заагаагүй буюу хоригдолд хүнд ч бай хөнгөн ч бай аль ч хөдөлмөрийг ялгалгүйгээр хөдөлмөр эрхлүүлэх боломжтой гэх ойлголтыг төрүүлж байгаа юм.

Албадан хөдөлмөрийн тухай олон улсын конвенц 1930

Үүнээс Монгол улс 29 дэх болон 105 дахь конвенцод 2005 онд нэгдэн орсон. “Албадан хөдөлмөр” гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг хэлнэ”. Гэхдээ хорих ял эдэлж буй хоригдол буюу шүүхийн шийдвэрээр ногдуулсан шийтгэлийн үр дүнд аливаа этгээдээр гүйцэтгүүлэх ажил буюу үйлчилгээ, гэхдээ уг ажил буюу үйлчилгээг төрийн эрх бүхий байгууллагын хяналт дор гүйцэтгэх бөгөөд тэрхүү этгээдийг хувь хүн, компани эсхүл нийгэмлэгийн мэдэлд хөлслөх буюу шилжүүлэхгүй байх ёстой; буюу хоригдолд энэхүү албадан хөдөлмөрлүүлэх тухай 29 дэх конвенц хамаарахгүй юм. (ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай конвенц(1930)-ийн 2014 оны протоколд нэгдэн орох боломжийн талаарх танилцуулга*, 1930)

Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд 1990 он

Энэхүү зарчмын 8 дахь хэсэгт “Хоригдлууд өөрийн орны хөдөлмөрийн талбарт эргэн ажиллахад хялбар байх, өөртөө болон гэр бүлдээ санхүүгийн тусламж үзүүлэх боломж олгох цалин хөлстэй, ажил хийх нөхцөл боломжийг бий болгох шаардлагатай” хэмээн заасан байдаг бол Монгол улсын хувьд энэ нөхцөл боломжийг хангаж чадахгүй байгаа буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдлын хөдөлмөрийн хөлсний хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоосон төдийгүй тэр тогтоосон цалингийн 70 хүртэлх хувийг шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөр, хоригдлын бууутай үйлдлээс хорих ангид учирсан хохирлыг суутгах зэрэг элдэв суутгалд татаад 30 хүрэх үү үгүйтэй юу мөнгийг хоригдлын нэрийн дансанд байршуулдаг. Ингэхээр хоригдлууд үлдсэн багахан хувиараа өөртөө хэрэглэхээс гадна гэр бүлдээ санхүүгийн туслалцаа болгож өгөхөд тун дутмаг билээ. Энэ нь дээрх Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмуудын 8 дах хэсгийн зорилтыг хангаж чадахгүй байна гэсэн ойлголтод хүргэж байгаа юм. (Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014 он.)

Дээрх баримт бичгүүдийн хэм хэмжээнүүд нь хоригдлын эрх зүйн байдал зохицуулсан үндэсний хууль тогтоомжийг хөгжүүлэх үүрэгтэй ба хүнлэг болон хөгжлийн шинж чанартай зөвлөмжүүдийг агуулсан байдаг. Хоригдлын эрх зүйн байдлын суурь эхлэл нь олон улсын баримт бичиг болон Монгол улсын иргэний иргэний эрх зүйн байдлаар тодорхойлогддог бөгөөд юуны өмнө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тогтоогдсон байдаг.

Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр бүлгийн 214 дүгээр зүйлийн 214.4-т “Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулна” хэмээн заасан байдаг нь учир дутагдалтай буюу зөвхөн “нээлттэй” хорих ангид ял эдэлж буй хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын ажил амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу тогтооно гэсэн нь дутмаг буюу хаалттай хорих ангид хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын ажил амралтын цагийг хэрхэн зохицуулахыг тусгаагүй байгаа нь дутагдалтай байгаа юм.

Мөн энэ хуулийн 21 дүгээр бүлгийн 210, 211 дүгээр зүйлд хоригдлын эрх үүргийг тус тус заасан боловч 210 дугаар зүйлд буюу хоригдлын эрхүүдэд хөдөлмөрлөх эрх болон түүнтэй холбогдох аливаа мэдээлэл авах, санал хүсэлтээ илэрхийлэх, гэрээ байгуулах, ажилласан хөдөлмөртөө тохирсон цалин урамшуулал авах, өгөөгүй тохиолдолд нэхэмжлэх, сайн дураар хувийн аж ахуй нэгжид гэрээ байгуулж ажиллах зэрэг хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд оролцохдоо эдлэх эрхийг огт тусгаж өгөөгүй байна. Энэ нь Албадан хөдөлмөрийн тухай 29 дэх конвенцод нийцэхгүй байна хэмээн үзэхэд хүргэж байгаа юм.

ХОРИГДЛЫН ТОДОРХОЙ ХЭМЖЭЭГЭЭР ХЯЗГААРЛАГДДАГ ҮНДСЭН ЭРХ

Хөдөлмөрлөх эрх

Л. Б. Смирнов хоригдлууд үндсэн хуулиар олгогдсон хөдөлмөрлөх эрхтэй бөгөөд суллагдахаасаа өмнө тодорхой хэмжээний хуримтлалтай болох зорилгоор хорих ангийн захиргаанаас тэднийг ажлын байраар хангах эрхтэй гэж үзсэн. Монгол улсын үндсэн хуулийн дагуу хөдөлмөрлөх эрх нь дараах агуулгатай бөгөөд 1/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, 2/

хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, 3/ цалин хөлс авах, 4/ амрах. Гэвч шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомж нь ял эдлүүлэх дэглэмийн шаардлагад нийцүүлэн зарим хязгаарлалтуудыг тогтоодог. А.Г. Левицкаягийн тэмдэглэснээр хоригдлууд хөдөлмөрлөх эрхээ шууд хязгаарлуулдаг байна. Нэгдүгээрт хууль тогтоомжоор, хоёрдугаарт хорих байгууллагын боломж бололцооны улмаас, гуравдугаарт хорих ангийн дотоод журамд заасан хоригдлыг ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтаар.

Н.Н. Дерюга, А.Я. Петров нар нийгмийн тусгаарлагдсан нөхцөлд заавал хөдөлмөр эрхлүүлэх зарчмаас татгалзаж түүнийг сайн дурын зарчмаар солих нь зөв гэж үзсэн. Мөн хоригдлууд ажил хийхээс татгалзвал шийтгэл оногдуулдаг нь хөдөлмөрөөр дамжуулж засан хүмүүжүүлэх гэсэн ойлголттой зөрчилдөж байгаа юм.

Хоригдлууд хорих ангийн байрлалд заавал байх шаардлагатай байдгаас хорих ангийн үйлдвэрлэлийн хязгаарлагдмал байдал нь хоригдлын хийх гэж буй ажлын сонирхолтой төдийлөн таардаггүй нь тухайн эрхийн хязгаарлалт болдог.

Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх

Энэхүү эрхээ бүх хоригдлууд хязгаарлуулаагүй байдгийг онцлох нь зүйтэй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 211 дүгээр зүйлийн 214.11 дүгээр хэсэгт хоригдлын хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй, 60-аас дээш насны эрэгтэй, -аас дээш насны эмэгтэй хоригдлыг бие, эрүүл мэндийн нөхцөлд нь таарсан ажил гүйцэтгүүлж болно гэж заасан нь зөвхөн тухайн хоригдлуудын хүсэлтийг үндэслэн ажил хийлгэж болох нь харагдаж байна.

Цалин, хөлс авах эрх


Цалин, хөлс авах эрх. Хорих ял эдлэх хугацаандаа ажил хийж байгаа хүний цалин, хөлс авах эрх зүйн байдал нь ажил эрхэлдэг бусад энгийн иргэдийнхээс ялгагдах зүйлгүй бөгөөд хийсэн хөдөлмөрт нь тооцож хөлс олгодог. Үүний зэрэгцээ тэд өөрийн цалин, хөлсийг бүрэн захиран зарцуулах боломжгүй бөгөөд учруулсан хохирлыг нь барагдуулах зорилгоор суутгал хийгддэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 215 дугаар зүйлийн 215.3 хорих анги хоригдлыг өөрийн үйлдвэрлэл дээр хөдөлмөрлүүлсний болон гэрээний үндсэн дээр хоригдлыг

хөдөлмөрлүүлсэн ажил олгогч хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөр, хоригдлын буруутай үйлдлээс хорих ангид учирсан хохирлыг суутгаж, үлдэх хэсгийг хоригдлын нэрийн дансанд төвлөрүүлнэ гэж заасан. 215.8 дугаар хэсэгт суутгалын хэмжээ нь хоригдлын хөдөлмөрийн хөлсний 70 хувиас ихгүй байна гэж заасан байдаг. (Галбадрах, 2020 он.)

ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН НИЙТЛЭГ ЗАРЧИМ, ХЭЛБЭР

Хорих байгууллагад хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулах ажил нь тэдэнд хөдөлмөрийн дадлага олгох, хүмүүжүүлэх гэсэн үндсэн зорилгод нийцсэн байх шаардлагатай бөгөөд хоригдол бүрийн хувийн зан төлөв, мэргэжлийн түвшин, үйлдсэн гэмт хэргийн байдал, зэргийг харгалзан тэднийг албадан хөдөлмөрт хамруулахтай холбогдсон иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулах, ажлын чухал зорилт болдог. Мөн хоригдлууд хөдөлмөрлөх эрх эдлэх, хөдөлмөрлөснийхөө хэрээр цалин хөлс авах, суутгал тооцуулах, сургалтыг зөв хослуулах зэрэг асуудлууд нь зах зээлийн эдийн засгийн болон хорих ангийн үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн зохион байгуулах зарчмуудад хамаардаг. Түүнчлэн хоригдлуудыг аль болох мэргэжлийн сургалтад бүрэн хамруулж, тэдний мэргэжлийн түвшин, үйлдвэрлэлийн соёлыг хэрхэн дээшлүүлснээр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэх, машин техниктэй зөв харьцах зэрэг зорилт хангагдана (Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014 он.)

Дээрх гурван хэлбэрээс дийлэнхдээ хорих газрын үйлдвэрлэлд хоригдлуудыг ажилдуулдаг байна. Энэ нь ихэнх хорих ангиуд өөрсдөө



дотроо ямар нэг эсвэл хэд хэдэн төрлийн үйлдвэр, цехтэй байдагтай холбоотой юм. Жишээ нь: Эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар анги нь оёдол, хувцас болон гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтын тасагтай, Эрэгтэйчүүдийн хорих 417 дугаар анги нь мод бэлтгэх, боловсруулах, гэрийн мод үйлдвэрлэх, буюу модон эдлэлийн үйлдвэртэй, хорих 421 дүгээр анги нь төмс, хүнсний ногооны аж ахуй эрхлэх, барилгын туслах материал, тоосгоны үйлдвэр, зам засвар, блокийн үйлдвэр, жоншны үйлдвэр зэрэг аж ахуй нэгж байгууллагатай гэрээгээр хамтран ажилладаг байна.

ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ПРАКТИК СУДАЛГАА

Хоригдлын хөдөлмөр эрхлэлт зохих ёсоор явагдаж байгаа эсэх талаар практикт хийсэн судалгаа төдийлөн олон байдаггүй нь энэхүү сэдвээр эрэл хайгуул хийж байх явцад анзаарагдлаа. 2014 онд Хүний эрхийн үндэсний комиссоос хийгдсэн “Монгол улс дахь ялтны хөдөлмөр эрхлэлтийн байдал” практик судалгаанаас өөр иш татаад оруулахуйц судалгааны ажлын тайлан хомс байна. Уг судалгаа нь хэдийгээр 9 жилийн өмнө хийгдсэн боловч энэхүү судалгаанаас хоригдлын хөдөлмөр эрхлэлт нүднээс далд яаж явагддагийг тодорхой, бодитой харуулсан юм. Мэдээж уг судалгааг хийгдэж байх үед тухайн үеийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэгдэн найруулагдаагүй буюу өмнөх жишгээрээ байсан ба уг судалгааны тайланд ихээхэн шүүмжлэл хүртсэн юм. Харин өнөөдрийн байдлаар тэр үед хөндөгдөж байсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл заалтууд өөрчлөгдөж шинэчлэгдэн найруулагдсан билээ.

Уг судалгаа нь олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Албадан хөдөлмөрийн тухай” 29 дүгээр конвенцын шаардлага бодитой хэрэгжиж байгаа эсэх талаар гол чиглэлээ болгож судалгааны ажлаа явуулсан байна. Судалгаанд нийт 3 хорих ангийн 522 хоригдол хамрагдаж санал асуулгад орсон байна. Хоригдлыг хөдөлмөрт татан оролцуулах нь олон талын сайн талтай ч ингэхдээ хоригдлын хөдөлмөрийн хуваарь, зохион байгуулалтыг зөв зохион байгуулах нь чухал бөгөөд хоригдлыг хувь хүн, компани, нийгэмлэгт хөлсөлж, тэдний мэдэлд шилжүүлж заавал хийлгэх ажил гүйцэтгүүлэх, эсхүл хийж буй ажил, үйлчилгээнд нь төрийн эрх бүхий

байгууллагаас хяналт тавиагүй тохиолдолд энэ нь 2005 онд Монгол Улсын нэгдэн орсон Албадан хөдөлмөрийн тухай 29-р конвенцыг зөрчсөн хэрэг болох юм (Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014 он.)хэмээн цохон тэмдэглэсэн юм.

Судалгааны үр дүнгээс хоригдлууд ажил хөдөлмөр хийхдээ албан ёсоор мэдэгддэг эсэх талаар 54-70 хувь нь өөрсдийнхөө гүйцэтгэж байсан ажилд ямар нэг гэрээ байгуулж байгаагүй, 33-64 хувь нь тухайн ажлыг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд ямар нэгэн заналхийлэл, шийтгэл хүлээж байсан, 36-59 хувь нь тухайн гүйцэтгэсэн ажилдаа ямар нэгэн хөлс авч байгаагүй, мөн судалгаанд хамрагдсан нийт хоригдлуудаас хэн нь ч илүү цагийн мөнгө авч байгаагүй, мөн судалгааны үр дүнд заавал хийлгэх болон сайн дурын хөдөлмөрийн нөхцөлүүд хоорондоо зохион байгуулалтын хувьд онцын ялгаагүй гэдгийг баталжээ. Энэ нь тухайн хөдөлмөр эрхэлж буй хоригдлууд заавал хийлгэх болон сайн дураар хийх гэдэг 2 ажлын төрлийг мэддэггүй буюу бүгдийг нь заавал хийх ёстой хэмээн ойлгоход хүргэдэг гэсэн утга санаа юм. Мөн судалгаанд хамрагдсан хоригдлуудын 51 хувь нь ажил хийхийг зөвшөөрөх болон татгалзах эрх нь хаалттай байдаг гэсэн бөгөөд удирдлагаас ажил хий л гэсэн бол өөрийнх нь санал хүсэлтийг огт сонсдоггүй хэсээн хариулжээ.

Мөн нийт судалгаанд хамрагдагсдын 45 хувь нь хорих ангийн үйлдвэрлэлд, 39 хувь нь хорих ангийн аж ахуйн ажилд, бусад нь төрийн үйлчилгээний болон хувийн аж ахуй нэгжид ажилладаг гэсэн байна. Түүнчлэн Санал асуулгад оролцсон эрэгтэйчүүдийн 68 хувь нь, эмэгтэйчүүдийн 72 хувь нь хорих ангийн удирдлагын шийдвэрээр хөдөлмөр эрхэлж байсан ба тэдний зарим нь хувийн ажил олгогчдын төлөө заавал хийлгэх хөдөлмөр эрхэлсэн байсан хэмээх хариултыг өгчээ.

ДҮГНЭЛТ

Дээрх олон улсын эрх зүйн зохицуулалтууд болон үндэсний эрх зүйн зохицуулалтуудаас харахад манай улсын хорих ял эдэлж буй хоригдлуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар зохицуулсан хууль эрх зүйн орчин нь зарим талаараа дутагдалтай байна. Жишээ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 214, 215 дугаар зүйлүүдэд хоригдлын хөдөлмөр эрхлэлт болон түүний нөхцөл, цалин хөлсийг тусгасан байдаг боловч хоригдлын хөдөлмөрийн хөлсний хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс

багагүй байлгана гэсэн нэг талаасаа хоригдлын эрхийг хангасан сайн зохицуулалт болсон гэж хэлж болохоор байгаа ч нөгөө талаасаа хоригдлын хөдөлмөрийн хөлсийг багаар буюу хөдөлмөрийн зах зээл дэх тухайн төрлийн ажил үйлчилгээний үнэлгээнээс багаар үнэлж хөдөлмөрлүүлэх боломжийг олгосон шударга бус зохицуулалт гэж харж байна.

Мөн хуулийн 214 дүгээр зүйлд хоригдлын хөдөлмөрлөх цаг, амралтын хугацааг заасан боловч зөвхөн нээлттэй хорих ангид ял эдэлж буй буюу нээлттэй хорих ангид хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын ажлын цаг, амралтын журмыг хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлтэй дүйцүүлж олгоно гэсэн нь мөн л учир дутагдалтай буюу хаалттай хорих ангид хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын эрхийг зөрчиж буй хэрэг юм.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр бүлгийн 210 дугаар зүйлд хоригдлын эрхийг тусгахдаа хоригдлыг хөдөлмөр эрхлэхтэй холбоотойгоор эдлэх эрхийг тусгаж өгөөгүй байгаа нь хоригдол хөдөлмөр эрхлэхдээ ямар ч эрх эдлэхгүй гэсэн ойлголтыг төрүүлж байгаа юм.

Судалгааны үр дүнгээс харахад бодит амьдрал дээр хоригдлуудын хөдөлмөрийг үнэлдэггүй бөгөөд дийлэнхдээ цалин хөлсийг нь олгодоггүй, илүү цагаар ажиллуулдаг ч илүү цагийн мөнгө олгодоггүй, хоригдлуудад сайн дураар ажиллах гэдэг ойлголт байдаггүй буюу бүгдийг албан шахалтаар хийдэг, ихэнх нь урьд өмнө нь хөдөлмөр эрхэлж байхдаа ямар нэг хөдөлмөрийн гэрээ байгуулж байгаагүй зэрэг олон асуудлууд тулгардгийг уг судалгаа харуулсан. Мэдээж тэр цаг хугацаанаас хойш зарим хуулийн агуулга заалтууд өөрчлөгдөж шинэчлэгдсэн ч хаалттай хөшигний цаана ахиад юу үргэлжилж байгааг таашгүй. Тиймээс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс сайтар анхаарч, тулгамдаж буй асуудлуудыг нь нээн илрүүлж түүнд чиглэсэн арга хэмжээ, эрх зүйн зохицуулалтуудыг хийж байх нь чухал юм. Хэдийгээр эрүүгийн хариуцлага хүлээж эрх, эрх чөлөөгөө хасуулсан ч гэлээ хоригдол нь олон улсын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 10 дугаар зүйлд заасан “Эрх чөлөөгөө алдсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ” гэсний дагуу хүнлэг харьцаж хөдөлмөрлөх эрхийг нь хүндэтгэх нь зүйтэй юм. Энэхүү дүгнэлтээ үндэслэн дараах саналыг гаргаж байна.

САНАЛ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр бүлгийн 210 дугаар зүйл буюу хоригдлын эдлэх эрхэд хоригдлын хөдөлмөр эрхлэх болон түүнтэй холбогдох эдэлж болохуйц эрхүүдийг нэмж тусгах. Жишээ нь хөдөлмөрийн гэрээ байгуулах, хорих ангийн болон Прокурорын байгууллагаас зөвшөөрсөн хувийн аж ахуй нэгж, байгууллагад ажиллах, хөдөлмөртөө тохирсон цалин хөлс авах, цалин хөлс олгоогүй нөхцөлд нэхэмжлэх;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр бүлгийн 214 дүгээр зүйлд “Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна” гэснийг “Нээлттэй болон хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна” гэж өөрчлөх;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр бүлгийн 215 дугаар зүйлд хоригдлын хөдөлмөрийн хөлсийг гэрээгээр тохиролцохдоо тухайн төрлийн ажил үйлчилгээнд олгож байгаа улсын дундаж цалин, хөдөлмөрийн хөлснөөс буурууулахгүй байх эрх зүйн хамгаалалтыг оруулж өгөх;

4. Хорих ангийн нөхцөлд заавал хөдөлмөр эрхлүүлэх зарчмаас татгалзаж түүнийг сайн дурын зарчмаар солих;

5. Хорих ангийн үйлдвэрлэлийн хязгаарлагдмал байдал нь хоригдлын хийх гэж байгаа ажлын сонирхолтой нь төдийлөн таардаггүй тул хорих ангийн үйлдвэрлэлийн төрлийг нэмэгдүүлэх.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб.,2017 он./шинэчилсэн найруулга/
- Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. Уб., 2014 он.
- Б. Галбадрах “Хоригдлын эрхийн байдал” УБ., 2020 он.
- Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Уб., 2015 он.
- Б. Дашзэвэг “ Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2-р дэвтэр. /тусгай анги/.

ЭМЭГТЭЙ ХОРИГДЛЫН ЯЛ ЭДЛЭХ ҮЕИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

A FEMALE PRISONER'S SENTENCE TRADITION & RENEWAL

Ц.Цэндсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахмад
Tsendsuren.Ts
Captian, Master's Student at the University of Internal Affairs

Хураангуй: Монгол Улс-ын эмэгтэй хоригдлын ял эдлэх тогтолцоо нь нийгмийн хөгжил, хууль эрх зүйн шинэчлэл, хүний эрхийн ойлголтын өөрчлөлттэй уялдан хувьсан хөгжиж ирсэн. Социализмын үед хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, хатуу сахилгын дэглэм давамгайлж байсан бол ардчиллын дараах үед хүний эрхэд суурилсан, нөхөн сэргээх чиг баримжаатай бодлого хэрэгжих болсон. Ялангуяа Нэгдсэн Үндэстний Байгууллага-ын стандартууд, тухайлбал Бангкокийн дүрэм-ийн зарчмуудыг нэвтрүүлэх нь эмэгтэй хоригдлын онцлог хэрэгцээг харгалзах чухал алхам болсон. Орчин үед боловсрол, мэргэжлийн сургалт, сэтгэлзүйн зөвлөгөө, гэр бүлийн холбоог дэмжих бодлого хэрэгжиж байгаа ч нийгмийн хандлага, санхүүжилтийн асуудал зэрэг сорилтууд тулгарч байна.

Abstract: The system of punishment for female prisoners in the Republic of Mongolia has evolved in line with social development, judicial reform, and changes in human rights perceptions. Under socialism, labor education and strict discipline prevailed, while in the post-democratic era, human rights-based and restorative policies were implemented. In particular, the introduction of United Nations standards, such as the principles of the Bangkok Rules, was an important step in addressing the specific needs of female prisoners. Today, there are policies in place to support education, vocational training, psychocounseling, and family ties, but there are challenges such as social attitudes and funding issues.

Түлхүүр үгс: Эмэгтэй хоригдол, ял эдлэлт, хүний эрх, шинэчлэл, нөхөн сэргээх бодлого, нийгэмд дахин нэгтгэх, олон улсын стандарт

Keywords: Women prisoners, Sentence execution / Imprisonment, Human rights, Reform, Rehabilitation policy, Social reintegration, International standards

Удиртгал

Эмэгтэй хоригдолд ял эдлүүлэх тогтолцоо нь тухайн нийгмийн соёл, хууль цааз, төрийн бодлоготой уялдан хөгжиж ирсэн түүхтэй. Монгол Улсын хувьд уламжлалт нүүдлийн нийгэмд хорих ял өнөөгийн хэлбэрээр төдийлөн хөгжөөгүй, харин торгох, эд хөрөнгөөр хариуцлага хүлээлгэх, нутаг заах, цөлөх зэрэг арга хэмжээ давамгайлж байв. Эмэгтэйчүүдийн хувьд гэр бүл, овог аймгийн хүрээнд хариуцлага тооцох, нэр төрийн шийтгэл оногдуулах хэлбэр илүү нийтлэг байсан.

1921 оны хувьсгалын дараагаас төрийн байгуулал өөрчлөгдөж, төвлөрсөн шүүх, хорих байгууллагын тогтолцоо бүрэлдэн тогтсон. Социализмын үед ял эдлүүлэх бодлого нь сахилга бат, хөдөлмөрөөр хүмүүжүүлэх үзэлд тулгуурлаж, эмэгтэй хоригдлуудыг үйлдвэрлэл, оёдол, гар урлал, хөдөө аж ахуйн ажилд дайчлан ажиллуулж байв. Энэ нь “засарч хүмүүжих” үзэл баримтлалтай холбоотой байлаа.

1990 оноос хойш ардчилсан шинэчлэл өрнөж, хүний эрхийг дээдлэх зарчим хууль тогтоомжид баталгаажсан. Үүний үр дүнд хорих байгууллагын үйл ажиллагаанд хүмүүнлэг хандлага нэмэгдэж, эмэгтэй хоригдлын онцлог хэрэгцээг харгалзан үзэх шаардлага тавигдах болсон. Олон улсын хэмжээнд Нэгдсэн Үндэстний Байгууллага-аас баталсан стандартууд, тухайлбал Бангкокийн дүрэм нь эмэгтэй хоригдолд жендерийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлсон.

Үндсэн хэсэг

Монгол улсад 1926, 1929, 1939, оны шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны эрүүгийн хуулиудад хорих ялаар шийтгүүлсэн хүнийг нийгмээс тусгаарлаж, тусгай тогтоосон дэглэмд, тусгайлсан газар ялыг эдлүүлж ирсэн уламжлалтай. Шүүхээс хорих ял оногдуулахдаа эрэгтэй болон эмэгтэйчүүдэд хорих ял оноох тухай тусгайлсан хууль эрх зүйн зохицуулалт байдаггүй учир нийтлэг зохицуулалтыг өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж ирсэн.

Монгол Улсын эртний эрх зүйн түүхэн замналын нэг онцлог нь гэмт хэрэг хийсэн хүнийг газар, нүхэнд хорьж шийтгэдэг хэлбэр нь одоогийн “ prison” шорон гэж нэрдэг байсан ба “Шороон гэр” гэсэн үгнээс гаралтай гэж үзэж байв.

1913 онд баталсан Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичгийг эртний хууль цаазын эх сурвалжуудтай харьцуулан үзэхэд нэг талаас

эмэгтэй хүнийг эрэгтэй хүний нэгэн адилаар онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол 49 дүгээр дэвтэрт “эмэгтэй хүн, хүн алсан бол шоронд хорино” гэж тусгайлан анх удаа зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт заасан онцлогтой.

Нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн хүнд эр, эм гэх хүйсийн ялгаваргүйгээр ял шийтгэл оногдуулж байхаар заасан байна. Үүнээс үзэхэд Монгол улсад эмэгтэй хүнд хорих ял оногдуулж, түүнийг биечлэн эдлүүлдэг эрх зүйн тогтолцоо бий болоод 100 гаруй жил болж байна.

1924 онд Анхдугаар Үндсэн хууль батлагдсанаас хойш 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд батлагдан гарсан билээ. Дээрх Үндсэн хуулиудын болон Ардын хувьсгалын үе шат, онцлогийг харгалзан:

1. Ардын засгийн газрын анхны арга хэмжээ / 1921-1924 /
2. Капиталист бус хөгжлийн замаар хөгжсөн үе / 1924-1940 /
3. Социализмын үндэс байгуулах үе / 1940-1960/
4. Социализмын материал техникийн бааз байгуулах үе /1961-1990/
5. Социализмын дараах үе / 1991 оноос хойших / гэж ангилан авч үздэг байв.

Хууль зүйн ухааны доктор, профессор А.Лхагва бүтээлдээ “Ардын намын төв хороо, түр засгийн газар”-ын хамтарсан хурал 1921 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Нийслэл хүрээнд болж засгийн газрын яамдыг шинээр байгуулахад шүүх яамны ерөнхий хэлтсийн харьяанд “Гяндан салаа” байгуулагдсан байна.

Шүүх яам үүсэж гяндан салаа байгуулагдангуут гяндангуудыг чөлөөлсөн ба гав, дөнгөтэй хүмүүсийг суллан тавьжээ. Гэвч 1921 оны 9 дүгээр сар гэхэд шүүхээр хорих ял шийтгэгдсэн 109 хоригдолтой болсон ба 1922-1925 оны хооронд 4 жилийн дотор хоригдлын тоо нийтдээ 7500 болж, хорих ял эдэлж байгаа хүн 16 дахин өссөн байжээ.

1921 онд эрүүгийн хэргийн тооллого явуулахад нэг хошуунд нэг эмэгтэй хоригдол байсан гэх баримт байгаа боловч ямар гэмт хэрэг хийсэн болоод аль хошуунд харьяалагдаж байсан тухай эх баримт байдаггүй аж.

Засгийн газрын 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1 дүгээр хурлаар шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг, 1926 оны 11 дүгээр сарын

11-ний өдрийн 3 дугаар хурлаар тусгай ангийг тус тус баталснаар 1926 оны “Шүүх цааз”-ын бичгийг баталсан түүхтэй.

1926 оны шүүх цаазын бичиг “Эм хүнийг бусад ялтай хүнээс тусгай зохино” гэж заасан байсан бол Ардын засгийн анхны жилүүдэд хоригдож байсан хэрэгтэн, ялтны архивын тоо баримтад 1926-1930 онд 17500 хоригдол байгаагаас 1,7% нь эмэгтэйчүүд байна гэсэн түүхийн баримт байдаг.

1926 оны Шүүх цаазын бичгийн 14, 16 дугаар зүйлд Эмэгтэй хүнийг бусад ялтнаас тусад нь хорихоос гадна хэрэв бие нь жирэмсэн аваас төрөхийн урьд, хойно 3 сарын чөлөө олговол зохино, гэж зааж байсан ба хувьсгалд тэрслэх, хортой санаа агуулах, хүнийг алах зэрэг аюултай гэмт хэрэг үйлдсэнээс бусад хөнгөн хэргийг анх удаа үйлдсэн болон үгээгүй хоосон ядуугийн улмаас үйлдсэн бол заавал хорихгүй байх ялын бодлого баримталж байжээ.

1929 оны Шүүх цаазын бичгийн 6 дугаар зүйлд “Хөхүүл хүүхэдтэй буюу жирэмсэн бүсгүйчүүдийг цаазаар авах ял оногдуулж болохгүй” гэж заажээ. Энэхүү энэрэнгүй өөрчлөлт нь зөвхөн жирэмсэн буюу хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд хамаатай байсан бөгөөд онц аюултай гэмт хэрэг үйлдсэнээс бусад эмэгтэйчүүдэд хамаарахгүй, өөрөөр хэлбэл жирэмсэн биш хөхүүл хүүхэдгүй эмэгтэй онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол түүнд алах ял оногдуулах асуудал нээлттэй хэвээр байжээ.

Бүгд Найрамдах Монгол ард улсын Сайд нарын зөвлөлийн 1934 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 17 дугаар хурлаар Шүүх цаазын бичгийг шинэчлэн баталжээ. 1930 оны сүүлч, 1940 эхээр улс төрийн хилс хэрэгт эмэгтэйчүүд олноор хэлмэгджээ.

Бүгд Найрамдах Монгол ард улс 1940 онд шинээр үндсэн хуулиа баталсан ба 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Бүгд найрамдах Монгол ард улсын Эрүүгийн хуулийг шинэчлэн баталсан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 26 дугаар зүйлд хорих ялын үндсэн хугацааг 6 сараас 10 жил хүртэлх хугацаагаар тогтоосон боловч тусгай ангийн олон зүйл заалтад заасан гэмт хэрэг үйлдэгчдийг 25 жил хүртэл хорьж шийтгэхээр хуульчилжээ.

Уг хуульд эмэгтэй хоригдлыг бусдаас тусад нь хорих, жирэмсэн бол ажилд гаргахгүй байх, төрөхийн өмнө 45 хоног, төрснөөс хойш 6 сарын хугацаатай чөлөө олгох тухай өмнөх хуультай адил төстэй зүйл оруулжээ.

1960 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг шинэчлэн баталсны дараа Ардын Их Хурлын 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Эрүүгийн хуулийг шинэчлэн баталсан. Уг хуулийн 18 дугаар зүйлд "60-аас дээш насны эрэгтэй, 18 насанд хүрээгүй хүн, эмэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй" гэж заасан нь жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулахгүй байх тухай өмнөх хуулиудын заалтуудтай харьцуулахад 1961 оны Эрүүгийн хууль нь нийт эмэгтэйчүүдэд эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны бодлогыг хэрэгжүүлэх албан ёсны зохицуулалт болж чадсан төдийгүй Монгол улсын эрүүгийн эрх зүйд томоохон дэвшил авирсан байна.

1974-1985 оны хооронд эмэгтэй гэмт хэрэг үйлдэгчдийн тоо 3-4 дахин өссөн ба эмэгтэй хоригдлын гэмт хэргийн бүтцийн хувьд нийт эмэгтэй хоригдлын 60 орчим хувь нь социалист өмчийг ашигласан, шамшигдуулсан гэмт хэргээр шийтгүүлж байсан аж.

Он	Нийт ял шийтгүүлсэн хүний тоо	Үүнээс эмэгтэй
1979	5223	286
1980	4019	303
1981	3495	319
1982	5537	362
1983	5908	498
1984	7749	707
1985	6774	584
1986	7600	750

1992 оноос эмэгтэйчүүдийн гэмт хэргийн тоо огцом буурсан ба учир нь 1991 онд Монгол улс анхны Ерөнхийлөгчтэй болж, 1991 оны 3 дугаар сард Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар социалист өмчийг ашиглан, шамшигдуулсан гэмт хэргийн улмаас хорих ялаар шийтгүүлсэн бүх хүнийг нэгэн зэрэг ялаас чөлөөлж байжээ.

1993, 2002 оны Эрүүгийн хуульд эмэгтэй хүний үйлддэг дийлэнх гэмт хэрэг дундаас биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах зэрэг гэмт хэрэгт тодорхой төрлийн ялын бодлого баримталж иржээ.

Монгол улс эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2015 оны Эрүүгийн хууль болон 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад хорих ялын дэглэмийг нээлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэхээр хуульчилсан ба хуулийн 201 дүгээр зүйлийн 201.1-т "Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ" гэж заасан нь насанд хүрээгүй хүнд насанд хүрсэн эмэгтэйчүүдийн дэргэд байхаа больж " Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага"-д ял эдлэх болсон.

Дүгнэлт

Эмэгтэй хоригдлын ял эдлэх тогтолцоо нь түүхийн явцад уламжлалт хатуу, шийтгэл давамгайлсан хэлбэрээс аажмаар хүний эрхэд суурилсан, хүмүүжүүлэх болон нийгэмшүүлэх чиглэлтэй тогтолцоо руу шилжиж байна. Өмнө үед эмэгтэй хоригдлуудын онцлог хэрэгцээ, нийгмийн нөхцөл байдлыг төдийлөн харгалзан үздэггүй байсан бол орчин үед тэдний сэтгэлзүй, гэр бүлийн байдал, хүүхэд асрах үүрэг зэрэг онцлогийг илүү анхаарах болсон нь чухал шинэчлэл болж байна.

Мөн ял эдлүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, мэргэжил олгох сургалт, сэтгэлзүйн дэмжлэг зэрэг нийгэмд эргэн дасан зохицоход чиглэсэн арга хэмжээнүүд нэмэгдэж байгаа нь эмэгтэй хоригдлуудын дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой юм. Иймээс уламжлал, шинэчлэлийг хослуулан хэрэгжүүлэх нь эмэгтэй хоригдлын эрхийг хамгаалах, тэднийг нийгэмд амжилттай буцаан нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Ашигласан ном зүй

1. "Эмэгтэйчүүд ба хорих ял", (2021), Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор, (Ph.D), Р.Оюунбадам
2. "Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй", (1996), Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор, (Ph.D) С.Жанцан, А.Лхагва
3. "Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал", (2011) 312, 345, 348, 363, 422, 427, 512 дахь талууд,
4. "Монгол улсын эрүүгийн хууль ", (2002) он.
5. "Монгол хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл", (2010) он.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭЭГҮЙ ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

CRIMINAL LIABILITY FOR FAILURE TO COMPLY WITH COURT DECISIONS

Б.Намуундарь
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахмад
Namuundari.B
Captain Böt, Lecturer at the Department of Social Work and Psychology

Товч агуулга: Монгол Улсад шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх, санаатайгаар удаашруулах, хэрэгжилтэд саад учруулах зэрэг зөрчил түгээмэл гарч байгаа нь эрх зүйн хариуцлагын зохицуулалтыг нарийвчлан судлах шаардлагыг бий болгож байна. Энэхүү өгүүлэлд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын эрх зүйн зохицуулалт, түүний онцлог, хэрэгжилтийн практик нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг шинжилсэн болно.

Судалгаанд Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлийн агуулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын практик хэрэгжилтийн талаар, Шийдвэр гүйцэтгэх алба, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон прокурорын байгууллагын баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийв. Үр дүнгээс харахад шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах механизмыг зөвхөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүрээнд бус, эрүүгийн эрх зүйн үр нөлөөгөөр дэмжих шаардлагатай байна. Мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагаанд шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал, төлбөр төлөгчийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд санаатай саад учруулж буй үйлдэл, гэм бурууг нотлох ажиллагааг сайжруулах нь зүйтэй гэж үзэв.

Ийнхүү шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй үйлдэл нь зөвхөн хууль зөрчих бус төрийн нэр хүнд, шүүхийн итгэлцлийг алдагдуулж буй тул эрүүгийн хариуцлагын бодит хэрэгжилт, хяналтыг бэхжүүлэх нь нэн чухал юм.

Abstract: In Mongolia, violations such as non-compliance with court decisions, intentional delay, and obstruction of enforcement are common, which creates a need for a detailed study of the regulation of legal liability. This article analyzes the legal regulation of criminal liability for persons who fail to comply

with court decisions, its features, practical implementation conditions, and emerging issues. The study analyzed the content of Article 21.7 of the Criminal Code, the practical implementation of the court decision enforcement agency, and documents from the Enforcement Service, the Capital Court's Enforcement Office, and the prosecutor's office. The results show that the mechanism for ensuring the execution of court decisions needs to be supported not only within the framework of the decision enforcement agency, but also through the effects of criminal law. It is also considered appropriate to improve the validity of court decisions in the process of imposing criminal liability, the actions of the payer intentionally obstructing the execution of court decisions, and the process of proving guilt. Thus, it is essential to strengthen the effective implementation and control of criminal liability, as failure to comply with court decisions not only violates the law but also undermines the reputation of the state and the trust of the judiciary.


Түлхүүр үг: Шүүхийн шийдвэрийн биелэлт, эрүүгийн хариуцлага, шийдвэр гүйцэтгэл, хууль дээдлэх зарчим, шүүхийн практик.

Key word: Enforcement of court decisions, criminal liability, execution of decisions, rule of law, judicial practice.

УДИРТГАЛ

Иргэний эрх зүй хэмээх нэр томьёо нь эртний Ромын эрх зүйгээс гаралтай бөгөөд Ромын иргэд эд хөрөнгөө өмчлөх, эзэмших эрхтэй гэсэн үзэл, сэтгэлгээ бий болж, улмаар тэр нь эрх зүйгээр баталгаажин эрх зүйн системд иргэний эрх зүй гэсэн салбар болон үүсэн хөгжсөөр иржээ. (Т.Мөнхжаргал, 2007)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхээс гарсан захирамж, шийдвэр, шийтгэх тогтоолын дагуу төлбөр төлөгч сайн дураар төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд төлбөр авагчийн хүсэлтээр бичигдсэн албадан гүйцэтгүүлэх захирамж болон шүүхийн гүйцэтгэх хуудасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу төлбөр гаргуулах ажиллагаа хэмээн ойлгож болох юм.



Хүснэгт: 1 Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны хагас жилийн мэдээгээр гүйцэтгэх баримт бичгийн тоо төлөвөөр:

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулна:

1.Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр;

2.Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж;

3.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр;

4.Шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр;

5.Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр;

6.Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж зэргийг үндэслэн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдаг. (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24, 2017)

Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ямар арга хэлбэрээр гүйцэтгэх, тэр хэлбэр нь хуулийг сахих, төлбөр төлөгчийн эд хөрөнгө ба мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг шуурхай гүйцэтгэх, шударга ёсыг дээдлэх, шийдвэрийг албадан гүйцэтгэх зарчимд хэрхэн нийцэж байгаа эсэхийг тодорхойлох үүрэгтэй. (Иргэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, 2015)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтлах ба шийдвэр гүйцэтгэх ажиллагааны туйлын зорилго нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээж бодит биелэлтийг хангахад оршино.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 51,2 хувь, 2024 оны жилийн эцсийн байдлаар 50,8 хувь, 2025 оны хагас жилийн байдлаар 32,9 хувийн биелэлттэй байна.

Төлбөр төлөгдөөгүй шалтгааныг дараах байдлаар тодорхойлно.

1. Төлбөрийн чадваргүй;
2. Оршин суугаа хаяг тодорхойгүй;
3. Хорих ял эдэлж байгаа;
4. Эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа;
5. Хэсэгчилсэн төлөлттэй.

Эрүүгийн хариуцлагын тухай ойлголт:

Хэлзүйн талаас **хариуцлага** гэдгийг а/ хариуцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, хариуцаж биедээ хүлээсэн үүрэг хариуцлага, б/ хууль зөрчсөн хүнд хүлээлгэх хариуцлага гэж тайлбарласан байдаг. (Я.Цэвэл, 1966)

Хариуцлага гэдэг нь өөрийн хийсэн үйлдэл, хэрэг явдал, тэдгээрийн үр дагаврыг хариуцах субъектийн бэлэн байдал юм (Г.Галиндэв).

Аливаа хариуцлага тэр тусмаа эрүүгийн хариуцлагын мөн чанар нь бие хүн, нийгэм ба төр хэмээн хоорондоо харилцан шүтэлцээ бүхий хүн төрөлхтний бодит ахуйгаар нөхцөлдсөн байдаг. Хүн бүр нийгмийн дотор ажиллаж, амьдрахдаа наад зах нь өөрийн ухамсар-хүсэл зоригийн нийгмийн, төрийн хүсэл зоригийн гэсэн гурван хүчтэй нөлөөлөлд автах байдаг. (Жанцан, 2014)

Эрүүгийн хариуцлага нь иргэний хуулиар хүлээлгэсэн үүрэг, хэрэгжүүлэх бодит боломжтой, чөлөөт хүсэл зориг зайлшгүй шаардлагатай хэрхэн харьцаж байгаад нийгэм-эрх зүйн хяналтыг ямар нэгэн хэмжээгээр

хэрэгжүүлж байдгаараа эрүүгийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд чухал байр эзлэн оршдог ойлголт юм. (Жанцан, 2014)

Өргөн утгаараа эрүүгийн хариуцлага нь дараах утгыг агуулдаг байна. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдэгдсэн фактаас шууд үүдэлтэй, эрүүгийн хуулийн хэм хэмжээнд үндэслэгдсэн. гэмт хэргийн субъект болох этгээдийн хийсэн хэргийнхээ төлөө төр, түүнийг төлөөлсөн байгууллагын өмнө хүлээх хариуцлага
2. Үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд төрийн нэрийн өмнөөс шүүхийн тогтоолоор өгч буй сөрөг үнэлгээ
3. Гэм буруутай нь нотлогдсон шүүгдэгчид оногдуулах эрүүгийн хуульд заасан төрийн албадлагын арга хэмжээ
4. Шүүхээр хорих ял шийтгэгдсэнтэй холбогдож үүсгэх ялтай байдал гэсэн 4 үндсэн шинжийг өөртөө агуулж байдаг гэмт хэрэг үйлдэгдсэн хууль зүйн фактын нийгэм эрх зүйн шууд үр дагавар юм (Жанцан, 2014).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 17 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа”-ны талаар заасан байдаг. Тухайлбал: “Цагдаагийн байгууллага, алба хаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчаас хэрэгжүүлж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээд, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн албаны үйл ажиллагаатай нь холбогдуулан түүний амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн тохиолдолд туслалцаа үзүүлж, харилцан мэдээлэл солилцоно (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24, 2017)”, “Энэ хуулийн 17.1-д заасан чиглэлээр туслалцаа үзүүлэх, мэдээлэл солилцох, энэ хуулийн 100.7, 162.6, 180.3, 187.2, 189.6, 190.4, 239.5, 250.1-д заасны дагуу хамтран ажиллах журмыг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга хамтран батална (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24, 2017)” гэж хуульчилжээ.


Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь заалтын практик хэрэгжилт:

Монгол улсын өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21 дүгээр зүйлийн 21.7-д зааснаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” хэмээн заасан байдаг.

Өнөөдрийн байдлаар дараах үндэслэлүүдээр төлбөр төлөгч, гуравдагч этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Цагдаагийн байгууллагад хандаж байна.

1. Хөрөнгийн мэдүүлгээ зориудаар буруу мэдүүлсэн
2. Эд хөрөнгөө нуун дарагдуулсан
3. Бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн
4. Оршин суух хаягаа дур мэдэн өөрчилсөн
5. Шүүхийн шийдвэрийг дүр эсгэн биелүүлсэн
6. Битүүмжилсэн, барьцаалсан, хураасан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан
7. Дүр үзүүлсэн гэрээ байгуулсан


Зураг 1: Нийслэлд 2017-2023 онд эрүүгийн хуулийн 258, 2015



оны эрүүгийн хуулийн 21.7-д заасан гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх судалгаа “Эх сурвалж: Улсын Ерөнхий прокурорын газрын судалгаа” (Я.Батгэрэл, 2024)

Тоон судалгааны өгөгдлийг авч үзвэл нийслэлд 2017-2023 онд эрүүгийн хуулийн 21.7-д заасан үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр цагдаад хандсан тоо их байгаа боловч эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан тоо маш хангалтгүй байгаа нь хуулийн хэрэгжилт муу байгаа нь харагдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэгдсэн батлагдсанаас хойш 2017-.2025 оны байдлаар Монгол улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 21.7-д заасан үндэслэлээр нийт 16 шийтгэх тогтоол гарч, 13 шүүгдэгчид ял хүлээлгэж 2 шүүгдэгчийг ялаас чөлөөлж, 1 шүүгдэгчийг цагаатгасан байна. (www.shuukh.mn) Үүнээс:



1.Хорих ял-1


2.Зорчих эрхийг хязгаарлах ял-2 оногдуулснаас 1 хөнгөрүүлэх нөхцөл байдлаас ялаас чөлөөлсөн

3.Торгох ял-6

4.Тэнссэн-2

5.Хөнгөрүүлэх нөхцөл байдлаас шалтгаалан эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн-2


6. Гэмт хэргийн шинжгүй тул шийтгэх тогтоолоор цагаатгасан-1



Зураг: Монгол улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 21.7-д заасан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тоон үзүүлэлт

Дээрх тооноос харахад 2018 онд ял шийтгэл оногдуулсан тоо хамгийн их буюу 4, 2024 онд 3, 2020, 2021 онуудад тус бүр 2, 2017, 2019, 2022 онуудад 1, 2023 болон 2025 оны байдлаар шүүхээр ял шийтгэгдсэн хүн, хуулийн тэгээд бүртгэгдээгүй байна.

Орон нутгийн хувьд



Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх-2
Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх-1
Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх-3
Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх-3
Өмнөговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх -1
Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх-1
Архангай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх -1
Баянхонгор аймаг дахь сум дундын анхан шатны шүүх -2
Хөвсгөл аймаг дахь сум дундын анхан шатны шүүх-1
Баян-Өлгий аймаг дахь сум дундын анхан шатны шүүх -1 шийтгэх тогтоолоор хүн, хуулийн этгээдэд ял шийтгэл оногдуулсан байна.

2025 оны байдлаар Монгол улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн 37 төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэхээр харьяа газар, хэлтсээс Цагдаагийн байгууллагад хандан гомдол, мэдээлэл гаргасан байх бөгөөд гомдол шалгах хугацаанд 7 төлбөр төлөгч төлбөрийн үүргийг бүрэн биелүүлж, 4 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс

татгалзаж, 2 гомдолд хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 1 гомдолд хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн боловч прокурорын байгууллагаас хэрэг үүсгэхээс татгалзаж 22 гомдол мэдээлэл шалгах ажиллагааг цагдаагийн байгууллагаас явуулж байх бөгөөд 1 төлбөр төлөгчид эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. (Шийдвэр гүйцэтгэх албаны мэдээ, судалгаа, 2025)

ДҮГНЭЛТ:

Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль, журмын хэрэгжилтийн талаар судлан дараах дүгнэлтэд хүрлээ.

Шүүхийн шийдвэр нь хууль ёсны хүчинтэй, заавал биелэгдэх эрх зүйн акт бөгөөд түүнийг биелүүлэх нь төрийн coercive (албадлагын) шинжийг илэрхийлдэг. Гэвч шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцад зарим этгээд санаатайгаар биелүүлэхээс зайлсхийх, удаашруулах, эсвэл хууль бус арга хэрэглэх зэрэг зөрчил гаргадаг нь нийгмийн шударга ёсны зарчимд сөргөөр нөлөөлдөг. Энэхүү өгүүлэлд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт, түүний онолын болон практикийн асуудлыг судлан шинжилсэн болно.

Судалгааны үр дүнгээр, шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх гэмт хэрэг нь зөвхөн эрх зүйн төдийгүй нийгмийн итгэлцэл, шударга ёсны үнэт зүйлийг алдагдуулж байгааг харуулсан бөгөөд эрх зүйн хариуцлагын механизмыг тодорхой болгох, шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх хэмжээг нарийвчлах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах үр нөлөөтэй арга зүйн шинэчлэл хийх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд “саад учруулах, зайлсхийх” гэмт хэргийг заасан бөгөөд хуулийн хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна гэж үзэж байна.

Тухайлбал, сүүлийн 4 жилийн байдлаар хариуцлага хүлээлгэхээр 253 санал хүргүүлснээс шүүхээс 5 хэргийг хянан шийдвэрлэж эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ. (Я.Батгэрэл, 2024)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хүргүүлсэн нийт саналын маш бага хувийг ханган шийдвэрлэсэн байгаагаас харвал хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

САНАЛ:

Дээрх судалгаа, дүгнэлтдээ үндэслэн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, төлбөр төлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалт, журмын хэрэгжилтийг нэг мөр ханган биелүүлэхэд эрх зүйн орчныг боловсронгуй болгох дараах саналыг гаргаж байна.

1. Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхийг нэмэгдүүлэх буюу эрүүгийн хуулийн 21.7-д заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд шууд прокурор, шүүхэд санал гаргах эрхийг шийдвэр гүйцэтгэгчид олгох нь хэрэгжилтийг хурдасгана.

2. Эрүүгийн хариуцлагыг зөвхөн шийтгэлд бус нөхөн төлүүлэх, эвлэрэл, эвлэрүүлэн зуучлалын элементтэй хослуулах нь илүү үр нөлөөтэй. Энэ нь шийдвэрийг гүйцэтгүүлэх зорилгыг бодитоор биелүүлэх ач холбогдолтой.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
2. Эрүүгийн хууль 2015 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он

Ном гарын авлага:

1. Я.Батгэрэл “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага” Хууль сахиулахуйн докторын зэрэг горилсон бүтээл УБ, 2024 он.

ЦАГДАН ХОРИХ БАЙРАНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА АЛБА ХААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION OF ENSURING THE SAFETY AND SECURITY OF OFFICERS PERFORMING DUTIES IN DETENTION FACILITIES

О.Энхмэнд
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахлах дэслэгч

Enkhmend.O
Senior Lieutenant, Master's Student at the University of Internal Affairs

Товч агуулга: Цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлыг олж илрүүлэхэд энэхүү илтгэлийн гол зорилго оршино.

Abstract: The main purpose of this report is to identify and analyze the issues and challenges associated with ensuring the safety of officers performing their duties within detention facilities.

Түлхүүр үг: алба хаагч, аюулгүй байдал, мэргэжлийн онцлог, эрхийг хамгаалах, эрх зүйн орчин, ажлын байрны нөхцөл

Key words: official, safety, supervisors, professional characteristics, protection of rights, legal framework, working conditions

Аюулгүй байдлын тухай ойлголт

Аюулгүй байдлын ухаан нь хүн, нийгэм, улс төр болон байгаль дэлхийн оршин тогтнох зүй тогтол дахь үнэт зүйлийг хамгаалан хөгжүүлэх шаардлагад хамаардаг бөгөөд аюулгүй байдал судлалыг учирч болох аюул, заналын шинж чанарыг өөрчлөгдөн хувьсаж илүү даяарших шинжтэй болсон өнөөгийн цаг үед аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг бууруулах, арилгах талаар бие даасан өвөрмөц судлагдахуун бүхий судлал болохын зэрэгцээ аюулгүй байдлын судалгааны объект нь улс орны дотоод, гадаад байдал, улс төрийн бодлого, нийгэм, хүрээлэн буй орчин гэж үзэх хандлага түгээмэл байдаг.

Аюулгүй байдлын суурь ухагдахуун нь аливаа салбар шинжлэх ухаантай, түүн дотор хорих байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан судлагдах шаардлагатай. Энэ хүрээнд аюулгүй байдлын тухай ойлголт, үзэл

баримтлалыг эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн онол, байр суурьтай харьцуулан авч үзэх нь онцгой ач холбогдолтой. Учир нь аливаа шинжлэх ухааны онолын үндэс болон судалгааны цар хүрээг уг шинжлэх ухааны үүсэл хөгжил, үндсэн ухагдахуунуудын харилцан уялдаа холбоо, судлаачдын хандлага, үзэл баримтлалаас ангид авч үзэх боломжгүй байдаг. (Ц.Очгэрэл, 2017, хууд. 9)

Хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдал нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцооны үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хоригдлын дэг журам, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, нийгмийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болдог. Хорих байгууллагад ажиллаж буй алба хаагчид өдөр тутам хоригдлуудтай шууд харилцаж, хяналт тавих, хамгаалалтын дэглэмийг хэрэгжүүлэх, хоригдлын зан төлөвийг зохицуулах зэрэг өндөр хариуцлагатай үүргийг гүйцэтгэдэг. Иймээс тэдний хөдөлмөрийн онцлог нь бие бялдар, сэтгэлзүйн ачаалал өндөртэй, эрсдэл бүхий нөхцөлд явагддаг гэж судлаачид үздэг (России, 2016).

Пенитенциарын байгууллагын үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангах нь зөвхөн физик хамгаалалтаар хязгаарлагдахгүй бөгөөд байгууллагын дэглэм, хоригдлын зан төлөвийн хяналт, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, байгууллагын удирдлагын зохион байгуулалт зэрэг олон хүчин зүйлсийн нэгдлээр тодорхойлогддог. Судлаач Ю.М. Антонян хорих байгууллагын аюулгүй байдлыг хоригдлын зан төлөв, нийгмийн орчин, байгууллагын дэг журамтай нягт холбоотой гэж үзсэн бөгөөд эдгээр хүчин зүйлсийг зөв зохицуулснаар алба хаагчдын аюулгүй байдлыг хангах боломжтой гэж тайлбарласан (Криминология, 2012).

Аюулгүй байдлын ойлголт нь улс төр, эрх зүй, нийгмийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг, олон талт агуулгатай ойлголт юм. Судлаачдын үзэж байгаагаар аюулгүй байдал нь хувь хүн, нийгэм, төрийн оршин тогтнох, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангахтай холбоотой нийгмийн чухал үзэгдэл бөгөөд аливаа аюул, заналхийлэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах нөхцөл байдлыг илэрхийлдэг (Buzan, 1991).

Гадаадын судлаачид аюулгүй байдлыг анх улс төр, цэргийн хүрээнд тайлбарлаж байсан боловч орчин үеийн судалгаанд уг ойлголтыг илүү өргөн хүрээнд авч үзэх болсон. Тухайлбал, Уолтер Липпманн аюулгүй

байдлыг “улс орон өөрийн амин чухал ашиг сонирхлоо хамгаалах чадвараа алдахгүй байх, шаардлагатай нөхцөлд тэдгээр ашиг сонирхлоо хамгаалах боломж бүхий байдал” гэж тодорхойлсон байдаг (Lippmann, 1943). Харин Барри Бузан аюулгүй байдлыг улс төр, цэрэг, эдийн засаг, нийгэм, байгаль орчны зэрэг олон хэмжигдэхүүнтэй холбон авч үзэж, аюулгүй байдлыг аюул заналхийлэлгүй оршин тогтнох нөхцөл байдал гэж тайлбарласан байна (Buzan, 1991).

Монголын эрдэмтэд аюулгүй байдлын ойлголтыг үндэсний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдлын хүрээнд тайлбарлах хандлагатай байдаг. Судлаач Б.Чимид аюулгүй байдлыг хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхлыг аливаа аюул заналхийллээс хамгаалж, тогтвортой оршин хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн нийгмийн төлөв байдал хэмээн тодорхойлсон байдаг (Чимид, 2008). Мөн Монголын зарим судлаачид аюулгүй байдлыг нийгмийн тогтвортой байдал, хууль ёсны дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн иж бүрэн тогтолцоо гэж тайлбарласан байна (Галбадрах, 2021).

Ийнхүү гадаад болон Монгол судлаачдын онолын үзэл баримтлалыг харьцуулан үзэхэд аюулгүй байдлын ойлголт нь анх улс төр, цэргийн хүрээнд хязгаарлагдаж байсан бол орчин үед хувь хүн, нийгэм, байгууллагын аюулгүй байдлыг хамарсан өргөн хүрээтэй ойлголт болон хөгжсөн байна. Иймээс аюулгүй байдлыг зөвхөн хамгаалалтын арга хэмжээ төдийгөөр ойлгох бус, харин эрх зүй, удирдлага, нийгмийн орчин, хүний хүчин зүйл зэрэг олон талт хүчин зүйлсийн уялдаа холбоонд тулгуурласан системийн шинжтэй ойлголт гэж үзэх нь зүйтэй.

Монгол улсын цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ) нь төрөөс тодорхойлсон бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий, эрх зүйн үйлчилгээний хэрэгжилтийг зохион байгуулах эрх мэдэлтэй төрийн тусгай байгууллага юм. Энэхүү байгууллага нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд шүүхээс гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тодруулбал, эрүү, иргэн, захиргаа болон бусад холбогдох хэрэг, маргааны талаар шүүхээр

баталгаажсан шийдвэрийг албадан биелүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй зохион байгуулах үүргийг хэрэгжүүлдэг байна. (ШШГТХ, 2017)

Ийнхүү ШШГЕГ нь шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгэмд шударга ёсыг тогтоон хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг төрийн тусгай чиг үүргийн байгууллага юм.

Цагдан хорих байрны аюулгүй байдлын асуудал нь тухайн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал, хууль сахиулах тогтолцооны үр нөлөөтэй шууд холбоотой чухал асуудлын нэг юм. Аюулгүй байдлын тогтолцооны хүрээнд цагдан хорих байрны үндсэн хамгаалагдах объект нь тухайн байгууллагад ажиллаж буй ажилтан, алба хаагчид байдаг бөгөөд тэдний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн мэргэжлийн үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх асуудал төдийгүй хүний эрх, эрх чөлөөний баталгаатай салшгүй уялдаа холбоотой юм. Өөрөөр хэлбэл, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах нь байгууллагын дотоод дэг журам, хэвийн ажиллагааг хангахын зэрэгцээ төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг бодитоор хэрэгжүүлэх нэг чухал механизм болдог.

Хүний аюулгүй байдлыг хангах асуудлыг онолын түвшинд авч үзвэл хүний хувийн орон зай, бие махбодын халдашгүй байдлыг хангах нь аюулгүй байдлын анхдагч бөгөөд бодит хэрэгцээний нэг гэж үздэг. Энэ нь хүний амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх зэрэг суурь эрхийн хэрэгжилтийг хангах үндсэн нөхцөл болдог. Иймээс аливаа байгууллагын аюулгүй байдлын бодлого, зохицуулалт нь эцсийн дүндээ хүний амь нас, эрүүл мэнд, эрх чөлөөг хамгаалах зорилгод чиглэсэн байх шаардлагатай юм.

Ялангуяа төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагад ажиллаж буй алба хаагчдын хувьд албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа эрсдэл, заналхийлэлтэй нүүр тулгарах магадлал харьцангуй өндөр байдаг онцлогтой. Иймд тэдний аюулгүй байдлыг хангах асуудал нь зөвхөн хамгаалалтын арга хэмжээгээр хязгаарлагдахгүй, харин байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого, эрх зүйн зохицуулалт, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоотой уялдсан

цогц асуудал болж байна. Энэ утгаараа алба хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудал нь байгууллагын тогтвортой, үр ашигтай үйл ажиллагааг хангах чухал нөхцөл төдийгүй байгууллагын удирдлагын бодлого, эрх зүйн орчны салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх үндэслэлтэй юм.

Аюулгүй байдлын онолын үүднээс авч үзвэл аливаа салбар, чиглэлийн аюулгүй байдлын тогтолцооны төвд хувь хүн оршдог бөгөөд “аюулгүй байдлын субъект ба объект”-ын харилцаанд хүн төв байр суурийг эзэлдэг зүй тогтолтой гэж судлаачид үздэг. (Хөдөлмөрийн аюулгүй байдал, 2008). Энэ утгаараа аюулгүй байдлын тогтолцоо нь нэг талаас хүнийг хамгаалах зорилготой объект болгон авч үздэг бол нөгөө талаас аюулгүй байдлыг хэрэгжүүлэгч субъектийн хувьд мөн хүний оролцоо зайлшгүй шаардлагатай байдаг. Ийм хоёр талт шинж чанар нь аюулгүй байдлын бодлого, зохицуулалтыг боловсруулахад хүнийг төвд нь тавих шаардлагыг бий болгодог.

Цагдан хорих байрны нөхцөлд энэхүү онолын ойлголт нь бодит практикт тодорхой илэрдэг. Учир нь цагдан хорих байгууллагад ажиллаж буй алба хаагчид нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч зэрэг эрх чөлөөг нь хязгаарласан этгээдүүдтэй өдөр тутам харилцах, тэднийг хяналт, хамгаалалтад байлгах үүргийг хэрэгжүүлдэг. Энэ нь алба хаагчдын хувьд сэтгэл зүй, бие махбодын болон мэргэжлийн эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог. Тиймээс цагдан хорих байрны аюулгүй байдлын бодлого, зохицуулалт нь зөвхөн хорих байрны дотоод дэг журам, өмч хөрөнгө, техник хэрэгслийн хамгаалалтыг хангах асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд хамгийн түрүүнд тухайн байгууллагад ажиллаж буй алба хаагчдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, албан үүргээ аюулгүй орчинд хэрэгжүүлэх нөхцөлийг хангахад чиглэгдэх шаардлагатай байдаг.

Иймд цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах бодлого, зохицуулалтын үндсэн зорилго нь байгууллагын дотоод хяналт, дэг журам, өмч хөрөнгийг хамгаалахтай зэрэгцэн, түүнээс илүүтэйгээр алба хаагчдын амь нас, эрүүл мэнд, нэр төрийг хамгаалах, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг аюулгүй, тогтвортой орчинд хэрэгжүүлэх эрх зүйн болон зохион байгуулалтын баталгааг бүрдүүлэхэд чиглэгдэх нь зүйтэй юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/200 дугаар тушаалаар батлагдсан “Хяналт шалгалт, дотоод аудит, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам”-

д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлж, түүний хүрээнд алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг томьёолон тусгасан байна. Гэвч уг журамд дээрх чиглэлүүдийг практикт хэрхэн хэрэгжүүлэх арга механизм, зохион байгуулалтын бүтэц, хэрэгжилтийг хангах нарийвчилсан аргачлал, зааварчилгаа тодорхой тусгагдаагүй байгаа нь анхаарал татах асуудал юм. Үүнээс шалтгаалан алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд жигд, нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл үүсэх магадлалтай байна. Иймээс дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх бодит механизм, хариуцлагын тогтолцоо, зохион байгуулалтын тодорхой чиглэлүүдийг нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзэж байна. (Хяналт шалгалт, дотоод аудит, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам, 2019)

Хэдийгээр дээрх журамд алба хаагчдын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг ерөнхий байдлаар томьёолон тусгасан боловч түүнийг бодитой хэрэгжүүлэх арга механизм, зохион байгуулалтын нарийвчилсан журам, хэрэгжилтийг хангах практик арга зүй хангалттай тодорхойлогдоогүй байна. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бодлогын чиглэл тодорхойлогдсон хэдий ч түүнийг хэрэгжүүлэх институцийн зохион байгуулалт, хяналт-үнэлгээ, хэрэгжилтийн үе шат, хариуцлагын тогтолцоо зэрэг асуудлууд бүрэн нарийвчлан тусгагдаагүй байна.

Аюулгүй байдлын ойлголт нь алба хаагчдын хувьд зөвхөн шууд хамгаалалт, харуул хамгаалалтын арга хэмжээгээр хязгаарлагдахгүй бөгөөд байгууллагын үйл ажиллагааны олон талт хүрээг хамарсан цогц шинжтэй байдаг. Үүнд байгууллагын ажлын зохион байгуулалт, албан тушаалын тодорхойлолт, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээний мөрдөлт, ажлын ачааллын зохистой хуваарилалт, бүртгэл, судалгаа, мэдээ тайлангийн систем, албан бичиг болон архивын үйл ажиллагаа, иргэд, байгууллага болон алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаа, алба хаагчдын мэргэжлийн сургалт, давтан бэлтгэл, түүнчлэн байгууллагын албаны бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа зэрэг өргөн хүрээний асуудлууд хамаардаг.

Иймд алба хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн нэг чиглэлийн хамгаалалтын арга хэмжээгээр бус, харин байгууллагын

удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого, сургалт, хяналт-шинжилгээ, дотоод сахилга, ёс зүй зэрэг олон хүчин зүйлсийн уялдаа холбоонд тулгуурласан цогц тогтолцооны хүрээнд авч үзэх шаардлагатай юм.

Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй цагдан хорих байруудад нийт 18–55 насны 500 гаруй алба хаагч харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн 90 орчим хувийг хамгаалалтын ажилтнууд эзэлж байна. Энэ нь цагдан хорих байгууллагын үйл ажиллагаанд харуул хамгаалалтын чиг үүрэг голлох байр суурь эзэлж байгааг харуулж байгаа юм. Хорих байгууллагын ажилтан, алба хаагчид нь албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа эдийн засаг, нийгмийн баталгаагаар хангагдахын зэрэгцээ албаны зориулалтын хувцас, шаардлагатай нөхцөлд галт зэвсэг болон тусгай хэрэгслээр хангагддаг нь тэдний албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг.

Гэсэн хэдий ч алба хаагчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн албан үүргээ гүйцэтгэж буй цаг хугацаа, орон зайгаар хязгаарлан ойлгох нь хангалтгүй юм. Учир нь хорих байгууллагын алба хаагч нь мэргэжлийн үйл ажиллагааныхаа онцлогоос шалтгаалан нийгмийн орчинд тодорхой эрсдэл, заналхийлэлд өртөх магадлалтай байдаг. Тухайлбал, олон нийтийн газар, ажилдаа ирэх болон буцах замд, эсхүл албан үүргээс гадуурх нөхцөлд ч тэдний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс үүсэх боломжтой. Иймээс алба хаагчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн байгууллагын хамгаалалтын арга хэмжээний хүрээнд бус, харин алба хаагчийн ажил, амьдралын орчин, нийгмийн харилцаатай уялдуулан цогц байдлаар авч үзэх шаардлага үүсч байна.

Цагдан хорих байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нараас алба хаагчдын аюулгүй байдалд заналхийлэх эрсдэл тодорхой хэмжээнд оршиж байдаг. Тухайлбал:

Тус этгээдүүд нь гэмт үйлдлээ нуун дарагдуулах, өөрсдийн гэмт санаа зорилгыг хэрэгжүүлэх, эсхүл өөрсдийн хань харилцаа бүхий этгээдүүдтэй холбоо тогтоох зорилгоор янз бүрийн хэлбэрийн сөрөг үйл ажиллагаа явуулах тохиолдол практикт ажиглагддаг.

Үүнээс гадна аюул, заналхийллийн гол объект нь хүн өөрөө байдаг бөгөөд эдгээр эрсдэл, заналхийлэл нь ихэвчлэн хүний хүчин зүйлээс

үүдэлтэй байдаг онцлогтой. Иймд алба хаагчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн хамгаалалтын техник хэрэгсэл, харуул хамгаалалтын зохион байгуулалтаар хязгаарлах бус, хүний нөөцийн бодлого, мэргэжлийн бэлтгэл, ёс зүйн төлөвшил, сэтгэл зүйн бэлтгэл, эрсдэлийн удирдлагын тогтолцоотой уялдуулан авч үзэх нь илүү үр нөлөөтэй гэж үзэх үндэслэлтэй байна.

Дээрх үйл ажиллагааны явцад алба хаагчдад дарамт шахалт үзүүлэх, ар гэр рүү заналхийлэх, хууль бус нөлөөлөл үзүүлэх, худал мэдээлэл тараах, хэл амаар доромжлох, зэрэг шууд болон шууд бус хэлбэрийн заналхийлэл үүсэх боломжтой байдаг. Энэ нь алба хаагчдын бие махбодын болон сэтгэл зүйн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна байгууллагын хэвийн үйл ажиллагаа, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллахад эрсдэл учруулах нөхцөлийг бүрдүүлдэг.

Иймд цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн хамгаалалтын арга хэмжээгээр хязгаарлах бус, харин болзошгүй эрсдэл, заналхийллийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалган баримтжуулах зохион байгуулалтын болон эрх зүйн цогц арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Учир нь хорих байгууллагын ажилтнууд өдөр тутмын ажлын хүрээнд хоригдлуудтай шууд харилцаж ажилладаг бөгөөд энэ нь сэтгэлзүйн болон биеийн ачаалал өндөртэй орчинд үйл ажиллагаа явуулахыг шаарддаг онцлогтой. Түүнчлэн тэд нийгмийн эмзэг бүлгийн хүмүүстэй харилцаж, тэдний зан төлөв, сэтгэлзүйн онцлогийг харгалзан ажиллах шаардлагатай байдаг. Иймээс хорих байгууллагын ажилтны хөдөлмөр нь бусад төрийн алба хаагчдын хөдөлмөртэй харьцуулахад илүү төвөгтэй, өндөр хариуцлага шаардсан бөгөөд нийгэм-сэтгэлзүйн хувьд ч өндөр ачаалалтай үйл ажиллагаанд тооцогддог.

Иймээс хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн хамгаалалтын техник хэрэгсэл, физик хамгаалалтын арга хэмжээгээр хязгаарлан ойлгох нь онол, практикийн хувьд хангалтгүй юм. Харин уг асуудал нь байгууллагын дотоод дэглэмийн хэрэгжилт, хоригдлын зан төлөв болон эрсдэлийн хяналт, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэл, түүнчлэн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоо зэрэг олон хүчин зүйлсийн

харилцан уялдаа, системчилсэн нэгдэлд тулгуурлан хэрэгждэг цогц үйл ажиллагаа болох нь тодорхой байна. Иймд хорих байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудлыг байгууллагын үйл ажиллагааны бүхий л түвшинд уялдуулсан, эрсдэлийн удирдлага болон аюулгүй байдлын системийн хандлагад тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарын зүгээс алба хаагч руу халдан довтлох, заналхийлэх, хэл амаар доромжлох зэрэг зөрчил, эрсдэл үүсэх боломж цагдан хорих байрны үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр байдаг тул үүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг байгууллагын аюулгүй байдлын бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх шаардлагатай байна. Үүнтэй холбоотойгоор хоригдлын зан төлөв, сэтгэл зүйн онцлогт тогтмол судалгаа, үнэлгээ хийж эрсдэлтэй этгээдийг урьдчилан илрүүлэх, ангилан байрлуулах зохион байгуулалтыг боловсронгуй болгох, камерын хяналт болон хамгаалалтын техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёл, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, мөн алба хаагчийн нэр төр, албан үүргийн халдашгүй байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бодитой хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх нь алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, байгууллагын дотоод дэг журам, хэвийн үйл ажиллагааг тогтвортой хадгалахад чухал ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь зөвхөн тодорхой нэг чиглэлд хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээгээр хязгаарлагдах ойлголт биш бөгөөд харин эрх зүй, нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн зохион байгуулалт, оюун санаа, эрүүл мэнд зэрэг олон талт хүчин зүйлсийг харилцан уялдаатай авч үзсэн цогц тогтолцоог бүрдүүлэхийг шаарддаг. Өөрөөр хэлбэл, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудал нь зөвхөн физик хамгаалалт, дотоод дэг журмыг сахиулах арга хэмжээгээр хязгаарлагдахгүй, харин эрх зүйн баталгаа, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн хамгаалал, сэтгэлзүйн тогтвортой байдал, эрүүл мэндийн хамгаалалт, байгууллагын удирдлага, зохион байгуулалтын үр нөлөө зэрэг олон хүчин зүйлсийн нэгдэл дээр тулгуурлан хэрэгжих шаардлагатай гэж дүгнэж байна.

Санал

Дээрх дүгнэлтэд тулгуурлан, цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор судалсан судалгаандаа үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

Нэгдүгээрт. Цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй хамгаалалтын ажилтнуудын ажлын ачааллыг бодитой үнэлэх, алба хаагчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын ачааллын жишиг норматив”-ийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний хүрээнд цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй хамгаалалтын ажилтны орон тоог норматив түвшинд хүргэх, шаардлагатай тохиолдолд нэмэгдүүлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх нь зүйтэй.

Хоёрдугаарт. Цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид нь мэргэжлийн онцлогоос шалтгаалан сэтгэл зүйн өндөр ачаалалтай орчинд ажилладаг тул тэдний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, ажлын стрессийг бууруулах зорилгоор мэргэжлийн сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх, алба хаагчдад тогтмол сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Гуравдугаарт. Цагдан хорих байранд хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарт нийгэмшүүлэх болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний эрх зүйн үндсийг боловсронгуй болгох нь зүйтэй. Үүний тулд холбогдох хууль, журамд хоригдолд үзүүлэх нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээний зохицуулалтыг тодорхой тусгах, үйлчилгээ үзүүлэх механизм, хариуцсан мэргэжилтний чиг үүргийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Очгэрэл.Ц, Хорих байгууллагын аюулгүй байдал.- Уб., 2017
2. Хорих байгууллага дахь нийгмийн ажил.-Уб., 2015

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖЛЫГ ҮНЭЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Д.Мөнхбаяр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн 8023 дугаар дамжааны магистрант, хошууч.

D.Munkhayar, aster's student of the 8023th course of Court order enforceent and Strategy, major

Товч агуулга: “Монгол Улсад төрийн удирдлагын шинэчлэлийн хүрээнд бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, тайланг үр дүнд чиглүүлэх алхмууд үе шаттайгаар хийгдэж ирсэн. 2000-2010 онд үр дүнд суурилсан удирдлагын зарчмыг төлөвлөлт, хяналт-шинжилгээнд нэвтрүүлэх эхлэл тавигдсан бол 2011 оноос гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлж, байгууллагын төлөвлөгөө, тайланг үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулахад анхаарч ирсэн. Харин 2020 оноос үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлагыг төсөвт байгууллагуудад хэрэгжүүлж эхэлсэн нь төрийн үйлчилгээний байгууллагын гүйцэтгэлийг шинэ шатанд гаргах бодлогын чухал алхам болсон” (Г.Жаргал & Н.Сэлэнгэ, 2026).

Гүйцэтгэлийн удирдлага нь хүртээмж, чанар, үр дүн, үр ашиг, үр өгөөж, хэрэглэгчийн сэтгэл ханамж зэрэг хэмжүүрээр үнэлж, "их ажил хийхэд бус", харин "үр дүнтэй ажиллахад" чиглэсэн хандлага, соёлыг байгууллага, хамт олонд төлөвшүүлдэг. Иймээс гүйцэтгэлийн удирдлага нь байгууллагын үйл ажиллагааг үр дүнд чиглүүлэн удирдах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, тасралтгүй сайжруулах боломжийг олгодог менежментийн арга юм. Энэ утгаараа гүйцэтгэл, хэмжилтийг үндсэн хэрэгсэл болгодог.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлж чадсан эсэх, шийдвэр гүйцэтгэгчийн өдөр тутмын ажлыг хэмжих, үнэлэх эрх зүйн орчныг оновчтой бүрдүүлсэн эсэх талаар судлан, тулгамдсан асуудлыг тодорхойлох, дүгнэлт-санал дэвшүүлэхэд энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Abstract: Under the framework of public administration reform in Mongolia, steps to align policy formulation, planning, implementation, and reporting with results have been implemented progressively, with the period from 2000 to 2010 marking the initial introduction of results-based management principles into planning and monitoring processes. From 2011 onwards, the focus

shifted to developing a performance management system that links organizational plans and reports to outcome indicators, and since 2020, the implementation of results-based performance management in budgetary organizations has represented a significant policy step toward enhancing the performance of public service institutions.

Performance management establishes an organizational and team culture oriented not toward mere "volume of work" but toward "effective achievement of results," by systematically assessing performance across dimensions such as accessibility, quality, outcomes, efficiency, effectiveness, and stakeholder satisfaction. Within this framework, performance management functions as a comprehensive managerial approach that aligns organizational activities with strategic objectives, facilitates evidence-based decision-making, and enables continuous improvement, positioning performance measurement as its core analytical and operational tool.

The purpose of this research is to examine whether the court enforcement agency has been able to effectively implement a performance management system and whether the legal environment for measuring and evaluating the daily work of the enforcement agency has been optimally created, identify pressing issues, and make conclusions and suggestions.

Түлхүүр үг: Гүйцэтгэлийн удирдлага, гүйцэтгэлийн үнэлгээ, шалгуур үзүүлэлт, үр дүн, үр нөлөө, ахиц дэвшил

Keywords: Performance management, performance evaluation, indicators, results, impact, and progress

УДИРТГАЛ

Төрийн байгууллагуудын өмнө нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажил, үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, чанарыг тасралтгүй сайжруулах, үр дүн болон үр нөлөөг бодитойгоор нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй, хариуцлагатайгаар хэрэгжүүлэх олон талт шаардлага тавигдаж байна. Энэхүү шаардлага нь зөвхөн үйлчилгээний цар хүрээ, чанарын үзүүлэлтээр хязгаарлагдахгүй, харин байгууллагын засаглал, шийдвэр гаргалт, нөөцийн оновчтой хуваарилалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүхэлд нь хамарсан цогц шинжтэй юм. Ийм нөхцөлд дээрх шаардлагыг үр дүнтэйгээр хангаж, тулгарч буй олон талт сорилтыг амжилттай даван

туулахын тулд гүйцэтгэлийг тодорхой шалгуур, хэмжүүрт тулгуурлан үнэлж, тасралтгүй сайжруулалтыг дэмжих үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ урган гарч байна.

"Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогод төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэх, байгууллагын гүйцэтгэлийг хариуцлагатай уялдуулах зорилтыг тусгасан нь үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн" (Г.Жаргал & Н.Сэлэнгэ, 2026).

Гүйцэтгэл нь байгууллага, нэгж, хувь хүн тодорхой хугацаанд төлөвлөсөн зорилго, зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүн, ахиц дэвшлийг илэрхийлдэг ойлголт юм. Товчоор бол, гүйцэтгэл нь байгууллагын зорилгын биелэлтийг их бага ажил хийснээр бус, харин үр дүн, амжилтаар нь хэмжих, үнэлэх үзэл санаа юм (Г.Жаргал & Н.Сэлэнгэ, 2026).

Хэмжилт нь байгууллагын гүйцэтгэлийн динамик байдлыг онолын болон арга зүйн үндэстэйгээр тоон болон чанарын үзүүлэлтээр тогтмол үнэлэх, үр дүнгийн ахиц, стратегийн зорилтын хэрэгжилтийг баримт, нотолгоонд тулгуурлан тогтоох системчилсэн процесс бөгөөд зөвхөн тайлагнах хэрэгцээнд бус, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг аналитик түвшинд үнэлж, гүйцэтгэлийн логик дараалал болох гарц →үр дүн→үр нөлөө үзүүлэлтээр тооцох боломжийг бүрдүүлдэг. Гүйцэтгэлийн хэмжилт хийхгүйгээр байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр өгөөжийг үнэн зөв үнэлэх боломж хязгаарлагдахаас гадна удирдлагын шийдвэр гаргалтыг мэдээллээр хангах нотолгоонд суурилсан суурь өгөгдөл боловсруулж чадахгүй эрсдэлтэй юм.

Гарц нь байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны шууд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ; Үр дүн нь гарцаас бий болсон бодит өөрчлөлт; Үр нөлөө нь уг өөрчлөлтөөс урт хугацаанд үүсэх өргөн хүрээний тогтвортой ач холбогдлыг илэрхийлдэг (Г.Жаргал & Н.Сэлэнгэ, 2026).

Гүйцэтгэлийн удирдлага (Performance Management) нь байгууллага стратегийн зорилгодоо хүрэхийн тулд гүйцэтгэлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэмжих, үнэлэх, сайжруулах менежментийн арга юм. Байгууллагын стратеги, үйл ажиллагааг зорилготой уялдуулан зохион

байгуулах, үр дүнд хүрэх явцыг тасралтгүй хянах, улмаар хэрэгжилтийг сайжруулах боломжийг бүрдүүлдэг гүйцэтгэлийн удирдлагын арга (Bush, 2011) боловсронгуй болсоор байна. Энэ арга нь стратеги, үйл ажиллагаа, хүний нөөц болон бусад нөөц, гарц, үр дүнг нэг системд уялдуулж, зорилгод хүрэх явцыг тогтмол хянах, үнэлэх, сайжруулахад тусалдаг (Armstrong, 2014).

Гүйцэтгэлийн удирдлага нь Зорилго →Шалгуур үзүүлэлт (KPI) →Үйл ажиллагаа →Хэмжилт →Үнэлгээ →Шийдвэр →Сайжруулалт гэсэн дарааллаар хэрэгждэг.

Гүйцэтгэлийн удирдлага нь байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг хэмжих, үнэлснээр бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, үр дүн, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх, сайжруулах арга, хэрэгсэл болдог (Poister, 2003). Энэ нь байгууллагын нөөцийг (хүн, санхүү, цаг хугацаа, мэдээлэл, технологи) стратегийн зорилттой уялдуулан оновчтой хэрэглэх, стратегийг өдөр тутмын үйл ажиллагаатай холбох, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, үнэлгээний үр дүнг шийдвэр гаргах, урамшуулал, бодлого тодорхойлоход хэрэглэх боломжийг бүрдүүлдэг (OECD, 2010).

Гүйцэтгэл нь зорилгодоо хүрсэн бодит үр дүнг илэрхийлдэг бол хэмжилт нь тухайн үр дүнг чанар, тоон үзүүлэлтээр нотлон тодорхойлох үйл явц юм.

Гүйцэтгэлийн удирдлага нь байгууллагын зорилгыг бодит үр дүнд хүргэхийн тулд үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хэмжих, үнэлэх, тасралтгүй сайжруулах арга, хэрэгсэл юм. Эдгээр нь байгууллагын ажил, үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд тусалдаг,

Шийдвэр гүйцэтгэгчийн ажлыг үнэлэх эрх зүйн зохицуулалт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/227 тоот тушаалаар батлагдсан “Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал”-ын хүрээнд хэрэгжиж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Ажил нь байгууллагын үйл ажиллагаа, процессын системийн нэгж бөгөөд гүйцэтгэл нь уг үйл ажиллагаа стратегийн зорилт, төлөвлөгдсөн үр дүнг хэр хэмжээнд биелүүлснийг тоон болон чанарын үзүүлэлтээр системтэйгээр үнэлэх аналитик арга, харьцуулалтын суурь үзүүлэлт болж,

түүнд хэмжилт, гарц, үр дүн, үр нөлөө зэрэг гүйцэтгэлийн удирдлагын суурь ойлголтууд онолын болон арга зүйн үндэслэлээр нэгтгэгддэг.

Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлага нь байгууллагын зорилго, үйл ажиллагаа, гарц, үр дүн, үр нөлөөний уялдаа холбоог тодорхойлж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурлан хэрэгжилтийг хянах, үнэлэх, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах боломж бүрдүүлдэг менежментийн арга юм. Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг бодитоор хэмжих, практикт тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг шийдвэрлэх, улмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг сайжруулах чухал ач холбогдолтой.

Гүйцэтгэл нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тоон ба чанарын үзүүлэлтэд тулгуурлан системчилсэн, шинжлэх ухааны аргаар хэмжиж, үнэлэх онол-арга зүйн үндсийг бүрдүүлдэг бөгөөд стратегийн зорилго, зорилтын хэрэгжилтийг бодитой, нотолгоонд суурилсан байдлаар тодорхойлох боломжийг олгож, үүний хүрээнд аливаа ажил, үйлчилгээ, үйл ажиллагааг үнэлэхэд ашиглагдах үзүүлэлт нь чанарын шалгуур, үнэлгээний хэмжүүрийн онол-арга зүйн суурь үзүүлэлт болж, байгууллагын гүйцэтгэлийн удирдлагын практик, стратегийн шийдвэр гаргалтыг аналитик түвшинд дэмждэг.

Байгууллагууд стратегийн менежментийг сайжруулах арга замыг эрж хайсаар байна. Энэ нь байгууллагын эрхэм зорилго, хүрэх зорилго, зорилтууд, гадаад орчинд зохицох арга замууд, давуу болон сул талууд, боломж, аюул заналыг тодорхойлно гэсэн үг (Овен Хьюс, 2017).

Аливаа ажил, үйлчилгээ, үйл ажиллагааг үнэлэхэд түүнийг илэрхийлэх үзүүлэлтийг хэрэглэдэг. Үзүүлэлт нь "Юуг сайн гэж үзэх вэ?" гэсэн үнэлгээний хэмжүүр, шалгуур буюу чанарын шаардлагын суурь ойлголт юм.

Гүйцэтгэлийн үзүүлэлт гэж байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих ердийн чанар, тоон үзүүлэлтийг хэлнэ. Энэ нь байгууллагын орц, үйл явц, гарц, үр дүн, үр нөлөө, үр ашиг, чанар зэрэг хэмжүүрийг хамарсан өргөн ойлголт юм.

Эдгээрээс байгууллагын стратегийн зорилгод хамгийн чухал ач холбогдолтой цөөн үзүүлэлтийг сонгон хэрэглэдэг. Үүнийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт гэнэ. Энэ нь байгууллагын стратегийн зорилгод хамгийн

чухал нөлөөтэй, амжилтыг тодорхойлох гол "түлхүүр" үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс хамгийн чухлыг сонгосон нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бөгөөд байгууллага амжилттай ажиллаж байгааг харуулах нэн чухал хэмжигдэхүүн гэж үзэж болно.

Аливаа үзүүлэлт нь үнэлгээ хийх үндсэн шаардлага, жишиг хэмжүүрийг илэрхийлдэг. Гүйцэтгэлийн үзүүлэлт (PI) нь байгууллагын үйл ажиллагааны явц, хэрэгжилтийн түвшнийг хэмжих үзүүлэлт бол Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI) нь байгууллагын стратегийн зорилгод хүрэх амжилтыг илэрхийлэх хамгийн чухал түлхүүр үзүүлэлт юм (Г.Жаргал & Н.Сэлэнгэ, 2026). Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт гэдэг нь байгууллагаа тодорхой хэсэгт хэр зэрэг ажиллаж байгааг хянах, боломжит сайжруулалтыг олж тогтоох системээр менежерийг хангадаг (Д.Баярхүүгийн орчуулга, 2021) .

Хэрвээ байгууллагын доторх нөхцөл байдлыг шинжлэх явцад гарч ирсэн алдаа ба асуудлуудыг цаг хугацаанд нь засаж залруулахгүй юм бол гадаад орчны нөхцөл ба хүний үйл хөдлөлийн ирээдүйн үнэлгээний алдаануудтай давхцаж хямралт байдал үүсэхэд хүргэнэ. Хяналтын функц нь асуудлыг илрүүлэх ба эдгээр асуудлуудыг хямрал болж даамжрахын өмнө байгууллагын үйл ажиллагааны хамт засаж залруулах боломж олгодог удирдлагын хүчин зүйл юм (Д.Болормаа, 2008).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага “Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал”-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү эрх зүйн баримт бичгийн үндсэн зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас тухайн жилд дэвшүүлсэн стратегийн зорилт, чиглэлийн хэрэгжилтийг байгууллагын албан хаагчдын түвшинд үнэлэхэд оршино. Тодруулбал, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил, үүргийг ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгч нар хэрхэн хэрэгжүүлж байгааг бодитой, шалгуурт суурилсан байдлаар дүгнэхэд чиглэнэ. Энэ хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн аргачлалыг ашиглан ажлын үр дүн, чанар, үр ашгийг хэмжих боломжийг бүрдүүлжээ. Мөн үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, байгууллагын үйл ажиллагааны ерөнхий гүйцэтгэлийг тодорхойлох, цаашдын бодлого, төлөвлөлтөд ашиглах суурь мэдээллийг бий болгох зэрэг өндөр ач холбогдолтой. Энэ аргачлал нь байгууллагын дотоод хяналт-шинжилгээ,

гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн онол, практикийн ач холбогдол бүхий баримт бичиг гэж үзэж болно.

Шийдвэр гүйцэтгэх алба нь ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ батлагдсан шалгуур үзүүлэлт, аргачлалыг үндэслэн хагас болон бүтэн жилийн гүйцэтгэлийг системтэйгээр нэгтгэн дүгнэж байна. Энэхүү үнэлгээ нь албан хаагчдын ажлын үр дүнг бодитой, хэмжигдэхүйц байдлаар үнэлэх, ажилд хариуцлагатай хандуулах, цаашлаад шагнал урамшуулал олгох, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн удирдлагын хэрэгсэл болж өгдөг.

Үнэлгээний үйл явцын хэрэгцээт мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа хэлтэс нь тухайн жилийн 6 дугаар сар болон 12 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар байдлаар шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлдэг. Энэ нь ажлын үр дүнг системтэй бүртгэх, дүн шинжилгээ хийх, удирдлагын шийдвэр гаргалт болон хүний нөөцийн менежментэд ашиглах боломжийг бүрдүүлдэг.

Энэ аргачлал нь байгууллагын дотоод хяналт, гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, ил тод, шударга үнэлгээний зарчимд нийцсэн байдлаар албан хаагчдын ажлын үр ашгийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн энэхүү зохицуулалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтээмж, үр ашиг, мэргэжлийн стандартыг тогтмол сайжруулахад үндсэн суурь болж өгдөг.

Мөн аргачлал нь ажлын гүйцэтгэлийг системтэй хянах, үнэлэх, дүгнэлт гаргах үйл явцыг оновчтой болгох төдийгүй байгууллагын бүтээмж, үр ашиг, хүний нөөцийн менежментийн үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ. Ийнхүү дотоод хяналт, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох энэхүү зохицуулалт нь байгууллагын үйл ажиллагаанд ил тод байдал, шударга ёсны зарчмыг хангах, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд үндсэн суурь болж өгдөг байна..

Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн ажлыг үнэлэх явцад тухайн албан хаагчийн гүйцэтгэж буй чиг үүргийн онцлог, албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн шалгуур үзүүлэлт бүрд оноо олгож, тус бүрийн үнэлгээг системтэйгээр бодно. Улмаар авсан оноог тухайн шалгуур үзүүлэлтийн дээд үнэлгээ буюу нийт онооны 100 хувиар

харьцуулан тооцох замаар гүйцэтгэлийн үнэлгээг нарийвчлан тогтоодог. Энэ аргачлал нь үнэлгээг ил тод, бодитой, албан тушаалын үүрэг, шаардлагад нийцсэн байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг төдийгүй албан хаагчдын гүйцэтгэл, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх менежментийн чухал хэрэгсэл болдог байна.

Ажлыг гүйцэтгэлийг үнэлэхдээ ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч гэж ангилан төрөл тус бүрээр авсан онооны дарааллаар байр эзлүүлэн дүгнэж хэвшжээ. Тухайлбал:

Ахлах шийдвэр гүйцэтгэгчдийн ажлыг дараах аргачлалын дагуу дүгнэж, сахилгын шийтгэлтэй бол авбал зохих нийлбэр дүнгээс 5 оноо хасна (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрий А/227 тоот тушаал, 2019).

Хүснэгт 1. Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлт (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрий А/227 тоот тушаал, 2019)

д/д	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт нь улсын дундаж үзүүлэлтээс буураагүй бол	15 оноо нэмэх
	Орон нутагт дундаж үзүүлэлтээс давсан 10 хувь тутамд	1 оноо буюу нийт 5 хүртэл оноо нэмэх
	Нийслэл дэх нэгжид 5 хувь тутам	
	Дундаж үзүүлэлтийг бууруулсан 1.0 хувь тутам	0.5 оноо хасах
2	Тухайн нэгжийн сүүлийн 3 жилийн дундаж үзүүлэлтээс гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт буураагүй бол	10 оноо нэмэх
	Орон нутаг дахь нэгжид бууруулсан 1.0 хувь тутам	1 оноо хасах
	Нийслэл дэх нэгжид бууруулсан 1.0 хувь тутам	0.5 оноо хасах
3	Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг бүрэн хангасан бол	10 оноо нэмэх
	Зөрчил шалган шийдвэрлэсэн бол	5 оноо нэмэх
	Энэ заалт нь зөрчил шалган шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тоотой нэгжийн ахлах шийдвэр гүйцэтгэгчид хамаарахгүй. Уг шалгуур үзүүлэлтийн оноог аргачлалын 6-д заасан 15 оноо дээр нэмж тооцно.	
4	Хариуцсан шийдвэр гүйцэтгэгчдээс явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн	20 оноо нэмэх

	шийдвэрийг шүүх болон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүчингүйд тооцоогүй бол	
	3-аас доош удаа хүчингүйд тооцогдсон бол	5 оноо нэмэх
	3-аас дээш удаа хүчингүйд тооцогдсон шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүрд	1 оноо хасах
5	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээ, судалгааг бодитой нэгтгэн боловсруулсан, хугацаа хоцроогүй, гүйцэтгэх баримт бичгийн цахим санд өргөдлийн бүртгэл хөтөлсөн, алдаагүй мэдээлэл оруулсан бол	20 оноо нэмэх
	Зөрчил гаргасан тохиолдол бүрд	0.5 оноо хасах
6	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан гаргасан нийт өргөдөл, гомдол үндэслэлгүй, ёс зүйн зөрчил гаргаагүй, хуулийн хугацаанд өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн бол	15 оноо нэмэх
	Үндэслэл бүхий өргөдөл, гомдол тутамд	0.2 оноо хасах

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгчийн ажлыг дараах аргачлалын дагуу дүгнэх ба сахилгын шийтгэлтэй бол авбал зохих нийлбэр дүнгээс 5 оноо хасах бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үзүүлэлтийн нийлбэр оноо нь улсын хэмжээнд байр эзлүүлэх шалгуур үзүүлэлт болно.

Хүснэгт 2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлт (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрий А/227 тоот тушаал, 2019)

д/д	**Шалгуур үзүүлэлт**	**Оноо**
1	зөрчлийн талаар хүлээн авсан нийт гомдол, мэдээллийг бүрэн шалгаж, шийтгэлийн хуудасны биелэлтийг хангасан бол шалган шийдвэрлэсэн хэргийн шийдвэрлэлтийг нийт оноонд харьцуулан хувилж тооцох;	80 оноо нэмэх
2	чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зөрчлийн үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан бол	5 оноо нэмэх
3	хариуцсан дүүргийн шүүхээр баталгаажуулсан зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт нь улсын дундаж үзүүлэлтээс буураагүй бол	15 оноо нэмэх
	бууруулсан 1.0 хувь тутам	2 оноо хасах

Шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын үзүүлэлтийг дараах аргачлалын дагуу дүгнэх ба сахилгын шийтгэлтэй бол авбал зохих нийлбэр дүнгээс 5 оноо хасна.

Хүснэгт 3. Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлт (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрий А/227 тоот тушаал, 2019)

д/д	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт улсын дундаж үзүүлэлтээс бууруулаагүй бол	15 оноо нэмэх
	нийслэл дэх нэгжид дундаж үзүүлэлтээс хүртэл давсан 5 хувь тутам 1 оноо буюу нийт 5	5 оноо нэмэх
	орон нутаг дахь нэгжид дундаж үзүүлэлтээс хүртэл давсан 10 хувь тутамд 1 оноо,	10 оноо нэмэх
	бууруулсан 1.0 хувь тутам	0.5 оноо хасах
2	хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичгийн 70 хувьд хуримтлагдсан төлбөр үүсээгүй бол 10 оноо,	10 оноо нэмэх
	50 хувийн гүйцэтгэлтэй бол	7 оноо нэмэх
	50-аас доош бол	5 оноо нэмэх
	Хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичигт хамаарах шалгуур үзүүлэлт нь нийслэл дэх нэгжийн шийдвэр гүйцэтгэгчид хамаарахгүй ба уг үзүүлэлтийн оноог аргачлалын 7-д заасан дээр нэмж тооцно.	15 оноо нэмэх
3	төлбөртэй хоригдолд холбогдох гүйцэтгэх баримт бичгийн биелэлтийн хувиас хувилж тооцох,	10 оноо нэмэх
4	гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүчингүйд тооцогдоогүй бол	15 оноо нэмэх
	3-аас доош удаа хүчингүйд тооцогдсон бол	5 оноо нэмэх
	3-аас дээш удаа хүчингүйд тооцогдсон шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүрд	1 оноо хасах
5	төсөвт төвлөрүүлэх гүйцэтгэх баримт бичгийн биелэлтийн хувиас хувилж тооцох	10 оноо нэмэх
6	шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээ, судалгааг бодитой боловсруулсан, талуудад цахим хэлбэрээр мэдээлэл хүргэсэн, цахим сангийн баяжилтыг тухай бүр хийсэн бол	20 оноо нэмэх
	зөрчил гаргасан тохиолдол бүрд	1 оноо хасах
7	шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан гаргасан нийт өргөдөл, гомдол үндэслэлгүй, ёс зүйн зөрчил гаргаагүй бол	15 оноо нэмэх
	үндэслэл бүхий өргөдөл, гомдол тутамд	0.2 оноо хасах

Ажлын үзүүлэлтийг нэгтгэн дүгнэх

Тухайн бүсийг хариуцсан ахлах мэргэжилтнүүд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын үзүүлэлтийг урьдчилсан байдлаар нэгтгэн шинжилж, үнэлгээ тооцох санал боловсруулан танилцуулдаг. Уг саналыг

Шийдвэр гүйцэтгэх албаны даргын зөвлөлийн хуралдаанд ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч тус бүрээр системтэйгээр хэлэлцэж, эцсийн дүгнэлт, шийдвэрийг баталгаажуулдаг. Энэхүү үйл явц нь үнэлгээг ил тод, бодитой, байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, менежментийн шаардлагад нийцсэн байдлаар хэрэгжүүлэх, албан хаагчдын гүйцэтгэл, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Ажлын үзүүлэлтийг нэгтгэн дүгнэхэд ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд шалгуур үзүүлэлтийн эхний үзүүлэлтийн оноог харгалзана. Уг оноо нь байр эзлүүлэх дараалал тогтоохгүй бол дараагийн шалгуур, үзүүлэлт тус бүрийн оноог үндэслэнэ.

Нийлбэр оноог үндэслэн улсын болон тухайн бүсийн хэмжээнд тус тус байр эзлүүлэх ба дараах үнэлгээ тооцож, ажлын үзүүлэлтийг нэгтгэн дүгнэж, дүнг баталгаажуулна.

Хүснэгт 4. Ажлын үр дүнг нэгтгэн дүгнэх үнэлгээ, оноо (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрий А/227 тоот тушаал, 2019)

д/д	Үнэлгээ	Оноо
1	Бүрэн хангалттай	90-100 оноо
2	Хангалттай	60-89 оноо
3	Хангалтгүй	59-өөс доош оноо

Ажлын үзүүлэлтийн үнэлгээ тооцох

Шийдвэр гүйцэтгэх алба нь ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийг ажлын үзүүлэлт, улсын болон тухайн бүсийн хэмжээнд эзэлсэн байр, онооны дарааллыг үндэслэн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ажлын үзүүлэлтийг нэгдсэн дүнг тухайн жилд багтаан Шийдвэр гүйцэтгэх алба нийт ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдэд ил тод, нээлттэй мэдээлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулна.

Ажлын шалгуур үзүүлэлт, онооны дүнгээр улсын хэмжээнд эхний 10 хүртэл байр эзэлсэн бол "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оны тэргүүний алба хаагч шалгаруулах журам" болон "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд шагнал, урамшуулал олгох журам"-д заасан шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн шагнал, урамшуулал олгох санал шийдвэрлүүлэх бөгөөд ажлын үзүүлэлт, онооны дарааллаар улсын

хэмжээнд эхний 20 хүртэл байр эзэлсэн боловч ажилласан жил нь шагнал, урамшуулал олгох болзол, шаардлагыг хангаагүй эсхүл тухайн бүсийн хэмжээнд эхний 10 байр эзэлсэн бол тухайн харьяа нэгжийн шагнал, урамшууллаар шагнуулна.

Энэхүү аргачлал нь үнэлгээний үр дүнг ил тод, бодитой болгож, байгууллагын дотоод хяналт, менежментийн тогтолцоонд нийцсэн, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Хэрвээ албан хаагч сүүлийн гурван жил дараалан ажлын үзүүлэлтээр “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан бол “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам” (ШШГБ-ын алба хаагчийг дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх журам, 2018)-ын 2.1-д заасан зохицуулалтад нийцүүлэн тухайн албан хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилуулах санал боловсруулж, шийдвэрлүүлэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлнэ. Энэхүү журам нь албан хаагчийн ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоог ил тод, системтэй хэрэгжүүлэх замаар мэргэжлийн ур чадвар, ажиллах идэвх, бүтээмжийг тасралтгүй дээшлүүлэх, албан хаагчийн мэргэшил, карьерын дэвшлийг дэмжих чухал механизм болдог байна.

Ажлын үзүүлэлтээр улсын хэмжээнд ахлах шийдвэр гүйцэтгэгч нь сүүлийн 5 байр, шийдвэр гүйцэтгэгч нь сүүлийн 20 хүртэл байр эзэлсэн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017)-ийн 281 дүгээр зүйлийн 281.1-д заасан сахилгын шийтгэл оногдуулах санал шийдвэрлүүлэхээр зохицуулна. Энэ зохицуулалт нь гүйцэтгэлд суурилсан сахилгын тогтолцоог ил тод, системтэй байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Тухайн жилийн ажлын үзүүлэлтээр "Хангалтгүй" үнэлгээ авсан бол журам (ШШГБ-ын алба хаагчийг дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх журам, 2018)-д заасны дагуу шилжүүлэн томилох, албан тушаал бууруулах санал шийдвэрлүүлэх арга хэмжээг авна. Энэ нь албан хаагчдын гүйцэтгэл, хариуцлагад суурилсан удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, мэргэжлийн ур чадвар, ажлын үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх боломжийг хангадаг гэж үзэж болно.

ДҮГНЭЛТ

Ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагаа нь ил тод байдал, шударга ёсны зарчимд нийцсэн байх шаардлагад тулгуурлан хэрэгжих ёстой. Энэ хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээг бодит шалгуур, хэмжүүрт үндэслэн хийж, ажлын үр дүнг оновчтой дүгнэх арга зүйг ашиглажээ. Үнэлгээний үр дүнг үндэслэн ажлын гүйцэтгэлд суурилсан шагнал, урамшууллыг олгох, мөн шаардлагатай тохиолдолд хариуцлагын арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн уг аргачлал нь албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшлийн түвшнийг дээшлүүлэхэд чиглэсэн удирдлагын хэрэгсэл юм. Энэхүү аргачлалыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлэх нь гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох чухал ач холбогдолтой.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үзүүлэлтийг алба хаагч тус бүрээр батлагдсан маягт, тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу нэгтгэн дүгнэдэг бөгөөд нийт онооны дүнгээр албан хаагчийн байр эзлүүлж байна. Шийдвэр гүйцэтгэх тойрог бүрийн бодит биелэлтийн хувь үзүүлэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын үр дүнг сар бүр нэгтгэн бүртгэж, төвлөрсөн мэдээллийн санг бүрдүүлэх замаар гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж байна.

Хэдийгээр ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгч нарын гүйцэтгэлийг хэмжин үнэлж, үр дүнг тооцон сайн ажилласан алба хаагчдадаа шагнал урамшуулал олгох болон тааруухан ажилласан алба хаагчдадаа хариуцлага хүлээлгэх тогтолцоог эрх зүйн зохицуулалтад тусгаж өгсөн боловч шийдвэр гүйцэтгэгч нарын үйл ажиллагаа явуулж байгаа тойргийн ажлын ачаалал харилцан адилгүй байдгийг тооцоогүй нь сул тал болжээ.

САНАЛ-ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүгнэлтэд тулгуурлан шийдвэр гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоог боловсронгуй болгохын тулд бодлогын болон арга зүйн түвшинд системийн шинжтэй, уялдаа холбоо бүхий цогц шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд нэн тэргүүнд гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц, шалгагдахуйц, олон талт (тоон ба чанарын) байдлаар боловсруулж, ажлын ачаалал, эрсдэл,

хэрэг шийдвэрлэлтийн онцлогийг иж бүрэн тусгасан нэгдсэн, стандартчилсан аргачлалыг нэвтрүүлэх нь зүйтэй.

Үүний зэрэгцээ гүйцэтгэлийн үнэлгээний үйл явцыг ил тод, хөндлөнгийн хяналт бүхий, нотолгоонд суурилсан тогтолцоонд шилжүүлж, үнэлгээний үр дүнг хүний нөөцийн бодлого болон сахилгын хариуцлагын механизмтай институцийн түвшинд уялдуулахын зэрэгцээ хүний эрхийн шалгуур, чанарын үнэлгээний бүрэлдэхүүнийг системтэйгээр шингээх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль ёсны байдал, шударга ёсны баталгааг хангах үндсэн нөхцөл болно.

Цаашид гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог өгөгдөл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, тасралтгүй сайжруулалтын мөчлөгийг хэрэгжүүлэх зарчимд нийцүүлэн хөгжүүлж, байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлагналын нэгдмэл уялдааг хангах нь шүүхийн шийдвэрийн биелэлтийг тогтвортойгоор дээшлүүлэхийн зэрэгцээ байгууллагын үр ашиг, хариуцлага, ил тод байдлыг институцийн түвшинд бэхжүүлэх стратегийн ач холбогдолтой юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Armstrong, M. (2014). Armstrong's handbook of performance management.

Bush, T. (2011). Theories of educational leadership and management.

OECD. (2010). Results-Based Management in Development Cooperation.

Poister, T. (2003). Measuring Performance in Public and Nonprofit Organizations. Jossey-Bass.

Г.Жаргал, & Н.Сэлэнгэ. (2026). Гүйцэтгэлийн удирдлага. Улаанбаатар.

Д.Баярхүүгийн орчуулга. (2021). Менежмент хэрхэн хийх вэ.

Д.Болормаа. (2008). Менежмент.

Овен Хьюс. (2017). Улсын салбарын менежмент ба төрийн захиргаа. Төрийн захиргаа засаглал.

Т.Дорж, Ү.Чимэд. (2000). Менежмент. Улаанбаатар.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрий А/227 тоот тушаал. (2019). Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал.

СОНСОГЧ СУРАЛЦАГЧ ШИНЭ УХАГДАХУУНЫГ ХЭРХЭН ОЙЛГОЖ БАЙГААГ СУДАЛСАН СУДАЛГАА ҮР ДҮН

FINDINGS OF A STUDY EXAMINING TRAINEES' AND STUDENTS' UNDERSTANDING OF NEWLY INTRODUCED CONCEPTS

О.Должинсүрэн

ҮБХИС-ийн цэргийн хөгжмийн политехник коллежийн ерөнхий эрдмийн тэнхимийн багш

O. Doljinsuren

Lecturer at the General Academic Department, Military Music Polytechnic College, University of Defense of Mongolia

Хураангуй: ЦХПК-ийн суралцагчид шинэ ухагдахууныг хэрхэн ойлгож байгааг асуулгын аргаар судалж илрүүлэхэд анхаарлаа хандууллаа. Судалгаанд оролцогчийн 46,4% нь шинэ ухагдахууныг маш сайн ба сайн ойлгодог гэж үзжээ. Суралцагчид шинэ мэдээллийг дахин тайлбарлаж ярих үедээ болон шинэ мэдээллийг бусадтай ярилцаж байхдаа хамгийн сайн ойлгодог байна. Тэд нойр муутай, ядарсан, оюуны ачаалалтай, ааш муутай үедээ ойлгодоггүй эсвэл ойлгохыг хүсдэггүй байна. Мөн багшийн аргазүй тааруу үед ойлгодоггүй /35%/, ойлгохыг хүсдэггүй /25%/ байна.

Abstract: This study focused on identifying how students of the Military Music Polytechnic College understand new concepts using a questionnaire-based approach. The findings indicate that 46.4% of the respondents reported that they understand new concepts very well or well. Students tend to understand new information most effectively when they are able to explain it in their own words and when they discuss it with others. However, they reported difficulties in understanding, or a lack of willingness to understand, when they are sleep-deprived, fatigued, mentally overloaded, or in a negative emotional state. In addition, when the teacher's instructional methodology is ineffective, 35% of students reported not understanding, while 25% indicated a lack of willingness to understand the material.

Түлхүүр үг: мэдлэг, ойлголт, ухагдахуун, сурах үйлүүд

Keywords: knowledge, comprehension, conceptual understanding, learning processes

Оршил: Суралцагч шинэ ухагдахууныг хэрхэн ойлгодгийг судалж үр дүнг тодорхойлох зорилго тавилаа. Судалгаагаа 18 бодомжийн хүрээнд боловсруулсан бөгөөд ЦХПК-ийн хөгжим 1,2,3,4 ангийн сурагчдаас Google forms болон асуулгын аргаар судалгаагаа авч, exsel программаар боловсруулан үр дүнг тодорхойлсон болно.

Үндсэн хэсэг:

Монгол хэлний тайлбар толиос **ойлголт** гэсэн үгийг харахад *юмны учир шалтгааныг ухааран ойлгосон байдал, ямар нэгэн зүйлийн талаар нарийн зөв мэдлэгтэй болох* гэсэн байна.

Блүүмийн таксономд танин мэдэхүйн айн хоёр дахь түвшин бол ойлголт. Тэнд ойлголтыг *дахин давтах, олох, тодорхойлох, харьцуулах, тайлбарлах, нэгтгэх, жишээ татах, гол зүйлийг тодруулах, тайлах үйлүүд* гэж тодорхойлжээ ((, 2014)). Бичвэр, уран зохиол, урлагийн бүтээлийн тайлбар, түүнчлэн янз бүрийн нөхцөл байдалд хүмүүсийн үйлдэл, үйл ажиллагаатай холбоотой бүх зүйлсийг ойлголтод хамааруулна (И., 1999) гэж Рузавин. Г тодорхойлсон байна.

Ухагдахууныг ойлгох нь үл мэдэгдэх зүйл рүү нэвтрэх үйл явц бөгөөд асуудлын тодорхойгүй, бүрэн биш байдлыг бүтээлч хүчин чармайлтын үр дүнд бий болгоно.

Сургалт үр дүнтэй байгаагийн хамгийн чухал үзүүлэлт бол шинэ хичээлийн агуулгыг ойлгох явдал юм. Иймд тухайн суралцагчийн аливаа зүйлийн утга учрыг ойлгох чадвар болон энэ чадвараар олж авсан үр дүн нь сургалтын гол мөн чанар болно.

Суралцагч судалж буй хичээлийн мэдээлэлд таамаглал дэвшүүлэх, ухагдахууны тодорхойлолт гаргах, график, схем, диаграммыг өөрийн үгээр тайлбарлах түүнчлэн бичиглэлийн нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт хувиргах, орчуулах, дахин танилцуулах, өөрчлөх, ахиж бичих, томьёолох, нэгтгэн дүгнэх, жишээ гаргаж чадаж байвал ойлгосон гэдгийг баталж байна.

Ойлголт ба тайлбар нь хоорондоо нягт холбоотой. Гэсэн хэдий ч ойлголт нь зөвхөн тайлбараар хязгаарлагдахгүй гэдгийг санах нь зүйтэй (Х, 1986.) гэж Вригт Г. Х тодорхойлжээ. Харин М.М.Бахтин эдгээр процедурыг ялгахдаа: "Тайлбарлах үед зөвхөн нэг ухамсар, нэг субьект байдаг бол ойлгоход хоёр ухамсар, хоёр субьект байдаг. Ойлголт нь үргэлж харилцан ярианы шинж чанартай байдаг гэсэн байна (М., 2000).

Суралцагч шинэ мэдээллийг хүлээн авах, ойлгох нь түүний хувийн сэтгэцийн шинж чанартай холбоотойгоос гадна багшийн мэргэжлийн ур чадвар, мөн судалж буй материалын шинж чанаруудаар тодорхойлогддог.

Суралцагч шинэ ухагдахуун материалыг сайн ойлгож тогтооход нь багшийн сургах аргазүй үр дүнтэй байдаг.

- Багш шинэ материалын агуулгыг оновчтой сонгож, сурах арга барилыг чиглүүлэх
- Сургалтын материал нь сэдэв, дүрслэл, яриа, кодчилол зэрэг хэлбэрээр байх.
- Сургалтын материалын хүндрэлийн түвшин нь суралцагчдын туршлага, мэдлэг, ур чадвараас хамаардгийг тооцох
- Хичээлийн материал нь суралцагчийн зорилго, сонирхол хэрэгцээг хангасан байвал шинэ ухагдахууныг ойлгох гол түлгуур болно.
- Хэлзүйн найруулга болон логик холбоо сайтай, утга төгөлдөр сургалтын материалыг суралцагч илүү хурдан ойлгох бөгөөд тэдний санах ойд удаан, бүрэн хадгалагддаг.

Иймд багш нь суралцагчдад танил бус нэр томьёог хэд хэдэн удаа давтаж утгыг нь тайлбарлах нь зүйтэй болов уу. Мөн сургалтын үйл явцыг зохион байгуулах, хэрэгжүүлэх үедээ түүнд нөлөөлөх биологийн хүчин зүйлийг харгалзан үзэх ёстой. Тухайлбал суралцагчийн оюуны ачаалал их, нойр дутуу, хэт ядрах, эрэг сэтгэл хөдлөл багатай байх, өдөр тутмын амьдралын хэв маяг нь алдагдах, цаг хугацаа шахуу гэх зэрэг үед ойлголт бэрхшээлтэй болдгийг тооцож үзэх хэрэгтэй.

Эдгээрээс гадна сэтгэлзүйн болон сурган хүмүүжүүлэх хүчин зүйлүүд болох оюутны дасан зохицох чадвар, мэдлэгийн түвшний зөрүү, багшийн авторитаризм, стресс болон заах арга барилд нь сэтгэл дундуур байх нь тэдний суралцах хүсэл эрмэлзлийн түвшнийг бууруулж, шинэ материалыг ойлгоход нь сөрөг нөлөө болдог байна.


Энэ бүхнийг харгалзан багш хичээлийн үйл явцыг оновчтой зохион байгуулах нь судалж буй хичээлийн ойлголтыг сайжруулах болно.

Багш шинэ ухагдахууны онолын заалтуудыг тодорхой жишээн дээр логик дараалалтай, дүрслэн харуулсан, ойлгомжтой байдлаар тайлбарлах эсвэл материал дээр ажиллуулбал илүү үр дүнтэй байна.

2. Судалгааны хэсэг:

Суралцагчид шинэ ухагдахууныг хэрхэн ойлгодогийг судалсан нь сэдвийн хүрээнд ЦХПК-ийн хөгжим 1,2,3,4 ангийн сонсогч сурагчдаас 18 бодомжийн хүрээнд шалгуур, үзүүлэлт боловсруулан, асуулгын арга болон, Google form ашиглан авсан.

График №1. Судалгаанд оролцогчдыг насаар авч үзвэл:



Судалгаанд оролцсон суралцагчдыг насны хувьд авч үзэхэд 16 насныхан хамгийн өндөр хувийг буюу нийт судалгаанд оролцогчдын 37.9%-ийг эзэлж байна.


Судалгаанд оролцогчдын курсээр нь ангилан авч үзвэл 1-р курсийн оюутнууд өндөр хувийг эзэлж байна.

График 2. Судалгаанд оролцогчдын ангиар авч үзвэл:



Суралцагчид шинэ ухагдахууныг хэрхэн ойлгож байгааг авч үзвэл:


Диаграмм №1



Судалгаанд оролцогчдын хариултаас харахад эерэг хариулт нь 46.4% байгаа нь хичээлийг маш сайн ба сайн ойлгодог гэж үзжээ. 48.2% нь дунд зэрэг ойлгодог гэж үзжээ.

Эерэг хариулт буюу маш сайн болон сайн ойлгох үйл,үйлдлийг эрэмбэлж авч үзье.

Диаграмм №2



Суралцагчид шинэ мэдээллийг дахин тайлбарлаж ярих үедээ болон шинэ мэдээллийг бусадтай ярилцаж байхдаа хамгийн сайн ойлгодог байна /маш сайн ба сайн ойлгодогийн нийлбэр 84% байна/. Эдгээрийн дараа судалгаа хийж байхдаа 79%, ухагдхууныг өөр зүйлтэй харьцуулан бодох үед 77%, ухагдахууны тодорхойлолтыг өөрөө зохиож бичих үед 72%, шинэ мэдээлэл нь схем, диаграмм, график сайтай байхад 72%, уншингаа тэмдэглэл бичих 71%, бие даалтын ажил хийж байхдаа 71% маш сайн болон сайн ойлгодог байна.

Сөрөг хариултууд буюу шинэ ухагдахууныг ойлгодоггүй ба ойлгохыг хүсэхгүй байх нөлөөллийг авч үзье.

Диаграмм №3



Суралцагчдын сөрөг хариултыг авч үзвэл:

Тэд нойр дутуу, нойрмог үедээ ухагдахууныг ойлгодоггүй /36%/ ба эсвэл ойлгохыг хүсдэггүй /26%/ гэсэн байна. Үүний дараа ядарч байхдаа, муухай ааштай, оюуны ачаалалтай, хугацаа давчуу үеүдэд ойлгодоггүй ба хүсдэггүй гэсэн хариултуудыг өгчээ. Мөн багшийн аргазүй муу үед ойлгодоггүй /35%/эсвэл ойлгохыг хүсдэггүй /25%/ гэсэн хариулт өгсөн байна.

Түүнчлэн уншиж буй материал нь ШУ-ны өндөр түвшинд бичигдсэн байхад маш сайн 4%, сайн 22%, дунд зэрэг 59%, ойлгодоггүй 10%, ойлгохыг хүсдэггүй 5% байна.

Дүгнэлт

1. Суралцагчдын 46.4% нь шинэ мэдээлэл, ухагдахууныг маш сайн ба сайн ойлгодог ба үлдсэн нь дунд зэрэг, эсвэл ойлгодоггүй ойлгохыг хүсэхгүй байдаг байна.
2. Судалгаанд оролцогч суралцагчид шинэ мэдээллийг уншаад ахин давтан ярих, бусдад тайлбарлавал маш сайн ба сайн ойлгодог байна. Иймээс шинэ мэдээллийг уншуулаад бусдад өөрийн үгээр давтан яриулах, тайлбарлуулах арга зүйг сонгож байх нь зүйтэй байна.
3. Суралцагчид бие даах ажил хийх, бичиж тэмдэглэх, өөрөө ухагдахууны тодорхойлолт гаргах зэрэг мэдлэг бүтээх үйлүүдийг хийж байхдаа сайн ойлгодог байна. Иймд хичээл бүрийг өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх аргазүйгээр оновчтой зохион байгуулж байвал үр дүнтэй гэдэг нь харагдаж байна.
4. Шинэ ухагдахууныг ойлгоход тэдний нойрмоглох, ядрах, сөрөг сэтгэлийн хөдөлгөөнтэй байх, оюуны ачаалал ихтэй зэрэг биологийн хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлдөг байна.
5. Улирлын эцсээр суралцагчид баахан бие даах ажил хийдэг тул нойргүй хонох, хугацаа давчуу байх зэрэг замбараагүй байдал бий болдог тул багш нар тэдний оюуны ачааллыг тохируулах , ажлын төлөвлөгөө гаргаж түүний дагуу суралцахад сургаж дэмжих нь зүйтэй.
6. Ядарсан, нойрмог, өвдсөн г.м байдлыг харгалзан үзэж хичээлээр шинэ ухагдахуун судлах эсэхээ шийдэж байх.
7. Багш нар мэдлэг бүтээлгэх болон идэвхтэй сургалтын аргуудыг чадварлаг ашиглан лекц, семинараа зохион байгуулж байвал суралцагчид маш сайн болон сайн ойлгох болно.

8. Сургалтын материалыг ойлгомжтой, логик дэс дараалал сайтай, элементарчилж бэлтгэж өгөх нь шинэ ухагдахууныг сайн ойлгох үндэс болох юм байна гэж судалгаанаас харагдлаа.

Ном зүй

1. Антони Ж.Нитко (2014) Суралцагчдын эзэмшсэн боловсролыг үнэлэх арга зүй В

2. Бахтин М. М. (2000) К философским основам гуманитарных наук. С. 308.

3. Вригт Г. Х.(1986.) Логико-философские исследования. - М. стр 167.

4. Ш.Ичинхорлоо (2014) Сургалтын онол, хэрэглээ УБ хуу 24

5. Рузавин Г. И. (1999) Методология научного исследования. - М. стр 214-215

Шинжлэн магадлах ухаан

ХУРУУНЫ ХЭЭНИЙ БОДИТ БАЙДЛЫГ ИЛРҮҮЛЭХ ТЕХНОЛОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ХЭТИЙН ТӨЛӨВИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН СУДАЛГАА

AN INTERNATIONAL REVIEW OF THE CURRENT STATUS AND FUTURE DEVELOPMENT OF FINGERPRINT LIVENESS DETECTION TECHNOLOGIES

П.Эрдэнэбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор,цагдаагийн хурандаа

P.Erdenebaatar

Senior teacher of Criminal Procedure Law Department, Doctor, Police Colonel, Police school of University of Internal Affairs

Хураангуй: Энэ өгүүллээр хуурамч хурууны хээ илрүүлэх алгоритм дахь дүрсийг урьдчилан боловсруулах, онцлог шинж чанарыг илрүүлэх, гаргаж авах, дүрсийг ангилах үндсэн зарчмуудыг авч үзлээ. Хурууны хээний ерөнхий болон хувийн шинж чанар, хөлсний сүвний чанарын тоон үзүүлэлтүүд, хөлсний хариу урвал, арьсны уян хатан чанараар илэрхийлэгдэх динамик шинж чанаруудыг хамруулан, олон улсад хийгдсэн судалгааны материал дээр тулгуурлан хурууны хээ таних технологийн судалгааны ахиц дэвшлийг нэгтгэн дүгнэсэн болно.

Дээрх судалгаан дээр үндэслэн хурууны хээг таних аргуудын давуу болон дутагдалтай талыг харьцуулан нөлөөлж болох хүчин зүйлсийг судалж, одоо ашиглагдаж байгаа илрүүлэх аргуудын тулгамдсан асуудал, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тоймлон авч үзсэн. Энэхүү судалгаа нь шүүх шинжилгээ, хиймэл оюун ухаан, мэдээллийн аюулгүй байдал болон бусад холбогдох салбарын судалгаанд онолын болон практик ач холбогдол юм.

Хурууны хээ нь хүний биеийн өвөрмөц бөгөөд насан туршийн тогтвортой шинж чанартай тул биометрийн баталгаажуулалт, хандалтын хяналт, цахим үйлчилгээний аюулгүй байдлыг хангахад өргөн хэрэглэгдэж байна. Сүүлийн жилүүдэд 3D хэвлэх технологи, биомиметик материалын хөгжлөөс үүдэн хуурамч хурууны хээ ашиглан хамгаалалтын системийг

хуурах эрсдэл нэмэгдэж, улмаар мэдээллийн аюулгүй байдал болон шүүх шинжилгээний практикт ноцтой сорилтууд үүсэж байна.

Судалгаанд хурууны хээний бодит байдлыг илрүүлэх программ хангамжид суурилсан аргуудыг голлон авч үзэж, дүрсийг урьдчилан боловсруулах, онцлог шинж чанарыг илрүүлэх, гарган авах, ангилах үндсэн зарчмуудыг задлан шинжиллээ. Үүнд хурууны хээний ерөнхий болон хувийн шинж чанар, хөлсний сүвний чанарын болон тоон үзүүлэлтүүд, түүнчлэн хөлрөх хариу урвал, арьсны уян хатан чанараар илэрхийлэгдэх динамик шинж чанаруудыг хамруулсан болно. Судалгааны үр дүнд олон шинж чанарыг хослуулсан, шүүх шинжилгээний үндэслэлтэй илрүүлэх алгоритмыг хөгжүүлэх нь онолын болон практикийн өндөр ач холбогдолтой юм.

Abstract: This study examines the fundamental principles of image preprocessing, feature detection and extraction, and image classification employed in algorithms for detecting spoofed fingerprints. Based on internationally published research, it synthesizes recent advances in fingerprint recognition technologies by incorporating both general and individual fingerprint characteristics, quantitative indicators of sweat pore features, perspiration responses, and dynamic properties reflected in skin elasticity.

On the basis of this analysis, the study compares the strengths and limitations of existing fingerprint recognition methods and investigates the factors that may influence their performance. It also reviews the current challenges faced by fingerprint liveness detection methods and outlines potential directions for future technological development. The findings of this research have both theoretical and practical significance for forensic science, artificial intelligence, information security, and other related fields.

Fingerprints possess unique and lifelong stable characteristics of the human body; therefore, they are widely used in biometric authentication, access control systems, and the security of electronic services. However, in recent years, the development of 3D printing technologies and biomimetic materials has increased the risk of deceiving security systems through the use of spoofed or artificial fingerprints. As a result, significant challenges have emerged in the fields of information security and forensic practice.

This research primarily focuses on software-based methods for fingerprint liveness detection and analyzes the fundamental processes of image

preprocessing, feature detection, feature extraction, and classification. These processes incorporate both global and local fingerprint characteristics, qualitative and quantitative indicators of sweat pores, as well as dynamic features expressed through perspiration responses and the elasticity of human skin. The results indicate that the development of forensic-based detection algorithms integrating multiple features is of considerable theoretical and practical importance.

Түлхүүр үгс: Хурууны хээ, Бодит байдал илрүүлэх, Биометрийн танилт, Шүүх шинжилгээ, Мэдээллийн аюулгүй байдал

Keywords: Fingerprint, Liveness detection, Biometric authentication, Forensic science, Information security

Удиртгал

Сүүлийн жилүүдэд дэлхий улсуудад биометрийн технологи, хурууны хээнд суурилсан таних системүүд нь иргэний болон төрийн үйлчилгээ, санхүүгийн гүйлгээ, хандалтын хяналт, цахим баталгаажуулалтын салбарт өргөн нэвтэрч байна. Хурууны хээ нь хүний биеийн өвөрмөц, давтагдашгүй насан туршид харьцангуй тогтвортой хадгалагддаг шинж чанартай тул таних, баталгаажуулах хэрэгсэл болгон ашиглахад өндөр найдвартай гэж үздэг. Хурууны хээнд суурилсан биометрийн системүүд нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсэн технологийн нэг болж хөгжиж байна.

Гэвч орчин үеийн үйлдвэрлэл, загварчлалын технологи, тэр дундаа 3D хэвлэх болон биомиметик материалын хөгжил нь хуурамч хурууны хээ үүсгэх боломжийг нэмэгдүүлж, биометрийн системийн найдвартай байдалд ноцтой сорилт учруулах болжээ. Хуурамч хурууны хээг ашиглан хандалтын хяналтын системийг хуурах, санхүүгийн болон мэдээллийн аюулгүй байдалд халдах тохиолдол бодитойгоор бүртгэгдэх болсон нь шүүх шинжилгээ, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд шинэ эрсдэлийг бий болгож байна (中国刑警学院学报. БНХАУ-ын Эрүүгийн цагдаагийн Их сургуулийн сэтгүүл, 2025).

Ийм нөхцөлд хурууны хээ нь бодит хүнийх эсэхийг тогтоох, хурууны хээний бодит байдлыг илрүүлэх технологийг хөгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай асуудал болоод байна. Энэхүү судалгаанд хурууны хээний арьсны бичил бүтэц, хөлсний сүвний шинж чанар, биологийн динамик өөрчлөлтөд тулгуурласан илрүүлэх аргуудыг шинжлэх ухааны

үндэслэлтэйгээр авч үзэж, шүүх шинжилгээний практикт хэрэглэх боломж, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохыг зорив.

Үндсэн хэсэг

Хүний хурууны хээ нь өвөрмөц бөгөөд насан туршийн тогтвортой шинж чанартай байдаг тул цахим төлбөрийн систем, нэрээр баталгаажуулах механизм, хандалтын хяналтын түгжээ тайлах, цахим иргэний үнэмлэх баталгаажуулах зэрэгт өргөн хэрэглэгдэж байна. Сүүлийн жилүүдэд "3D" хэвлэх технологи хөгжилд биомиметик материалыг ашиглан хурууны хээний хуулбар үүсгэж, хандалтын хяналтын системийг хуурахтай холбоотой гэмт хэргийн тохиолдлууд нэмэгдэх хандлагатай болжээ. Тухайлбал, iPhone 5S загвар гар утас худалдаанд гарснаар хоёр хоногийн дотор Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад байх хакеруудын бүлэглэл өөрсдийн бүртгэлтэй хэрэглэгчдийн өндөр нягтралтай хурууны хээний зургийг ашиглан хурууны хээг хуурамчаар үйлдэж, "Touch ID" системийг ашиглан залилах гэмт хэрэг үйлдсэн тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь орчин үеийн хэвлэх болон загварчлалын аргууд нь хурууны хээний арьсны бичил бүтцийн шинж чанарыг өндөр түвшинд дуурайх боломжтойг харуулсан байна (Galbally J., Alonso-Fernandez F., Fierrez J., et al., 2009).

Гэмт хэрэгтнүүд бусдын хурууны хээг хууль бусаар олж авсны дараа хурууны хээний хуулбарыг бий болгож, хандалтын хяналтын системийг хялбархан эвдэх боломжтой болсон нь хэрэглэгчийн өмч хөрөнгө, мэдээллийн аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулдаг. Үүнээс гадна хуурамч хурууны хээний хуулбарыг ашиглан өөрсдийн хууль бус үйлдлийг нуун дарагдуулах, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах, гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд эрсдэл бий болдог сөрөг талтай. Иймд хурууны хээ таних системийг гэмт хэргээс хамгаалах, хурууны хээний бодит эсэхийг илрүүлэх технологийг хөгжүүлэх нь яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудал болж байна.

Хүний хурууны хээ илрүүлэх технологиудыг техник хангамжид суурилсан болон программ хангамжид суурилсан аргуудад ангилж болно.

Техник хангамжид суурилсан арга нь олон төрлийн таних модулийг нэгтгэн ашиглаж, цусны урсгал, судасны цохилт, арьсны температур, үнэр зэрэг биометрийн шинж чанарыг илрүүлэх замаар хурууны хээний жинхэнэ эсэхийг баталгаажуулдаг. Энэ төхөөрөмжүүд нь өртөг өндөртэй, овор

хэмжээ ихтэй төдийгүй хүрээлэн буй орчны нөлөөлөлд мэдрэмтгий сул талтай байдаг байна.

Үүний эсрэгээр нь дүрс танихад суурилсан программ хангамжийн аргууд нь алгоритмын тусламжтайгаар хурууны үзүүрийн арьсны бүтцийн онцлогийг шинжилж, бодит болон хуурамч хурууны хээг ялган таних боломж олгодог. Эдгээр аргууд нь нэмэлт техник хангамжийн дэмжлэг шаардахгүй, алгоритм тасралтгүй сайжрахын хэрээр давтаж шинэчлэх, оновчлох боломжтой давуу талтай. Программ хангамжийн технологид тулгуурлан бодит хурууны хээний илрүүлэлтийг хэрэгжүүлэх нь дотоодын болон олон улсын шүүх шинжилгээний салбарын эрдэмтдийн нийтлэг судалгааны сонирхлын чиглэл болж байна (袁超 (Yuan Chao), 李鑫 (Li Xin), 吴强 (Wu Qiang) 等, 2019).

Олон улсын судалгааны практикийг авч үзвэл, бодит хурууны хээг илрүүлж байгаа одоогийн программ хангамжийн аргууд нь мэдээлэл технологийн шинжлэх ухааны мэргэжилтнүүдийн судалгааны анхаарлын төвд байсаар ирсэн. Гэвч хурууны хээний мэргэжлийн мэдлэг дутмаг байдлаас шалтгаалан зарим судалгаанд хурууны хээний бүх шинж чанарыг бүрэн гүнзгий судалж, үр дүнтэй ашиглахад хүндрэл учирч, улмаар ангиллын нарийвчлалд сөргөөр нөлөөлөх тохиолдлууд ажиглагдаж байгааг дурдах нь зүйтэй.

Иймд хурууны хээний мэргэжилтнүүд хуурамч хурууны хээний онцлог шинжүүдийг системтэйгээр нэгтгэн дүгнэж, ангиллын нарийвчлалыг сайжруулах алгоритмуудыг оновчтой болгох, хурууны хээг илрүүлэх технологийг цаашид хөгжүүлэхэд мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Орчин үед хурууны хээ илрүүлэх технологид программ хангамжид суурилсан аргууд асар их боломжтойг харгалзан үзвэл хурууны хээ илрүүлэх алгоритмыг хөгжүүлэх зорилгоор хурууны хээ илрүүлэх технологийн өнөөгийн судалгааны байдал, дэвшлийг хурууны хээг шинжлэх ухааны үүднээс системтэйгээр хянаж, үнэлэхийн зэрэгцээ тус технологийн ирээдүйн хөгжлийн чиг хандлагын урьдчилсан таамаглал дэвшүүлэхэд чиглэж байна.

Иймд энэхүү өгүүлэлд хуурамч материалын физик шинж чанар, хэвний технологийн онцлогийг харгалзан үзэж, хурууны хээний шинж

чанар, хөлсний сүвний шинж чанар, динамик шинж чанар гэсэн гурван хэмжээсний үүднээс арьсны бичил бүтцэд суурилсан бодит хурууны хээг илрүүлэх технологийг системтэйгээр авч үзлээ.

Хурууны хээний шинж чанарууд нь зургийн чанарыг тоон хэлбэрээр тодорхойлон үнэлэхэд ашиглагддаг дүрслэх параметрүүд тул хурууны хээний бүтэц, ялгарал, ирмэгийн хурц байдал зэрэг мэдээллийг тусгадаг. Энэ шинж чанарууд нь зөвхөн зургийн чанарыг үнэлэх төдийгүй хурууны хээний бодит байдлыг илрүүлэхэд шүүх шинжилгээний шинжлэх ухаанд суурилсан параметрийн дэмжлэг болдог. Эдгээр шинж чанарт барзгар байдал, хоосон хэсгийн онцлог, ирмэгийн контур, чиглэлийн детерминизмын түвшин, нуруу болон завсрын өргөний гөлгөр байдал, нурууны хоорондын давтамжийн домэйн шинжилгээ зэрэг олон үзүүлэлт багтана. Эдгээрийг ерөнхий болон хувийн шинж чанар гэж ангилдаг. Ерөнхий шинж чанарууд нь хурууны хээний зургийг бүхэлд нь хамарсан барзгар байдал, хоосон хэсэг, ирмэгийн контур зэрэг макро түвшний шинж чанаруудыг хэлнэ. Барзгаржилтын шинж чанар нь бодит болон хуурамч хурууны хээний гадаргуугийн барзгар байдлын ялгааг илэрхийлдэг.

Хувийн шинж чанарууд нь папиляр шугамын тасралтгүй байдал, чиглэл, тод байдал, хэлбэр, давтамж зэрэг бичил түвшний шинж чанаруудыг илэрхийлдэг. Жинхэнэ хурууны үзүүр дээрх хөлсний булчирхай ихтэй, арьс уян хатан байдаг тул чийглэг, тасралтгүй, тод харагддаг бол хуурамч хурууны хээ нь хөлсний нүх сүв, арьсны суналтын нөлөөгүйгээс хугарсан, бүдэг харагдах хандлагатай. Иймээс эдгээр шинж чанарууд нь хурууны хээний бодит байдлыг илрүүлэхэд шүүх шинжилгээний чухал шалгуур болдог.

Тод байдлын шинж чанар нь тод байдлыг ихэвчлэн саарал өнгийн зургийн дундаж утга болон стандарт хазайлтаар тодорхойлдог. Зарим судалгаанд папилляр шугам ба завсрын синус долгионы далайц, фазыг дуурайлган загварчилж, сегментчилсэн папиляр-завсрын саарал өнгийн тархалтын давхацсан бүсийг ашиглан тод байдлыг тооцоолсон. 10,000 гаруй дээж агуулсан эрлийз мэдээллийн сан (LivDet 2009 + ATVS) дээр хийсэн туршилтаар уг аргын ангиллын дундаж алдааны түвшин 10% байсан байна.

Папиляр шугамын морфологи ба давтамжийн шинж чанарууд нь бодит хурууны хээнд блокуудын хоорондох папиляр шугамын завсрын

өргөн болон давтамж харьцангуй тогтвортой байдаг бол хуурамч хурууны хээнд ашиглагдсан материалын физик шинж чанарын хязгаарлалтаас шалтгаалан папиляр шугамын өргөн жигд бус болж, улмаар давтамжид мэдэгдэхүйц өөрчлөлт үүсдэг. Иймээс папиляр шугамын морфологи болон давтамжид суурилсан шинж чанаруудыг ашиглах судалгаа сүүлийн жилүүдэд шүүх шинжилгээний практикт өргөн тархаж байна.

Хөлсний сүвний шинж чанар нь генетикийн биомаркерын хувьд хүний хурууны үзүүр дээр байрлах хөлсний сүвний орон зайн тархалт, нягтрал нь хувь хүн тус бүрд харьцангуй тогтвортой байдаг. Харин хуурамч хурууны хээ үүсэх явцад хэрэглэгддэг дулааны хэвний процессын үед материалыг жигд бус халааснаас коллоид бөмбөлөг үүсэх, папилляр шугам гулсах, суналтын нөлөө үүсэх зэрэг технологийн согог гардаг. Үүний улмаас хөлсний сүвний хэлбэр, хэмжээ, байрлал хэвийн бус болж, папиляр шугамын морфологийн гажуудал бий болдог. Ийм үйлдвэрлэлийн согогоос шалтгаалсан хөлсний сүвний хэвийн бус байдал нь бодит хурууны хээ болон хуурамч хурууны хээг ялган танихад ашиглагдах чухал шүүх шинжилгээний шинж чанар болдог.

Хөлсний сүвнийй чанарын шинжилгээ нь хөлсний сүвийг нарийвчлалтай гаргаж авах, улмаар коллоид бөмбөлгөөс үүссэн жинхэнэ хөлсний сүв (диаметр нь 50–250 μм) болон хуурамч хөлсний сүв (диаметр нь 250 μм-ээс их)-ийг ялгах замаар бодит байдлыг илрүүлэхэд чиглэдэг. Энэхүү арга нь хөлсний сүвний хэмжээ, хэлбэрт суурилсан шүүлтүүрийн нарийн параметрүүдийг тогтоох замаар үр дүнтэй сүвийг ялган гаргаж авдаг.

Хурууны хээний динамик шинж чанарууд нь хөлрөх хариу урвал, арьсны уян хатан чанарын өөрчлөлт зэрэг богино хугацааны биологийн идэвхжилтэй холбоотой бөгөөд эдгээр нь хурууны хээний дүрсэнд цаг хугацааны явцад илэрдэг.

Хүний хөлсний диэлектрик тогтмол нь липидийнхээс ойролцоогоор 30 дахин их байдаг. Иймээс арьсны гадаргуугийн импеданс, багтаамж зэрэг цахилгаан шинж чанарууд нь хөлсний ялгаралтай шууд хамааралтай. Үүнд суурилан арьсыг зэрэгцээ холбогдсон резистор болон конденсаторуудын матриц хэлбэрээр загварчилж, хөлсний ялгарал үүсэх боломжийг тооцоолдог.

Арьсны уян хатан чанар гэдэг нь гадны хүчний нөлөөгөөр сунасны дараа анхны төлөвтөө эргэн орох чадварыг хэлнэ. Энэхүү чанар нь коллаген, эластин болон байгалийн өөх тосны агууламжтай нягт холбоотой. Жинхэнэ хүний хуруугны хээ даралт үйлчлэх үед уян хатан деформацид ордог бол хуурамч хуруугны хээ нь анхны хэлбэрээ сэргээх чадвар сул байдаг.

Хуурамч хуруугны хээнд даралт үзүүлэхэд макроскопийн түвшинд дүрсний талбайн өөрчлөлт илэрч, микроскопийн түвшинд папилляр шугамын морфологи, давтамж, мөн хөлсний сүвийн тоо, нягтралд өөрчлөлт ордог. Иймээс даралттай болон даралтгүй нөхцөл дэх хуруугны хээний талбай, папиляр шугамын морфологи, давтамж, хөлсний сүвний шинж чанарын ялгааг харьцуулах нь бодит байдлыг илрүүлэх чухал шүүх шинжилгээний арга юм.

1. Хуруугны хээний шинж чанарт суурилсан илрүүлэлтийн судалгааны үр дүн

Он	Судлаач	Арга / алгоритм	Мэдээллийн сан	Үр дүн
2005	MOON Y S, CHEN J, CHAN K нар (MOON Y. S., 2005)	Вейвлетэд суурилсан барзгаржилтын шинжилгээ	–	Ангиллын дундаж алдаа **42.8%**
2013	PEREIRA L, PINHEIRO H, CAVALCANTI G D, нар (PEREIRA L., 2013)	Орон зайн шинж чанарт суурилсан арга + SVM	–	Нарийвчлал **70.09%**
2022	LIU H, ZHANG W, LIU F, нар (IU H., 2021)	Хувийн шинж тэмдгийн загвар	–	Алдааны түвшин **2.28%**
2022	YUAN C., CHEN M., WU Y. A нар	Гүн сургалт, тасралтгүй байдлын шинжилгээ	LivDet 2013	Алдааны түвшин **0.3%**
2018	XIA Z, YUAN C, LV R, нар (XIA Z, 2018)	Weber Local Binary Descriptor	–	Илрүүлэлтийн нарийвчлал сайжирсан
2022	MEHBOOB R, DAWOOD H нар (MEHBOOB R, 2022)	Чиглэлийн шинж чанарын сайжруулсан тодорхойлогч	LivDet 2013	Алдаа **1.72%**

2. Хуруугны хээний тод байдал ба папилляр шугамын шинжилгээ

Он	Судлаач	Судалгааны арга	Мэдээллийн сан	Үр дүн
–	Судалгааны туршилт	Саарал түвшин ба стандарт хазайлт	LivDet 2009 + ATVS	Алдаа **10%**
2019	SHARMA R P, DEY S нар (SHARMA R P, 2019)	Папилляр завсрын өргөний шинжилгээ	–	Алдаа **4.22%**
2015	Өмнөх судалгаа	Папилляр завсрын шинжилгээ	–	Алдаа **4.49%**
–	Судалгааны туршилт	Саарал түвшин ба стандарт хазайлт	LivDet 2009 + ATVS	Алдаа **10%**
2019	SHARMA R P, DEY S нар (SHARMA R P, 2019)	Папилляр завсрын өргөний шинжилгээ	–	Алдаа **4.22%**
2015	Өмнөх судалгаа	Папилляр завсрын шинжилгээ	–	Алдаа **4.49%**

3. Папилляр шугамын морфологи ба давтамжийн судалгаа

Он	Судлаач	Арга	Мэдээллийн сан	Үр дүн
2023	RAI A, TIWARI P K, BAISHYA J нар (RAI A, 2023)	DenseNet-121 CNN	LivDet 2017	Нарийвчлал **96.49%**
–	ABHYANKAR A, SCHUCKERS S нар (ABHYANKAR A, ABHYANKAR A, SCHUCKERS S. Fingerprint liveness detection using local ridge frequencies and multiresolution texture analysis techniques[C] // International Conference on Image Processing. IEEE, 2006: 321–324., 2006)	Олон нягтралтай бүтэц шинжилгээ	–	Алдаа **1.4%**
2018	KHADE S, THEPADE S D, AMBEDKAR A нар (KHADE S, KHADE S, THEPADE S D, AMBEDKAR A. Fingerprint liveness detection using directional ridge frequency with machine learning classifiers[C] // ICCUBEA 2018. IEEE, 2018: 1–5., 2018)	Олон чиглэлд давтамж тооцоолох арга	ATVS	Нарийвчлал **94.86%**
2018	KHADE S, THEPADE S D, AMBEDKAR A нар	Олон чиглэлд давтамж	FVC2000	Нарийвчлал **91.33%**

Он	Судлаач	Арга	Мэдээллийн сан	Үр дүн
2024	LI J, WANG Y, ZHANG E. нар (LI J, 2024)	Fisher vector + Fourier	–	Алдаа **5.16%**

4. Хөлсний сүвийн шинж чанарт суурилсан судалгаа

Он	Судлаач	Арга	Мэдээллийн сан	Үр дүн
2009	ZHAO Q, ZHANG L, ZHANG D, нар (ZHAO Q, 2009)	Дасан зохицох олборлолтын арга	–	Алдаа **20.49%**
2019	XU Y, LU G, LU Y нар (XU Y, 2019)	SIFT + Hough	DBI	Алдаа **1.86%**
2019	XU Y, LU G, LU Y нар (XU Y, XU Y, LU G, LU Y, et al. High resolution fingerprint recognition using pore and edge descriptors[J]. Pattern Recognition Letters, 2019(125): 773–779., 2019)	SIFT + Hough	DBII	Алдаа **0.12%**
2018	LABATI R D, GENOVESE A, MUNOZ E, нар (LABATI R D, 2018)	CNN-д суурилсан сүв илрүүлэлт	–	Илүү өндөр гүйцэтгэл
2021	AGARWAL D, BANSAI A.нар (AGARWAL D, 2021)	Олон масштабт олборлолт	–	Нарийвчлал сайжирсан

5. Хөлсний сүвийн тоон шинжилгээ

Он	Судлаач	Үзүүлэлт	Үр дүн
2010	MARCIALIS G L , ROLI F, TIDU A. нар (KHADE S, KHADE S, THEPADE S D, AMBEDKAR A. Fingerprint liveness detection using directional ridge frequency with machine learning classifiers[C] // ICCUBEA 2018. IEEE, 2018: 1–5.)	PD100, PD160, PDwhole	Бодит хээний утга илүү өндөр
2010	MARCIALIS G L , ROLI F, TIDU A. нар (IU H., 2021)	ED100, ED160, EDwhole	Сүв хоорондын зай ялгаатай
–	ESPINOZA M., CHAMPOD C. нар (Espinoza M., 2011)	1–25 пиксел сүв тодорхойлолт	Алдаа **8.31%**

Он	Судлаач	Үзүүлэлт	Үр дүн
2012	ESPINOZA M., CHAMPOD C. ар	Сүвийн коэффициент **11–33**	Нягтрал **0.4–1.2 мм/нүх**
2021	SHI M., ZHAO L., CHEN H.нар (3. Shi M., 3. Shi M., Zhao L., Chen H., et al. Fast and quantitative analysis of level 3 details for latent fingerprints [J]. Analytical Methods, 2021(46): 5664–5572., 2021)	Сүвийн байрлалын давтамж	Алдаа **0.82% – 3.28% – 2.05%**

6. Динамик шинж чанарын судалгаа

Он	Судлаач	Судалгааны объект	Үр дүн
2003	DERAKHSHANI R., SCHUCKERS S. A., HORNAK L. A., нар (Derakhshani R., 2003)	Хөлрөх динамик (0–5 сек / 5–10 сек)	Амьд хурууны өөрчлөлт илэрсэн
2010	TAN B., SCHUCKERS S. нар (Tan B., 2010)	Хөлрөх хариу урвал	**2–55 секунд** хэлбэлзэл
2012	MARASCO E., SANSONE C. нар (Marasco E., 2012)	Хөлрөх + статик шинж	Алдаа **12.45%**

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд хурууны хээний бодит байдлыг илрүүлэх технологийн судалгааны өнөөгийн түвшин, хөгжлийн чиг хандлагыг гадаадын эрдэмтдийн судалгаанд тулгуурлан системтэйгээр авч үзэв. Судалгааны үр дүнгээс харахад хурууны хээ таних уламжлалт аргачлал нь биометрийн баталгаажуулалтын салбарт өргөн хэрэглэгдэж байгаа боловч 3D хэвлэх технологи, биомиметик материалын хөгжилтэй холбоотойгоор хуурамч хурууны хээ ашиглан таних системийг хуурах боломж нэмэгдэж, мэдээллийн аюулгүй байдал болон шүүх шинжилгээний практикт шинэ эрсдэл бий болж байна.

Судалгааны хүрээнд хурууны хээний бодит байдлыг илрүүлэх программ хангамжид суурилсан аргуудыг шинжилж, хурууны хээний ерөнхий болон хувийн шинж чанар, папилляр шугамын морфологи ба давтамжийн үзүүлэлтүүд, хөлсний сүвийн чанарын болон тоон үзүүлэлтүүд, түүнчлэн хөлрөх хариу урвал, арьсны уян хатан чанараар илэрхийлэгдэх динамик шинж чанаруудыг харьцуулан авч үзэв. Эдгээр судалгаанууд нь бодит болон хуурамч хурууны хээг ялган танихад

биологийн болон морфологийн олон шинж чанарыг хамтад нь ашиглах нь илрүүлэлтийн нарийвчлал, найдвартай байдлыг нэмэгдүүлдэг болохыг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд гүнзгий сургалт болон хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмууд хурууны хээний бодит байдлыг илрүүлэхэд өндөр үр ашигтай болох нь туршилтын судалгаануудаар нотлогдож байгаа боловч бодит нөхцөлд хэрэглэхэд мэдээллийн сангийн хязгаарлалт, алгоритмын тайлбарлагдах чадвар, орчны нөлөөлөл зэрэг асуудлууд бүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

Иймд хурууны хээний бодит байдлыг илрүүлэх технологийг цаашид хөгжүүлэхдээ биологийн шинж чанар, дүрсний морфологи болон динамик үзүүлэлтүүдийг цогцоор нь ашигласан, шүүх шинжилгээний үндэслэл бүхий алгоритмын судалгааг хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь биометрийн таних системийн найдвартай байдлыг дээшлүүлэхийн зэрэгцээ нотлох баримтыг хууль зүйн үндэслэлтэй бэхжүүлэх ач холбогдолтой юм.

САНАЛ

1. Хурууны хээний бодит байдлыг илрүүлэх судалгаанд ерөнхий болон хувийн шинж чанар, хөлсний сүвийн бүтэц, динамик биологийн үзүүлэлтүүдийг хослуулсан олон параметрт алгоритмын судалгааг хөгжүүлэх шаардлагатай.

2. Хиймэл оюун ухаан, гүнзгий сургалтад суурилсан илрүүлэх аргуудыг шүүх шинжилгээний практикт хэрэглэхийн тулд стандартчилагдсан, олон эх сурвалжит мэдээллийн санг бүрдүүлэх, алгоритмын тайлбарлагдах чадварыг нэмэгдүүлэх судалгааг эрчимжүүлэх нь зүйтэй.

3. Хурууны хээ илрүүлэх технологийг бодит орчны нөхцөлд турших, тухайлбал цус, тос, бохирдол бүхий ул мөр, бүдгэрсэн эсвэл бүрэн бус хурууны хээ зэрэг шүүх шинжилгээний практикт тулгардаг нөхцөлд алгоритмын гүйцэтгэлийг үнэлэх судалгааг өргөжүүлэх шаардлагатай.

4. Хурууны хээ судлал болон мэдээллийн технологийн салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, шүүх шинжилгээ, мэдээллийн аюулгүй байдал, биометрийн баталгаажуулалтын салбарын уялдаа холбоог бэхжүүлэх нь бодит хурууны хээ илрүүлэх технологийн хөгжлийг түргэтгэх ач холбогдолтой.

5. Хурууны хээний бодит байдлыг илрүүлэх судалгааг хууль сахиулах байгууллагын практикт нэвтрүүлэхийн тулд шинжилгээний аргачлал, үнэлгээний шалгуур, нотлох баримтын хэрэглээний стандартыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. MOON Y. S., CHEN J., CHAN K., et al. Wavelet based fingerprint liveness detection [J]. Electron Letters, IEEE, 2005, 20:1112–1113.

2. PEREIRA L., PINHEIRO H., CAVALCANTI G. D., et al. Spatial surface coarseness analysis: technique for fingerprint spoof detection [J]. Electron Letters, 2013(4):260–261.

3. IU H., ZHANG W., LIU F., et al. Fingerprint presentation attack detector using global-local model [J]. IEEE Transactions on Cybernetics, 2021(10):12315–12328.

4.YUAN C., CHEN M., WU Y. A low-rank LBP with local differential polarization for fingerprint liveness detection [J]. International Journal of Autonomous and Adaptive Communications Systems, 2023(5):451–460.

5. XIA Z, YUAN C, LV R, et al. A novel weber local binary descriptor for fingerprint liveness detection[J]. IEEE Transactions on Systems, Man, and Cybernetics: Systems, 2018(4): 1526–1536.

6. MEHBOOB R, DAWOOD H D. Dehff: a hybrid approach based on distinctively encoded fingerprint features for live fingerprint detection[J]. Biomedical Signal Processing and Control, 2022: 103572.

7. SHARMA R P, DEY S. Fingerprint liveness detection using local quality features[J]. The Visual Computer, 2019(10): 1393–1410.

8.RAI A, TIWARI P K, BAISHYA J, et al. Dynapd: dynamic fusion of convolutional and handcrafted features for fingerprint presentation attack detection[J]. arXiv preprint, 2023:

9. ABHYANKAR A, SCHUCKERS S. Fingerprint liveness detection using local ridge frequencies and multiresolution texture analysis techniques[C] // International Conference on Image Processing. IEEE, 2006: 321–324.

10. KHADE S, THEPADE S D, AMBEDKAR A. Fingerprint liveness detection using directional ridge frequency with machine learning classifiers[C] // ICCUBEA 2018. IEEE, 2018: 1–5.

11. LI J, WANG Y, ZHANG E. Striver: an image descriptor for fingerprint liveness detection[J]. Signal, Image and Video Processing, 2024(11): 8229–8239.

Цэргийн дэг журамтай болон цэргийн дэг журамгүй сургалтын орчин дахь сонсогч, суралцагчдын биеийн антропометрийн үзүүлэлт ба сэтгэцийн төлөв байдлын харьцуулсан судалгаа

Anthropometric and Psychological Differences Between Cadets and Civilian Students: A Comparative Study of Military and Non-Military Educational Environments

Ц.Нандинцэцэг

Шинжлэн магадлах ухааны сургуулийн Байгалийн ухаан, техник зүйн шинжилгээний тэнхимийн багш, цагдаагийн хошууч, email: [nandintsetseg779@gmail.com]

Хураангуй: Энэхүү судалгаа нь цэргийн дэг журамтай (Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль) болон цэргийн дэг журамгүй энгийн сургалттай (Эрх зүй, нийгмийн ухааны сургууль) сонсогч, суралцагчдын биеийн антропометрийн үзүүлэлт (өндөр, жин, биеийн жингийн индекс) болон сэтгэцийн төлөв байдлын ялгаа, хамаарлыг тодорхойлоход чиглэсэн тоон, нэг агшингийн судалгаа юм. Судалгаанд нийт 137 оролцогчийн өгөгдлийг SPSS 29.0 программд боловсруулж, бүлгүүдийн хоорондын ялгааг тодорхойлоход хараат бус хоёр түүврийн t-шинжилгээ, хувьсагчдын хоорондын хамаарлыг үнэлэхэд Пирсоны корреляцийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Үр дүнгээс цэргийн дэг журамтай сургалтын орчин нь биеийн үзүүлэлтүүд болон сэтгэцийн зарим дэд хэмжээсүүдтэй статистик ач холбогдолтой хамааралтай байж болохыг харууллаа.

Түлхүүр үг: антропометр, BMI, сэтгэцийн төлөв байдал, цэргийн дэг журам, сонсогч

Keywords: anthropometric characteristics, body mass index (BMI), psychological state, military discipline, cadets

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд сонсогч, суралцагчдын дунд биеийн жин, биеийн гадаад төрхтэй холбоотой сэтгэл зүйн асуудал, стрессийн түвшин, өөрийгөө үнэлэх үнэлэмж нь боловсролын орчин болон амьдралын хэв маягтай нягт уялдаа холбоотойгоор судлагдах болсон. Ялангуяа сургалтын орчны дэг журам, бие бялдрын шаардлага нь оюутнуудын бие махбодын хөгжил, сэтгэцийн төлөв байдалд ялгаатай нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэж

байна. Цэргийн дэг журамтай хуулийн сургуулийн оюутнуудын биеийн антропометрийн үзүүлэлтүүд болох өндөр, жин, биеийн жингийн индекс (BMI) нь суралцах чадвар, стрессийг тэсвэрлэх чадвар, хувь хүний сэтгэл ханамжтай шууд хамааралтай хүчин зүйлсийн нэг болохыг судалгаанууд харуулдаг (Tomulescu, 2025). Цэргийн дэг журамтай сургалтын орчин нь оюутнуудын сахилга бат, биеийн идэвхтэй байдал, стрессийн удирдлагад эерэг нөлөө үзүүлдэг болохыг олон улсын судалгаагаар тогтоосон байна (Reinhard, 2021). Америкын нэгдсэн улсын цэргийн академийн оюутнуудын дунд хийсэн судалгаагаар бие бялдрын үзүүлэлт өндөртэй оюутнууд сэтгэл зүйн тогтвортой байдал, стресс тэсвэрлэх чадварын үзүүлэлт өндөр болох нь тогтоогдсон (O'Farrell, 2024). Монгол Улсад сэтгэцийн зан үйлийн онцлог, стрессийн түвшин, биеийн гадаад төрхөд сэтгэл ханамжгүй байдал нь хувь хүний сэтгэл зүйн төлөвшилд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна (Battushig, 2021). Дээрх олон улсын болон дотоодын судалгааны үр дүнгүүдээс дүгнэхэд, цэргийн дэг журамтай сургалтын орчин нь сонсогч, суралцагчдын биеийн антропометрийн үзүүлэлт болон сэтгэцийн төлөв байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой бөгөөд биеийн гадаад төрхөд сэтгэл ханамжгүй байдал нь сэтгэцийн төлөв байдалд шууд сөргөөр нөлөөлдөг болох нь нотлогдож байна. Цэргийн дэг журамтай сургалтын байгууллагууд нь бие бялдрын тодорхой шалгуур, тогтмол хөдөлгөөн, сахилга батад суурилсан сургалтын орчныг бүрдүүлдэг бол энгийн сургалтын байгууллагуудад эдгээр шаардлага харьцангуй сул байдаг онцлогтой. Иймд эдгээр хоёр өөр сургалтын орчинд суралцаж буй сонсогч, суралцагчдын антропометрийн болон сэтгэцийн төлөв байдлын үзүүлэлтүүд хоорондоо ялгаатай илрэх үндэслэл бүрдэж байна.

Монгол Улсын нөхцөлд одоогоор хуулийн сургуулийн сонсогч, суралцагчдын дунд энэхүү харьцуулалтыг системтэй судалсан судалгаа хомс тул бидний судалгааны үндэслэл болсон юм.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Дотоод хэргийн их сургуулийн цэргийн дэг журамтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогч ба цэргийн дэг журамгүй энгийн эрхзүй, нийгмийн ухааны сургуулийн суралцагчдын биеийн антропометрийн үзүүлэлт болон сэтгэцийн төлөв байдлыг харьцуулан судлах зорилго тавилаа. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

1. Цэргийн дэг журамтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогч ба цэргийн дэг журамгүй энгийн эрхзүй, нийгмийн ухааны сургуулийн суралцагчдын биеийн өндөр, жин, биеийн жингийн индексийн бүлгүүдийн ялгааг тодорхойлох;

2. Цэргийн дэг журамтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогч ба цэргийн дэг журамгүй энгийн эрхзүй, нийгмийн ухааны сургуулийн суралцагчдын сэтгэцийн төлөв байдлын дэд хэмжээсүүдийг хэмжих;

3. Цэргийн дэг журамтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогч ба цэргийн дэг журамгүй энгийн эрхзүй, нийгмийн ухааны сургуулийн суралцагчдын антропометрийн үзүүлэлт ба сэтгэцийн төлөв байдлын хамаарлыг судлах;

Судалгааны практик ач холбогдол

Энэхүү судалгааны үр дүнгээс биеийн антропометрийн болон сэтгэцийн төлөв байдлын ялгаа нь сургалтын орчинд тохирсон бие бялдрын бэлтгэл, сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөр боловсруулах үндэслэл болно. Мөн сонсогч, суралцагчдыг эрүүл мэндийг дэмжих, стрессээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зорилтот бүлэгт чиглүүлэхэд практик ач холбогдолтой.

Судалгааны арга зүй

Бид судалгааг 2026 онд Дотоод хэргийн их сургуулийн материаллаг баазыг түшиглэн, 18-30 насны (35 эрэгтэй, 102 эмэгтэй) цэргийн дэг журамтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 2 дугаар дамжаанд суралцаж буй 28 сонсогч, цэргийн дэг журамгүй эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 3 дугаар дамжаанд суралцаж буй 109 суралцагч, нийт 137 сонсогч, суралцагчдыг сайн дурын үндсэн дээр санамсаргүй түүврийн аргаар сонгон, судалгаанд хамруулав.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Судалгааг тоон судалгааны аргаар, нэг агшингийн загвараар, Google Forms платформоор тусгайлан боловсруулсан 3 бүлэг, 13 асуулт бүхий хаалттай асуумжийн аргаар мэдээлэл цуглуулсан.

Судалгааны асуумж нь:

Нийгэм-демографийн ерөнхий мэдээлэл: Нас, хүйс, суралцаж буй сургуулийн төрөл гэсэн 3 асуулт,

Антропометрийн үзүүлэлт: Өндөр, жин гэсэн 2 асуулт, өндөр, жингийн өгөгдөлд тулгуурлан биеийн жингийн индекс (BMI)-ийг SPSS программын “Хувьсагч тооцоолох” функц ашиглан дараах томьёогоор тооцсон.

$$\boldsymbol{BMI} = \frac{\text{жин (кг)}}{\text{өндөр2(м)}}$$

Сэтгэцийн төлөв байдал ба биеийн талаарх хандлага:

1. Биеийн гадаад төрхөд сэтгэл ханамж;
2. Биеийн галбиртаа сэтгэл дүүрэн байдал;
3. Стресс удирдах чадвар;
4. Дарамттай үед тайван байх чадвар;
5. Тогтмол биеийн тамирын дасгал хийх байдал;
6. Өдөр тутмын хөдөлгөөний идэвх;
7. Биеийн гадаад төрхөөс ичих мэдрэмж;
8. Биеийн гадаад төрхөөс үүдэх сэтгэл зүйн дарамт гэсэн 8 асуултаар авч

Ликертийн 1-5 шатлал бүхий үнэлгээгээр тооцсон.

Судалгааны статистик үр дүнгийн боловсруулалтыг SPSS 29.0 программыг ашиглан хийж гүйцэтгэв.

Хүснэгт 1. Оролцогчдын нийгэм-демографийн ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт	N	%
Хүйс		
Эмэгтэй	102	74.5
Эрэгтэй	35	25.3
Сургалтын төрөл		
Цэргийн дэг журамтай (Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль)	28	20.2
Цэргийн дэг журамгүй (Эрхзүй, нийгмийн ухааны сургууль)	109	79.8
Нас (жил)		
Дундаж нас (SD)	20.3	(±1.8)
Насны хүрээ	18-30	-

Тайлбар. Хүснэгт 1-ыг дүгнэхэд 74.7% нь эмэгтэй, 25.3% нь эрэгтэй, 20.2% нь цэргийн дэг журамтай сургалттай (Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогч), 79.8% нь энгийн сургалттай (Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн суралцагч) хамрагдсан байна. Дундаж нас ойролцоогоор 20.8±1.6 байв.

Хүснэгт 2. Биеийн антропометрийн үзүүлэлтүүдийн дундаж (см, кг, BMI)

Үзүүлэлт	Нийт (N = 137) Mean ± SD	Цэргийн (n = 28) Mean ± SD	Энгийн (n = 28) Mean ± SD	t	p
Өндөр (см)	168.4±7.9	171.2±6.8	167.7±8.1	2.31	0.022
Жин (кг)	63.5±10.6	67.5±9.4	62.4±10.7	2.45	0.016
BMI (кг/м^2)	22.4±3.1	23.1±2.6	22.2±3.2	1.98	0.049

Тайлбар. Хүснэгт 2-ыг дүгнэхэд цэргийн дэг журамтай болон энгийн бүлгийн биеийн жингийн индекс болон зарим сэтгэцийн дэд хэмжээсүүдэд статистик ач холбогдолтой ялгаа илэрсэн.

Хүснэгт 3. Антропометрийн үзүүлэлт ба сэтгэцийн төлөв байдлын корреляци

Хувьсагч	BMI	Биеийн гадаад төрхийн сэтгэл ханамж	Стрессийн удирдлага	Сөрөг хандлага
Биеийн жингийн индекс	1			
Биеийн гадаад төрхийн сэтгэл ханамж	−.34**	1		
Стрессийн удирдлага	−.28**	.41**	1	
Биеийн гадаад төрхтэй холбоотой сөрөг хандлага	.39**	−.52**	−.47**	1

Тайлбар. Хүснэгт 3-ыг дүгнэхэд корреляцийн шинжилгээгээр биеийн жингийн индекс болон биеийн гадаад төрхөд сэтгэл ханамж, стрессийн түвшин хооронд ач холбогдолтой хамаарал ажиглагдав.

Үр дүн

Цэргийн дэг журамтай сургалтын орчинд суралцаж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогчдын биеийн жингийн индексийн хэлбэлзэл бага, биеийн гадаад төрхтэй холбоотой сөрөг хандлага харьцангуй бага харин цэргийн дэг журамгүй сургалттай эрх зүй, нийгмийн

ухааны сургуулийн энгийн сургалтын орчинд суралцагчдын хувьд биеийн жингийн индексийн үзүүлэлт болон сэтгэл зүйн сөрөг хандлагын хооронд статистикийн хувьд ач холбогдолтой хамаарал илэрсэн ($p < 0.05$).

Судалгааны үр дүнгээс харахад цэргийн дэг журамтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогчдын биеийн өндөр, жин, биеийн жингийн индекс нь цэргийн дэг журамгүй сургалттай эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн энгийн сургалттай суралцагчдаас статистикийн хувьд ач холбогдолтойгоор өндөр байв ($p <0.05$).

Дүгнэлт

Цэргийн дэг журамтай сургалттай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогчдын биеийн өндөр, жин болон биеийн жингийн индекс (BMI) нь энгийн цэргийн дэг журамгүй сургалттай эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн суралцагчидтай харьцуулахад статистикийн ач холбогдолтойгоор өндөр байгааг бие даасан хоёр түүврийн t-шинжилгээний үр дүн харууллаа ($p < 0.05$). Энэхүү ялгаа нь цэргийн дэг журамтай сургалтын орчинд бие бялдрын тодорхой шалгуур, тогтмол дасгал хөдөлгөөн, сахилга батад суурилсан амьдралын хэв маяг давамгайлж байгаатай холбоотой байж болохыг илтгэнэ.

Биеийн жингийн индекс (BMI) болон сэтгэцийн төлөв байдлын зарим үзүүлэлтүүдийн хооронд статистикийн ач холбогдолтой хамаарал илэрсэн. Тухайлбал биеийн жингийн индекс өндөр байх тусам биеийн гадаад төрхөд сэтгэл ханамж буурах, стрессийн түвшин нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд энэ нь корреляцийн шинжилгээгээр батлагдсан ($p < 0.05$). Харин биеийн идэвхтэй байдал, стрессийг удирдах чадварын үзүүлэлтүүд нь биеийн гадаад төрхөд хандах эерэг хандлагатай уялдаа холбоотой болох нь тогтоогдлоо.

Судалгааны үр дүнгээс харахад сургалтын орчин нь сонсогч, суралцагчдын биеийн антропометрийн үзүүлэлтээс гадна сэтгэцийн төлөв байдал, стрессийн удирдлага, өөртөө итгэх итгэлд нөлөөлөх чухал хүчин зүйл болохыг харуулж байна. Энэ нь олон улсын болон Монгол Улсын өмнө судлагдсан судалгааны дүнтэй нийцэж байгаа бөгөөд сургалтын орчны зохион байгуулалт нь сонсогч, суралцагчдын бие махбодь, сэтгэцийн төлөв байдлын хөгжилд цогц байдлаар нөлөөлдөг болохыг баталж байна.

Санал

Энэхүү судалгаа нь Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын дунд биеийн антропометрийн үзүүлэлт ба сэтгэцийн төлөв байдлыг сургалтын хэлбэртэй уялдуулан судалсан бөгөөд цаашид сонсогч, суралцагчдын сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөр боловсруулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Tomulescu, I. M., & Marian, M. (2025). New bio-psychological perspectives on obesity: The relevance of anthropometric health indicators in students. *Journal of Psychological & Educational Research, 33*(1).

2. Reinhard, R. L. (2021). The evolution of organization development in the US military: An examination of intervention typologies (Doctoral dissertation, Benedictine University).

3. O'Farrell, K. D. (2024). Trauma, academic resilience, and physical activity: An examination of prevalence and practice (Doctoral dissertation, The University of Utah).

4. Battushig, B., & Yoo, J. Y. (2021). Relationship between socio-demographics, body composition, emotional state, and social support on metabolic syndrome risk among adults in rural Mongolia. *PLOS ONE, 16*(9), e0254141. https://doi.org/10.1371/journal.pone.0254141п

ХУУРАМЧ ТАМГАНЫ ДАРДАСТ ИЛРЭХ ШИНЖ ТЭМДГИЙН АСУУДАЛ

THE PROBLEM OF SYMPTOMS OF COUNTERFEIT LABELS

М.Цогтбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн 7071-р дамжааны магистрант, цагдаагийн ахлах дэслэгч

M.Tsogtbayr

Master's Student (Class 7071), School of Forensic Science, University of Internal Affairs, Police Senior lieutenant

Хураангуй: Цахим техник, технологийн хөгжилтэй энэ үед баримт бичгийн үнэн зөв, хууль ёсны байдлыг баталгаажуулах чухал хэрэгсэл нь албан ёсны тамга, дардас болж байна. Гэвч технологийн дэвшил, хэвлэлийн дижитал болон 3D принтерийн хөгжлийг ашиглан хуурамч тамга, дардас үйлдвэрлэх боломж нэмэгдэж, хууль бус үйл ажиллагаанд өргөн ашиглагдах нөхцөл бүрдэж байна. Энэ нь хууль сахиулагчид, шинжээчид болон төрийн байгууллагын ажилтнуудад хуурамч тамганы дардасыг илрүүлэх мэдлэг, арга технологи нь зайлшгүй чухал болохыг харуулж байна.

Тамга, дардас нь байгууллага, албан тушаалтны эрх мэдлийг илэрхийлж, баримт бичгийн хууль ёсны хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах үндсэн хэрэгсэл юм. Монгол Улсад тамга нь төр, орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэн бүрийн эрх зүйн харилцаанд чухал байр суурь эзэлдэг.

Сүүлийн жилүүдэд хуурамч тамга, дардас ашиглан баримт бичгийг хуурамчаар үйлдэх, төрийн нэрийг барин бусдыг залилан мэхлэх гэмт хэрэг ихсэж, нийгмийн итгэлцэл, шударга ёсонд сөргөөр нөлөөлж байна. Энэхүү өгүүлэлд хуурамч тамганы дардасны илрэх шинж тэмдэг, илрүүлэх арга зүй, хууль эрх зүйн зохицуулалт, судалгааны үр дүнг авч үзэх бөгөөд цаашид Монгол Улсад илрүүлэх арга, технологийг сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлж дүгнэлт гаргана.

Түлхүүр үг: Хуурамч дардас, шүүх шинжилгээ, лазер сийлбэр, бичил шинж тэмдэг, уламжлалт арга, геометрийн гажилт, дүрс давхцуулах арга, бэхний нэвчилт.

Abstract: In this era of rapid digital advancement, official seals and stamps remain critical tools for verifying the authenticity and legal validity of documents. However, technological progress in digital printing and 3D printing has increased the potential for producing counterfeit seals, creating conditions for their widespread use in illegal activities. This underscores the urgent need for law enforcement officers, forensic experts, and government officials to possess the knowledge and technical expertise required to detect counterfeit impressions.

Seals and stamps represent the authority of organizations and officials, serving as the primary instrument for ensuring the legal force of documents. In Mongolia, seals hold a significant position in the legal relations of state and local organizations, legal entities, and individuals alike.

In recent years, crimes involving document forgery and fraudulent activities conducted in the name of the state using counterfeit seals have risen, negatively impacting social trust and justice. This article examines the identifying features of counterfeit seal impressions, detection methodologies, legal regulations, and research findings. Furthermore, it identifies key areas for improving detection methods and technologies in Mongolia and provides comprehensive conclusions.

Keywords: Counterfeit stamp, Forensic examination, Laser engraving, Micro-features, traditional way, Geometric distortion, Image overlay method, Ink penetration.

Үндсэн хэсэг

Судалгааны ном, өгүүлэлд дурдсанаар, “хуурамч тамга” гэдэг нь жинхэнэ эрх бүхий байгууллага, этгээдийн зөвшөөрөлгүйгээр түүний нэр, тэмдэг, загварыг хуулбарлан хийсэн буюу анхны хэлбэрийг дуурайлган бүтээсэн тамгыг хэлдэг. Энэ нь хууль бус зорилгоор ашиглагддаг бөгөөд гэрээ хэлцэл, нотариатын баталгаа, төрийн бичиг баримт, аж ахуйн нэгжийн тамга зэрэгт хэрэглэгддэг.[20] (Chung, 2019; Micenková et al., 2012).

Олон улсын судалгаагаар хуурамч тамга илрүүлэх арга нь физик шинж, химийн шинжилгээ, технологийн шинж, дүрсний шинжилгээнд суурилсан байдаг. Жишээ нь, Micenková нар (2012) тамга хэвийн болон

[20] (Chung, 2019; Micenková et al., 2012).

хуурамч хэсгийн геометрийн ялгааг автомат аргаар илрүүлэх арга боловсруулсан бол, Chung (2019) нь тамганы фонт, төвийн байрлалын зөрүүгээр хуурамчийг оношлох алгоритмыг танилцуулжээ.

Тамга хэрэглэх соёл эртний Хятадаас үүссэн бөгөөд Монголчууд XIII зуунаас төрийн тамгыг хэрэглэх болсон. Түүхийн явцад хуурамч тамга ашиглах оролдлого аль ч нийгэмд байсаар ирсэн. XXI зуунд технологийн хөгжил нь хуурамч тамга үйлдвэрлэх боломжийг улам хялбар болгож байна. Өндөр нягтралтай хэвлэгч, лазер сийлбэрийн төхөөрөмж, компьютерийн график загварын программ хангамжийг ашиглан жинхэнэтэй тун төстэй хуурамч тамга үйлдвэрлэх боломж бүрдсэн нь гэмт хэрэгтний хувьд эрсдлийг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 19.6 дугаар зүйлд “төрийн тамга, тэмдэг, үнэмлэх, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, ашигласан, тараасан этгээдийг эрүүгийн хариуцлагад татна” гэж заасан байдаг. Мөн тамга тэмдгийн тухай хууль, Архивын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль зэрэгт тамга, тэмдэг ашиглах журам, бүртгэл, нөөц хяналтын үүрэг тодорхойлсон.[21] (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2024; Тамгын тэмдгийн тухай хууль, 2011).

Олон улсын судалгааны чиглэлд хуурамч тамгыг илрүүлэх олон төрлийн арга, техник боловсруулсан бөгөөд голлон геометрийн болон дүрсний анализ, дижитал алгоритм, материалын шинжилгээ, цахим хамгаалалтын арга гэсэн үндсэн ангилалд багтдаг. Геометрийн болон дүрсний анализын арга нь тамганы дүрс, бэхний тархалт, даралтын хувиралыг судалж, хуурамчийг оношлоход чиглэсэн байдаг. Жишээ нь, 1999 онд Forensic Science International сэтгүүлд нийтэлсэн судалгаанд автомат тамга илрүүлэх алгоритм боловсруулж, тамганы дүрс, геометрийн шинж чанарыг ашиглан хуурамч хэсгийг тодорхойлжээ.[22]

Мөн сүүлийн үеийн судалгаанд дижитал алгоритм болон гүн сургалтын (deep learning) аргыг ашиглан хуурамч шошго, тамгыг илрүүлэх туршлага гарчээ. Huang нарын 2023 онд Applied Sciences сэтгүүлд

[21] (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2024; Тамгын тэмдгийн тухай хууль, 2011)

[22] Chung, W. H. (2019). Seal imprint verification via feature analysis and geometric transformation. *Forensic Science International*

нийтэлсэн судалгаанд convolutional neural network (CNN) ашиглан хуурамч шошго, тамгыг дүрсний шинжилгээгээр ялгах боломжтой болохыг харуулсан. Материалын шинжилгээний арга нь бэхний найрлага, давхаргын бүтэц, хэвлэлийн даралтын ялгааг ашиглан хуурамч тамгыг илрүүлдэг бөгөөд Scientific Reports 2018 онд нийтлэгдсэн судалгаанд энэ аргыг жишээ болгон дурдсан байна.[23]

Цахим хамгаалалтын арга ч судлагдаж байгаа бөгөөд Blockchain болон Physically Unclonable Functions (PUF) технологийг ашиглан тамга, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах боломжийг олон улсын судалгаанууд харуулж байна. Тухайлбал, Arif нарын 2019 онд arxiv дээр нийтэлсэн судалгаанд цахим систем, блокчейн ашиглан хуурамч бүтээгдэхүүн, тэмдэг, тамгаас урьдчилан сэргийлэх боломжийг авч үзсэн байна.

Гэвч олон улсын судалгааны арга, техникүүдэд зарим бэрхшээлүүд тулгардаг бөгөөд үүнд тоног төхөөрөмжийн өндөр өртөг, мэргэжилтний бэлтгэл, тамгын хэв маягийн бүс нутгийн ялгаа асуудал багтдаг. Гэсэн ч олон улсын туршлага нь дижитал болон материалын шинжилгээг хослуулан ашиглахад илүү үр дүнтэй болохыг харуулж байна.

Монгол Улсад хуурамч тамга, тэмдэг ашигласан гэмт хэрэг, түүний илрүүлэлттэй холбоотой мэдээлэл харьцангуй хязгаарлагдмал байна. Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээллээр хуурамч тамга ашигласан гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд зарим тохиолдолд шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрийн цахим сангаас авсан жишээ нь хуурамч тамга ашигласан хэрэгт хамаарах нотолгоо, шийдвэрийг харуулдаг.

Монголд энэ сэдвээр эрдэм шинжилгээний нийтлэл, судалгааны өгүүлэл тун цөөн бөгөөд ихэнх мэдээлэл нь хэвлэл мэдээлэл, практик туршлага дээр суурилсан байдаг. Жишээ нь, зарим нийтлэлд тамгыг хуурамч эсэхийг хараад ялгах боломжгүй, зөвхөн мэргэжлийн шинжилгээний аргаар тодорхойлогддог гэж мэдээлсэн байдаг. Мөн Эрүүгийн хуулийн 19.6 дугаар зүйлд тамга, тэмдэг, дардасыг хуурамчаар

[23] Micenková, B., van Beusekom, J., & Shafait, F. (2012). Stamp Verification for Automated Document Authentication. *IWCF*

үйлдэхийг хориглосон байдаг бөгөөд энэ нь хууль эрх зүйн орчинд хуурамч тамга илрүүлэх үндэслэл болдог.[24]

1. Хуурамч дардасны үүсэх шалтгаан

Шалтгаан	Тайлбар
Эдийн засгийн	Хуурамч гэрээ, баримт ашиглан ашиг олох
Захиргааны хяналт сул	Тамга хадгалах, ашиглах журам сул
Технологийн дэвшил	3D принтер, лазер сийлбэрээр үйлдвэрлэх боломж
Иргэдийн мэдлэг сул	Дардасны бодит байдлыг шалгах дадалгүй байх

1.1 Хуурамч дардасны илрэх шинж тэмдгүүд

Физик: ирмэгийн ялгаа, хэлбэрийн зөрүү, шрифт ба бичгийн ялгаа
Химийн: бэхний найрлага, хэт ягаан туяанд үзэгдэх ялгаа, химийн урвал
Технологийн: хэвлэлийн ялгаа, 3D бүтэц
Визуал: бэхний өнгө, төв хэсэг гажсан, дардасны гадаргуунд бэх асгарсан

2.3 Илрүүлэх шинжилгээний аргууд

1. Уламжлалт арга
2. Микроскоп болон томруулдаг шил
3. Хэт ягаан туяа
4. Химийн болон спектрийн шинжилгээ
5. Харьцуулалтын шинжилгээ

2.4 Тулгамдаж буй бэрхшээл

- Технологийн дэвшил: хуурамч тамга бараг жинхэнээс ялгарахгүй
- Стандартын ялгаа: байгууллага бүрт тамгын хэмжээ, бэхний стандарт харилцан адилгүй
- Хүний хүчин зүйл: шинжээчийн ур чадвар харилцан адилгүй
- Баримтын чанар муу байх: дардас бүдгэрсэн, бэх арилсан

2.5 Монгол Улсад хуурамч тамганы эсрэг авч буй арга хэмжээ

1. Хууль эрх зүйн шинэчлэл
2. Техник, лабораторийн чадавх нэмэгдүүлэх

[24] Монгол Улсын Эрүүгийн хууль (2024)

3. Иргэдийн мэдлэг, мэдээллийг сайжруулах
4. Цахим тамга, дижитал гарын үсэг.[25]

ҮР ДҮН

Хуурамч тамганы дардасыг илрүүлэх, урьдчилан сэргийлэхийн тулд Монгол Улсад дараах чиглэлүүдээр бодитой, шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Тамганы стандарт, бүртгэлийг нэгдсэн цахим системд нэгтгэх. Төрийн болон хувийн байгууллагуудын ашиглаж буй бүх тамга, дардсыг бүртгэдэг “Тамганы нэгдсэн мэдээллийн сан”-г бий болгож, хуурамч тамга илрүүлэхэд харьцуулалтын жишиг болгон ашиглах боломжтой. Энэ системийг Архивын ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан удирдлагын дор ажиллуулах нь зохимжтой.

Хуурамч баримт илрүүлэх лабораторийн чадавхыг сайжруулах. Шүүх шинжилгээний байгууллага, цагдаагийн криминалистикийн лабораторид өндөр нарийвчлалтай микроскоп, спектрофотометр, хэт ягаан болон инфра улаан туяаны шинжилгээний тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэвтрүүлэх шаардлагатай. Мөн шинжээчдийн мэргэшлийг олон улсын Interpol, Europol-ийн сургалтын хөтөлбөртэй уялдуулах боломжтой.

Цахим гарын үсэг ба дижитал тамгын хэрэглээг өргөжүүлэх. Төрийн цахим үйлчилгээний системүүдэд (e-Mongolia, e-Gov зэрэг) цахим гарын үсэг, блокчэйн суурьт дижитал тамга ашиглах технологийг нэвтрүүлснээр баримт бичгийн хуурамчлалын эрсдэл эрс буурна. Энэ чиглэлд хувийн хэвшлийн банкууд, нотариат, даатгалын байгууллагууд хамрагдах нь чухал.

Хууль сахиулагчид болон шинжээчдийн чадавхыг тогтмол дээшлүүлэх.
Криминалистикийн шинжээч, мөрдөн байцаагч, прокурор, нотариатын ажилтнуудад зориулсан “Баримт бичгийн хуурамчлал илрүүлэх дэвшилтэт арга зүй” сэдэвт сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай. Үүнийг Дотоод хэргийн их сургууль, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн хамтран хэрэгжүүлэх боломжтой.

[25] Батжаргал, Д. (2023). Хуурамч баримт бичгийн шинжилгээний арга зүй.

Олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх. Иргэд, байгууллагууд хуурамч дардасны талаар мэдээлэл өгөх, баталгааг шалгах энгийн аргачлалтай болохын тулд цахим хуудас, гар утасны аппликейшн (жишээ нь “SealCheck”) нэвтрүүлэх нь үр дүнтэй.

ДҮГНЭЛТ

Хуурамч тамганы дардас нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, баримт бичгийн найдвартай байдал, иргэдийн хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлдөг, нийгмийн итгэлцэлд ноцтой аюул занал учруулж буй асуудал юм. Энэ үзэгдэл нь зөвхөн нэг байгууллагын дотоод хяналтын сул тал бус, харин төрийн нэгдсэн хяналт, технологийн дэд бүтцийн хөгжил, иргэдийн эрх зүйн боловсрол зэрэг олон хүчин зүйлтэй нягт уялдаатай гэж үзэж болно.

Хуурамч тамганы дардас илрүүлэх асуудлыг зөвхөн шинжээчийн түвшинд бус, харин төрийн бодлого, технологийн шинэчлэл, олон нийтийн оролцоог хослуулсан цогц системээр шийдвэрлэх шаардлагатай байна. Ингэснээр Монгол Улсад баримт бичгийн аюулгүй байдал, төрийн үйл ажиллагааны итгэлцэл, хууль ёсны харилцааны баталгааг бодитой хамгаалах нөхцөл бүрдэнэ.

КИБЕР ГЭМТ ХЭРЭГ, ДИЖИТАЛ НОТЛОХ БАРИМТЫН ШИНЖИЛГЭЭ

CYBERCRIME AND DIGITAL EVIDENCE EXAMINATION: CONTEMPORARY CHALLENGES AND FORENSIC APPROACHES

Ш.Батсүх

Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн 7071-р дамжааны магистрант, ахлах дэслэгч

Sh.Batsukh

Master's Student (Class 7071), School of Forensic Science, University of Internal Affairs, Senior lieutenant

Хураангуй: Хүн төрөлхтөн мэдээллийн технологийн эрин үед шилжсэнээр нийгмийн харилцаа, бизнес, төрийн үйлчилгээ, хүн хоорондын харилцаа бүрэн дижитал хэлбэрт шилжиж байна. Энэхүү хөгжлийн үр нөлөөгөөр зэрэгцэн кибер орчинд үйлдэгдэх гэмт хэргүүд эрчимтэй өсөж, улмаар иргэн, байгууллагын аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалд ноцтой заналхийлэл учруулан эдгээр гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх асуудал нь мэргэжлийн түвшинд хийгдэх шаардлагатайг сануулж буй явдал юм.

Дэлхий нийтээр гэмт хэргийн объектив шинж өөрөөр хангагдаж байгаа буюу үйлдэгдэж буй газар орныг цахим орчинд үйлдэгдэх хандлага ихсэж байгаа явдал нь манай улсад ч мөн адил тулгамдаж буй асуудалын нэг болон цаашид зайлшгүй анхааран шинэ төрлийн мөрдөн шалгах ажиллагааны арга барил, дижитал нотлох баримттай ажиллах арга зүйг нарийн оновчтой болгох нь зүйтэй.

Монгол Улсад 1994 оноос эхлэн кибер гэмт хэрэг үйлдэгдэж байгааг хүлээн зөвшөөрч эрүүгийн эрх зүйн хувьд зохицуулалт хэрэгтэй гэж үзэн 1996 оны Эрүүгийн хуульд "Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг" гэх шинэ бүлгийг нэмэлт өөрчлөлтөөр оруулж ирсэн цагаас өдийг хүртэл шинэчлэгдэн судлагдсаар байгаа бөгөөд 2021 онд "Кибер аюулгүй байдлын тухай" хууль батлагдсан явдал нь хууль эрх зүйн орчин мэдээллийн технологийн хөгжлийн дагуу хувьсан өөрчлөгдөж байна. Гэсэн хэдий ч кибер орчинд үйлдэгдсэн гэм үйлдлийн нотлох баримтыг цуглуулах, шинжлэх асуудал нь төдийлөн нарийвчлан хөгжөөгүй байна.

Abstract: As humanity has entered the era of information technology, social relations, business activities, government services, and interpersonal communication are increasingly transitioning into digital formats. Alongside these developments, cybercrimes have rapidly increased, posing significant threats to the security of individuals and organizations as well as to economic stability. Consequently, the processes of collecting, preserving, and analyzing digital evidence required to detect and investigate such crimes must be conducted at a professional and specialized level.

Globally, the objective elements of criminal activity are undergoing transformation, with an increasing tendency for crimes to be committed within cyberspace rather than in traditional physical environments. This emerging trend has also become a pressing issue in Mongolia. Therefore, it is essential to further develop and refine new investigative methods and techniques, particularly those related to digital forensics and the handling of digital evidence, in order to effectively address cyber-related offenses.

In Mongolia, cybercrime was first officially recognized in 1994, leading to the acknowledgment of the need for legal regulation within the framework of criminal law. As a result, the 1996 Criminal Code introduced a new chapter titled “Crimes Against Information Security.” Since then, the legal framework has continued to evolve and be further studied. The adoption of the Law on Cyber Security in 2021 demonstrates that the legal environment is adapting to the rapid development of information technology. Nevertheless, the methodologies and practices related to the collection, preservation, and analysis of digital evidence in cybercrime cases remain insufficiently developed and require further advancement.

Түлхүүр үг: кибер гэмт хэрэг, цахим мэдээллийн хэрэгсэл, дижитал нотлох баримт, орчин нөхцөл, шинжлэн судлах

Keywords: Cybercrime, Digital Evidence, Digital Forensics, Cyber Environment, Forensic Analysis, Cybersecurity

Зорилго: Кибер гэмт хэрэг, дижитал нотлох баримтын шинжилгээ сэдвийн хүрээнд цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гаралтын шалтгаан, нотлох баримт шинжлэх тэдгээрт тулгамдаж буй асуудлыг шинжлэх зорилготой.

Зорилт:

1. Кибер гэмт хэргийн ойлголт, криминологийн онцлог, ангилал, түгээмэл хэлбэрийг тайлбарлах.

2. Дижитал нотлох баримтын онолын үндэслэл, түүний бүтэц, эрх зүйн зохицуулалтыг судлах, гэмт хэргийн ул мөр тогтоох, криминалистикийн арга хэлбэрүүдийг шинжлэх

3. Монгол Улсад кибер гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн орчин, тулгамдсан асуудлыг тодорхойлох.

Судалгааны объект: Кибер гэмт хэрэг, дижитал нотлох баримтын криминалистик шинжилгээний онол, практик, эрх зүйн зохицуулалт.

Судлагдсан байдал: Тус сэдэвтэй холбоотойгоор ном, сурах бичиг болон эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллэг, бакалаврын ажил зэргийг уншиж судаллаа. Тухайн судалгааны ажлуудад кибер гэмт хэрэг, дижитал нотлох баримтын тухай онол, үзэл баримтлалыг тусган мөрдөн шалгах эрх бүхий албан байгууллага, албан тушаалтаны явуулах мөрдөн шалгах ажиллагааны тухай шүүмжлэлтэй хандсан байдал илүү ажиглагдаж байх ба дижитал нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх асуудал учир дутагдалтай бөгөөд нарийн мэргэжлийн шинжээч, мэргэжилтэнг хамруулах тухай тусгагдаагүй байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Техник технологийн үсрэлттэй хөгжлийн үр дүнд бидэнд цахим мэдээллийн хэрэгсэл, ухаалаг гар утасны хэрэглээ үүсэж жил ирэх тусам нэмэгдсээр байгаа нь давуу тал ихтэй боловч үүнийг ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт өсөн нэмэгдсээр байгаа нь анхаарал татсан хэрэг билээ. Тухайлбал: Цахим мэдээллийн хэрэгсэл ашиглан үйлдэх боломжтой хэд хэдэн гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгаж өгсөн байдаг. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан Залилах гэмт хэрэг, мөн тус хуулийн 26 дугаар бүлэг, 13.10, 13.11, 13.14 дугаар зүйлд заасан гэмт үйлдэл гэх мэтийг дурьдаж болох юм. Эдгээрээс гадна кибер орчныг ашиглан гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөх, үгсэн хуйвалдах, гэмт хэрэг үйлдэхээр завдах, бэлтгэх зэрэг үйлдлүүд олширч байгаа нь зөвхөн Монгол Улсын асуудал бус олон улсад тулгамдаж буй явдал юм. НҮБ-ын шинжээчдийн үзэж байгаагаар кибер гэмт хэрэг гэдэг нь виртуал орон зайд (хүмүүс, баримт, үйл явдлын талаархи мэдээллийг өөр хэлбэрээр агуулсан цахим орчин) явагддаг аливаа хууль бус үйлдэл бөгөөд харилцаа холбооны сүлжээ эсвэл компьютерийн систем, түүнчлэн компьютерийн дагалдах

хэрэгсэл, сүлжээний эсрэг үйлдэгдсэн бүх гэмт хэргийг хэлнэ. (https://www.mglbar.mn/a/4065)

НҮБ болон Будапешийн конвенцод кибер гэмт хэргийг дараах үндсэн бүлэгт хуваадаг. (Цахим гэмт хэргийн тухай конвенц, 2001)

Мэдээллийн аюулгүй байдал руу чиглэсэн гэмт хэрэг

- Хакер халдлага
- Сүлжээ нэвтрэх, өгөгдөл устгах
- Malware, ransomware халдлага

Цахим орчин ашигласан уламжлалт гэмт хэрэг

- Онлайн залилан
- Хувийн мэдээлэл хулгайлах
- Хүүхдийн порнограф
- Интернэтээр сүрдүүлэх, дарамтлах

Бизнес, төрийн байгууллагад чиглэсэн кибер халдлага

- DDoS халдлага
- Мэдээллийн сангийн хулгай
- Криптовалюттай холбоотой залилан

Кибер орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн онцлог шинж чанар нь бусад төрлийн гэмт хэргээс нэн ялгаатай орчин нөхцөл, үйлдлээр илэрч байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл цахим мэдээллийн орчинд эзэн бие тодорхойгүй, санаа сэдэл тогтооход хүндрэлтэй нөхцөлд хүний эд хөрөнгө, эрүүл мэнд, сэтгэл санаанд гэм хор учирснаар шалтгаант холбоо үүсэж эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөл болно гэж үзнэ. Тэгвэл кибер орчинд үйлдэгдэж буй гэмт үйлдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд задлан үзээд гэмт хэрэгт хамаарах эсэхийг шалгаж үзье. Гэмт хэргийн бүрэлдэхүүний Объектив шинжийг хангах нь тухайн гэмт хэргийн объектыг түүний эзэмшигч буюу гуравдагч этгээдийн мэдээллийн аюулгүй байдал[26]-ыг зөрчсөн, халдсан үйлдэл байна. Субъектив шинжийн хувьд санаатайгаар хүсэж үйлдсэн байх бөгөөд үүнийг эрүүгийн хариуцлага хүлээх чадамжтай этгээд өөрийн үйлдлийн хор уршиг, хохирлыг мэдсээр байж хүсэж үйлдсэн байх ба зарим тохиолдолд тусгай субъект байж болно (Г. Совд. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, 2002, 320-321 дэх тал)

Гэмт хэрэг бүрт тохирсон мөрдөн байцаалтын арга зүй тогтоох нь боломжгүй зүйл хэдий ч дээр дурдсанаар цахим мэдээллийн хэрэгслээр үйлдэгдсэн гэмт хэрэгт зайлшгүй шинэ мөрдөх арга зүй болон тусгайлан мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь илүү үр дүнд хүргэх нь гарцаагүй. Одоогийн байдлаар манай улсад энэ төрлийн гэмт хэрэгт ямар төрлийн мөрдөн шалгах ажиллагаа, криминалистикийн арга зүй ашиглаж байгааг судалвал ихэвчлэн хуульд заасан арга хэрэгслээр мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. Тухайлбал: (С. Цогтбаяр, Д. Мөнхсайхан. Криминалистикийн тактик арга зүй, 2005, 123 дахь тал)

- Гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, үйлдэгдсэн нөхцөл тодорхойлох
- Өгөгдсөн файлын системийн өөрчлөлт, халдлагын объектыг тодорхойлох
- Каталоги ба файлын нэр сольсон, компьютерийн урд өгөгдсөн гадаад байдлын өөрчлөлт
- Файлын хэмжээ түүнд байгаа зүйлийг өөрчилсөн, ажиллагааны системийн удааширсан буюу буруу ачаалалтай холбосон
- Программ бусад мэдээ, мэдээллүүд өөрчлөгдсөн байдал
- Гэмт хэргийг үйлдсэн этгээд, хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан тодорхойлох эдгээр дарааллаар мөрдөн шалгах эрх бүхий албан хаагч ажиллагааг явуулна. Үүнээс үзэхэд Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь нарийн мэргэжлийн мэдлэг ур чадвар шаардагдах боловч тухайн ажиллагаанд дижитал нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх арга хэрэгслийг мэргэжилтэн болоод шинжээчид үүрэг болгон хийх нь илүү үр дүнтэй байх боломжтой байна.

Криминалистикийн нарийн мэргэжилтэн болоод шинжээчид энэ төрлийн гэмт хэрэгт нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа онолын үүднээс тоон криминалистикийн аргыг ашигладаг байна. Гэвч тухайн ажиллагаанд ихэвчлэн мөрдөгч нар үйлдэж байгаа тул учир дутагдалтай байгаа явдал юм. Иймд криминалистикийн нарийн мэргэжилтэн, шинжээч нарын хүрээнд хийгдэх ажиллагааг судлаж үзье.

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд цаашид анхаарвал зохих бас нэгэн гол асуудалын нэг бол хэргийн газрын үзлэгийг оновчтой зөв тогтоох явдал. Учир нь энэ төрлийн гэмт хэргийн газрын үзлэг нь өвөрмөц онцлогтой бөгөөд олон янзын ул мөр бэхжүүлэх, шалгах, хураан авах, хадгалах зэрэг олон асуудлуудыг нэгэн зэрэг

шийдвэрлэх шаардлага гарч байгаагаараа бусад төрлийн гэмт хэргээс ялгарч байгаа юм. Иймээс цахим орчинд үйлдсэн гэмт хэргийн газрын үзлэгийг дараах байдлаар явуулбал зүйтэй. Үүнд:

1. Зөврхөн цахим орчинд үйлдэгддэг гэмт хэргийн ул мөрүүдийг цуглуулах, бэхжүүлэх,хураан авах, тээвэрлэх, хадгалах,цаашдаа тэдгээр ул мөрүүдэд холбогдох шинжилгээ, судалгаа хийж албан ёсны дүгнэлт гаргадаг мэргэшсэн шинжээчдийг гадаад, дотоодын криминалистик шинжилгээний их, дээд сургуулиудад эхний ээлжид богино хугацааны курс дамжаагаар, цаашдын хууль хэрэгжүүлэх бодлогын түвшинд үндсэн анги салбарт нь суралцуулах замаар тусгайлан бэлтгэж, тэднийг оролцуулсан мөрдөн шалгах, эрэн сурвалжлах ажиллагааны бүлэг гэж нэрлэж болох бүлгийн бүтцээр хэргийн газрын үзлэгийг явуулдаг арга барилд шилжих

2. Цахим орчинд үйлдсэн гэмт хэргийн газрын үзлэгийг “ төвөөс нь зах уруу нь “ гэдэг тактикаар явуулж хэвших. Ингэхдээ “ төв “ цэгээр сонгох

а/ Хэрэв гэмт хэргийн шинж тэмдэг илэрсэн байр орон, текник, эсхүл компьютерийн сүлжээнд үзлэг хийж байгаа бол төв серверийг сонгох

б/ Хэрэв гэмт үйл ажиллагаа явуулж хохирол учруулсан гэж үзэж байгаа байр орон , газарт үзлэг хийж байгаа бол цахим сүлжээний зангилаа, эсхүл компьютерийн тухайлсан программ хангамжийг сонгох

в/ Хэрэв гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байсан газар орон, байранд үзлэг хийж байгаа бол тухайлсан ажлын байрыг тус тус сонгох.

Цахим гэмт хэрэгт холбогдуулан мөрдөгч холбоотой этгээдийг ямар IP хаяг ашиглан, хаанаас ямар төхөөрөмжөөс нэвтрэн үйлдсэн талаар тогтоох ажиллагааг явуулж холбогдогч этгээдийг олох нь олонтаа байдаг. Гэхдээ ихэнхи залилах, мөнгө угаах зэрэг гэмт хэргүүд нь учирсан хохирол болох их хэмжээний мөнгөн хөрөнгийг гуравдагч оронд байрлах дансанд интернет банк буюу мөн адил цахим мэдээллийн хэрэгсэл ашиглан гуйвуулж байгаа юм. Энэ зэрэг томоохон хохирол учруулж байгаа гэмт хэргүүдэд хэрэг учралын газарт үзлэг хийх явдал нь энгийн нэг гэмт хэрэгт үзлэг хийхээс өөр түвшиний асуудал болж байгаагаас гадна гэмт этгээд тухайн нөхцөлд хэд хэдэн байршил солих төхөөрөмж, аппликэйшн зэргийг ашиглан нуугдах, нотлох баримтыг нэг үйлдлийн систем дамжуулан бүгдэнг нь устгах тохиолдол их байна. Нэгэнт олон нийтийн мэдээллийн сүлжээнээс устгагдсан баримт дахин сэргэх нь ховор, дийлэнх тохиолдолд сэргэх боломжгүй мөн компьютер, программаас 2 дахин удаагийн устгал

хийсэн нөхцөлд нотлох баримтыг олох нөхцөл хүнд байдалд тулгарч хэрэг илрүүлэлт удаашрах болно.

2021 онд Нийслэлийн прокурорын газраас олон нийтийн цахим мэдээллийн хэрэгслээр мэдээллэгдсэн 388 зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан 377 хэрэгт хяналт тавин ажилласан байна. Нийт хэргийн 98.2 хувь буюу 372 нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлд заасан "Цахим мэдээлэлд хууль бусаар халдах" гэмт хэрэг, 1.6 хувь буюу 6 нь 26.2 дугаар зүйлд заасан "Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах" гэмт хэрэг, 1.1 хувь буюу 4 нь 26.3 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн байна[27]. Гэмт хэрэг үйлдэж буй хүмүүс ихэвчлэн гадаад сервертэй вэб сайтуудыг хэрэглээндээ ашигладаг ба тухайлвал Фэйсбүүк, твиттер нь АНУ-д бүртгэлтэй компани бөгөөд эдгээрт бүртгүүлсэн хэрэглэгчийн мэдээлэл Америкийн хуулиар хамгаалагддаг, манай улсын хуулиар зохицуулагдах боломжгүй тул иргэн гомдол гаргасан тохиолдолд тэр улсаас нь тухайн сайтыг шалгаж өгөх, мэдээлэл авах хүсэлтийг явуулдаг, цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн мэдээллийг автоматаар олж авах технологийн боломж дэлхийн аль ч улсад хязгаарлагдмал байдаг.

Эдгээр гэмт хэргүүдийн гаралт өдөр ирэх тусам өсөн нэмэгдэх хандлагатай байна. иймд бид цаашид эрх зүйн зохицуулалт түүнчлэн мөрдөн шалгах ажиллагаа, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх тухай асуудлыг хөндөн гарц гаргалгаа олох шаардлагатай байна.

Бид мөрдөн шалгах ажиллагааны тухай өмнө нь дурдсан бол одоо нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх тухай тоон криминалистикийн арга зүйн талаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй болов уу. Дээрхээс үзэхэд кибер гэмт хэргийг илрүүлэхэд IP хаяг тогтоогдсон зөвхөн нэг цахим мэдээллийн хэрэгсэл, компьютерыг ашиглах нь учир дутагдалтай тул холбоо хамаарал бүхий хэдхэдэн хэрэгсэлд хэргийн газрын үзлэг хийх шаардлагатай бөгөөд гэмт этгээд тухайн хэргийг нуун дарагдуулах зорилгоор үйлдлийн систем, хадуу диск зэргийг устгах магадлалтай тул нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх асуудал нь хүндрэлтэй байж болох юм. Шинжээчийн зүгээс сүлжээгээр дамжин

хийсвэр гэмт хэргийн газарт үзлэг хийх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх зэрэг ажиллагаануудыг явуулахыг шаарддаг.

Компьютерын криминалистикийн шинжилгээ нь үндсэндээ 2 объект дээр шинжилгээ хийдэг: (Б. Хишигтогтох, Л. Цогтбаяр, Д. Сумъяацэрэн. Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийг мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс, 2015, 245-257 дахь тал)

1. Сүлжээний бус орчинд байрших компьютер, дижитал нотлох баримтад хийх шинжилгээ
2. Сүлжээний орчин дахь компьютер, дижитал нотлох баримтад хийх шинжилгээ

Эдгээр шинжилгээнээс сүлжээний орчинд байгаа компьютерт хийх шинжилгээ нь дээр дурдсан шиг нарийн төвөгтэй буюу гэмт этгээд хаанаас ч холбогдон үйлдсэн байх боломжтой байдаг. Үүнээс нотлох баримт цуглуулахдаа 3 эх сурвалжаас цуглуулдаг. Үүнд:


- Халдагчийн компьютер
- Халдагчийн нэвтэрсэн сервер
- Халдагч болон халдлагад өртсөн компьютерыг холбосон сүлжээ

Тухайн эх сурвулжуудаас шинжээч нотлох баримтуудыг цуглуулах бөгөөд ингэхдээ журмын дагуу цуглуулснаар түүний нотлох баримт чанараа алдахгүй байх шаардлагатай. Шинжээч нотлох баримт цуглуулахдаа халдлагад өртсөн хэрэгслийг /гар утас, таблет, компьютер, компьютерын хатуу болон уян диск гэх мэт/ хураан аван тухайн сүлжээний нэвтрэх нэр, нууц үг зэргийг аван тухайн сүлжээнд болгоомжтойгоор нэвтрэн мэдээллүүдийг хуулбарлан авах, шинжилгээнд явуулах ажиллагааг хийнэ. Хураан авсан нотлох баримтад тоон шижилгээг хийнэ. Тоон шинжилгээ гэдэгт аливаа тоон тоног төхөөрөмжтэй хамааралтай материал дээр үндэслэн төрөл бүрийн тусгай арга механизм, техникийг ашиглан дүн шинжилгээ хийх замаар баримт бүрдүүлэх шинжилгээний нэг төрөл.[28] Өөрөөр хэлбэл зөрчил хэрхэн болсоныг тогтоох зорилгоор тухайн хэрэгсэлд хадгалагдаж байгаа эсхүл дамжуулж буй өгөгдөлд шинжилгээ хийх явдал юм. Иймд дижитал нолох баримтыг цуглуулах, бэхжүүлэх нь маш нарийвчлалтай мэргэжлийн түвшинд хийгддэг боловч тухайн


баримтыг цуглуулснаар шинжилгээ хийгдэн шүүхийн өмнө баттай нотлох баримт болох боломжтой байна.

Кибер гэмт хэргүүдээс тодорхой нэг төрлийн гэмт хэргийг сонгон авч судалгаа хийвэл:

- Сүүлийн жилүүдэд газар аваад буй цахим залилан нь олон улсын түвшинд тулгамдаж буй асуудал юм. Тухайлбал:



Статистик №1: Монголын статистикийн мэдээллийн нэгдсэн сан (https://www.1212.mn/mn)



Статистик №2: Монголын статистикийн мэдээллийн нэгдсэн сан (https://www.1212.mn/mn)

Дээрх тоон статискаас харахад 2022-2024 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд нийтдээ 34851 залилах гэмт хэрэг гарснаас 25733 буюу 73.8% нь цахим орчинд үйлдэгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд цахим мөрийтэй тоглоомыг ашиглан их хэмжээний мөнгийг залилах, “даалгавар биелүүлээд өөрт байгаа мөнгөө өсгөн авааарай” гэх мэт гэмт хэргүүдийн тоо гаралт их болоод байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг гаралтад хууль зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай бөгөөд засан сайжруулахад анхаарах тухай санууллж байгаа

явдал гэж үзэж байна. Цагдаагийн байгууллагад энэ оны эхний 10 сарын байдлаар 14 мянган орчим залилах хэрэг бүртгэгдсэн. Энэ нь нийт гэмт хэргийн 35 хувийг эзэлж байна. Нийт үйлдэгдсэн залилах гэмт хэргийн 10 мянга орчим нь цахим хэрэгсэл ашиглаж үйлдэгдсэн байна. (https://police.gov.mn/)

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг нь ихэвчлэн фэйсбүүкээр дамжин явагддаг байсан бол одоо инстаграм, твитер хаягаар мөн өргөн тархжээ. Энэ гэмт хэргийн хохирогчид нь санаанд оромгүй байдлаар мөнгө, хөрөнгө, цаг хугацаа, сэтгэл санаагаа залилуулсан байдаг.

Цахим орчинд интернэт сүлжээгээр мэдээллийн өндөр технологи, комьпютерийн текник, программ хангамж ашиглан үйлдэж байгаа гэмт хэргүүд түүн дотроо залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн, шинжээчдийн шинжлэх ухаан текникийн мэдлэг, мэргэшлийг ашиглах хэлбэрүүд нь лрр дурьдсан шаардлагыг хангаж байх ёстой. Үүнд :

1. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хэм хэмжээний хүрээнд байх
2. Мэргэжилтэн, шинжээчийн тусламжтайгаар гарган авсан мэдээлэл нь эрүүгийн процессын ажиллагааны нотолгооны онол, арга зүйд нийцэж байх
3. Мэдээлэл нь шинжлэх ухааны танин мэдэхүйн арга замаар тогтоогдож, гэмт хэргийн тухайлсан нөхцөл байдалд бүрэн нийцсэн тогтолцооны чиг хандлагыг хангаж байх ёстой.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тухайлсан салбарын тусгай мэдлэгийг ашиглах процессын бүх хэлбэрийн өөр нэгэн түгээмэл төрөл бол гэмт хэргийн талаар ач холбогдол бүхий обьектуудыг урьдчилан шинжлэх арга юм. Энэ аргын мөн чанар нь сэжиглэж байгаа этгээдийн үйлдэл, үйл ажиллагаанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл байгаа эсэхийг тухайлсан салбарын тусгай мэдлэг ашиглан шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгаа эсэхийг шийдэх болон гэмт этгээдийг халуун мөрөөр нь илрүүлж баривчлахад тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн мөн л шаардлагатай.

Харьцуулсан судалгаа

Кибер гэмт хэргийн гаралт нь дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад эрчимтэй өсч байна. Дэлхийн улс орнуудаас АНУ-д цахим гэмт

хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг бөгөөд илтгэлийн сэдвийн хүрээнд сүүлийн 3 жилийн статистикаар харуулахаар зорьсон. АНУ-ын Холбооны мөрдөх товчоо (FBI) болон IC3 төвийн мэдээгээр 2022–2024 онд цахим гэмт хэргийн гомдлын тоо жил бүр 800 мянгаас дээш байж, гэмт хэргийг үйлдэх арга хэлбэр уламжилсан гэмт хэрэгтэй харьцуулахад илүү боловсронгуй, хөндлөнгийн нотлох баримтыг устгах боломж өндөр болсон нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулсаар байна.

АНУ-д дижитал нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх ажиллагаа нь орон нутгийн цагдаа, холбооны мөрдөх байгууллагууд, прокурорын байгууллага болон тусгай дижитал шинжилгээний лабораториудын уялдаатай ажиллагаанд тулгуурладаг. Хэрэг гарахад хамгийн түрүүнд очих байгууллага нь тухайн мужийн цагдаагийн байгууллага бөгөөд тэд нотлох баримт байх магадлалтай төхөөрөмж, сүлжээ, сервер, үүлэн орчин, камер, утас зэрэг бүх нэгжийг шууд хамгаалж тусгаарлана. Энэ үе шатанд тэд төхөөрөмжийг сүлжээнээс салгаж, радио-долгион хаах тусгай багаж ашиглан хадгалдаг.

Цуглуулах ажиллагааг ихэвчлэн мужийн кибер гэмт хэрэгтэй тэмцэх нэгж, эсвэл холбооны мөрдөх товчооны дижитал нотлох баримтын баг гүйцэтгэнэ. Эдгээр багууд төхөөрөмжид гар хүрэх өмнө хууль ёсны зөвшөөрөл (шийдвэр, прокурорын зөвшөөрөл) авсан байх шаардлагатай. Төхөөрөмжөөс мэдээлэл авахдаа анхны өгөгдөлд өөрчлөлт оруулахгүй байх зарчмыг чанд мөрдөж, тусгай хамгаалагч төхөөрөмж ашиглан хатуу дискийн яг хуулбарыг авдаг.

Бэхжүүлэх ажиллагааны үед авсан хуулбарыг баталгаажуулах зорилгоор кодчилсон тооцоолол хийж хоёр хувилбарын хоорондын зөрүүгүй байдлыг нотолдог. АНУ-ын дижитал лабораториуд (холбооны шинжилгээний лабораториуд, бүс нутгийн компьютерийн лабораториуд) нь авсан бүтэн хуулбарт гүнзгий шинжилгээ хийж, устгасан файл сэргээх, өгөгдлийн мөр илрүүлэх, цаг хугацааны дараалал сэргээх, сүлжээний урсгалд дүн шинжилгээ хийх, хортой программын бүтэц задлан шинжлэх зэрэг аргуудыг ашиглана.

БНСУ дижитал нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх үйл ажиллагааг өндөр төвлөрсөн системээр зохион байгуулдаг. Гэмт хэрэг бүртгэгдмэгц орон нутгийн цагдаагийн байгууллага анхны хамгаалалтыг хийх бөгөөд Солонгост дижитал нотлох баримтын үндсэн төв нь Улсын

Прокурорын газрын харьяа Үндэсний дижитал шинжилгээний төв бөгөөд энэ байгууллага улс даяарх бүх дижитал нотлох баримтын шинжилгээг нэгдсэн стандартаар гүйцэтгэдэг. Цагдаа анхны төхөөрөмжийг тээвэрлэж ирсний дараа төвлөрсөн системд бүртгэн, хуулбар авч баталгаажуулсны дараа шинжээчид нарийвчилсан шинжилгээг хийдэг.

Хятад улс нь төхөөрөмжийг хураасны дараа орон нутгийн дижитал шинжилгээний төвүүдэд хүргэж өгөгдлийн хуулбарыг авдаг. Хятад улсын шинжилгээний нэг онцлог нь дотоодод өргөн хэрэглэгддэг мессежийн платформ, төлбөрийн системээс өгөгдөл сэргээх тусгай програм, аргачлалуудыг ашигладаг явдал юм. Мөн том өгөгдлийн дүн шинжилгээ, хиймэл оюуны тусламжтайгаар олон төхөөрөмжийн лог, оролцогчдын хоорондын уялдааг илрүүлэх арга зүй өргөн хэрэглэгддэг. Бэхжүүлэх үед өгөгдлийн хуулбарын баталгаажуулалт олон шаттай хийгддэг бөгөөд шүүхийн материал болгон өгөхдөө прокурорын байгууллага шалгаж баталгаажуулдаг.

Японд дижитал нотлох баримтыг цагдаагийн мужийн нэгжүүд анхны шатанд цуглуулж, хамгаалдаг. Мөрдөн шалгах ажиллагаанд дижитал нотлох баримт ашиглах нь өндөр нарийвчлал, стандартад тулгуурласан байдаг ба Улсын цагдаагийн агентлагийн дижитал технологийн төв бүх аймагт мэргэжлийн зөвлөгөө, шинжилгээний дэмжлэг үзүүлдэг. Шинжилгээний үеэр суулгасан програмын өгөгдлийн мөр, устгасан файл, түүхэн лог, сүлжээний урсгалын мэдээлэл, цахим мөнгө шилжүүлсэн бүртгэл, харилцааны бичлэг зэрэг бүх мэдээллийг сэргээж, цаг хугацааны дараалалд оруулдаг. Хортой программын бүтэц задлан шинжлэх, сүлжээний халдлагын маршрутыг тогтоох ажиллагаанд тусгай мэргэжлийн баг ажилладаг.

Их Британид дижитал нотлох баримтыг үнэлж, шинжлэх ажиллагааг цагдаагийн дижитал шинжилгээний нэгжүүд, үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх газар болон прокурорын байгууллагууд хамтран гүйцэтгэдэг. Цагдаагийн байгууллага нь анхны хамгаалалт хийж, төхөөрөмжийг тусгаарлах, нотлох баримтын бүртгэл хөтлөх, өгөгдлийн хуулбар авах ажлыг хийдэг. Гэхдээ анхны төхөөрөмж дээр ажиллахыг аль болох хориглодог бөгөөд зайлшгүй шаардлагатай үед хатуу журмын дагуу ажилладаг. Хуулбар авсны дараа шинжээчид мэдээллийн бүх үе давхаргыг шалгана: устгасан файл, далд хавтас, харилцааны мэдээлэл, байршлын лог,

цахим шуудан, банкны шилжүүлэг, үүлэн үйлчилгээний мэдээлэл, нийгмийн сүлжээний өгөгдлийг сэргээж нэгтгэнэ. Шүүхийн ажиллагаанд нотлох баримтыг ашиглахын тулд дотооддоо мөрдөх чанарын баталгаажуулалтын хэм хэмжээг чандлан сахидаг бөгөөд шинжилгээний бүх үр дүнг стандартын дагуу тайлагнана.

Эдгээр мэдээлэлд үндэслэн дараах 5 орны харьцуулсан судалгааг хийв.

Улс	**Гол оролцогч байгууллага (шатаар)**	**Гол хууль / стандарт / практик**	**Цуглах → Бэхжүүлэх → Шинжлэх арга-зүй (товч)**
АНУ (https://www.fbi.gov)	First responders / Local police (анхны scene preservation) → FBI ERT / CART, Regional Computer Forensics Labs (RCFL) (on-scene imaging, transport) → FBI Labs / State forensic labs / Private DFIR vendors (deep analysis, malware RE, timeline).	CFAA, ECPA/SCA, Fourth Amendment case law; NIST IR 8387, NIST SP-series, SWGDE, ASTM (forensic standards).	- Scene: secure, Faraday bags, device isolation; live acquisition (RAM/network) only if warranted; forensic imaging with write-blocker (bit-stream), compute SHA-256/MD5 hashes; chain-of-custody logs; analysis: artifact carving, timeline reconstruction, log correlation, malware dynamic/static RE (tools: EnCase, FTK, XRY, open tools). (Практик зааврыг NIST, FBI ERT/RCFL-үүд мөрддөг).
БНСУ (Өмнөд Солонгос) (https://spo.go.kr/site/eng)	Local police cyber units (prefectural) (first responders, preservation) → NPA Digital Forensic Center / regional forensic labs (imaging, analysis) → Supreme Prosecutors' Office (SPO) / NDFaaS platform (case management, centralized forensic service) ; KISA / KrCERT-CC (technical incident response, ISP coordination).	Network Act (Information and Communications Network Act), Criminal Procedure Act; практик: Korean national frameworks, NDFaaS, & KISA guidance. (SPO-operated NDFaaS 2023+)	- Scene: preservation orders, device seizure per prosecutor/police instruction; imaging: write-blocker, bin/case image; centralized upload to NDFaaS (mobile images бүртгэх), standardized evidence metadata; analysis: log correlation (ISP/cloud), mobile forensic extraction, timeline, malware analysis; coordination: KISA provides threat intel and ISP liaison. (NDFaaS-тай төвлөрсөн

			pipeline нь Солонгост онцгой).
Хятад (PRC) (https://www.mps.gov.cn)	Public Security Bureaus (PSB) / Ministry of Public Security (MPS) (анхны мөрдөн шалгах, preservation) → муж/төвийн forensic laboratories (MPS-ийн криминалистик төв) → People's Procuratorates (Prosecutor) (хяналт, илгээх) ; техник дэмжлэг: төрийн лабораториуд, MPS-ийн төсөл.	Cybersecurity Law (2017), Data Security Law, MLPS (Classifi cation & critical infra rules); forensic accreditation шаардлагатай; MPS-ийн дотоод удирдамж, шалгах журам.	Scene: PSB-гийн багууд сүлжээнээс тусгаарлах, immediate preservation (RAM dump, network capture) хийх; imaging: write-protected forensic imaging, hashing; analysis: metadata correlation, platform-specific recovery (WeChat, Alipay logs), AI-assisted traceability; документ: provenance болон legality-г прокурорын оффис хянадаг. (Forensic labs нь аккредит/стандартчилсан).
Япон (https://www.npa.go)	Prefectural police cyber units / first responders (анхны scene) → National Police Agency (NPA) High-Tech Crime Technology Division / Digital Forensic Center (advanced imaging, malware analysis) → Public Prosecutors Office (хууль ёсны хяналт, evidence submission).	Act on Prohibition of Unauthorized Computer Access, Criminal Procedure Code; JIS/NPA internal guidance, NPA Digital Forensic Center-ын үйл ажиллагаа. (Japanese Law Translation)	- Scene: device isolation, quick triage (volatile data assessment), lawful seizure (warrant) шаардлагатай; acquisition: write-protected bit-stream imaging, calculated hashes; analysis: timeline reconstruction, packet-level forensics, mobile forensics (UFED, XRY), malware dynamic/static analysis; reporting: NPA-тай зохицуулан прокурор шүүхэд танилцуулна. (NPA нь Digital Forensic Center-тай).
Их Британи (UK) (https://www.digital-detective.net/digital-	Local police Digital Forensics Units (DFU) (scene triage, imaging) → National Crime Agency (NCA) (үндэсний/олон бүсийн хэрэгт coordination, deep forensics) →	Computer Misuse Act 1990, PACE, Criminal Procedure rules; ACPO/NPCC Good Practice, Forensic	- Scene: DFU performs device isolation, prioritized triage, live capture if necessary; imaging: bit-stream imaging, cryptographic hashing, dedicated DFU workflows; analysis: disk/mobile

forensics-documents)	Crown Prosecution Service (CPS) / Prosecutors (disclosure, evidence strategy).	Science Regulator statutory Code (ISO/IEC 17025 emphasis).	forensics, cloud data retrieval (where lawful), OSINT integration, malware RE; disclosure: CPS-ийн Digital Material Guidance (Chapter 30) хариуцна (MME/streaming requirements).

Дүгнэлт

Кибер гэмт хэрэг нь техник технологийн хурдацтай хөгжлийн нөлөөгөөр улам боловсронгуй болж, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдал, иргэдийн эрх–хууль ёсны ашиг сонирхолд бодит аюул заналхийлж буй орчин үеийн ноцтой нийгмийн үзэгдэл болоод байна. Тус асуудал нь зөвхөн Монгол Улсын бус дэлхийн улс орнуудын асуудал болоод байгаа юм.

Манай улсад кибер гэмт хэрэгтэй 1994 оноос эхлэн хууль эрх зүйн орчин бүрдүүлэн тэмцэж эхэлсэн боловч дижитал нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх криминалистикийн арга зүй дутмаг байна. Үүний улмаас хэрэг илрүүлэлт, хохирогчдын хохирлыг барагдуулах нөхцөл боломж бага байгаа юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудыг харьцуулан үзэхэд ихэнхи орнуудад тусгай мэргэжлийн түвшиний баг ажилладаг бөгөөд дижитал нотлох баримтыг цагдаагийн байгууллагаас гадна түүний харьяа эсхүл прокурорын байгууллагын дэрэгдэх нарийн мэргэжлийн байгууллагууд хамтран мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг бөгөөд хууль эрх зүйн зохицуулалт нь энэ төрлийн гэмт хэрэгт тусгайлан анхаарсан байна.

Үүнд хүн амын тоо, хөгжлийн түвшин хамаарч болох хэдий ч бид үүнээс суралцан мөрдөн шалгах ажиллагаанд шинэ арга зүй тогтоох, криминалистикийн шинжээч, мэргэжилтэнг байнгын хамруулах шаардлагатай байгаа юм.

Санал

1. Кибер гэмт хэрэгтэй холбоотойгоор хууль эрх зүйн орчинд нэмэлт өөрчлөлт оруулах, мөрдөн шалгах ажиллагаанд нарийвчилсан зөвлөмж гаргах.

2. Мөрдөн шалгах ажиллагаа тэр дундаа хэргийн газрын үзлэгт анхааран үзлэгт оролцох мэргэжилтэнг бэлтгэх өөрөөр хэлбэл шинжээч болон мэргэжилтэнг энэ төрлийн гэмт хэрэгтэй холбогдуулан сургалт, судалгааны ажил зохион байгуулах.

3. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуулийн этгээд, иргэнд аливаа цахим мэдээллийн хэрэгсэл, компьютер түүний дагалдах хэрэгсэлд хамгаалалт хийх, сонор сэрэмжтэй байх тухай анхааруулсан мэдээ мэдээлэл хүргэх. Тухайлбал: two-factor authentication, firewall monitoring

4. Дижитал нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх ажиллагааг мэргэжлийн нарийн түвшинд хийхийн тулд шүүх шинжилгээний байгууллага болон цагдаагийн байгууллагын төсөвт нарийн мэргэжлийн шинжилгээний багаж хэрэгслийг тусгаж өгөх. Ингэснээр нотлох баримтыг эвдрэл гэмтэлгүйгээр цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх ач холбогдолтой.

5. Мөн дижитал нотлох баримтын тухай ойлголт түүнийг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх сэдвийн хүрээнд илүү дэлгэрэнгүй ном зохиол, судалгааны ажил хийх

Ашигласан материал

1. Г. Совд. (2002) Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар. Уб.
2. Б. Хишигтогтох, Л. Цогтбаяр, Д. Сумъяацэрэн. (2015) Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийг мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс. Уб.
3. А. Доржготов, Ч. Сонгино. (1998) Эд мөрийн баримтын товч нэр томьёо. УБ.,
4. Б. Лхагвасүрэн. (2011) Мөр. УБ.,
5. С. Цогтбаяр, Д. Мөнхсайхан. Криминалистикийн тактик арга зүй. (2005)Уб.
6. Т. Халтар нар. (2022). Криминалистикийн арга зүй. Уб.
7. Хурцгэрэл. (2004) Ж. Криминалистик II. УБ.

Хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцууд :

8. Цахим гэмт хэргийн тухай конвенц. Будапешт хот., 2001
9. Монгол Улсын Эрүүгийн хууль
10. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
11. Цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэрэг мөрдөн шалгах орчин үеийн арга зүй, тулгарч буй бэрхшээлүүд болон боломжууд. Journal of Cybersecurity Research, 2019,

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

SELECTED ISSUES IN TRAFFIC ACCIDENT SCENE INVESTIGATION

Л.Отгонбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн 7071-р дамжааны магистрант, цагдаагийн ахмад

L.Otgonbayar

Master's Student (Class 7071), School of Forensic Science, University of Internal Affairs, Police Captain

Хураангуй: Зам тээврийн ослын хэргийн газрын үзлэг хийх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль хэрэгжүүлж ажиллах, хэргийн газраас ул мөр эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх ажиллагааг чанартай хийхэд хиймэл оюун ухаан, дижитал технологид суурилсан олон улсын сайн туршлага, дэвшилтэт шийдлүүдийг ашиглах шаардлагатай байна. Зам тээврийн ослын нөхцөл байдлыг сэргээн тогтоох нь осол гарахаас өмнө, ослын үед, ослын дараах үйл явцыг шинжлэх ухаан, техникийн үндэслэлтэйгээр дахин сэргээж тогтоох ажиллагаа юм.

Түлхүүр үг: Хэргийн газрын үзлэг, Зам тээврийн осол, Зарим асуудал, Сэргээн дүрслэх, Замын хөдөлгөөн.

Abstract: There is a critical need to adopt international best practices and advanced solutions based on Artificial Intelligence (AI) and digital technology to enhance the quality of traffic accident scene investigations, the implementation of road traffic safety laws, and the detection and preservation of physical evidence. Traffic accident reconstruction is the process of scientifically and technically recreating the sequence of events before, during, and after a collision to establish the precise circumstances of the incident.

Keywords: Crime Scene Investigation (CSI) , Traffic Accident (Crash) , Selected Issues , Reconstruction (Reconstruction and Visualization) , Road Traffic , Detection and Preservation

ҮНДСЭН ХЭСЭГ:

Монгол улсад 2024 оны байдлаар цагдаагийн байгууллагад 702821 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс 133475 (18,9%) нь зам тээврийн ослын

шинжтэй дуудлага мэдээлэл эзэлж байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлага мэдээлэл өмнөх оны мөн үеэс 19,3 хувиар өсжээ. Нийслэлд 125046 буюу 19,5 хувь, орон нутагт 8429 буюу 17,0 хувиар өссөн байна.Зам тээврийн осол гарах болсон шалтгаан жолоочийн буруутай үйлдэл, явган зорчигчийн буруутай үйлдэл, замын нөхцөл техникийн гэмтлээс шалтгаалсан гэж бүртгэгддэг. 2024 оны байдлаар 97.2% нь жолоочийн буруутай үйлдэл, 2.5% нь явган зорчигчийн буруутай үйлдэл, 0.4% нь замын нөхцөл техникийн гэмтлээс шалтгаалсан гэж бүртгэгдсэн байна. Зам тээврийн осол гэдэг нь зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдал юм. Манай улсын хувьд жилээс жилд автомашины тоо ихсэх тусам зам тээврийн ослын тохиолдлын тоо өссөөр байна.

Зам тээврийн осол гэдэг нь зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдал юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, захиргааны хэм хэмжээний актаас бүрдэнэ.

"Тээврийн хэрэгсэл" гэж хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг хэлнэ.

"Механикжсан тээврийн хэрэгсэл" гэж мопедоос бусад, хөдөлгүүрээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг хэлнэ. "жолооч" гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн, жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүнийг хэлнэ.

“Зам" гэж тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газрыг. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, явган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарна;

"Замын хөдөлгөөн" гэж нийтийн хэрэгцээний зам дээр явганаар болон тээврийн хэрэгслээр хүн, ачаа шилжих үйл ажиллагааг;

"Зам тээврийн осол" гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг;

"Замын хөдөлгөөнд оролцогч" гэж замаар явж байгаа жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчийг;

"Замын хөдөлгөөний аюулгүй байдал" гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг;

"Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах" гэж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

"Замын хөдөлгөөний зохион байгуулалт" гэж замын хөдөлгөөнийг удирдан явуулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг;

"Явган зорчигч" гэж замаар явган яваа /зам дээр ажил үүрэг гүйцэтгэж яваагаас бусад/ хүн, жагсаалаар яваа болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж, чарга чирж, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүнийг хэлнэ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, захиргааны хэм хэмжээний актаас бүрдэнэ.

Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөх замын хөдөлгөөний нэгдсэн журмыг Замын хөдөлгөөний дүрмээр тогтооно.Замын хөдөлгөөний дүрмийг Засгийн газар батална. Эрүүгийн хуулийн 27-р бүлэгт хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг шийдвэрлэх тухай заасан байдаг.

Зам тээврийн ослын үеийн хэргийн газрын үзлэг шалгалтыг
хиймэл оюун ухаан, дижитал технологид суурилсан
олон улсын сайн туршлага, дэвшилтэт шийдлүүд

1. Дрон (UAV) + AI суурилсан үзлэг

АНУ, Их Британи, Австрали, Герман улсууд дроныг ослын газрын үзлэгт ашигладаг.

AI нь тоормосны мөр, тээврийн хэрэгслийн байрлал, мөргөлдөөний цэгийг автоматаар илрүүлдэг.

Давуу тал: Хурдан, аюулгүй, хүний алдаа багасна.

2. 3D лазер сканнер ба виртуал хэргийн газар

Герман, Япон, Канад улсад лазер сканнер ашиглан ослын газрыг 3D хэлбэрт оруулдаг.

Шүүх хуралд виртуал байдлаар сэргээж үзүүлэх боломжтой.

3. AI-д суурилсан ослын шалтгаан тогтоох программ

PC-Crash, HVE зэрэг програмуудаар хурд, тоормос, мөргөлдөөний өнцгийг тооцоолдог.

AI нь дүгнэлтийн алдааг бууруулна.

4. Биеийн камер (Body cam) + ухаалаг тэмдэглэл

АНУ, Канад, Швед улсад цагдаагийн биеийн камер ашигладаг.

AI нь дууг текст болгох, цагийн дараалал үүсгэнэ.

5. Цахим протокол, ухаалаг төхөөрөмж

Эстони, Финланд, Сингапур улсад цаасгүй систем ашигладаг.

GPS, фото, видео мэдээлэл автоматаар хадгалагдана.

6. Big Data + AI урьдчилан сэргийлэх систем

Япон, Сингапур улсад осол их гардаг бүсийг AI тодорхойлдог.

Цагдаагийн хяналтыг оновчтой болгодог.

7. Автомашины хар хайрцаг (EDR)

АНУ, Герман улсад EDR өгөгдлийг ослын шинжилгээнд ашигладаг.

Хурд, тоормос, жолооны өнцгийг тодорхой харуулна.

8. Монгол Улсад нутагшуулах боломж

1-р үе шат: Дрон, цахим протокол, биеийн камер

2-р үе шат: 3D сканнер, AI анализ

3-р үе шат: Big Data, урьдчилан сэргийлэх AI

Монгол улсад хийгдэж байгаа шинжилгээний төрлүүд.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын “Инженер-Техникийн шинжилгээний хэлтэс” дараах лабораториудтай:

1. Авто техникийн шинжилгээний лаборатори
2. Цахим технологийн лаборатори
3. Барилга-инженер байгууламжийн шинжилгээний лаборатори
4. Галын техникийн шинжилгээний лаборатори
5. Хэргийн газрыг сэргээн дүрслэх лаборатори

Авто техникийн шинжилгээний лаборатори дараах шинжилгээг хийдэг:

- Автомашины эвдрэл гэмтэл тогтоох
- Зам тээврийн ослын нөхцөл байдлыг сэргээн тогтоох
- Хурд тодорхойлох
- Хэсгээс бүхлийг тогтоох

- Тээврийн хэрэгслийн явагч хэсэг шинжилгээ
- Бусад техник хэрэгслийн шинжилгээ

Автомашины хий дэрний компьютерээс ослын өмнөх 5 секундийн мэдээллийг шинжилж, хурд, моторын эргэлт, жолооны хүрдний байрлал, тормос гишгэсэн эсэх зэрэг мэдээллийг тогтоодог.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ СЭРГЭЭН ТОГТООХ

Зам тээврийн ослын нөхцөл байдлыг сэргээн тогтоох гэдэг нь осол гарахаас өмнө, ослын үед, ослын дараах үйл явцыг шинжлэх ухаан, техникийн үндэслэлтэйгээр дахин сэргээж тогтоох ажиллагаа юм.

Сэргээн тогтоохын зорилго нь Осол хэрхэн, яагаад гарсныг бодитой тогтоох Жолоочийн үйлдэл, хариуцлагыг үнэлэх, Шүүхийн нотлох баримтыг шинжлэх ухааны үндэслэлтэй болгох, Урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах

Ашиглагддаг үндсэн мэдээлэл

- Тээврийн хэрэгслийн байрлал, эвдрэл
- Замын нөхцөл байдал
- Тоормосны болон дугуйн мөр
- Цаг агаар, орчны гэрэлтүүлэг
- Фото, видео бичлэг- Хар хайрцаг (EDR)-ийн өгөгдөл
- Гэрч, жолоочийн мэдүүлэг

Сэргээн тогтоох арга, технологи

3.1 Уламжлалт арга
- Хэмжилт, схем зураг
- Математик тооцоолол
- Шүүх шинжилгээ

3.2 Дижитал ба хиймэл оюунд суурилсан арга
- 3D лазер сканнер
- Дрон (UAV)
- AI ослын анализын программ (PC-Crash, HVE)
- Хар хайрцаг (EDR)
- CCTV, Body cam бичлэг

Сэргээн тогтоох үе шат

1. Хэргийн газрын баримтжуулалт
2. Мэдээлэл цуглуулах, нэгтгэх
3. 2D/3D загвар үүсгэх
4. Тооцоолол, анализ хийх
5. Ослын явцыг сэргээх
6. Дүгнэлт, тайлан боловсруулах

ДҮГНЭЛТ

Зам тээврийн ослын хэргийн газрын үзлэг хийх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль хэрэгжүүлж ажиллах, хэргийн газраас ул мөр эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх ажиллагааг чанартай хийхэд хиймэл оюун ухаан, дижитал технологид суурилсан олон улсын сайн туршлага, дэвшилтэт шийдлүүдийг ашиглах шаардлагатай байна. Зам тээврийн ослын нөхцөл байдлыг сэргээн тогтоох нь осол гарахаас өмнө, ослын үед, ослын дараах үйл явцыг шинжлэх ухаан, техникийн үндэслэлтэйгээр дахин сэргээж тогтоох ажиллагаа юм. Сэргээн тогтоохын зорилго нь Осол хэрхэн, яагаад гарсныг бодитой тогтоох Жолоочийн үйлдэл, хариуцлагыг үнэлэх, Шүүхийн нотлох баримтыг шинжлэх ухааны үндэслэлтэй болгох, Урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах тээврийн хэрэгслийн байрлал, эвдрэл замын нөхцөл байдал, тоормосны болон дугуйн мөр, цаг агаар, орчны гэрэлтүүлэг Фото, видео бичлэг- хар хайрцаг (EDR)-ийн өгөгдөл гэрч, жолоочийн мэдүүлэг гэх зэрэг мэдээллүүд дээр тулгуурлагдаг. Иймд зам тээврийн ослын хэргийн газрын үзлэгийг дэвшилтэт технологи ашиглах нь хэргийг үнэн зөв бодит шийдэх, нотлох баримтыг үнэлэхэд өндөр ач холбогдолтой.

Ном зүй:

- Монгол Улсын Эрүүгийн хууль (2024)
- Тамгын тэмдгийн тухай хууль, УИХ, 2011
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, 2019
- Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн. Баримт бичгийн шинжилгээний гарын авлага, 2022
- Батжаргал, Д. (2023). Хуурамч баримт бичгийн шинжилгээний арга зүй. Цагдаагийн академийн эрдэм шинжилгээний бичиг
- ISO 14145–1:2016 — Document marking inks
- Интерпол. Forgery Detection Manual, Lyon, 2021

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

EXPERT OPINION AND ITS EVALUATION INTERNATIONAL EXPERIENCE

Э.Ижилцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн 7071-р дамжааны магистрант, цагдаагийн ахмад

E.Ijiltsetseg

Master’s Student (Class 7071), School of Forensic Science, University of Internal Affairs, Police Captain

Хураангуй: Энэхүү илтгэлд шинжээчийн дүгнэлтийн ойлголт, түүний нотлох баримтын систем дэх байр суурь, үнэлэх шалгуур үзүүлэлт болон олон улсын туршлагыг судаллаа. Судалгаагаар Монгол Улсад шинжээчийн дүгнэлтийг үнэлэх эрх зүйн үндэс нь холбогдох процессын хууль тогтоомжид тусгагдсан бөгөөд түүнийг зөвхөн ерөнхий нотлох баримтын хүрээнд бус, харин тусгай шалгууруар үнэлэх шаардлагатай нь тогтоогдлоо. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд хууль зүйн, шинжлэх ухааны, хүний хүчин зүйлийн болон технологийн шалгуур чухал үүрэгтэй байна. Олон улсын туршлагаас үзэхэд шинжээчийн дүгнэлтийг шинжлэх ухааны үндэслэл, хараат бус байдал, логик уялдаа болон бусад нотлох баримттай нийцэж буй байдлаар үнэлэх нийтлэг хандлага ажиглагдсан.

Түүнчлэн орчин үеийн судалгаагаар шинжээчийн дүгнэлтэд танин мэдэхүйн хазайлт зэрэг субъектив хүчин зүйлс нөлөөлөх боломжтойг тогтоосон бөгөөд энэ нь үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна. Иймд шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ хууль эрх зүй, шинжлэх ухаан, хүний хүчин зүйл, технологийн нэгдмэл хандлагыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэв.

Түлхүүр үг: шүүх шинжилгээ, шинжээчийн дүгнэлт, нотлох баримт, үнэлгээ, эрх зүйн тогтолцоо, харьцуулсан эрх зүй.

Abstract: This paper examines the concept of expert opinion, its place in the evidence system, evaluation criteria, and international experience. The study found that the legal basis for evaluating expert opinions in Mongolia is reflected

in the relevant procedural legislation, and it is necessary to evaluate it not only in the context of general evidence, but also by special criteria. Legal, scientific, human factors, and technological criteria play an important role in evaluating expert opinions. International experience shows a common tendency to evaluate expert opinions in terms of scientific basis, independence, logical coherence, and consistency with other evidence. In addition, modern research has shown that subjective factors such as cognitive bias can affect expert opinions, which indicates the need to improve evaluation methodologies. Therefore, it is concluded that it is advisable to implement an integrated approach of law, science, human factors, and technology when evaluating expert opinions.

Keywords: Forensic examination, expert conclusion, evidence, evaluation, legal system, comparative law.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Манай улсад 1920-оод оноос эхлэн шүүх шинжилгээний тусгай мэдлэг шаардсан шинжилгээг хийж эхэлсэн гэж үздэг. Тухайлбал, 1923 онд БНМАУ-ын Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатарын цогцост Орос-Монголын хамтарсан тусгай комисс шүүх шинжилгээ хийснийг Монголын түүхэн дэх анхны шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ гэж үздэг байна. Харин бичиг судлалын шинжилгээг 1930-аад оноос эхлэн тухайн үеийн хэл бичгийн эрдэмтэд Д.Нацагдорж, Я.Цэвэл болон Д.Донров нараар гүйцэтгүүлдэг байсан байна.

Ийнхүү шүүх шинжилгээний үйл ажиллагаа аажмаар хөгжихийн хэрээр шинжээчийн дүгнэлт гэсэн ойлголт хууль тогтоомж, эрх зүйн актууд болон шинжлэн магадлахуй, эрх зүйн салбарын эрдэмтдийн бүтээлүүдэд өөр өөр байдлаар тайлбарлагдаж, томьёологдох болсон байна. Шүүх шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “шинжээчийн дүгнэлт гэж хуульд заасан шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг хангаж, тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг” хэлнэ гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь шинжээчийн дүгнэлтийн үндсэн шинж болох тусгай мэдлэг, шинжлэх ухааны арга зүй, нотлох баримтын ач холбогдлыг цогцоор нь илэрхийлж байна.

Эрдэмтэн, судлаачид шинжээчийн дүгнэлтийг өөр өөрийн өнцгөөс тайлбарласан байдаг. Тухайлбал, доктор С.Бадарчи “криминалистикийн онолын судалгаандаа шинжээчийн дүгнэлт нь эд мөрийн баримт, ул мөр,

бичиг баримт болон бусад шинжилгээний объектыг шинжлэх ухааны аргаар судалсны үндсэн дээр гарсан шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт бөгөөд хэрэг маргааныг шийдвэрлэхэд чухал нотлох баримтын ач холбогдолтой" гэж үзсэн байдаг бол доктор Ж.Хурцгэрэл "шинжээчийн дүгнэлтийг шинжлэх ухааны аргаар баталгаажсан мэдлэгийн үндсэн дээр гарсан мэргэжлийн дүгнэлт" гэж тодорхойлсон байна.

Шинжлэн магадлахуйн салбарын эрдэмтэн, хууль зүйн ухааны доктор Б.Лхагвасүрэн "шинжээчийн дүгнэлт гэдэг нь шинжээч шинжлэх ухааны аргачлал, ашиглан шинжилгээний зүйлийг шинжилсэн үйл ажиллагааны явц, үр дүнг харуулсан нотолгооны эх сурвалж буюу байцаан шийтгэх ажиллагааны баримт бичиг мөн" гэж тодорхойлсон. Харин доктор Ж.Бямбаа шинжээчийн дүгнэлтийг "харьцангуй бодитой, нотлох баримтын онцгой шинж бүхий эх сурвалж" хэмээн тодорхойлсон бөгөөд энэхүү "онцгой" гэдэг ойлголтыг бусад нотлох баримтаас давуу, илүү чухал гэсэн утгаар бус, харин өөрийн гэсэн онцлог шалгууруар үнэлэгдэх шинжтэй гэж ойлгох нь зүйтэй гэж үзсэн байдаг.

Шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтаар ашиглахын тулд нэн тэргүүнд тухайн дүгнэлтийг үнэлэх асуудал тавигдана. Шинжээчийн дүгнэлтийн баталгаатай, эргэлзээгүй байдлыг үнэлэхдээ нотлох баримтын бусад эх сурвалжтай өрсөлдүүлэх нь зохимжгүй. Харин шинжлэн магадлах үйл ажиллагааны мөн чанар, зарчим, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах арга зүйн онцлогт үндэслэн боловсруулагдсан тусгай шалгуурыг баримтлан шинжээчийн дүгнэлтийг үнэлэх нь процесс хэрэгжүүлэгчдийн шинжлэх ухааны хандлагыг илтгэх ба хэргийн бодит үнэнийг эргэлзээгүй тогтоох зарчимд илүү нийцнэ.

Шинжээчийн дүгнэлт нь хэд хэдэн онцлог шинжтэй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч буй зарим асуудлыг мөрдөн шалгах байгууллага, шүүхийн бүрэлдэхүүн дангаараа шийдвэрлэх боломжгүй бөгөөд тухайн салбарын нарийн мэргэжлийн мэдлэг шаардах юм. Ийм тохиолдолд шинжээчийн тусгай мэдлэгийг ашиглан шинжилгээ хийж, шинжээчийн дүгнэлт гаргадаг. Энэхүү дүгнэлт нь зөвхөн шинжээчийн хувийн үзэл бодол биш бөгөөд шинжилгээний арга зүй, туршилт, ажиглалт, харьцуулалт, хэмжилт зэрэг шинжлэх ухааны аргууд дээр тулгуурлан дүгнэлтэд хүрнэ. Судлаач Б.Бат-Эрдэнэ шинжээчийн дүгнэлт нь шинжлэх

ухааны үндэслэлтэй, баталгаажих боломжтой, логик дараалалтай байх ёстой бөгөөд энэ нь дүгнэлтийн үнэлэмжийг тодорхойлдог гэж үзсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэхдээ шүүх тухайн дүгнэлтийг бусад нотлох баримттай хамтатган авч үздэг. Гэвч шинжээчийн дүгнэлт нь тухайн салбарын мэргэжлийн мэдлэг дээр тулгуурлан гардаг учир зарим тохиолдолд хэрэг шийдвэрлэхэд голлох чухал ач холбогдолтой.

Шинжлэх ухаан, технологийн хөгжил нэмэгдэхийн хэрээр шүүхийн ажиллагаанд тусгай мэдлэг ашиглах шаардлага нэмэгдэж, шинжээчийн дүгнэлтийн ач холбогдол улам бүр өсөж байна. Олон улсын судалгаанд шинжээчийн дүгнэлт нь шүүхийн шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлдэг бөгөөд эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаанд бодит байдлыг тогтооход өргөн хэрэглэгддэг гэж тэмдэглэсэн байдаг. Гэсэн хэдий ч шинжээчийн дүгнэлтийг үнэлэх асуудал нь улс орнуудын эрх зүйн тогтолцоо, шүүхийн практик, нотлох баримтын үнэлгээний зарчим зэргээс хамааран харилцан адилгүй зохицуулагддаг. Иймээс олон улсын практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд тавигдах шаардлага, шалгуур, шүүхийн хяналтын механизм зэрэг нь өөр өөрийн онцлогтой хөгжсөн байдаг.

Дэлхийн улс орнуудын Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоог хүн ам, эрх зүйн тогтолцооны онцлогтой нь уялдуулан авч үзвэл:

д/д	Улсын нэр	Хүн амын тоо	Эрх зүйн тогтолцооны онцлог	Шүүх шинжилгээний байгууллагын нэр	Шүүх шинжилгээний байгууллагын харьяалал
1	Монгол Улс	3,5 сая	Ром-Германы эрх зүй	Шүүх шинжилгээний ерөнхий газар	Хууль зүй, дотоод хэргийн яам
2	АНУ	342 сая	Английн нийтийн эрх зүй	Холбооны мөрдөх товчооны лаборатори	Холбооны мөрдөх товчоо
				Муж улсын шүүх шинжилгээний төв лабораториуд	Мужийн захирагч
				Шүүх шинжилгээний нэгжүүд	Мужийн цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний хувийн лабораториуд	
3	ОХУ	146 сая	Иргэний эрх зүй	Шүүх шинжилгээний алба	Хууль зүйн яам
				Шүүх шинжилгээний	Эрүүл мэндийн яам

				алба	
				Криминалистикийн шинжилгээний төв	Дотоод хэргийн яам
				Шүүх шинжилгээний алба	Батлан хамгаалахын яам
				Шүүх шинжилгээний лаборатори	Онцгой байдлын яам
				Шүүх шинжилгээний лаборатори	Холбооны гаалийн алба
				Шүүх шинжилгээний лаборатори	Холбооны аюулгүй байдлын алба
				Криминалистикийн шинжилгээний лаборатори	Прокурорын байгууллага
				Шүүх шинжилгээний хувийн лабораториуд	
4	БНХАУ	1,40 тэр бум	Уламжлалт болон иргэний эрх зүй	Шүүх шинжилгээний байгууллагууд	Нийтийг аюулаас хамгаалах яам
5	Австрали	27,4 сая	Английн нийтийн эрх зүй	Шүүх шинжилгээ, мэдээллийн төв	Холбооны цагдаагийн газар
6	ХБНГУ	83,9 сая	Иргэний эрх зүй	Шүүх шинжилгээний хүрээлэн	Холбооны эрүүгийн цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний хүрээлэн	Баварын цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний хүрээлэн	Баден-Вюртембергийн эрүүгийн цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний хүрээлэн	Дотоод саксоны эрүүгийн цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний хүрээлэн	Хессэний эрүүгийн цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний хүрээлэн	Берлиний эрүүгийн цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний газар	Хамбургийн эрүүгийн цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний газар	Умард Рейн Вестфалийн Эрүүгийн цагдаагийн алба
7	Япон	123 сая	Америк-Европын хуулийн уламжлал	Шүүх шинжилгээ, судалгааны хүрээлэн	Үндэсний аюулгүй байдлын комисс, Үндэсний цагдаагийн агентлаг

8	Норвеги	5,6 сая	Иргэний болон уламжлалт эрх зүй	Шүүх шинжилгээний үндэсний товчоо	Дотоод хэргийн яамны цагдаагийн газар
9	Канад	41,5 сая	Англиийн нийтийн эрх зүй	Шүүх шинжилгээ, адилтгалын алба	Үндэсний цагдаагийн алба
10	Швейцар	9 сая	Иргэний болон уламжлалт эрх зүй	Цюрих хотын шүүх шинжилгээний хүрээлэн	Цагдаагийн газар
11	Их Британи	69,3 сая	Англиийн нийтийн эрх зүй	Шүүх шинжилгээний алба	Шотландын цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний төв	Стратклайтын их сургууль
				Умард Ирландын Шүүх шинжилгээний төв	Хууль зүйн газар
				Шүүх шинжилгээний үндсэн алба	Хувийн байгууллага
12	Франц	65,0 сая	Исламын шариат, Францын эрх зүйд үндэслэн	Шүүх шинжилгээний хүрээлэн	Францын цагдаагийн алба
				Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн	Үндэсний цагдаагийн даргын зөвлөлийн удирдлага
13	Испани	49,3 сая	Иргэний эрх зүй	Шүүх шинжилгээ, хор судлалын үндэсний хүрээлэн	Хууль зүйн яам
14	БНСУ	51,7 сая	Хятад, Америк, Европын эрх зүй	Үндэсний шүүх шинжилгээний алба	Аюулгүй байдал, төрийн захиргааны яам
				Шүүх дижитал судлалын үндэсний төв	Дээд прокурор
				Шүүх шинжилгээний лаборатори	Цагдаагийн газар
15	Польш	38,5 сая	Францын эрх зүй, коммунист хууль эрх зүйн уламжлал	Шүүх шинжилгээний төв лаборатори	Цагдаагийн газар
				Шүүх шинжилгээний товчоо	Дотоодыг хамгаалах газар
				Шүүх шинжилгээний хүрээлэн	Хууль зүйн агентлаг
16	Эстони	1,4 сая	Иргэний эрх зүй	Шүүх шинжилгээний хүрээлэн	Хууль зүйн яам
17	Гүрж	3,7 сая	Иргэний эрх зүй	Шүүх шинжилгээний төв, хэлтэс	Дотоод хэргийн яам
				Шүүх шинжилгээний үндэсний товчоо	Хуулийн этгээд
18	Израил	10 сая	Англиийн нийтийн эрх зүй, еврей,	Шүүх шинжилгээний хүрээлэн	Хууль зүйн яам
				Шүүх шинжилгээ,	Цагдаагийн газар

			христ, мусульманы хуулийн уламжлал	адилтгалын хэлтэс	

АНУ-д шинжээчийн дүгнэлтийг үнэлэх асуудал нь шүүхийн практикт өргөн хөгжсөн бөгөөд шинжлэх ухааны нотлох баримтыг шүүхэд ашиглах шалгуур нь хэд хэдэн шүүхийн шийдвэрийн үндсэн дээр бүрэлдэн тогтсон байна. Ялангуяа Daubert стандарт нь шинжээчийн дүгнэлтийн шинжлэх ухааны үндэслэлийг шалгах чухал механизм болжээ.

Энэ стандартын дагуу шүүхээс шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах шалгуурыг хэрэглэдэг. Үүнд:

- Шинжилгээний арга нь шинжлэх ухааны үндэслэлтэй эсэх;
- Тухайн арга туршилтаар баталгаажсан эсэх;
- Шинжилгээний арга нь шинжлэх ухааны нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдсөн эсэх;
- Боломжит алдааны магадлал тодорхой эсэх.

Эдгээр шалгуур нь шинжээчийн дүгнэлт нь бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй эсэхийг тогтоох зорилготой бөгөөд шүүх тухайн шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтын хувьд ашиглах эсэхийг шийдвэрлэхдээ уг шалгуурыг ашигладаг.

Их Британийн эрүүгийн эрх зүйн тогтолцоонд шинжээчийн дүгнэлтийг шүүхийн ажиллагаанд өргөн ашигладаг. Их Британийн эрх зүйн практикт шинжээчийн үүрэг нь шүүхэд тусгай мэдлэг шаардсан асуудлыг тайлбарлахад оршдог гэж үздэг. Шүүх өөрөө тухайн асуудлыг мэргэжлийн түвшинд үнэлэх боломжгүй үед шинжээчийн дүгнэлт ашиглагддаг.

Англи болон Уэльсийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн нотлох баримтыг ашиглах эрх зүйн үндсийг Criminal Justice Act 1988 болон шүүхийн практикт бий болсон зарчмууд тодорхойлдог. Энэхүү тогтолцоонд шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах үндсэн шаардлагыг харгалзан үздэг. Үүнд:

- Тухайн шинжээч нь тусгай мэдлэг, ур чадвар, туршлагатай байх;
- Шинжээчийн дүгнэлт нь шүүхэд ойлгомжтой байдлаар тайлбарлагдсан байх;
- Дүгнэлт нь хэрэгт ач холбогдолтой асуудлыг тодруулсан байх

Мөн тус улсад шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ хараат бус байдал чухал шаардлага болдог. Шинжээч нь аль нэг талын ашиг сонирхлыг хамгаалах бус харин шүүхэд үнэн зөв, бодит мэдээлэл өгөх үүрэгтэй гэж үздэг.

Германы эрүүгийн процессын эрх зүйд шинжээчийн дүгнэлт нь нотлох баримтын нэг төрөл бөгөөд шүүх тухайн дүгнэлтийг нотлох баримтын бусад эх сурвалжтай хамтатган үнэлдэг. Германы эрх зүйн тогтолцоонд шинжээчийг шүүхээс томилдог бөгөөд шинжээч нь шүүхийн туслах шинжлэх ухааны мэргэжилтэн гэж үздэг.

ХБНГУ-д шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах асуудлыг харгалзан үздэг.

- Шинжээчийн мэргэжлийн чадвар;
- Шинжилгээний арга зүй;
- Шинжилгээний үр дүнгийн шинжлэх ухааны үндэслэл;
- Дүгнэлтийн логик үндэслэл.

ХБНГУ-ын шүүхийн практикт шинжээчийн дүгнэлт нь шүүхийн шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй боловч шүүх тухайн дүгнэлтийг заавал дагах үүрэггүй бөгөөд бусад нотлох баримттай хамтатган үнэлдэг байдаг.

БНЭУ-ын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд шинжээчийн дүгнэлтийг Indian Evidence Act-ийн хүрээнд зохицуулдаг. Энэ хуульд шинжээчийн дүгнэлт нь шүүхэд тусгай мэдлэг шаардсан асуудлыг тайлбарлахад ашиглагддаг нотлох баримтын төрөл гэж тодорхойлсон байдаг. БНЭУ-ын шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах шалгуурыг ашигладаг.

- Шинжээчийн мэргэжлийн мэдлэг, боловсрол;
- Шинжилгээний арга зүй;
- Шинжилгээний үр дүнгийн баталгаажуулалт.

Шүүх шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ тухайн дүгнэлтийг бусад нотлох баримттай харьцуулж үздэг бөгөөд зарим тохиолдолд давтан шинжилгээ хийх замаар дүгнэлтийн бодит байдлыг шалгадаг байна.

Олон улсын эрүүгийн шүүхүүдэд шинжээчийн дүгнэлт нь мөн адил хэрэг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа дайны гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчилтэй холбоотой хэргүүдэд шинжээчийн дүгнэлт

нь баримтыг тогтооход чухал ач холбогдолтой байдаг. Олон улсын эрүүгийн шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах зарчмыг баримталдаг.

- Шинжээчийн хараат бус байдал;
- Шинжилгээний арга зүйн баталгаажуулалт;
- Нотлох баримтын логик уялдаа.

Олон улсын судалгаанд шинжээчийн дүгнэлт нь шүүхийн шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлдэг боловч тухайн дүгнэлтийг бусад нотлох баримттай хамтатган үнэлэх шаардлагатай гэж үздэг. Олон улсын шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэх асуудал нь онолын төдийгүй бодит хэрэг маргаанд гарсан туршлагын үндсэн дээр хөгжиж ирсэн байдаг. Тухайлбал, зарим улс оронд шинжээчийн дүгнэлт буруу үнэлэгдсэнээс шалтгаалан шүүхийн шийдвэрийг дахин хянах, цагаатгах ажиллагаа явагдсан тохиолдлууд байдаг байна.

АНУ-д гарсан People v. Collins (1968) хэргийн жишээг дурдаж болно. Энэ хэрэгт гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд статистикийн шинжээчийн дүгнэлт ашигласан бөгөөд тухайн дүгнэлт нь математик магадлалын тооцоололд үндэслэсэн байсан. Гэвч шүүх уг дүгнэлтийг дахин үнэлэх явцад шинжилгээ хийхдээ ашигласан статистикийн арга зүй нь шинжлэх ухааны үндэслэлгүй, магадлалын тооцоолол буруу хэрэглэгдсэн болохыг тогтоосон байна. Үүний улмаас шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтын хувьд дахин үнэлэх шаардлагатай болсон байдаг. Энэхүү хэрэг нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ шинжлэх ухааны арга зүйн үндэслэлийг нарийвчлан шалгах шаардлагатайг харуулсан практик жишээ юм.

Мөн АНУ-д гарсан State v. Krone (2002) хэргийн жишээг авч үзэхэд шүдний ул мөрийн шинжилгээнд үндэслэн гэм буруутайд тооцогдсон этгээдийг хожим ДНХ-ийн шинжилгээний үр дүнгээр гэм буруугүй болох нь тогтоогдсон байдаг. Анхны шүүхийн шийдвэр нь шүдний ул мөрийн шинжээчийн дүгнэлт дээр үндэслэж байсан боловч дараагийн шинжилгээгээр уг дүгнэлт буруу байсан нь тогтоогдсон. Үүний үр дүнд тухайн хэрэг нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ олон төрлийн нотлох баримттай харьцуулж үзэх шаардлагатайг харуулсан чухал жишээ болсон.

Германы шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ давтан шинжилгээ хийх механизмыг өргөн ашигладаг. Жишээлбэл,

Германд гарсан зарим хүн амины хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд шүүхийн шинжилгээний лабораторийн дүгнэлтүүд хоорондоо зөрсөн тохиолдолд шүүх нэмэлт шинжилгээ томилж, хэд хэдэн шинжээчийн дүгнэлтийг харьцуулан үнэлэх замаар бодит байдлыг тогтоох практик тогтсон байдаг. Ийм практик нь шинжээчийн дүгнэлтийн бодит байдлыг баталгаажуулах чухал механизм болж байна.

Япон Улсын шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ шинжилгээний үйл явцын ил тод байдлыг чухалчилдаг. Тухайлбал, ДНХ шинжилгээний дүгнэлтийг шүүхэд ашиглахдаа лабораторийн протокол, шинжилгээний аргачлал, шинжилгээний үр дүнгийн статистикийн үндэслэлийг шүүхэд дэлгэрэнгүй танилцуулах шаардлагатай байдаг. Энэ нь шүүхийн бүрэлдэхүүн шинжээчийн дүгнэлтийн шинжлэх ухааны үндэслэлийг ойлгож, бодитой үнэлэх боломжийг бүрдүүлдэг.

БНСУ-ын шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ шинжээчийн мэргэжлийн ур чадвар, лабораторийн стандарт, шинжилгээний арга зүйн баталгаажуулалтыг хамтад нь шалгах практик өргөн хэрэглэгддэг. Жишээлбэл, лабораторийн шинжилгээний дүгнэлт гаргахдаа лабораторийн чанарын хяналтын стандарт мөрдсөн эсэхийг шүүх шалгадаг бөгөөд энэ нь шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв байдлыг баталгаажуулах нэг арга болдог.

Олон улсын эрүүгийн шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ шинжээчийн хараат бус байдалд онцгой анхаарал хандуулдаг. Тухайлбал, олон улсын эрүүгийн шүүхийн зарим хэргүүдэд шинжээчийн дүгнэлт нь улс төрийн нөлөөлөлд автах эрсдэлтэй гэж үзэгдсэн тохиолдолд шүүх бие даасан шинжээчдийн баг томилж, давхар шинжилгээ хийлгэх замаар нотлох баримтын бодит байдлыг шалгах арга хэрэглэдэг.

Дээрх практик жишээнүүдээс харахад шинжээчийн дүгнэлтийг үнэлэх асуудал нь зөвхөн онолын зарчим төдийгүй бодит хэрэг маргаанд гарсан туршлага дээр үндэслэн хөгжиж ирсэн байна. Улс орнуудын туршлагаас харахад шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах нийтлэг арга механизмыг ашиглаж байна. Үүнд:

- Шинжээчийн дүгнэлтийг бусад нотлох баримттай харьцуулан үнэлэх;
- Шинжилгээний арга зүйн шинжлэх ухааны үндэслэлийг шалгах;
- Шаардлагатай тохиолдолд давтан болон нэмэлт шинжилгээ хийх;

- Шинжээчийн хараат бус байдлыг хангах.

Шинжээчийн дүгнэлтэд хүний танин мэдэхүйн хүчин зүйлс хэрхэн нөлөөлдөг талаар сүүлийн жилүүдэд эрчимтэй судалгаа хийгдэж байна. Энэ чиглэлийн судалгаанд Dror (2020) нь шинжээчийн дүгнэлтэд “cognitive bias” буюу танин мэдэхүйн хазайлтын нөлөөг системтэйгээр тайлбарласан голлох судлаачдын нэг юм.

Dror (2020)-ын судалгаанд шинжээчийн дүгнэлт нь зөвхөн шинжилгээний техник ажиллагаанд тулгуурладаггүй, харин тухайн шинжээчийн мэдээлэл хүлээн авах, боловсруулах, тайлбарлах танин мэдэхүйн үйл явцтай нягт холбоотой болохыг онцолсон. Тэрээр шинжээчид тухайн хэрэгт хамааралтай болон хамааралгүй нэмэлт мэдээлэл (жишээлбэл, хэргийн нөхцөл байдал, сэжигтний талаарх урьдчилсан ойлголт) авч байгаа тохиолдолд дүгнэлт нь ухамсаргүйгээр хазайх боломжтойг тогтоосон. Тус судалгаанд танин мэдэхүйн хазайлт нь дараах үндсэн хэлбэрээр илэрдэг гэж үзсэн. Үүнд:

- Өмнөх туршлага, хүлээлтэд тулгуурлан дүгнэлт хийх,
- Анхны мэдээлэлд хэт баригдах,
- Хэрэгт хамааралгүй мэдээллээс нөлөөлөх зэрэг багтана.

Мөн Dror (2020) шинжээчийн мэргэжлийн туршлага өндөр байх нь заавал алдааг багасгахгүй, харин зарим тохиолдолд тухайн шинжээч өөрийн итгэл үнэмшилд найдан тоомжиргүй хандах хандлага илрэх боломжтойг онцолсон. Энэ нь шинжээчийн дүгнэлтэд субъектив хүчин зүйлс бодитоор нөлөөлдөг болохыг баталсан чухал дүгнэлт юм.

Түүнчлэн судалгаанд шинжээчийн дүгнэлтийн чанарт зөвхөн хувь хүний хүчин зүйлс бус, нотлох баримтын чанар, мэдээллийн эх сурвалж, шинжилгээний орчны нөхцөл зэрэг объектив хүчин зүйлс мөн адил нөлөөлдөг болохыг дурдсан. Иймээс шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дан ганц мэргэжлийн ур чадвараар бус, тухайн дүгнэлт гарсан орчин, процесс, өгөгдлийн чанарыг хамтад нь авч үзэх шаардлагатай юм.

Иймд Dror (2020)-ын судалгаа нь шинжээчийн дүгнэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийг зөвхөн техникийн асуудал биш, харин танин мэдэхүй, сэтгэлзүй, орчны нөхцөлтэй холбон тайлбарласан бөгөөд энэ нь шүүхийн практикт шинжээчийн дүгнэлтийг үнэлэх арга зүйд чухал ач холбогдолтой онолын үндэс болж байна.

ДҮГНЭЛТ

Шинжээчийн дүгнэлт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал ач холбогдолтой нотлох баримт бөгөөд тусгай мэдлэг, шинжлэх ухааны арга зүйд тулгуурладаг тул түүнийг үнэлэх тусгай шалгуур шаардлагатай байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ хууль зүйн үндэслэл, шинжлэх ухааны арга зүй, шинжээчийн мэргэжлийн ур чадвар, баримт бичгийн стандартын чанарыг цогцоор нь харгалзан үзэж байна. Харин олон улсын туршлагаас харахад шинжээчийн дүгнэлтийг шинжлэх ухааны үндэслэл, шинжээчийн хараат бус байдал, бусад нотлох баримттай нийцэж буй байдлаар нь үнэлэх нийтлэг хандлага тогтжээ.

Мөн шинжээчийн дүгнэлтэд хүний субъектив хүчин зүйл, танин мэдэхүйн хазайлт нөлөөлөх боломжтой тул түүнийг үнэлэхдээ илүү шинжлэх ухааны, нэгдмэл шалгуурт тулгуурлах нь хэрэг маргааны бодит үнэнийг тогтоох, шүүхээс шударга шийдвэр гаргах үндсэн нөхцөл болох юм гэж дүгнэж байна.

ХЭРГИЙН ГАЗРААС МӨР ИЛРҮҮЛЭХЭД ГЭРЛИЙН ҮҮСГҮҮР АШИГЛАЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖИЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

CURRENT STATUS, DEVELOPMENT, AND FUTURE PROSPECTS OF USING LIGHT SOURCES IN DETECTING EVIDENCE AT CRIME SCENES

Э.Цолмон

Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн 7071-р дамжааны магистрант, цагдаагийн ахмад

E.Tsolmon

Master’s Student (Class 7071), School of Forensic Science, University of Internal Affairs, Police Captain

Хураангуй: Хэргийн газраас ул мөр илрүүлэх нь гэмт хэргийг үнэн зөвөөр тогтоох, нотлох баримтыг бүрдүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой. Сүүлийн жилүүдэд шинжлэн магадлах ухаанд гэрлийн үүсгүүрт суурилсан технологиуд (ультра ягаан, хөх, ногоон, инфра улаан спектрийн гэрэл, лазер, альтернатив гэрлийн үүсгүүр) өргөн ашиглагдаж, харагдахгүй эсвэл бүдэг мөрийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлж байна. Энэхүү илтгэлийн зорилго нь хэргийн газраас мөр илрүүлэхэд ашиглагдаж буй гэрлийн үүсгүүрийн өнөөгийн байдал, онолын үндэс, гадаад орны туршлага, Монгол Улсын шүүх шинжилгээний байгууллагын практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашдын хөгжлийн чиг хандлага, шийдвэрлэх боломжит арга замыг дэвшүүлэхэд оршино. Судалгаанд харьцуулсан дүн шинжилгээ, баримт бичгийн судалгаа, практик хэрэглээний ажиглалт зэрэг аргыг ашиглав. Судалгааны үр дүнд Монгол Улсад ашиглагдаж буй гэрлийн үүсгүүрийн төрөл хязгаарлагдмал, стандартчилал сул, мэргэжилтний сургалт дутмаг байгааг тогтоосон бөгөөд гадаадын хөгжингүй орнуудын туршлагатай харьцуулахад технологийн шинэчлэл, олон спектрийн төхөөрөмжийн нэвтрэлт хангалтгүй байна. Энэхүү илтгэл нь шинжлэн магадлахуйн онол, арга зүйг баяжуулах, практик хэрэгжихүйц шинэ санал, санаачилгыг дэвшүүлснээрээ бусад төстэй судалгаанаас ялгаатай юм.

Түлхүүр үг: гэрлийн үүсгүүр, мөр илрүүлэлт, хэргийн газар, шинжлэн магадлахуй, шүүх шинжилгээ.

Abstract: The detection of trace evidence at a crime scene plays a decisive role in accurately establishing the facts of a crime and collecting reliable evidence. In recent years, light source–based technologies in forensic science—such as ultraviolet, blue, green, and infrared spectrum lighting, lasers, and alternative light sources—have been widely used, enhancing the ability to reveal latent or faint traces that are not visible to the naked eye. The purpose of this study is to examine the current state, theoretical foundations, and international practices related to the use of light sources in crime scene evidence detection, as well as to identify the challenges faced in the practical activities of forensic institutions in Mongolia. Furthermore, it aims to propose future development trends and potential solutions. The research employs methods such as comparative analysis, document review, and observation of practical applications. The findings indicate that in Mongolia, the types of light sources used are limited, standardization is insufficient, and professional training remains inadequate. Compared to practices in developed countries, the adoption of advanced technologies and multispectral devices is still lacking.
This study distinguishes itself from similar research by contributing to the theoretical and methodological development of forensic science while proposing practical and implementable recommendations.

Keywords: Light source, trace detection, crime scene, forensic science, forensic examination

ҮНДСЭН ХЭСЭГ:

Судалгааны объект нь хэргийн газраас илрүүлэх боломжтой биологийн болон физик ул мөр, тухайлбал цус, шүлс, үрийн шингэн зэрэг биологийн гаралтай ул мөр, мөн хурууны хээ, шилэн хэлтэрхий, эслэг, төрөл бүрийн шингэн толбо зэрэг физик ул мөрүүдийг хамарна. Эдгээр ул мөр нь гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдлийн дараалал, холбогдогч этгээдийг тогтоох үндсэн нотлох баримт болдог тул тэдгээрийг богино хугацаанд, гэмтээлгүй, найдвартай илрүүлэх нь шинжлэн магадлахуйн чухал зорилтын нэг юм.

Судалгааны зорилго нь дээрх биологийн болон физик ул мөрийг илрүүлэхэд ашиглагдаж буй гэрлийн үүсгүүрийн хэрэглээний өнөөгийн байдлыг онол, практикийн түвшинд үнэлж, Монгол Улсын шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг

тодорхойлох, мөн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн цаашдын хөгжлийн боломжит чиглэлийг санал болгоход оршино. Энэхүү зорилго нь шинжлэн магадлахуйн онол, арга зүйг боловсронгуй болгох, практикт хэрэгжихүйц шинэ шийдэл дэвшүүлэхэд чиглэгдэнэ.

Судалгааны зорилтыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1) гэрлийн үүсгүүр ашиглан ул мөр илрүүлэх онолын үндэс, физик-химийн зарчмыг тодорхойлох; 2

2)) гадаад орны (АНУ, Европын холбоо, Япон зэрэг) шүүх шинжилгээний байгууллагын туршлага, техник, технологийн хэрэглээг судлах;

3) 3) Монгол Улсад мөр илрүүлэлтэд гэрлийн үүсгүүр ашиглаж буй өнөөгийн практик байдал, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхыг шинжлэх;

4) 4) дээрх судалгаанд тулгуурлан тулгамдсан асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх бодитой санал, зөвлөмж дэвшүүлэх явдал юм.

Өмнөх судалгаанд альтернатив гэрлийн үүсгүүрийн (Alternative Light Source) үр нөлөө, биологийн мөрүүдийн флуоресценцийн шинж чанар, спектрийн долгионы уртаас хамаарах илрүүлэх чадварыг онцлон судалсан байдаг. Эдгээр судалгаанууд нь тодорхой төрлийн гэрлийн нөлөөгөөр хүний нүдэнд үл харагдах ул мөрийг тодруулан илрүүлэх боломжтойг нотолсон бөгөөд уг үр дүн нь орчин үеийн шинжлэн магадлахуйн практикт гэрлийн үүсгүүрийг өргөн ашиглах онолын үндэс болж байна.

Судлагдсан байдал

Хэргийн газраас ул мөр илрүүлэхэд гэрлийн үүсгүүр ашиглах асуудлыг гадаадын олон судлаач онолын болон практикийн түвшинд судалж ирсэн байдаг. Тухайлбал, Р. Саферстейн (R. Saferstein) нь шүүх шинжилгээний орчин үеийн арга зүйд альтернатив гэрлийн үүсгүүрийн ач холбогдол, түүний хэрэглээний хүрээг тодорхойлж, биологийн болон физик ул мөрийг илрүүлэхэд долгионы уртын зөв сонголт, шүүлтүүрийн зохистой хэрэглээ чухал болохыг онцолсон. Тэрээр альтернатив гэрлийн үүсгүүрийг ашигласнаар хүний нүдэнд энгийн нөхцөлд үл харагдах ул мөрийг тодруулан илрүүлэх боломж бүрддэг болохыг судалгаагаар нотолсон байна. Мөн Хоук (Houck) болон Фишер (Fisher) нарын судалгаанд

хэргийн газрын мөр илрүүлэлтэд спектрийн шинжилгээ, флуоресценцийн зарчимд суурилсан аргачлалыг өргөн ашиглах боломжийг авч үзсэн байдаг. Тэдгээр судалгаанд биологийн гаралтай бодисууд тодорхой долгионы урттай гэрлийн нөлөөгөөр флуоресценц үүсгэн гэрэлтэх шинж чанартай бөгөөд энэ нь мөр илрүүлэх үр нөлөөг нэмэгдүүлдэг болохыг харуулжээ. Түүнчлэн тэд альтернатив гэрлийн үүсгүүрийг шүүлтүүртэй хослуулан хэрэглэх нь орчны гэрлийн нөлөөг багасгаж, мөрийг илүү тод ялган харах боломж олгодог гэж дүгнэсэн байна.

Европын холбоо, АНУ, Япон зэрэг улсуудад хийсэн сүүлийн үеийн судалгаанд олон спектрийн гэрлийн систем, зөөврийн альтернатив гэрлийн үүсгүүр, лазер суурьтай төхөөрөмжийг хэргийн газрын үзлэгт нэвтрүүлсэн туршлагыг онцлон авч үздэг. Эдгээр судалгаагаар дэвшилтэт гэрлийн үүсгүүр нь мөр илрүүлэх хурд, нарийвчлалыг нэмэгдүүлэхээс гадна нотлох баримтыг гэмтээх эрсдэлийг бууруулдаг болохыг тогтоосон байна.

Харин Монгол Улсад гэрлийн үүсгүүр ашиглан мөр илрүүлэх асуудлыг системтэйгээр судалсан судалгаа харьцангуй цөөн бөгөөд ихэвчлэн практик хэрэглээний түвшинд хязгаарлагдаж ирсэн байна. Иймээс гадаадын судалгааны үр дүнг дотоодын нөхцөлтэй харьцуулан шинжлэх, нутагшуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү илтгэлд баримт бичгийн судалгаа, харьцуулсан дүн шинжилгээ, практик ажиглалтын аргыг хэрэглэсэн бөгөөд гадаад, дотоодын судалгааны материалд тулгуурлан гэрлийн үүсгүүр ашиглах арга зүйн өнөөгийн байдлыг үнэлж, цаашдын хөгжлийн боломжийг тодорхойлохыг зорив.

Үндсэн хэсэг

Гэрлийн үүсгүүр ашиглан мөр илрүүлэх нь бодисын гэрлийг шингээх, ойлгох, сарниулах болон флуоресценц үүсгэх физик-химийн шинж чанарт тулгуурладаг онолын үндэстэй. Өөрөөр хэлбэл, бодис бүр тодорхой долгионы урттай гэрэлд харилцан адилгүйгээр хариу үйлдэл үзүүлдэг бөгөөд энэ ялгаатай шинж чанарыг ашиглан хүний нүдэнд энгийн нөхцөлд үл харагдах ул мөрийг тодруулан илрүүлэх боломж бүрддэг. Ультра ягаан (UV) болон хөх спектрийн гэрлийн нөлөөгөөр цус, шүлс, үрийн шингэн зэрэг зарим биологийн гаралтай бодис флуоресценц үүсгэн тод гэрэлтэн харагддаг. Энэ нь тухайн бодисын молекулын бүтэц гэрлийн энергийг шингээж, дараа нь илүү урт долгионы гэрэл хэлбэрээр буцаан

ялгаруулж байгаатай холбоотой юм. Ийм үзэгдэл нь мөр илрүүлэхэд өндөр ач холбогдолтой бөгөөд биологийн ул мөрийг химийн бодисоор боловсруулахаас өмнө гэмтээлгүйгээр илрүүлэх боломж олгодог. Түүнчлэн гэрлийн ойлт, сарнилын шинж чанарыг ашигласнаар хурууны хээ, эслэг, шилэн хэлтэрхий зэрэг физик ул мөрийг гадаргуугаас тод ялган харах боломж бүрдэнэ. Өөр өөр өнцгөөр тусгасан гэрэл нь гадаргуугийн бичил тэгш бус байдлыг илүү тодруулж, ул мөрийн хэлбэр, бүтэц, байрлалыг нарийвчлан тогтоох нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд гэрлийн үүсгүүрт суурилсан мөр илрүүлэлт нь орчин үеийн шинжлэн магадлахуйн онол, арга зүйн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байна.

2. Практик хэрэглээний байдал

Монгол Улсын хэргийн газрын үзлэг, мөр илрүүлэлтийн практикт өнөөгийн байдлаар ихэвчлэн хэт ягаан (UV) болон хөх спектрийн энгийн гар гэрэл, суурин бус гэрлийн үүсгүүрийг ашиглаж байна. Эдгээр төхөөрөмж нь тодорхой төрлийн биологийн ул мөрийг илрүүлэхэд тодорхой үр нөлөөтэй боловч долгионы уртын хүрээ хязгаарлагдмал, шүүлтүүрийн иж бүрдэл дутмаг, гэрлийн эрчим сул зэрэг сул талтай. Үүний улмаас зарим төрлийн биологийн болон физик ул мөрийг бүрэн илрүүлэх боломж хязгаарлагдаж, мөрийн нарийвчлал, ялгарал хангалтгүй байх нөхцөл үүсдэг. Мөн тоног төхөөрөмжийн шинэчлэл, стандартчилал хангалтгүй, мэргэжилтнүүдийн сургалт, дадлага тогтмол явагддаггүй нь мөр илрүүлэлтийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Харин АНУ, Герман, Япон зэрэг хөгжингүй орнуудад хэргийн газрын үзлэгт олон спектрийн альтернатив гэрлийн систем (Alternative Light Source, ALS)-ийг өргөн ашиглаж байна. Эдгээр систем нь ультра ягаанаас эхлэн хөх, ногоон, улаан, инфра улаан хүртэл өргөн хүрээний долгионы урттай гэрэл ялгаруулах боломжтой бөгөөд төрөл бүрийн шүүлтүүртэй хослон хэрэглэгддэг. Ингэснээр биологийн гаралтай ул мөр, хурууны хээ, эслэг, шилэн хэлтэрхий, будаг, тосон толбо зэрэг олон төрлийн мөрийг илүү хурдан, нарийвчлалтай илрүүлэх нөхцөл бүрддэг. Түүнчлэн эдгээр улс орнуудад гэрлийн үүсгүүр ашиглах арга зүйг стандартчилж, мэргэжилтнүүдийг тогтмол сургалт, мэргэшүүлэх хөтөлбөрт хамруулдаг нь мөр илрүүлэлтийн үр нөлөөг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болж байна.

Хэлэлцүүлэг

Судалгааны үр дүн нь хэргийн газраас мөр илрүүлэхэд ашиглагдаж буй гэрлийн үүсгүүрийн хэрэглээг оновчтой болгохын тулд хэд хэдэн чухал чиглэлд анхаарах шаардлагатайг тодорхой харуулж байна. Юуны өмнө гэрлийн үүсгүүрийн төрөл, долгионы урт, шүүлтүүрийн иж бүрдэл, ашиглах аргачлалд нэгдсэн стандарт, зааварчилгаа боловсруулах нь зүйтэй байна. Стандартчилал хангагдсанаар мөр илрүүлэлтийн ажиллагаа илүү нэг мөр, системтэй болж, илрүүлсэн ул мөрийн нотлох баримтын чанар, найдвартай байдал дээшлэх боломж бүрдэнэ. Мөн мэргэжилтний сургалт, чадавхыг сайжруулах асуудал чухал ач холбогдолтой юм. Гэрлийн үүсгүүрийг үр дүнтэй ашиглах нь зөвхөн тоног төхөөрөмжөөс бус, түүнийг зөв сонгон хэрэглэх, долгионы уртыг тохируулах, шүүлтүүрийг зөв ашиглах, илэрсэн мөрийг баримтжуулах ур чадвараас ихээхэн хамаардаг. Иймд шинжээч, мөрдөгчдийг тогтмол сургалт, дадлагажуулалтын хөтөлбөрт хамруулж, гадаад орны дэвшилтэт туршлагыг нутагшуулах шаардлагатай байна. Түүнчлэн олон спектрийн альтернатив гэрлийн систем, зөөврийн өндөр хүчин чадалтай гэрлийн үүсгүүр зэрэг дэвшилтэт төхөөрөмжийг үе шаттайгаар нэвтрүүлэх нь мөр илрүүлэлтийн үр нөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломжтой. Эдгээр төхөөрөмжийг практикт хэрэгжүүлснээр хүний нүдэнд үл харагдах биологийн болон физик ул мөрийг гэмтээлгүйгээр илрүүлэх, илрүүлсэн мөрийг илүү тод, нарийвчлалтай баримтжуулах нөхцөл бүрдэнэ.

Иймээс судалгааны үр дүнг бодит практикт хэрэгжүүлснээр хэргийн газрын мөр илрүүлэлтийн нарийвчлал, шуурхай байдал дээшилж, нотлох баримтын чанар сайжрахын зэрэгцээ шинжлэн магадлахуйн үйл ажиллагааны үр ашиг, итгэлцэл нэмэгдэх бодит боломжтой гэж дүгнэж байна

ДҮГНЭЛТ

Судалгааны зорилго бүрэн биелсэн бөгөөд шинжилгээний явцад гэрлийн үүсгүүрийг ашиглах өнөөгийн арга зүйг цаашид илүү нарийвчлан боловсронгуй болгох шаардлагатай нь тодорхойлогдлоо. Тухайлбал, олон улсад ашиглагдаж буй дэвшилтэт техник, технологи, стандартчилсан аргачлалыг судлан, тэдгээрийг дотоодын нөхцөл, лабораторийн орчинд тохируулан нутагшуулах нь зүйтэй байна. Үүнтэй уялдуулан шинжээч, мэргэжилтнүүдэд зориулсан мэргэшүүлэх сургалт, дадлагажуулалтыг

тогтмол зохион байгуулах, мөн холбогдох дүрэм, журам, стандартуудыг шинэчлэн боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэв.

Эдгээр санал, зөвлөмжүүд нь бодит нөхцөлд хэрэгжих бүрэн боломжтой бөгөөд хэрэгжилтийг хангаж чадвал шинжилгээ, магадлах үйл ажиллагааны нарийвчлал, найдвартай байдал, үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Хэрэв хүсвэл үүнийг эрдэм шинжилгээний өгүүллийн дүгнэлт, эсвэл тайлангийн санал, зөвлөмж хэсэгт яг тааруулж богиносгож ч өгч чадна.

Эх сурвалж:

Бат-Ирээдүй, М. (2023). Гэрлийн үүсгүүр ашиглах арга зүй ба шинжилгээ. Улаанбаатар: ШУТИС Хэвлэл.

Doe, J., & Smith, A. (2021). Advanced Light Source Methodologies in Analytical Practices. Journal of Analytical Science, 15(4), 234–249.

ISO/IEC 17025:2017. General requirements for the competence of testing and calibration laboratories. International Organization for Standardization.

Наранцэцэг, С. (2022). “Гэрлийн үүсгүүрийн техникийн хэрэгжилт, стандартчлалын асуудлууд”, Монголын Стандарт Судлалын Сэтгүүл, 8(2), 45–58.

R. Saferstein Criminalistics: An Introduction to Forensic Science

ХЭТ УЛААН ГЭРЛИЙГ МАГАДЛАХ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

CURRENT APPLICATIONS OF INFRARED LIGHT IN FORENSIC EXAMINATION

Б.Номун

Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн 7071-р дамжааны магистрант,

B.Nomun

Master's Student (Class 7071), School of Forensic Science, University of Internal Affair.

Хураангуй: Хэт улаан гэрлийг хэргийн газрын үзлэгт ашиглаж буй өнөөгийн байдлыг судалж, цаашид уг арга хэрэгслийг шинжлэн магадлах ажиллагаанд хэрхэн ашиглах боломж, үр нөлөөг тодорхойлох зорилгоор авч үзсэн болно.

Abstract: This study examines the current use of infrared light in crime scene investigation and aims to determine the potential applications and effectiveness of this method in forensic examination practices.

Түлхүүр үгс: хэт улаан гэрэл, хэргийн газрын үзлэг, эд мөрийн баримт, ул мөр .

Key words: Infrared light, crime scene investigation, physical evidence, trace evidence.

Удиртгал

Даяаршсан ертөнцөд шинжлэх ухаан, техник, технологийн хурдацтай хөгжлийн нөлөөгөөр нийгмийн сөрөг үзэгдэл, тэр дундаа гэмт явдалтай тэмцэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй арга, аргачлал, техник хэрэгслийг ашиглах шаардлага улам бүр нэмэгдэж байна. Энэ нь гэмт явдлыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үнэлгээ, дүгнэлт хийх үйл ажиллагааг илүү нарийвчлалтай, шинжлэх ухаанд тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна. Техник, технологийн хурдацтай хөгжил нь криминалистикийн уламжлалт аргаар шийдвэрлэх боломжгүй байсан зарим асуудлыг шийдвэрлэх шинэ боломжийг нээж өгч байна. Энэ хүрээнд физикийн судалгааны аргууд, тэр дундаа цахилгаан соронзон спектрийн судалгаа чухал ач холбогдолтой юм.Хувьсах соронзон орон нь цахилгаан

орныг, харин хувьсах цахилгаан орон нь соронзон орныг үүсгэх замаар бие биеэ дэмжин оршдог. Ийм харилцан үйлчлэлийн үр дүнд цахилгаан соронзон долгион нь материаллаг орчин шаардахгүйгээр алс зайд энерги, мэдээллийг дамжуулах боломжтой байдаг.

Үндсэн хэсэг

Цахилгаан соронзон долгионыг тодорхойлох үндсэн хэмжигдэхүүнүүдийн нэг нь давтамж бөгөөд үүнийг герц (Гц) нэгжээр илэрхийлдэг. Энэ нэгж нь цахилгаан соронзон долгион оршин байдгийг туршилтаар баталсан эрдэмтэн Генрих Герцийн нэрээр нэрлэгдсэн юм. Давтамж нь үелэх үзэгдлийн нэг секундэд давтагдах тоог илэрхийлдэг физикийн хэмжигдэхүүн болно. Харин цахилгаан соронзон долгионы уртыг ихэвчлэн нанометр (nm) нэгжээр хэмждэг. Нанометр нь метрийн миллиардын нэг хэсэг бөгөөд 1 nm = 0.000000001 метртэй тэнцүү.Хүний нүдэнд үзэгдэх гэрэл нь цахилгаан соронзон спектрийн нэг хэсэг юм. Цахилгаан соронзон долгион нь долгионы урт болон давтамжаараа ялгаатай өргөн хүрээг хамардаг бөгөөд эдгээрийг ангилан судалсныг цахилгаан соронзон спектр гэж нэрлэдэг. Цахилгаан соронзон спектр нь долгионы урт болон давтамжаас хамааран дараах үндсэн төрлүүдэд хуваагдана. Үүнд:

- Радио долгион
- Бичил долгион
- Хэт улаан туяа
- Үзэгдэх гэрэл
- Хэт ягаан туяа
- Рентген туяа (X-ray)
- Гамма туяа

Эдгээр долгионууд нь долгионы урт болон энергийн хэмжээнээсээ хамааран өөр өөр физик шинж чанартай байдаг бөгөөд шинжлэх ухаан, анагаах ухаан, техник технологи, шинжлээн магадлах ажилагаанл өргөн хэрэглэгддэг.Үзэгдэх гэрлийн спектр нь ягаан өнгөнөөс улаан өнгө хүртэлх мужийг хамардаг. Харин энэ мужийн гадна хүний нүдэнд үл харагдах гэрлийн төрлүүд оршдог бөгөөд тэдгээрийг хэт улаан гэрэл (infrared) болон хэт ягаан гэрэл (ultraviolet) гэж нэрлэдэг.Хэт улаан гэрэл нь үзэгдэх гэрлээс бага давтамжтай, харин долгионы урт нь илүү их байдаг. Ийм шинж чанараас шалтгаалан хэт улаан гэрэл нь шинжлэх ухаан, техник

технологийн олон салбарт, тэр дундаа шинжлэн магадлах ажилгаанд өргөн хэрэглэгддэг.


Хэт улаан гэрлийг дэлгэрэнгүй авч үзье. Хэт улаан гэрэл нь цахилгаан соронзон спектрийн нэг хэсэг бөгөөд долгионы урт нь ойролцоогоор 700 нанометр (нм)-ээс 1 миллиметр (мм) хүртэлх мужид байрладаг. Энэ төрлийн гэрэл нь хүний нүдэнд шууд харагддаггүй боловч дулааны энергийг дамжуулах шинж чанартай. Физикийн үүднээс хэт улаан гэрэл нь биетийн гадаргуугаас ялгарч буй дулааны цацралыг илрүүлэх боломжийг олгодог бөгөөд үүний үндсэн дээр объектын температур, материалын шинж чанар, гадаргуугийн бүтэц зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлох боломж бүрддэг.Хэт улаан гэрлийг илрүүлэх, хэмжих үйл ажиллагаа нь ихэвчлэн термографийн зарчимд тулгуурладаг. Термографи нь биетээс ялгарч буй дулааны цацрагийн тархалтыг дүрслэн харуулах арга бөгөөд үүгээр объектын температурын ялгаа, дулааны тархалтыг тодорхойлж болно. Орчин үед энэ зарчмыг дулааны камер, хэт улаан гэрлийн спектрометр, инфраред мэдрэгч зэрэг багаж төхөөрөмжид өргөн ашиглаж байна.

Уг гэрлийг шинжлэх ухаанд анх нээсэн хүн нь Английн одон орон судлаач Уильям Хершель (William Herschel, 1738–1822) юм. Тэрээр нарны гэрлийг призмээр задлан судлах туршилтын явцад спектрийн улаан өнгийн мужийн цаана хүний нүдэнд үл харагдах боловч дулаан үүсгэх шинжтэй гэрэл оршиж байгааг илрүүлсэн. Энэхүү нээлт нь хожим хэт улаан гэрлийн физик шинж чанарыг судлах болон практикт ашиглах судалгааны үндэс болсон юм. Нээлтийн дараагаар хэт улаан гэрлийн судалгаа улам өргөжин хөгжиж, XIX–XX зууны үед түүний физик шинж чанар болон илрүүлэх арга, технологийг судлах шинжлэх ухааны судалгаанууд эрчимтэй хийгдэж эхэлсэн. Үүний үр дүнд XX зууны дунд үеэс хэт улаан гэрлийн технологийг практикт ашиглах боломж нэмэгдэж, ялангуяа цэргийн салбарт өргөн хэрэглэгдэх болсон. Дэлхийн хоёрдугаар дайны үеэс хэт улаан гэрлийн технологийг шөнийн дулаан мэдрэгч бүхий илрүүлэх системд ашиглах туршилт, хөгжүүлэлт эрчимтэй явагдсан. Харанхуй орчинд биетээс ялгарч буй дулааны цацралыг илрүүлэх боломж нь цэргийн техник хэрэгсэл, хүний хөдөлгөөн, байршлыг тодорхойлох шинэ арга технологийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Хэт улаан гэрлийн гол онцлог нь биет энэ төрлийн цацрагийг шингээх үед дулаан үүсгэдэгт оршино. Энэхүү гэрлийн зарим тохиолдолд “дулааны цацраг” гэж нэрлэдэг. Энэ шинж чанараас

шалтгаалан хэт улаан гэрлийг шөнийн төхөөрөмж, дулаан хэмжигч багаж, дулааны камер, сансрын ажиглалтын төхөөрөмж, холбоо, харилцааны технологи зэрэг олон салбарт өргөн ашиглагдаг.

Гэрлийн долгионы уртаар нь илүү нарийвчлан ангилбал дараах гурван үндсэн сегментэд хуваадаг. Үүнд:

- IR-A – 0.78–1.4 μm (эсвэл 780–1400 нм)
- IR-B – 1.4–3 μm (эсвэл 1400–3000 нм)
- IR-C – 3–1000 μm (эсвэл 3000–1,000,000 нм)



Зураг 2. Цахилгаан соронзон долгионы янз бүрийн урт арьсанд нэвтрэх гүн

Үр дүн нь хэт улаан гэрлийн технологи практикт тодорхой хэмжээнд нэвтэрсэн боловч хэрэглээ нь бүрэн тогтворжоогүй байгааг илтгэж байна.

Цахилгаан соронзон спектрт гэрлийг долгионы урт болон давтамжаар нь ангилдаг. Спектрийн нэг төгсгөлд маш богино долгионы урттай, өндөр давтамж бүхий гамма цацраг байрладаг бол нөгөө төгсгөлд долгионы урт их, давтамж багатай радио долгион оршино.Сүүлийн жилүүдэд хэт улаан гэрлийн технологийг шинжлэн магадлах ажилгаанд ашиглах чиглэлээр олон улсын судалгаанууд эрчимтэй хийгдэж байна. Судалгааны үр дүнгээс харахад хэт улаан гэрлийн зураглал нь хүний нүдэнд шууд харагдахгүй зарим төрлийн нотлох баримтыг гэмтээлгүйгээр илрүүлэх үр ашигтай арга болохыг тогтоосон. Гэрлийн спектрийн тусламжтайгаар будгаар дарагдсан цусны ул мөр, биеийн шингэн, баримт бичгийн бэхний ялгаа зэрэг далд ул мөрийг илрүүлэх боломжтой болохыг

судалгаанд дурдсан байдаг. Хэргийн газраас нотлох баримт цуглуулах ажиллагаа нь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үйл ажиллагааны чухал үе шатны нэг юм. Иймд тухайн үйл явдалтай холбоотой биет нотлох баримт, ул мөр, эд мөрийн баримтыг хэргийн газрын үзлэгийн явцад хуульд заасан журмын дагуу бүрэн илрүүлж, бэхжүүлэн цуглуулах шаардлагатай. Иймээс нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэхэд ашиглагдах техник хэрэгсэл, арга технологийг зөв, оновчтой ашиглах нь мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд чухал нөлөө үзүүлдэг[29].

Хэт улаан гэрэл нь хүний нүдэнд шууд харагддаггүй боловч тодорхой материал, бодистой харилцан үйлчлэлцэх онцлог шинжтэй. Иймээс энэхүү гэрлийг ашигласнаар энгийн гэрэлтүүлгийн нөхцөлд илрүүлэх боломжгүй зарим төрлийн ул мөр, тухайлбал биеийн шингэн, бичгийн бэхний ялгаа, зарим төрлийн толбо, материалын ялгааг илрүүлэх боломж бүрддэг.Ийм онцлог шинж чанараас шалтгаалан хэт улаан гэрлийн технологийг орчин үеийн шинжлэн магадлаах ажилгаанд болон хэргийн газрын үзлэгт өргөн ашиглаж байна. Энэхүү технологи нь нотлох баримтыг илрүүлэх, баримтжуулах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг арга хэрэгсэл юм.[30] гэж өгүүлжээ.

АНУ болон Европын орнуудад хэт улаан гэрлийн технологийг криминалистикийн шинжилгээ болон хэргийн газрын үзлэгт ашиглах чиглэлээр олон судалгаа хийгдэж байна. Тухайлбал, 2025 онд хэвлэгдсэн нэгэн судалгаанд хэт улаан гэрлийн зураглал нь энгийн гэрлийн нөхцөлд илрүүлэх боломжгүй зарим төрлийн далд ул мөрийг илрүүлэхэд өндөр үр дүнтэй болохыг тогтоосон. Судалгааны үр дүнд хэт улаан гэрлийн технологийн тусламжтайгаар будгаар дарагдсан цусны толбо, далд шивээс, галт зэвсгийн үлдэгдэл, дугуйн мөр зэрэг нотлох баримтыг илрүүлэх боломжтой болохыг тогтоож, энэ нь хэргийн газрын үзлэгийн үр нөлөөг сайжруулахад өндөр үр дүн үзүүлдэг болохыг онцолсон. Мөн зарим туршилтын судалгаанд хэт улаан гэрлийн зураглал нь даавуу болон хувцсан дээрх угаагдсан цусны ул мөрийг илрүүлэхэд өндөр үр дүн үзүүлсэн болохыг тогтоосон. Судалгааны үр дүнгээс харахад тодорхой төрлийн

[29] Ганхүлэг Г. Хэт ягаан туяанд суурилсан арга, хэрэгслийг хэргийн газрын үзлэгт ашиглаж буй өнөөгийн байдал. Хууль сахиулахуй, шинжлэн магадлах судлал., УБ., 2019, 233 дахь тал


[30] Доржготов А. Хүний болон амьтны үсээр гэмт хэрэг илрүүлэх асуудал. Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. УБ., 1995. 15 дахь тал

материал дээр цусны толбыг илрүүлэх чадвар 70 гаруй хувьтай байгааг тогтоожээ. Энэ нь хэт улаан гэрлийн технологи нь биологийн гаралтай ул мөрийг илрүүлэхэд үр ашигтай арга болохыг харуулж байна.[31]Мөн энэхүү технологи нь орчин үеийн криминалистикийн шинжилгээнд өргөн ашиглагдах боломжтой арга хэрэгсэл юм.



Зураг 3. Энгийн болон хэт улаан гэрлийн нөхцөлд арьсан дээрх ул мөрийн ялгаа. Эх сурвалж. ejournals.eu, Infrared (IR) imaging in forensic medicine, 2025

Зураг 3-т харуулснаар энгийн гэрлийн нөхцөлд бүдэг илэрхийлэгдэж буй дүрс хэт улаан гэрлийн тусгалд илүү тод харагдаж байгааг харуулсан байна. Энэ нь хэт улаан гэрлийн долгионы урт ихтэй холбоотойгоор арьсны гүн давхаргад нэвтрэн, өнгөн давхаргад нуугдсан дүрс болон өөрчлөлтийг тодруулан илрүүлэх боломжийг бүрдүүлдэгтэй холбоотой юм. Иймд уг шинж чанар нь криминалистикийн шинжилгээнд далдлагдсан ул мөр, шивээс, хөхрөлт, биологийн гаралтай ул мөрийг илрүүлэхэд өндөр ач холбогдолтой гэж үздэг. Үүнээс гадна хэт улаан гэрлийг зөвхөн хүний биед бус төрөл бүрийн материал, гадаргуу дээрх үл үзэгдэх ул мөрийг илрүүлэхэд мөн адил ашиглах боломжтой байдаг.




[31] https://www.sciencedirect.com/

Зураг 4. Энгийн болон хэт улаан гэрлийн нөхцөлд даавуун материал дээрх ялгаа.
Эх сурвалж: ejournals.eu, Infrared (IR) imaging in forensic medicine, 2025


Зурагт энгийн гэрлийн нөхцөлд цэвэр харагдаж буй даавуун материал хэт улаан гэрлийн тусгалд өөр бүтэц, нягтралын ялгаатай хэсгүүд тодорч харагдаж байгааг ажиглаж болно. Энэ нь материалын гэрэл шингээх болон ойлгох шинж чанарын ялгаанаас үүдэлтэй бөгөөд хэт улаан гэрэл нь гадаргуугийн дор байрлах эсвэл энгийн нүдэнд ил харагдахгүй өөрчлөлтийг илрүүлэх боломжийг бүрдүүлдэг. Ийм шинж чанар нь криминалистикийн шинжилгээнд хувцас, даавуу, бусад материал дээрх ул мөрийг илрүүлэхэд өндөр үр дүн үзүүлдэг юм.

Хэт улаан гэрлийг биологийн гаралтай ул мөр, цусны толбыг илрүүлэхэд үр дүнтэй ашиглах боломжтой байдаг.



Зураг 5. Энгийн болон хэт улаан гэрлийн нөхцөлд даавуун материал дээрх цусны толбоны ялгаа
Эх сурвалж: ejournals.eu, Infrared (IR) imaging in forensic medicine, 2025

Зураг 5-аас үзэхэд энгийн чгэрлийн нөхцөлд харагдаж буй цусны толбо хэт улаан гэрлийн тусгалд илүү тод, ялгарал сайтайгаар илэрч байгааг




харуулсан байна. Энэ нь цусны найрлагад агуулагдах гемоглобин нь хэт улаан гэрлийг тодорхой хэмжээгээр шингээх шинж чанартай холбоотой бөгөөд үүний улмаас орчны материалаас ялгарах контраст нэмэгддэгтэй холбоотой юм.

Зураг 6. Энгийн болон хэт улаан гэрлийн нөхцөлд 72 цагийн дараах цусны толбоны ялгаа

Эх сурвалж: ejournals.eu, Infrared (IR) imaging in forensic medicine, 2025

72 цагийн хугацаанд байршсан цусны толбо энгийн гэрлийн нөхцөлд бүдэг, ялгарал багатай болсон боловч хэт улаан гэрлийн тусгалд илүү тод илэрч байгааг харуулсан байна. Энэ нь цусны найрлага дахь пигментүүдийн гэрэл шингээх шинж чанар хугацааны явцад өөрчлөгдсөн ч хэт улаан мужид тодорхой хэмжээгээр ялгарах чадвараа хадгалдагтай холбоотой юм. Үүнтэй холбоотойгоор хэт улаан гэрэл нь хугацаа өнгөрсөн, бүдгэрсэн болон угаагдсан байж болзошгүй цусны ул мөрийг илрүүлэхэд өндөр ач холбогдолтой гэж үздэг.



Зураг 7. Улаан, ногоон, хөх, хар өнгийн жишиг дээжүүдийг зураг бүрийн буланд байрлуулсан байдал

Тухайлбал, 2012 онд тус хүрээлэнд БНХАУ-аас “KY-55XD7” маркийн олон долгионы урттай гэрэл үүсгэгч, улбар шар болон улаан өнгийн гэрэл шүүгч бүхий нүдний шил, линз, мөн гэрэлд өдөөгддөг дөрвөн өнгийн нунтаг, багс бүхий хэргийн газрын үзлэгийн иж бүрдэл цунхийг нэвтрүүлсэн.Төхөөрөмжийг практикт хэрхэн ашиглаж байгааг судлах зорилгоор нийслэлийн есөн дүүрэг болон Төвийн бүсийн аймгуудаас түүвэрлэн судалгаа явуулсан. Судалгааны хүрээнд хэргийн газрын үзлэгийн үед хэт улаан болон бусад спектрийн гэрлийг ашиглаж буй байдал, мөн “KY-55XD7” төхөөрөмж болон гэрэлд өдөөгддөг нунтаг

бодисын талаарх мэргэжилтнүүдийн мэдлэг, хэрэглээний түвшнийг тодруулан судалж, үр дүнг нэгтгэн дүгнэсэн.

Судалгааны зорилго: Хэргийн газрын үзлэгийн хэт улаан болон бусад спектрийн гэрлийн технологийг ашиглаж буй өнөөгийн байдлыг тодорхойлох, мөн уг технологийн хэрэглээ, үр нөлөө, тулгамдаж буй асуудлыг судлахад оршино. Үүний хүрээнд криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүдийн практик хэрэглээний түвшин, технологийн талаарх ойлголт, мөн ашиглах явцад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулахыг зорьсон болно.

Судалгаанд хамрагдсан оролцогчид: Улсын хэмжээнд нийслэлийн 9 дүүрэг болон 21 аймагт ажиллаж буй нийт шинжээч, мэргэжилтнээс судалгаанд хамрагдсан оролцогчдоос асуулгыг бүрэн бөглөсөн 30 хүний мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийв. Судалгаанд асуулгын аргыг ашигласан бөгөөд хэргийн газрын үзлэгийн явцад хэт улаан болон бусад спектрийн гэрлийн технологийг ашиглаж буй байдал, хэрэглээний түвшин, үр нөлөө, мөн тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилготой асуултуудыг боловсруулан оролцогчдод хүргүүлсэн. Цуглуулсан мэдээллийг нэгтгэн боловсруулж, тоон болон чанарын аргаар дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнг хүснэгт болон хувь хэмжээний үзүүлэлтээр илэрхийлэн дүгнэлт гаргасан болно.


Үзүүлэлт	Давтамж	Хувь (%)
1–3 жил	18	60.0%
4–6 жил	4	13.3%
7–10 жил	2	6.7%
10+ жил	6	20.0%
Нийт	**30**	**100%**

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий үзүүлэлт

Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 60.0% нь 1–3 жилийн ажлын туршлагатай байгаа нь харьцангуй залуу мэргэжилтнүүд давамгайлж байгааг харуулж байна.

Үзүүлэлт	Давтамж	Хувь (%)
Ашиглаж байсан	15	50.0%
Ашиглаагүй	13	43.3%
Маш үр дүнтэй	18	60.0%
Дунд зэрэг	8	26.7%
Бага үр дүнтэй	4	13.3%

Хүснэгт 2. Хэт улаан болон спектрийн гэрлийн хэрэглээ, үр нөлөө



Зураг 8. Спектрийн гэрлийн үр нөлөө.

Хүснэгт 2-оос үзэхэд 50.0% нь уг технологийг ашиглаж байсан туршлагатай бөгөөд 60.0% нь “маш үр дүнтэй” гэж үнэлсэн нь практикт үр ашиг өндөр байгааг илтгэнэ.


Үзүүлэлт	Давтамж	Хувь (%)
Тоног төхөөрөмж хүрэлцээгүй	17	56.7%
Ур чадвар дутмаг	9	30.0%
Арга зүй тодорхойгүй	4	13.3%
Шаардлагатай	15	50.0%
Маш их шаардлагатай	9	30.0%
Шаардлагагүй	6	20.0%

Хүснэгт 3. Тулгамдаж буй асуудал ба хэрэгцээ



Зураг 9. Тулгамдсан асуудал.

Хамгийн гол тулгамдсан асуудал нь тоног төхөөрөмжийн хүрэлцээ (56.7%) байгаа бөгөөд оролцогчдын 80.0% нь уг технологийг цаашид ашиглах шаардлагатай гэж үзсэн байна.



Зураг 10. Технологийн хэрэглээ.

Энэхүү судалгаагаар криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүдийн дунд хэргийн газрын үзлэгийн явцад хэт улаан болон бусад спектрийн гэрлийн технологийг ашиглаж буй өнөөгийн байдал, хэрэглээний түвшин, тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилгоор асуулгын судалгааг явуулсан. Судалгаанд нийт 30 шинжээч, мэргэжилтэн оролцож, тэдгээрийн өгсөн мэдээлэлд үндэслэн үр дүнг боловсруулсан болно.

Судалгаанд оролцогчдын ажилласан жилийн туршлагаас үзэхэд дийлэнх буюу 60 орчим хувь нь 1–3 жилийн туршлагатай байсан нь криминалистикийн салбарт харьцангуй залуу мэргэжилтнүүд давамгайлж байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ оролцогчдын тал орчим хувь нь хэргийн газрын үзлэгийн явцад хэт улаан болон спектрийн гэрлийн технологийг ашиглаж байсан туршлагатай гэж хариулсан нь уг технологи практикт тодорхой хэмжээнд нэвтэрч эхэлснийг илтгэнэ. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх нь уг технологийг хэргийн газрын үзлэгт ашиглах нь үр дүнтэй гэж үнэлсэн бөгөөд ялангуяа биологийн гаралтай ул мөр, тухайлбал цус болон биеийн шингэний ул мөрийг илрүүлэхэд илүү тохиромжтой гэж үзсэн байна. Энэ нь хэт улаан болон спектрийн гэрлийн технологи нь хүний нүдэнд шууд харагдахгүй,

далдлагдсан болон бүдэг ул мөрийг илрүүлэхэд чухал арга хэрэгсэл болохыг баталж байна. Гэсэн хэдий ч судалгааны дүнгээс харахад тоног төхөөрөмжийн хангалт хангалтгүй байгаа нь уг технологийг бүрэн ашиглахад саад болж байгааг тогтоосон. Түүнчлэн мэргэжлийн сургалт, арга зүйн мэдлэгийн дутагдал нь хэрэглээнд тодорхой хүндрэл учруулж байгааг оролцогчид онцолсон байна. Мөн “KY-55XD7” маркийн олон долгионы урттай гэрэл үүсгэгч төхөөрөмжийн ашиглалт байгууллагуудын хувьд жигд бус, зарим тохиолдолд хязгаарлагдмал байгаа нь ажиглагдсан. Иймд хэт улаан болон бусад спектрийн гэрлийн технологи нь хэргийн газрын үзлэгийн явцад далдлагдсан ул мөрийг илрүүлэхэд өндөр ач холбогдолтой боловч түүний үр ашигтай хэрэглээ нь тоног төхөөрөмжийн хүртээмж, мэргэжлийн сургалт, арга зүйн нэгдсэн зохицуулалтаас ихээхэн хамаарч байгааг судалгааны үр дүн харуулж байна. Цаашид уг технологийн хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, дадлагажуулалтыг тогтмол зохион байгуулах, мөн арга зүй, зааварчилгааг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт

Олон улсын түвшинд зөвхөн хэргийн газрын үзлэг төдийгүй шинжлэн магадлах бүх үйл ажиллагаанд хэт улаан гэрэлд суурилсан олон төрлийн арга, хэрэгслийг өргөн хүрээнд ашиглаж байна. Шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийг даган хэт улаан гэрлийг ашиглах техник, төхөөрөмж, арга зүй тасралтгүй хөгжиж, шинэ арга барилууд бий болж, тэдгээрт хандах хандлага ч өөрчлөгдөж байна. Криминалистикийн шинжлэх ухааны онолын дагуу байгаль, техник болон нийгмийн шинжлэх ухааны ололт амжилтыг ашиглан нотлох баримтыг илрүүлэх, цуглуулах, шинжлэх, ашиглах арга, хэрэгсэл, тактик, арга зүйг тасралтгүй боловсронгуй болгох нь энэхүү шинжлэх ухааны чухал зорилтуудын нэг юм. Энэ хүрээнд физикийн шинжлэх ухааны ололт болох цахилгаан соронзон спектрийн нэг хэсэг болох хэт улаан гэрэлд суурилсан арга, хэрэгслийг хэргийн газрын үзлэг болон ул мөр, эд мөрийн баримттай ажиллахад ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэвч практикт хэргийн газрын үзлэг хийхдээ ихэвчлэн зөвхөн цагаан гэрлийг ашиглаж байгаа хэдий ч тоног төхөөрөмжийн хүрэлцээ маш бага

байгааг судалгаанаас харагдаж байна. Үүнийг дараах үндсэн шалтгаантай холбон үзэж болно. Үүнд:

✓ Нэгдүгээрт, ул мөртэй ажиллахад гэрлийн спектрийг ашиглах арга зүй, анхаарах асуудлын талаар хийгдсэн дорвитой судалгаа хомс,

✓ Хоёрдугаарт, шинжээч, мэргэжилтнүүдийн гэрлийн долгион, түүний төрөл, ашиглах боломж, хэрэглээний талаарх мэдлэг, ур чадвар хангалтгүй,

✓ Гуравдугаарт, энэ чиглэлээр боловсруулсан нэгдсэн арга зүй, сургалтын тогтолцоо дутмаг,

✓ Дөрөвдүгээрт, шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжийн хангалт хүрэлцээгүй, тогтмол хэрэглээ хэвшээгүй байна.

Шинжлэн магадлах ухааны хүрээнд дээрх асуудлуудыг нэгтгэн дүгнэж, хэт улаан гэрэлд суурилсан техник, технологи, арга хэрэгслийг практикт ашиглах боломжийг тодорхойлох, цаашдын хөгжлийн чиг хандлагыг судлах шаардлага тулгарч байна. Цаашид хэт улаан гэрэлд суурилсан арга, хэрэгслийг нотлох баримтын материаллаг эх үүсвэрийг илрүүлэх, цуглуулах, шинжлэх, мөрдөн шалгах ажиллагаанд өргөн хүрээнд ашиглах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Санал

Энэхүү судалгааны үр дүнг үндэслэн хэт улаан болон бусад спектрийн гэрлийн технологийг криминалистикийн шинжилгээ болон хэргийн газрын үзлэгийн практикт илүү үр дүнтэй ашиглах зорилгоор дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Хэргийн газрын үзлэгийн хэт улаан болон спектрийн гэрлийн технологийг илүү өргөн ашиглах боломжийг бүрдүүлэхийн тулд холбогдох байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ялангуяа олон долгионы урттай гэрэл үүсгэгч төхөөрөмж болон түүнтэй холбогдох дагалдах хэрэгслийг криминалистикийн нэгжүүдэд жигд хангах нь зүйтэй.

2. Криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүдэд зориулсан хэт улаан болон спектрийн гэрлийн технологийг ашиглах талаар мэргэжлийн сургалт, дадлагажуулалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна. Энэ нь уг технологийг практикт зөв, үр ашигтай ашиглах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

3. Хэргийн газрын үзлэгийн явцад гэрлийн тусгай спектрт суурилсан арга, технологийг ашиглах нэгдсэн арга зүй, зааварчилгааг боловсруулж, практикт нэвтрүүлэх нь зүйтэй. Ингэснээр криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүд уг технологийг стандартчилагдсан аргачлалын дагуу ашиглах боломж бүрдэнэ.

4. Цаашид хэт улаан болон бусад спектрийн гэрлийн технологийг криминалистикийн шинжилгээ болон хэргийн газрын үзлэгийн практикт ашиглах чиглэлээр илүү өргөн хүрээтэй судалгаа, туршилтыг хийх нь зүйтэй. Энэ нь уг технологийн хэрэглээний боломжийг нэмэгдүүлэх, шинжлэх ухааны үндэслэлийг улам бүр баталгаажуулах ач холбогдолтой.

Ашигласан эх сурвалж

Ном сурах бичиг

1. Ганхүлэг Г. Хэт ягаан туяанд суурилсан арга, хэрэгслийг хэргийн газрын үзлэгт ашиглаж буй өнөөгийн байдал. Хууль сахиулахуй шинжлэн магадлах судлал., УБ., 2019.
2. Доржготов А. Хүний болон амьтны үсээр гэмт хэрэг илрүүлэх асуудал. Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. УБ., 1995.
3. Физик ДиДо, Монсудар УБ. , 2019. 313 дахь тал
4. https://www.slideshare.net , www.redeweb.com
5. https://infrared-heaters.ru/blog/ir-sushka-kuzova-avtomobilya/
6. https://gogo.mn/
7. Stuart H. James, Jon J. Nordby. Forensic Science: An Introduction to Scientific and Investigative Techniques. CRC Press, 2022.
8. https://pubmed.ncbi.nlm.nih.gov/41790150/
9. https://www.sciencedirect.com/

RESEARCH LINKING PRACTICE